

Хуучин Гэрээ

Сайн Мэдээний Сургаалын Багшийн Гарын Авлага



Хуучин Гэрээ

Сайн Мэдээний Сургаалын Багшийн Гарын Авлага

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс хэвлэв
Солт Лейк Хот, Юта

Санал зөвлөмжүүд

Энэ гарын авлагын талаарх таны санал, зөвлөмжүүдийг талархан хүлээн авах болно.
Тэдгээрийг дараах хаягаар ирүүлнэ үү:

Curriculum Planning

50 East North Temple Street, Floor 24

Salt Lake City, UT 84150-3200

USA

e-mail: cur-development@ldschurch.org

Өөрийн нэр, хаяг, хэсэг болон гадсыг жагсаана уу.

Гарын авлагын нэрийг бичихээ мартуузай.

Тэгээд энэ гарын авлагын чадамж хийгээд сайжруулах боломжтой
зүйлүүдийн талаарх өөрийн санал, зөвлөмжүүдийг ирүүлнэ үү.

Хавтас: *Өөрийн Хүү Самуелыг Елид Танилцуулж Байгаа Ханна*, Роберт Т.Барретт

© 1996, 2001 by Intellectual Reserve, Inc.

Бүх эрх хамгаалагдсан

Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв

Англи эхийн зөвшөөрөл: 1/01

Орчуулгын зөвшөөрөл: 01/01

Old Testament: Gospel Doctrine Teacher's Manual-ын орчуулга

Mongolian

Агуулга

Хичээлийн Дугаар ба Нэр	Хуудас
Багшид Зориулсан Тусламж	v
1 “Энэ бол миний ажил хийгээд миний алдар суу” (Моше 1)	1
2 “Чи төрөхөөсөө өмнө сонгогдсон билээ” (Абрахам 3; Моше 4:1–4)	6
3 Бүтээлт (Моше 1:27–42; 2–3)	10
4 “Зөрчлийн минь улмаас нүд минь нээгдсэн юм” (Моше 4; 5:1–15; 6:48–62)	14
5 “Хэрэв чи сайн хийх аваас, чи хүлээн авагдах болно” (Моше 5–7)	20
6 “Ноа . . . гэр бүлээ аврахын тулд хөвөгч авдар бэлтгэв” (Моше 8:19–30; Эхлэл 6–9; 11:1–9)	27
7 Абрахамын Гэрээ (Абрахам 1:1–4; 2:1–11; Эхлэл 12:1–8; 17:1–9)	32
8 Ёс Бус Дэлхийд Зөв Шударгаар Амьдрах нь (Эхлэл 13–14; 18–19)	37
9 “Бурхан өөртөө Хурга бэлтгэх болно” (Абрахам 1; Эхлэл 15–17; 21–22)	42
10 Өв Залгамжлах Эрхийн Адислалууд; Гэрээн дэх Гэрлэлт (Эхлэл 24–29)	47
11 “Би яаж ийм их муухай хэрэг үйлдэж чадав аа?” (Эхлэл 34; 37–39)	54
12 “Миний зүтгэж хөдөлмөрлөсөн газраас үр бүтээлтэй” (Эхлэл 40–45)	59
13 Боолчлол, Дээгүүр Өнгөрсний Баяр, Египетээс Гарсан нь (Египетээс Гарсан нь 1–3; 5–6; 11–14)	64
14 “Та нар миний эзэмшил болно” (Египетээс Гарсан нь 15–20; 32–34)	71
15 “Бурханд найдан, амьдар” (Тооллого 11–14; 21:1–9)	78
16 “Би ЭЗЭНИЙ тушаалтай зөрчилдөх зүйл хийж чадахгүй” (Тооллого 22–24; 31:1–16)	84
17 “Чи мартахгүйн тулд өөрийгөө хяна” (Дэд Хууль 6; 8; 11; 32)	89
18 “Тууштай бөгөөд зоригтой бай” (Иошуа 1–6; 23–24)	94
19 Шүүгчдийн Засаглал (Шүүгчид 2; 4; 6–7; 13–16)	100
20 “Хотын бүх хүмүүс . . . чамайг онцгой сайн эмэгтэй гэдгийг мэднэ” (Рут; 1 Самуел 1)	106
21 Бурханыг Хүндэтгэдэг Хүмүүсийг Тэрбээр Хүндлэх Болно (1Самуел 2–3; 8)	111

22	“Их Эзэн зүрх сэтгэлийг хардаг” (1 Samuel 9–11; 13; 15–17)	117
23	“Их Эзэн чи бид хоёрын хооронд үүрд мөнхөд байх болно” (1 Самуел 18–20; 23–24)	124
24	“Надад цэвэр ариун зүрх сэтгэлийг бий болгооч” (2 Самуел 11–12; Дуулал 51)	129
25	“Амьсгалдаг бүхэн ЭЗЭНийг магтагтун” (Дуулал)	136
26	Хаан Соломон: Мэргэн Хүн ба Тэнэг Хүн (Хаадын Дээд 3; 5–11)	142
27	Ёс Бус хийгээд Зөв Шударга Удирдагчдын Нөлөө (Хаадын Дээд 12–14; 2 Шастирын Дэд 17; 20)	148
28	“Галын дараах намуухан зөөлөн дуу хоолой” (Хаадын дээд 17–19)	154
29	“Тэр . . . Елиагийн нөмрөгийг авсан. . .” (Хаадын Дэд 2; 5–6)	160
30	“ЭЗЭНий өргөөнд ирэгтүн” (Шастирын Дэд 29–30; 32; 34)	165
31	“Мэргэн ухааныг олдог хүн баяр хөөртэй” (Сургаалт Үгс ба Номлогчийн Үгс)	172
32	“Гэтэлгэгч минь амьдардгийг би мэднэ” (Иов 1–2; 13; 19; 27; 42)	179
33	Сайн Мэдээг Дэлхийтэй Хуваалцах нь (Иона 1–4; Мика 2; 4–7)	184
34	“Би зөвт байдалд чамтай сүй тавина” (Хосеа 1–3; 11; 13–14)	189
35	Бурхан Өөрийн Нууцуудыг Бошиглогчиддоо Илчилдэг (Амос 3; 7–9; Иоел 2–3)	193
36	Сионы Алдар Суу Хамгаалалт Байх Болно (Исаиа 1–6)	199
37	“Та гайхамшгуудаа гүйцэтгэв” (Исаиа 22; 24–26; 28–30)	204
38	“Надаас өөр Аврагч байхгүй” (Исаиа 40–49)	208
39	“Уулсын дээр хичнээн үзэсгэлэнтэй вэ” (Исаиа 50–53)	213
40	“Майхныхаа талбайг өргөтгө” (Исаиа 54–56; 63–65)	216
41	“Би чамайг өнөөдөр . . . төмөр багана болгов” (Иеремиа 1–2; 15; 20; 26; 36–38)	221
42	“Би үүнийг тэдний зүрх сэтгэлд бичих болно” (Иеремиа 16; 23; 29; 31)	226
43	Израилын Хоньчид (Езекиел 18; 34; 37)	230
44	“Гол урсах газарт бүх юм амьдрах болно” (Езекиел 43–44; 47)	237
45	“Хэрэв би үхэх бол үхнэ” (Даниел 1; 3; 6; Естер 3–5; 7–8)	241
46	“Хэзээ ч усташгүй хаант улс” (Даниел 2)	247
47	“Босоцгоож, барьцгаая” (Езра 1–8; Нехемиа 1–2; 4; 6; 8)	252
48	“ЭЗЭНий аугаа, аймшигт өдөр” (Зехариа 10–14; Малахи)	258

Багшид Зориулсан Тусламж

“[Судруудыг судлах нь] та нарын хувьд үүрэг гэхээсээ илүүгээр, ихэд таалагдахуйц, Бурханы үгийн төлөө хайраар илрэх үйл хэрэг байх болно гэдэгт би найддаг. Та нар унших юм бол, оюун ухаан чинь гэгээрч, зүрх сэтгэл чинь өргөгдөх болно гэдгийг би амлаж байна” гэж Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хэлжээ (“The Light within You,” *Ensign*, 1995 оны 5-р сар, 99).

Сайн Мэдээний Сургаалын багшийн хувьд, Хуучин Гэрээнд дуртай байж, түүнчлэн Ерөнхийлөгч Хинклийн амласан гэгээрлийг олоход нь ангийн гишүүдэд туслах боломж танд байх болно. Та заах үедээ, судруудад дуртай байж, шавь нартаа заахад тэдгээрийг ашигладаг байсан Аврагчийн үлгэр жишээг та дагах болно.

Есүс дөнгөж амилсныхаа дараа өөрийн хоёр шавьд хүчирхэг үнэнүүдийг заахад судруудыг ашигласан юм. Клеоп нэртэй нэгэн шавь нь хамтрагчтайгаа хамт Есүсийн цогцос булшинд байхгүй болсон тухай өөрсдийнхөө дөнгөж саяхан сонссон сониныг ярилцан Еммау хүрэх замаар алхалж явжээ. Тэднийг явж байтал Есүс ирж тэдэнтэй нийлсэн боловч түүнийг таньсангүй. Тэд юун тухай ярилцаж явааг нь, мөн тэд яагаад уйтгартай байгааг Тэрээр асуухад түүний Цовдлуулалт болон Амилалтын тухай тэд түүнд ярьжээ. Есүс үүнийг сонсоод, “бүх судар өөрийнх нь тухай юу хэлснийг тэдэнд тайлбарлав” (Лук 24:27).

Клеоп болон түүний хамтрагч Аврагчийг өөрсөдтэйгөө хамт үлдэхийг хүссэнд тэд хооллохоор хамтдаа суух үед тэр хоёр амилсан Их Эзэнийг таньсан ажээ. Тэгээд Тэрээр тэдэнд харагдахгүй болоход тэд бие биендээ хэлсэн нь, “Замд Тэр бидэнтэй ярилцаж, судруудыг бидэнд тайлбарлаж байхад зүрх маань бидний дотор шатаж байсан бус уу?” (Лук 24:32).

Шавь нарын зүрх сэтгэлийг шатахад хүргэсэн судрууд нь бидний мэдэх— Мосегийн номнууд буюу Хуучин Гэрээний эхний таван ном болон бошиглогчдын бичсэн бусад номнууд байлаа. Та эдгээр нандин үнэнүүдийг заах үед Клеоп болон түүний хамтрагчид Тэрээр заасан лугаа адил Ариун Сүнс тэдгээрийн үнэний тухай танай ангийнханд гэрчлэх болно.

Хуучин Гэрээг судлах нь Аврагчийн тухай танай ангийнхны гэрчлэлүүдийг, түүнчлэн түүний сайн мэдээгээр амьдрах тэдний шийдвэр төгс байдлыг бэхжүүлэх ёстой. Өөрсдийн судалгаанд Сүнсээр удирдагдан ангийн гишүүд “Миний Гэтэлгэгч амьд гэдгийг болон эцсийн өдөр тэрээр дэлхий дээр байр сууриа эзэлнэ гэдгийг би мэднэ” (Иов 19:25) гэсэн Иовын үгсийг гэрчлэх боломжтой болох ёстой.

Сүнсээр Заах нь Сайн Мэдээний Сургаалын хичээлд бэлтгэхдээ та Их Эзэний Сүнсний нөлөө хийгээд удирдамжийг эрэлхийлэх нь чухал. “Сүнс итгэлийн залбирлаар та нарт өгөгдөх болно; мөн хэрэв та нар Сүнсийг эс хүлээн авбаас та нар заах нь үгүй” хэмээн Их Эзэн хэлжээ (С ба Г 42:14). Ариун Сүнс бол таны хичээл дээрх багш мөн гэдгийг санагтун.

Залбирал, мацаг барилт, судруудыг өдөр бүр судлах болон зарлигуудад дуулгавартай байхаар дамжуулан Сүнсний эрэлхийлэх нь таны арга зам мөн. Хичээлд бэлтгэх үедээ судруудыг, түүнчлэн ангийн гишүүдийн хэрэгцээг ойлгоход өөртөө туслуулахын тулд Сүнсний төлөө залбир. Сүнс нь бас судруудын тухай ярилцах болон тэдгээрийг бидний өнөөгийн амьдралд (1 Нифай 19:23) хэрэглэх утга учир бүхий арга замуудыг төлөвлөхөд тань тусална. Та Сүнсний туслалцаатайгаар Их Эзэний үгийг түүний хүүхдүүдэд заахад түүний мутар дахь үр ашигтай зэмсэг болох болно.

Сүнснийг хичээлдээ хэрхэн урих тухай зарим зөвлөмжүүдийг доор өгөв:

1. Хичээлийн өмнө болон дараа залбирал хийхэд ангийн гишүүдийг урь. Хичээлийн үед Сүнс таныг удирдахын тулд, ангийн гишүүдийн зүрх сэтгэлийг нээхийн тулд түүнчлэн гэрчилж, сүнслэгээр нөлөөлөхийн тулд дотроо залбир.
2. Судруудыг ашигла (доорх “Судруудад Анхаарал Төвлөрүүлэх нь” хэсгийг үз).
3. Зөвхөн хичээлийн төгсгөлд төдийгүй, Сүнс таныг өдөөсөн үед гэрчлэлээ хэл. Аврагчийн тухай гэрчлэлээ хэл. Ангийн гишүүдийг гэрчлэлээ хэлэхэд байнга урьж бай.
4. Сүнснийг мэдрэхэд ангийн гишүүдийн зүрх сэтгэлийг бэлтгэхийн тулд дууллауд, Хүүхдийн Хэсгийн дуунууд болон бусад ариун хөгжмийг ашигла.
5. Ангийн гишүүдийг, бусад хүмүүсийг түүнчлэн Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрыг хайрлах хайраа илэрхийл.
6. Хичээл дээрх зарчмуудад холбогдох ойлголтууд, бодол санаанууд хийгээд туршлагауудыг хуваалц. Мөн ингэхийг ангийн гишүүдээс хүс. Өмнөх хичээлүүд дээр заагдсан буюу ярилцсан зүйлийг тэд хэрхэн хэрэглэдгээ гишүүд бас ярилцаж болно.

Судруудад Анхаарал Төвлөрүүлэх нь

Сайн Мэдээний Сургаалын хичээлд бэлтгэх нь судруудыг хичээнгүйлэн, залбиралтайгаар судлахыг шаарддаг. “Миний үгийг тунхаглахыг бүү эрэлхийл, харин эхлээд миний үгийг олж авахыг эрэлхийл” хэмээн Их Эзэн зарлиглажээ (С ба Г 11:21).

Энэ гарын авлага бол судруудыг заахад танд туслах хэрэгсэл мөн. Долоо хоног бүр судруудаа хичээл дээрээ авч ирж байхад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж. Боломжтой газарт Хожмын Үеийн Гэгээнтний судруудын хэвлэлийг ашиглах ёстой.

Хичээлийн үед судруудад анхаарал хандуулсан ярилцлагауудыг явуул. Тайлбарууд болон судрын биш бусад мэдээллийг ашиглахдаа ухаалаг хэрсүү бай. Ангийн гишүүд судрууд болоод хожмын үеийн бошиглогчдын үгсээс мэдлэг хийгээд сүнсний нөлөө олж авахын тулд тэдэнд заах ёстой.

Хуучин Гэрээний Ангийн Гишүүний Судлах Удирдамжийн (34592) нэг хувийг ангийн гишүүн бүрд өгсөн байх ёстой. Энэ товхимол нь судруудыг ойлгож, тэдгээрийг хэрхэн хэрэглэх талаар тунгаан бодож, хичээлийн ярилцлагад

бэлтгэхэд нь ангийн гишүүдэд туслах хураангуйллууд болоод асуултуудаар хангадаг. Гэр бүлийн судрын судалгаанд энэ судлах удирдамжийг ашиглахад эцэг эхчүүдийг урамшуулан дэмж.

Хичээлийн Хэмжээ

Энэ гарын авлага Сайн Мэдээний Сургаалын залуучууд болон насанд хүрэгчдийн ангиудад зориулан бичигдсэн бөгөөд дөрвөн жил тутамд ашиглагдах ёстой. Хичээлүүд нь нэг хичээлийн хугацаанд таны заах боломжтойгоос илүү их мэдээллийг агуулахаар төлөвлөгдсөн болно. Ангийн гишүүдийн хэрэгцээг хамгийн сайнаар хангах судрын шастирууд, асуултууд хийгээд үйл ажиллагаануудыг сонгож авахад Их Эзэний Сүнсийг эрэлхийл.

Хичээл бүр нь дараах хэсгүүдийг агуулсан байна:

1. *Зорилго.* Та хичээлд бэлтгэх болон заахдаа анхаарал төвлөрүүлэх гол санаа нь таны зорилгыг тодорхойлох болно.
2. *Бэлтгэл.* Энэ хэсгийн эхний хэсэг нь хичээлийн төлөвлөгөөн дэх судрын шастируудын хураангуйллыг өгдөг. Зарим хичээлүүд өсгөн нэмэгдүүлсэн ойлголтыг танд өгөх нэмэлт уншлагыг санал болгодог. Олон хичээлд энэ хэсэг нь бас хичээл дээр өөрийн чинь авчирч болох материалууд зэрэг хичээлийн бусад бэлтгэлүүдийг багтаасан байгаа.
3. *Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа.* Энэ хэсэг нь энгийн үйл ажиллагаа, зорилгот хичээл буюу суралцах, оролцох, түүнчлэн Сүнсний нөлөөг мэдрэхэд ангийн гишүүдэд туслах асуултуудаас бүрддэг. Та энэ гарын авлага дахь анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашиглах буюу эсвэл өөрийнхөөнийг ашиглана уу ялгаагүй, ангийн гишүүдийн анхаарлыг хичээлийн эхлэлд хандуулах нь чухал. Энэ үйл ажиллагаа богино байх ёстой.
4. *Судрын ярилцлага ба хэрэглээ.* Энэ бол хичээлийн гол хэсэг. Судрын шастируудыг зааж, үр ашигтайгаар ярилцахын тулд та судруудыг залбирч судал. Өөрийн заах арга барилыг өөрчилж, ангийн гишүүдийн анхаарлыг төвлөрүүлэн барьж байхын тулд “Судруудыг Заахад Зориулсан Тусламжууд” (доорх) дахь зөвлөмжүүдийг ашигла.
5. *Дүгнэлт.* Энэ хэсэг нь хичээлийг нэгтгэн дүгнэж, та нарын ярилцсан зарчмуудаар амьдрахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмжихэд танд тусална. Энэ нь бас гэрчлэлээ хэлэхийг танд сануулна. Хичээл бүрийг дүгнэхэд хангалттай цаг үлдэхэд анхаар.
6. *Нэмэлт Үйл Ажиллагаанууд. Заах Санаанууд.* Судрын шастируудаас авсан нэмэлт үнэнүүд, заах аргын хувилбарууд болон хичээлийн төлөвлөгөөг баяжуулагч бусад зөвлөмжүүд энэ хэсэгт агуулагддаг. Та хичээлийн нэг хэсэг болгон эдгээр санаануудаас заримыг нь ашиглаж болно.

Судруудыг Заах Тусламж

Судрын шастируудыг илүү үр ашигтайгаар, олон янзын аргаар заахад дараах зөвлөмжүүдийг ашигла:

1. Түүний төрөлт, мөнх бус байдлын үе дэх үүрэг зорилго, хоёр дахь ирэлт хийгээд мянган жилийн хаанчлал нь Хуучин Гэрээнд бошиглогдсоныг,

Хуучин Гэрээний Иехова, Есүс Христийн тухай судрууд юу заадгийг ойлгоход нь ангийн гишүүдэд тусал.

2. Судрын аль нэг хэсэг тэдний амьдралд хэрэглэгдэж болох арга замуудын тухай бодож, хуваалцахыг ангийн гишүүдээс хүс.
3. Сургаалд нэмэлт болгож, Хуучин Гэрээн дэх түүхүүдэд, ялангуяа итгэлийн тухай түүхүүдэд онцгой анхаарал хандуулж, түүнчлэн тэдгээрийг ангийн гишүүд ойлгож, амьдралдаа хэрэглэх арга замуудын талаар ярилцахад анхаар.
4. Судрын хэсэгт олонтаа давтагддаг үг, холбоо үг буюу санаанууд, эсвэл тэдгээрийн өвөрмөц утга санааг оюутнуудаар хайлгуул.
5. Судрын шастирт холбогдох зарим холбоо үгс, түлхүүр үгс буюу асуултуудыг самбар дээр бич. Дараа нь уг шастирыг унших буюу нэгтгэн дүгнэ. Эдгээр холбоо үгс, өгүүлбэр, түлхүүр үгс буюу асуултуудын хариуг ангийн гишүүд сонсохыг зогсоож, тэдгээрийн талаар ярилц.
6. Мормоны Номонд байнга байдаг “мөн ийн бид үздэг” гэсэн өгүүлбэр нь заагдсан зарчмуудын хураангуйг таниулахад хэрэглэгддэг. Судрын аль нэг хэсгийг ярилцсаны дараа энд заагдсан сайн мэдээний зарчмыг тайлбарлахын тулд “мөн ийн бид үздэг” гэсэн өгүүлбэрийг гүйцээхийг ангийн гишүүдээс хүс.
7. Хуучин Гэрээнд байнга хэрэглэгддэг бэлэгдлүүдийг эрж олон, ярилц. Жишээ нь, сүйт бүсгүй болон Хүргэн хүү нь Израил, Аврагч хоёрыг төлөөлдөг.
8. Судрууд дахь хүмүүс буюу үйл явдлууд хэрхэн эсрэг тэсрэг байж болохыг ажигла. Жишээ нь, та Каиныг Абел болон Енохтой (Моце 5–7); Давид, Батшеба нарыг (2 Самуел 11) Египетийн Иосеф болон Потифарын эхнэртэй (Эхлэл 39:7–13); эсвэл бошиглогч Елиаг ёс бус хаан Ахабтай (Хаадын Дээд 16:29–33; 17–19) сөргүүлэн тавьж болно.
9. Судрууд дахь өөр өөр хүмүүсийн үгсийг ангийн гишүүдээр уншуулах замаар уншигчдын театр бий болго.
10. Ангийг хоёр буюу түүнээс олон жижиг бүлгүүд болгон хуваа. Судрын шастирыг нэгтгэн дүгнэсний дараа, уг шастирт заагдсан зарчмуудыг бүлэг бүрээр бичүүл. Дараа нь эдгээр зарчмууд тэдний амьдралд хэрхэн хэрэглэгддэгийг бүлгүүдээр ээлжээр яриул.
11. Та нар тэдгээрийг ярилцах үед чухал ач холбогдолтой шүлгүүдийг тэмдэглэж авахын тулд харандаа авчрахыг ангийн гишүүдээс хүс.

**Ангиараа
Ярилцахыг
Урамшуулан
Дэмжих нь**

Ердийн байдлаар бол та лекц унших ёсгүй, харин судруудыг ярилцахад утга учиртайгаар оролцоход нь ангийн гишүүдэд туслахыг хичээх ёстой. Ангийн гишүүд оролцсон үед тэд судруудын тухай илүү үр ашигтайгаар сурч, сайн мэдээний зарчмуудыг хэрхэн хэрэглэхийг илүү сайн ойлгодог. Ямар

асуултууд асуух, тэдгээрийг хэрхэн зохион байгуулж, хэрхэн хөгжүүлэхийг шийдэхдээ Сүнсний удирдамжийг эрэлхийл. Христэд ирж, түүний шавь нар болж амьдрахад нь гишүүдэд туслах асуудлууд дээр ангид хийх ярилцлагууд төвлөрөх ёстой. Эдгээр зорилгуудыг хэрэгжүүлж эс чадах ярилцлагуудыг дахин чиглүүл.

Судрууд дахь олонхи асуултад хариултуудыг олоход өөрт чинь болон ангийн гишүүдэд туслах судрын ишлэлүүд өгөгдсөн байгаа. Зарим асуултын хариултууд ангийн гишүүдийн туршлагаас гарч ирэх болно.

Хичээлийн бүх материалыг хамран заах нь судруудыг илүү сайн ойлгож, шавь байх өөрсдийн шинж чанарыг дээшлүүлэхэд шийдвэр төгс байхад нь ангийн гишүүдэд туслахаас илүү чухал биш юм. Хэрэв ангийн гишүүд сайн ярилцлагаас юм сурч байвал, үүнийг цааш үргэлжлүүлэх нь хичээлийн бүх материалыг бүгдийг нь заахыг хичээхээс илүү ашиг тустай байх нь олонтаа тохиолддог.

Ангиараа ярилцахыг урамшуулан дэмжихийн тулд дараах удирдамжуудыг ашигла:

1. Нэг асуулт асуугаад дараа нь ангийн гишүүд хариуг олохын тулд судрын нэг ишлэл өг.
2. Тийм, эсвэл Үгүй гэсэн хариултуудаас илүүгээр эргэцүүлэн бодох хийгээд шүүн ярилцахыг шаардсан асуултууд асуу. *Яагаад, яаж, хэн, юу, хэзээ, хаана* гэсэн үгсээр эхэлсэн асуултууд ярилцлагыг урамшуулан дэмжихэд ихэвчлэн хамгийн үр ашигтай байдаг.
3. Судруудаас тэд юу сурсан тухай бодол санаагаа хуваалцахад ангийн гишүүдийг урамшуулан дэмж. Мөн судрын зарчмууд амьдралд хэрхэн хэрэгжиж болохыг харуулсан туршлагуудыг хуваалцахад нь тэднийг урамшуулан дэмж. Тэдний хувь нэмрүүдийн талаар нааштай тайлбаруудыг хий.
4. Ангийн гишүүн бүрийн хэрэгцээнд мэдрэмтгий бай. Хэдийгээр анги дахь ярилцлагуудад оролцоход нь бүх гишүүдийг урамшуулан дэмжих ёстой ч гэсэн, зарим гишүүд хариулахдаа эргэлзэж болно. Чанга унших буюу хичээлд оролцох тухайд тэд ямар бодолтой байдгийг нь мэдэхийн тулд та тэдэнтэй ганцаарчлан ярилцахыг хүсч болно. Ичиж магадгүй ангийн гишүүдийн нэрийг дуудахдаа болгоомжтой ханд.
5. Даалгасан судрын шастир болон *Хуучин Гэрээний Ангийн Гишүүний Судлах Удирдамжийг* (34592) судлах замаар ангийн гишүүдийг хичээлд бэлтгэхэд нь урамшуулан дэмж. Хэрэв тэд бэлтгэгдсэн байх юм бол, тэд ярилцлагуудад оролцох илүү сайн боломжтой байх болно. Ангийн гишүүд судрын шастирууд болон хичээлүүдийг гэр бүлийнхэнтэйгээ ярилцахыг санал болго.

“Энэ бол миний ажил хийгээд миний алдар суу”

Хичээл

1

Моце 1

Зорилго

(1) Бид бол Бурханы хүүхдүүд, (2) бид Сатаны уруу таталтуудыг эсэргүүцэж чадна, (3) Бурханы ажил хийгээд алдар суу бол бидний үхэшгүй байдал болон мөнх амьдралыг тохиолгон авчрах явдал гэдгийг ойлгоход нь ангийн гишүүдэд туслах.

Бэлтгэл

1. Агуу Үнэт Сувдаас дараах судруудыг залбирч судал:
 - а. Моце 1:1–11. Моце Бурханыг харж, түүнтэй нүүр тулан ярилцжээ. Тэр бол Эцэгийн Төрсөн Ганцтай адил, Бурханы Хүү гэдгийг Моце мэджээ. Анхаар: Энэ үзэгдэлд Тэнгэрлэг Эцэг биш, Иехова Моце дээр хүрч ирснийг ангийн гишүүд ойлгох ёстой. Иехова бол мөнх бус байдлын өмнөх Есүс Христ бөгөөд Хуучин Гэрээний Бурхан байлаа. Тэр бол зорилгоороо Эцэгтэй нэг бөгөөд хүч хийгээд эрх мэдэлд түүнийг төлөөлдөг. Түүний үгс Эцэгийнх бөгөөд, зарим үед, Моце 1:6-д гардагчлан, Эцэгийн өмнөөс нэгдүгээр биеэр ярьсан байдаг.
 - б. Моце 1:12–23. Сатан Мосетой сөргөлдөв; Моце түүнийг хөөн зайлуулав.
 - в. Моце 1:24–39. Бурхан дахин хүрч ирж, өөрийн ажил хийгээд алдар сууг заав.
2. Хичээлийг үзэж, судрын шастируудыг хэрхэн заахаа шийд. Хичээл дэх асуулт болгоныг асуух буюу юм болгоныг бүгдийг заах нь хэцүү учраас ангийн гишүүдийн хэрэгцээг хамгийн сайнаар хангах зүйлүүдийг залбиран сонгож ав. Ангийн гишүүдийн байдалд тохируулан та зарим асуултуудыг хялбаршуулах хэрэгтэй байж болно.
3. *Хуучин Гэрээний Ангийн Гишүүний Судлах Удирдамжийн* (34592) хувиудыг ангийнхаа гишүүн бүрийн тоогоор олж ав. (Эдгээр сургалтын удирдамжуудыг жил тутмынхаа сургалтын материалын захиалгад оруулан Хэсэг захиалах ёстой; бишопын зөвлөлийн гишүүн тэдгээрийг Ням Гарагийн Сургуулийн Ерөнхийлөгчийн Зөвлөлд өгөх ёстой.)
4. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх хоёр дахь үйл ажиллагааг ашиглах бол, цаасан буюу даавуун хүүдий олж, жижиг чулуу, сам, харандаа мэт өдөр тутмын амьдралд хэрэглэдэг зүйлүүдийг дотор нь хий.

Энэ Хичээлийг Заах Зөвлөмж

Хуучин Гэрээтэй
Танилцах нь

Хуучин Гэрээ бол Бүтээлтийн үеэс хойш Аврагчийн төрөлтийн өмнөх хэдэн зуун жилд өөрийн гэрээт хүмүүстэй Бурхан харилцсан тухай шастир юм. Итгэлийн хийгээд дуулгавартай байдлын хүчирхэг үлгэр жишээнүүдээр Хуучин Гэрээ хангаж өгдөг. Энэ нь бас мартагын, дуулгаваргүй байхын, эсвэл Бурханыг эсэргүүцэхийн үр дагавруудыг бас харуулдаг. Хуучин Гэрээний бошиглолууд нь Мессиагийн төрөлт, гэтэлгэгч золиослол, хоёр дахь ирэлт хийгээд мянган жилийн хаанчлалын тухай бас харуулдаг.

Энэ сургалтын гарын авлага Хуучин Гэрээн дээр нэмэлт болгож Агуу Үнэт Сувдаас Мосегийн болон Абрахамын номнуудыг өөртөө багтаадаг. Эдгээр номнууд Эхлэлийн номон дахь зарим материалыг чухал нэмэлт, тодруулгаар хангадаг. Мосегийн Ном бол Библийн Иосеф Смитийн Орчуулгаас авсан түүвэр юм. Абрахамын Ном бол Египетийн үйсэн дээрх зарим бичээснээс Бошиглогч Иосеф Смитийн хийсэн орчуулга юм. Иосеф Смитийн Орчуулгын тухай дэлгэрэнгүй мэдээллийг “Bible Dictionary, хуудас 717 дахь “Joseph Smith Translation”-г үз. Иосеф Смитийн Орчуулгын түүврүүд бас багтаасан байдгийг тэмдэглэ.

Анхаарал
төвлөрүүлэх
үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагаануудын аль нэгийг (эсвэл өөрийнхөө үйл ажиллагаануудын нэгийг) ашиглахыг хүсч болно. Ангийн хувьд хамгийн тохиромжтой үйл ажиллагааг сонгож ав.

1. Илчлэгдсэн чухал үнэнүүдийг тогтоохын тулд Мосе 1:6, 20–22, 39-ийг харахыг ангийн гишүүдээс хүс. Хариултууд өөр өөр байж болно. Энэ хичээл 1-р хуудсан дээрх “Зорилгод” жагсаасан гурван үнэн дээр анхаарал төвлөрүүлэх болно гэдгийг тайлбарла.
2. Ангийн хоёр гишүүнийг сонгож, өдөр тутам хэрэглэдэг хэд хэдэн зүйлийг агуулсан хүүдийг тэдэнд өг (1-р хуудсан дээрх “Бэлтгэлийг” үз). Тэд нэг тоглоом тоглох гэж байгааг оролцогчдод хэл, гэвч тоглоомын зааврыг буюу эсвэл үүний зорилгыг бүү таниул. Хүүдийг нээж, тоглоомыг эхлэхийг оролцогчдоос хүс. Тоглоомыг тайлбарлахын тулд тэд хүүдийн доторх зүйлүүд юу болохыг хүлээх болно. Гэвч, хүүдийн доторх зүйлүүд энэ мэдээллээр хангахгүй байна. Тэгээд оролцогчид юу хийх талаараа гайхацгаах болно.

Тоглоомыг ойлгохын тулд бид үүний зорилгыг ойлгох ёстойг тэмдэглэн хэл. Үүнтэй адилхан, бид дэлхий дээрх өөрсдийн амьдралыг ойлгохын тулд, бид амьдралынхаа зорилгыг ойлгох ёстой. Мосе 1 нь гурван чухал асуултад хариулах замаар үүнийг ойлгоход бидэнд тусалдаг:

Бид хэн бэ?

Бэрхшээл зовлонгийн нөлөөг бид хэрхэн даван туулж чадах вэ?

Бурханы ажил хийгээд алдар суу юу вэ?

Судрын ярилцлага
ба хэрэглээ

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж. Хичээлд тохирох *Хуучин Гэрээний Ангийн Гишүүний Судлах Удирдамжийг* (34592) тарааж өгөөд, тэдний хувиараа болон гэр бүлээрээ судар судлахад нь түлхэц өгөхийн тулд үүнийг ашиглахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Мосе бол Бурханы хүү болохыг Бурхан заав.

Мосе 1:1–11-ийг зааж, ярилц.

- Мосе 1:1–7-д дүрслэгдсэн туршлагааудаас Мосе Бурханы талаар юу мэдсэн бэ? Мосе өөрийнхөө тухай юу мэдсэн бэ? (Бурхан хэд хэдэн удаа Мосег “хүү минь” хэмээн эдгээр шүлгүүдэд нэрлэснийг та ангийн гишүүдээр ажиглуулж болно.)

- Мосе Аврагчтай “адилаар” бүтээгдсэн гэсэн нь ямар утга учиртай вэ? (Мосе 1:6). Бид бол Түүний хүүгийн адилаар бүтээгдсэн Бурханы хүүхдүүд гэдгийг мэдэх ямар ялгаа бидний амьдралд байдаг вэ?

Ахлагч Даллин Х.Өүкс заахдаа: “‘Би Бурханы хүүхэд’ хэмээх бидний дуртай дуунд заагддаг тэрхүү санааны хүчийг аваад үз. . . . ‘Би хэн бэ?’ гэсэн амьдралын аугаа асуултуудын нэгнийх нь хариу энд байна. Би бол сүнсний уг сурвалж нь тэнгэрлэг эцэг эх рүү очих Бурханы хүүхэд билээ. Энэхүү эцэг эхийн холбоо бидний мөнхийн чадавхийг тодорхойлдог. Энэхүү хүчирхэг санаа бол ихэд үнэмшилтэй, өдөөгч баримт юм. Энэ нь бид бүгдийг зөв шударга сонголтууд хийхэд, түүнчлэн өөрсдийн доторх хамгийн шилдгийг эрэлхийлэхэд хүчирхэгжүүлж чадна. Тэр бол Бурханы хүүхэд гэсэн хүчтэй санааг хүний оюун ухаанд төлөвшүүл, тэгвэл танд өөрийгөө хүндэтгэх хүндэтгэл ирж, амьдралын асуудал бэрхшээлүүдийн эсрэг сөрөн зогсох хүсэл эрмэлзэл танд байх болно” гэжээ (Conference report, 1995 оны 10-р сар, 31; *Ensign*, 1995 оны 11-р сар, 25).

- Мосег “хүү минь” хэмээн дахин давтан дуудсанаар, түүнчлэн тэрээр “миний Төрсөн Ганцын адилаар” бүтээгдсэнийг хэлснээр, итгэл хийгээд өөрийнхөө үнэ цэнийг ойлгох ойлголтыг Бурхан Мосед хайрласан ажээ. Эцэг эхчүүд болох бидний хувьд энэхүү зарчмыг дагах нь бидэнд хэрхэн тусалж чадах вэ? Энэ нь гэрлэлтийг хэрхэн хүчирхэгжүүлж, нөхөрлөлийг хэрхэн бэхжүүлж чадах вэ?

Шүүмжлэл, сөрөг бодол санаа, дорд үзэн басамжлагч үг яриа давамгайлсан дэлхийд бид Их Эзэний үлгэр жишээг дагаж, бусад хүмүүс өөрсдийгөө өндөр нэр төр, үнэ цэнэ бүхий Бурханы хүүхдүүд гэдгээр харахад нь туслах зүйлүүдийг хэлж байх ёстой.

- Мосе1:1–7-д Мосегийн ач холбогдол хийгээд мөнхийн чадавхийг онцлон тэмдэглэсэн байдаг. Гэвч, Бурханы оршихуй түүнээс татан авагдсаны дараа, Мосе “Эдүгээ, энэ шалтгааны учир хүмүүн юу ч биш гэдгийг би мэднэ” гэж хэлжээ (Мосе 1:10). Ямар учраас хоёр үзэл баримтлал хоёул зөв бэ? (Бурхан мөнх бус эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдээс хязгааргүй цэцэн хийгээд илүү хүчирхэг юм. Түүнгүйгээр бид юу ч биш юм. Гэвч, бид түүний хүүхдүүд учраас түүнтэй адилхан болох чадавхи бидэнд бий.)

2. Сатан Мосетой сөргөлдөв; Мосе түүнийг хөөн зайлуулав.

Мосе1:12–23-ыг зааж, ярилц.

- Сатан ирээд, юу хийхийг тэрээр Мосед зарлигласан бэ? (Мосе 1:12-ыг үз) Сатан яагаад Мосег “хүний хүү” гэж нэрлэсэн бэ? (Тэрээр Бурханы хүү биш гэдэгт Мосе итгээсэй хэмээн Сатан хүсч байжээ.) Бид Бурханы хүүхдүүд гэдэгтээ эргэлздэг буюу эсвэл үл ойшоодог байхыг Сатан яагаад хүсдэг вэ? Тэр үүнийг хэрхэн хийхээр хичээдэг вэ?
- Сатан түүнийг “хүний хүү” гэж нэрлэхэд Мосе хэрхэн хандсан бэ? (Мосе 1:13-ыг үз) Бид бол Бурханы хөвгүүд, охид мөн гэдэг хүчтэй гэрчлэл уруу таталтыг эсэргүүцэхэд бидэнд хэрхэн тусалж чадах вэ?
- Мосе Сатанд зайл гэж хэдэн удаа хэлсэн бэ? (Мосе 1:16, 18, 20, 21-ийг үз) Сатаны хүч чармайлтуудыг эсэргүүцэх талаар энэ нь бидэнд юу зааж байна вэ?

- Сатаны уруу таталтуудыг эсэргүүцэх хүч чадлыг Мосе хэрхэн хүлээн авсан бэ? (Моисе 1:18, 20–21-ийг үз) Мосе Сатаныг яаж зайлан явахад хүргэсэн бэ? Уруу таталтыг эсэргүүцэхэд залбирал биднийг хэрхэн хүчирхэгжүүлж чадах вэ? Энэхүү хүч чадлыг олж авахын тулд бид өөр юу хийж болох вэ?

3. Бурхан дахин хүрч ирэн өөрийн ажил хийгээд алдар суугийн тухай заав.

Моисе 1:24–39-ийг зааж, ярилц.

- Сатаныг зайлсны дараа Мосе Бурханы алдар сууг дахин болгоож, дэлхий болоод үүний оршин суугчдын талаар өөр нэг үзэгдэл түүнд үзэгдэв (Моисе 1:24–28). Энэ үзэгдэл түүнд үзэгдэхэд Мосе ямар хоёр асуулт асуусан бэ? (Моисе 1:30-ыг үз) Бурхан ямар хариултауд өгсөн бэ? (Моисе 1:31–32, 39-ийг үз)
- Хэдийгээр Бурхан дэлхийнүүдийг бүтээсэн бөгөөд бидний хувьд хүмүүс тоо томшгүй олон ч гэсэн тэрээр бүгдийг нь мэддэг болохыг Мосед итгүүлсэн ажээ (Моисе 1:35). Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр таныг биечлэн таньдаг, мөн таныг хайрладаг гэж та хэрхэн боддог болсон бэ? (Тэд таныг хайрлаж, бас таны төлөө санаа тавьдаг гэж бодсон үеийнхээ тухай та гэрчлэлээ хэлэхийг хүсч болно.)
- Бурханы ажил болон алдар суу бол “хүмүүний үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг тохиолгон авчрах явдал мөн” (Моисе 1:39). Үхэшгүй байдал гэж юу вэ? Үхэшгүй байдлыг хэн хүлээж авах вэ? Мөнх амьдрал гэж юу вэ? Мөнх амьдралыг хэн хүлээж авах вэ?

Ахлагч Жеймс Е. Фауст хэлэхдээ: “Үхэшгүй байдал буюу эсвэл Бурханы оршихуйд байртай байх мөнхийн оршихуй болон мөнх амьдралын хооронд ялгаа бий. Есүс Христийн ач ивээлээр дамжин үхэшгүй байдал бүх хүмүүст, шударга буюу шударга бус хүмүүст, зөв шударга буюу ёс бус хүмүүст ирнэ. . . . Гэвч, мөнх амьдрал бол Бурханы бүх бэлгүүдээс хамгийн агуу нь юм (С ба Г 14:7). Их Эзэний өгүүлснээр, ‘хэрэв та нар миний зарлигуудыг сахьж, эцсээ хүртэл тэвчих юм бол’, бид энэхүү агуу бэлгийг олж авна. Хэрэв бид ийнхүү тэвчих юм бол, ‘та нарт мөнх амьдрал байх болно’ С ба Г 14:7) гэсэн амлалт буй” гэжээ (Conference report, 1988 оны 10-р сар, 14; *Ensign*, 1988 оны 11-р сар, 12).

- Бурханы ажил хийгээд алдар суу юу болохыг мэдэх нь бидний хувьд яагаад чухал вэ? Энэхүү агуу ажилд бид тусалж чадах ямар зарим тодорхой арга зам байдаг вэ?

Ерөнхийлөгч Гордон Б. Хинкли хэлэхдээ: “Бид Тэнгэрлэг Эцэгтээ Түүний ажил хийгээд Түүний алдар сууд туслахын тулд, ‘хүмүүний үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг тохиолгон авчрахын тулд’ (Моисе 1:39) энд байгаа билээ. Та нарын үүрэг бол би өөрийнхөө хүрээнд үүрэг хариуцлага хүлээдэг шиг та нар өөрсдийнхөө хүрээнд нухацтай үүрэг хариуцлага хүлээдэг байх явдал мөн. Жижигхэн буюу үр дагавар нь өчүүхэн дуудлага гэж энэ сүмд үгүй. Бид бүгд өөрсдийнхөө үүргийн дагуу бусдын амьдралд нөлөөлдөг. Бидний хүндэт үүрэг хариуцлагын талаар Их Эзэн бидний хүн нэг бүрд хандан . . . ‘Эдгээр зүйлүүдийг хийснээрээ чи нөхөлдөө хамгийн агуу сайныг үйлдэх болно, мөн өөрийн

Их Эзэн болох түүний алдар сууд тус нэмэрлэх болно' гэжээ (С ба Г 81:4)" (Conference report, 1995 оны 4-р сар, 94; *Ensign*, 1995 оны 5-р сар, 71; мөн С ба Г 81:5–6-г үз).

Дүгнэлт

Мосе 1 нь бид Бурханы хөвгүүд, охид болох тухай хүчирхэг сургаалыг заадаг. Энэхүү үнэний ач холбогдлын тухай тунгаан бодоход ангийн гишүүдийг урь. Бидний Тэнгэрлэг Эцэг бид бүгдийг нэг бүрчлэн мэддэг, бас биднийг нэг бүрчлэн хайрладгийг гэрчил. Мосе 1-ээс мэдсэн зүйлийнхээ талаарх бодол санаагаа гэр бүлийнхэндээ илэрхийлэхэд нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

Нэмэлт заах санаанууд

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

1. “Мосе өөрийнхөө байдалд үлдсэн байв” (Мосе 1:9)

- Бид Мосе шиг “[өөрсдийнхөө] байдалд үлдэх” цаг —Сүнснийг хүчтэйгээр мэдрэхгүй эсвэл олон гай зовлонгийн цаг бидэнд тохиолдож болно. Ийм цаг үе тулгарахад бид өөрсдөдөө туслахын тулд Мосе 1-р бүлгээс бид юу сурч болох вэ? (Хариултууд нь гэвэл: Ийм хүндрэл бэрхшээлүүд бидний үйлдсэн аливаа буруу зүйлийн нэг хэсэг байж болно; шүлэг 15-д харуулсанчлан, Бурхан биднийг бүхэлд нь орхидоггүй; бид өөрсдийн зовлон бэрхшээлтэй тулгарч, Бурханыг дуудсанаар, тэрчлэн итгэлээ өсгөн нэмэгдүүснээр бид агуу хүч чадлыг олж авах нь олонтаа байдаг.)

2. Бүх хүмүүс Бурханы хүүхдүүд

- Мосе Израилын хүүхдүүдийг Египетээс удирдан гаргахаасаа өмнө Мосе 1-д цэдэглэгдсэн үзэгдлийг хүлээн авчээ. Энэ үзэгдэл түүнд энэхүү хүч чармайлтад нь, ялангуяа тэрээр хүмүүсийн олон удаагийн эсэргүүцлээр, бас итгэл дутагдах явдлаар урам нь хугарч байхад нь тусалсан гэж та нар боддог уу? Бид бүгдээрээ Бурханы хүүхдүүд гэдгийг мэдэх нь багш буюу удирдагчид хэрхэн тусалж чадах вэ? Энэхүү мэдлэг гэр бүлийн гишүүд, найз нөхөд болон бусад хүмүүстэй харилцахад бидэнд хэрхэн тусалж чадах вэ?

3. Библийн Иосеф Смитийн Орчуулга

Хэрэв *Old Testament Video Presentations* (53224) байдаг бол, “The Power of the Joseph Smith Translation” (53224) гэсэн таван минутын хэсгийг та хичээлийнхээ нэг хэсэг болгон үзүүлж болно. Мосегийн ном бол Библийн Иосеф Смитийн Орчуулгаас авсан түүвэр гэдгийг ангийн гишүүдэд сануул.

Зорилго

Урьдчилсан томилолтын сургаал болон Бурханы хаант улсыг байгуулах болоод бодгалиудыг Христэд авчрахад туслах өөрсдийн хувийн үүрэг хариуцлагыг ойлгоход нь ангийн гишүүдэд туслах.

Бэлтгэл

1. Агуу Үнэт Сувд болон Сургаал ба Гэрээнээс дараах судруудыг залбирч судал:
 - а. Абрахам 3:11–12, 22–23; Сургаал ба Гэрээ 138:53–57. Абрахам Их Эзэнтэй нүүр тулан ярилцаж, мөнх бус байдлын өмнөх амьдралд олон “сурвалжит хийгээд агуу” сүнснүүд өөрсдийн мөнх бус байдлын үүрэг зорилгуудад урьдчилан томилогдсоныг мэдсэн ажээ (Абрахам 3:11–12, 22–23). “Сурвалжит хийгээд агуу тэдний” талаар Аврагч Өөрийн Амилалтаас өмнө сүнсний дэлхийд очсон тухай үзэгдэлд Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит илүү ихийг мэджээ (С ба Г 138:53–57).
 - б. Абрахам 3:24–28; Мосе 4:1–4. Тэнгэр дэх Зөвлөл дээр Есүс Христ бидний Аврагч байхаар сонгогдсоныг, бас бид түүнийг дагахаар сонгосныг уг үзэгдэлд Абрахам, Мосе хоёрт үзүүлжээ. Түүнчлэн Люцифер (Сатан) болон түүнийг дагасан сүнснүүд тэнгэрээс хөөгдсөнийг тэдэнд үзүүлсэн аж.
2. Нэмэлт уншлага: Исаиа 14:12–15; Илчлэлт 12:7–9; Алма 13:3–5; Сургаал ба Гэрээ 29:36–39; түүнчлэн Абрахам 3-ын үлдсэн хэсэг болон Сургаал ба Гэрээний Хэсэг 138.

**Энэ хичээлийг
заах зөвлөмж**

Анхаарал
төвлөрүүлэх
үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагаануудын аль нэгийг эсвэл (өөрийнхөө үйл ажиллагаануудын нэгийг) ашиглахыг хүсч болно. Ангийн хувьд хамгийн тохиромжтой үйл ажиллагааг сонгож ав.

1. Бид эдгээр судруудын заадаг зүйлүүдийг амьдралдаа хэрэглэх үед тэдгээр нь илүү утга учир дүүрэн байх болно гэдгийг онцлон заа. Үүнийг хийхийн тулд бид өөрсдийгөө эртний бошиглогчид хийгээд тэднийг дагалдагчдын байранд олонтаа тавьж үзэх ёстой. Гэвч Абрахам 3:22–28-д бид өөрсдийгөө хэн нэгний байранд тавьж үздэггүй, учир нь эдгээр шүлгүүд бидний оролцдог чухал үйл явдлуудын тухай өгүүлдэг. Эдгээр үйл явдлууд бидний мөнх бус байдлын өмнөх амьдралд болсон ажээ.
2. *Урьдчилсан томилолт* гэдэг үгэн дэх 18 үсгийг бөглөж бичих 18 хоосон нүдтэй тэгш өнцөгтийг самбар дээр зур. Эдгээр нүднүүдэд нөхөн бөглөгдөх үг мөнх бус байдлын өмнөх үед хамаарна гэдгийг тайлбарла.
Ямар үсгүүд уг үгийг бүрдүүлэх тухайд 18 удаа таах боломжийг ангийн гишүүдэд олго Тэд зөв үсгийг таасан тохиолдолд тохирох зай буюу

нүдэнд бич. Тэд уг үгэнд ордоггүй үсэг хэлсэн тохиолдолд, үүнийг дахин хэлэхгүйн тулд самбар дээр өөр хаа нэгтээ бич.

Ангийн гишүүд бүх нүдэн дэх үсгүүдийг бөглөсөн буюу үгийг таасан үед, энэ үгийн утгыг тодорхойлоход тэдэнд тусал. (Урьдчилсан томилот бол Бурхан өөрийн сүнсэн хүүхдүүдийг мөнх бус амьдралынх нь үед тодорхой үүрэг зорилгуудыг гүйцэтгүүлэхээр томилсон мөнх бус байдлын өмнөх амьдралын томилот мөн.) Энэ хичээл бол олон сүнс Тэнгэрлэг Эцэгийн төлөө чухал зүйлүүдийг хийхийн тулд урьдчилан томилогдсон тэрхүү мөнх бус байдлын өмнөх амьдралын тухай юм гэдгийг тайлбарла.

Судрын ярилцлага
ба хэрэглээ

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Мөнх бус байдлын өмнөх амьдралд олон сүнс мөнх бус байдал дахь өөрсдийн үүрэг зорилгуудад урьдчилан томилогдсоныг Абрахам мэдэв.

Абрахам 3:11–12, 22–23, Сургаал ба Гэрээ 138:53–57-ыг зааж, ярилц.

- Абрахам 3-т цэдэглэгдсэн үзэгдэлд, дэлхий бүтээгдэхээс өмнө Тэнгэрт болсон Зөвлөгөөнийг Их Эзэн Абрахамд үзүүлжээ. (Тэнгэр дэх Зөвлөгөөн нь ганцхан хуралдаан биш, харин цуврал хурлууд байсныг хожмын үеийн бошиглогчид харуулсныг анхааруул.) Энэ зөвлөгөөн дээр ямар хүмүүс байсан бэ? (Тэнгэрлэг Эцэг болон түүний сүнсэн хүүхдүүд) Абрахам 3:22–23-аас энэ зөвлөгөөний тухай бид юу мэддэг вэ?
- Абрахам 3:22–23-т дүрслэгдсэн “сурвалжит хийгээд агуу тэд” хэн бэ? (Бошиглогчид болон Сүмийн бусад удирдагчид) 1918 онд Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит сүнсний дэлхийн тухай үзэгдэлд “сурвалжит хийгээд агуу тэдний” заримыг нь харжээ. Ерөнхийлөгч Смит хэнийг харсан бэ? (С ба Г 138:53; мөн түүнчлэн хоёр дахь нэмэлт заах санааг үз)
- Абрахам “[тэрээр төрөхөөсөө] өмнө сонгогдсон” гэсэн нь ямар утгатай вэ? (Абрахам 3:23-ыг үз. Тэр бошиглогч байхаар урьдчилан томилогдсон байв.) Урьдчилан томилогдох гэдэг нь юу гэсэн үг вэ? (Анхаарал төвлөрүүлэх хоёр дахь үйл ажиллагаан дахь тодорхойлолтыг үз.) Сургаал ба Гэрээний 138:53-т дурдагдсан хүмүүс юу хийхийн тулд урьдчилан томилогдсон бэ? (С ба Г 138:53–56-г үз)
- Урьдчилсан томилот нь Абрахам, Иосеф Смит болон бусад хүмүүсийг бошиглогчид байхыг баталгаатай болгосон уу? Урьдчилсан томилот болон сонгох эрх хоорондоо ямар холбоотой вэ? (Хэдийгээр хүн аль нэг дуудлагад урьдчилан томилогддог ч гэсэн, тэр дуудлага нь тухайн хүний зохистой байдал хийгээд үүнийг хүлээн авах хүслээс нь хамааралтай байдаг.)
- Бошиглогчдыг тэдний дуудлагуудад урьдчилан томилохоос гадна түүний хаант улсыг олон янзын арга замаар байгуулахад туслуулахын тулд Бурхан олон “бусад сонгогдсон сүнснүүдийг” урьдчилан томилжээ. Бид юу хийхээр урьдчилан томилогдсон байж болох вэ? (С ба Г 138:56-г үз)

Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон заахдаа:

“Их Эзэний хоёр дахь ирэлтийн өмнөх эцсийн өдрүүдэд таныг байлгахын тулд Бурхан таныг хадгалан хамгаалж байгаа билээ. Зарим хувь хүмүүс урвах болно; гэвч Бурханы хаант улс өөрийн тэргүүнийг—бүр Есүс Христ эргэж ирэхийг баяртайгаар хүлээн хөдөлшгүй хэвээр үлдэх болно. Манай үеийнхэн ёс бус байдлаараа Их Эзэн газар дэлхийг үерээр цэвэршүүлсэн Ноагийн өдрүүдийнхтэй харьцуулагдах үед, энэ цаг үед их ялгаа гарах болно. Энэ бол уг хаант улсыг ялгуусан байдлаар авч явах Өөрийн зарим хамгийн хүчирхэг хүүхдүүдийг эцсийн сайн сайхан байдлын төлөө Бурхан хадгалан хамгаалсан хэрэг юм. . . .

“ . . . Энэ тухайд бүү алдаа гарга—та нар бол онцгой үеийнхэн. Бидний үе болох энэхүү богинохон хугацаанд ийм олон итгэлтнүүд хэзээ ч хүсэн хүлээгдэж байгаагүй юм” гэжээ (*The Teachings of Ezra Taft Benson* [1988], 104–5).

- Бид өөрсдийн урьдчилан томилогдсон дуудлагуудыг биелүүлж байгаадаа бид хэрхэн итгэлтэй байж чадах вэ? (Сайн мэдээгээр амьдрах, патриархын адислалуудаа судлах болоод хувийн илчлэлтийг эрэлхийлэх нь хариултууд нь юм. Эдгээр дуудлагуудыг гүйцэтгэхийн тулд бид хүсэл эрмэлзэлтэй, бас зохистой байх ёстойг ангийн гишүүдэд сануул. Мөн С ба Г 58:27–28-ыг үз)

2. Есүс Христ Тэнгэр дэх Зөвлөгөөн дээр бидний Аврагч байхаар сонгогджээ; бид түүнийг дагахаар сонгосон байлаа. Люцифер (Сатан) болон түүнийг дагасан сүнснүүд тэнгэрээс хөөгдөв.

Абрахам 3:24–28, Мосе 4:1–4-ийг зааж, ярилц.

- Тэнгэр дэх Зөвлөгөөнд Тэнгэрлэг Эцэг өөрийн авралын төлөвлөгөөг танилцуулж, бидний төлөө Аврагчийг сонгожээ. Бидний Аврагч байхаар санал болгосон хоёр сүнс хэн хэн байсан бэ? (Абрахам 3:27; Мосе 4:1-2-ыг үз) Тэдний санал болголт ямар ялгаатай байсан бэ? (Есүс Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг дагаж түүнд алдар сууг өгөхийг хүсч байв, Люцифер өөрийнхөө хувийн төлөвлөгөөг дагаж, алдар сууг өөртөө авахыг хүсч байлаа.) Тэнгэрлэг Эцэг яагаад Есүс Христийг бидний Цагаатгагч болгохоор сонгосон бэ? (Мосе 4:2–3-ыг үз)
- Тэнгэр дэх зөвлөгөөнд бид хэнийг дагахаар сонгосон бэ? Бид Есүсийг дагахаар сонгосноо яаж мэддэг вэ? (Бид бие махбодь хүлээн авахын тулд дэлхий дээр төрсөн билээ.)
- Абрахам 3:26 дахь *анхны байдал*, *хоёр дахь байдал* гэсэн нэр томъёонууд ямар утгатай вэ? (*Анхны байдал* нь мөнх бус байдлын өмнөх амьдралыг, *хоёр дахь байдал* нь бидний мөнх бус байдлыг заадаг. Люциферийн оронд Есүс Христийг дагахаар сонгосноороо бид анхны байдлаа хадгалдаг.) Бид анхны байдлаа хадгалсны улмаас бидний хүн бүр ямар адислал хүлээж авсан бэ? (Дэлхий дээр төрөх боломж) Хэрэв бид хоёр дахь байдлаа хадгалах юм бол бид ямар адислалууд хүлээж авах вэ? (Абрахам 3:26-г үз) Бид хоёр дахь байдлаа хэрхэн хадгалж чадах вэ?
- Люцифер (Сатан) болон түүнийг дагахаар сонгосон тэдэнд юу тохиолдсон бэ? Тэд тэнгэрээс хөөгдөж, бие махбодьтой болох боломж нь үгүй болжээ. Мосе 4:3; Абрахам 3:28; Илчлэлт 12:7–9; С ба Г 29:36–37-г үз)

- Сатан болон түүний дагалдагчид одоо юу хийдэг вэ? (Тэд бидний сонгох эрхийг устгахаар хичээсэн хэвээр байна. Тэд өнөөдөр дэлхий дээр биднийг нүгэл үйлдэхэд уруу татдаг муу ёрын сүнснүүд болж оршдог. Мосе 4:4-ийг үз) Сатан болон түүнийг дагалдагчид бидний сонгох эрхийг хязгаарлах буюу устгахыг хичээдэг зарим арга замууд юу вэ? Тэдний хүч чармайлтуудыг танин мэдэж, эсэргүүцэхийн тулд бид юу хийж болох вэ?
- Тэнгэр дэх Зөвлөгөөнөөр та Есүс Христийг дагахаар сонгосныг мэдэх нь танд хэрхэн тусалдаг вэ? Тэд мөнх бус байдлын өмнөх оршихуйд хийснийхээ нэгэн адил Христийг дагах шийдвэр гаргахаа үргэлжлүүлэхэд нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

Дүгнэлт

Есүс Христ болон бидний Аврагч болж, урьдчилан томилогдсон түүний үүргийн тухай гэрчлэлээ хэл. Бурханы хаант улсыг байгуулахад туслахын тулд өөрсдийн урьдчилан томилогдсон үүрэг зорилгыг гүйцэлдүүлэх ангийн гишүүдийн чадварт бат итгэдгээ илэрхийл.

Нэмэлт заах санаанууд

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

1. “Үүгээр бид тэднийг нотлох болно”

- Абрахам 3:24–25 нь Тэнгэрлэг Эцэгийн удирдлага дор Есүс Христ дэлхийг бүтээсэн гол зорилгуудын нэгнийх нь талаар өгүүлдэг. Дэлхий яагаад бүтээгдсэн бэ? Та нар энд соригдохоо мэдэж, улмаар дэлхийд ирэхээр сонгосныг мэдэх нь та нарт хэрхэн тусалдаг вэ?

2. “Агуу хийгээд хүчирхэг хүмүүс”

- Сургаал ба Гэрээний 138-д цэдэглэгдсэн үзэгдэлд Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит Христийг төрөхөөс өмнө дэлхий дээр амьдарч байсан “агуу хийгээд хүчирхэг хүмүүсийн” заримыг нь бас харжээ. Ерөнхийлөгч Смит хэн хэнийг харсан бэ? (С ба Г 138:38–49-ийг үз. Та эдгээр нэрнүүдийг самбар дээр жагсаан бичиж болно. Ням гарагийн Сургуулийн ирж буй хичээлийн жилийн туршид эдгээр хувь хүмүүсийн ихэнхийнх нь тухай ангийн гишүүд мэдэх болно гэдгийг тэмдэглэн хэл.)

Зорилго	Бурхан бүх зүйлийг бидний ашиг тусын тулд бүтээсний төлөө, түүнчлэн бид түүний дүр төрхөөр бүтээгдсэний төлөө талархахад нь ангийн гишүүдэд туслах.
Бэлтгэл	<ol style="list-style-type: none"> 1. Агуу Үнэт Сувдаас дараах судруудыг залбирч судал: <ol style="list-style-type: none"> а. Моисе 1:27–42. Моисе Бурханы бүтээлтүүдийн тухай үзэгдэл харж, дэлхийн бүтээлтийн тухай шастир бичихээр зарлиг болгогджээ. б. Моисе 2:1–25; 3:1–14. Бурхан бүх зүйлийн бүтээгч болохыг Моисе мэджээ. в. Моисе 2:26–31; 3:7, 15–25. Эрэгтэйчүүд мөн эмэгтэйчүүд Бурханы дүр төрхөөр бүтээгдсэнийг Моисе мэджээ. 2. Нэмэлт уншлага: Абрахам 4–5; Эхлэл 1–2 3. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх хоёр дахь үйл ажиллагааг сонгох бол, баримлын шавар буюу шохой авчир. 4. Хэрэв дараах үзүүлэн таниулах материалууд олддог бол, та тэдгээрийн заримыг хичээлийнхээ хэсэг болгон ашиглаж болно: <ol style="list-style-type: none"> а. “Бурханы дүр төрхөөр” <i>Old Testament Video Presentations</i> (53224)-гийн гурван минутын бичлэг. в. Бүтээлтийн зураг–Амьд Бүтээлүүд (62483; Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 100)

**Энэ хичээлийг
заах зөвлөмж**

Анхаарал
төвлөрүүлэх
үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагаа эсвэл (өөрийнхөө нэг үйл ажиллагааг) ашиглахыг хүсч болно. Ангийн хувьд хамгийн тохиромжтой үйл ажиллагааг сонгож ав.

1. Хэрэв тэд сургуулийн өмнөх насны хүүхдүүд бол дараах асуултуудын нэгийг нь хариулахын тулд хэдий хэмжээний мэдээлэл шаардагдахыг ангийн гишүүдээс асуу: Нисэх онгоц агаарт яаж тогтдог вэ? Телевизор яаж ажилладаг вэ? Ургамлууд яаж ургадаг вэ? Бидний олонхи нь сургуулийн өмнөх насны хүүхдийн ойлгох зүйлийг авч үзэн, нарийн ширийн зүйлүүдийг хүүхдийг өсч хөгжих хүртэл нь хойш тавьж, зөвхөн ерөнхий ойлголтуудыг өгдөг.
 - Эдгээр жишээнүүд Бүтээлтийн талаарх Их Эзэний илчлэлтүүдтэй хэрхэн адилхан байдаг вэ? (Зөвхөн бидний мөнх бус оюун ухаан ойлгож чадах хийгээд авралыг олохын тулд бид мэдэх хэрэгтэй тэрхүү мөнхийн үнэний хэсгийг л Их Эзэн илчлээд байгаа билээ.)

Энэ хичээл нь Бүтээлтийн талаар Их Эзэний илчилсэн үнэнүүдийг ярилцах болно.

2. Баримлын шавар буюу шохой ашиглан сайн дураараа жижигхэн амьтан хийх буюу зурахыг ангийн нэг гишүүнээс хүс (зөвхөн нэг буюу хоёр минут олго). Тэгээд бид зөвхөн амьд амьтны дүрсийг л хийж чаддаг бол, Бурхан амьдралыг бүтээж чаддаг баримтын тухай ярилц. Энэ хичээлээр дэлхийг болон үүн дээр амьдардаг юм бүхнийг Бурхан бүтээсэн тэрхүү агуу гайхамшгийн тухай ярилцах болно.

Судрын ярилцлага
ба хэрэглээ

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагауудаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Бурханы бүтээлүүдийн тухай үзэгдлийг Мосе үзэв.

Мосе 1:27–42-ыг зааж, ярилц.

- Эхлэл дэх Бүтээлтийн шастирыг хэн бичсэн бэ? (Мосе 1:40; 2:1-ийг үз) Мосе энэ шастирыг яагаад бичсэн бэ? (Мосе 1:40–41-ийг үз) Бурханы хүчний тухай бид Мосе 1:27–39-өөс юуг мэдэж болох вэ? Өөрийнхөө хүүхдүүдийг хайрладаг Бурханы хайрын тухай бид юу мэдэж болох вэ?
- Эхлэл, Мосе болон Абрахамд байдаг Бүтээлтийн шастирууд бие биенээсээ юугаар ялгаатай вэ? (Абрахам Мосе хоёр энэ дэлхийг зохион байгуулж байгааг үзэгдэлд харж, дараа нь тэдгээр үзэгдлүүдийг цэдэглэжээ. Тэд тус бүрдээ ялигүй өөр нарийн тодорхой зүйлүүдийг оруулсан байдаг. Эхлэл дэх шастир эхлээд Мосегоор бичигдсэн хэдий ч, түүний бүрэн цэдгээс зарим нь алга болжээ. Энэхүү бүрэн байдал Мосегийн номонд цэдэглэгджээ.)

2. Бурхан бүх зүйлийг бүтээснийг Мосе мэдэв.

Мосе 2:1–25; 3:1–14-ийг зааж, ярилц.

- Дэлхийг хэн бүтээсэн бэ? (Мосе 1:32; 2:1-ийг үз; мөн түүнчлэн Иохан 1:1–3, 14; Еврей 1:1–2; Мозая 3:8; С ба Г 14:9-ийг үз) Хэн Бүтээгч болохыг мэдэх нь бидний хувьд яагаад чухал вэ?
- Бүтээлтийн зорилгын талаар Бурхан юу илчилсэн бэ? (Мосе 1:39; Абрахам 3:24–25-ыг үз; мөн түүнчлэн 1Нифай 17:36; 2 Нифай 2:11–15-ыг үз. Бүтээлтийн зорилго бол Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүд тэнд ирж, бие махбодтой болж, соригдох буюу тэд түүний оршихуйгаас ангид байх үедээ түүнийг дуулгавартай дагах нь уу гэдгийг харах тийм газар бий болгох явдал байв. Итгэлтэй хүмүүс мөнх амьдрал хүлээн авах болно. Бүтээлтийн шастир нь Эхлэлийн номонд агуулагддаг хэдий ч, Бүтээлтийн зорилго болоод ач холбогдол зөвхөн хожмын үеийн илчлэлтэд тайлбарлагддагийг та тэмдэглэн хэлж болно.)
- Дэлхийн амьдрал биднийг ямар арга замаар мөнх амьдралд бэлтгэдэг вэ? (Хариултууд нь гэвэл: Бид бие махбодь хүлээн авдаг, өөрсдийн сонгох эрхийг ашиглаж, мэдлэг хуримтлуулж суран, гэр бүлтэй болж, ёслолууд хүлээн авч, бас гэрээнүүд хийдэг.)

- Бүтээлтийн үр дүнгүүдийн талаар Бурхан юу гэж хэлсэн бэ? (Мосе 2:4, 10, 12, 18, 21, 25, 31; 3:2-ыг үз. Бүтээлтийн богино шастирт Бурхан өөрийнх нь ажил сайн байсан хэмээн 8 удаа мэдэгджээ.) Бурханы бүтээлүүдээс аль нь та нарт онцгой сайхан бэ? Бүтээлтийн сайхныг өдөр бүр илүү анхааралтайгаар ажиглах нь яагаад бидэнд ашиг тустай байдаг вэ?
- Дэлхий оргүй хоосноос бүтээгдсэн үү? (Абрахам 3:24; 4:1-ийг үз)
 “Бүтээх гэдэг үг *baugau* гэдэг [еврей] үгнээс гаралтай бөгөөд энэ нь оргүй хоосноос бүтээх гэсэн утгатай биш юм; энэ нь зохион байгуулах гэсэн утгатай ажээ; хүн материалуудыг зохион байгуулж, хөлөг онгоц барьдагтай яг ижил юм. Ингэхлээр, эмх замбараагүй юмнаас—эмх замбараагүй материас дэлхийг зохион байгуулах материалууд Бурханд байжээ хэмээн бид дүгнэлт хийдэг” гэж Бошиглогч Иосеф Смит хэлжээ (*Teachings of the Prophet Joseph Smith*, эмхтгэсэн Joseph Fielding Smith [1976], 350–51).
- Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийн талаарх та нарын бодол санаанд Бүтээлтийн шастир хэрхэн нөлөөлдөг вэ? Бүтээлтүүд Бурханы тухай хэрхэн “гэрчилдэг” вэ? (Мосе 6:63; Алма 30:44-ийг үз) Бүтээлтийн бэлгийн төлөө бид талархлаа хэрхэн харуулж чадах вэ?

3. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд Бурханы дүр төрхөөр бүтээгдсэнийг Мосе мэдэв.

Мосе 2:26–31; 3:7, 15–25-ыг зааж, ярилц.

- Бид хэний дүр төрхөөр бүтээгдсэн бэ? (Мосе 2:26–27-ийг үз)
 Тэргүүн Зөвлөл хэлэхдээ: “Бүх эрэгтэйчүүд мөн эмэгтэйчүүд ертөнц дахины Эцэг хийгээд Эхтэй адил юм, тийнхүү Бурханы шууд хөвгүүд, охид нь билээ” гэжээ (“The Origin of Man,” *Improvement Era* “ 1909, 78).
- Бид Бурханы дүр төрхөөр бүтээгдсэнийг мэдэх нь бидний амьдралыг хэрхэн адисалж чадах вэ? Энэ нь бусад хүмүүстэй харилцах бидний харилцаанд хэрхэн нөлөөлж болох вэ?
- Бурхан бидний хүн нэг бүрд тусгайлан анхаарал тавьдаг тухай Мосе 7:3 дахь Енохын үгс юу заадаг вэ? Бидний Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрын тухай эдгээр үгс бидэнд юу заадаг вэ?
- Энэ дэлхий дээрх түүний бүтээлүүдийн дээр бид эзэгнэлтэй байхыг тэрээр бидэнд хэлэх үедээ Их Эзэн юу гэж хэлсэн гэж та нар боддог вэ? (Мосе 2:26-г үз. Бид дэлхийг хүндэтгэж, Бурханы бүтээлүүдэд анхаарал халамж тавих хэрэгтэй) Бид бүтээлүүд дээр эзэгнэлтэй байх хариуцлагаа хэрхэн илүү сайнаар хэрэгжүүлж чадах вэ?

Дүгнэлт

Өөрийн чинь заасан зарчмууд үнэн болох тухай гэрчлэлээ хэл. Бүтээлтийн тухай бодол санаагаа хуваалцахад ангийн гишүүдийг урь.

Нэмэлт заах санаанууд

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

Бүтээлтийн үргэлжлэх хугацаа

Бүтээлтэд шаардагдсан, үүний үргэлжилсэн хугацаа мэдэгддэггүй. Бүтээлтийн тухай судрын шастирт өгүүлэгддэг *өдөр* гэдэг нэр томъёо нь 24 цагаар хэмжигдэх хугацааг төлөөлдөггүй. *Үот* гэдэг еврей үг “өдөр” “цаг” буюу “хугацаа” гэдэг үгсээр орчуулагдаж болдог. “Эзэний хувьд нэг өдөр нь мянган жил мэт” хэмээн Төлөөлөгч Паул хэлсэн байдаг (2 Петр 3:8; мөн Абрахам 3:4-ийг үз).

“Зөрчлийн минь улмаас нүд минь нээгдсэн юм”

Моце 4; 5:1–15; 6:48–62

Зорилго

Уналт бол бидэнд зориулсан Тэнгэрлэг Эцэгийн Төлөвлөгөөний зайлшгүй чухал хэсэг байсныг ойлгоход нь ангийн гишүүн бүрд туслах.

Бэлтгэл

1. Дараах судруудыг залбирч судал:
 - а. Моце 4; 5:10–11; 6:48–49, 55–56. Сатан Еденийн Цэцэрлэгт ирж, Еваг мэхлэхийг эрэлхийлэв. Ева, Адам хоёр сайн ба муугийн мэдлэгийн модны жимснээс хүртэв (4:5–12). Адам, Ева хоёр унаж, цэцэрлэгээс хөөгдөв (4:13–31). Адам, Ева хоёр хожим нь Уналтын адислалуудад баясав (5:10–11). Уналтын үр нөлөөнүүдийн талаар Енох заав (6:48–49, 55–56).
 - б. Моце 5:14–15; 6:50–54, 57–62. Есүс Христийн Цагаатгалын улмаас мөнх бус хүмүүс Амилуулалтаар дамжин биеийн үхлээс аврагддаг бөгөөд мөн итгэл, наманчлал, баптисм, Ариун Сүнсний бэлэг, зарлигуудад дуулгавартай байснаар сүнсний үхлээс аврагдаж болно.
 - в. Моце 5:1–9, 12. Адам Ева хоёр мөнх бус хүмүүс болж, амьдралыг эхлэв. Тэд хүүхдүүдтэй болж, өөрсдийн сурсан үнэнүүдийг тэдэнд заадаг байв (5:1–4, 12). Төрсөн Ганцын золиослолтой адил төстэй золиослолуудыг Адам санал болгов (5:5–9).
2. Нэмэлт уншлага: Эхлэл 2–3; 1 Коринт 15:20–22; 2 Нифай 2:5–30; 2 Нифай 9:3–10; Хиламан 14:15–18; Сургаал ба Гэрээ 19:15–19; 29:34–44; Итгэлийн Тунхаг 1:2;
3. Та Адам Ева хоёрын Уналтын (Моце 5:5–9) шастирыг товчлон бэлтгэхийг ангийн нэг гишүүнээс, мөн золиослолууд санал болгож байгаа Адамын тухай шастирыг (Моце 4:6–31) товчлон бэлтгэхийг ангийн өөр нэг гишүүнээс хүсч болно.
4. Хэрэв дараах үзүүлэн таниулах материалууд байгаа бол, та тэдгээрийн заримыг хичээлийнхээ нэг хэсэг болгон ашиглаж болно:
 - а. *Old Testament Video Presentations* (53224)-гийн “The Fall,” зургаан минутын бичлэг.
 - б. Адам Ева хоёрын зураг (62461; Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 101).


Энэ хичээлийг заах зөвлөмж

Анхаарал
төвлөрүүлэх
үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагааг (эсвэл өөрийнхөө үйл ажиллагаануудын нэгийг) ашиглахыг хүсч болно.

Хуудас 13 дээрх зургийг самбар дээр зур. “Бурханлиг гурван үйл явдал— үүрд мөнхийн гурван баганын” улмаас бидний аврал боломжтой болсон юм хэмээн Ахлагч Брюс Р.МкКонки хэлснийг ангийн гишүүдэд ярь (A New Witness for the Articles of Faith [1985], 81). Тэгээд дараах асуултыг асуу:

- Авралыг боломжтой болгосон “үүрд мөнхийн багананууд” байхад хангалттай тийм чухал зарим үйл явдлууд юу вэ? (Эдгээр багананууд бол бидний авралын төлөөх Бурханы төлөвлөгөөний бүх хэсэг болох Бүтээлт, Уналт, Цагаатгал мөн хэмээн Ахлагч МкКонки хэлжээ. *Бүтээлт, Уналт, Цагаатгал* гэсэн үгсийг самбар дээр гурван багана болгон бич)



Уналт бол бидний үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг тохиолгон авчрах Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний зайлшгүй чухал хэсэг байсныг ойлгоход энэ хичээл бидэнд туслах болно гэдгийг тайлбарла (Мосе 1:39).

Судрын ярилцлага
ба хэрэглээ

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Адам Ева хоёрын Уналт, хүмүүст болон бидэнд үзүүлсэн үүний үр нөлөө

Мосе 4; 5:10–11; 6:48–49, 55–56-г зааж, ярилц.

Еденийн Цэцэрлэгт Бурхан Адам Ева хоёрт, “үр жимстэй байж, мөн өсөн үржиж, дэлхийг бүрхтүгэй” хэмээн зарлиглажээ (Мосе 2:28). Тэрээр бас сайн ба муугийн мэдлэгийн модны жимснээс идэхгүй байхыг тэдэнд зарлигласан аж (Мосе 3:17) Тэд хориглогдсон жимснээс хүртэхгүй хичнээн уднав, тэр чинээгээр уг цэцэрлэгт үлдэж, үхэхгүй байж болох байв. Гэвч тэд өсөн үржих тухай зарлигийг дуулгавартай даган биелүүлэх боломжгүй болох байв (Мосе 5:11; 2 Нифай 2:23). Тэнгэрлэг Эцэг энэ хоёр зарлигаас сонгох эрхийг тэдэнд олгожээ.

Мосе 4:6–31-ээс Адам Ева хоёрын Уналтын тухай цэдгийг товчхон нэгтгэн дүгнэ, эсвэл ангийн томилогдсон нэг гишүүнээр үүнийг хийлгэ.

- Уналтын үр нөлөө нь Адам Ева хоёрын хувьд—бидний хувьд юу байсан бэ? (Мосе 4:22–29; 5:10–11; 6:48–49, 55–56; 2 Нифай 2:22–23; 9:6; Эхлэл 3:16–23-ыг үз) Эдгээр үр нөлөөнүүдээс та заримыг нь самбар дээр жагсаан бичиж болно. Уналтын тухай эдгээр үнэнүүдээс олон нь Бошиглогч Иосеф Смитээр дамжин сэргээгдсэн бөгөөд дэлхий нийтэд мэдэгдээгүй билээ.

- а. Адам Ева хоёр хүүхдүүдтэй болох боломжтой байсан нь дэлхийд ирж, мөнх бус биетэй болох боломжийг бидэнд олгосон юм (Мосе 5:11; 6:48; 2 Нифай 2:23, 25).
- б. Бид биеийн үхэл буюу бие махбодь сүнснээс салахыг биеэрээ амсдаг (Мосе 4:25; 6:48; 2 Нифай 9:6).
- в. Бид сүнсний үхэл буюу Бурханы оршихуйгаас салахыг биеэр амсдаг (Мосе 4:29; 6:49; 2 Нифай 9:6).
- г. Бид бол зовлон, гасланг хүртэгчид юм (Мосе 6:48; Эхлэл 3:16–17).
- д. Бид нүгэл үйлдэх чадвартай (Мосе 6:49, 55; 2Нифай 2:22–23).
- е. Газар зүхэгдсэн нь биднийг ажиллах шаардлагатай болгосон юм (Мосе 4:23–25; Эхлэл 3:17–19).
- ё. Бид сайн ба мууг ялган таньж чадна (Мосе 4:28; 6:55–56; 2 Нифай 2:23; Эхлэл 3:22).
- ж. Үхэшгүй байдалд бид баяр баясгалантай байж чадна (Мосе 5:10; 2 Нифай 2:23, 25).
- з. Бид гэтэлгэлийнхээ баяр баясгаланг мэдэж чадна (Мосе 5:11).
- и. Бид мөнх амьдрал олж авч чадна (Мосе 5:11).

Та нар Уналтын эдгээр үр нөлөөнүүдийн тухай ярилцахдаа, Уналт бидний хувьд ямар ашиг тустайг онцгойлон анхаар. Бүр Бүтээлтээс өмнө Тэнгэрлэг Эцэг манай дэлхийн амьдралыг бидний хувьд сорилтын хийгээд өөрсдийгөө нотлон харуулах хугацаа байхаар төлөвлөснийг хожмын үеийн илчлэлт тодруулсан бөгөөд иймээс бид түүнтэй илүү адилхан болж чадна (Абрахам 3:24–26). Бид мөнх бус хүмүүс байж, Уналтаар дамжин боломжтой болсон, сайн ба муугийн аль нэгийг сонгож сурах чадвартай байхыг энэ нь биднээс шаарддаг билээ.

- Уналтын тухай зөв ойлголт нь мөнх бус байдлын үед бидэнд хэрхэн тусалж чадах вэ?
- Бурхан Уналтыг угтан харсан бөгөөд энэ нь бидний авралын төлөөх түүний төлөвлөгөөний салшгүй чухал хэсэг байсныг ойлгох нь яагаад чухал вэ?
- Адам Ева хоёрыг хориглогдсон жимснээс идүүлснээрээ тэрээр Бурханы төлөвлөгөөг тасалдуулна хэмээн Сатан найдаж байжээ (Мосе 4:6). Бурханы зорилгуудыг тасалдуулах Сатаны чадварын талаар Уналтын шастир бидэнд юу заадаг вэ? (С ба Г 3:1–2-ыг үз)

2. Есүс Христийн Цагаатгал биднийг биеийн болон сүнсний үхлээс авардаг.

Мосе 5:14–15; 6:50–54, 57–62-ыг зааж, ярилц.

Адам Ева хоёрын Уналт биеийн болон сүнсний үхлийг дэлхийд авчирсан юм. Биеийн үхэл бол бидний мөнх бус амьдралын төгсгөлд тохиодог бие, сүнс хоёрын салалт юм. Сүнсний үхэл бол Адам Ева хоёр Еденийн Цэцэрлэгээс хөөгдөх үед тохиосон Бурханы оршихуйгаас салах буюу тусгаарлагдах явдал мөн. Бид өөрсдөө үхлийг даван туулж чадахгүйг тайлбарла. Энэ шалтгааны улмаас түүний цагаатгагч золиослолоор дамжуулан биднийг үхлээс гэтэлгэхийн тулд Тэнгэрлэг Эцэг Өөрийн Төрсөн Ганц Хүүг илгээсэн билээ (Алма 22:14).

- Бошиглогчид Адам Ева хоёрын Уналтын тухай заахдаа Есүс Христийн Цагаатгалын талаар олонтаа заадаг (Мосе 5:10–15; 6:48–62; 2 Нифай 9:6–10). Уналтын хамтаар Цагаатгалыг заах нь яагаад чухал вэ? (Уналт нь Цагаатгалыг бидний авралын төлөөх Бурханы төлөвлөгөөний салшгүй хэсэг болгосон юм. Цагаатгалыг Уналттай хамт заах нь бид биеийн болон сүнсний үхлээс хэрхэн аврагддагийг ойлгоход бидэнд тусалдаг.)

Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон хэлэхдээ: “Гэтэлгэлийн төлөвлөгөө нь Адамын Уналтын шастираар эхлэх ёстой. Моронайн үгсээр бол, ‘Адамаар хүмүүний уналт ирсэн. Мөн хүмүүний уналтын улмаас Есүс Христ . . . ирсэн, мөн Есүс Христийн улмаас хүмүүний гэтэлгэл ирсэн буюу’ (Мормон 9:12). Хүн зөвхөн өлсөх хүртлээ хоолыг үнэхээр хүсдэггүй шиг, Христ яагаад түүнд хэрэгтэйг тэрээр мэдэх хүртлээ Христийн авралыг хүсдэггүй. Уналтын сургаал болон бүх хүн төрөлхтөнд үзүүлдэг үүний нөлөөг ойлгож, хүлээн авах хүртлээ Христ яагаад өөрт нь хэрэгтэйг нэг ч хүн зохих ёсоор нь мэддэггүй” гэжээ (Conference Report, 1987 оны 4-р сар, 106; *Ensign*, 1987 оны 5-р сар, 85).

- Бид биеийн үхлээс хэрхэн аврагдаж чадах вэ? (1 Коринт 15:20–22; 2 Нифай 2:8; 9:6-г үз. Есүс Христийн Цагаатгалаар дамжин бид амилуулагдах болно.)
- Бид сүнсний үхлээс хэрхэн аврагдаж чадах вэ? (Мосе 5:14–15; 6:50–52, 59; Хиламан 14:15–18; С ба Г 19:15–19-ийг үз. Цагаатгалын улмаас бид Есүс Христэд итгэх итгэл, наманчлал, баптисм, Ариун Сүнсний бэлэг, түүнчлэн зарлигуудад дуулгавартай байхаар дамжуулан бид цэвэр ариун, зохистой болгогдож Бурхантай хамт байж чадна.)

Мормоны Номны бошиглогч Иаков Аврагчийн цагаатгал золиослолоор дамжин ирдэг үхлийн гэтэлгэлд баяссан байдаг (2 Нифай 9:10). Та энэ хэсгийг уншиж, өөрийн гэрчлэл болон Цагаатгалаар дамжуулан бидний хүлээн авдаг адислалуудын тухай өөрийн зарим санаа бодлыг хуваалцаж болно. Мөн ингэхэд ангийн гишүүдийг урь.

3. Адам Ева хоёр мөнх бус хүмүүс болж амьдралаа эхлэн хүүхдүүд төрүүлж, тэдэнд сайн мэдээг зааж, Бурханыг шүтэн биширч, дуулгавартай дагаж байлаа.

Мосе 5:1–9, 12-ыг зааж, ярилц.

- Еденийн Цэцэрлэгээс хөөгдсөнийхөө дараа Адам Ева хоёр юу хийсэн бэ? (Мосе 5:1–5, 12-ыг үз) Ямар талаараа Адам Ева хоёрын амьдрал өнөөгийн бидний амьдралтай адилхан байсан бэ? Бидний мөнх бус амьдралын зорилгуудын талаар бид Мосе 5:1–9, 12-оос юу мэдэж болох вэ?
- Мосе 5:5–9 дахь шастирыг давтаж буюу эсвэл үүнийг ангийн нэг томилогдсон гишүүнээр хийлгэ. Их Эзэн Адамд ямар зарлиг өгсөн бэ? (Мосе 5:5-ыг үз) Бүр тэрээр үүнийг хийхийн шалтгааныг мэдэхгүй байсан атлаа Адам яагаад тахил өргөсөн бэ? (Мосе 5:6-г үз)

“Үйл явдал болж өнгөрснөөс хойш урт удаан хугацаанд үүний шалтгааныг бид ойлгохгүй байж болох ч гэсэн . . . Бурханы шаардсан юу ч гэсэн зөв байдаг. . .” гэж Бошиглогч Иосеф Смит хэлжээ (*Teachings of the Prophet Joseph Smith*, эмхтгэсэн Joseph Fielding Smith [1976], 256).

- Их Эзэний зарлигуудын бүх шалтгааныг бид мэдэхгүй байлаа ч гэсэн, тэдгээрийг дуулгавартай дагах нь яагаад чухал вэ? Өөрсдийнхөө бүрэн ойлгоогүй зарлигийг сахьсны төлөө та нар хэрхэн адислагдсан бэ?
- Адамын өргөсөн тахилуудын зорилго юу байсан бэ? (Моше 5:7–9-ийг үз. Тэдгээр нь Тэнгэрлэг Эцэг Өөрийн Төрсөн Ганцын талаар хийсэн золиослолтой адил буюу төстэй байлаа. Ийм байдлаар тахил өргөх нь Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан бүх мөнх бус хүмүүс уналтаас гэтэлгэгдэж болох тухай Адам болон түүний үр удамд өгсөн сануулга байв.) Энэ сургаалын ямар сануулгууд бидэнд өгөгдсөн бэ? Уналт хийгээд Цагаатгалын төлөөх талархлаа бид хэрхэн харуулж чадах вэ?

Дүгнэлт

Уналтын адислалуудын тухай Евагийн гэрчлэлийг дахин унш (Моше 5:11). Адам, Ева хоёрын үйлдлийн төлөө, Уналтын төлөө, түүнчлэн Есүс Христийн Цагаатгалын төлөө талархал илэрхийл.

Нэмэлт заах санаанууд

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

1. Хориглогдсон жимснээс хүртсэн нь нүгэл байгаагүй

Адам, Ева хоёр хориглогдсон жимснээс хүртсэн нь нүгэл байгаагүй гэдгийг тайлбарлан тусал, Ахлагч Даллин Х.Өүксийн дараах мэдэгдлийг унш:

“Үхэшгүй байдлын нөхцөлийг санаачлахын тулд Еденийн хязгаарлалтыг эхлээд зөрчсөн нь Ева байлаа. Түүний үйлдэл, энэ үйлдлийнх нь мөн чанар албан ёсоор зөрчил байсан хэдий ч, мөнх амьдрал уруу хөтлөх үүд хаалгыг нээх мөнхийн алдар суут, зайлшгүй чухал алхам байлаа. Мөн үүнийг хийснээрээ Адам өөрийн мэргэн ухааныг харуулсан юм. . . .

“. . . Бид Евагийн үйлдлийг тэмдэглэж, Уналт хэмээн нэрлэгдсэн агуу үйл хэрэгт түүний харуулсан мэргэн ухаан хийгээд эрэлхэг зоригт хүндэтгэл үзүүлдэг билээ. . . . Ахлагч Иосеф Фиелдинг Смит хэлэхдээ: “Энэхүү уналтад Евагийн гүйцэтгэсэн үүргийг би хэзээ ч нүгэл хэмээн хэлж байгаагүй, түүнчлэн би Адамыг ч нүгэлд буруутгадаггүй. . . . Энэ бол хуулийг зөрчсөн болохоос биш, нүгэл биш’ . . . гэжээ.

“Нүгэл ба зөрчлийн хоорондох энэхүү эсрэг тэсрэг утга санааг Итгэлийн хоёр дахь тунхагт: “Адамын зөрчлийн улмаас бус, хүмүүн өөрсдийнхөө нүглүүдийн улмаас шийтгэгдэх болно гэдэгт бид итгэдэг” (онцлон тэмдэглэлт нэмэгдсэн) хэмээн энэ үгийг хянуураар хэрэглэхийг бидэнд сануулдаг. Энэ нь бас хуулин дахь адил төстэй ялгааг тусган харуулдаг. Аллага мэтийн зарим үйлдлүүд гэмт хэрэг байдаг, учир нь гэмт хэрэг бол угаасаа буруу юм. Зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа явуулах гэх мэтийн бусад үйлдлүүд нь зөвхөн хууль зүйн хувьд хориглогдсон учраас л гэмт хэрэг болдог. Эдгээр ялгаануудын улмаас Уналтыг бий болгосон үйлдэл нь—угаасаа буруу—нүгэл биш, харин энэ нь албан ёсоор хориглогдсоны улмаас буруу зүйл—зөрчил байсан юм. Эдгээр үгс ямар нэг ялгаатай зүйлийн утгыг илэрхийлэхэд төдийлөн хэрэглэгддэггүй ч гэсэн, энэ ялгаа нь Уналтын нөхцөл байдалд утга учиртай юм” (Conference report, 1993 оны 10-р сар, 98; *Ensign*, 1993 оны 11-р сар, 73).

2. Уналтын үр дагаврууд болон Уналтын төлөөх үүрэг хариуцлагын хоорондох ялгаа

Адам Ева хоёрын бүх үр удам Уналтын үр дагавруудыг, түүний дотор биеийн болон сүнсний үхлийг өвлөн авсан, харин Уналтын төлөөх үүрэг хариуцлагыг өвлөж аваагүй юм. Итгэлийн хоёр дахь тунхаг “Адамын зөрчлийн улмаас бус, хүмүүн өөрсдийнхөө нүглүүдийн улмаас шийтгэгдэх болно” гэдгийг заадаг. Мөн Моронай 8:5–23-ыг үз.

3. “Хүсэл чинь нөхөрт чинь байх болно”

“Хүсэл чинь нөхөрт чинь байх болно, мөн тэрээр чамайг захирах болно” (Моисе 4:22) хэмээн Евад хэлсэн Их Эзэний мэдэгдлийг ойлгоход нь дараах мэдэгдлүүд ангийн гишүүдэд тусалж болно.

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл хэлэхдээ: “Захирах гэдэг үгийн талаар надад асуулт байна. Энэ үг буруу сэтгэгдэл төрүүлдэг. Тэргүүлэх гэдэг үгийг хэрэглэх нь дээр гэж би үзнэ, учир нь энэ бол түүний хийдэг зүйл. Зөв шударга нөхөр гэргий болоод гэр бүлээ тэргүүлдэг шүү дээ” гэжээ (“The Blessings and Responsibilities of Womanhood,” *Ensign*, 1976 оны 3-р сар, 72).

Ахлагч М.Рассел Баллард хэлэхдээ: “Эрэгтэйчүүд санваар хүлээн авч, эцгүүд болж, Аврагч Сүмийг удирддаг шиг тийм зөв шударга байдлаар эелдэг найрсаг, цэвэр, чин үнэнч хайраар гэр бүлээ удирдаж, тэжээн тэтгэх ёстойг Бурхан өөрийн бошиглогчдоор дамжуулан илчилсэн юм” гэжээ (Ефес 5:23-ыг үз), (“Equality through Diversity,” *Ensign*, 1993 оны 11-р сар, 90).

“Хэрэв чи сайн хийх аваас, чи хүлээн авагдах болно”

Моисе 5–7

Зорилго

Христийг дагах сонголтууд нь эрх чөлөө, аз жаргал, мөнх амьдрал уруу хөтөлдөг бол Сатаныг дагах сонголтууд гай зовлон, боолчлол уруу хөтөлдгийг ойлгоход нь ангийн гишүүдэд туслах.

Бэлтгэл

1. Агуу Үнэт Сувдаас дараах судруудыг залбирч судал:

- а. Моисе 5:16–41. Каин Бурханаас илүүгээр Сатаныг хайрлаж, Их Эзэнд өргөл өргөх Сатаны зарлигийг дуулгавартай дагав (5:16–19). Их Эзэн Каины өргөлөөс татгалзаж, наманчлахыг Каинд зарлиглав (5:20–25). Каин Сатантай гэрээнд орж, Абелыг алав (5:26–33). Их Эзэн Каиныг зүхэж, тэгээд Каин Их Эзэний оршихуйгаас таслагдав (5:34–41).
- б. Моисе 6:26–63. Адамын дөрөв дэх ачинцар Енох хүмүүст наманчлалыг номлохоор Их Эзэнээр дуудагдав (6:26–36). Енох Их Эзэний зарлигийг дуулгавартай дагаж хүмүүст заав (6:37–63).
- в. Моисе 7:13, 17–21, 23–47, 68–69. Уулс нүүлгэгдэж, голууд урсгалаа өөрчлөн, бүх үндэстнүүд үлэмж эмээхээр Енохын итгэл тийм агуу байв (7:13, 17). Дэлхий дээрх хүмүүсийн ёс бусын учир Их Эзэн, Енох хоёр уйлан хайлав (7:23–47). Енохын хотын хүмүүс Их Эзэнтэй нэг зүрх сэтгэлтэй, нэг оюун ухаантай байж, бүх хотоороо тэнгэрт аваачигджээ (7:18–21, 68–69).

2. Нэмэлт уншлага: Моисе 5:42–55; 6:10–23; 7:14–16, 59–64; 2 Нифай 2:25–27; Эхлэл 4:1–16.

Энэ хичээлийг заах зөвлөмж

Анхаарал
төвлөрүүлэх
үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагааг (эсвэл өөрийнхөө нэг үйл ажиллагааг) ашиглахыг хүсч болно.

Хичээлийн өмнө, дараах хоёр мэдэгдлийг самбар дээр зэрэгцүүлэн бич:

Жишээ 1	Жишээ 2
“Миний мэдэх ёстой тэр Их Эзэн чинь хэн бэ?”	“Тэр бол миний Бурхан, бас чиний Бурхан”
“Би эрх чөлөөтэй боллоо”	“Яагаад та нар өөрсдөдөө зөвлөдөг хэрнээ, тэнгэрийн Бурханыг үгүйсгэнэ вэ?”
“Би дүүгийнхээ харгалзагч юм уу?”	“Та нар бол миний ах нар”

Энэ хоёр жагсаалт дахь мэдэгдлүүдийг хичээл дээр тэдний мэдэж авах хоёр хүн хийснийг ангийн гишүүдэд хэл. Хийсэн мэдэгдлүүд дээр нь тулгуурлан энэ хоёр хүн тус бүрийн талаар тэд юу хэлж чадахыг нь ангийн гишүүдээс хүс. (Та ангийн гишүүдийг жижиг бүлгүүд болгон хувааж, мэдэгдлүүдийг хэлэлцүүлж болно. Бүлгүүд мэдэгдлүүдийг тав, зургаан минут ярилцсаны дараа, бүлэг бүрээс нэг хүнээр ангийн үлдсэн гишүүдийн өмнөөс уг бүлгийн ярилцлагыг нэгтгэн дүгнүүл)

Ангийн гишүүд хариулахад, эхний жишээн дэх мэдэгдлүүдийг Сатаныг дагахаар сонгосон Каин хийснийг тайлбарла. Хоёр дахь жишээн дэх мэдэгдлүүдийг Их Эзэнийг дагахаар сонгосон Енох хийсэн ажээ. Хүн тус бүрийн мэдэгдлүүд нь Бурханд хандах түүний хандлагыг тусгаж байна.

Судрын ярилцлага
ба хэрэглээ

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагауудаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Каин Сатантай гэрээнд орж, Абелыг алаад, ийн Их Эзэнээр зүхэгдэв.

Моше 5:16–41-ийг зааж, ярилц.

- Хүү Каин нь өөрсдийнх нь нэгэн адил Их Эзэнийг дагах болов уу хэмээн Адам Ева хоёр найдаж байв. Гэвч Каин эцэг эхээ болон Их Эзэнийг “анхааран сонссонгүй,” тэгээд, “Миний мэдэх ёстой тэр Их Эзэн чинь хэн бэ?” хэмээн тэр асуужээ (Моше 5:16). Бурханд хандах Каины хандлагын талаар энэ асуулт юу харуулж байна вэ? Бурханыг мэдэхийн тулд бид юу хийх ёстой вэ? (Алма 22:17–18-ыг үз)
- Каин яагаад Их Эзэнд өргөл өргөсөн бэ? (Моше 5:18-ыг үз) Каин юу өргөсөн бэ? (Моше 5:19-ийг үз) Их Эзэн яагаад Абелын өргөсөн тахилыг хүлээн авснаа Каины өргөлийг хүлээж аваагүй вэ? (Моше 5:5, 20–23-ыг үз. Сүргийнхээ ууган төлүүдийг өргөл болгон өргөж байхыг Их Эзэн Адам Ева хоёр болон тэдний хүүхдүүдэд зарлиглажээ. Абел дуулгавартай дагасан боловч, Каин Сатаны үгст анхаарал тавьж, газрын үр жимс өргөл болгов.) Их Эзэний зарлигласан замаар тахил өргөх нь яагаад чухал байсан бэ?

“Абел сүргийнхээ ууган төлүүдийг Бурханд тахил болгон өргөсөн нь хүлээн авагджээ. Каин газрын жимс өргөн барьсан нь хүлээн авагдсангүй, учир нь тэр үүнийг итгэлээр үйлдэж чадсангүй. . . . Хүмүүнийг цагаатгахын төлөө Төрсөн Ганцын цусыг урсгах нь . . . гэтэлгэлийн төлөвлөгөө байв; . . . тийнхүү үүгээр хүмүүн Бурханы бэлтгэсэн агуу Золиослолыг ялган таних учиртай золиослолын хэв шинж бий болгогджээ; үүний эсрэгээр тахил өргөхөд, энд итгэл байж чаддаггүй . . . ; үүний улмаас Каин итгэлтэй байж чадаагүй аж; иймээс итгэл биш юу ч гэсэн нүгэл байдаг” хэмээн Бошиглогч Иосеф Смит заажээ (*Teachings of the Prophet Joseph Smith*, эмхтгэсэн Joseph Fielding Smith [1976], 58).

- Их Эзэн түүний тахилыг хүлээн авалгүй, түүнийг наманчлалд дуудахад Каин хэрхэн хариу үйлдэл үзүүлсэн бэ? (Моше 5:21, 26-г үз) Наманчлалд дуудагдах нь зарим үед бидэнд яагаад хэцүү байдаг вэ? Бид илүү наманчлагч зүрх сэтгэлийг хэрхэн хөгжүүлж чадах вэ?

- Каин дүү Абелыгаа алсны дараа, “Би эрх чөлөөтэй боллоо” гэж хэлжээ (Моисе 5:33). Каин юугаар эрх чөлөөтэй болсон гэж итгэсэн гэж та нар боддог вэ? Бурханы зарлигуудыг дуулгавартай дагахгүй байх нь хэрэг дээрээ хэрхэн бидний эрх чөлөөг хумьдаг вэ? Дуулгавартай байдал бидний эрх чөлөөг хэрхэн нэмэгдүүлдэг вэ?
- Абел хаана байна гэж Их Эзэнийг асуухад Сатан юу гэж хариулсан бэ? (Моисе 5:34-ийг үз) Дүүгийнхээ манаач байх гэдэг нь юу гэсэн үг вэ? (1 Иохан 3:11, 17–18) Ямар арга замуудаар бид ах, эгч, дүүсийнхээ манаач болон ажиллаж чадах вэ?

“Найзыгаа ганцааранг нь орхи хэмээн өнөөдөр дэлхий та нарт хэлдэг. Тэрээр, өөрт нь таалагдсаны дагуу ирж, очих эрхтэй шүү дээ. Сүмд эсвэл санваартны цуглаанд оролцох хатуу үзэл бодол, эсвэл муу дадал зуршлыг орхих нь гутрал хийгээд эвгүй дарамт руу хөтөлдөг хэмээн өнөөдөр дэлхий та нарт хэлдэг; гэвч би Их Эзэний үгийг би дахин давтъя: Та нар бол ах дүүсийнхээ манаач нар, иймээс та нар хөрвүүлэгдсэн үедээ ах дүүгээ бэхжүүлэх үүрэгтэй” гэж Бишоп Роберт Л.Симпсон хэлжээ (Conference Report, 1971 оны 10-р сар, 114; *Ensign*, 1971 оны 12-р сар, 103).

- Бурханы оронд Сатаныг дагахаар сонгосных нь хариуд Каинд юу тохиолдсон бэ? (Моисе 5:23–25, 36–41-ийг үз) Каины сонголт үр удамд нь болон түүнчлэн өөрт нь хэрхэн нөлөөлсөн бэ? (Моисе 5:41–43, 49–52, 55-ыг үз) Бидний зөв шударга хийгээд зөв шударга биш сонголтууд гэр бүлийн гишүүдэд маань хэрхэн нөлөөлж болох вэ?

2. Енох хүмүүст наманчлалыг номлов.

Моисе 6:26–63-ыг зааж, ярилц.

- Тэрээр хүмүүст наманчлалыг номлохоор Их Эзэнээр дуудагдсан үедээ Енох хэрхэн хариу үйлдэл үзүүлсэн бэ? (Моисе 6:31-ийг үз) Хэрэв Енох зарлигласны дагуу урагш явбал Их Эзэн түүнд юу амласан бэ? (Моисе 6:32–34-ийг үз) Их Эзэн өөрийн удирдагчдыг хэрхэн сонгодог тухай Енохын өгүүллээс бид юу сурч болох вэ? (1 Самуел 16:7-г үз) Бид бүр үүнийг чадахгүй болов уу гэж бодож байсан ч, Их Эзэнд үйлчлэх тухайд бид Енохоос юу сурч болох вэ?
- Енох наманчлалыг номлож эхлэхэд хүмүүс яагаад гомдсон гэж та нар боддог вэ? (Моисе 6:37; түүнчлэн 1 Нифай 16:2; Мозая 13:7-г үз) Хэдийгээр тэд гомдсон ч гэсэн, яагаад түүнийг сонсохоо үргэлжлүүлсээр байсан бэ? (Моисе 6:38–39-ийг үз. Эхлээд тэд ердөө л сониучирхаж байсан ч, тэрбээр Бурханы хүн байсныг тэд мэдсэн ажээ) Амьд бошиглогч бол Бурханы хүн мөн гэдэг гэрчлэлийг бид хэрхэн олж авч чадах вэ? Бүр бошиглогчийн заадаг зүйлүүд нийтэд түгээмэл биш ч гэсэн түүнийг дагахад энэ гэрчлэл бидэнд хэрхэн тусалж чадах вэ?
- Тэрээр хүмүүсийг наманчлалд дуудах үедээ Енох сайн мэдээний ямар сургаалуудыг заасан бэ? (Моисе 6:47–63-г үз) Хэрэв та нар хичээл 4 дэх энэ шүлгүүдийг ярилцсан бол, та эдгээрийг дахин нэгтгэн дүгнэх хэрэггүй байж болно.)

- Их Эзэн биднийг “[өөрсдөдөө] чөлөөтэйгөөр сонгогчид” болгосон билээ (Мосе 6:56). Энэ нь юу гэсэн үг вэ? (Сонгох хүч бидэнд байдаг) Бидний авралын төлөөх Бурханы төлөвлөгөөнд сонгох эрх яагаад зайлшгүй чухал вэ? (Бид сонголтуудынхаа төлөө хариуцлага хүлээх учраас сонгох эрх бидэнд хэрэгтэй.) Сатаныг дагахаар сонгосны үр дагаврууд юу байдаг вэ? Их Эзэнийг дагахаар сонгосны үр дагаврууд юу байдаг вэ? (2 Нифай 2:25–27-г үз)

3. Енохын хотын хүмүүс Их Эзэнтэй нэг зүрх сэтгэлтэй, нэг оюун ухаантай байсан бөгөөд хот бүхлээрээ тэнгэрт аваачигджээ.

Мосе 7:13, 17–21, 23–47, 68–69-ийг зааж, ярилц.

- Енохын агуу итгэлийн улмаас Их Эзэн ямар гайхамшгуудыг үйлдсэн бэ? (Мосе 7:13-ыг үз) Хүмүүсийн итгэлийн улмаас Их Эзэн өнөө үед ямар гайхамшгуудыг үйлддэг вэ?
- Енохын үгсийг сонсож, нүглүүдээ наманчилсан хүмүүс хэрхэн адислагдсан бэ? (Мосе 7:17–18-ыг үз) Тэдний хот яагаад Сион гэж нэрлэгдсэн бэ? (Мосе 7:18-ыг үз) Нэг зүрх сэтгэлтэй мөн нэг оюун ухаантай байх гэдэг нь юу гэсэн үг вэ? Их Эзэнтэй, гэр бүлийнхэнтэйгээ, мөн Сүмд “нэг зүрх сэтгэлтэй мөн нэг оюун ухаантай” байх гэдэг нь юу гэсэн үг вэ?
- Енох болон энэ хотын хүмүүст эцэст нь юу тохиосон бэ? (Мосе 7:19–21, 69-ийг үз)
- Мосе 7:28-д, Их Эзэн уйлж байхыг Енох харжээ. Их Эзэн яагаад уйлж байсан юм бол? Их Эзэн уйлж байсныг Енох яагаад асуусан бэ? (Мосе 7:29–31-г үз) Их Эзэн юу гэж хариулсан бэ? (Мосе 7:32–33, 36–37-г үз) Та нар эдгээр шүлгүүдийг уншихдаа Их Эзэний талаар юу гэж боддог вэ?
- Енох хүмүүсийн ёс бусыг хараад бас уйлжээ (Мосе 7:41, 44-ийг үз). Их Эзэн Енохыг хэрхэн тайтгаруулсан бэ? (Мосе 7:44–47-ийг үз)

Ирээдүйн хичээлүүдээр хожмын өдрүүдэд Сионыг, (түүний дотор Шинэ Иерусалимыг) дахин байгуулах, Аврагчийн Хоёр дахь Ирэлт, түүнчлэн үзэгдэлд Енохын харсан дэлхий дээрх түүний мянган жилийн хаанчлалын тухай ярилцах болно гэдгийг та ангийн гишүүдэд хэлж болно (Мосе 7:62–65).

Дүгнэлт

Каин Сатаныг дагахаар сонгож, өөрийн хилэнцэт дадал зуршлуудыг хүүхдүүддээ хийгээд дагалдагчиддаа заадаг байсныг тэмдэглэн хэл. Үүний үр дүнд, Каины үр удам ёс бус байдалд өсч, улмаар зөв шударга бус байдлынхаа төлөө Бурханаар зүхэгдсэн ажээ. Енох үүний эсрэгээр, Их Эзэнийг дагахаар сонгосон билээ. Үүний үр дүнд Енохын сонголт нь дуулгавартай байдал болж, сонсож болох бүх хүмүүст сайн мэдээг зааснаар бүхэл хотоороо Бурхантай хамт оршихын тулд дэлхийгээс зөөгдөхөөр тийм зөв шударга байсан ажээ.

Есүс Христийг дагахаар бидний хийдэг сонголтууд түүнтэй ойр байхад бидэнд тусалж, эрх чөлөө, аз жаргал, мөнх амьдрал уруу биднийг хөтлөх болно гэдгийг гэрчил.

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

1. Гэр бүлийн цэдэг хөтлөх нь


- Адам Ева хоёр болон тэдний үр удам дурсамжийн ном болон удмын бичиг хөтөлдөг байсан нь яагаад чухал ач холбогдолтой вэ? (Мосе 6:5–8, 45–46-г үз) Ийм цэдгүүдийг өнөө үед хөтлөх нь яагаад бидэнд чухал вэ? Та нарын өвөг дээдсийн бичигдсэн шастирууд та нарт хэрхэн тусалдаг вэ? Таны амьдралын болон итгэлийн тухай бичигдсэн шастирууд гэр бүлийн чинь гишүүдэд хэрхэн тусалж болох вэ?
- Судруудыг хэрхэн гэр бүлийн цэдгүүд гэж үзэж болох вэ? Эцэг эхчүүд болон багш нар хүүхдүүддээ заахын тулд судруудыг хэрхэн үр ашигтайгаар ашиглаж болох вэ?

2. Енох Каин хоёрыг харьцуулах нь

Нэг нь дээш чиглэсэн, нөгөө нь доошоо чиглэсэн (хуудас 21 дээрх зургийг хар) хоёр хөлийн мөрийг самбар дээр зур. Дээш чиглэсэн мөрүүдийг *Биднийг Бурхан өөд хөтөлдөг зүйлүүд* гэж нэрлээд, эхний мөрөн дээр Енохын нэрийг бич. Доош чиглэсэн мөрүүдийг *Биднийг устгал уруу хөтөлдөг зүйлүүд* гэж нэрлээд, эхний мөрөн дээр Каины нэрийг бич.

Енохын мөрүүд дээр гарсан эхний шүлгийг (Мосе 7:59) мөн Каины мөрүүд дээр гарсан эхний шүлгийг (Мосе 5:16) ангийн гишүүдээр уншуул. Тэгээд самбар дээрх холбогдох мөрүүдэд хэдэн түлхүүр үгийг бич. Үлдэж байгаа мөрүүдэд үүнийг давтан хий. Бүх шүлгүүдийг уншсаны дараа Енохын мөрүүдийн төгсгөлийг *Бурхантай хамт ориших*, Каины мөрүүдийн төгсгөлийг *Сүнсний устгал* гэж нэрлэ. Енохын үгс хийгээд үйл хэрэг Бурханд ойр дотно болоход нь түүнд хэрхэн тусалсныг мөн Каины үгс хийгээд үйл хэрэг түүнийг Сатанд хэрхэн ойртуулсныг ярилц.

- Бид ямар арга замуудаар Енохын үлгэр жишээг дагаж, Бурханд илүү ойртож чадах вэ?



3. “Нүдэндээ шавар түрх . . . тэгвэл чи харах болно” (Моисе 6:35)

Есүс Христ нэг удаа хараагүй хүний нүдэнд шавар түрхэж эдгээсэн ажээ (Иохан 9:1–7). Сүнслэг байдлын хувьд эрийн цээнд хараахан хүрээгүй асан Енох зарим зүйлүүдэд сүнсний хувьд харалган байсан учир ийнхүү “[өөрийнхөө] нүдэнд шавар түрхэж, үүнийг угаахаар” зарлигдуулжээ (Моисе 6:35).

- Үүнийг хийсэн үедээ Енох юу харсан бэ? (Моисе 6:36-г үз) Шаврыг угааж арилгах бэлэгдлийн үйлдэл бидэнд юу заадаг вэ?
- Бид Бурханы зүйлүүдэд мэлмийгээ илүү бүрэн дүүрэн нээхийн тулд юу хийж чадах вэ? Судруудад байдаг эрдэнэсийг олж харахын тулд бид судрууд судлахаа хэрхэн сайжруулж чадах вэ?

4. Замаасаа гажсан бидний хайртай хүмүүс

- Хэдийгээр Адам Ева хоёр сайн мэдээг хүүхдүүддээ зааж байсан ч (Моисе 5:12), Каин болон бусад хүмүүс зөв шударга бишээр амьдрахаар сонгожээ. Хайртай хүмүүс маань замаасаа гажсан үед тэрхүү гай зовлонг үүрэхэд өөрсдөдөө туслахын тулд бид юу хийж чадах вэ? Бид эдгээр хайртай хүмүүсийн төлөө юу хийж чадах вэ?

Ахлагч Ричард Г. Скотт зөвлөхдөө:

“Таны хүү юм уу охин, нөхөр буюу эхнэр тань хилэнцэтийг дагахын тулд зөв шударга ёсноос гажсан учраас та нараас олон чинь зүрх сэтгэлийн хүнд эмзэглэлтэй байгаа, миний захиас үг та нарт зориулагдаж байна.

“Амьдрал тань сэтгэлийн эмзэглэл, гай зовлонгоор, зарим үед, цөхрөлөөр дүүрэн байна. Та нар Их Эзэнээр хэрхэн тайтгаруулагдаж болох тухай би та нарт ярих болно.

“Нэгдүгээрт, хоёр тулгуур зарчмыг та мэдэх ёстой:

- “1. Гачигдсан өөрийн хайртай хүнд туслахын тулд таны хийж чадах олон зүйл байхад, бас Их Эзэнээр хийгдэх ёстой зарим зүйл байдаг.
- “2. Бас, зөв шударга сонгох эрхгүйгээр сайжралтыг тэвчээртэйгээр олох аргагүй. Сонгох эрхийг бүү үл тоомсорло. Их Эзэн өөрөө ч ингэхийг зөвшөөрөхгүй. Албадуулсан дуулгавартай байдал адислал авчирдаггүй (С ба Г 58:26–33-ыг үз).

“Таны тусалж чадах долоон арга замыг би санал болгож байна.

“Нэгдүгээрт, хязгааргүйгээр хайрла. . . . Хоёрдугаарт, зөрчлүүдийг бүү үл тоомсорло, гэвч зөрчигчид бүхий л найдвар хийгээд дэмжлэг үзүүл. . . . Гуравдугаарт, үнэнийг заа. . . . Дөрөвдүгээрт, энэ нь олонтаа шаарддагийн дагуу, чин сэтгэлээсээ уучил. . . . Тавдугаарт, итгэлтэйгээр залбир. ‘Зөвт хүний залбирал . . . үр нөлөөтэй бөгөөд ихийг гүйцэлдүүлж чадна’ (Иаков 5:16). . . .

“Зургадугаарт, алсын хараатай бай. . . . Туслахын тулд өөрийн чинь бодитойгоор хийж чадах зүйлүүд хийгдсэн бол, уг асуудлыг Их Эзэний мутарт үлдээгээд цаашид санаа зовсны хэрэггүй. Үүнээс илүүг хийж чадаагүй учраас өөрийгээ гэм буруутайд бүү бод. Дэмий санаа зовж, эрч хүчээ бүү үр. . . . Хэсэг хугацааны дараа танд шинэ санаа төрж, цаашдаа яаж туслахаа мэдэх болно. Та илүү амар амгалан, аз жаргалыг олж, тэдэнд хэрэгтэй байгаа бусад хүмүүсийг үл тоомсорлохгүй байж, мөнхийн хэтийн төлвийн улмаас илүү их тусламж үзүүлэх чадвартай болно. . . .

“Сүүлчийн зөвлөмж—*Хайртай хүнээ хэзээ ч, хэзээ ч бүү орхи!*” (Conference report 1988 оны 4-р сар, 69–71; *Ensign*, 1988 оны 5-р сар, 60–61)

“Ноа . . . Гэр бүлийнхээ Авралын төлөө Хөвөгч Авдар Бэлтгэв”

Моце 8:19–30; Эхлэл 6–9; 11:1–9

Зорилго Зохистойгоор амьдарч, дэлхийн хилэнцүүдээс зайлсхийхийг хүсэхэд нь ангийн гишүүдэд туслах.

- Бэлтгэл**
1. Дараах судруудыг залбирч судал:
 - а. Моце 8:19–30; Эхлэл 6:5–22; 7:1–10. Ноа сайн мэдээг номлов, гэвч хүмүүс сонссонгүй (Моце 8:19–25). Хүмүүсийн ёс бусын улмаас, дэлхий дээрээс бүх махан бодийг тэрээр устгана хэмээн Их Эзэн мэдэгдэв (Моце 8:26–30; Эхлэл 6:5–13). Хөвөгч авдар барьж, өөрийнхөө гэр бүл болон амьд амьтан бүрээс хосыг авч үүн дотор хийхийг Их Эзэн Ноад зарлиглав (Эхлэл 6:14–22; 7:1–10).
 - б. Эхлэл 7:11–24; 8; 9:8–17. 40 өдөр, 40 шөнө бороо оров (7:11–12). Хөвөгч авдарт ороогүй бүх хүмүүс хийгээд амьд бүхэн үхэж, ус 150 өдрийн турш дэлхийг бүрхсэн байлаа (7:13–24). Ус татрахад Ноа, түүний гэр бүл болон амьтад хөвөгч авдраас гарч (8:1–19), тэгээд Ноа Их Эзэнд тахил өргөв (8:20–22). Их Эзэн Ноатай өөрийн гэрээг хийж, уг гэрээний тэмдэг болгон солонго татуулжээ (9:8–17; Иосеф Смитийн Орчуулгад шүлэг 15 нь уг гэрээ Бурхан болон бүх амьд бүхний хооронд бус, харин Бурхан Ноа хоёрын хооронд хийгдсэнийг нотолдгийг анхаар).
 - в. Эхлэл 11:1–9. Үерээс хойш хэдхэн үеийнхний дараа хүмүүс тэнгэрт хүрэх цамхаг барих гэж оролджээ (Бабелын цамхаг). Их Эзэн тэдний хэлийг будлиулж, хүмүүс бие биенээ ойлгож чадахгүй болж, тэднийг бүх дэлхий дээгүүр тараасан ажээ.
 2. Нэмэлт уншлага: Еврей 11:7; Моце 7:32–36.
 3. Хэрэв дараах үзүүлэн таниулах материалууд олддог бол, та тэдгээрийн заримыг хичээлийнхээ хэсэг болгон ашиглаж болно:
 - а. *Эхлэл/Абрахам* видео хуурцгийн “Ноа ба Үер” хэсэг 2 (53150).
 - б. Хөвөгч Авдрын зураг (62053; Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 102); Ноа ба Амьтад бүхий Хөвөгч Авдар (62305; Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 103); Бүтээлт—Амьд Бүтээлүүд (62483; Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 100).

Энэ хичээлийг заах зөвлөмж

Анхаарал
төвлөрүүлэх
үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагаануудын аль нэгийг (эсвэл өөрийнхөө үйл ажиллагаануудын нэгийг) ашиглахыг хүсч болно. Ангийн хувьд хамгийн тохиромжтой үйл ажиллагааг сонгож ав.

1. Хэрэв танай анги хангалттай том бол, ангийн нилээд хэдэн гишүүнийг нэг эгнээнд жагсаан, хоёр гараа урагш сунган, хуруунуудынхаа үзүүрийг дараагийнхаа хүний хурууны үзүүрт хүргэн зогсохыг хүс. Ноагийн барьсан авдрын урттай адил эгнээ бий болгохын тулд ойролцоогоор ангийн 85 гишүүн хэрэгтэйг тайлбарла.
2. Ноагийн хөвөгч авдрын хэмжээг ангийн гишүүд тэдний илүү сайн мэдэх хөлөг онгоцны хэмжээтэй харьцуулан нүдэн баримжаагаар тогтооход тэдэнд туслахын тулд хичээлийн төгсгөлд бүдүүвч зургийг үзүүл.

Судрын ярилцлага
ба хэрэглээ

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Ноагийн наманчлах уриалгыг хүмүүс эсэргүүцэв; Ноа хөвөгч авдар барив.

Моше 8:19–30 болон Эхлэл 6:5–22; 7:1–10-ыг зааж, ярилц. (Хэрэв ангийн гишүүд “цэвэр” ба “бузар” амьтдын талаар асуулт асуувал, та тэдэнд Левит 11:1–31-ийг зааж өгч болно.)

- Их Эзэн Ноаг сайн мэдээг номлуулахаар дуудсан үед дэлхий ямар байдалтай байсан бэ? (Моше 8:20–22-ыг үз) Ноагийн үеийн хүмүүс болон манай өнөө үеийн хүмүүсийн хооронд ямар адил төстэй зүйлүүдийг та нар олж хардаг вэ? Ноагийн үеийн хүмүүс устгалаас хэрхэн зайлсхийж болох байсан бэ? (Моше 8:23–24-ийг үз) Бошиглогчдыг сонсож дагах нь сүнсний болон биеийн устгалаас зайлсхийхэд бидэнд хэрхэн тусалж чадах вэ?
- Юуны учир Ноа хөвөгч авдар барьсан бэ? (Еврей 11:7-г үз) “Хувийнхаа хөвөгч авдар” барихыг Сүмийн удирдагчид бидний хүн нэг бүрд зөвлөж байна” (В. Дон Ладд, Conference Report, 1994 оны 10-р сар, 36; *Ensign*, 1994 оны 11-р сар, 29). Сүнслэг байдлын хувьд бид өөрсдийгөө болон гэр бүлийнхнээ хамгаалахын тулд юу хийж болох вэ? Өнөөдөр биднийг хамгаалахад ямар зарлигууд онцгой ач холбогдолтой гэж та нар боддог вэ? (Та ярилцлагадаа *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* [34285] товхимлыг ашиглаж болно.)
- Гай зовлон буюу эсвэл бусад гачигдлын үед бие махбодийн хувьд бэлтгэгдсэн байхын тулд бид юу хийж болох вэ? (Доорх ишлэлүүд болон хуудас 54 дээрх Ахлагч Л.Том Перрийн ишлэлүүдийг үз) Яагаад биднээс олон нь зайлшгүй шаардлагатай бэлтгэлүүдийг хийхээ хойшлуулдаг вэ? Одооноос бэлтгэхэд бид хэрхэн илүү шийдвэр төгс байж чадах вэ?

“Хүнс үйлдвэрлэж нөөцлөх илчлэлт өнөөдрийн бидний цаг зуурын сайн сайхан байдлын учир Ноаг зуурдын сайн сайхан байдлын хувьд хөвөгч авдарт ачаалахын нэгэн адил чухал юм” гэж Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон хэлжээ (Conference Report 1987 оны 10-р сар, 61; *Ensign*, 1987 оны 11-р сар, 49).

Ахлагч В.Дон Ладд заахдаа: “Бороо орж эхлэхэд, хөвөгч авдар барьж эхэлбэл нэгэнт оройтсон байна. . . . Бид . . . Их Эзэний төлөөний хүнийг сонсох хэрэгтэй. Бид тайвнаар урагш үргэлжлүүлэн ахиж, зайлшгүй

тохиох зүйлд бэлтгэлтэй байх хэрэгтэй. Бид үймэлдэн тэвдэх буюу айх хэрэггүй, хэрэв бид сүнслэг байдал, бие махбодийн хувьд бэлтгэгдсэн байх л юм бол, бид болон бидний гэр бүлүүдийн хүнсний хэрэгцээ ямар ч үерийг даван гарах болно. Хэрэв бидний ажил үйлс ирээдүйн бэлтгэлийн төлөө гуйвшгүй хийгээд баттай чиглэх юм бол, бидний хөвөгч авдрууд итгэлийн далайд хөвсөөр байх болно” гэжээ (Conference Report, 1994 оны 10-р сар, 37; *Ensign*, 1994 оны 11-р сар, 29).

- Хөвөгч авдрыг барихад Ноа ямар шинж чанаруудыг харуулсан бэ? (Хариултууд нь итгэл, дуулгавартай байдал, шаргуу ажил байж болно.) Эдгээр шинж чанаруудыг бид өөрсдөдөө хэрхэн бэхжүүлж чадах вэ?

Ноа хөвөгч авдар барьж байх үед, “бороо болон үерийн ямар ч шинж тэмдэг байгаагүй. . . . Түүний сэрэмжлүүлэг бодитой бишид тооцогдож байв. . . . Нар шарж, амьдрал ердийнхөөрөө урагш ахиж байхад хуурай газар дээр хөвөгч авдар барих нь хичнээн тэнэг хэрэг байв аа! Гэвч цаг хугацаа өнгөрсөөр байв. Хөвөгч авдар дуусав. Үер боллоо. Дуулгаваргүй хүмүүс болон эсэргүүцэгчид үйж үхэв. Хөвөгч авдрыг барихад харагдсан итгэлийг хөвөгч авдрын гайхамшиг дагалдсан юм” хэмээн ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл хэлжээ. (*Faith Precedes the Miracle* [1972], 5–6)

2. Их Эзэн дэлхийг үерээр цэвэршүүлэв.

Эхлэл 7:11–24; 8; 9:8–17-г зааж, ярилц.

- Үер болоход юу тохиолдсон бэ? (Эхлэл 7:23-ыг үз) Бидний эргэн тойрон дахь хилэнцээс бид өөрсдийгөө аварч чадах ямар “хөвөгч авдрууд” бидэнд байдаг вэ? (Та хариултуудыг самбар дээр жагсаан бичиж, эдгээр “хөвөгч авдрууд” тэднийг хэрхэн хамгаалсныг ярихыг ангийн гишүүдээс хүсч болно. Боломжтой хариултууд нь бидний гэр орон ба гэр бүлүүд, найз нөхөд, ариун сүмүүд, семинар, Сүмийн цуглаанууд, залбирал, судрууд, түүнчлэн амьд бошиглогчид байж болно) Бусад хүмүүс эдгээр “хөвөгч авдруудад” толгой хоргодоход нь бид хэрхэн тусалж чадах вэ?
- Бороо зогссоны дараа Ноа яагаад хөвөгч авдраас тагтаа гаргаж тавьсан бэ? (Эхлэл 8:8-ыг үз) Тэрээр тагтаа гаргаж тавьсан эхний хоёр удаад яасан бэ? (Эхлэл 8:8–11-ийг үз) Гурав дахь удаад яасан бэ? (Эхлэл 8:12-ыг үз)
- Хөвөгч авдраас гарсны дараа Ноагийн хийсэн анхны зүйл юу вэ? (Эхлэл 8:20;) Хүнд нөхцөл байдалд тэрээр бидэнд тусалсан үед бид талархлаа Их Эзэнд хэрхэн харуулж болох вэ?
- Үер дууссаны дараа Бурхан тэнгэрт юу тавьсан бэ? (Эхлэл 9:13-ыг үз) Солонго юуг төлөөлнө гэж Бурхан хэлсэн бэ? (Эхлэл 9:12–13, 16–17-г үз) Бурхан Ноатай ямар гэрээ хийсэн бэ? (Эхлэл 9:8–11, 15;)

3. Хүмүүс Бабелын цамхгийг барив.

Эхлэл 11:1–9-ийг зааж, ярилц.

- Ноагийн үр удам яагаад цамхаг барихаар шийдсэн бэ? (Эхлэл 11:4-ийг үз) Өөрсдөдөө “нэр олсноор” тэд юуг хэрэгжүүлэхийг хүсч байсан гэж та нар бодож байна вэ? Бид өөрсдөдөө нэр олох, Христийн нэрийг өөрсөд дээрээ авах нь ямар ялгаатай вэ? Бид Христийн нэрийг авсан үед ямар үүрэг хариуцлагуудыг өөрсөд дээрээ авдаг вэ? (Мозая 18:8–10-ыг үз)

- Тэнгэрт хүрэх цамхаг барих гэж оролдсоны үр дүн нь юу болсон бэ? (Эхлэл 11:5–9-ийг үз) Бид өөрсдийн буюу хүмүүний аргуудаар яагаад тэнгэрт хүрч чадахгүй вэ? Бидний хувьд тэнгэрт хүрэх Их Эзэний арга зам юу вэ?

Дүгнэлт

Бабелын цамхгийг барьсан хүмүүс дэлхийн арга замаар тэнгэрт хүрэхийг оролдсон учраас тэд шийтгэгдсэнийг тайлбарла. Үүний эсрэгээр, Ноа болон түүний гэр бүл Бурханы зарлигуудын дагуу амьдарсан учраас үерээс аврагдсан билээ.

Бидний хувьд тэнгэрт хүрэх—Тэнгэрлэг Эцэгтэйгээ хамт амьдрахын тулд эргэж очих цорын ганц зам бол Есүс Христийн сайн мэдээгээр дамжих явдал гэдгийг гэрчил. Бид Ноагийн нэгэн адилаар Есүс Христэд итгэх итгэлтэй байж, нүглүүдээ наманчлан, ариун ёслолуудыг хүлээн авч, амьдралынхаа эцсийг хүртэл тэвчиж, зөв шударгаар амьдрах ёстой. Хэрэв бид эдгээр зүйлүүдийг хэрэгжүүлэх юм бол, бид хилэнцийг даван гарч, Бурханы оршихуйд эргэн очиж чадах болно.

Нэмэлт заах санаанууд

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.


1. Ноагийн өдрүүдийг Енох үзэгдэлд харав

Ноагийн элэнц өвөг эцэг Енох үерийн шалтгаан болсон Ноагийн үеийнхний ёс бусыг үзэгдэлд харжээ (Мосе 7:41–52). Энэхүү ёс бусын улмаас Енох харамсан гашуудаж, Ноа болон түүний хүүхдүүдэд нигүүлсэл үзүүлэхийг Их Эзэнээс гуйсан аж. Тэрээр дэлхийг дахиад хэзээ ч үерээр устгахгүй хэмээн Их Эзэн Еноход амлажээ (Мосе 7:51). Их Эзэн бас Ноа бол түүний үр удам байхыг, мөн үерийн дараа ч гэсэн Енохын үр удам дэлхий дээр үргэлжлэн байхыг амлажээ (Мосе 7:52; 8:2, 6, 8–9). Үерийн дараа Их Эзэн Ноатай хийсэн гэрээгээ шинэчилжээ (Эхлэл 9:8–17; шүлэг 9 ба 11-ийн Иосеф Смитийн орчуулга Енохтой хийсэн Их Эзэний гэрээний тухай өгүүлдгийг анхаар; мөн түүнчлэн Иосеф Смитийн Орчуулга, Эхлэл 9:21–25-ыг үз).

2. Их Эзэн зөв шударга хүмүүсийг хадгалан хамгаалдаг

Зөв шударгынхаа улмаас Ноа болон түүний гэр бүл үерээс аврагдсаны нэгэн адил Их Эзэн бас Бабелын цамхгийн үед зөв шударга хүмүүсийг хамгаалсан юм. Ифер 1:1–5, 33–37-д гардаг Жаред болон түүний ахын тухай, мөн яагаад тэдний хэл будлиулагдаагүй тухай түүхийг товч ярилц.

Янз бүрийн хөлөг онгоцнуудын харьцуулсан хэмжээ
(анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг үз)



Абрахам 1:1–4; 2:1–11; Эхлэл 12:1–8; 17:1–9

Зорилго	Абрахамын гэрээний адислалууд, үүрэг хариуцлагуудыг ойлгоход нь ангийн гишүүдэд туслах.
Бэлтгэл	<ol style="list-style-type: none"> 1. 1:1–4; 2:1–11; Эхлэл 12:1–8; 17:1–9-ийг залбирч судал. Абрахам зохистой байж, Бурханы адислалуудын төлөө зохистойгоор амьдрахыг эрэлхийлж байв. Бурхан Абрахамтай гэрээ хийж, түүний үр удам тоо томшгүй олон тоотой болж, амлагдсан нутаг хийгээд санваарын болон сайн мэдээний адислалуудыг хүлээн авах болно гэж амлажээ. 2. Нэмэлт уншлага: Эхлэл 15; Сургаал ба Гэрээ 132:19–24, 29–32; 3. Хэрэв дараах үзүүлэн таниулах материалиуд байдаг бол, та тэдгээрийг хичээлийнхээ нэг хэсэг болгон ашиглаж болно: <ol style="list-style-type: none"> Номлогчдын (62611) болон орон нутгийн ариун сүмийн зураг.

**Энэ хичээлийг
заах зөвлөмж**Анхаарал
төвлөрүүлэх
үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагааг (эсвэл өөрийнхөө нэг үйл ажиллагааг) ашиглахыг хүсч болно.

- Патриархын адислал гэж юу вэ?

“Патриархын адислал бол уг адислалыг хүлээн авагчийн удам угсааны бурханлигаар нөлөөлөгдсөн тунхаглал, мөн түүнчлэн хүлээн авагчийн амьдралын үүрэг зорилгын Сүнсээр өдөөгдсөн, бурханлигаар нөлөөлөгдсөн хийгээд бошиглолын, түүнчлэн патриархын өгөхөөр өдөөгдсөн. . . ийм адислалууд, анхааруулгууд хийгээд зөвлөгөөнүүд хамтдаа орсон мэдэгдэл юм. . . . Амлагдсан бүх адислалуудын хэрэгжилт нь бидний Их Эзэний сайн мэдээнд итгэлтэй байхаас хамааран нөхцөлдсөн байдаг” гэж Тэргүүн Зөвлөл хэлжээ (Гадасны ерөнхийлөгчдөд бичсэн захидал, 1957 оны 6-р сарын 28; Брус Р.МкКонкигаас иш татжээ, *Mormon Doctrine*, 2 дахь хэвлэл. [1966], 558).

- Та нараас хичнээн нь патриархын адислалаа хүлээн авсан бэ? Бидний удам угсааг патриархын адислалд мэдэгдэнэ гэдэг нь юу гэсэн үг вэ? (Патриарх бидний удам угсааг мэдэгдэхдээ, бид бол Ефраим, Манассе буюу Абрахамын бусад үр удмаар дамжсан бошиглогч Абрахамын үр удам болохыг тэрээр бидэнд илчилдэг.)

Энэ хичээлээр бидний хүлээн авч болох адислалууд хийгээд Абрахамын үр удмын хувьд бидний хүлээдэг үүрэг хариуцлагуудын тухай ярилцах болно гэдгийг тайлбарла.

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Бурхан Абрахамтай гэрээ хийв.

Абрахам 1:1–4; 2:1–11; Эхлэл 12:1–8; 17:1–9-ийг зааж, ярилц.

- Абрахам залуу байхдаа зөв шударга байж, Бурханы адислалуудыг хүртэхээр зохистой амьдрахыг хүсдэг байжээ. Абрахам 1:2–4-д өгүүлснээр, Абрахам ямар адислалуудыг хүсдэг байсан бэ?
- Ур дахь гэр орноо орхиж, Харан хэмээн тэдний нэрлэдэг байсан нутаг уруу явахад Абрахам болон түүний гэр бүлийг Бурхан чиглүүлжээ (Абрахам 2:1–4). Тэнд Абрахам залбирч, түүнийг болон үр удмыг нь адислахаар Бурхан түүнтэй гэрээ хийсэн үзэгдэл хүлээн авчээ. Энэ нь Абрахамын гэрээ хэмээн нэрлэгддэг. Энэ гэрээнд Бурхан Абрахамд ямар адислалууд амласан бэ? (Абрахам 2:6–11; Эхлэл 12:1–8; 17:1–9-ийг үз. Амлагдсан эдгээр адислалууд гүйцэлдэх хүртэл Абрахам олон жил хүлээх шаардлагатай болсон бөгөөд тэдгээр амлалтууд өнөөдөр ч гэсэн үргэлжлэн хэрэгжсээр байгааг тэмдэглэн хэл)

Абрахамын гэрээний адислалуудыг нэгтгэн тоймлоход дараах бүдүүвч танд тусалж чадна. Та товчилсон үсгээр тэмдэглэсэн бүдүүвчийг, хуудас (00) 29-д харуулснаар “Үүрэг хариуцлагууд” хэсэгт зориулж зай үлдээн, самбарт өлгөж болно:

Абрахамын гэрээний адислалууд болон үүрэг хариуцлагууд			
Дэлхийн адислалууд:	Амьдрах амлагдсан нутаг (Абрахам 2:6, 19; Эхлэл 12:7; 17:8)	Агуу их үр удам (Абрахам 2:9–10; Эхлэл 12:2–3; 17:2, 4–6)	Есүс Христийн сайн мэдээ ба Абрахам болон түүний үр удамд зориулсан санваар (Абрахам 2:9–11; Эхлэл 17:7)
Мөнхийн зэрэгцэлтүүд:	Селестиел хаант улс (С ба Г 88:17–20)	Мөнхийн гэрлэлт ба мөнхийн өсөн нэмэгдэлт (С ба Г 132:19–22)	Өргөмжлөл ба мөнх амьдрал (С ба Г 132:23–24)

2. Бид бол Абрахамын гэрээний адислалууд болон үүрэг хариуцлагуудын өв залгамжлагчид.

Сүмийн бүх гишүүд “Абрахамын үр удам” энэ нь бид түүний удам угсаа гэсэн үг юм. Ахлагч Иосеф Фиелдинг Смит хэлэхдээ: “Сүмийн гишүүд болсон хүмүүсийн дийлэнх олонхи нь Иосефын хүү Ефраимаар дамжсан

Абрахамын шууд үр удам байдаг. Абрахам болон Израилын шууд удам угсааных биш хүмүүс баптисм хүртэж, гишүүнээр батлагдсан үедээ тэд модонд залгагдаж, өв залгамжлагчийн бүх эрх хийгээд онцгой боломжийг хүлээн авснаар тэд мөн ийм хүмүүс болох ёстой” гэжээ (“How One May Become of the House of Israel,” *Improvement Era*, 1923 оны 10-р сар, 1149).

- Сүмийн гишүүд Абрахамын үр удмын хувьд Абрахамын гэрээний адислалууд хийгээд үүрэг хариуцлагуудын өв залгамжлагчид байдаг. Бид яаж энэ гэрээний өв залгамжлагчид болдог вэ? (Бид Сүмд баптисм хүртсэн үед Абрахамын гэрээний *авралын* амлалт бидэнтэй хамт шинэчлэгддэг. Бид ариун сүмд лацдан холбуулах үед Абрахамын гэрээний *өргөмжлөлийн* амлалт бидний хувьд шинэчлэгддэг. Уг гэрээний адислалуудыг хүлээн авахын тулд бид холбогдох үүрэг хариуцлагуудыг биелүүлж, зохистой амьдрах ёстой.)

Ахлагч Брус Р.МкКонки тайлбарлахдаа:

“Абрахам эхлээд сайн мэдээг баптисмаар (энэ нь авралын гэрээ юм) хүлээн авчээ; дараа нь тэрээр илүү дээд санваарыг өөр дээрээ авч, селестиел гэрлэлтэд (энэ нь өргөмжлөлийн гэрээ) орж, үүгээр тэрээр мөнхийн дэвшлийг хүлээн авчээ; эцэст нь эдгээр бүх адислалууд түүний мөнх бус бүх үр удамд санал болгогдох болно гэсэн амлалтыг тэрээр хүлээн авчээ. (Абрахам 2:6–11; С ба Г 132:29–50) Абрахамд өгөгдсөн бурханлиг амлалтуудын дотор Христ түүний удмаар дамжин ирэх болно, мөн Абрахамын үр удам тодорхой сонголт, амлагдсан нутгуудыг үүрд мөнхийн өв болгон хүлээн авах болно гэсэн амлалт багтжээ. (Абрахам. 2; Эхлэл. 17; 22:15–18; Галат 3)

“Эдгээр бүх амлалтууд нийлээд *Абрахамын гэрээ* гэж нэрлэгддэг. Энэ гэрээг Исаактай (Эхл. 24:60; 26:1–4, 24) мөн дахин Иаковтай хийж шинэчилжээ. (Эхл. 28; 35:9–13; 48:3–4) Энэ гэрээний хувь хүний өргөмжлөл болоод мөнхийн дэвшилд хамаарах хэсгүүд нь селестиел гэрлэлтийн жаягт ордог Израилын угсааны гишүүн бүртэй шинэчлэгддэг; энэ жаягаар дамжуулан оролцогч талууд Абрахам, Исаак болон Иаковын бүх адислалуудын өв залгамжлагчид болдог” гэжээ. (С ба Г 132; Ром 9:4; Галат. 3; 4) (*Mormon Doctrine*, 2 дахь хэвлэл. [1966], 13)

- Абрахамын гэрээгээр дамжуулан бид ямар адислалууд хүлээн авч болох вэ? (Өмнөх бүдүүвчид тоймлосноор, Абрахамын хүлээн авсан бүх адислалуудыг бид хүлээн авч чадна. Эдгээр адислалуудын дотор сайн мэдээ, санваар, өргөмжлөл, түүнчлэн гэр бүлийн мөнхийн харилцаа багтдаг.)
- Абрахамын гэрээний өв залгамжлагчдын хувьд бидний үүрэг хариуцлага юу вэ? (Абрахам 2:9, 11; Эхлэл 18:19-ийг үз. Бид Бурханы бүх хүүхдүүд, амьд байгаа хүмүүс болон нас барагсад тусалж, сайн мэдээний бүрэн адислалуудыг хүлээн авах ёстой. Бид бас Бурханы зарлигуудыг сахих ёстой.)

Хэрэв та хуудас 28 дээрх бүдүүвчийг самбар дээр бичсэн бол, бидний үүрэг хариуцлагуудыг доорх байдлаар жагсаан, бүдүүвчийн доод талд нэг хэсэг нэм:

Үүрэг хариуцлагууд:	Сайн мэдээний бүрэн адислалуудыг хүлээн авахад нь Бурханы бүх хүүхдүүдэд тусал (Абрахам 2:9, 11)	Бурханы зарлигуудыг дуулгавартай дага (Эхлэл 18:19)
---------------------	--	---

- Сайн мэдээг хүлээн авахад нь бид бусдад хэрхэн тусалж болох вэ? (Номлогчийн ажлыг хийснээр, нас барагсдын төлөө ариун сүмийн ёслолуудыг гүйцэтгэснээр, түүнчлэн зөв шударга үлгэр дуурайл үзүүлснээр. Та ариун сүмийн болон номлогчдын зураг үзүүлж болно.)

“Абрахамын үр удам болох бидний үүрэг хариуцлага бол ‘энэхүү тохинууллыг хийгээд Санваарыг бүх үндэстнүүдэд хүргэх номлогч нар байх явдал мөн’ (Абрахам 2:9)” гэж Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон хэлжээ (Conference Report, 1987 оны 4-р сар, 107; *Ensign*, 1987 оны 5-р сар, 85).

Сайн мэдээг бусадтай хуваалцах бидний үүрэг хариуцлагыг Ахлагч Бонд К.Пакер онцлон тэмдэглэж, дараах адил төстэй дүгнэлтийг хийжээ:

Хэсгийнхээ гишүүдийн зугаалгыг төлөвлөхийн тулд манай бишоп биднийг томилжээ гэж бодъё. Энэ бол хэсгийн түүхэн дэх хамгийн шилдэг олон нийтийн үйл ажиллагаа байх ёстой байв, иймээс зардал бол санаа зовоох асуудал биш байлаа. Хөдөө нутаг дахь зугаалгын үзэсгэлэнт газрыг бид нөөцлөн хадгалж байв. Бид үүнийг бүгдээрээ өөрсдийнхөө төлөө л байлгах ёстой байв.

Нөгөөх өдөр нь болоход юм бүхэн төгс сайн байлаа. Ширээнүүд засагдаж, сайхан найр эхлэх нь тэр. Тэгтэл, адислал дөнгөж хэлэгдэж байтал, нэг хуучин машин зугаалга болж байсан газар руу эргэж, тар нярхийн зогсов. Сандарсан нэг хүн моторын хавхгийг өргөхөд бөөн уур савсан гарах нь тэр. Машин дотроос нилээд хэдэн хүүхэд гарч ирлээ. Санаа нь зовсон ээж нь нэг хайрцгийг ойролцоох ширээ рүү аваачив. Тэрээр ширээн дээрээс жаал зугаа идэх юмны үлдэгдэл цуглуулж, өлссөн хүүхдүүддээ өгөх гэж байгаа янзтай байв. Гэвч тэнд хангалттай юм байсангүй.

Тэгтэл бяцхан охидын нэг нь манай ширээг ширтэн харлаа. Тэр жаахан эрэгтэй дүүгээ бидэн рүү түлхээд, толгойгоо бид хоёрын хоорондуур түрэн оруулав. Бид хажуу тийш зайллаа. “Тэрийг хараач; ямархуу амттай бол оо гэж би гайхаж байна” гэж нөгөөх бяцхан охин хэлэв.

Бид юу хийх хэрэгтэй байсан бэ? Бид тэр хүмүүсийг эс анзаарч, дуу шуугиан гаргахгүй байхыг хүсэх ёстой байсан уу? Бид тэдний ширээ рүү нуруугаа харуулан, бидэнд ерөөсөө хэрэггүй байсан идэх юмнаасаа хэсгийг тэдэнд өгөх хэрэгтэй байсан уу? Эсвэл бид тэднийг ирж, бидэнтэй нэгдэхийг урьж, өөрсдийнхөө дунд суулган, найрын идээ будаанаасаа хуваалцан, машиныг нь засахад бид тусалж, тэднийг явахад нь зориулж тэдэнд ямар нэг зүйл өгөх хэрэгтэй байсан уу?

“Тэдгээр өлссөн хүүхдүүдийг хооллоход хичнээн их зүйл, эсвэл хичнээн мөнгө хэрэгтэйг тооцож үзэхээс илүүгээр цэвэр ариун цэнгэл баяслыг тэдэнд байдгаж болох сон бус уу? Тэдний машиныг засахад [тэдэнд]

туслахын тулд бид зугаа цэнгэлээ түр завсарлахаас илүү сэтгэл ханамж тэнд байж болох байсан бус уу? . . .

“ . . . Дэлхий даяар болон бидний эргэн тойронд—бидний хөршүүд, бидний найз нөхөд байдаг, бидний өөрсдийн гэр бүлүүдэд зарим нь—сүнслэг байдлын хувьд авч үзвэл, өлөн зэлмүүн явдаг. Тэднээс зарим нь өлсгөлөнгөөр үхэж байна! Хэрэв бид энэ бүхнийг өөрсөд дээрээ авч үзвэл, энэ нь өлссөн хүмүүсийн өмнө найрлан цэнгэхтэй явч адилгүй байх вий” хэмээн Ахлагч Пакер асуусан байдаг (Conference Report, 1984 оны 4-р сар, 59–61; *Ensign*, 1984 оны 5-р сар, 41–42).

- Сайн мэдээний адислалуудыг бусад хүмүүс хүлээн авахад туслах бидний үүрэг хариуцлагын талаар энэ дүгнэлт юу зааж байна вэ? (Дэлхий нэгэн цагт мэдсэн хамгийн агуу найр, сайн мэдээний бүрэн байдлаар бид адислагдаад байна [С ба Г 58:8–12]. Энэхүү адислалыг амьд байгаа хүмүүс болон нас барагсадтай аль алинтай нь хуваалцахыг Бурхан биднээс хүсэн хүлээдэг билээ.)
- Бидний патриархын адислалууд дахь удам угсааны мэдэгдэл нь Абрахамын гэрээний өв залгамжлагчдын хувьд бид өөрсдийн үүрэг хариуцлагуудыг хэрэгжүүлэх дуудлагатай хичнээн адилхан байна вэ? (Биднийг Абрахамын үр удам хэмээн мэдэгддэгээрээ бидний патриархын адислалууд Абрахамын гэрээний адислалуудыг хүлээн авах болон үүнийг хэрэгжүүлэх бидний үүргийн талаарх онцгой боломжид дахин чухал ач холбогдол өгдөг.)

Дүгнэлт

Абрахамын гэрээний адислалуудын тухай гэрчлэлээ хэл. Энэ гэрээний өв залгамжлагчдын хувьд үүрэг хариуцлагаа биелүүлэхэд нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

Нэмэлт заах санаа

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон үүнийг ашиглаж болно.

Дэлхийд амьдрахын сорилт

Эртний израилчууд, хүмүүс нь үнэн Бурханд итгэдэггүй олон үндэстнүүдээр хүрээлүүлсэн байсныг тайлбарла. Эдгээр үндэстнүүдэд ассиричууд, вавилончууд, египетчүүд түүнчлэн бусад үндэстнүүд ордог байв.

- Их Эзэн яагаад өөрийн гэрээт хүмүүсийг тусад нь байлгахын оронд эртний дэлхийн гол дунд байрлуулсан гэж та нар боддог вэ? (Дэд хууль 4:6–8-ыг үз. Тэд бусдад үлгэр жишээ үзүүлж, бүх үндэстнүүдийг адислахын тулд Абрахамын гэрээг хэрэгжүүлэхийг Тэрээр хүсч байжээ.)

Гэрээнүүдээ сахих болон зөв шударга байдлаар бусдад нөлөөлөх талаар Их Эзэний хүмүүс амжилт олж байсан буюу бүтэлгүйтэж байсныг Хуучин Гэрээн дэх олон түүх харуулдгийг тайлбарла. Абрахам, Иосеф, Даниел, Естер болон бусад олон хүмүүс зөв шударгаар нөлөөлж байв. Самсон, Ахаб, аглаг буйдад бэдрэн явсан Израилын хүүхдүүд болон бусад хүмүүс тэдэнд нөлөөлөх боломжийг дэлхийд олгосон ажээ.

Их Эзэн эртний Израилын нэгэн адилаар, өөрийн хожмын үеийн гэрээт хүмүүс биднийг дэлхийн гол дунд байрлуулсан юм. Бидний сорилт бол зөв шударга бус замуудаар бидэнд нөлөөлөх боломжийг дэлхийд олгохын оронд зөв шударга замуудаар бид дэлхийд нөлөөлөх явдал мөн.

Ёс бус дэлхийд зөв шударгаар амьдрах нь

Хичээл
8

Эхлэл 13–14; 18–19

Зорилго

Ёс бус явдал өсч байгаа үед зөв шударга жишгүүдийг гуйвшгүй чандаар мөрдөхөд ангийн гишүүн бүрийн шийдвэр төгс байдлыг бэхжүүлэх.

Бэлтгэл

1. Дараах судруудыг залбирч судал. Анхаар: Эхлэл 17:5-д Абрамын нэрийг Их Эзэн Абрахам болгож өөрчилсөн тухай өгүүлдэг. *Абрахам* гэдэг нэр энэ хичээлийн эхнээс дуустал хэрэглэгдэх болно.
 - а. Эхлэл 13. Канааны нутагт өлсгөлөн болсны улмаас Египетэд хэсэг хугацаагаар амьдарсны дараа Абрахам болон түүний гэр бүл Канаанд эргэж иржээ. Абрахам Хебронд суурьшиж, харин түүний ач хүү Лот Содомын ойролцоо суурьшсан аж.
 - б. Эхлэл 14:1–2, 8–24. Лот хаадын тулалдааны үед олзлогдож, Абрахамаар аврагдав (14:1–2, 8–16). Абрахам Мелкизедект аравны нэг төлдөг байсан бөгөөд Содомын хаанаас дайны олз хүлээн авахаас татгалзжээ (14:17–24).
 - в. Эхлэл 18:16–33; 19:1–29. Хүмүүсийнх нь ёс бусын улмаас Содом, Гоморра хоёрыг тэрээр устгах болно хэмээн Их Эзэн мэдэгдэв (18:16–22). Хэрэв тэрээр тэнд амьдардаг зөв шударга хүмүүсийг олох юм бол, энэ хоёр хотыг хадгалж үлдэхийг Абрахам Их Эзэнээс гуйв (18:23–33). Содомыг орхиж явахыг Лот болон түүний гэр бүлд зарлиглажээ (19:1–23; Иосеф Смитийн Орчуулга, Эхлэл 19:11–13-т Лот өөрийн охидыг Содомын эрчүүдэд санал *болгоогүйг* нотолсныг анхаар; харин ч, тэрээр охидоо тэдгээр эрчүүдээс хамгаалахыг хичээж байжээ). Их Эзэн Содом, Гоморра хоёрыг устгасан билээ (19:24–29).
2. Нэмэлт уншлага: Эхлэл 12;
3. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашиглах бол, саяхны нэг сонинг ангид авчир.

Энэ хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагааг (эсвэл өөрийнхөө нэг үйл ажиллагааг) ашиглахыг хүсч болно.

Авчирсан сонингоо ангид үзүүл. Аль нэгэн онцгой мэдээнд орж үзэлгүйгээр, бид хэрхэн зөв шударга бус нөлөөгөөр хүрээлэгдсэнийг тайлбарла. Энэ хичээл, ёс бус явдал бүр бидний эргэн тойронд байхад ч гэсэн, зөв шударга байхын ач холбогдлын тухай юм гэдгийг тайлбарла.

Судрын ярилцлага ба хэрэглээ

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Абрахам болон түүний гэр бүл Хебронд суурьшиж, Лот болон түүний гэр бүл Содомын ойролцоо суурьшив.

Эхлэл 13-ыг зааж, ярилц.

Абрахам амьдралдаа энэ нутагт аялсан тухай товч тоймыг та өгч болно. Тэрээр Халдеин Урт өсч, дараа нь Харанд суурьшихаар Их Эзэнээр удирдагджээ (Эхлэл 11:31; Абрахам 2:1–5). Канааны нутаг болон “Би чиний үр хүүхдүүдэд энэ нутгийг өгье” (Эхлэл 12:7) хэмээн Өөрийн амласан нутгийн зүг Их Эзэн түүнийг Харанаас гарган удирдсан юм. Канаан дахь өлсгөлөнгийн улмаас, Абрахам болон түүний гэр бүл Египет рүү явжээ (Эхлэл 12:10). Абрахам болон түүний гэр бүл Египетээс Канаанд эргэж ирснээр Эхлэл 13 эхэлдэг.

- Абрахам Лот нар, түүнчлэн тэдний гэр бүл Египетээс Канаанд буцаж ирснийхээ дараа яагаад хамтдаа амьдарч чадаагүй вэ? (Эхлэл 13:5–7-г үз) Эхлэл 13:8–9 дахь түүний тайлбараас бид Абрахамын тухай юу мэддэг вэ? Бид гэр бүлийнхээ гишүүд буюу бусад хүмүүстэй зөрчилдөх үед бид Абрахамын үлгэр дуурайлыг хэрхэн дагаж болох вэ?
- Лот хаана амьдрахаар сонгосон бэ? (Эхлэл 13:10–12-ыг үз) Содомын хүмүүс үлэмж ёс бус байсан хэдий ч, Лот тэдний ойролцоо амьдрахаар сонгосныг онцлон тэмдэглэ (Эхлэл 13:13). Содомын ойролцоох газар юугаараа Лотыг татсан бэ? (Эхлэл 13:10-ыг үз. Энэ нутаг “ус сайтай” бас үзэсгэлэнтэй байв.)
- Лот эхлээд Содомын гадна, “талын хотуудад амьдарч байсан” хэдий ч, тэрээр “майхнаа Содом тийш харуулан босгодог байв” (Эхлэл 13:12). Хожим нь тэрээр бүр Содом хотод амьдарч байжээ (Эхлэл 14:12). Бид майхнуудаа Содом уруу харуулан босгохтой сүнсний хувьд эн тэнцэх ямар зүйлүүдийг бид хийж болох вэ? (Бид хилэнцэт зүйлүүдээс зугтаахын оронд жижиг нүглүүд илүү том нүглүүд рүү хөтөлж болохыг бодолгүйгээр ийм нүглүүд үйлдэх бололцоог өөрсдөдөө олгодог явдал бий.) Жижиг асуудлууд буюу нүглүүдийн өмнө бид зан төлвөө хэрхэн өөрчилж болох вэ?
- Лотын нэгэн адил Мормоны Номон дахь Хаан Бенжамины хүмүүс бас майхнуудаа нэгэн онцгой зүг рүү харуулан босгодог байжээ. Тэд майхнуудаа юу уруу харуулдаг байсан бэ? (Мозая 2:6-г үз) Бид гэр орноо дэлхийн газруудаас илүүтэйгээр ариун сүм рүү хэрхэн чиглүүлж болох вэ?

2. Абрахам Лотыг аварч, Мелкизедект аравны нэгийг төлөн, Содомын хаанаас дайны олз хүлээн авахаас татгалзав.

Эхлэл 14:1–2, 8–24-ийг зааж, ярилц.

- Лотыг Содомд амьдарч байхад, хэд хэдэн хот-улсын, түүний дотор Содом, Гоморрагийн хаад өөр хоорондоо дайтаж эхэлжээ (Эхлэл 14:1–2, 8–9). Энэ дайны үед Лотод юу тохиолдсон бэ? (Эхлэл 14:10–12-ыг үз) Лотыг боолчлолд аваачигдсаны дараа Абрахам түүнд хэрхэн тусалсан бэ? (Эхлэл 14:13–16-г үз)
- Лотыг аварсны дараа Абрахам хэнтэй уулзсан бэ? (Эхлэл 14:17–18-ыг үз) Мелкизедек гэж хэн байсан бэ? (Эхлэл 14:18; мөн түүнчлэн С ба Г 107:1–2-ыг үз) Абрахам Мелкизедект юу өгдөг байсан бэ? (Эхлэл 14:20)

- Яагаад Абрахам Содомын хааны шагналыг бүр аюул занал гэж үзэн үүнийг хүлээж авахаас татгалзсан бэ? (Эхлэл 14:21–24-ийг үз. Тэрээр зөв шударга бус хаанаас юуг ч хүлээн авахыг хүсээгүй ажээ) Өнөөгийн дэлхийн ёс суртахуунгүй байдлын юуг “өчүүхэн шагнал” гэж үзэж болох вэ? Үнэнч шударга бус байдлын “өчүүхэн шагнал” юу байж болох вэ? Бид өөрсдийн эрэлхийлдэг зугаа цэнгэлээр хүлээн авахыг хүсдэг нилээд олон шударга бус явдалд бид зарим үед хэрхэн бууж өгдөг вэ? Яагаад бид дэлхийн цөөн боловч арга замуудыг өөрсдийнхөө амьдралд оруулахгүй байхыг хичээх нь чухал вэ? (2 Нифай 28:20–21-ийг үз)
- Мелкизедек болон Содомын хаанд үзүүлсэн түүний хариу үйлдлүүдийг харьцуулах замаар Их Эзэнд хандах Абрахамын шийдвэр төгс байдлын талаар бид юу мэдэж болох вэ?

3. Их Эзэн Содом, Гоморра хоёрыг устгав.

Эхлэл 18:16–33; 19:1–29-ийг зааж, ярилц.

- Содом, Гоморрагийн хүмүүсийн алдсын улмаас Их Эзэн эдгээр хотуудыг устгахаар төлөвлөж байжээ (Эхлэл 18:20–21). Энэ төлөвлөгөөг мэдсэний дараа Абрахам Их Эзэнээс юу хүссэн бэ? (Эхлэл 18:23–32-ыг үз) Хэрэв эдгээр хотуудад зөв шударга хүмүүс байх юм бол тэднийг Их Эзэн хамгаалан үлдээхийг хүсч байсан баримтаас бид юу мэдэж болох вэ?
- Яагаад Лот Содомыг орхин явахаар зааварлагдсан бэ? (Эхлэл 19:12–13, 15-ыг үз) Тэрээр тэднийг орхин явахыг шаргуу хүсэхэд Лотын хүргэнүүд хэрхэн хариу үйлдэл үзүүлсэн бэ? (Эхлэл 19:14-ийг үз) Яагаад зарим хүмүүс, тэр ч байтугай аюулын дохио авсан үедээ ч өөрсдийгөө муу нөлөөнөөс зайлуулахыг татгалздаг вэ?
- Лот болон түүний гэр бүл хотыг орхин явах үед тэнгэр элчүүд ямар зөвлөгөө өгсөн бэ? (Эхлэл 19:17-г үз) Аврагч өөрийн дагалдагчдад мөн адил зөвлөгөө өгснийг онцлон тэмдэглэ (Лук 9:62; 17:29–32; С ба Г 133:14–15). “Эргэж харах” гэдэг нь юуг төлөөлж байна вэ? (Орхихыг биднээс хүссэн зүйлд дургүй байх; Христийг дагахад эргэлт буцалтгүй шийдвэр төгс биш байх) Зарим үед бид хэрхэн “эргэж харж” болох вэ?
- Содом уруу эргэж харахад Лотын эхнэрт юу тохиолдсон бэ? (Эхлэл 19:26.-г үз) Лотын эхнэрийн түүх наманчлалын талаар бидэнд юу зааж болох вэ? (Наманчлахын тулд бид зүрх сэтгэл, зан төлвөө өөрчлөх хэрэгтэй. Үүнийг хийхийн тулд бид зарим үед шинэ орчин, шинэ хэлхээ холбоог сонгох ёстой.)
- Тэрээр “майхнаа Содом уруу харуулан босгосны” улмаас Лот юу алдсан бэ? Бид соригдох болно гэдгээ мэдсэн газарт өөрсдийгөө тавьснаар юу алдах учиртай вэ? Бид нүгэлт үйлдэлд шууд оролцоогүй ч гэсэн, өөрсдийгөө хилэнцээр хүрээлүүлэх болгосон үед гай зовлон бидэнд хэрхэн тохиолддог вэ?
- Содом, Гоморра хоёр устгагдахад Лот аврагдсан шалтгааныг Эхлэл 19:29-д юу гэсэн байдаг вэ? (Их Эзэн Абрахамын зөв шударга байдлыг дурсан санажээ.) Бидний зөв шударга зан төлөв бусдад хэрхэн ашиг тусаа өгч болох вэ?

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл хэлэхдээ: “Хэрэв зөв шударга хүмүүсийн залбирлууд байгаагүйсэн бол та нар бүр одоо ч бүрмөсөн сүйрэх устгалаар зочлогдох байсан. . .” (Алма 10:22) гэж нифайчуудын бошиглогч хэлсэн тэр үетэй манай дэлхий эдүгээ маш адилхан байна. Мэдээж хэрэг, бүх зарлигуудын дагуу амьдардаг, тэдний амьдрал болоод залбирлууд нь дэлхийг устгалаас хамгаалж байгаа шулуун шударга, итгэлтэй өдий төдий хүмүүс байгаа шүү дээ” гэжээ (Conference Report, 1971 оны 4-р сар, 7; *Ensign*, 1971 оны 6-р сар, 16).

Дүгнэлт

Хилэнц бидний эргэн тойронд байхад ч гэсэн өөрсдийгөө нүглээс хол байлгахын ач холбогдлыг гэрчил. Дэлхийн зүйлүүд бидэнд нөлөөлөхийн оронд дэлхийд зөв шударга нөлөө үзүүлэхийн төлөө хичээн зүтгэхэд нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

Та Ахлагч М.Рассел Баллардын дараах мэдэгдлээр хичээлээ дүгнэж болно:

“Дэлхийд бай, харин дэлхийнх бус бай” гэсэн энэ хоёр мөртийг бид Сүмд олонтаа хэлдэг. Бүдүүлэг үг хэллэг, хүчирхийлэл, хаа сайгүй нийтлэг, тэр ч байтугай гайхширмаар болсон үнэнч шударга бус явдлыг харуулдаг телевизийн үзүүлбэрүүдийг хараад, бид ямар нэг байдлаар дэлхийгээс тусгаарлагдаж, гэр бүлүүдээ энэ бүхнээс ангид байлгахсан гэж хүсэх нь олонтаа тохиолддог. . . .

“Өмнө дурдсан хоёр мөртийг бид хоёр тусдаа зөвлөгөө болгон хэлж болох юм. Нэгдүгээрт, *‘Дэлхийд бай.’* Оролц; Мэдээлэлтэй бай. Ойлгож, хүлээцтэй байхыг, соёл, зан заншил, сэтгэлгээний ялгааг харгалзан үзэхийг хичээ. Үйлчлэл хийгээд оролцоогоор дамжуулан нийгэмд утга учир бүхий хувь нэмэр оруул. Хоёрдугаарт, *‘Дэлхийнх бус бай’* Буруу замыг бүү дага, эсвэл зөв биш зүйл рүү бүү хэлбий, үүнийг бүү хүлээж ав. . . .

“Сүмийн гишүүд өөрсдөө нөлөөнд автахаас илүүгээр бусдад нөлөөлөх хэрэгтэй. Бид нүгэл, хилэнцийг зогсоох талаар юу ч хийлгүй, өсөн нэмэгдэхийг нь зүгээр харж суулгүй, үүнийг үргэлжлэн өсөхийг нь зогсоохын төлөө ажиллах ёстой. Бид бүгд үүнээс зайлсхийх буюу үл тоомсорлохын оронд асуудлыг шийдвэрлэхэд туслах хэрэгтэй байна.” (Conference Report, 1989 оны 4-р сар, 100–101; *Ensign*, 1989 оны 5-р сар, 80)

Нэмэлт заах санаанууд

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

1. Содом ба Гоморрагийн нүглүүд

Эхлэл 19:4–11 болон Эхлэл 19:9–15-ын Иосеф Смитийн Орчуулгад өгүүлснээр Содом, Гоморра хоёрын хүмүүс бэлгийн харилцааны гутамшигт нүгэлд орооцолдсон ажээ. Гэвч эдгээр нүглүүд ноцтой байсан хэдий ч, зөвхөн үүний улмаас уг хотууд устгагдсан цорын ганц нүгэл биш байв. Езекиел 16:49–50-ийг ангийн гишүүдээр чангаар уншуулж, Содом, Гоморрагийн хүмүүс гэмтэй байсан бусад нүглүүдийн талаар ангитай ярилц. Жижиг мэт санагддаг нүглүүдээр ч, мөн түүнчлэн том нүглүүдээр ч бид устгагдаж болохыг ойлгоход нь ангийн гишүүдэд тусал.

2. Үлгэр жишээгээр удирдах нь

Хожмын үеийн Гэгээнтнүүд дэлхийгээр нөлөөлөгдөхийн оронд өөрсдөө сайн нөлөө үзүүлж болох нэг арга замыг харуулахын тулд та *Old Testament Video Presentations* (53224)-ын “Үлгэр жишээгээр удирдах нь” долоон минутын хэсгийг үзүүлж болно. Энэ хэсэгт, залуу эмэгтэйн зөв шударга үлгэр жишээ, Есүс Христийн сайн мэдээнд хөрвөгдөхөд нь нэг найзад нь тусалсан тухай өгүүлдэг.

“Бурхан Өөрийгөө Хургаар Хангана”

Абрахам 1; Эхлэл 15–17; 21–22

Зорилго

Исаакаар тахил өргөхөд Абрахам бэлэн байсныг тэд мэддэг учир өөрийн Хүүг өргөлд барьсан Тэнгэрлэг Эцэгийн золиослолыг илүү сайн ойлгоход нь ангийн гишүүдэд туслах.

Бэлтгэл

1. Дараах судруудыг залбирч судал. Анхаар: Эхлэл 17-д Их Эзэн Абрамын нэрийг Абрахам, Сарайгийн нэрийг Сара (шүлэг 5, 15-ыг үз) болгон өөрчилсөн тухай өгүүлдэг. *Абрахам, Сара* гэдэг нэрнүүд энэ хичээлийн туршид хэрэглэгдэх болно.
 - а. Абрахам 1:1, 5–20. Абрахам залуу байхдаа Фараогийн хуурамч санваартнуудаар мөрдөн хавчигдаж байжээ. Тэд түүгээр тахил өргөх гэж оролдсон ч, түүнийг Иехова аварчээ.
 - б. Эхлэл 15–17; 21. Абрахам амьдралдаа хожуу үр хүүхэд хүсч, мөн энэ нь амлагджээ (15:1–6). Сара Хагарыг Абрахамд эхнэр болгон өгөв; Хейгар Ишмаэлыг төрүүлэв (16:1–16). Бурхан Абрахамтай хийсэн өөрийн гэрээний тухай дахин ярьж, тэрээр олон үндэстний эцэг байх болно хэмээн амлав (17:1–14; хичээл 7-г үз). Түүгээр дамжин гэрээ үргэлжлэх Исаакийн төрөлт зарлагдав (17:16–22). Сара Исаакийг төрүүлэв (21:1–12).
 - в. Эхлэл 22. Исаакийг тахилд өргөхийг Бурхан Абрахамд зарлиглав (22:1–2). Абрахам Исаакийг тахилд өргөхөөр бэлтгэсэн хэдий ч, түүний оронд тахил өргөх эр хониор Бурхан хангав (22:3–19).
2. Нэмэлт уншлага: Еврей 11:8–19; Иаков 2:21–23; Иаков 4:5; Сургаал ба Гэрээ 132:34–36
3. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх хоёр дахь үйл ажиллагааг ашиглах бол, тэд золиослох хүсэлтэй байсны улмаас адислагдсан үеийнхээ тухай ярихаар бэлтгэхийг энэ хичээлээс наад зах нь долоо хоногийн өмнө ангийн хэдэн гишүүнээс хүс.
4. Хэрэв дараах үзүүлэнгүүд байдаг бол, та тэдгээрийн заримыг хичээлийнхээ хэсэг болгон ашиглаж болно:
 - а. Тэнгэр Элч Абрахамыг аварсан нь (62607; Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 104) Абрахам Исаакийг Тахилд Өргөхөөр Аваачсан нь (62054; Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 105) зургууд.

Энэ хичээлийг заах зөвлөмж

Анхаарал
төвлөрүүлэх
үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагаануудын аль нэгийг (эсвэл өөрийнхөө үйл ажиллагаануудын нэгийг) ашиглахыг хүсч болно. Ангийн хувьд хамгийн тохиромжтой үйл ажиллагааг сонгож ав.

1. Өөрсдийнхөө маш их хайрладаг нэг хүний тухай эсвэл өөрсдийнхөө эзэмшдэг өндөр үнэтэй зүйлийн тухай бодохыг ангийн гишүүдээс хүс.
 - Хэрэв энэ хүнээ, эсвэл нөгөөх эзэмшдэг зүйлээ хаях буюу золиослохыг Бурхан танаас хүсвэл танд ямар санагдах вэ? Та яах вэ?
2. Тэд золиослох хүсэлтэй байсны улмаас адислагдсан үеийнхээ тухай ярихыг ангийн хэдэн гишүүнээс хүс.

Абрахам маш их хайртай байсан хүү Исаагаа тахилд өргөхийг Бурхан Абрахамд зарлигласныг энэ хоёр үйл ажиллагааны дараа тайлбарла. Энэхүү золиослолыг бүрмөсөн хийх нь Абрахамаас шаардагдаагүй ч гэсэн, үүнийг хийх түүний хүсэл “зөв шударга зүйл хэмээн түүнд тооцогдсон бөлгөө” (С ба Г 132:36). Абрахамын зөв шударгын улмаас тэр болон түүний үр удам агуу ихээр адислагдсан билээ.

Судрын ярилцлага
ба хэрэглээ

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагауудаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Фараогийн хуурамч санваартнууд Абрахамыг бараг л тахилд өргөх шахав.

Абрахам 1:1, 5–20-ийг зааж, ярилц. Энэ хичээлийн нэг хэсгийг Абрахам Исаакийг тахилд өргөх тухай Бурханы зарлиг дээр төвлөрүүл. Энэ зарлигийн ач холбогдол хийгээд Абрахамын гүн итгэлийг ойлгоход нь ангийн гишүүдэд туслахын тулд, Абрахам залуу байхдаа Фараогийн хуурамч санваартнуудаар золтой л тахилд өргүүлчихээгүй тухай Абрахамын туршлагын тухай товч яриагаар хичээлийг эхэл.

- Абрахамыг тэнд амьдарч байхад Халдеин нөхцөл байдал ямар байсан бэ? (Абрахам 1:1, 5–8-ыг үз) Фараогийн хуурамч санваартнууд Абрахамыг яах гэсэн бэ? Абрахам 1:7, 12-ыг үз) Абрахам эдгээр хуурамч санваартнуудаас хэрхэн аврагдсан бэ? (Абрахам 1:15–16, 20-ийг үз)
- Хуурамч санваартнуудын тахилын ширээний дэргэдэх Абрахамын туршлага түүнийг ирээдүйн зовлон зүдгүүрүүдэд хэрхэн бэлтгэсэн байж болох вэ? Бидний зовлон зүдгүүрүүд ирээдүйн бэрхшээлүүдэд биднийг хэрхэн бэлтгэж болох вэ?

2. Абрахам Хейгар, Сара нараас хүүхдүүдтэй болов.

Эхлэл 15–17; 21-ийг зааж, ярилц.

- Хүүхдүүдийн талаар Их Эзэн Абрахамд ямар амлалт өгсөн бэ? (Эхлэл 15:1–6-г үз) Яагаад Сара Хагарыг Абрахамд эхнэр болгон өгсөн бэ? (Эхлэл 16:1–3; С ба Г 132:34–35-ыг үз) Их Эзэн Хагарт ямар амлалт өгсөн бэ? (Эхлэл 16:10–11-ийг үз)
- Эхлэл 17:15–16, 19 болон 21-д Их Эзэн Абрахамд юу илчилсэн бэ? Абрахам хэрхэн хариулсан бэ? (Эхлэл 17:17-г үз. Сара хүү төрүүлэх болно гэдгийг Абрахам сонсоод “инээсэн” гэж Библийн Хаан Жеймсийн Хувилбарт өгүүлдэг бол, еврей үгийн ижил орчуулга нь уг сониныг дуулаад “баяссан” гэсэн утгатай ажээ.) Иосеф Смитийн Библийн орчуулагад Абрахам уг сониныг дуулаад “баяссан” гэж өгүүлсэн байдаг.

- Абрахам Сара нар хүүхэдтэй болно гэсэн илчлэлт Бурхан өөрийн амлалтуудыг хэрхэн хэрэгжүүлдэг талаар бидэнд юу зааж болох вэ? (Бурхан өөрийн амлалтуудыг бидний хүсэн хүлээсэн арга зам буюу цаг хугацаанд биш ч гэсэн, биелүүлэх болно. Абрахам болон судрууд дахь бусад олон хүмүүс амлагдсан адислалууд нь хэрэгжих хүртэл олон жил итгэлтэйгээр хүлээх шаардлагатай байсныг тэмдэглэн хэл)
- Исаакийн талаар хийсэн Бурханы амлалт Ишмаелын талаарх амлалтуудаас ямар ялгаатай байсан бэ? (Эхлэл 17:19–21-ийг үз)

3. Исаакийг тахилд өргөхийг Бурхан Абрахамд зарлиглав.

Эхлэл 22-ыг зааж, ярилц.

- Бурхан яагаад Исаакийг тахилд өргөхийг Абрахамаас хүссэн бэ? (Эхлэл 22:1-ийг үз. Энэ шүлэг дэх уруу *татах* гэдэг үг сорих буюу нотлох гэсэн утгатай гэж заасан зүүвэр тайлбар1а-г анхаар) Энэ нь Абрахамын хувьд яагаад хүнд сорилт байсан бэ? (Зөвхөн Исаак түүний хүү байсан төдийгүй, Исаак болон түүний үр удмаар дамжин Абрахамын гэрээ үргэлжлэх болно хэмээн Бурхан амласан байлаа [Эхлэл 17:19]. Хүнд хэцүү байж болох өөр нэг шалтгаан бол Абрахам өөрөө залуу байхдаа Фараогийн хуурамч санваартнуудаар тахилд өргөгдчих шахсан тэр явдал байлаа [Абрахам 1:1, 5–20])
- Исаакийг тахилд өргөх Бурханы зарлигт Абрахам хэрхэн хариулсан бэ? (Эхлэл 22:2–3-ыг үз) Итгэл хийгээд дуулгавартай байдлын талаар бид Абрахамаас юу сурч болох вэ? (Еврей 11:17–19; Иаков 2:21–23-ыг үз)
- Энэ нөхцөл байдалд Исаак хэрхэн хариулсан бэ? (Эхлэл 22:3–10-ыг үз. Түүнийг тахилд өргөх гэсэн Абрахамын бодлыг Исаак эсэргүүцсэн шинж тэмдэг илрээгүй ажээ.)

“Тэд зааж өгсөн газарт хүрч ирээд, Абрахам тахилын ширээ босгож, модоо бэлтгэжээ. Тэгээд, Библид өгүүлснээр ‘Абрахам . . . хүү Исаакаа хүлж, тахилын модон дээр тавив’ (Эхлэл 22:9). Абрахам ийм хачин зүйл хийж байхад Исаак юу бодож байсан бол? Эсэргүүцэн тэмцсэн тухай Библид дурдагдаагүй. Исаак нам чимээгүй байсан нь эцэгтэй итгэж, түүнд дуулгавартай байсан ганцхан нөхцөлөөр л тайлбарлагдаж болно” хэмээн Ахлагч Даллин Х.Өүкс тайлбарласан байдаг (Conference report, 1992 оны 10-р сар, 51; *Ensign*, 1992 оны 11-р сар, 37).

- Исаакийг тахилд өргөхөд Абрахам бэлэн байсан нь Өөрийн Төрсөн Ганц Хүүг золиослоход Тэнгэрлэг Эцэг бэлэн байсантай адил төстэй юм (Иаков 4:5; Эхлэл 22:8, 13). Абрахамын болон Тэнгэрлэг Эцэгийн туршлагуудын хооронд ямар адил төстэй зүйл байна вэ? Хамгийн агуу ялгаа нь юу вэ?
- Бид ямар байдлаар Исаактай харьцуулагдаж болох вэ? Хэрэв Исаак биднийг төлөөлсөн бол, шугуй дахь эр хонь хэнийг төлөөлдөг вэ? Хүүгээ золиосолсонд илэрдэг та нарын төлөөх Тэнгэрлэг Эцэгийн хайрыг илүү сайн ойлгоход эдгээр харьцуулалт та нарт хэрхэн тусалдаг вэ?

Ахлагч Даллин Х.Өүкс хэлэхдээ: “Энэ түүх . . . Исаакийг хамгаалж, тэрээр үхэхгүй байхын тулд түүнийг орлуулах зүйлээр хангасан Бурханы нинжин сэтгэлийг харуулдаг. Бидний нүглүүд хийгээд бидний мөнх бус байдлын улмаас бид, Исаак шиг, үхэлд буруутгагддаг. Бусад бүх найдвар

үгүй болоход, Тэнгэр дэх бидний Эцэг Бурханы Хургаар хангаж, тэгээд бид түүний золиослолоор аврагдсан билээ” гэжээ (Conference report, 1992 оны 10-р сар, 51; *Ensign*, 1992 оны 11-р сар, 37).

- Энэ сорилтоор дамжуулан Абрахам юуг нотолсон бэ? (Эхлэл 22:11–12-ыг үз) Хувь хүмүүс өөрсдийн итгэлтэй байдлыг нотлон харуулах боломжийн хувьд, хувь хүмүүс соригдсон судрын болон хувь хүний бусад тохиолдлуудын тухай ярихад ангийн гишүүдийг урь. Итгэлтэйгээ нотолсноор дамжин ирдэг баяр хөөр хийгээд адислалуудын тухай мөн ярихыг ангийн гишүүдээс хүс.
- Эхлэл 22:16-д яагаад Исаакийг Абрахамын ганц хүү гэсэн бэ? (Исаак бол түүгээр дамжин гэрээ үргэлжлэх хүү байлаа. Энэхүү ишлэл нь бас Исаак болон бидний Аврагч, Эцэгийн Төрсөн Ганц Хүүгийн хоорондох адил төстэй байдлыг онцлон заадаг.) Түүний итгэлтэй байдлын улмаас ямар адислалууд Абрахамд итгэмжлэгдсэн бэ? (Эхлэл 22:15–18-ыг үз) Абрахамын гэрээгээр дамжин ямар адислалууд бидэнд амлагдсан бэ? (Хичээл 7-г үз) Абрахамын гэрээний өв залгамжлагчдын хувьд бидний үүрэг хариуцлага юу вэ?

Дүгнэлт

Абрахамын харуулсан итгэл болон дуулгавартай байдлын үлгэр жишээний төлөө талархлаа илэрхийл. Исаакийг тахилд өргөхөд Абрахам бэлэн байсан нь Өөрийн Төрсөн Ганц Хүүг золиослоход Тэнгэрлэг Эцэг бэлэн байсантай адил төстэйг гэрчил. Цагаатгалын тухай, түүнчлэн Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрын биднийг хайрладаг агуу хайрын тухай бодол санаагаа хуваалцахад ангийн гишүүдийг урь.

Нэмэлт заах санаанууд

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

1. Зовлон зүдгүүрээс суралцах нь

- “Абрахамын тухай ямар нэг зүйлийг Абрахам мэдэх хэрэгтэй байсан учраас” (Труман Г.Мадсен, *The Highest in Us* [1978], 49) Исаакар тахил өргөхийг Бурхан Абрахамд зарлигласан юм хэмээн Ерөнхийлөгч Хью Б.Браун хэлжээ. Энэ туршлагаас Абрахам өөрийнхөө тухай юу мэдэж авсан байж болох вэ? Өөртөө тохиолдсон зовлон зүдгүүрүүдээс та нар юу сурсан бэ?
- Бид “бүр Абрахам шиг” соригдох ёстойг Их Эзэн илчилсэн юм (С ба Г 101:4). Яагаад та нар энэ нь чухал гэж боддог вэ? (С ба Г 101:5, 35–38; 122:5–7-г үз) Их Эзэн биднээс хийхийг хүсдэг золиослолуудад бид өөрсдийгөө бэлтгэхийн тулд бид одоо юу хийж болох вэ?

2. Бурхантай хүчтэй харилцааг бий болгох нь

Абрахам 1, 2 нь Абрахам, түүний эцэг хоёр Бурхантай харилцаатай байсныг дүрслэн өгүүлдэг. Абрахамын эцэг зовлон зүдгүүрийн үед Бурханд ханддаг байсан боловч, юмс амьдралд нь сайн байсан үед хиймэл шүтээн рүү эргэсэн ажээ (Абрахам 1:5, 30; 2:5). Нөгөө талаар, Абрахам Бурханыг эрж хайхаа үргэлжлүүлсээр байжээ (Абрахам 1:2, 4; 2:12).

- Бид Бурхантай харилцах харилцаагаа идэвхгүй биш, харин идэвхтэй болгосноор Бурханыг хэрхэн эрж хайж чадах вэ? Бид амар амгалангийн цагт ч, бас зовлон зүдгүүрийн цагт ч түүнийг эрж хайхын тулд Бурханд хандах шийдвэр төгс байдлаа хэрхэн байнгын болгож чадах вэ?

Залгамжлах эрхийн адислалууд; Гэрээн дэх гэрлэлт

Хичээл
10

Эхлэл 24–29

Зорилго

Залгамжлах эрхийн адислалууд болон мөнхийн гэрлэлтэд нийцэхүйцээр зохистой амьдрах ангийн гишүүдийн хүслийг хүчтэй болгох.

Бэлтгэл

1. Дараах судруудыг залбирч судал:
 - а. Эхлэл 24. Исаакт зохистой эхнэр сонгосноор дамжуулан гэрээн дэх гэрлэлтийн (мөнхийн гэрлэлт) ач холбогдлыг Абрахам онцгойлон үзэв.
 - б. Эхлэл 25:20–34. Ребека төрөөгүй ихэр хөвгүүдийнхээ талаар илчлэлт хүлээн авав (25:22–23). Эдгээр хөвгүүд өсөхөд, Есав залгамжлах эрхээ Иаковт худалджээ (25:29–34).
 - в. Эхлэл 26–29. Абрахамын гэрээний адислалууд Исаак болон түүний үр удамд амлагдав (26:1–5). Есав гэрээнээс гадуур гэрлэж, эцэг эхдээ уй гашуу авчрав (26:34–35). Хүмүүс хийгээд үндэстнүүдийн дээр захируулахаар Исаак Иаковыг адислав (27:1–46). Абрахамын гэрээний адислалуудыг Исаак Иаков дээр зарлан мэдэгдэж, зохистой эхнэр олуулахаар түүнийг хол явуулав (28:1–10). Иаков Леа, Рахел нартай гэрээнд гэрлэжээ (29:1–30).
2. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх нэгдэх үйл ажиллагаа ашиглавал, жижигхэн аяга буюу эсвэл шарсан эрдэнэ шиштэй хүүдий эсвэл нэг жимс авчир.
3. Хэрэв та өсвөр насныхан буюу ганц бие залуу насанд хүрэгчдэд заадаг бол, “Зөв гэрлэлт зөв болзооноос эхэлдэг” гэсэн хоёр дахь нэмэлт заах санааг ашиглахыг бод.
4. Хэрэв дараах үзүүлэнгүүд байдаг бол та тэдгээрийн заримыг хичээлийнхээ хэсэг болгон ашиглаж болно:
 - а. *Хуучин Гэрээний Видео Танилцуулгууд* (53224)-ын “Гэрээн дэх Гэрлэлт,” дөрвөн минутын бичлэг.
 - б. Худаг дээр байгаа Ребекагийн зураг (62160)

Энэ хичээлийг заах зөвлөмж

Анхаарал
төвлөрүүлэх
үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагаануудын аль нэгийг (эсвэл өөрийнхөө үйл ажиллагаануудын нэгийг) ашиглахыг хүсч болно. Ангийн хувьд хамгийн тохиромжтой үйл ажиллагааг сонгож ав.

1. Аяга буюу шарсан эрдэнэ шиштэй хүүдий эсвэл нэг жимс үзүүлж, дараах асуултыг ангийн гишүүдээс асуу:
 - Хэрэв та яг одоо нэг аяга шарсан эрдэнэ шиш (эсвэл нэг жимс) авах, эсвэл тарьж, арчилж тордон, хураасны дараа хожим хязгааргүй их эрдэнэ шиш (эсвэл жимс) авах сонголт хийх болбол, та алийг нь сонгох вэ? Яагаад?

Бид одоо хялбархнаар олж авч чадах зүйлүүд эсвэл үүний төлөө ажиллаж, хүлээх шаардлагатай зүйлүүдийн аль нэгийг сонгох сонголт бидэнд олонтаа тулгардгийг тайлбарла. Ажиллаж, хүлээх сонголт нь эцэстээ илүү их адислал авчрах байлаа ч гэсэн, заримдаа бид тэр даруйд тааламж буюу сэтгэл ханамж авчрах зүйлийг сонгодог. Эрдэнэ шишийг (эсвэл жимсийг) одоо юу эсвэл хожим авахаар сонгох уу гэдэг нь чухал шийдвэр биш. Гэвч, хэнтэй, хаана гэрлэх вэ гэх мэтийн өөр сонголтуудтай бид амьдралд тулгардаг—энд тэр даруйд ирэх тааламжийг сонгох нь алдар суут хийгээд урт удаан үргэлжлэх адислалыг бидний хувьд үгүй болгож болно.

2. Дараах асуултыг ангийн гишүүдээс асуу:

- Та нар хэзээ нэгэн цагт ямар нэг юм олж авахын тулд мөнгө, цаг хугацаа зараад, тэр юм зарсан зүйлийн чинь үнэ цэнэд хүрэхгүй байсан тийм тохиолдол байсан уу?

Өөрсдөд нь хэрэгтэй гэж хүсч байсан ямар нэг зүйлд хэтэрхий ихийг төлсөн үеийнхээ тухай ярихад ангийн хэдэн гишүүнийг урь (эсвэл та өөрийнхөө туршлагыг хуваалцахыг хүсч болно).

Сүнсний хувьд ч яг ийм зүйл тохиолдож болохыг тайлбарла. Зөв шударга биш сонголтууд хийснээр бид өчүүхэн бага үнэ цэнэтэй зүйлүүдийн төлөө мөнхийн адислалуудыг алдаж болно. Гэтэл зөв шударгаар амьдарснаар бидэнд зориулж Тэнгэрлэг Эцэгийн бэлтгэсэн бүх адислалуудыг бид хүлээн авч чадна.

Судрын ярилцлага ба хэрэглээ

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагауудаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Гэрээн дэх гэрлэлтийн (мөнхийн гэрлэлт) ач холбогдлыг Абрахам онцлон тэмдэглэв.

Эхлэл 24-ийг зааж, тэмдэглэ. Та нар мөнхийн гэрлэлтийн ач холбогдлын талаар ярилцахдаа, өөрсдөө буюу эцэг эх нь ариун сүмд гэрлээгүй байгаа ангийн гишүүдийн сэтгэл санаанд болгоомжтой ханд.

- Яагаад Абрахам өөрөө болон Исаак нутаг дээр нь амьдарч байсан канаанчуудаас биш, өөрийнх нь овгийн эмэгтэйтэй гэрлэх ёстой гэж шаргуу шаардаж байсан бэ? (Исаак өөрийнхөө итгэлийн эмэгтэйтэй гэрлэснээр тэрээр гэрээнд гэрлэж чадна гэж Абрахам хүсч байжээ. Абрахамын үр удамд Абрахамын гэрээний адислалууд өгөгдөхөд энэ нь чухал юм) Бид гэрээнд гэрлэх нь яагаад чухал вэ? (Хэрэв шаардлагатай бол, манай өнөө үед *гэрээн дэх гэрлэлт*, *мөнхийн гэрлэлт*, *ариун сүмийн гэрлэлт* гэдэг холбоо үгс олонтаа бие биенээ орлон хэрэглэгддэгийг тайлбарла)
- Гэрээн дэх гэрлэлт хэр зэрэг удаан хугацааны туршид Бурханы зарлиг байгаа вэ? (Энэ бол сайн мэдээний бүрэн байдал дэлхий дээр байсан бүх үеийн туршид Их Эзэний жаяг байсаар ирсэн мөнхийн ёслол юм. Адам Ева хоёр энэ дэлхий дээр энэ гэрээнд анх удаа оржээ.)
- Исаакт эхнэр олохоор Абрахам зарцаа явуулжээ (Эхлэл 24:4). Абрахамын зарц та нарт ямар сэтгэгдэл төрүүлдэг вэ? (Эхлэл 24-ийг үз. Хариулт нь

олон өөр байж болох хэдий ч, тэрээр итгэл хүлээсэн, үнэнч, залбирдаг хийгээд итгэл бишрэлтэй байсан нь энд багтана. Тэр ч байтугай, урт удаан аяллын дараа тэрээр Абрахамын зарсан ажлыг дуусгахаас өмнө хоолоо иддэггүй байв. Баяр тэмдэглэхээр 10 өдөр саатахын оронд тэрээр Ребека авч Абрахам руу шууд буцжээ.) Их Эзэн бидэнд ноогдуулсан үүрэг хариуцлагуудыг илүү сайн биелүүлэхийн тулд бид Абрахамын зарцаас юу сурч болох вэ?

- Ребека Исаакт сайн эхнэр байх болно гэдгийг Абрахамын зарц яаж хэлж чадсан бэ? (Эхлэл 24:15–20, 58-ыг үз. Абрахамын зарц болон түүний тэмээнүүдэд худгаас ус татаж өгснөөр Ребека эелдэг найрсаг, бусдад туслах хүсэлтэйгээ харуулсан аж. Нэг тэмээ өдөрт 30 галлон хүртэл (1 галлон=3.8 л) ус уудаг гэж бодоход 10 тэмээг услахын тулд Ребека худгаас асар их ус татсаныг та тэмдэглэн хэлж болно. Түүчлэн Ребека Исаактай гэрлэхийн тулд гэр бүлээ орхин явахыг хүсч байсан нь тэрээр Исаактай гэрлэх нь Их Эзэний таалал гэдгийг мэдэж байсных, магадгүй тэрээр агуу итгэлтэй байсных биз ээ.)
- Та нар эхнэр буюу нөхөртөө ямар чанарууд байгаасай гэж хүсдэг вэ? Яагаад сүнслэг чанарууд биеийн гадаад төрх байдлаас илүү чухал вэ? Биднийг сайн нөхөр буюу эхнэр болгодог ямар чанаруудыг бидний хүн нэг бүр өөртөө хөгжүүлэх ёстой вэ? (бид аль хэдийн гэрлэсэн буюу гэрлээгүй нь хамаагүй)
- Хүн мөнхийн гэрлэлтэд хэзээнээс эхэлж бэлтгэх ёстой вэ? Хүүхдүүд болон залуучууд мөнхийн гэрлэлтэд бэлтгэхийн тулд хийж болох зарим зүйлүүд юу вэ? Ариун сүмд гэрлэхэд бэлтгэхэд нь хүүхэд залуучуудад туслахын тулд эцэг эхчүүд болон насанд хүрсэн бусад хүмүүс юу хийж болох вэ?

Ерөнхийлөгч Ховард В.Хантер хэлэхдээ: “Бидний хүүхдүүд Их Эзэний өргөөнд гэрлэх явдлыг төлөвлөж, зааж, шаргуу хүсэцгээе. Та нар хаана гэрлэж, ямар эрх мэдлээр нөхөр, эхнэр болж зарлагдах нь үнэхээр их учиртайг өнгөрсөн үед бидэнд хэзээ ч байгаагүй илүү их идэвхтэйгээр дахин баталцгаая” гэжээ (Conference Report, 1994 оны 10-р сар, 118; *Ensign*, 1994 оны 11-р сар, 88).

2. Есав өв залгамжлах эрхээ Иаковт худалдав.

Эхлэл 25:20–34-ийг зааж, ярилц.

- Хараахан төрөөгүй ихэр хөвгүүдийнхээ талаар Ребека ямар илчлэлт хүлээн авсан бэ? (Эхлэл 25:22–23-ыг үз) “Ахмад нь дүүмэддээ үйлчлэх болно” гэсэн Их Эзэний мэдэгдэл яагаад ер бусын илчлэлт байсан бэ? (Өв залгамжлах эрх нь ихэвчлэн эцгээс ууган хүүд дамжуулагддаг байв. Энэхүү өв залгамжлах эрхийг хүлээж авснаар ууган хүү гэр бүлийнхээ эд хөрөнгийг хоёр дахин ихээр өвлөх бөгөөд үүнийхээ хариуд тэрээр гэр бүлээ тэргүүлж, эцгээ нас барсны дараа эх, эгч, эмэгтэй дүү нартаа анхаарал халамж тавьдаг байв. “Ахмад нь дүүмэддээ үйлчлэх болно” хэмээн Ребекад өгсөн Их Эзэний илчлэлт дэх мэдэгдэл нь энэ нөхцөлд бага хүү нь залгамжлах эрхийг хүлээн авч, улмаар түүний үр удам гэрээт хүмүүс болно гэсэн утгатай ажээ.)

- Ууган хүү Есав өөрийн өвөг эцэг Абрахам, Их Эзэн хоёрын хооронд хийгдсэн гэрээг өв залгамжлах өөрийнхөө эрхийн талаар ямар бодолтой байсан бэ? (Эхлэл 25:29–34-ийг үз. Биеийнхээ түр зуурын өлсгөлөнг хангахын тулд Есав өв залгамжлах эрхээ орхиход бэлэн байсан нь тэрээр уг эрхийг хичнээн өчүүхнээр үнэлдэг байсныг харуулж байна.)
- Бид сүмийн гишүүний хувьд, бүгдээрээ тэнгэрлэг эцэг эхчүүдээс сүнсний өв залгамжлэх эрхтэй билээ. Бидний өв залгамжлах эрхэд ямар адислал багтдаг вэ? (Хариултууд нь санваар, ариун сүмийн адислалууд, ёслолууд, илчлэлт түүнчлэн өргөмжлөлийн чадавхи байж болно.)
- Бид хаана гэрлэх нь өв залгамжлах эрхийн адислалуудаа хүлээн авах бидний чадварт хэрхэн нөлөөлдөг вэ? (Бид ариун сүмийн хишиг хүртэх болон мөнхийн гэрлэлтийн гэрээнүүд хийж, сахьснаар өргөмжлөл хийгээд мөнхийн өсөлт дэвшилтэд хамаардаг Абрахамын гэрээний хэсэгт ордог.)
- Бидний үг, үйл хэрэг биднээс өв залгамжлах эрхээ үнэлэх үнэлэмжид хэрхэн харагддаг вэ? Мөнхийн үнэ цэнээс илүүгээр тэр даруйд сэтгэл ханамж авчирдаг зүйлүүдийг сонгосноороо бидний зарим нь хэрхэн Есавынхтай төстэй алдаа гаргаж болох вэ?
- Гэрээний өв залгамжлагчийг тогтоохын тулд Их Эзэн Исаакийг түүний ах Ишмаелаас дээгүүрт (Галат 4:22–23), Иаковыг түүний ах Есаваас, Иосефыг түүний ах Реубенээс (Шастирын дээд 5:1–2), түүнчлэн Ефраимыг түүний ах Манассегаас тус тус (Эхлэл 48:17–20) дээгүүрт сонгосон юм. Бид Бурханы дуудлагууд хийгээд адислалуудад тэнцэхийн тулд энэ нь юу хийхийг бидэнд сануулж байна вэ?

3. Иаков Леа, Рахел хоёртой гэрээнд гэрлэж, түүгээр дамжин Абрахамын гэрээ үргэлжлэв.

Эхлэл 26–29-ийг зааж, ярилц.

- Есав эхнэрүүдээ сонгосон нь түүний энэ тэргүүнд тавьдаг зүйлүүдийн талаар бидэнд юу өгүүлж байна вэ? (Эхлэл 26:34–35; 28:6–9-ийг үз) Гэрээнд гэрлэх түүний хүч чармайлтуудаас Иаковын талаар бид юу мэдэж болох вэ? (Эхлэл 28:1–5; 29:1–28-ыг үз. Бидний сурах нэг зүйл бол гэрээнд гэрлэх нь Иаковын хувьд туйлын чухал байсан явдал мөн. Гэрлэх итгэлтэй эмэгтэйг олохын тулд тэрээр урт удаан аян хийжээ. Рахелтай гэрлэхээсээ өмнө тэрээр Лабанд долоон жил ажил хийж, дараа нь ч түүнд ажиллахаа үргэлжлүүлсэн аж.) Гэрээнд гэрлэх нь бидний хувьд чухлыг бид хэрхэн харуулж чадах вэ?

Австралид Сүмд элсэж, дараа нь Шинэ Зеланд уруу аялж, гэр бүлээрээ лацдан холбуулахын тулд бүх эд хөрөнгөө худалдсан нэг гэр бүлийн тухай Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли ярьжээ. “Бид [ариун сүмд] явах мөнгөгүй байв. Бидний дэлхийн өмч хөрөнгө гэвэл нэг хуучин машин, гэрийн тавилга, сав суулга л байлаа. ‘Бид *явахгүй* байж болохгүй. Хэрэв Их Эзэн надад хүч чадал өгдөг юм бол, би ажил хийж өөр машин, тавилга, сав суулга худалдаж авах мөнгө олж чадна, харин би хайртай хүмүүсээ алдах юм бол, би үнэн хэрэгтээ энэ амьдралд, үүрд мөнхөд аль алинд нь ядуу байх болно’ хэмээн би эхнэртээ хэлж билээ” гэж тэр гэр бүлийн эцэг хэлжээ (*Be Thou an Example* [1981], 138).

- Хоёр хүн ариун сүмд гэрлэсний дараа тэд үнэхээр мөнхийн гэрлэлт хийсэндээ бат итгэлтэй байхын тулд тэд юу хийх ёстой вэ? Ариун сүмд хийгдсэн гэрээнүүд болон амлагдсан адислалууд биелэгдэхийн тулд нөхөр эхнэр хоёр гэрлэлтийн харилцаагаа хэрхэн цааш үргэлжлүүлж, улам сайжруулж болох вэ? (Тэдний нөхөр буюу эхнэр эсвэл эцэг эх өөрсдийн гэрлэлтэд селестиел сүнсийг авчирдаг ямар нэг зүйлийн үлгэр жишээг хуваалцахад та ангийн хэдэн гишүүнийг урьж болно.)

Дүгнэлт

Гэрээнд гэрлэх болон өв залгамжлах эрхийн адислалуудын төлөө зохистой амьдрахын ач холбогдлыг онцлон тэмдэглэ. Түр зуурын тааламж буюу сэтгэл ханамжийн төлөө мөнхийн адислалуудыг алдахгүй ухаалаг сонголтууд хийхэд нь ангийн гишүүдэд түлхэц үзүүл.

Нэмэлт заах санаанууд

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

1. Ребека Исаакийн эхнэр болон сонгогдов

Эхлэл 24-ийн дараах ишлэл тус бүрийг өөр өөр цаасан дээр бичиж, ангийн гишүүдэд нэг буюу түүнээс олныг өг. Ангийн гишүүдийг судар ашиглуулан эдгээр нотолгоонуудыг хэн хийсэн мөн ямар шүлгүүдэд цэдэглэгдсэнийг олуул. Ангийхныг дууссаны дараа эдгээр нотолгоонууд болон тэд ямар нөхцөлд хүрсэн талаар ярилц. Гэрээнд гэрлэхийн ач холбогдол, Абрахамын зарцын итгэл хийгээд үнэнч шударга зан, түүнчлэн мөнхийн хамтрагчаа сайн сонгоход түүнийг хүргэсэн Ребекагийн зан чанаруудын ач холбогдлыг онцлон тэмдэглэ.

- “Чи Канаанчуудын охидоос хүүд минь эхнэр сонгох ёсгүй.”
- “Чи миний нутагт, төрөл төрөгсдөд минь очиж, хүүд минь эхнэр авч өгөх ёстой.”
- “Тэнгэрийн Бурхан ЭЗЭН . . . Өөрийнхөө тэнгэр элчийг чиний өмнө илгээнэ.”
- “Чи миний эзэнд нинжин сэтгэлээр хандсаныг чинь би үүгээр мэдэх болно.”
- “Би бас ус утгаж, таны тэмээнүүдийг ч бас ханатал нь усалъя.”
- “Би бол Милкагийн Нахорт төрүүлж өгсөн хүү Бетуелийн охин.”
- “Намайг эзний минь дүүгийн гэрт ирүүлсэн Их Эзэн Бурхан адислагдаг.”
- “Тэр надад ‘Уу, уу! Би бас тэмээнүүдэд чинь ус авчиръя гэж хэлбэл тэр бүсгүй нь ЭЗЭНЭЭС миний эзний хүүд заяасан хүн болно.”
- “Одоо та нар миний эзэнд энэрэл хайраа, үнэнч шударгаа үзүүлье гэвэл надад хэлээрэй: тэгэхгүй гэсэн ч надад хэлээрэй.”
- “Болгоогтун, Ребека чиний өмнө байна, түүнийг аваад яваарай, Эзэний айлдсан ёсоор тэрээр таны эзний хүүгийн гэргий болог.”
- “Би явна.”
- “Охин дүү минь, чи мянга түмэн хүний эх болох болтугай.”

Хариултууд: а-Абрахам (ш. 3); б-Абрахам (ш. 4); в-Абрахам (ш. 7); г-зарц (ш. 14); д-Ребека (ш. 19); е-Ребека (ш. 24); ё-зарц (ш. 27); ж-зарц (ш. 44); з-зарц (ш. 49); и-Лабан Бетуел хоёр (ш. 51); й-Ребека (ш. 58); к-Ребекагийн гэрийнхэн (ш. 60)

2. “Зөв гэрлэлт зөв болзооноос эхэлдэг”

- Исаак Иаков хоёр аль аль нь өөрсдийн итгэл бишрэлийн эмэгтэйчүүдтэй гэрлэхийг эцгүүдээрээ зааварчлуулсан ажээ. Есав Абрахамын Бурханд итгэдэггүй эхнэрүүдтэй гэрлэснээрээ эцэг эхдээ уй гашуу авчирчээ. Хүн өөрийнхөө итгэл бишрэлийн хүмүүстэй гэрлэх нь яагаад чухал вэ?

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл дараах зөвлөгөөг өгчээ: ‘Та нар тэгш бишээр хамтдаа буулганд бүү ор . . . ‘ хэмээн Паул коринтчуудад хэлсэн байдаг. Шашин шүтлэгийн ялгаа үндсэн гол ялгаа байдгийг Паул тэдэнд хэлэхийг хүссэн бололтой. Шашин шүтлэгийн ялгаанууд зөрчилдөөний өргөн хүрээг хамардаг. Сүмд үнэнч шударга байх, гэр бүлдээ үнэнч шударга байх нь зөрчилддөг. Хүүхдүүдийн амьдрал олонтаа бүтэлгүйтдэг. Гишүүн биш хүн бишрэм ухаантай, сайн боловсрол олсон, сэтгэл татам, тэрээр хамгийн тааламжтай хувь хүн байж болно, гэвч адил итгэл бишрэлгүй бол, гэрлэлтийн хувьд ирээдүйд төвөг бэрхшээл гарах болно. Энд зарим нь хамааралгүй хэдий ч, дүрэм нь хатуу бөгөөд аз жаргалд хүргэдэггүй.” (*The Miracle of Forgiveness* [1969], 240)

- Таны гэрлэх хүн бол түүнтэй хамт та мөнхийн гэрлэлт хийлгэх тэрхүү хүн мөн гэдэгт итгэлтэй байхад туслахын тулд та юу хийж чадах вэ? Таны эдүгээгийн хэлхээ холбоо, үерхэл нөхөрлөл амьдралын чинь үлдсэн хугацаанд хийгээд үүрд мөнхөд хэрхэн нөлөөлөх вэ?

Ерөнхийлөгч Кимбалл цааш нь үргэлжлүүлэхдээ: “Зөв гэрлэлт зөв болзооноос эхэлдэг нь тодорхой. Хүн ерөнхийдөө өөрийнхөө харилцаа холбоотой байдаг хүмүүсийн дундаас л гэрлэдэг. Тиймээс, энэхүү сэрэмжлүүлэг онцгой чухал учир холбогдолтой юм. Гишүүн бус хүмүүстэй ном уу, эсвэл сургагдаагүй, итгэл бишрэлгүй гишүүдтэй бүү болз. ‘Өө, би энэ хүнтэй гэрлэх бодолгүй байна. Болзох нь зүгээр л “зугаатай хэрэг” гэж охин хэлж болно.’ Гэвч сайн мэдээг хэзээ ч хүлээн авахгүй байж мэдэх хэн нэгэнд хүн хайр сэтгэлтэй болчихгүй гэж хэлэх аргагүй. Сүмийн гишүүдтэй гэр бүл болсон хүмүүсийн багахан хувь нь эцэст нь баптисм хүртдэг . . . Тэд бол манай цөөхөн адислагдасад юм. . . . Гэвч олонхи нь Сүмд элсдэггүй . . . тэгээд тэдний гэрлэлтийн үлэмж олон нь үзэл бодлын зөрөлдөөн, урам хугаралт, улмаар салалтад хүргэдэг нь үнэн юм” гэжээ (*The Miracle of Forgiveness*, 241–42).

3. Бурхан эрэгтэйчүүдийн нэгэн адил эмэгтэйчүүдэд илчлэлт өгдөг

Илчлэлтийн тухай судрын шастирууд эрэгтэйчүүд—санваартны удирдагчидтай Бурхан харилцсан тухай ихэвчлэн өгүүлдэг. Гэвч, Эхлэл 25:22–23-д Бурхан эмэгтэй хүнд илчлэлт өгсөн тухай агуулагддаг.

Ребекагийн залбирлын талаар Ахлагч Брус Р.МкКонки хэлэхдээ: “Бид бүхний өвөг дээдсийн нэг Ребекаг би Сүм дэх түүний охид өнөөдөр юу хийж болохын загвар болгон тавихыг надад зөвшөөрнө үү? . . . Ребекад зовлон тохиолдож, бурханлиг удирдамж хэрэгтэй болсон үед Их Эзэнд хандан уг асуудлыг тэрээр өөртөө асуухад Тэрээр хариуд нь түүнтэй ярьжээ. Түүнд хандаж итгэлтэй залбирсан эмэгтэйчүүдэд Их Эзэн илчлэлт өгдөг” гэжээ (Conference report, Тахитийн Бүсийн Чуулган 1976, 16).

- Эрэгтэй эмэгтэйчүүд адилхан хувийн илчлэлт хүлээн авахад өөрсдийгөө хэрхэн бэлтгэж болох вэ?

4. Тэнгэрт хүрсэн шатны тухай Иаковын үзэгдэл

- Иаков өөртөө эхнэр хайж бас Есавын уур хилэнгээс зугтаж, Канааны нутгаас өөрийнхөө овгийн нутаг уруу явж байхдаа шөнө амарч хоноглохоор буудаллаж, тэгээд нэгэн гайхамшигтай зүүд зүүдэлжээ (Эхлэл 28:10–19). Энэ зүүдэнд Иаков юу харсан бэ? Их Эзэн түүнд ямар адислалууд амласан бэ? (Эхлэл 28:13–15. Эдгээр адислалууд бол энэ үзэгдэлд Иаковын хийсэн Абрахамын шинэчлэгдсэн гэрээний адислалууд юм; хичээл 7-г үз) Тэр шат юуг бэлэгддэг вэ?

Ахлагч Марион Г.Ромни энэ зүүдний тухай хэлэхдээ: “Их Эзэнтэй түүний хийсэн гэрээнүүд нь . . . амлагдсан амлалтууд—тэнгэрт тэрээр өөрөө орж Их Эзэнтэй хамт байх адислалуудыг олж авахын тулд дээш авирах шатны гишгүүрүүд байсныг Иаков мэджээ” гэсэн байдаг. (“Temples—The Gates to Heaven,” *Ensign*, 1971 оны 3-р сар, 16)

“Би яаж ийм их муухай хэрэг үйлдэж чадав аа?”

Эхлэл 34; 37–39

Зорилго

(1) Бүх туршлага болон нөхцөл байдал тэдний сайн сайхны төлөө хамтдаа хэрхэн үйлчлэхийг сурахад нь, (2) бэлгийн харилцааны ёс суртахууны талаарх Их Эзэний жишгийг дуулгавартай дагах өөрсдийн шийдвэр төгс байдлыг бэхжүүлэхэд нь ангийн гишүүдэд туслах.

Бэлтгэл

1. Дараах судруудыг залбирч судал:

- а. Эхлэл 37. Иаковын арваннэг дэх хүү Иосеф ах нараараа үзэн ядагдаж, улмаар боол болон худалдагджээ.
- б. Эхлэл 39. Иосеф боол болж цэцэглэн хөгжсөн хэдий ч, ёс суртахуунгүй хэрэгт буруутгагдаж, шоронд хаягдсан аж (39:1–20). Шоронгийн харгалзагч шоронгийн бүх хоригдлыг Иосефын гарт даатгав (39:21–23).
- в. Эхлэл 34:1–12; 35:22; 38:1–30. Ёс суртахуунгүй байдлын нүгэл Иаковын гэр бүл—түүний охин Дина (34:1–12); түүний ууган хүү Реубен, (35:22); мөн түүний бусад хөвгүүдийн нэг Иуда (38:1–30) нарт сөрөг үр дагавар үзүүлжээ.

2. Нэмэлт уншлага: Эхлэл 34:13–31.

3. Хэрэв дараах үзүүлэнгүүд байдаг бол та тэдгээрийн заримыг хичээлийнхээ нэг хэсэг болгон ашиглаж болно:

- а. Иосеф Ах нараараа Худалдагдсан нь (62525; Сайн Мэдээний Уран Зургийн цуглуулга 109) Иосеф Потифарын Эхнэрийг Эсэргүүцсэн нь (62548; Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 110)

Энэ хичээлийг заах зөвлөмж

Анхаарал
төвлөрүүлэх
үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагааг (эсвэл өөрийнхөө нэгийг үйл ажиллагааг) ашиглахыг хүсч болно.

Одоо танай бүст нийтэд дэлгэрсэн зарим кино, телевизийн үзүүлбэр, ном буюу сэтгүүлүүдийг нэрлэхийг ангиас хүс.

- Олон нийтийн мэдээллийн эдгээр түгээмэл хэрэгслүүдээр бэлгийн харилцааны ёс суртахууны ямар жишгүүдийг үзүүлдэг вэ? Судруудад болон Сүмийн удирдагчдын заадаг Их Эзэний жишгээс эдгээр жишгүүд ямар ялгаатай вэ?

Нийгмийн ёс суртахууны зан төлөв Их Эзэний бий болгосон жишгүүдээс ялгаатай байх нь олонтаа тохиолддогийг тайлбарла. Нийгмийн жишгүүд өөрчлөгдөж болдог бол, Их Эзэний жишгүүд өөрчлөгддөггүй.

Их Эзэний ёс суртахууны жишгийг дагасан нэг хүн, мөн дагаагүй бусад хүмүүсийн туршлагуудыг энэ хичээлээр ярилцах болно. Бас энэ хичээлээр Их Эзэний жишгийг дагасны болон дагаагүйгээс гарах үр дагавруудын тухай ярилцах болно.

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагауудаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Иосеф ах нараараа боол болон худалдагдав

Эхлэл 37-г зааж, ярилц.

Иаков ээжийнхээ дүү Лабаны охид Леа, Рахел хоёртой, түүнчлэн тэдний шивэгчин Зилпа, Билха нартай гэрлэжээ. Иаковын эхнэрүүд Израилын арванхоёр овгийн эхлэлүүд болсон арванхоёр хөвгүүнийг түүнд төрүүлж өгсөн ажээ (Их Эзэн Иаковын нэрийг Израил болгон өөрчилсөн аж; Эхлэл 32:28-ыг үз). Иаковын арваннэг дэх хүү нь Иосеф байв; Иаков Леа хоёрын ууган хүү Реубен зөв шударга бусын улмаас өв зөлгэмжлэх эрхээ алдахад Иаков Рахел хоёрын ууган хүү Иосеф энэ эрхийг хүлээн авчээ (Шастирын дээд 5:1–2).

- Яагаад Иосефын ах нар түүнд атаархдаг байсан бэ? (Эхлэл 37:3–8-ыг үз) Танай гэр бүлийн гишүүд таныг гомдоох буюу эсвэл өөрөөс чинь илүү сайнаар танд хандвал та хэрхэн хариу үйлдэл үзүүлдэг вэ? Гэр бүлийн гишүүддээ буюу найз нөхөддөө атаархах буюу уурлах мэдрэмжийг бид хэрхэн даван туулж чадах вэ?
- Ах нар нь ямар байгааг харахын тулд Шехем рүү явахыг эцэг нь түүнээс хүсэхэд Иосеф хэрхэн хариулсан бэ? (Эхлэл 37:13–14-ийг үз. Шехем 45 орчим бээрийн зайтай байсныг анхаар) Иосеф ах нараа Шехемд олж чадаагүй үед яасан бэ? (Эхлэл 37:15–17-г үз. Дотан хамгийн багаар дахиад 12 бээр зайтай байсныг анхаар) Энэ шастираас бид залуу Иосефын тухай юу мэдэж болох вэ? (Хариултуудад нь тэрээр эцэгтээ дуулгавартай байсан хийгээд аавынхаа хүссэн зүйлийг хийхэд шаргуу байсан зэрэг нь юм.)
- Иосефын ах нар хонио тэжээж байхад нь Иосеф талбай дээр ирэхэд тэд юу хийхээр хуйвалдсан бэ? (Эхлэл 37:12–18-ыг үз) Иосефын амь насыг аврах гэсэн Реубений учир шалтгаан Иудагийнхаас ямар ялгаатай байсан бэ? (Эхлэл 37:21–22, 26–27-ийг үз) Ах нар нь Иосефыг алахын оронд эцэстээ түүнийг яахаар болсон бэ? (Эхлэл 37:28, 31–33-ыг үз)

2. “Бурханы эсрэг нүгэл үйлдэхээс” Иосеф татгалзав

Эхлэл 39-ийг зааж, ярилц.

- Иосефыг боол болон худалдагдсаны дараа Их Эзэн түүнийг хэрхэн адисалсан бэ? (Эхлэл 39:1–4-ийг үз) Фараогийн баян ажилтан Потифар яагаад боол Иосефт тэгтлээ итгэдэг байсан бэ? (Эхлэл 39:5–6)
- Потифарын эхнэр түүгээр буруу зүйл хийлгэх гэж уруу татахаар оролдоход Иосеф яасан бэ? (Эхлэл 39:11–12-ыг үз. Иосеф тэрхүү нөхцөл байдлаас өөрийгөө тэр даруйд гаргаж авсныг тэмдэглэн хэл) Бид уруу татагдсан үедээ Иосефын үлгэр жишээг хэрхэн дагаж болох вэ?
- Хэрэв Иосеф Потифарын эхнэрийн сээтэгнэлд авдагдсан бол тэрээр үүнд ямар шалтаг зааж болох байсан бэ? Хүмүүс өнөө үед ёс суртахууны зөрчлүүдээ зөвтгөхийн тулд ямар шалтгууд заадаг вэ? Яагаад эдгээр шалтгуудуудад үнэмшилтэй зөвтгөл байдаггүй вэ?

- Потифарын эхнэр түүнд сээтэн хаяхад ариун журамтай байсныхаа төлөө Иосеф яаж шийтгэгдсэн бэ? (Эхлэл 39:12–20-ийг үз. Тэрээр Потифарын гэрийн захирагч байснаа шоронгийн хоригдол болохоор явжээ.) Өнөөдөр дэлхийд зарим хүмүүс ариун журамтай бусад хүмүүст хэрхэн ханддаг вэ? (Хариултууд нь олон янз байж болно. Ариун журамтай хүмүүсийг зарим үед элэг доог болгож, нийгмээс зайлуулдаг хэдий ч, тэд олонтаа хүндлэгддэг.) Өнөөгийн залуучуудад тулгардаг дэлхийн дарамт шахалт ёс суртахуунгүй байдалд хүргэж болох хийгээд залуучууд үүнийг хэрхэн сөрөн зогсвол зохих тухай ярилцахыг та хүсч болно.
- Иосефыг шоронд байхад Их Эзэн түүнтэй хамт байсныг судрууд онцлон тэмдэглэдэг (Эхлэл 39:21–23). Энэ нь Иосефын тухай юуг илчилдэг вэ? (Ариун журмаас үүдэлтэйгээр шоронд хоригдсондоо эргэлзэж, Бурханыг буруутгахын оронд тэрээр итгэлд үргэлжлүүлсэн) Муу туршлага, муу нөхцөл байдлыг сайн зүйл болгон хувиргах талаар бид Иосефоос юу сурч болох вэ? (Та энэ ярилцлагын үеэр Ром 8:28-ыг уншиж болно.)

Ахлагч Бага Хартман Ректор тайлбарлахдаа: “Аливаа юмыг ямар нэгэн сайн зүйл болгож хувиргах чадвар нь бурханлиг шинж чанар болон илэрдэг. Бидний Тэнгэрлэг Эцэг ямагт ингэх чадвартай байдаг. Юм болгон, хичнээн хэцүү байх нь хамаагүй, Их Эзэний хувьд ялалт болдог. Боол болсон Иосефт энэхүү хувь заяа бүхэлдээ хилс байсан ч, тэрээр Их Эзэнд итгэлтэй хэвээр үлдэж, зарлигуудаар амьдрахаа үргэлжлүүлэн, энэхүү гутамшигт нөхцөл байдлыг нэн сайн зүйл болгож байлаа. Үүн шиг хүмүүс өвдөг сөхрөн унадаггүй юм” гэжээ (Conference report, 1972 оны 10-р сар, 170; *Ensign*, 1973 оны 1-р сар, 130).

3. Шехем, Реубен, Иуда нар ёс суртахууны ноцтой нүглүүд үйлдэв.

Эхлэл 34:1–12; 35:22; түүнчлэн 38:1–30-ийг зааж, ярилц. Эдгээр хүмүүсийн нүглүүдийг бүгдийг нь ярилцах хэрэггүй; эдгээрийг Иосефын итгэлтэй байдлын эсрэг сөргүүлэн тавьж ашигла.

- Иосефын гэр бүлийн гишүүд болон танилууд уруу таталттай тулгарсан үед бүгдээрээ Иосеф шиг шийдэмгий зоримог биш байлаа. Бэлгийн харилцааны уруу таталтад Шехем, Реубен, Иуда нар хэрхэн хариулсан бэ?
- Шехемийн Динад гаргаж байгаа сэтгэлийг дүрслэн үзүүлсэн Эхлэл 34:3-т: “Түүний сэтгэл . . . Динад хүчтэй татагдаж . . . тэр охиныг хайрлан, энхрий үгээр түүнтэй ярив” гэснийг нь анхаар. Яагаад энэ дүрслэл Шехемийн үйлдэлтэй нийцэхгүй байна вэ? (Хэрэв Шехем үнэхээр Динад хайртай байсан бол, тэрээр түүнийг хүчирхийлэн бузарлахгүй байсан. Хүмүүс ёс суртахуунгүй үйлдлээ зөвтгөхийн тулд “Бид хайр сэтгэлтэй” гэдэг шалтгийг олонтаа ашигладаг боловч, үнэхээр бие биендээ хайртай хүмүүс маханбодийн тачаал хүслээ хангахын тулд нэг нь нөгөөдөө гэм үйлдэж, зовлонд учруулахгүй шүү дээ. Залбирлыг хүнд хэцүү болгодог зан авир нь хүмүүсийг ариун сүмд орохуйц зохистой биш болгодог, эсвэл хайр дээр суурилагагүй гэр бүлүүдийг бусниулдаг.)
- Иаков амьдралынхаа сүүлчид бүх хөвгүүдээ адислах үед Реубений ёс суртахууны зөрчлийг зааж, Реубен “ус шиг бургилдаг” гэжээ (Эхлэл 49:3–4). Энэ нь хэр зэрэг үнэмшилтэй харьцуулал вэ? Тэрээр “ус шиг бургилдаг” байснаас ямар үр дагавар гарч болохыг Иаков Реубенд хэлсэн бэ?

- Ариун журамтай байсныхаа төлөө Иосефын төлсөн төлөөсийг ёс суртахуунгүй байсныхаа төлөө төлсөн Реубений төлөөстэй харьцуул. Ёс суртахуунгүйнхээ улмаас Реубен юу алдсан бэ? (Шастирын Дээд 5:1–2-ыг үз) Өнөө үе дэх бэлгийн харилцааны нүглийн сүнсний хийгээд цаг зуурын үр дагаврууд юу вэ? Ёс суртахууны цэвэр ариун байдалд Их Эзэн яагаад ийм их ач холбогдол өгдөг вэ?
- Бурханы зарлигуудад дуулгавартай байх нь жинхэнэ эрх чөлөө гэдгийг Сүмийн удирдагчид үргэлж заадаг. Үүнийг бид Иосефын амьдралд хэрхэн хардаг вэ? Дуулгаваргүй байдал нь Шехем, Реубен, Иуда нарын эрх чөлөө хомсдоход хэрхэн нөлөөлсөн бэ? Зарлигуудыг сахихаар сонгох нь тэдгээрийг зөрчихөөр сонгосноос биднийг хэрхэн илүү эрх чөлөөтэй болгодог вэ? (Иохан 8:31–36-г үз)

Дүгнэлт

Их Эзэний туслалцаатайгаар бидний бүх туршлага, нөхцөл байдал хамтдаа бидний сайн сайхны төлөө үйлчилж болно гэдгийг гэрчил. Бодол санаа, үйл хэрэгтээ ёс суртахууны хувьд цэвэр ариун байхын үнэ цэнийг бас гэрчил. Кино, сэтгүүл, олон нийтийн бусад мэдээллийн хэрэгсэлд үнэлгээ өгч, тэдгээрээс бэлгийн харилцааны ёс суртахууны талаарх Их Эзэний жишгийг баримталдгийг нь л зөвхөн ашиглахад ангийн гишүүдэд түлхэц өг. Ариун явдлын хуулийг дуулгавартай дагахад Иосеф шиг шийдвэр төгс байхад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

Нэмэлт заах санаанууд

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

1. Бетел—Бурханы өргөө

- Иаков Канаанаас өөрийн овгийн нутаг уруу явж байхдаа, шөнө хоноглож амрахын тулд буудаллаж, тэнгэрт хүрсэн шатны тухай гайхамшигт зүүд зүүдэлжээ (Эхлэл 28:10–19; хичээл 10-ын дөрөв дэх нэмэлт заах санааг үз). Иаков энэ газрыг *Бетел* гэж нэрлэсэн нь “Бурханы өргөө” гэсэн утгатай аж (Эхлэл 28:19; 19a зүүвэр тайлбарыг үз). Өнөө үед ямар газар мөн ийм нэртэй вэ? (Их Эзэний өргөө гэж нэрлэгддэг ариун сүм)

“Ариун сүмүүд бол Иаковын хувьд Бетел ямар байсан, бидний хувьд тийм зүйл мөн” хэмээн Ахлагч Марион Г.Ромни мэдэгджээ (“Temples—The Gates to Heaven,” *Ensign*, 1971 ны 3-р сар, 16).

- Эхлэл 35:1–15-д, Иаков гэр бүлээ энэ ариун нутагт буцаан авчирдаг. “Бурханы өргөө,” Бетелд эргэж ирэхэд бэлтгэхийн тулд юу хийхийг Иаков гэр бүлээсээ хүссэн бэ? (Эхлэл 35:2-ыг үз) Бид Их Эзэний өргөө рүү явахын тулд хийдэг бэлтгэлүүдтэй эдгээр зүйлүүдийг хэрхэн харьцуулж болох вэ? Ямар “харийн бурхад” бидний дунд байж болох вэ?

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл хэлэхдээ:

“Их Эзэн биднийг өнгөрсөн үеүдтэй эн зэрэгцэшгүй байдлаар цэцэглэн хөгжсөн хүмүүс болгон адисалсан билээ. Бидний хүч чадалд байрлуулсан нөөц боломжууд сайн бөгөөд энэ дэлхий дээрх бидний ажилд чухал юм. Гэвч биднээс олон хүн мал сүрэг, байшин барилга, эд баялгаар бялхаж,

тэдгээрийг хуурамч бурхад лугаа адил шүтэн биширч, тэдгээр нь бидний дээр эрх мэдэл хүчтэй болоо юу даа гэж би айдаг. Бидний итгэл бат бөх байхаас илүү сайн зүйлүүд бидэнд байдаг гэж үү? . . .

“Бид өөрсдийгөө орчин үеийн хэмээн тодорхойлдогт баярладгаа, мөн өнгөрсөн үеүдэд хүмүүст хэзээ ч байгаагүй тийм нарийн боловсорсон байдлыг бид эзэмшсэн хэмээн боддог бидний хандлагыг эс тооцвол— эдгээр зүйлүүдийг эс тооцвол, бид, бүхэлдээ, Их Эзэний хувьд хамгийн олиггүй нөхцөл болох хиймэл шүтээн шүтэгч хүмүүс юм” гэжээ. (“The False Gods We Worship,” *Ensign*, 1976 оны 6-р сар, 4, 6)

- Бид хэрхэн “[өөрсдийн] харийн бурхдыг хойш тавьж . . . ариун сүмд орохын тулд цэвэр ариун” хийгээд зохистой байж чадах вэ? (Эхлэл 35:2; Дуулал 24:3–4; 2 Коринт 7:1; Моронай 10:30, 32-ыг үз)

2. Иаков Есав хоёр дахин нэгдсэн нь

- Канааны нутагт эргэж ирснийхээ дараа Иаков ах Есавтайгаа уулзах болно гэдгээ мэдэж байжээ (Эхлэл 32:3–23; 33:1–17). Иаков Есавтай уулзахаас яагаад айж байсан бэ? (Эхлэл 32:11-ийг үз) Иаков Есавтай уулзахын тулд хэрхэн бэлтгэсэн бэ? (Эхлэл 32:13–20-ийг үз) Тэд дахин уулзах үед Есав Иаковт ямар хариу үйлдэл үзүүлсэн бэ? (Эхлэл 33:4, 8–11-ийг үз) Бид гэр бүлийнхээ зөрчлүүдийг шийдвэрлэх талаар Иаков, Есав нараас юу сурч болох вэ?

3. Хуучин Гэрээний үе дэх татвар эмс

Эхлэл 35:22-т, Рахелын шивэгчингүүдийн нэг Билхаг Иаковын татвар эм гэж дурдсан байдаг. Хуучин Гэрээн дэх *татвар эм* гэдэг нэр томъёог хэрэглэх талаар Ахлагч Брус Р.МкКонки дараах тайлбарыг хийсэн байдаг:

“Бурхан өөрийн хүмүүстэй, түүний дотор Израилын удмынхантай харилцсан бүх түүхийн туршид татвар эмс нь гэрлэлтийн шинэ бөгөөд үүрдийн гэрээнд нөхөртэйгөө хууль ёсоор гэрлэсэн эхнэрүүд байлаа. . . . Эрт дээр үед тэд хоёр дахь *эхнэрүүд* хэмээн тооцогддог байсан нь, зэрэглэлийн тогтолцоонд татвар эмс хэмээн нэрлэгддэггүй байсан эхнэрүүдтэй адил байдалд байдаггүй гэсэн утгатай ажээ” гэсэн байна (*Mormon Doctrine*, 2 дахь хэвлэл. [1966], 154).

“Миний зүтгэж хөдөлмөрлөсөн газраас үр бүтээлтэй”

Хичээл
12

Эхлэл 40–45

Зорилго

Хэрэв бид итгэлтэй, дуулгавартай байх юм бол Бурхан бидний гай зовлонгуудыг бидний сайн сайхны төлөө ариулан адислах болно гэдгийг ойлгоход нь ангийн гишүүдэд туслах.

Бэлтгэл

1. Дараах судруудыг залбирч судал:
 - а. Эхлэл 40–41. Шоронд Иосеф Фараогийн зарц нарын зүүдийг зөв тайлжээ. Дараа нь тэрээр үхэр болоод тариан түрүүний тухай Фараогийн зүүдийг тайлсан ажээ. Иосеф Фараогийн удирдлага дор бүх Египетийн захирагч болгогдож, айсуу яваа өлсгөлөнд хүмүүсийг бэлтгэв.
 - б. Эхлэл 42–45. Үр тариа худалдаж авахаар Иаков хөвгүүдээ Египет рүү хоёр удаа явуулав. Иосеф ах нартаа өөрийгөө мэдүүлж, тэднийг уучлан, тэгээд тэд хамтдаа баяртай байлаа.
2. Нэмэлт уншлага: 2 Нифай 2:2; Сургаал ба Гэрээ 64:8–11; 122:5–9.
3. Эхлэл 42–43-ын товч тоймыг бэлтгэж танилцуулахыг та ангийн нэг гишүүнээс хүс.

Энэ хичээлийг заах зөвлөмж

Анхаарал
төвлөрүүлэх
үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагааг (эсвэл өөрийнхөө нэг үйл ажиллагааг) ашиглахыг хүсч болно.

Тэд нас барж, сүнсний дэлхийд очоод, мөнх бус байдал дахь өөрсдийнхөө туршлагыг нэгтгэн дүгнэж байна хэмээн төсөөлөн бодохыг ангийн гишүүдээс хүс. Бэрхшээл зовлон тэдний амьдралыг хэрхэн төлөвшүүлсэн тухай бодоход нь тэдэнд туслах дөрвөн асуултыг та асууна гэдгээ тайлбарла. Дөрвөн асуултыг бүгдийг нь асуусны дараа тэд өөр ямар асуултууд асуухыг хүсч байгааг ангийн гишүүдээс асуу.

- Мөнх бус амьдралд та нарт тулгарсан зарим бэрхшээл зовлонгууд юу байв?
- Амьдралын бэрхшээл зовлонгуудаас та нар ямар сургамж авсан бэ?
- Хэрэв та нар цаашид өөрийн амьдралаар дахин амьдарч чадсан бол, та нар зовлон бэрхшээлүүддээ хандаж байсан арга замаа өөрчлөхийн тулд юу хийх байсан бэ?
- Та нар амьдралын туршлагуудаа хэрхэн давуу тал болгон ашиглаж чадах байсан бэ?

Энэ хичээл бол Иаковын хүү Иосефын тухай, түүнчлэн тэрээр агуу гай зовлонгийн үед хэрхэн итгэлтэй, дуулгавартай байсан тухай юм гэдгийг тайлбарла.

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой туршлагауудаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Иосеф Фараогийн сөнчийн, талхчины, мөн Фараогийн зүүдийг тайлав. Фарао Иосефыг бүх Египетийн захирагч болгов.

Эхлэл 40–41-ийг зааж ярилц.

Амьдралынх нь эхэн үед Иосефт тохиолдсон гай зовлонгуудаас заримыг нь нэрлүүлэх замаар ангийн гишүүдээр өмнөх хичээлийг нэгтгэн дүгнүүл (Эхлэл 37; 39). Ангийн гишүүдийн хариултуудыг та самбар дээр жагсаан бичиж болно. Дараах хариултууд байж болно:

- а. Ах нар нь түүнийг үзэн ядаж байв (Эхлэл 37:4).
 - б. Ах нар нь түүнийг алахаар хуйвалдаж байснаа, ингэхийн оронд түүнийг боол болгон худалджээ (Эхлэл 37:18–28).
- в. Тэрээр хилэнцийг үйлдэхээс татгалзсаны дараа шударга бусаар шоронд хаягдсан байлаа (Эхлэл 39:20).
- Иосеф өөрт нь тохиолдсон гай зовлонгуудад хэрхэн хариулж байсан бэ? Бүр гай зовлонтой цагт ч зөв шударга байсных нь төлөө Их Эзэн Иосефыг хэрхэн адисалсан бэ?
 - Иосеф шоронд Фараогийн сөнч, талхчин хоёртой хамт байсан бөгөөд тэд хоёул өөрсдийнхөө зүүдийг ойлгохгүй байжээ. Иосеф сөнчийн зүүдийг тайлах үед тэрээр үүний хариу болгож, сөнчөөс юу хүссэн бэ? (Эхлэл 40:14–15-ыг үз) Сөнч шоронгоос суллагдахад юу тохиолдсон бэ? (Эхлэл 40:21, 23-ыг үз) Өөр нэг хэцүү сорилт юуны учир Иосефт тохиолдсон бэ? (Эхлэл 41:1, 14-ийг үз. Тэр дахиад хоёр жил шоронд үлдсэн ажээ.)
 - Эцэст нь Иосеф яагаад шоронгоос суллагдсан бэ? (Эхлэл 41:1, 8–15-ыг үз) Түүнийг зүүд тайлж чаддаг гэж сонспоо гэж Фараог хэлэхэд Иосеф юу гэж хариулсан бэ? (Эхлэл 41:16-г үз) Бид өөрсдийн авьяас бэлгүүдийн төлөө Их Эзэнд хэрхэн зохих ёсоор талархаж болох вэ? (Бид тэдгээрийг өөрсдөдөө алдар нэр олохын тулд биш, харин Бурханыг алдаршуулж, бусдыг адислахын тулд ашиглах ёстой.)
 - Фарао юу зүүдэлсэн бэ? (Эхлэл 41:1–7; 17–24-ийг үз) Фараогийн зүүдний тайлал юу байсан бэ? (Эхлэл 41:25–32-ыг үз) Иосеф зүүдийг тайлсны дараа Фарао яахыг санал болгосон бэ? (Эхлэл 41:33–36-г; мөн түүнчлэн хоёр дахь нэмэлт заах санааг үз) Өлсгөлөнд бэлтгэх тухай Иосефын саналд Фарао хэрхэн хариулсан бэ? (Эхлэл 41:37–43-ыг үз)

2. Иосеф өөрийгөө ах нартаа мэдүүлж, тэднийг уучлав.

Эхлэл 42–45-ыг зааж, ярилц. Та ангийн томилогдсон нэг гишүүнээр Эхлэл 42–43-аас товчлол хийлгэн нэгтгэхийг хүсч болно.

- Иосефын ах нар анх удаа Египетэд яах гэж ирсэн бэ? (Эхлэл 42:1–3-ийг үз) Хоёр дахь удаад тэд Египетэд яах гэж ирсэн бэ? (Эхлэл 42:33–34; 43:2-ыг үз) Бенжаминыг Египет рүү ах нартай нь хамт явуулахад Иаков яагаад дургүй байсан бэ? (Эхлэл 42:36, 38-ыг үз) Эцэстээ тэр яагаад Бенжаминыг явуулахыг зөвшөөрсөн бэ? (Эхлэл 43:3–5, 11–14-ийг үз)

- Бенжаминыг Египет рүү ах нартай нь хамт явуулахад Иаков дахиад нэг хүүгээ алдах нь гэж бодож байв (Эхлэл 42:36). Энэ хүнд сорилтыг Их Эзэн Иаковын хувьд хэрхэн адислал болгон хувиргасан бэ?
- Иосеф бага байхдаа, эцэстээ ах нар нь түүнийг хүндэтгэн мэхийн бөхийхөд хүрэх болно гэдгийг угтан хэлсэн нэг зүүд зүүдэлжээ. (Эхлэл 37:5–11) Энэ зүүд хэрхэн биелэгдсэн бэ? (Эхлэл 42:6; 43:26–28-ыг үз) Өөрсдөд нь агуу хүнд сорилт байх болно гэж ах нар нь бодсон энэхүү хэрэгжилт хэрхэн адислал болсон бэ?
- Ах нар нь Иосефыг боол болгон худалдсанаас хойш 20 гаруй жилийн дараа тэд өөрсдийнхөө үйлдэлд гэм буруутайгаа мэдэрчээ. (Эхлэл 42:21) Бидний амьдрал дахь гэм буруу нь хэрхэн эерэг нааштай хүч болж болох вэ? Энэ нь хэрхэн сөрөг хүч болж болох вэ? Төгс наманчлал гэм буруугийн мэдрэмжид хэрхэн нөлөөлдөг вэ? (Инос 1:4–6-г үз)
- Иосефын ах Иуда Иосефтай сүүлчийн удаа уулзсанаас хойш илүү найрсаг хүн болсноо хэрхэн харуулсан бэ? (Эхлэл 44:18, 30–34-ийг үз. Иосефыг боол болгон худалдах санаа Иудагийнх байсныг ангийн гишүүдэд сануул)
- Иосеф өөрийнхөө байгааг ах нартаа мэдэгдэхэд тэд яагаад сандарсан гэж та нар бодож байна? (Эхлэл 45:1–3-ыг үз) Иосеф ах нараа уучилснаа яаж харуулсан бэ? (Эхлэл 45:4–11, 14–15-ыг үзүүл) Иосефын уучлал ах нарыг нь сүнслэг байдлын хувьд өргөгдөхөд хэрхэн тусалсан гэж та нар боддог вэ?
- Иосефын ах нар түүнд үйлдсэн шиг, хэн нэгэн хүн бидэнд буруу юм хийхэд яах ёстой гэж дэлхий бидэнд хэлдэг вэ? Их Эзэн яаа гэж бидэнд хэлдэг вэ? (Эхлэл 64:8–11-ийг үз) Өөрт чинь буруу юм хийсэн бусад хүмүүст найрсагаар хандсан үед та хэрхэн адислагдсан бэ? Бид яаж илүү уучламтгай болж чадах вэ?
- Иосефын хувьд хүнд сорилт байсан түүний шоронд хоригдсон нь түүний хувьд, гэр бүлийнх нь хувьд, түүнчлэн бүх Египетийн хувьд хэрхэн адислал болсон бэ? (Эхлэл 45:4–8-ыг үз) Бид өөрсдийнхөө бэрхшээл сорилтуудыг шийдвэрлэхэд Иосефын үлгэр жишээг хэрхэн дагаж болох вэ?
- Шинэ Гэрээнд Төлөөлөгч Паул, “Бурханыг хайрладаг хүмүүст сайны төлөө бүх юмс хамтдаа ажилладаг” хэмээн ромчуудад хэлсэн байдаг (Ром 8:28). Энэ нь таны амьдралд хэрхэн үнэн байдаг вэ? Эхлээд сөрөг юм шиг байснаа хожим нь адислал болдог үйл явдлын талаарх хувийн туршлагаа хуваалцахыг ангийн гишүүдээс хүс.

Дүгнэлт

Иосеф өөрт нь тохиолдсон олон хүнд сорилтын туршид итгэлтэй хэвээр үлдсэнийг ангийн гишүүдэд сануул. Тэр ч байтугай түүнийг боол болгон худалдсан ах нараа тэр уучилсан шүү дээ. Зөв шударгынхаа учир Иосеф агуу ихээр адислагдсан юм. Хэрэв бид итгэлтэй байх юм бол, бүх юмсыг бидний сайн сайхны төлөө хамтад нь ажиллуулснаар Бурхан биднийг адислах болно гэдгийг гэрчил.

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

1. Агуу их хожмын үеийн Иосеф

Эхлэл 50:24–38-ын Иосеф Смитийн Орчуулга, Иосеф өөрийнхөө үр удмынхны нэгийг “сонгогдсон үзмэрч” болгох тухай бошиглоуудыг агуулдаг. Мормоны Номын бошиглогч Лихай эдгээр бошиглоуудыг 2 Нифай 3:5–15-д өгүүлдэг. Эдгээр бошиглоуудад дурдагддаг тэр үр удам бол Бошиглогч Иосеф Смит юм.

Египетийн Иосефын хийсэн дараах бошиглоууд Иосеф Смитийн амьдралд хэрхэн биелэгдсэн тухай ярилц:

- а. Иосефын үр удмынхны нэг нь “сонгогдсон үзмэрч байх болно” (Иосеф Смитийн Орчуулга, Эхлэл 50:26; 2 Нифай 3:6).
- б. Энэ үзмэрч Иосефын бусад үр удмынхнаар ихэд хүндлэгдэх болно (Иосеф Смитийн Орчуулга, Эхлэл 50:27; 2 Нифай 3:7).
- в. Тэрээр өвөг дээдэстэй нь Бурханы хийсэн гэрээнүүдийг тэдэнд заах болно (Иосеф Смитийн Орчуулга, Эхлэл 50:28; 2 Нифай 3:7).
- г. Тэрээр Бурханд дуулгавартай байх болно (Иосеф Смитийн Орчуулга, Эхлэл 50:28; 2 Нифай 3:8).
- д. Тэрээр Мосегийн адил агуу бошиглогч байх болно (Иосеф Смитийн Орчуулга, Эхлэл 50:29; 2 Нифай 3:9).
- е. Тэрээр оршин байгаа судрыг (Библи) дэмжиж түүнтэй хамтран ажиллах шинэ судрыг (Мормоны Ном) урагш авчрах арга хэрэгсэл байх болно (Иосеф Смитийн Орчуулга, Эхлэл 50:30–31; 2 Нифай 3:11–12).
- ё. Тэр хэдийгээр сул байх боловч, Их Эзэн түүнийг хүчтэй болгоно (Иосеф Смитийн Орчуулга, Эхлэл 50:32; 2 Нифай 3:13).
- ж. Тэр болон түүний эцэг хоёул Иосеф хэмээн нэрлэгдэх болно (Иосеф Смитийн Орчуулга, Эхлэл 50:33; 2 Нифай 3:15).

2. Өлсгөлөнд бэлтгэсэн нь

- Элбэг дэлбэг долоон жилийг дараа нь болох өлсгөлөнгийн долоон жилд бэлтгэхэд ашиглахыг Иосеф Фараод зөвлөжээ (Эхлэл 41:29–30, 34–36). Өлсгөлөнгийн буюу бусад хүнд цаг үед бэлтгэхийн тулд Сүмийн удирдагчид бидэнд ямар зөвлөгөө өгдөг вэ?

Ахлагч Л.Том Перри заахдаа:

“Бид өөрсдийгөө сүнслэг байдлын хувьд бэлтгэх нь чухлын нэгэн адил, бид бас өөрсдийгөө цаг зуурын хэрэгцээнүүдэд бэлтгэдэг байх ёстой. . . . Бид болох зүйлд бэлтгэхийн тулд наад зах нь дөрвөн шаардлагыг хэрэгжүүлэх тухай олон жилийн туршид зааварчлагдаж байгаа билээ.

“Нэгдүгээрт, боломжийн боловсролтой бол. Өөрийгөө болон гэр бүлээ хангахад хүрэлцэхүйц цалингаар хангах тогтвортой ажилтай байхын тулд аль нэг мэргэшил буюу мэргэжилд суралц. . . .

“Хоёрдугаарт, орлогодоо хатуу багтаан амьдарч, хүнд бэрх цагийн төлөө ямар нэг зүйл нөөцөл. Их Эзэн таныг адисалсан зүйлийг сахилгатайгаар төсөвлөж, амьдралдаа нэг мөр болгон мөрд. Та аравны нэгээ тогтмол төлөхийн хамт гэр бүлийнхээ ирээдүйн хэрэгцээнд шаардагдах тодорхой тооны мөнгийг хадгал. . . .

“Туравдугаарт, хэт их өрөөс зайлсхий. Зайлшгүй шаардлагатай өр зээлийг зөвхөн анхааралтай, ул суурьтай залбирлын дараа, түүнчлэн хамгийн сайн зөвлөгөө хүлээж авсны дараа л авах ёстой. Төлбөрийн чадварынхаа хэмжээг ягштал баримтлах сахилга бидэнд хэрэгтэй. . . .

“Дөрөвдүгээрт, амьжиргаанд нэмэр болох хүнс, хангамжийн зүйл олж, нөөцөл [хэрэв орон нутгийн хуулиуд ингэж нөөцлөхийг зөвшөөрдөг бол]. Хувцас хунар, онцгой нөхцөлд хэрэглэх үндсэн дээр ухаалгаар, сайн төлөвлөгдсөн хадгаламжийн данстай бол. Миний санаж байгаагаар, бид ирээдүйд бэлтгэж, эн тэргүүний шаардлагатай зүйлүүдтэй жилийн нөөцтэй байхыг бидэнд олон жилийн турш зааж байсан. Элбэг дэлбэг жилүүд энэ зөвлөгөөг бараг бүх нийтээрээ хойш тавихад хүргэдэг байх гэж би боддог. Энэ зөвлөгөөг үл хайхрах цаг дуусч байгаа гэдэгт би итгэнэ. Дэлхийд өнөө үед болж байгаа үйл явдлуудыг харгалзан, үүнийг бүхий л нухацтай байдлаар авч үзэх ёстой” гэжээ (Conference Report, 1995 оны 10-р сар, 46–47; *Ensign*, 1995 оны 11-р сар, 36).

- Өлсгөлөнгийн үед, хүнс худалдаж авахын тулд “бүх орнууд Египетэд Иосеф уруу ирдэг байжээ” учир нь Египет бол өлсгөлөнд бэлтгэсэн цорын ганц орон байв (Эхлэл 41:54–57). Бэлтгэлтэй байх нь бусдад үйлчлэх боломжоор биднийг хэрхэн хангадаг вэ?

3. Иосефын хөвгүүд

- Фарао түүнийг Египетийн захирагч болгосны дараа Иосеф Асенат гэдэг нэртэй эмэгтэйтэй гэрлэж, тэд хоёр хүүтэй болжээ (Эхлэл 41:45, 50). Иосеф, Асенат нар хөвгүүдээ хэн гэж нэрлэсэн бэ? (Эхлэл 41:51–52-ыг үз) Яагаад ийм нэрүүдийг Иосефын хөвгүүдэд тохиромжтой гэж үзэн өгсөн бэ? (*Манассе* гэдэг нь “Мартахуй,” *Ефраим* гэдэг нь “Үр жимстэй” гэсэн утгатайг та ангийн гишүүдэд хэлж өгч болно.)

Боолчлол, Дээгүүр Өнгөрсний Баяр ба Египетээс Гарсан нь

Египетээс Гарсан нь 1–3; 5–6; 11–14

Зорилго

(1) Их Эзэн амлалтуудаа биелүүлдэгт итгүүлэх, (2) Аврагчийн цагаатгагч золиослолын төлөөх тэдний талархлыг нэмэгдүүлэх, (3) ариун ёслолыг амьдралдаа илүү утга учир бүхий болгоход ангийн гишүүдийг урамшуулан дэмжих.

Бэлтгэл

1. Дараах судруудыг залбирч судал:

- а. Египетээс Гарсан нь 1–3. Израилын хүүхдүүд египетчүүдээр боол болгогдсон байв (1:1–14). Израилчуудад төрсөн бүх хөвгүүдийг алах ёстой гэж Фарао тушаажээ (1:15–22). Мосе төрж, Фараогийн охин түүнийг өсгөжээ (2:1–10). Мосе нэг египет хүнийг алаад, Мидиан уруу зугтаж, тэнд тэрээр Зиппоратай гэрлэв (2:11–22). Их Эзэн шатаж байгаа бутан дотор Мосед үзэгдэж, Израилыг боолчлолоос чөлөөлөхөөр түүнийг дуудав (3:1–22; Библийн Иосеф Смитийн Орчуулгад, Египетээс Гарсан нь 3:2 дахь “ЭЗЭНИЙ тэнгэр элч” гэсэн холбоо үг “Их Эзэний оршихуй” гэж өөрчлөгдсөнийг анхаар.
- б. Египетээс Гарсан нь 5–6. Мосе, Аарон хоёр Израилыг чөлөөлөхийг Фараогоос хүссэн боловч, Фарао татгалзаж, хүмүүст илүү их ачаалал ноогдуулав (5:1–23). Абрахамтай хийсэн гэрээгээ биелүүлэхээр Их Эзэн амлав (6:1–8). (Анхаар: Бүлэг 7–10 нь Фараод дахин олон удаа хандаж, Израилыг чөлөөлөхийг хүссэн Мосегийн тухай өгүүлдэг. Олон тэмдэг, гайхалтай зүйлс, түүнчлэн өвчин тахлыг үл хайхран Фарао татгалзсаар байлаа. Эдгээр бүлгүүдийн Иосеф Смитийн Орчуулга Фарао зүрх сэтгэлээ хатууруулж байсныг тайлбарладаг.
- в. Египетээс Гарсан нь 11–13. Гэр бүр дэх ууган төрсөн нь үхэх өөр нэг тахлыг Египет дээр илгээхийг Их Эзэн амлажээ (11:1–10). Израилыг уг тахлаас хамгаалах Дээгүүр Өнгөрсний Баярт бэлтгэх талаар Их Эзэн Мосед зааварлав (12:1–20). Египетэд ууган төрснүүд алагдав (12:29–30). Хүмүүсээ Египетээс гарган авч явахыг Фарао Мосед хэлж, тэгээд израилчууд гарч явав (12:31–42). Өөрсдийнхөө чөлөөлөгдсөний дурсгал болгож, ирээдүйд Исгээгүй Талхны Баяр хийж байхыг Мосе Израилын хүүхдүүдэд хэлжээ (13:1–16). Их Эзэн Израилын буудлын өмнө өдөр нь үүлэн дотор, шөнө нь галан баганан дотор явж байлаа (13:17–22). (“Дээгүүр Өнгөрсний Баяр” “Исгээгүй Талхны Баяр” гэдэг нэрнүүд ойролцоо утгаар хэрэглэгдэх нь олонтаа байдаг; Дээгүүр Өнгөрсний Баяр бол Исгээгүй Талхны Баярын анхны өдөр юм)
- г. Египетээс Гарсан нь 14. Фарао болон түүний цэрэг Израилын хүүхдүүдийг мөрдөн хөөв (14:1–9). Хүмүүс айж, Мосе тусламж хүсч Их Эзэнд хандав (14:10–18). Израилын хүүхдүүд цэргээс чөлөөлөгдөж, Улаан Тэнгисийг гаталж, хуурай газар дээр гарав; тэднийг мөрдөн хөөсөн Фараогийн хүмүүс үйж үхэв (14:19–31).

2. Нэмэлт уншлага: Египетээс Гарсан нь 4; 7–10; 15
3. Египетээс Гарсан нь 1, 2-ын товч тоймыг бэлтгэж танилцуулахыг ангийн нэг гишүүнээс хүс.
4. *Дээгүүр Өнгөрсний Баяр, Ариун Ёслол* гэсэн үгс бичсэн туузууд бэлтгэ.
5. Хэрэв дараах үзүүлэнгүүд байдаг бол, та тэдгээрийн заримыг хичээлийнхээ хэсэг болгон ашиглаж болно:
 - а. *Хуучин Гэрээний Видео Танилцуулгууд* (53224)-ын “Малаар Өргөх Тахил ба Цагаатгал,” есөн минутын бичлэг.
 - б. Есүс Христ (62572; Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 240); Мосе Зэгсэн дотор (62063; Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 106); Мосе ба Шатаж буй Бут (62239; Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 107); Улаан Тэнгисийг Гаталсан нь (62100) зургууд.

Энэ хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагааг (эсвэл өөрийнхөө нэг үйл ажиллагааг нэгийг) ашиглахыг хүсч болно.

Тэд хэзээ нэгэн цагт аюултай нөхцөл байдлаас аврагдаж байсан эсэхийг ангийн гишүүдээс асуу. Тэдний нэг буюу хоёроос нь туршлагаа хуваалцахыг урих буюу эсвэл та өөрийнхөө туршлагыг ярь. Өөрсдийг нь аварсан хүмүүсийн талаар ямар бодол санаатай байсныг нь ангийн гишүүдээс хүс.

Энэ хичээл бол урьд хожид тохиолдож байсан аврах үйл ажиллагаануудаас хамгийн эмгэнэлтэй нь буюу Израилын хүүхдүүдийг үхлийн тахал болон египетчүүдийн боолчлолоос чөлөөлсөн тухай юм гэдгийг тайлбарла. Энэхүү авралт нь бүр илүү агуу авралт—Аврагчийн цагаатгагч золиослолоор дамжуулан биднийг нүгэл болоод үхлээс чөлөөлдөг чөлөөлөлтийг олон талаар бэлэгддэгийг бас тайлбарла.

Судрын ярилцлага ба хэрэглээ

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагауудаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

Иаков болон түүний гэр бүл Египетэд шилжиж очсоноос хойш израилчууд тэнд 430 жил амьдарчээ. Тэр үед тэднийг боолчилж, тэдэнд хүнд ачаа үүрүүлж асан Фарао бий болжээ. Иосефын бошиглосончлон, Их Эзэн Израилын хүүхдүүдийг чөлөөлөхийн тулд Мосег өсгөн бойжуулсан ажээ (2 Нифай 3:10).

1. Израилыг боолчлолоос чөлөөлөхийн тулд Их Эзэн Мосег дуудав.

Ангийн томилогдсон нэг гишүүнээр Египетээс Гарсан нь 1, 2-ын товч тоймыг бэлтгүүлж танилцуул; тэгээд Египетээс Гарсан нь 3-ыг зааж, ярилц.

- Израилыг боолчлолоос чөлөөлөхийн тулд Их Эзэн Мосег хэрхэн дуудсан бэ? (Египетээс Гарсан нь 3:1–4-ийг үз) Их Эзэн Мосег дуудах үедээ юу гэж хэлсэн бэ? (Египетээс Гарсан нь 3:5–10-ыг үз) Мосег дуудсан түүний

дуудлагаас бид Их Эзэний талаар юу мэдэж болох вэ? (Их Эзэн өөрийн хүмүүсийг мэддэг, тэдэнд нигүүлсэнгүй ханддаг, тэднийг адислахыг хүсдэг, тэрчлэн тэдэнд өгсөн амлалтуудаа хэрэгжүүлдэг гэсэн хариултууд байж болно.)

- Өөрсдийгөө Египетэд амьдарч байгаа Израилын хүүхдүүд гэж төсөөлөн бодохыг ангийн гишүүдээс хүс. Тэд бол Бурханы гэрээт хүмүүс бөгөөд тэрээр Абрахамд өгсөн амлалтуудаа биелүүлэх болно хэмээн тэдэнд олон үеийн туршид заасаар иржээ. Гэтэл эдүгээ тэд дарлал, боолчлолд амьдарч, боолууд хэвээрээ байлаа. Бэрхшээл зовлон тохиолдоход бидэнд тусалж болох энэ нөхцөл байдлаас бид юу сурч болох вэ? (Тэрээр Мосег дуудсанаар эцэстээ Израилыг чөлөөлснөө харуулсан лугаа адил, Бурхан биднийг зовлон бэрхшээлд байгааг мартдаггүй. Гэвч тэрээр ихэнх тохиолдолд биднийг зовлон бэрхшээлээс тэр даруйд чөлөөлдөггүй. Зовлон бэрхшээл хичнээн урт үргэлжлэх нь хамаагүй, тэрээр бидэнд хайртай гэдэгт, хэрэв бид түүнийг дуулгавартай дагах юм бол, бүх юмсыг бидний сайн сайхны төлөө хамтад нь ажиллуулах болно гэдэгт итгэн, бид түүнд хандан залбирахаа үргэлжлүүлэх ёстой. С ба Г 90:24; 98:3; Мозая 24:14–15-ыг үз) Зовлон бэрхшээлийн үед та нар Их Эзэнээс тайтгарал, тусламжийг хэрхэн хүлээж авсан бэ?
- Израилыг чөлөөлөхийн тулд Их Эзэн түүнийг дуудах үед Мосе юу гэж хэлсэн бэ? (Египетээс Гарсан нь 3:11; 4:1, 10-ыг үз) Ямар талаараа Мосе тэнцэхгүй гэж бодсон бэ? Их Эзэн түүнд ямар баталгаа өгсөн бэ? (Египетээс Гарсан нь 3:12; 4:11–12-ыг үз) Их Эзэнээс дуудлага хүлээн авах үед та нарт ямар санагддаг вэ? Тэнцэхгүй байх зарим бодол яагаад сайн байж болдог вэ? Өөрийгөө тохирохгүй гэж бодсон дуудлагуудад Их Эзэн та нарт хэрхэн тусалсан бэ?
- Өөрийн хүмүүсийг удирдах дуудлага хүлээж авснаар Мосе ямар золиослол хийсэн бэ? (Еврей 11:24–26-г үз) Их Эзэнд үйлчлэх дуудлага хүлээн авснаар бид ямар золиослол хийдэг вэ? Бид Их Эзэний төлөө золиослол хийх хүсэлтэй байх нь яагаад чухал вэ?

2. Их Эзэн Египет дээр өвчин тахлууд илгээв.

Египетээс Гарсан нь 5–6-г зааж, ярилц. Мосе Фараод олон удаа хандаж, Израилыг чөлөөлөхийг түүнээс хүссэнийг тайлбарлаж, Египетээс Гарсан нь 7–10-ын товч тоймыг танилцуулахыг та бас хүсч болно. Тэмдгүүд, гайхалтай зүйлүүд, өвчин тахлуудыг үл хайхран Фарао татгалзсаар байлаа. Та тэмдгүүд, гайхалтай зүйлүүд хийгээд өвчин тахлуудыг тус тусад нь хичээл дээр нэгтгэн дүгнэх цаг гаргах шаардлагагүй байх.

- Мосе, Аарон нар Израилын хүүхдүүдийг явуулахыг түүнээс анх удаа хүсэхэд Фарао юу гэж хариулсан бэ? (Египетээс Гарсан нь 5:1–9-ийг үз) Энэ хүнд сорилтод Израилын хүүхдүүд хэрхэн хариулсан бэ? (Египетээс Гарсан нь 5:15–21-ийг үз) Үүнд Мосе хэрхэн хариулсан бэ? (Египетээс Гарсан нь 5:22–23-ыг үз) Энэ шастираас бид юу сурч болох вэ? (Бидний сурах нэг зүйл бол бэрхшээл зовлонд тэвчээртэй байх хэрэгцээ юм. Их Эзэн өөрийн амлалтуудыг биелүүлэх болно, гэвч тэрээр үүнийг бидний хүсэн хүлээсэн цаг хугацаанд буюу бидний бодсон арга замаар хийхгүй байж болно)

- Фарао Израилын ачааллыг нэмэгдүүлсний дараа Их Эзэн Өөрийн амлалтуудыг Мосед давтан хэлжээ. Эдгээр амлалтууд нь юу байсан бэ? (Египетээс Гарсан нь 6:4–8-ыг үз) Эдгээр амлалтуудын тухай Мосе тэдэнд сануулахад Израилын хүүхдүүд хэрхэн хариулсан бэ? (Египетээс Гарсан нь 6:9-ийг үз) Хүнд сорилтын цагт бидний зарим нь яагаад бошиглогчдыг сонсохоо буюу эсвэл Бурханы амлалтуудад итгэхээ больдог вэ? Бэрхшээл хүндрэлийн үед бид Бурханд итгэх итгэлээ хэрхэн хэвээр хадгалж чадах вэ?
- Израилын чөлөөлөлтийн талаар Фараогийн өмнө хоёр дахь удаагаа очихыг Их Эзэн түүнээс хүсэхэд Мосе юу гэж хариулсан бэ? (Египетээс Гарсан нь 3:11; 4:1, 10-ыг үз) Ямар талаараа Мосед эвгүй байсан гэж бодсон бэ? Их Эзэн түүнд ямар баталгаа өгсөн бэ? Египетээс Гарсан нь 3:12; 4:11–12-ыг үз) Их Эзэнээс дуудлага хүлээн авах үед та нарт ямар санагддаг вэ? Өөрийгөө тохирохгүй гэж бодсон дуудлагуудад Их Эзэн та нарт хэрхэн тусалсан бэ?

3. Дээгүүр Өнгөрсний Баярт Бэлтгэхэд Их Эзэн Мосег зааварлав.

Египетээс Гарсан нь 11–13-ыг зааж, ярилц.

- Анхны Дээгүүр Өнгөрсний Баярын зорилго юу байсан бэ? (Египетээс Гарсан нь 12:12–13, 22–23-ыг үз. Дээгүүр өнгөрсний Баярыг Их Эзэн яагаад ирээдүйд үргэлжлүүлэхийг Израилаас хүссэн бэ? (Египетээс Гарсан нь 12:24–27, 42; 13:1–10-ыг үз)
- Бурхан тэднийг үхлийн тахлаас хамгаалж, Израилын хүүхдүүд тэднийг чөлөөлснийг Израилд сануулахаас гадна, Дээгүүр өнгөрсний Баяр нь бас ирээдүйн чухал үйл явдлыг бэлэгддэг. Энэ үйл явдал юу байсан бэ? (Есүс Христийн цагаатгагч золиослол, биднийг нүгэл, үхлээс чөлөөлдөг Бурханы Хурга. 1 Коринт 5:7-г үз) Дээгүүр Өнгөрсний Баяр Цагаатгалыг хэрхэн бэлэгддэг вэ?

Дээгүүр Өнгөрсний Баяр болон Есүс Христийн цагаатгагч золиослолын хоорондох дараах адил төстэй талуудыг та харуулахыг хүсч болно:

- Дээгүүр Өнгөрсний Баяраар египетчүүд өө сэвгүй, ууган эр хурга хэрэглэдэг байжээ (Египетээс Гарсан нь 12:5-ыг үз) Аврагч бол Бурханы ууган Хүү, толбогүй буюу өө сэвгүй Бурханы Хурга юм (1Петр 1:19-ийг үз).
- Өөрсдийн ууган төрснүүдийг үхлээс аврахын тулд Израилын хүүхдүүд хурганы цусыг хаалганыхаа хатавчин дээр түрхдэг байв (Египетээс Гарсан нь 12:7, 22-23-ыг үз) Гетсеманид болон загалмай дээр Аврагчийн асгаруулсан цус итгэлтнүүдийг ариусгаж, тэднийг сүнсний үхлээс авардаг (Мозая 4:2).
- Израилын хүүхдүүд исгээгүй талх идэх ёстой байлаа (Египетээс Гарсан нь 12:8, 15–20-ийг үз). “Хөрөнгө буюу исгүүрийн хөрөнгө нь эрт дээр үед ялзалын бэлэгдэлд тооцогддог байв, учир нь энэ нь маш амархан муудаж, хөгцөрдөг ажээ. . . . Иймээс исгээгүй талх иддэг израилчууд, тэд ялзарч муудаагүй буюу цэвэр талх, нэрлэвэл, Есүс Христ болох Амьдралын Талхнаас хүртэж байгааг бэлэгддэг байжээ (Иохан 6:35-ыг үз)” (Хуучин Гэрээний Оюутны Гарын Авлага:Эхлэл–2 Самуел [1981], 119). Исгүүрийн хөрөнгийг зайлуулах нь бас наманчлал буюу хүний амьдралаас нүглийг зайлуулахыг санал болгодог ажээ.

г. Израилын хүүхдүүд дээгүүр өнгөрсний баярын зоогийг яаравчлан идэх учиртай байв (Египетээс Гарсан нь 12:11). Израилчуудын нэгэн адил бид Их Эзэний санал болгосон чөлөөлөлтөд хүсэл эрмэлзэлтэйгээр, тэр даруйд хариулах хэрэгтэй.

- Аврагч Сүүлчийн Үдшийн Зоог дээр Дээгүүр Өнгөрсний Баярын оронд ариун ёслолыг бий болгожээ (Матай 26:19, 26–28-ыг үз). Аврагчийн зургийг үзүүлж, *Дээгүүр Өнгөрсний Баяр* гэж бичсэн туузыг зүүн талд нь, *Ариун ёслол* гэж бичсэн туузыг баруун талд нь байрлуул. Дээгүүр Өнгөрсний Баяр, ариун ёслолын хооронд ямар адил төстэй тал байдаг вэ? (Египетээс Гарсан нь 12:14; 13:9–10; С ба Г 20:75–79-ийг үз)

Эдүгээ Сүүлчийн Үдшийн Зоог хэмээн мэдэгддэг Дээгүүр Өнгөрсний Баярын зоог дээр, түүнийг үүрд санан дурсахын тулд “Хурганы бие болон цусны агуу бэлэгдэл [болдог байсан] мал, ургамлын оронд талх, дарсыг хүндэтгэлтэйгээр идэж, уух бэлэгдэл болжээ.

“Энэхүү энгийн мөртлөө сэтгэлд хоногшим байдлаар Аврагч эдүгээ Их Эзэний Үдшийн Зоогийн ариун ёслол хэмээн нэрлэгддэг ёслолыг бий болгосон билээ. Гетсеманид зовсон болон Калвари дээрх золиослол, түүнчлэн булшны цэцэрлэгээс амилснаар Есүс эртний хуулийг гүйцэлдүүлж, золиослолын хуулийн илүү өндөр, илүү ариун хууль дээр үндэслэгдсэн шинэ эрийн үеийн үүд хаалгыг нээсэн билээ. Бурханы Ууган Хүү өөрийгөө ‘хязгааргүй хийгээд мөнхийн золиослол’ болгон өргөхөөр ирсэн учир хүмүүс сүргээсээ ууган төрсөн хургыг өргөлд өргөх шаардлагагүй болсон юм” хэмээн Ахлагч Ховард В.Хантер заасан байдаг. (Conference Report, 1985 оны 4-р сар, 22; *Ensign*, 1985 оны 5-р сар, 19)

- Дээгүүр Өнгөрсний Баяр эртний Израилын хувьд хамгаалалтын гэрээ байсны нэгэн адил, ариун ёслол бол бидний хувьд “аюулгүй байдлын шинэ гэрээ юм” гэж Ахлагч Ховард В.Хантер хэлжээ (Conference Report, 1974 оны 4-р сар, 24; *Ensign*, 1974 оны 5-р сар, 18). Ариун ёслол бидний хувьд хэрхэн аюулгүй байдлын гэрээ болдог вэ? (Биднийг нүгэл, үхлийн боолчлолоос чөлөөлөх замаар мөнхийн аюулгүй байдлыг авчирдаг Аврагчийн цагаатгагч золиослолыг ариун ёслол бидэнд сануулдаг. Ариун ёслолоос хүртэхдээ бидний шинэчилдэг гэрээнүүд нь бас мөнхийн аюулгүй байдлыг бидэнд хангахад тусалдаг.)

Ахлагч Жефффри Р.Холланд:

“Өөрсдийнхөө [Ариун ёслолыг] бид *өөрсдийн* дээгүүр өнгөрсний баяр, *өөрсдийн* аюулгүй байдал, чөлөөлөлт хийгээд гэтэлгэлийн дурсамж гэж бид үздэг үү?

“Маш их аюул дундах, харанхуйн элчээс зугтаах бидний зугтаалтыг бид дурсан хүндэтгэх энэхүү ёслолыг зарим үед байдгаас нь илүү нухацтай авч үзэх ёстой. Энэ нь хүчтэй, хүндэтгэлтэй, буурь суурьтай байх ёстой. Энэ нь сүнслэг бодлууд хийгээд сэтгэгдлүүдийг урамшуулан дэмждэг байх ёстой.” (Conference Report, 1995 оны 10-р сар, 89; *Ensign*, 1995 оны 11-р сар, 68)

- Дээгүүр Өнгөрсний Баярын тухай өөрийн заавруудад үүний ач холбогдлыг эцэг эхчүүд хүүхдүүддээ заах хэрэгтэйг Их Эзэн онцлон авч үзжээ. (Египетээс Гарсан нь 12:26–27; 13:8, 14). Израил эцэг эхчүүд үүнийг хийх нь яагаад чухал байсан бэ? Энэ нь манай өнөө үед хэрхэн холбогдох вэ?

(Эртний Израилын нэгэн адил, нүгэл, үхлээс биднийг чөлөөлөхөд Их Эзэний мутар оролцогийг бидэнд сануулдаг ариун ёслол, мөн бусад ёслолуудын ач холбогдлын тухай бид хүүхдүүддээ заах ёстой.)

4. Израилын хүүхдүүд Улаан Тэнгисийг гаталсан нь.

Египетээс Гарсан нь 14-ийг зааж, ярилц.

- Египетийг орхиж явахыг Израилын хүүхдүүдэд зөвшөөрснийхөө дараа Фарао тэдний эсрэг эргэж, цэргээ тэдний араас явуулжээ (Египетээс Гарсан нь 14:5–9). Давшин ирж байгаа цэргийг хараад Израилын хүүхдүүд яасан бэ? (Египетээс Гарсан нь 14:10–12-ыг үз) Тэдний итгэл гуйвахад Мосе Израилын хүүхдүүдэд юу гэж хэлсэн бэ? (Египетээс Гарсан нь 14:13–14-ийг үз) Айдсаар дүүрэхэд биднийг хангалттай дэмжих хүч болох итгэлийг бид хэрхэн хөгжүүлж болох вэ?
- Давшин ирж байсан Египетийн цэргээс Израилын хүүхдүүдийг Их Эзэн хэрхэн аварсан бэ? (Египетээс Гарсан нь 14:21–31-ийг үз) Хүнд сорилтын үед энэ түүх бидэнд хэрхэн тусалж чадах вэ?

Дүгнэлт

Их Эзэн Израилчуудыг боолчлолоос чөлөөлөх амлалтаа биелүүсэн шиг, тэрээр бидэнд өгсөн амлалтуудаа мөн биелүүлэх болно. Аврагчийн цагаатгагч золиослолын төлөө талархлаа өгсөн нэмэгдүүлж, бүх ариун ёслолоос зохистойгоор хүртэж, “түүнийг үргэлж дурсан санах” гэрээг сахихад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж (С ба Г 20:77).

Нэмэлт заах санаанууд

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

1. Сатан Бурханы хүчийг дуурайдаг

- Мосе Аарон хоёр Бурханы хүчний тэмдгүүдийг түүнд үзүүлэхэд Фарао яасан бэ? (Египетээс Гарсан нь 7:8–12, 17–22-ыг үз) Эдгээр шүлгүүдээс бид Сатаны тухай юу мэдэж болох вэ?
- Бурханы хүч болон адислалуудыг өнөөдөр Сатан ямар арга замуудаар эсэргүүцдэг вэ? Сайн ба мууг ялган танихад туслах ямар бэлгүүдийг Их Эзэн бидэнд өгсөн бэ? Сайн ба мууг ялган таних чадвараа бид хэрхэн нэмэгдүүлж болох вэ?

2. Өвчин тахал

- Их Эзэн Египет дээр яагаад өвчин тахал илгээсэн бэ? (Египетээс Гарсан нь 7:5, 17; 8:10; 9:14, 29; 10:2; 14:4-ийг үз) Өвчин тахалд Фарао ямар хариу үйлдэл үзүүлсэн бэ? (Жишээ нь, Египетээс Гарсан нь 8:8, 15, 25, 28, 32-ыг үз) Өвчин тахал Израилын хүүхдүүдэд яагаад хор хөнөөл учруулаагүй вэ? (Египетээс Гарсан нь 9:4–6, 23–26; 10:22–23; 11:4–7-г үз)

3. Дээгүүр Өнгөрсний Баяр

Дээгүүр Өнгөрсний Баяр бол Есүс Христийн Цагаатгалын бэлэгдэг гэдгийг заахдаа та Дээгүүр Өнгөрсний Баярын бэлэгдлийг харуулахын тулд дараах зүйлүүдийг олж бэлтгэж болно:

- а. Хурганы болон хаалганы зургууд.
- б. Бин, жигнэмэг буюу мацуу хэмээх нимгэн боов (исгээгүй хавтгай талхыг төлөөлүүлэх).
- в. Тунхуу буюу цэцэгт байцаа (гашуун ургамлуудыг төлөөлүүлэх).
- г. Хос шаахай буюу углааш (Израилчууд гуталтайгаа хоол иддэг байсан нь Египетийг яаравчлан орхиж гарсныг бэлэгддэг байж).

4. “Бүгд . . . үүл болон тэнгист баптисм хүртжээ” (1 Коринт 10:2)

Израилын хүүхдүүд үүл болон тэнгист баптисм хүртсэн тухай Паулын заадаг 1 Коринт 10:1–4-ийг та уншихыг хүсч болно. Үүний ач холбогдлыг тайлбарлаж, Ахлагч Брус Р.МкКонки тайлбарлахдаа, “Израил бүр Улаан Тэнгисийг гатлахдаа Египетийн дэлхийн шинж чанараас зугтаасан лугаа адил, тэдний Христэд итгэгч үр удмынхан баптисмаар дамжуулан, махан биеийн хүсэл тачаалуудыг орхиж, бурханлиг байдлаар амьдардаг гэж [Паул] хэлсэн байдаг” гэжээ (*Doctrinal New Testament Commentary*, 3 боть. [1966–73], 2:355).

“Та нар Миний ЭЗЭМШИЛ БОЛНО”

Хичээл
14

Египетээс Гарсан нь 15–20; 32–34

Зорилго

Их Эзэн тэднийг “ариун үндэстэн” болгохын тулд Түүний сүнсний ус, талхнаас хүртэх, түүний сонгогдсон удирдагчдыг дэмжих болон түүний зарлигуудыг дуулгавартай дагахад ангийн гишүүдийг урамшуулан дэмжих (Египетээс Гарсан нь 19:6).

Бэлтгэл

1. Дараах судруудыг залбирч судал:
 - а. Египетээс Гарсан нь 15:22–27; 16:1–31; 17:1–7. Израилын хүүхдүүд өлсөж, цангасан учраас дургүйцэн үглэхэд Их Эзэн тэднийг ус, манна, бөднө шувуугаар хангажээ.
 - б. Египетээс Гарсан нь 17:8–13; 18:13–26. Амалек Израилтай байлдахаар ирэв. Мосег гараа өргөсөн үед Израил дийлж байсан боловч Мосе ядарч, гараа буулгасан үед Амалек дийлж байв. Аарон, Хур хоёр Мосегийн гарыг өргөхөд Израил тулалдаанд ялжээ (17:8–13). Шүүгчдийг томилох Иетрогийн зөвлөгөөг Мосе дагаж, тэдэнд эрх мэдэл олгов (18:13–26).
 - в. Египетээс Гарсан нь 19–20. Их Эзэн Мосетой Синайн Уулан дээр уулзаж, Израилд Арван Зарлиг өгөв.
 - г. Египетээс Гарсан нь 32–34. Их Эзэний заавруудыг агуулсан чулуун хавтангуудыг Мосе хүлээж авсан боловч, тэрээр Синайгаас эргэж ирэх үедээ хавтангуудыг эвдчихсэн аж, мөн хүмүүс алтан тугалыг шүтэж байгааг харжээ (31:18; 32:1–24). Их Эзэн Мелкизедек Санваарын ёслолуудыг Израилаас буцаан авч, үүнээс бага хууль, Мосегийн хуулийг өгөв (Иосеф Смитийн Орчуулга, Египетээс Гарсан нь 34:1–2). Мосе чулуугаар шинэ хавтангууд сийлж, эвдсэн хавтангуудыг орлуулсан боловч шинэ хавтангууд нь “ариун санваарын үүрдийн гэрээний үгсийг” агуулаагүй байв (Египетээс Гарсан нь 34:1–5; Иосеф Смитийн Орчуулга, Дэд Хууль 10:2). Мосегийн хуулийг дуулгавартай дагахаар хүмүүс гэрээ хийжээ (34:10–35).
2. Нэмэлт уншлага: Дуулал 78; 1 Коринт 10:1–11; Сургаал ба Гэрээ 84:19–27.
3. Хэрэв та хуудас 73–74 дээрх үзүүлэх хичээлийг ашиглавал, хэдэн ном буюу бусад хүнд зүйлүүдийг хичээлд авчир.
4. Хэрэв *Хуучин Гэрээний Видео Танилцуулгууд* (53224) байдаг бол, та “Орчин Үеийн Хиймэл Шүтээн” долоон минутын бичлэгийг хичээлийнхээ хэсэг болгон үзүүлж болно.

Энэ хичээлийг заах зөвлөмж

Анхаарал
төвлөрүүлэх
үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагааг (эсвэл өөрийнхөө нэг үйл ажиллагааг ашиглахыг хүсч болно)

- Та нар өмнө нь хэзээ ч очиж үзээгүй, тэгээд бас газрын зураг дээр тэмдэглэгдээгүй зэлүүд газар уруу аялал хийх боллоо гэж төсөөлөн бод. Энэ аялалд та нар хэрхэн бэлтгэх вэ? (Хариултууд нь олон янз байж болно, гэвч ашиг тустай нэг бэлтгэл бол хөтөч олох явдал.)
- Зэлүүд нутаг уруу та нарыг удирдах хөтчид ямар чанарууд байгаасай гэж та нар хүсэх вэ? (Хариултууд нь янз бүр байж болно, гэвч уг хөтөч тэр нутгийг мэддэг бас итгэл даах хүн байх ёстой.)
- Мосе болон Израилын хүүхдүүд Египетээс зугтаж, аглаг буйдад ороход хэн тэдний хөтөч байсан бэ? (Их Эзэн)

Аглаг буйдад израилчуудын аялсан туршлага мөнх бус байдлын туршид бидний хийх аялалд чухал сургамж болж чадахыг тэмдэглэн хэл. Нэг чухал сургамж бол Бурхан израилчуудын нэгэн адил биднийг удирдаж, бидний төлөө анхаарал халамж тавина гэдэгт бид итгэх явдал юм.

Судрын ярилцлага
ба хэрэглээ

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагуудаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж. Энэ хичээл дэх асуулт бүрийг асууж, бүх зүйлийг хамрах нь хэцүү байж болох учраас ангийн гишүүдийн хэрэгцээг хамгийн сайнаар хангах зүйлүүдийг залбиран сонгож ав.

1. Их Эзэн Израилын хүүхдүүдийг ус, манна, түүнчлэн бөднө шувуугаар хангав.

Египетээс Гарсан нь 15:22–27; 16:1–31; 17:1–7-г зааж, ярилц.

Израилчууд Улаан Тэнгисийг гаталсны дараа, тэднийг амлагдсан нутгийн зүг удирдахыг Их Эзэн Мосед зааварлажээ. Гэвч Их Эзэн эхлээд аглаг буйд дахь израилчуудын итгэлийг сорьсон ажээ. Хүмүүсийн олонд нь итгэл дутагдаж, Их Эзэнд хандахын оронд түүнд гомдоллож байв. Гэсэн хэдий ч, Их Эзэн тэдний цангааг тайлахын тулд усаар, өлсгөлөнг дарахын тулд манна болоод бөднө шувуудаар хангасан ажээ.

- Египетээс Гарсан нь 15:22–24 болон 17:1–3-т израилчууд ямар асуудалтай тулгарсан бэ? Хүмүүс өөрийнх нь эсрэг дургүйцэн үглэхэд Мосе хэрхэн хариулсан бэ? (Египетээс Гарсан нь 15:25; 17:4-ийг үз. Тэр тусламж хүсэхээр Их Эзэнд ханджээ) Мосегийн хариултаас бид юу сурч болох вэ? Тусламж хүссэн Мосегийн залбирлуудад Их Эзэн хэрхэн хариулсан бэ? (Египетээс Гарсан нь 15:25–26; 17:5–7-г үз)
- Их Эзэн Израилын хүүхдүүдийг уух болон сүнсний усаар хангасан юм. Уух ус нь Мосегийн түншсэн хаднаас гарсан бол; “сүнсний ундаа” нь Христ болох “сүнсний Хаднаас” ирсэн юм (1 Коринт 10:4). Христээс ирдэг сүнсний ус нь юу вэ? (1Нифай 11:25-ыг үз) Тэр усыг бид яаж ууж болох вэ? Энэ усыг уудаг хүмүүст юу амлагддаг вэ? (Иохан 4:14; Сургаал ба Гэрээ 63:23-ыг үз)
- Египетээс Гарсан нь 16:2–3-т Израилчууд ямар асуудалтай тулгарсан бэ? Их Эзэн хэрхэн хариулсан бэ? (Египетээс Гарсан нь 16:4, 11–15-ыг үз) Хүмүүсийн өлсгөлөнг дарахаас гадна, маннаг илгээсний бусад зорилго нь юу байсан бэ?

- а. Энэ нь Их Эзэний хүмүүс түүнийг дуулгавартай дагах нь уу гэдгийг Түүнд харуулах явдал байв (Египетээс Гарсан нь 16:4, 16–31).
 - б. Энэ нь Их Эзэний хүч хийгээд хайрыг хүмүүст өдөр тутам сануулагч болж байв (Египетээс Гарсан нь 16:12).
 - в. Энэ нь “хүн зөвхөн талхаар амьдардаггүй, харин хүн ЭЗЭНИЙ амнаас гарах үг бүхнээр амьдардаг”-ийг (Дэд хууль 8:3) хүмүүст заахын тулд байлаа.
 - г. Энэ нь хүмүүсийг даруусгаж, авралыг хүлээн авахад нь тэдэнд туслахын тулд байлаа (Дэд хууль 8:16).
- Маннаг илгээсэн нь эдгээр зорилго тус бүрт хүрэхэд хэрхэн тусалсан гэж та нар боддог вэ? Эдгээр зорилго тус бүрийг Их Эзэн бидний амьдралд хэрхэн хэрэгжүүлдэг вэ?
 - Манна хэрхэн Их Эзэний төлөөлөл болдог вэ? (Иохан 6:35-ыг үз) Христийн амьдралын талх маннагаас юугаараа ялгаатай вэ? (Иохан 6:48–51-ийг үз) Христийн амьдралын талхнаас бид өдөр тутам хэрхэн хүртдэг вэ?
 - Израилчууд бие бялдынхаа хүч чадлыг хадгалахын тулд маннаг өдөр бүр түүх хэрэгтэй байв. Бид сүнсний хүч чадлаа хадгалахын тулд хийх ёстой зүйлтэй маннаг хэрхэн харьцуулж болох вэ? (Бид бие бялдынхаа хүч чадлыг хадгалахын тулд тэжээл өдөр тутам хэрэгтэй байдаг шиг, сүнсний хүч чадлаа хадгалахын тулд бидэнд бас өдөр тутам тэжээл хэрэгтэй байдаг. Бид судруудыг судалж, зөвхөн үе үе залбирснаар сүнсний хувьд тэжээгдэж болно гэж хүсэн хүлээж болохгүй.)
 - Израилчууд маннаг шөнө хадгалахад юу тохиолдож байсан бэ? (Египетээс Гарсан нь 16:19–20-ийг үз) Тэд Хүндэтгэлийн өдөрт зориулан маннаг шөнө хадгалахад юу тохиолдсон бэ? (Египетээс Гарсан нь 16:22–25-ыг үз) Бид долоо хоног бүр Хүндэтгэлийн өдрийн бэлтгэл хийхдээ энэ зарчмыг хэрхэн хэрэглэж болох вэ?
 - Хэрэв израилчууд Их Эзэний тусламжгүйгээр аглаг буйдыг туулан аялах гэж оролдсон бол тэдэнд юу тохиолдож болох байсан бэ? Хэрэв бид Их Эзэний тусламжгүйгээр мөнх бус байдлыг туулан аялах гэж оролдвол бидэнд юу тохиолдох вэ?

2. Аарон Хур хоёр Мосегийн гарыг өргөхөд Израил Амалекийн эсрэг тулалдаанд дийлж байв. Шүүгчдийг томилж, тэдэнд эрх мэдэл олгох тухай Иетрогийн зөвлөгөөг Мосе дагав.

Египетээс Гарсан нь 17:8–13 болон 18:13–26-г зааж, ярилц. Энэ хоёр шастир хоёул Сүмийн удирдагчдыг дэмжин батлахын ач холбогдлыг бидэнд заадгийг тэмдэглэн хэл.

- Мосегийн үеэс эхлэн амалекчууд Израилын хүүхдүүдтэй олон жилийн турш дайтжээ. Египетээс Гарсан нь 17:8–13-т дүрслэгдсэн тулалдаанд израилчууд хэрхэн Амалекийн хүмүүсийг бут цохих боломжтой болсон бэ? (Аарон, Хур хоёр Мосег дэмжиж гарыг нь өргөхөд, Израил тулалдаанд дийлсэн ажээ.) Өнөө үед бид сүнсний ямар тулалдаануудыг хийдэг вэ? Бошиглогчийг дэмжин батлах нь эдгээр тулалдаануудад дийлэхэд бидэнд хэрхэн тусалдаг вэ?

Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон хэлэхдээ: “Израилын цэргийн ялалтын төлөө Мосе хэрхэн толгой дээр гарч гараа өргөдөг байсныг надад сануулан хэлдэг. Түүний гар хичнээн удаан өргөгдөх тутам Израил дийлж, харин ядарснаас гар нь доош буухад дайсан нь дийлж байв. Мөн Аарон, Хур хоёр түүний хоёр талд нэг нэгээрээ зогсож гарыг нь өргөхөд Израил ялж байв (Египетээс Гарсан нь 17:12). Тийнхүү бид Их Эзэний тослогдсон үйлчлэгчдийн гарыг өргөхөд бид ялагчид байх болно” гэжээ. (Conference Report, 1986 оны 4-р сар, 98; *Ensign*, 1986 оны 5-р сар, 77)

- Хүмүүс Мосе уруу өдөржин, бас орой нь ирэхийг хараад Иетро юунд санаа нь зовсон бэ? (Египетээс Гарсан нь 18:13–18-ыг үз) Иетро Мосед юу хийхийг зөвлөсөн бэ? (Египетээс Гарсан нь 18:19–23-ыг үз)
- Бошиглогчийн ямар үүрэг хариуцлагууд Египетээс Гарсан нь 18:16–20-д дурдагдсан бэ?

Та эдгээр шүлгүүд дэх үүрэг хариуцлагуудыг ангийн гишүүдээр эрүүлж, дараа нь хариултуудыг самбар дээр жагсаан бичиж болно. Бас та дараах биет үзүүлэнт хичээлийг ашиглаж болно: ангийн нэг сурагчийг гараа алдлан өргөхөд урь. Нэг дэх үүрэг хариуцлага тогтоогдоход ном буюу эсвэл өөр ямар нэг хүнд зүйлийг уг гишүүний гарт бариул. Бусад үүрэг хариуцлага бүр тогтоогдох болгонд өөр нэг ном буюу хүнд зүйлийг нэмж бариул.

а. Хүмүүсийн хооронд шүүгч бай (Египетээс Гарсан нь 18:16).

б. Бурханы өмнө хүмүүсийг төлөөл (Египетээс Гарсан нь 18:19).

в. “Ёслолууд хийгээд хуулиудыг тэдэнд заа” (Египетээс Гарсан нь 18:20).

г. “Явах ёстой замыг нь тэдэнд [үзүүл]” (Египетээс Гарсан нь 18:20).

д. “Хийх ёстой ажлыг нь . . . тэдэнд [үзүүл]” (Египетээс Гарсан нь 18:20).

- Өнөөдөр бид хэрхэн гараа өргөж, өөрсдийн бошиглогчид, төлөөлөгчдийн ачааллыг хөнгөвчилж болох вэ? (С ба Г 21:4–5; 107:22-ыг үз. Ангийн гишүүд саналаа хэлэх тоолонд номнууд буюу хүнд зүйлүүд гартаа барьсан ангийн гишүүний гараас уг юмнуудыг ав.)
- Бид орон нутгийнхаа Сүмийн удирдагчдыг хэрхэн дэмжиж чадах вэ? (Тэдний тухай сайнаар ярих, Сүмийн дуудлагууддаа хичээнгүйлэн үйлчлэх, гэрийн болон айлчлагч сайн багш нар байх зэрэг нь хариултууд байж болно.)
- Сүмийн удирдагчдыг дэмжсэнээрээ та нар хэрхэн адислагдсан бэ? (Та энэ ярилцлагад С ба Г 21:6-г ашиглаж болно.)

3. Их Эзэн Синайн Уулан дээр Мосетой уулзаж, Израилд Арван Зарлиг өгөв.

Египетээс Гарсан нь 19–20-ийг зааж, ярилц.

Их Эзэн Израил аглаг буйдад орсноос хойш гурван сарын дотор тэдэнтэй хийх өөрийн гэрээг бий болгохыг хүсчээ (Египетээс Гарсан нь 19:5–6). Энэ гэрээний хэсэг болгон Тэрээр Арван Зарлигийг Мосед илчилжээ.

- Израилын хүүхдүүд Синайн Ууланд буудаллаад байх үед, хэрэв тэд дуулгавартай байх юм бол, Их Эзэн юу амласан бэ? (Египетээс Гарсан нь 19:3–6-г үз. Тэрбээр тэднийг “Өөрийн онцгой эзэмшил, . . . санваартнуудын хаант улс, бас ариун үндэстэн болгох болно.”) Эдгээр

амлалтууд ямар утгатай вэ? Эдгээр амлалтууд өнөөдөр бидэнд хэрхэн холбогдох вэ?

Эдгээр амлалтууд Израил бусад бүх үндэснүүдээс онцгой эрхэмлэгдсэн, санваар болон сайн мэдээг бүх хүмүүст хүргэхээр сонгогдсон Их Эзэний гэрээт хүмүүс байх болно гэсэн утгатай юм (Дэд Хууль 7:6; 14:1–2; 1 Петр 2:9-ийг үз). Энэ хам сэдэвт *онцгой* гэдэг үг нь “Их Эзэний тусгай хүмүүс буюу эрдэнэс” гэсэн утгатай болохоос биш “хачирхалтай буюу этгээд сонин” гэсэн утгагүй.

- Өөрийнх нь хүмүүс Синайн Ууланд ямар туршлагатай болоосой гэж Их Эзэн хүссэн бэ? (Египетээс Гарсан нь 19:9, 11, 16–17; С ба Г 84:23-ыг үз) Тэд өөртэй нь уулзаж болохоос өмнө өөрийнх нь хүмүүс юу хийхийг Их Эзэн шаардсан бэ? (Египетээс Гарсан нь 19:10, 14-ийг үз)
- Синай Уул бол Их Эзэн өөрийн хүмүүстэй ярилцахыг хүсдэг мөн өөрийгөө тэдэнд үзүүлэхийг хүсдэг байсан ариун газар байжээ. Мөн эдгээр адислалуудыг бид хүлээн авч болох ямар ариун газруудаар Тэр биднийг хангасан бэ? (Ариун сүмүүд; С ба Г 97:15–16; 109:12–13-ыг үз) Их Эзэний дуу хоолойг сонсож, түүний оршихуйг мэдрэхэд ариун сүм тэдэнд хэрхэн тусалсныг яриулахаар ангийн гишүүдийг урь.
- Египетээс Гарсан нь 20 дахь эхний дөрвөн зарлиг Бурхан болон бидний хоорондох зохих ёсны харилцааны тухай заадаг (Египетээс Гарсан нь 20:3–11). Их Эзэнийг шүтэн бишрэх болон түүний өмнө өөр бурхадгүй байх ёстой гэсэн зарлиг өнөө үед хэрхэн холбогдох вэ? Өнөөдөр зарим хүмүүс ямар хуурамч бурхдыг шүтэн биширдэг вэ? (1 Самуел 15:23; Ефес 5:5; С ба Г 1:15–16)

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл хэлэхдээ:

“Хиймэл шүтээн бол хамгийн ноцтой нүглүүдийн дотор багтдаг. . . . Орчин үеийн хиймэл шүтээн буюу хуурамч бурхад нь хувцас, гэр орон, бизнес, машин тоног төхөөрөмж, авто машин, гоёмсог хөлөг онгоц болоод бурханлиг чанар руу хөтөлдөг замаас гажуудуулдаг бусад үй олон материаллаг гажуудлууд юм. . . .

“Биет бус зүйлүүд зүгээр л бэлэн бурхад болдог. Зэрэг дэв, утга зохиол, цол гуншин хиймэл шүтээнүүд болж болно. . . .

“Олон хүн орон байшин барьж, гэр орноо тавилгаар дүүргэн, юуны түрүүнд авто машин худалдан авч—тэгээд тэд аравны нэгээ төлөх ‘бэл бэнчингүй’ болдог. Тэд хэнийг шүтэн биширдэг вэ? Мэдээжийн хэрэг тэнгэр хийгээд газрыг бүтээсэн Их Эзэнийг биш. . . .

“Олон хүн анд явах, загасчлах, амралт сувилал, долоо хоногийн амралтын өдрүүдээр аялал зугаалга хийж гадагшаа явахыг шүтэн биширдэг. Бусад нь спорт тоглоомууд, сагсан бөмбөг, хөл бөмбөг, бухын тулалдаан эсвэл гольфыг хиймэл шүтээнээ болгодог. . . .

“Хүмүүсийн шүтэн биширдэг өөр нэг зүйл бол хүч, эрх мэдэл, нэр хүнд хэвээр байна. . . . Хүч, эд баялаг, нөлөөний эдгээр бурхад хамгийн их эрэлт хэрэгцээтэй бөгөөд аглаг буйд дахь Израилын хүүхдүүдийн алтан тугалууд лугаа адил тун бодитой юм” гэжээ (*The Miracle of Forgiveness* [1969], 40–42).

- Хүмүүс Бурханы нэрийг хий хоосон хэрэглэдэг ямар хэлбэрүүд байдаг вэ? Бид түүний нэрийг хий хоосон хэрэглэхгүй байх нь яагаад чухал вэ?
- Хүндэтгэлийн өдрийг ариунаар хадгалах нь бидний хувьд яагаад чухал вэ? (Египетээс Гарсан нь 20:8; 31:16–17; Исаиа 58:13–14; С ба Г 59:9–10) Ямар үйл ажиллагаанууд Хүндэтгэлийн өдрийн хувьд тохиромжтойг бид хэрхэн шийдэх ёстой вэ? Та нар энэ өдрийг ариунаар хадгалснаар хэрхэн адислагдсан бэ?
- Бусад хүмүүстэй харилцах бидний харилцааны талаарх зургаан зарлигийг нэгтгэн дүгнэ (Египетээс Гарсан нь 20:12–17). Эдгээр зарлигуудыг дуулгавартай дагаснаар бусадтай харилцах бидний харилцаа хэрхэн сайжирдаг вэ? (Та зарлиг тус бүр дээр анхаарал төвлөрүүлж, тэдгээр нь ямар утгатайг тодорхойлж, үүнтэй нь холбогдуулан ярилцахыг хүсч болно.)

4. Их Эзэн Мосегийн хуулийг танилцуулав.

Египетээс Гарсан нь 32–34-ийг зааж, ярилц.

Их Эзэн Синайн Уулан дээр Мосетой ярилцах үеэр Мелкизедек Санваарын ёслолуудыг багтаасан хуулийг тэрээр илчилсэн ажээ (С ба Г 84:19–23). Гэвч израилчуудын хиймэл шүтээн шүтэгч зан авир тэднийг сайн мэдээний бүрэн байдлаар амьдрахад бэлэн биш байгааг харуулжээ (Египетээс Гарсан нь 32:1–9; С ба Г 84:24-ийг үз). Тэд Их Эзэнийг тийм хурдан мартсан учраас Тэрээр Мелкизедек Санваарыг тэднээс эргүүлэн татаж, бага хууль— Мосегийн хуулийг илчилсэн ажээ (Иосеф Смитийн Орчуулга, Египетээс Гарсан нь 34:1–2; С ба Г 84:25–27).

Мосегийн хууль зарлигууд, гэрээнүүд, эсвэл сайн мэдээний зарчмуудыг халаагүй юм. Харин ч, энэ нь “гүйцэтгэлийн болон ёслолуудын хууль, Бурханыг мөн түүний өмнө хүлээсэн өөрсдийнх нь үүргийг тэдэнд сануулж байхын тулд, тэд өдрөөс өдөрт чандаар сахих хуулиар” хангасан юм (Мозая 13:30). Мосегийн хууль нүглүүдээ хүлээж, залруулга хийх, малаар тахил өргөх чанд хуулиудыг дагах, өөрсдийн биеийг эрүүл байлгах, Их Эзэний ажилд дэмжлэг үзүүлэх, талархал илэрхийлж байх, түүнчлэн Бурхантай нийцсэн байхыг хүмүүст заадаг байв.

- Их Эзэн Израилын хүүхдүүдэд яагаад Мосегийн хуулийг өгсөн бэ? (Египетээс Гарсан нь 3:23–24; Мозая 13:29; Алма 25:15–16; С ба Г 84:19–27-г үз) Энэ хууль Израилыг хэрхэн ариун болгож, тэднийг Христэд авчрахад хэрхэн тусалж чадах байсан бэ? (Мозая 13:30; Алма 34:14–15-ыг үз)
- Мосегийн хууль хэзээ гүйцэлдсэн бэ? (3 Нифай 15:4–10-ыг үз) Мосегийн хуулийн чухал хэсэг байсан малаар тахил өргөхийг Их Эзэн цаашид шаардахгүй болсноор ямар золиослол хийхийг тэрээр биднээс хүсдэг вэ? (3Нифай 9:19–22-ыг үз) Харууссан зүрх, гэмшсэн сэтгэлийг өргөнө гэдэг нь юу гэсэн үг вэ?

Ахлагч М.Рассел Баллард заахдаа:

“Мосегийн хууль гүйцэлдсэн ч гэсэн, золиослолын хуулийн зарчмууд сүмийн сургаалын нэг хэсэг болон үргэлжилсээр байгаа билээ.

“Золиослолын хуулийн анхдагч зорилго нь Христэд ирэхэд бидний хувьд сорилт бас туслацаа болон үргэлжилсээр байгаа бөгөөд Христийн төгс золиослолын дараа хоёр зохицуулалт хийгдсэн юм. Нэгдүгээрт, ариун ёслол нь [малаар] тахил өргөх ёслолыг халсан; хоёрдугаарт, энэ өөрчлөлт нь аль нэг хүний малаар тахил өргөхөд анхаарал төвлөрүүлэхээс уг хүнд өөр дээр нь анхаарал төвлөрүүлэх болгожээ. Энэ утгаар, золиослол нь өргөл өргөх явдлаас золиослогч руу өөр рүү нь шилжсэн юм. . . .

“. . . Христ өөрийн мөнх бус тохинууллын дараа, золиослолын хуулийг шинэ түвшинд гаргасан юм. . . . Хүний мал буюу үр тариаг Их Эзэн шаардахын оронд эдүгээ Их Эзэн бурханлиг бус бүхнийг таягдан хаяхыг биднээс хүсч байна. Энэ бол золиослолын хуулийн илүү өндөр дадал зуршил; энэ нь хүний дотоод сэтгэлд хүрдэг” гэжээ (*The Law of Sacrifice* [Сүмийн Боловсролын Системийн Симпозиум дээр энэ үгийг хэлжээ, 1996 оны 8-р сарын 13], 5).

Дүгнэлт

Хэрэв тэд Их Эзэний сүнсний ус хийгээд талхнаас хүртэж, түүний сонгогдсон удирдагчдыг дагаж, түүний зарлигуудыг дуулгавартай дагах юм бол, тэрээр тэднийг өөрийн ариун уул—ариун сүмд урих болно гэдгийг ангийн гишүүдэд гэрчил. Тэнд тэд түүнтэй уулзаж, түүний хуулиудыг хүлээн авч, түүний алдар сууг болгоож, мөн түүнтэй илүү адилхан болохын тулд урагш ахьж чадна.

Нэмэлт заах санаанууд

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

1. Арван Зарлиг

Арван Зарлиг Дэд Хууль 5:5–21, Мозая 12:33–36 болон 13:12–24, мөн С ба Г 42:18–27, 59:5–16-д давтагддаг. Арван Зарлигийг илүү гүнзгий ойлгохын тулд эдгээр хэсгүүдийг нэгтгэн дүгнэ.

2. Алтан тугал

Египетээс Гарсан нь 32-т цэдэглэгдсэн алтан тугал бий болгож, шүтэн биширч байсан тухай түүхийг ярилцахыг та хүсч болно. Энэ түүхээс олон зарчмыг, түүний дотор доорх хоёр зарчмыг гаргаж болно:

- а. Итгэлийн хуучин дадал заншил болон загварууд, эсвэл зан төлвийг эвдэх нь хэцүү байдаг. Хэдийгээр израилчууд Египетийг бие махбодын хувьд орхисон боловч сүнслэг байдлын хувьд тэдний нөлөөнүүдээс ангид биш байлаа. Бурхан Арван Зарлигийг Синайгаас тунхагласныг сонссоны дараа израилчууд эхний хоёр зарлигийг хурдан зөрчсөн ажээ.
- б. Сөрөг дарамт үзэл бодлыг сөрөн зогсох нь чухал. Аарон израилчуудын зөв шударга бус хүслүүдэд бууж өгсөн ажээ. Зарим үед удирдагчид, эцэг эхчүүд бүр хариуцсан хүмүүсийг нь гомдоох буюу тэднийг холдон хөндийрөхөд хүргэж болох ч гэсэн “үгүй” гэж хэлэх ёстой.

Зорилго

Дэлхийн хүсэл бодлууд, айдсыг даван туулж, удирдамжийн төлөө Аврагч болон түүний бошиглогчид өөд харахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмжих.

Бэлтгэл

1. Дараах судруудыг залбирч судал:
 - а. Тооллого 11. Израилчууд маннагийн талаар гомдоллож, мах идэхийг хүсч байв (11:1–9). Мосе удирдамжийн төлөө Их Эзэнээс асууж, өөрийнх нь ачааг үүрэхэд тусламж хүсэв (11:10–15). Их Эзэнээр зааварчлагдсаны дагуу Мосе өөртөө туслуулах 70 ахлагчийг цуглуулав (11:16–17, 24–30). Мах хүссэн израилчуудын хүсэлтэд Их Эзэн хариулан, бөднө шувууг үй олноор нь илгээж, мөн тэдний шунаг сэтгэл, хэт давилуун зангийнх нь учир тэднийг тахлаар цохив (11:18–23, 31–35).
 - б. Тооллого 12. Мириам Аарон хоёр этиоп эмэгтэйтэй гэрлэснийх нь учир гомдоллон, Мосегийн эсрэг ярьж, түүний тэргүүлэх эрх мэдэлд сэв суулгав (12:1–3). Дургүйцэн үглэснийх нь төлөө Их Эзэн Мириам, Аарон хоёрыг шүүмжилж, шийтгэв (12:4–16).
 - в. Тооллого 13–14. Канааны нутгийг тандах 12 хүнийг Мосе зааварчлав (13:1–20; шүлэг 16 дахь “Хошеа” гэсэн нэр Иошуа хэмээх нэрнээс үүссэн ажээ). Тэд тэр нутгийн нөөц баялгийн тухай аятай сайхан мэдээтэй буцаж ирсэн хэдий ч, Иошуа, Калев хоёроос бусад хүмүүс тэндхийн оршин суугчдаас айж, Египет рүү буцахыг хүсч байв (13:21–14:10). Итгэлгүй хийгээд гомдоллогч израилчууд, Иошуа, Калев хоёроос бусад бүх насанд хүрэгч үеийнхэн үхэж дуустал аглаг буйдад бэдрэх болно гэдгийг Их Эзэн Мосед хэлжээ (14:11–39).
 - д. Тооллого 21:1–9. Өөрсдийнх нь эсрэг ирсэн канаанчуудыг израилчууд устгав (21:1–3). Тасралтгүй гомдоллосных нь төлөө Их Эзэн израилчуудыг шийтгэхийн тулд галт могойнууд илгээжээ (21:4–6). Мосе гуулин могой хийж, үүнийг саваанд бэхлэн, хэрэв тэд үүнийг харах юм бол, тэд амьдрах болно хэмээн хэлэв (21:7–9).
2. Нэмэлт уншлага: Иохан 3:14–16; 1Нифай 17:41; Алма 33:18–22; 37:46–47; Хиламан 8:13–15.
3. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашиглах бол, *Амлагдсан Нутаг* гэдэг үг бичсэн үзүүлэн хий.
4. Хэрэв Мосегийн болон Гуулин могойны зураг байвал, та үүнийг хичээлийн үеэр ашиглаж болно (62202).

Энэ хичээлийг заах зөвлөмж

Анхаарал
төвлөрүүлэх
үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагааг (эсвэл өөрийнхөө нэг үйл ажиллагааг) ашиглаж болно.

Egypt гэсэн үгийг самбар дээр бич. *Амлагдсан Нутаг* гэсэн үг бүхий үзүүлэнг тасалгааны нөгөө талд байрлуул. Ангийн нэг гишүүнийг *Egypt* гэдэг үг рүү эргэж харуулан самбараас үзүүлэн рүү алхуул.

Хэрэв ийм байдлаар ангийн тэр гишүүн үзүүлэнд хүрэхэд хэцүү байвал дараах асуултыг асуу:

- Та нар арагшаа хараад, урагшаа шулуун явахад яагаад хэцүү байдаг вэ?

Хэрэв ангийн тэр гишүүн үзүүлэнд амархан хүрвэл дараах асуултуудыг асуу:

- Зам зууртаа тэнэлгүйгээр шулуун шугамаар та нар хэр зэрэг хол явна гэж бодож байна?

Энэ үзүүлэнг Египетээс хийсэн израилчуудын аянтай харьцуулж болно гэдгийг тайлбарла. Их Эзэнээс израилчуудын хүлээн авсан адислалуудыг эс хайхран, тэдний айдас, итгэл дутмаг байдал нь Египетийг орхин яваагүй ч болоосой гэсэн хүслийг тэдэнд олонтаа төрүүлж байжээ. Тэд Египетэд хоргодож байсан нь амлагдсан нутгийн зүг хийсэн тэдний аяныг саатуулж, ээдрээ төвөгтэй болгожээ.

Судрын ярилцлага
ба хэрэглээ

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж. Энэ хичээл дэх бүх асуултыг асуух буюу бүх зүйлийг хамрах нь хэцүү байж болох учраас ангийн гишүүдийн хэрэгцээг хамгийн сайнаар хангах зүйлүүдийг залбиран сонгож ав. Та зарим асуултуудыг ангийн гишүүдийн нөхцөл байдалд тохируулан хялбаршуулах хэрэгтэй байж болно.

1. Бөднө шувуудыг тэдэнд илгээх замаар мах хүссэн израилчуудын хүсэлд Их Эзэн хариулж, мөн тэднийг тахлаар цохив.

Тооллого 11-ийг зааж, ярилц.

- Хэдийгээр манна Их Эзэнээс ирсэн агуу адислал байсан ч, израилчууд үүний талаар гомдоллож эхлэв (Тооллого 11:6). Юу тэднийг гомдлоход өдөөсөн бэ? (Тооллого 11:4–5; тэд мах болон Египетэд өөрсдийн идэж байсан бусад хоол хүнсний тухай бодож, хүсч эхлэв.) Бид өөрсөддөө байгаа юмнаас илүү ихийг хүсэн шаардах нь ямар аюултай вэ?
- Израилчууд амлагдсан нутаг дээр анхаарал төвлөрүүлэхээ орхиж, Египетийг орхин яваагүйсэн болоосой хэмээн мөрөөдөх хүртлээ тийм ихээр махыг эгээрэн хүсч байжээ (Тооллого 11:4–6). Хүмүүс түр зуурынхаа хүслийг хангахын тулд агуу адислалуудыг орхидог өнөө үеийн зарим жишээ юу вэ? Хүмүүс яагаад ингэдэг вэ? Ийм уруу таталтуудыг бид хэрхэн даван туулж чадах вэ?

- Израилчууд мах хүссэнд Их Эзэн хэрхэн хариулсан бэ? (Тооллого 11:18–20; 31–33-ыг үз)
- Мосе израилчуудын нүглүүдээр ачаа нь ихэд хүндэрч, тэгээд өөрийнхөө амийг авахыг Их Эзэнээс гуйв (Тооллого 11:14–15). Их Эзэн түүнд хэрхэн тайтгарал өгсөн бэ? (Тооллого 11:16–17. Мосед туслахаар далан хүн дуудагдав.) Эдгээр хүмүүс ямар агуу адислалууд хүлээн авсан бэ? (Тооллого 11:24–29-ийг үз)

2. Мосегийн эсрэг ярьсных нь төлөө Мириам Аарон хоёрыг Их Эзэн зэмлэв.

Тооллого 12-ыг зааж, ярилц.

- Мириам Аарон хоёр тэд ч бас илчлэлт хүлээн авсан хэмээн өгүүлж өөрсдийнхөө тэргүүлэх эрхийн тухайд Мосегийн эсрэг ярьжээ (Тооллого 12:2). Тэдний гомдолд Их Эзэн юу гэж хариулсан бэ? (Тооллого 12:5–9-ийг үз) Илчлэлт хүлээн авах бидний эрхийг юу хязгаарладаг вэ?
Ахлагч Жеймс Е. Фауст хэлэхдээ: “Дэлхийн төлөө Бурханы үгийг хүлээн авч, тунхаглах үүрэг хариуцлага, онцгой боломж бошиглогчид, үзмэрчид хийгээд илчлэгчдэд байсаар ирсэн, одоо ч байгаа болно. Гишүүд, эцэг эхчүүд болон удирдагчид өөрсдийнхөө үүрэг хариуцлагын төлөө илчлэлт хүлээн авах эрхтэй, гэвч өөрсдийнхөө үүрэг хариуцлагын хүрээнээс гадуур Бурханы үгийг тунхаглах үүрэг ч, эрх ч тэдэнд байхгүй” гэжээ (Conference report, 1989 оны 10-р сар, 9; *Ensign*, 1989 оны 11-р сар, 8).
- Мосе этиоп эмэгтэйтэй гэрлэсний төлөө дургүйцсэн Мириам, Аарон хоёрыг Их Эзэн зэмлэж, шийтгэв (Тооллого 12:1, 9–10). Бид Сүмийн удирдагчдыг шүүмжлэхэд энэ нь бидэнд хэрхэн нөлөөлдөг вэ? Бид Сүмийн удирдагчдыг шүүмжлэх нь бидний гэр бүл, найз нөхдөд хэрхэн нөлөөлдөг вэ?
- Тооллого 12:3-т “Мосе маш даруу байсан” гэжээ. Даруу байх гэсэн нь юу гэсэн үг вэ?
Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хэлэхдээ, “Номхон даруу байдал нь өөртөө сэтгэл хангалуун байхын эсрэг талархлын сүнс, бусдын өөрөөсөө илүү агуу хүчийг хүлээн зөвшөөрөх, Бурханыг хүлээн зөвшөөрөх хийгээд түүний зарлигуудыг хүлээн авах явдал мөн” гэжээ (“With All Thy Getting Get Understanding,” *Ensign*, 1988 оны 8-р сар, 3–4).
- Түүнийг эсэргүүцсэний төлөө Мириам шийтгэгдэхэд Мосе номхон даруу байдлаа хэрхэн харуулсан бэ? (Тооллого 12:13–15-ыг үз. Тэрээр эмэгтэй дүүгээ тэргүүлэх эрх мэдлийнхээ төлөө баярлах учиртай байтал тэрээр түүнийг эдгээхийг Их Эзэнээс гуйжээ. Түүнийг эдгэртэл тэр болон түүний хүмүүс аянаа хойшлуулжээ) Хүмүүс биднийг шүүмжлэх юм уу, тэр ч байтугай бидний эсрэг эргэхэд бид хэрхэн номхон даруу байж болох вэ?

3. Канааны нутгийг тандах 12 хүнийг Мосе зааварлав.

Тооллого 13–14-ийг зааж ярилц.

- Израилчууд Канааны нутгийн хилд хүрч ирэхэд Мосе уг нутаг, үүний нөөц баялаг болоод хүмүүсийг нь тандуулахаар 12 хүнийг илгээв

(Тооллого 13:17–20). Тэр нутгийн нөөц баялгийн тухай тэд ямар мэдээлэлтэй ирсэн бэ? (Тооллого 13:23–27-г үз) Калев, Иошуа хоёроос бусад арван хүн Канаанд амьдардаг хүмүүсийн талаар ямар мэдээлэл хийсэн бэ? (Тооллого 13:28–33-ыг үз) Бидний зарим нь эдгээр 10 хүнийхтэй адил алдааг хэрхэн гаргадаг вэ?

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хэлэхдээ:

“Тандуулуудын арав нь эргэлзээ, айдсынхаа хохирогчид болсон юм. Тэд канаанчуудын тоо, тэдний байдлын талаар сөрөг мэдээлэл өгчээ. . . . Тэр нутагт харсан аварга хүмүүстэй өөрсдийгөө харьцуулахад царцаа мэт мэт байсан ажээ. . . .

“Энэ ажлын ирээдүйн талаар хайхрамжгүй, идэвхгүй байдаг, хязгаарлалтуудын тухай ярьдаг, айдсаа илэрхийлдэг, үнэхээр үр дагавар нь бодитой биш байхад сул тал гэж өөрсдийнхөө боддог тэр зүйлийг ухаан гаргаж, энэ тухай бичдэг хүмүүсийг бид эргэн тойрондоо хардаг. Үүний өнгөрсөн үеийн тухай тэд эргэлздэг учраас үүний ирээдүйн талаар тэдэнд үзэгдэл байдаггүй” гэжээ (Conference report, 1995 оны 10-р сар, 93–94; *Ensign*, 1995 оны 11-р сар, 71).

- Калев Иошуа хоёрын мэдээлэл бусад 10 хүний мэдээллээс юугаараа ялгаатай байсан бэ? (Тооллого 13:30; 14:6–9-ийг үз) Калев Иошуа хоёр Канааны оршин суугчдаас яагаад айгаагүй вэ? (Тооллого 14:9-ийг үз) Бидэнд хүнд нөхцөл байдал тулгарахад Калев Иошуа хоёрын үлгэр жишээг бид дагаж болох зарим арга зам юу вэ?

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хэлэхдээ:

“Сайн мэдээг бүтэлгүйтлээр буюу баяр хөөргүй, итгэл найдваргүйгээр заадаг хүмүүсийн хувьд энэ ажилд байр байдаггүй. Сайн мэдээ бол үнэхээр сайн мэдээ юм. Энэ бол ялгуусан байдлын захиас. Энэ бол үүнийг урам зоригтойгоор хүлээн авах учир шалтгаан мөн.

“Бэрхшээл төвөг байхгүй болно гэж Их Эзэн хэзээ ч хэлээгүй. Энэ ажлыг эсэргүүцдэг хүмүүсийн бий болгосон төрөл бүрийн бэрхшээл зовлон тэдэн дээр ирснийг манай хүмүүс ойлгож мэдсэн юм. Гэвч тэдний бүх зовлон зүдгүүрийн туршид хойш хэзээ ч нэг ч алхам ухарч байсангүй. . . .

“Энэ үе бол гутрангуй үзлийн үе юм. Итгэлийн зорилго бол биднийх. Итгэлээ дахин нотолж, энэ ажлыг дэлхий даяар урагш ахиулахыг би газар бүрийн ах эгч, дүүс та нартаа уриалж байна. Та нар амьдралын төрх байдлаараа энэ ажлыг илүү хүчирхэг болгож чадна.” (Conference Report, 1995 оны 10-р сар, 94–95; *Ensign*, 1995 оны 11-р сар, 71–72)

- Калев, Иошуа хоёрын үгсэд цугларагсад хэрхэн хариу үйлдэл үзүүлсэн бэ? (Тооллого 14:10-ийг үз). Байнгын дургүйцэл, Египет рүү буцах гэсэн хүслийнх нь төлөө Их Эзэн израилчуудыг яаж шийтгэсэн бэ? (Тооллого 14:22–23, 26–35-ыг үз) Канааны нутгийн тухай сөрөг мэдээлэл өгсөн 10 хүнийг Их Эзэн хэрхэн шийтгэсэн бэ? (Тооллого 14:36–37-г үз) Итгэлтэй байдлынх нь төлөө тэрээр Калев, Иошуа хоёрыг хэрхэн адисалсан бэ? (Тооллого 14:24, 38)

4. Мосе гуулин могой хийж, хэрэв хүмүүс үүнийг харах юм бол тэд эдгэрэх болно хэмээн тэдэнд хэлэв.

Тооллого 21:1–9-ийг зааж, ярилц.

- Канаанчуудын дайралтыг бут цохиход Их Эзэн израилчуудад тусалсан хэдий ч, израилчууд дургүйцэн гомдоллохоо үргэлжлүүлсээр байв. Их Эзэн тэднийг хэрхэн шийтгэсэн бэ? (Тооллого 21:6-г үз) Энэ шийтгэлд израилчууд хэрхэн хариу үйлдэл үзүүлсэн бэ? (Тооллого 21:7-г үз)
- Галт могойнуудыг зайлуулахыг түүнээс Мосе хүсэхэд Их Эзэн юу хий гэж Мосед хэлсэн бэ? (Тооллого 21:8–9-ийг үз) Галт могойнуудад хатгуулахаас аврагдахын тулд хүн болгон юу хийх хэрэгтэй байсан бэ?
- Тэд гуулин могойг хараагүйн учир олон израилчууд үхсэн хэмээн Мормоны Номны хоёр бошиглогч Нифай, Алма нар заасан байдаг. Тэд яагаад могойг хараагүй вэ? (1 Нифай 17:41; Алма 33:18–20-ийг үз)
- Гуулин могой хэнийг бэлэгдсэн бэ? (Иохан 3:14–16; Хиламан 8:13–14-ийг үз)
- Израилын хүүхдүүд амьдрахын тулд гуулин могойг харах хэрэгтэй байсны нэгэн адилаар, бид мөнх амьдрал хүлээн авахын тулд Есүс Христ өөд харах хэрэгтэй (Алма 37:46–47; Хиламан 8:15-ыг үз). Христ өөд харах гэж юу гэсэн үг вэ? Гуулин могойг хараагүй израилчуудын гаргасантай яг адил алдааг өнөө үеийн хүмүүс хэрхэн гаргадаг вэ? (Алма 33:20-ийг үз. Тэд Христ өөд хардаггүй, учир нь ингэснээр аврагдаж чадна гэдэгт тэд итгэдэггүй)

“Хэрэв бид мөнх амьдрал олоход найдах юм бол, бид эртний Израилын адил, мэлмий хийгээд оюунаа . . . Христ дээр тавих ёстой. . . . бидний үзэл бодол замын дагуу тэнүүчилж, эсвэл мөхөх ёстой дэлхийн зүйлүүд дээр тогтсон байх ёсгүй. Урагш харахад мэлмий сургагдах ёстой. Бид Бурханд найдаж, амьдрах ёстой!” гэж Ахлагч Карлос Е.Асей хэлжээ (Conference Report, 1978 оны 10-р сар, 81; *Ensign*, 1978 оны 11-р сар, 54).

- Галт могойнуудаас эдгэрэх нь амархны нэгэн адил, мөнх амьдралд хүрэх зам амархныг Алма заадаг байв (Алма 37:46). Ямар утгаар мөнх амьдралд хүрэх зам амархан бэ? Зарим хүмүүс ямар байдлаар мөнх амьдралд хүрэх замыг төвөгтэй болгодог вэ? (Иаков 4:14-ийг үз. Тэд Есүс Христэд итгэх энгийн, аврагч зарчмууд, наманчлал хийгээд дуулгавартай байдлыг олж хардаггүй.) Бид Есүс Христэд итгэх итгэл дээр хэрхэн анхаарал төвлөрүүлж чадах вэ?

Дүгнэлт

Дэлхийн өнгөрсөн зүйлүүдийг харж хамгийн чухал зүйлүүдээс биднийг хөндийрүүлдэг, “аварга” том зүйлүүдээс айхгүй байхад ангийн гишүүдийг урамшуулан дэмж. Хэрэв бид “Бурханы Хүүг итгэлээр харж” (Хиламан 8:15), түүний бошиглогчдыг дагах юм бол, бид энэ амьдралд, бас ирэх амьдралд адислагдах болно.

Нэмэлт заах санаанууд

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

1. “Египет уруу буцацгаая” (Тооллого 14:4)

- Дараах нөхцөлд израилчууд хэрхэн хариулсан байсан бэ:
 - а. Египетчүүд, Улаан Тэнгис хоёрын хооронд хавчуулагдаад байсан үед? (Египетээс Гарсан нь 14:10–12-ыг үз)
 - б. Маннагаас өөр идэх юм юу ч үгүй байхад? (Тооллого 11:4–6, 18–20-ийг үз)
 - в. Канааны нутгийг байлдан эзлэх зорилго тавигдахад? (Тооллого 14:1–4-ийг үз)
 - г. Аглаг буйд дахь хүнд аянаар зориг нь мохоход? (Тооллого 21:4–5-ыг үз)
- Египетийг орхин явах нь израилчуудын хувьд яагаад ийм хэцүү байсан бэ? Өнөөдөр бидний хувьд орхиход хэцүү ямар зарим зүйл байдаг вэ? Хуучны дадал зуршил буюу дэлхийн үзэл бодлоос зайлсхийснээрээ бид бие биенээ хэрхэн бэхжүүлж чадах вэ?

2. Удирдамжийн төлөө хаашаа харах вэ?

Бид удирдамжийн төлөө хаашаа харах ёстойг Тооллогын ном бидэнд заадаг. Та судрын шастируудыг заах үедээ дараах зарчмуудыг самбар дээр бичих замаар эдгээр заадаг зүйлүүдэд онцгой анхаарал хандуулж болно:

- а. Бошиглогч уруу хар (Тооллого 12).
- б. Амлагдсан нутаг уруу—бидний хувьд селестиеп хаант улс уруу хар (Тооллого 13–14).
- в. Аврагч өөд хар (Тооллого 21:4–9).

“Би ЭЗЭНИЙ тушаалтай зөрчилдөх зүйл хийж чадахгүй”

Тооллого 22–24; 31:1–16

Зорилго

Аливаа эргэлзээгүйгээр Бурханы таалалд захирагдахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмжих.

Бэлтгэл

1. Дараах судруудыг залбирч судал:

- а. Тооллого 22:1–21. Моабын хаан Балак, израилчуудыг ойртон ирэхэд айн сандрав. Хэрэв Балаам Моабд ирж, израилчуудыг зүхэх аваас тэрээр Балаамд шагнал амлав. Бурхан Балаамд татгалзахыг зарлиглахад тэрээр дуулгавартай дагав (22:1–14). Хэрэв Балаам Моабд ирж, израилчуудыг зүхэх аваас, Балаамд нэмэлт хүндэтгэл, эд баялгийг Балак санал болгов. Хэрэв тэр хүсвэл тийшээ очиж болохыг, гэвч тэрээр түүнд зөвхөн Бурханы үгсийг ярих ёстойг Бурхан Балаамд хэлжээ (22:15–21). Балаам тийшээ явахыг хүссэн аж.
- б. Тооллого 22:22–35. Балаам Балакаас шагнал горьдож буйг мэдсэн Бурхан Балаамд ууртай байлаа. Балаам замд явж байтал, түүний илжиг болон тэнгэр элч түүнд хандан ярихад тэрээр Бурханыг уурлуулах аюултай юм хийж байгаага мэджээ.
- в. Тооллого 22:36–24:25. Балаам Балактай уулзав (22:36–23:2). Израилыг зүхэхийг Балак түүнээс гурван удаа хүссэн хэдий ч, Балаам Бурханыг дуулгавартай дагаж, тэр бүрд Израилыг адислав (23:3–24:9). Тэгээд тэрээр Моабыг зүхэж, Есүс Христийн тухай бошиглов (24:10–25).
- г. Тооллого 31:1–16. Израилчууд мидианчуудыг устгаж, Балаамыг алав. Израилчуудыг нүгэлд уруу татахыг Балаам мидианчуудад зөвлөсөн гэж Мосе тайлбарлав. (Балаамын зөвлөгөөний үр дагаврууд Тооллого 25:1–3-д дүрслэгдсэн байдаг. Балаам хэдийгээр Израилыг шууд зүхээгүй ч гэсэн, тэрээр Балакаас шан харамжийг ихэд хүсч байсан нь илт бөгөөд Израилыг нүгэлд уруу татахыг санал болгосноор Бурханы хамгааллаа алдахад тэднийг хүргэсэн ажээ.)

2. Нэмэлт уншлага: 2 Петр 2:15–16; Иуда 1:11; Илчлэлт 2:14.

Энэ хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагааг (эсвэл өөрийнхөө нэг үйл ажиллагааг) ашиглаж болно.

Дараах нотолгоонуудыг ангийн гишүүдэд анхааралтай сонсгож, эдгээрийг ямар шинж байдалтай хүн хийснийг бодохыг тэднээс хүс:

“[Хаан] надад алт мөнгөөр дүүрсэн гэрээ өгсөн ч, би Бурхан ЭЗЭНИЙхээ тушаалтай зөрчилдөх зүйл хийж чадахгүй.” (Тооллого 22:18)

“ЭЗЭНий айлдсан болгоныг би хийх ёстой.” (Тооллого 23:26)

“ЭЗЭНий тушаалын эсрэг би өөрийн хүслээр, сайныг ч, муут ч, юуг ч хийж чадахгүй; гэвч ЭЗЭН юу айлдсаныг л би ярих болно.” (Тооллого 24:13)

- Эдгээр зүйлүүдийг хэлсэн хүний зарим шинж чанар юу вэ? (Ийм мэдэгдлүүд хийсэн хүн дуулгавартай, итгэлтэй, даруу гэдгийг харуулж байна.)

Эдгээр мэдэгдлүүдийг чанд дуулгавартай боловч, зүрх сэтгэлдээ дэлхийн шагнал, нэр хүндийг хүсдэг Балаам хэмээх нэртэй хүн хийснийг тайлбарла. Ийм хүслүүдийг гүйцэлдүүлэхийн тулд өөрийнхөө хүслээр мугуйдлан зүтгэхийн үр дагавруудыг энэ хичээл харуулдаг.

Судрын ярилцлага
ба хэрэглээ

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Израилыг зүхсэний хариу болох Балакийн санал болгосон шагналаас Балаам татгалзав.

Тооллого 22:1–21-ийг зааж, ярилц.

- Израилчууд ойртон ирж байгаад айн балмагдсан Моабын хаан Балак, хэрэв Балаам Моабд ирж, Израилыг зүхэх юм бол түүнд шагнал санал болгохоор элч нарыг илгээжээ (Тооллого 22:5–7). Энэ саналд Балаам хэрхэн хариулсан бэ? (Тооллого 22:8–14-ийг үз). Бурханд дуулгаваргүй байсны хариуд ямар нэртэй шагнал зарим үед бидэнд санал болгогддог вэ?
- Балаам Моабд ирэхээс татгалзсаны дараа түүнийг ятгахаар хичээхийн тулд Балак хоёр дахь бүлэг хүмүүсийг илгээсэн нь эхнийхээс илүү сэтгэгдэл төрүүлэхүйц байжээ. Балак Балаамд юу санал болгосон бэ? (Тооллого 22:15–17-г үз). Балаам хэрхэн хариулсан бэ? (Тооллого 22:18–19-ийг үз). Тэр яагаад Их Эзэнээс дахин асуухыг хүссэн бэ? (Их Эзэн бодлоо өөрчилж, Балакийн санал болгосон шагналыг авахыг түүнд зөвшөөрч магадгүй гэж Балаам найдаж байсан байж болох юм.) Бурханы зарлигууд болон зөвлөгөөг өөрчлүүлэхийг эрэлхийлэхийн аюул юу вэ?
- Хэрэв тэр хүсч байгаа бол Балакийн элчүүдтэй хамт явахыг Их Эзэн Балаамд зөвшөөрчээ. Гэвч тийшээ явсных нь төлөө Их Эзэн Балаамд уурлаж байв (Тооллого 22:20–22-ыг үз). Балаамын зүрх сэтгэлд байсан юуны учир Их Эзэний уур хүрсэн бэ? (2 Петр 2:15; Исаиа 29:13-ыг үз)

2. Балаам өөрийнхөө хүслээр мугуйдлан зүтгэсний аюулыг Их Эзэн харуулав.

Тооллого 22:22–35-ыг зааж, ярилц.

- Балаам Моаб уруу явах замдаа илжгээ урагш явуулахаар албадах гэж гурван удаа оролджээ (Тооллого 22:22–30-ийг үз). Энэ нь ямар талаараа Их Эзэнтэй харилцсан Балаамын харилцаатай адилхан бэ? (Балаам өөрийн хүслийг илжигт, бас Их Эзэнд тулгах гэж хүсч байв. Бас илжиг тэнгэр элчийг харсан байхад Балаам хараагүйг та тэмдэглэн хэлж болно. Үүнчлэн Балаамын хараагүй олон зүйлийг Их Эзэн харсан ажээ.)
- Бурханы таалалд буюу эсвэл эцэг эхчүүд, удирдагчдын зөв шударга зөвлөгөөнд захирагдахаас илүүгээр өөрсдийнхөө хийх гэсэн зүйлд мугуйдлан зүтгэдэг өнөө үеийн хувь хүмүүс болон бүлгүүдийн дээрхтэй адил ямар жишээ байдаг вэ?

Та дараах жишээнүүдээс заримыг нь ярилцахыг хүсч болно:

- а. Эцэг буюу эхийнхээ аль нэгний хариултад баярлаагүй хүүхэд өөр хариу сонсохыг найдан нөгөө рүү нь очжээ.
 - б. Санваартны нэг удирдагчийн зөвлөгөөнд сэтгэл дундуур байсан Сүмийн нэг гишүүн санваартны өөр нэг удирдагч уруу очжээ.
 - в. Бусад гишүүдэд хамаатай зарлиг өөрт нь холбогдолгүйн учир шалтгааныг тайлбарлаж буй Сүмийн гишүүн.
- Тэнгэр элч болон илжгээр дамжуулан Их Эзэн Баламыг зэмлэжээ. Тэнгэр элчийн зэмлэсэн үгсэд Балаам хэрхэн хариулсан бэ? (Тооллого 22:31–35-ыг үз) Бурхан хүүхдүүдээ яагаад зэмлэдэг вэ? (С ба Г 95:1-ийг үз) Бурханы зэмлэл бидэнд хэрхэн адислал болдог вэ?

3. Балаам Израилыг зүхэхээс татгалзав.

Тооллого 22:36–24:25-ыг зааж, ярилц.

- Балаамыг Моабд ирсний дараа, Балак Израилыг зүхэхийг түүнээс гурвантаа хүсчээ. Тэр болгонд Их Эзэн Израилыг адислахыг Баламд хэлэхэд, Балаам дуулгавартай дагасан аж. Энэ шастирт Балаам ямар хүч чадлыг харуулсан бэ? (Тооллого 22:38; 23:8, 19–20; 24:1, 12–13-ыг үз) Балаамд ямар сул харагдсаар байсан бэ? (Тооллого 22:41; 23:1–3, 13–15, 27–30-ийг үз). Израилыг зүхэх Балакийн хүсэлтээс Балаам татгалзсан ч гэсэн, тэрээр эдгээр хүсэлтүүд буруу гэдгийг мэдэж байсан хэрнээ тэрээр Балакийг нэг газраас нөгөөд даган, түүний хүсэлтийг сонсохыг хүсч байсан ажээ) Зөв шударга бус зөвлөмжүүд (жишээ нь, найз нарынхаа буюу олон нийтийн мэдээллийн хэрэгслийн) буруу гэдгийг мэдсээр байж тэдгээрийг сонсох нь ямар аюултай вэ?

4. Израилчууд мидианчуудыг устгаж, Балаамыг алав.

Тооллого 31:1–16-г зааж, ярилц.

- Израилчууд яагаад мидианчуудын эсрэг дайтахаар очсон бэ? (Тооллого 31:1–3-ыг үз; Тооллого 25:1–3-д цэдэглэгдсэнээр, Израилыг нүгэлд уруу татсаныг нь төлөө Их Эзэн мидианчуудад ууртай байлаа). Израилын хүүхдүүдийг хиймэл шүтээн шүтэх болон ёс суртахуунгүй явдалд оролцоход уруу татахад мидианчуудад хэн зөвлөгөө өгсөн бэ? (Тооллого 31:16-г үз). Балаам яагаад энэ зөвлөгөөг өгсөн бэ? (Израилыг зүхэх биш адислах Их Эзэний зарлигуудад Балаам дуулгавартай байсан хэдий ч, тэрээр зүрх сэтгэлдээ дэлхийн хүндэтгэл, шагналыг хүсдэг байжээ. Эдгээр шагналуудыг хүлээн авахын тулд тэрээр Израилыг нүгэлд уруу татах зөвлөгөө өгч, Их Эзэний хамгаалалтыг алдахад тэднийг хүргэсэн ажээ.) Израилчууд мидианчуудтай тулалдах үед Балаамд юу тохиолдсон бэ? (Тооллого 31:8-ыг үз)
- Шинэ Гэрээнд гурван зохиогч (2 Петр 2:15–16; Иуда 1:11; Илчлэлт 2:14) Балаамыг дурдсан байдаг. Түүний тухай тэд ямар сэтгэгдэлтэй байсан бэ?
- Энэ түүхээс бид ямар сургамж авч болох вэ? (Дэлхийн шагнал хийгээд хүндэтгэлийг эрэлхийлдэг, Бурханы зөвлөгөө, зарлигуудаас өөрийг эрэлхийлдэг буюу эсвэл дэлхийн санаа, дадал хэвшил буюу жишгүүдийг Сүмд нэвтрүүлэхийг хичээдэг Сүмийн гишүүд Балаамын зөв шударга бус жишээг дагадаг. Илчлэлт 2:14-т үүнийг “Балаамын сургаал” гэж нэрлэдэг.)

Ахлагч Брус Р.МкКонки хэлэхдээ:

“Энэ нь ямар гайхалтай түүх билээ! Тэнгэрийн Их Эзэний чиглүүлдэг гагцхүү тэр зүйлийг л тунхаглахад эргэлтгүй шийдвэр төгс бошиглогч энд байна. Түүний оюун санаандаа баримталдаг үзэл бодлынх нь тухайд өчүүхэн ч эргэлзэх юмгүй мэт. Тэрбээр Их Эзэнийг төлөөлдөг, хааны санал болгосон алт мөнгөөр дүүрэн гэр орон ч, өндөр хүндэтгэл ч түүнийг хатуу тогтсон үзэл бодлоос нь хэлтийлгэж чадахгүй мэт. . . .

“Гэвч эд баялгийн шунал, алдар хүндэтгэлийн тачаал түүнийг даллан дууддаг аж. Баян бөгөөд хүчтэй байх нь [түүний хувьд] хичнээн гайхамшигтай билээ. . . . Магадгүй Их Эзэн өөрийнх нь жишгүүдэд буулт хийх, дэлхийн зарим цэцэглэн хөгжилт хийгээд хүчтэй байх боломжийг түүнд олгож болох байсан аж. . . . Биднээс зарим нь өөрсдийн чиглэлийг Сүмээс холдуулж, тэгээд Балаамын нэгэн адил, дэлхийн шагналуудыг эгээрэн хүсэх нь хичнээн олонтаа байдагт би гайхдаг. . . .

“Нэгэнтээ бурханлигаар нөлөөлөгдсөн, хүчирхэг нэгэн асан Балаам, . . . үүрд мөнхийн баялгуудаас илүүгээр энэ дэлхийн зүйлүүд дээр зүрх сэтгэлээ тавьснаар эцэстээ сүнслэг байдлаа алдсан юм” гэжээ (“The Story of a Prophet’s Madness,” *New Era*, 1972 оны 4-р сар, 7).

- Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаан дахь нотолгоонуудыг эргэн хар. Балаам чанд дуулгавартай мэт харагддаг хэдий ч, түүний зүрхний бодлууд дэлхийн шагнал, нэр хүндийг хүлээн авахын төлөө байсныг тэмдэглэн хэл. Бид зүрх сэтгэлээ цэвэр ариун байлгахын ач холбогдлын тухай энэ түүх бидэнд юу зааж байна вэ? Бид зүрх сэтгэлийнхээ бодлуудыг хэрхэн цэвэр ариун байлгаж чадах вэ?

Дүгнэлт

Хэрэв Балаам Бурханы таалалд даруухнаар захирагддаг байсан бол түүний өөрийнх нь хувьд, түүнчлэн Израилын хувьд их нүгэл, зовлон холдон зайлах байсан биз ээ. Зөрүүд байхаас илүүгээр гуйвшгүй чанд байхад—Их Эзэний тааллын эрэлхийлж, дагахдаа эргэлзэж тээнэгэлзэхгүй, эсвэл өөрчлөгдөхгүй байхад ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

Нэмэлт заах
санаанууд

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

1. Их Эзэнийг дуулгавартай дагах нь

Их Эзэнийг дуулгавартай дагахын ач холбогдлыг бид Балаамаас сурч болно. Бид бас үүнийг судрууд дахь бусад олон эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн үлгэр жишээнээс сурч болно. Та дараах жишээнүүдэд хандаж болно:

- Аврагч, Гетсемани болон загалмай дээр шаналан зовж, “өвдөг сөгдөөд ингэж залбирав, Эцэг минь, хэрэв та хүсэж байгаа бол энэ аягыг надаас зайлуулаач: гэвч миний хүсэл бус, таны хүсэл биелэгдэг.” (Лук 22:41–42)
- Абрахам хүү Исаакаа тахилд өргөхөөр зарлигдуулаад, Мориа Уул уруу явахаар бэлтгэхийн тулд “өглөө эртлэн босчээ” (Эхлэл 22:3).

- в. Тэрээр Бурханы Хүүгийн эх байх болно гэдгийг Мариад хэлэхэд, “Эзэний шивэгчнийг харагтун; хэлсэн үгийн тань дагуу надад биелэх болтугай” гэжээ (Лук 1:38).
- г. Нифай Лебенээс гуулин ялтсуудыг авч ирэхийн тулд Иерусалим уруу буцахаар зааварлагдсан үед тэрээр, “Би явж, бас Их Эзэний зарлиг болсон тэр зүйлүүдийг биелүүлэх болно” гэж тэр даруй хариулжээ (1 Нифай 3:7).
- д. “Тэд зарлигийн үг бүрийг яг таг гүйцэтгэхдээ дуулгавартай мөн шаргуу байсан” учир Хиламаны хөвгүүд тулалдаанд амжилт олжээ (Алма 57:21).

2. “ЭЗЭН чамайг хүндлэлээс буцаан татав” (Тооллого 24:11)

- Балаам Израилыг зүхэх болон Балакийн шагнал, хүндэтгэлийг хүлээн авахаас татгалзахад Балак түүнд, “Эзэн чамайг хүндлэлээс буцаан татав” гэж хэлжээ (Тооллого 24:11). Их Эзэн зарим үед биднийг хэрхэн дэлхийн шагнал, хүндлэлээс холдуулдаг вэ? Дэлхийн шагналуудын оронд Их Эзэн юу амладаг вэ? (С ба Г 81:6-г үз)

“Чи мартахгүйн тулд өөрийгөө хяна”


Дэд Хууль 6; 8; 11; 32

Зорилго	(1) Их Эзэн болон түүнтэй хийсэн өөрсдийнхөө гэрээг санахад, (2) ийн үйлдэхэд нь тэдэнд туслах орчныг бүрдүүлэхэд ангийн гишүүдийг урамшуулан дэмжих.
Бэлтгэл	<ol style="list-style-type: none"> 1. Дараах судруудыг залбирч судал: <ol style="list-style-type: none"> а. Дэд Хууль 6:1–9; 11:18–21. Гэрээнүүдээ санахад нь тэдэнд туслахын тулд Мосе израилчуудад заавар өгөв. Тэрээр өөрийнх нь үгсийг хүүхдүүддээ заахыг эцэг эхчүүдэд зааварлав. б. Дэд Хууль 6:10–12; 8:1–20. Тэдэнд өгсөн Бурханы адислалуудын талаар Мосе Израилчуудад сануулав. Хэрэв тэд Бурханы зарлигуудыг дуулгавартай дагахгүй, Түүнийг санахгүй бол тэд мөхөх болно гэдгийг тэрээр тэдэнд сэрэмжлүүлжээ. в. Дэд Хууль 32:1–4, 15–18, 30–40, 45–47. Өөрсдийнхөө авралын Хадыг (Есүс Христ) санаж байхыг Мосе Израилчуудад зөвлөв. 2. Нэмэлт уншлага: Дэд Хууль 4; 7:1–4; 13:1–8; 34. 3. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх эхний үйл ажиллагааг ашиглах бол, “Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаанд” заагдсан юмсыг гэрээсээ авчир.

Энэ хичээлийг заах удирдамж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа	Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагааг (эсвэл өөрийнхөө нэг үйл ажиллагааг) ашиглахыг хүсч болно. Ангийн хувьд хамгийн тохиромжтой үйл ажиллагааг сонгож ав.
	<ol style="list-style-type: none"> 1. Их Эзэний тухай, түүнчлэн түүнтэй хийсэн таны гэрээнүүдийг өөрт чинь сануулдаг гэрээсээ авчирсан юмсыг үзүүл. (Ийм зүйлүүд нь судрууд, зургууд, номнууд, хөгжмийн бичлэгүүд байж болно). Эдгээр юмнууд өөрт чинь яагаад чухал болохыг ангийн гишүүдэд хэл. Энэ хичээлийн нэг хэсэг бол Их Эзэний тухай болон түүнтэй хийсэн өөрсдийнхөө гэрээний тухай өөрсдөдөө сануулахын тулд эртний израилчуудын хэрэглэдэг байсан биет зүйлүүдийн тухай байх болно гэдгийг тайлбарла. Биет зүйлүүд нь бидний хувьд ч бас хүчтэй сануулагч байж чадна гэдгийг тэмдэглэн хэл. 2. Дараах үгсийг самбар дээр бич: <p><i>Мэхлэх, залилах, урхидах, луйвардах, ховдоглон идэх, буруу нөлөө үзүүлэх, уруу татах, нүд хуурах (аргалах), уурлан хилэгнэх, харалган болгох, худал хэлэх, зусардах, устгах</i></p> <ul style="list-style-type: none"> • Эдгээр үгст байдаг нийтлэг зүйл юу вэ? (Нийтлэг нэг шинж бол эдгээр үгс бүгдээрээ биднийг Их Эзэнээс холдуулах хүч чармайлтдаа Сатан ашигладаг арга тактикийг дүрсэлдэг.)

- Ангийн нэг гишүүнээр С ба Г 76:28–29-ийг уншуул. Эдгээр шүлгүүд Иосеф Смит, Сидней Ригдон нарт өгөгдсөн илчлэлтэд байдгийг тайлбарла. Сатаны нөлөөнөөс өөрсдийгөө хамгаалахын тулд бид юу хийж болох вэ? (Бид өөрсдийгөө Сатаны нөлөөнөөс хамгаалахын тулд бидний хийж болох зарим зүйлийг харуулсан дараах схемийг та ашиглаж болно.)



Дэд Хуулийн номонд, Сатаны уруу таталтуудыг эсэргүүцэхэд нь тэдэнд туслах орчныг хэрхэн бүрдүүлэх талаар Мосе израилчуудад заадаг байсныг тайлбарла. Энэ хичээл Мосегийн зөвлөгөөг нэгтгэн дүгнэж, үүнийг бид өнөө үед хэрхэн хэрэглэхийг ярилцдаг.

Судрын ярилцлага ба хэрэглээ

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагауудаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

Аглаг буйдад израилчуудыг 40 жил сорьж, зэмлэн, тэдэнд заасны дараа тэд амлагдсан нутагт ороход бэлэн боллоо гэж Их Эзэн хэлжээ. Гэвч эхлээд тэрээр тэдэнд зарим чухал заавруудыг өгсөн ажээ. Мосе эдгээр заавруудыг Дэд Хуульд цэдэглэгдсэн гурван номлолд өгчээ.

Эдгээр номлолуудад Мосе тэдний чөлөөлөлтөн дэх Их Эзэний мутрыг хүлээн зөвшөөрч, аглаг буйд дахь Израилын 40 жилийн хээрийн аяныг нэгтгэн дүгнэжээ. Мосе түүнчлэн Бурханы сонгогдсон хүмүүс болох Израилын үүрэг хариуцлагуудын тухай өгүүлсэн аж. Тэд Бурханы зарлигуудыг, ялангуяа Түүнийг дурсан санаж, хиймэл шүтээнээс татгалзах зарлигуудыг дуулгавартай дагах ёстойг тэрээр онцлон тэмдэглэжээ. Хэдийгээр Израилын хүүхдүүд амлагдсан нутагт ороход бэлэн байсан боловч, хэрэв тэд аглаг буйд уруу буцах юм бол тэд өөрсдийн өвийг алдаж, улмаар тараагдаж болохыг Мосе сэрэмжлүүлж байв.

1. Гэрээнүүдээ санахад нь тэдэнд туслахын тулд Мосе израилчуудад зааврууд өгөв.

Дэд Хууль 6:1–9, 11:18–21-ийг зааж, ярилц.

- Израилчуудад хандаж хэлсэн Мосегийн сүүлчийн үгсийг Дэд Хууль агуулдаг. Хэрэв та гэр бүл болон найз нартаа сүүлчийн захиас өгөх боллоо гэхэд энэ нь юу байх вэ?

- Дэд Хууль 6:5–7-д Их Эзэн юу хийхийг израилчуудад зарлигласан бэ? Судруудын үгсийг бид зүрх сэтгэлдээ хэрхэн авчирч болох вэ? Эцэг эхчүүд сайн мэдээг хүүхдүүддээ хэрхэн үр ашигтай зааж, судруудыг хайрлаж сурахад нь тэдэнд хэрхэн тусалж болох вэ?
- Дэд Хууль 6:8–9 болон 11:18–20-д Мосе израилчуудад юу гэж зөвлөсөн бэ? Сахиус нь “дээр судрын дөрвөн хэсгийг бичсэн илгэн цаасан тууз бөгөөд . . . үүнийг хуйлж, духан дээрээ болон гарнаасаа савхиар оосорлон уядаг байжээ.”
- Судрын хэсгүүдийг хоёр нүднийхээ хооронд, гартаа, гэрийнхээ хаалганы хатавчин дээр, дааман хаалган дээр байрлуул гэж Мосе яагаад хүмүүст хэлдэг байсан гэж та нар бодож байна вэ? Ийм байнгын сануулагчид бидний үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлдөг вэ? Их Эзэнийг, түүний үгсийг, түүнчлэн түүнтэй байгуулсан гэрээнүүдээ өөрсөддөө сануулахын тулд бид гэр орондоо юу хийж болох вэ? Манай хананууд дээрх зурагнууд, бидний уншдаг номнууд, бидний үздэг кинонууд болон телевизийн үзүүлбэрүүд бидэнд Их Эзэний тухай сануулдаг уу, эсвэл эдгээр нь дэлхийг хүсэн санагалзахыг бидэнд санал болгодог уу?

“Христээр ахлуулдаг хүмүүс Христэд сэтгэл санаагаа юүлдэг байх болно. . . . Тэдний гэрт ороод үз, тэгвэл ханан дээрх зургууд нь, тавиур дээрх номнууд нь, агаар дахь хөгжим нь, тэдний үгс хийгээд үйл хэрэг нь тэднийг Христийнх болохыг илчилнэ” гэж Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон хэлжээ (Conference Report, 1985 оны 10-р сар, 6; *Ensign*, 1985 оны 11-р сар, 6–7).

2. Бурханы зарлигуудыг дуулгавартай дагаж, Түүнийг дурсан санахыг Мосе израилчуудад зөвлөдөг байв.

Дэд Хууль 6:10–12, 8:1–20-ийг зааж ярилц.

- Дэд Хууль 6:10–12, 8:1–20 дахь гол захиас юу вэ? Их Эзэнийг мартагч гэдэг нь юу гэсэн үг вэ? (Дэд Хууль 8:11-ийг үз) Түүнийг мартагчын үр дагаврууд юу вэ? (Дэд Хууль 8:19-ийг үз) Их Эзэнийг мартаггүй гэдэгтээ бид хэрхэн итгэлтэй байж чадах вэ?
- Бурханыг хүмүүс мартагчид хүргэж болох ямар нөхцөлүүд хийгээд сорилтуудыг Мосе нэрлэсэн бэ? (Дэд Хууль 6:10–12; 8:10–20-ийг үз) Их Эзэн тэднийг элбэг дэлбэгээр адисалсны дараа яагаад зарим хүмүүс Түүнийг мартдаг вэ? (Дэд Хууль 8:17-г үз)

Ерөнхийлөгч Бригам Янг хэлэхдээ: “[Энэ Сүмийн гишүүдийн] тухайд миний хамгийн их айдаг зүйл бол тэд энэ оронд баяжиж, Бурхан болон түүний хүмүүсийг умартан, бүдүүрч таргалаад, өөрсдийгөө Сүмээс тасалж, тэгээд там уруу одох вий гэсэн айдас гэжээ. Энэ хүмүүс танхайрлыг, дээрэмдлэгийг, ядуурлыг тэрчлэн бүх төрлийн хавчлагыг тэсвэрлэх болно, мөн үнэнч байх болно. Гэвч тэдний төлөө миний илүү ихээр айдаг зүйл бол тэд эд баялгаас тэсэн гарч чадахгүй гэсэн айдас бөгөөд; мөн эдүгээ ч гэсэн тэд эд баялагт соригдох ёстой болоод байна, учир нь тэд энэ дэлхий дээрх хамгийн баян хүмүүс болох болно.” (Preston Nibley, *Brigham Young: The Man and His Work* [1936], 128)

- Бидэнд тохиож болох аливаа цэцэглэн хөгжилтийн эх сурвалж нь хэн бэ? (Дэд Хууль 8:18-ыг үз) Бид өөрсдийн цэцэглэл хөгжилтийг Их Эзэний ажлыг урагш ахиулахад хэрхэн ашиглаж болох вэ? (Дэд Хууль 8:18; Иаков 2:18–19-ийг үз)

3. Өөрсдийн авралын Хадыг (Есүс Христ) санадаг байхыг Мосе израилчуудад зөвлөв.

Дэд Хууль 32:1–4, 15–18, 30–40, 45–47-г зааж, ярилц.

- Дэд Хууль 32:3–4-т өгүүлэгдсэн Хад хэн бэ? (Есүс Христ; түүнчлэн шүлэг 15, 18, 30–31-ийг үз) Яагаад Есүс Христ заримдаа Хад гэж нэрлэгддэг гэж та нар боддог вэ? (Хиламан 5:12-ыг үз)
- “Тэдний хад” (ёс бусчуудын хуурамч бурхад) “бидний хад шиг биш” (Дэд Хууль 32:31) гэж Мосе мэдэгджээ. “Тэдний хад” “бидний Хаднаас” ямар ялгаатай вэ? (Дэд Хууль 32:37–40-ийг үз)
- Хадан дээр барих гэдэг нь юу гэсэн үг вэ? (Дэд Хууль 32:46–47; Матай 7:24–27; С ба Г 50:44-ийг үз) Бид үүнийг хэрхэн хийж чадах вэ? (Дэд Хууль 18:18–19-ийг үз, энэ нь, Христийн ирэлтийн талаарх бошиглолд, түүний үгсийг анхааран сонсох хэрэгтэй тухай өгүүлдэг.)

Дүгнэлт

Аврагчийн тухай өөрийнхөө гэрчлэлийг хэлж, түүнтэй хийсэн гэрээнүүдийнхээ төлөө талархлаа илэрхийл. Бурханыг дурсан санах хийгээд түүнтэй хийсэн өөрсдийн гэрээнүүдийг сахихын ач холбогдлыг онцлон тэмдэглэ. Бидний эргэн тойрондоо байлгадаг зүйлүүд—зурагнууд, номнууд, тэрчлэн хөгжим мэт нь—Их Эзэн хийгээд түүнтэй бидний байгуулсан гэрээнүүдийн хүчирхэг сануулагч байж чадна. Бид эдгээр зүйлүүдээр өөрсдийгөө хүрээлүүлэхийн зорилго нь эртний израилчууд сахиус зүүдэг байсан тэрхүү зорилго нь: Хадан дээр барихад бидэнд туслах—Их Эзэнийг дурсан санаж, түүнийг дагахад бидэнд туслахтай агаар нэг болохыг тэмдэглэн хэл.

Нэмэлт заах санаанууд

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

1. “Түүнийг гэрийнхээ хаалганы хатавчин дээр бич” (Дэд Хууль 6:9)

Гэрт нь байдаг уран зургууд, үзүүлэнгүүд, хөгжмийн бичлэгүүд болон бусад зүйлүүдийг жагсаан бичихэд ангийн гишүүдийг урь. Жагсаалтанд багтсан зүйлүүдийг нэг бол “+” тэмдгээр (Уг юм Их Эзэнийг дурсан санахад тэднийг хөтөлдгийг харуулна) эсвэл “-” тэмдгээр тэднээр тэмдэглүүл (энэ зүйл тэдний зүрх сэтгэлийг Их Эзэнээс холдуулахад илүү хөтөлдгийг харуулна). Ангийн гишүүд үүнийг гэр бүлийн үдшийн үеэр гэрийнхэнтэйгээ хамт хийхийг та ангийн гишүүдэд санал болгож болно.

2. “Тэрээр чамайг орхихгүй” (Дэд Хууль 4:31)

- Израилчууд бусад бурхдыг шүтэн бишрэхэд эргэж, улмаар тараагдах болно гэдгийг бошиглосны дараа Мосе найдварын үгсийг санал болгожээ

(Дэд Хууль 4:25–28). Бүх зүрх сэтгэлээрээ Их Эзэнийг эрэлхийлдэг хүмүүст тэрээр юу амласан бэ? Дэд Хууль (Дэд Хууль 4:29–31; Исаиа 49:14–16-г үз) Энэ амлалт таны амьдралд хэрхэн биелэгдсэн бэ? Бид бүх зүрх сэтгэлээрээ Их Эзэнийг эрэлхийлэхийн тулд юу хийх ёстой вэ?

3. Бусдын сөрөг нөлөөнд автахгүй байх нь

- Дэд Хууль 13:6–8-д Мосе ямар аюулын эсрэг сэрэмжлүүлсэн бэ? Хэн нэгэн нь биднийг Их Эзэнээс холдуулах гэж оролдож байгааг бид яаж мэдэх вэ? Ийм хүнд бид ямар хариулт өгөх ёстой вэ?

4. “Тэд ЭЗЭНий өмнө гар хоосон үзэгдэж болохгүй” (Дэд Хууль 16:16)

- Дэд Хууль 16:2, 11, 16-д дурдагддаг табернекл (асар) бол израилчуудын хувьд авсаархан ариун сүм байлаа. Асарт хийх баярт бэлтгэх үеэр “ЭЗЭНий өмнө гар хоосон үзэгдэхгүй” байхад хүмүүсийг зааварласан ажээ (Дэд Хууль 16:16). Энэ нь биднийг ариун сүмд ороход хэрхэн холбогдох вэ? Бид ариун сүмд “хоосон” орохгүйн тулд өөрсдийгөө хэрхэн бэлтгэж болох вэ? Энэ бэлтгэл ариун сүмд “ЭЗЭНий өмнө хөгжин баярлахад” бидэнд хэрхэн туслах вэ? (Дэд Хууль 16:11)
- Ерөнхийлөгч Ховард В.Хантер зөвлөхдөө: “Ариун сүмд ордог хүмүүс байцгаая. Хувь хүний нөхцөл байдалд боломж олгохын хэрээр ариун сүмд олон орцгоо. Хүүхдүүд чинь харахаар газарт ариун сүмийн зургийг гэртээ байрлуул” гэжээ (Conference Report, 1994 оны10-р сар, 8; *Ensign*, 1994 оны 11-р сар, 8). Боломжоороо ариун сүмд аль болох олон удаа явах нь бидний хувьд яагаад чухал вэ? Ариун сүмийн зургийг гэр орондоо байлгах нь яагаад чухал вэ?

5. “Түүний булшийг хэн ч мэдэхгүй” (Дэд Хууль 34:6)

Дэд Хууль номыг дуусгасан зохиогч л Мосе алга болчихсоныг ганцаараа мэдэж байсан бөгөөд тэрээр нас барсан байх, мөн түүнийг Их Эзэн оршуулсан байх гэж бодож байжээ, бас түүний булшийг хэн ч мэдэхгүй байв. Гэвч, Мосе зөөгдсөнийг бид мэддэг билээ. (Зөөгдсөн хүмүүн биесийн байдлын тухай тайлбарыг 3 Нифай 28:7–9, 37–40–өөс үз). Мосе зөөгдсөн тухай Библийн Толь Бичигт дараах тайлбар байдаг:

“Эртний олон бошиглогчдод тохиолдсоны нэгэн адил Мосегийн тохинуулал түүний мөнх бус амьдралын хугацааны хязгаараас даван гарсан юм. Тэрбээр Елиагийн хамт Хувиралтын Уулан дээр ирж, санваарын түлхүүрүүдийг Петр, Иаков, Иохан нарт олгожээ (Матай 17:3–4; Марк 9:4–9; Лук 9:30; С ба Г 63:21; *History of the Church*, 3:387). Есүсийн амилалтаас өмнө тохиосон үйл явдлаас хойш Мосе зөөгдсөн хүмүүн бие байгаа бөгөөд тэрээр үхээгүйг бид Дэд Хууль 34-өөс (Алма 45:19) ойлгодог. Амилалт хараахан тохиогоогүй байсан учраас, зөөгдөхийн тулд тэрээр хувиралтын үед мах ясан биетэй байх нь зайлшгүй байжээ. Тэр бол зөвхөн сүнс байсан бол мөнх бус Петр, Иаков, Иохан нарт уулан дээр түлхүүрүүдийг өгөх ажлыг гүйцэтгэж чаддаггүй байх байсан. (С ба Г 129)” (*Bible Dictionary*, “Moses,” 735)

Зорилго

Есүс Христийн сайн мэдээгээр амьдрахад тууштай, зоригтай байхад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмжих.

Бэлтгэл

1. Дараах судруудыг залбирч судал:
 - а. Иошуа 1. Мосег залгамжлуулахаар Их Эзэн Иошуаг дуудаж, хүчтэй, зоригтой байж, судруудыг судлан, зарлигуудыг сахихыг түүнд зарлиглажээ. Их Эзэн тэдэнд амласан нутгийг эзэмшихэд Иошуа израилчуудыг бэлтгэж байв.
 - б. Иошуа 3–4; 6. Израилчууд Иордан голыг гаталж, гол гаталсныхаа дурсгал болгон хуурай газар дээр 12 чулуу тавьжээ. Израилчуудын итгэлээр дамжин Иерихо устгагджээ.
 - в. Иошуа 23; 24:14–31. Иошуа болон түүний хүмүүс Их Эзэнд үйлчлэх гэрээ байгуулсан ажээ.
2. Нэмэлт уншлага: Иошуа 7; 14.
3. Тэрээр Иерихогийн тулалдааны шастирыг нүдээр харсан гэрчийн байдлаар ярихыг ангийн нэг гишүүнээс хүс (Иошуа 6). Бурханы хүч болон хайрыг өөрсдөд нь сануулдаг туршлагаа хуваалцахаар бэлтгэж ирэхийг ангийн нэг буюу хоёр гишүүнээс хүс.
4. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашиглах бол хуудас цаас, тууз буюу резинэн уяа, нэг ном авчир. Хэрэв та хавх буюу урхин дээрх асуултуудыг ашиглах бол, хулганын хавх, жижиг урхи авчирч, ярилцлагын үзүүлэн болгон ашиглаж болно.

Эн хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагааг (эсвэл өөрийнхөө нэг үйл ажиллагааг) ашиглахыг хүсч болно.

Энэ хичээл бол Израилын хүүхдүүдийг амлагдсан нутгийг байлдан дагуулахад нь удирдсан бошиглогч Иошуагийн тухай ном гэдгийг тайлбарла. Иошуаг бошиглогч болгохоор дуудах үед Их Эзэн түүнд “тууштай бөгөөд зоригтой бай” (Иошуа 1:6) хэмээн зөвлөжээ. Энэ өгүүлбэрийг самбар дээр бич. Хуудас цаас, номыг үзүүл. Хуудас цаасыг эрмэг дээр нь тогтоох, мөн номыг уг цаасан дээр тавихаар оролдохыг ангийн нэг гишүүнээс хүс.

Ангийн нэг гишүүн үүнийг хийх гэж оролдсоны дараа цаасан дээр нь ном тавихад тогтохуйц бат бөх болгох арга байдгийг тайлбарла. Цаасыг хоолой хэлбэртэй болгон хуйлж, үүнийг туузаар буюу резинэн уяагаар бүсэл. Хоолойг тэгш гадаргуу дээр нэг талаар нь босгон тавь. Номыг дээр нь болгоомжтой тавь. (үүнийг хичээлээс өмнө туршин үзэж болно)

Өөрийнх нь зан төрхийг төлөвшүүлэхийг Бурханд зөвшөөрснөөр Иошуа ийм хүчтэй болсныг тайлбарла. Үүн лугаа адил, өөрсдийнхөө зан төрхийг төлөвшүүлэхийг бид Бурханд зөвшөөрснөөр бид хүчирхэг болж, Их Эзэн биднээр хийлгэхийг хүсдэг зүйлүүдийг бид хэрэгжүүлж чадна.

Судрын ярилцлага
ба хэрэглээ

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагауудаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

Аглаг буйд дахь израилчуудын 40 жилийн хээрийн аяны туршид Мосе тэдэнд Бурханы хуулийг өгч, Бурханы төлөөлөгчийн хувиар үйл ажиллагаа явуулж, тэдний хөтөч болон үйлчилж байв. Тэр бол Израилын нэг бүхэл үеийнхний мэдэх цорын ганц удирдагч юм. Гэвч Их Эзэн тэдний аяны төгсгөлд—тэднийг их сорилттой тулгарах яг тэр үед түүнийг аваачжээ. Их Эзэн Израилд өгсөн амлалтаа санаж, амлагдсан нутгийн байлдан дагуулалт хийгээд суурьшилтыг чадварлагаар удирдсан шинэ удирдагч Иошуаг өсгөн бойжуулсан билээ.

1. Их Эзэн Иошуаг дуудав.

Иошуа 1-ийг зааж, ярилц.

- Мосег залгамжлан израилчуудыг удирдуулахаар Их Эзэн Иошуаг дуудах үед түүнд ямар хүндрэл бэрхшээл тулгарсан гэж та нар боддог вэ? (Тэрээр Канааныг байлдан дагуулж, тэнд суурьшихад Израилыг удирдах ёстой болсон нь хүч чармайлт их шаардах үүрэг байлаа. Тэрээр бас агуу их удирдагчийг орлов.) Амлагдсан нутагт ороход нь Иошуаг бэлтгэхэд Их Эзэн түүнд ямар баттай итгэл өгсөн бэ? (Иошуа 1:5) Бидний шинэ дуудлагууд буюу сорилтуудад энэхүү баттай итгэл бидэнд хэрхэн тусалдаг вэ? Ийм нөхцөл байдлуудад Их Эзэн бидэнд хэрхэн тусалдаг вэ?
- Их Эзэн ямар зарлигийг Иошуа 1:6–9-д гурвантаа давтсан бэ? Юуг хийхэд нь Иошуад зориг, хүч чадал хэрэгтэй гэж Их Эзэн хэлсэн бэ? (Иошуа 1:7-г үз. Цэрэг дайны олон тулалдаан хийхэд нь Иошуад зориг хэрэгтэй байсны зэрэгцээгээр бас түүнд ёс суртахууны зориг—зөвийг хийх зориг хэрэгтэй байсныг тэмдэглэн хэл) Хүч чадал, ёс суртахууны зориг шаарддаг ямар сорилтуудтай бид өнөөдөр тулгардаг вэ?
- “Амжилтад хүрэхийн тулд” юу хий гэж Их Эзэн Иошуд хэлсэн бэ? (Иошуа 1:8-ыг үз. Хуулийн ном бол судрууд гэдгийг тайлбарла) Дуудлагадаа амжилтанд хүрэхийн тулд судруудыг судлах нь яагаад Иошуад чухал байсан гэж та нар боддог вэ? Судруудыг тогтмол судлах нь бидэнд хэрхэн тусалдаг вэ?

2. Израилчууд Иордон голыг гаталж, хуурай газар дээр гарав; тэдний итгэлийн дүнд Иерико устгагдав.

Иошуа 3–4 ба 6-г зааж, ярилц.

- Израилчууд Иордан голыг гатлах хэрэгтэй болсон үед, гол эрэг бялхам устай байв. Их Эзэн Мосетой хамт байсны нэгэн адил Иошугагай хамт байснаа Израилын хүүхдүүдэд хэрхэн харуулсан бэ? (Иошуа 3:7–8, 14–17; 4:14-г үз. Хэрэв шаардлагатай бол, гэрээний авдар нь ариун бичээсүүд, түүний дотор Мосегийн бичээсүүд болон Арван Зарлигийг агуулсан

самбар бүхий авсаархан тахилын ширээ байсныг тайлбарла.) Их Эзэн өнгөрсөн үеийн бошиглогчдын нэгэн адил амьд бошиглогчийг чиглүүлэн бурханлигаар нөлөөлдгийг бидэнд хэрхэн үзүүлдэг вэ?

- Авдрыг авч явсан санваартнууд Иордан голын ус татрахаас өмнө юу хийсэн бэ? (Иошуа 3:13–17-г үз. Тэд аврыг авч, үерлэсэн гол уруу орох хэрэгтэй байв.) Зарим үед үүнтэй төстэй зүйлүүдийг хийхийг Их Эзэн биднээс хэрхэн хүсдэг вэ?

Ахлагч Бойд К.Пакер хэлэхдээ:

“Би Ерөнхий эрх мэдэлтнээр дуудагдсаныхаа дараахан ахлагч Харольд Б.Лийгээс зөвлөгөө авахаар түүн дээр очиж билээ. Тэрээр миний асуудлыг нэн анхааралтай сонсоод, Ерөнхийлөгч Давид О.МкКейтэй уулзахыг надад санал болгов. Ерөнхийлөгч МкКей миний хаашаа явах ёстой тэр зүг рүү намайг чиглүүлсэн юм. Би дуулгавартай байхыг ихэд хүссэн хэдий ч, намайг хий хэмээн түүний зөвлөсөн зүйлийг хийх боломжтой арга замыг би олж харахгүй байлаа.

“Би Ахлагч Лий дээр буцаж очоод надад зөвлөсөн тэр чиглэлээр явах замыг би олж харахгүй байгаагаа түүнд хэлэв. “Таны асуудал бол та төгсгөлийг эхлэлээс нь харахыг хүсч байгаа явдал мөн” гэж тэрээр хэллээ. Би ядахдаа л нэг буюу хоёр алхам урагшаа харах юм сан гэж санадаг хэмээн хариулав. Тэгээд дараа нь насан туршийн нэгэн сургамж авсан нь: “Та гэрлийн ирмэгээр алхаж сурах хэрэгтэй, тэгээд харанхуй руу хэдэн алхам хий; тэгвэл гэрэл үзэгдэж, өмнөх замыг чинь харуулах болно” гэсэн үгс байлаа” гэжээ (“The Edge of the Light,” *BYU Today*, 1991 оны 3-р сар, 22–23).

- Израил Иордан голыг гаталсны дараа яагаад 12 чулуун дурсгал босгосон бэ? (Иошуа 4:1–9-ийг үз. Энэ бол тэдний эцгүүдийн нэгэн адилаар Их Эзэн тэднийг адислах болно гэдгийг тэдэнд сануулан, Их Эзэний хүчний тухай ирээдүйн үеийнхэнд хандсан гэрчлэл болох учиртай байлаа.) Хувь хүний ямар дурсгалууд өөрийн чинь амьдрал дахь Бурханы хүчийг та нарт сануулдаг вэ? (Ариун ёслол, Христийн зургууд, ариун сүмүүд, бошиглогчид болон судрууд; түүнчлэн өдрийн тэмдэглэлүүдэд тэмдэглэгдсэн сүнслэг туршлагууд хариултууд нь байж болно.) Эдгээр дурсгалууд бусдын амьдралыг хэрхэн адисалж чадах вэ? (Иошуа 4:21–24-ийг үз)

Их Эзэн залбирлуудад хариулж, адислалууд, илчлэлт өгч, шинэ үеийнхэн болгонд зориулж гайхамшигт ажлууд үйлддэгийг гэрчил. Бурхан хүч болон хайрыг өөрсдөд нь сануулдаг туршлагуудаа хуваалцахыг урьдчилан даалгавар авсан ангийн гишүүдээс хүс.

- Иерихогийн уналтыг нүдээр үзсэн гэрчийн байдлаар дүрслэхийг урьдчилан даалгавар авсан ангийн нэг гишүүнээс хүс (Иошуа 6). Иерихогийн хэрмийг юу унахад хүргэсэн бэ? (Еврей 11:30-ыг үз) Яагаад изриалчуудын зан төлөв итгэлийн үйл хэрэг байсан бэ?
- Аврагдсан Иерихогийн хэдхэн оршин суугчид хэн байсан бэ? (Иошуа 6:17, 22–25; түүнчлэн Иошуа 2:1–15-ыг үз) Рахаб болон түүний гэр бүлийн аврагдалтаас бид юу сурч болох вэ?

3. Иошуа болон түүний гэр бүл Их Эзэнд үйлчлэхээр гэрээ хийв.

Иошуа 23, 24:14–31-ийг зааж, ярилц.

- Бурхан өөрсдийнх нь төлөө юу хийснийг Иошуа амьдралынхаа эцэст израилчуудад сануулжээ. Бас хавх, урхинаас зайлсхийж байхыг Иошуа тэдэнд зөвлөдөг байв. Хэрэв та жижигхэн хавх авчирсан бол, яаж ажилладгийг нь харуул. Хэрэв та хавх авчраагүй бол, яаж ажилладгийг нь дүрслэн тайлбарла. Бид хавханд орохоос зайлсхийхийн тулд хийх ёстой зарим зүйлүүд юу вэ? (Эхлээд бид энэ бол хавх гэдгийг таньж, дараа нь түүнээс хол байх ёстой.)
- Иошуа өөрийн сүүлчийн зөвлөгөөнд “үндэстнүүдийн үлдэгдэлтэй [канаанчууд] нийлэх биш” харин “Их Эзэнтэй нэгдэн нийлэхийг” израилчуудад ухуулжээ (Иошуа 23:8, 12-ыг үз. Энэ жишээнд, *нийлэх* гэдэг үг нь наалдах, нэгдэн нийлэх гэсэн утгатайг анхаар). Бид “дэлхийтэй нийлэхээс” илүүгээр хэрхэн “Их Эзэнтэй нэгдэн нийлж” болох вэ? Канаан үндэстэнтэй нийлэх нь израилчуудын хувьд хэрхэн урхи, хавх байж болох вэ? Өнөөдөр бидэнд тулгардаг дэлхийн зарим урхи, хавх юу вэ?
- Иошуа амьдралынхаа эцэст ямар чухал зөвлөгөө өгсөн бэ? (Иошуа 24:14–15-ыг үз) Иошуа болон Израил хэнд үйлчлэхээр гэрээ хийсэн бэ? (Иошуа 24:15–18, 21–25, 31-ийг үз) Хүн яагаад үнэн Бурхан болон дэлхийн бурхдад нэгэн зэрэг үйлчилж чадахгүй вэ?
- Өнөөдөр Их Эзэнд үйлчлэхээр сонгох нь яагаад чухал вэ? Түүнд үйлчлэхээр сонгосноо бид хэрхэн харуулж болох вэ?

Ахлагч Марвин Ж.Аштон хэлэхдээ: “Хэнд үйлчлэх вэ гэдгээ өөрсдөдөө сонго; . . . харин би болон манай гэрийнхэн, бид ЭЗЭНД үйлчилнэ” (Иошуа 24:15) гэснээр шийдвэрийг шуурхай гаргахын ач холбогдлыг Иошуа бидэнд сануулдаг” гэжээ. Маргааш биш, бид бэлэн болсон үедээ, тохиромжтой үедээ биш— харин ‘энэ өдөр, хэнд та нар үйлчлэхээ шууд сонго’. Биднийг дагахад урьдаг хүн ямагт бидний өмнө Түүний сүнстэй хамт байж, алхам хийхэд нөлөөлж байдаг. Тэрээр чиглэлийг дүрслэн тэмдэглэж, хаалгыг нээн, замыг харуулдаг. Тэрээр Түүнд ирэхэд биднийг урьдаг бөгөөд Түүнтэй хамтын нөхөрлөлийг эдлэх хамгийн аятай сайхан цаг хугацаа шууд шулуун юм. Бид Есүсийн нэгэн адил—Түүний Эцэгийн тааллыг гүйцэлдүүлэхийн төлөө бүхэлдээ шийдвэр төгс байснаар тэр чиглэл дээр хамгийн сайнаар гарч, тэндээ үлдэж чадна” гэжээ (Conference Report, 1983 оны 4-р сар, 41; *Ensign*, 1983 оны 5-р сар, 30–31).

Дүгнэлт

Израилчуудад өгсөн Иошуагийн сүүлчийн зөвлөгөө нь Их Эзэн түүнийг бошиглогчоор дуудах үед өгсөн—тууштай бөгөөд зоригтой байх (Иошуа 23:1–6) тэрхүү даалгаврыг мөн агуулдаг. Бид бүгд сайн ба муугийн хоорондох сүнсний чухал тулалдаанд оролцдог учраас энэ даалгавар тэр үед байсны адил өнөөдөр ч гэсэн чухал ач холбогдолтой юм.

Аюулгүй байдал болон амар амгалангийн хувьд хоёр зарчим: “нэгдүгээрт, Бурханд итгэх; хоёрдугаарт, зарлигуудыг сахих, Их Эзэнд үйлчлэх, зөвийг хийхэд шийдвэр төгс байдал чухал . . . Цаг хугацаа хүнд хэцүү, аюултай байлаа ч гэсэн, бид уруу таталт, нүглээр хүрээлүүлсэн ч гэсэн, хүмүүсийн зүрх сэтгэл алдарч, тэдний бодгаль сэтгэлийн түгшүүрээр дүүрлээ ч гэсэн, хэрэв бид гагцхүү Бурханд итгэж, түүний зарлигуудыг сахих аваас, бид айх хэрэггүй” гэж Ахлагч Эзра Тафт Бенсон хэлжээ. (Conference Report, 1950 оны 10-р сар, 146)

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

1. Амжилттай удирдагчийг замгамжлах нь

- Иошуа, Бригам Янг мэтийн олон хүмүүс агуу удирдагчдыг залгамжлахаар дуудагдсан билээ. Тэдэнд тохиолддог зарим бэрхшээлүүд юу байж болох вэ? Амжилттай байхад нь тэдэнд юу тусалсан гэж та нар боддог вэ? Ажил дээрээ, сүмд, сургууль дээрээ буюу гэр орондоо онцгой ялгардаг хүмүүсийг дуурайснаар амжилттай байхад бидэнд туслах юуг бид хийж болох вэ?

2. Бусад хүмүүст нөлөөлдөг хувь хүмүүсийн нүглийн үр дагаврууд

- Иошуа 7 дахь Аханы тухай шастирыг заа. Аханы дуулгаваргүйн улмаас, израилчууд Аигийн хүмүүст бут цохигдсан ажээ (Иошуа 7:1–5). Үүнд шалтгаалах юуг Ахан хийсэн бэ? (Иошуа 7:20–21-ийг үз. Түүнд дуулгаваргүй хандсан болон Иерихогоос хувцас хунар, мөнгө авсны улмаас тэрээр Их Эзэний дургүйцлийг Израил дээр авчирсан байна).
- Бидний хувийн нүглүүд бусад хүмүүст хэрхэн нөлөөлж болох тухайд Аханы нүглийн үр дагавар бидэнд юу сануулдаг вэ? Бидний юу хийх нь бидний өөрсдийн хэрэг бөгөөд өөр хэнд ч хор хөнөөлгүй гэж бодох нь хэрхэн төөрөгдөл байдаг вэ? (Нэг хүний үйл ажиллагаа бусдад хэрхэн нөлөөлж болох тухай жишээнүүдийг та ашиглахыг хүсч болно: Согтуу жолоочийн гаргасан ослын улмаас гэмтэж бэртсэн гэм буруугүй хүмүүсийн амьдралд нөлөөлж болно. Ням гарагийн Сургуулийн хичээл дээр үймүүлдэг хэн нэгэн, анхаарлаа төвлөрүүлж, Сүнсийг мэдрэхэд нь бусдад хүндрэл учруулдаг. Бэлгийн харилцааны нүгэл үйлддэг буюу Мэргэн Ухааны Үгээр амьдардаггүй хүн бусад хүмүүст сэтгэл санааны эмзэглэл, зовлон учруулдаг. Итгэлтэй бус эхнэр буюу нөхөр гэр бүлээ бусниулж, гэр бүлийнхээ гэм зэмгүй гишүүдэд сэтгэл санааны их эмзэглэл учруулж болно. Их Эзэнийг дагадаггүй Сүмийн хувь гишүүд Сүм нийтгээрээ Их Эзэний адислалуудыг хүлээн авахаас хойш татаж болно)

“Хувийн сонголтууд хувийнх биш байдаг; тэдгээр нь бүгдээрээ нийгмийн үр дагавруудтай байдаг. . . . Манай нийгэм бол сая сая хувь хүмүүс амьдралдаа хэрэгжүүлдэг зүйлийн нийлбэр дүн юм. Хувийн зан төлвийн энэхүү нийлбэр дүн бол дэлхий даяарх олон нийтийн үй түмэн чухал үр дагаврууд байдаг. Дан ганц хувийн сонголт гэж байдаггүй” гэж Ахлагч Жеймс Е. Фауст хэлжээ (Conference Report, 1987 оны 4-р сар, 101; *Ensign*, 1987 оны 5-р сар, 80).

3. Калев Хеброны нутгийг хүлээн авав

- Калев Иошуагаас Хеброны нутгийг хэрхэн хүлээн авсныг Иошуа 14-т өгүүлдэг. Калев яагаад Хеброны нутгийг хүлээн авсан бэ? (Иошуа 14:6–14-ийг үз. “Их Эзэнийг бүх зүрх сэтгэлээрээ дагасан” гэсэн өгүүлбэр шүлэг 8, 9, 14-т давтагдсаныг анхаар)

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл Калебыг бишрэн гайхдагаа нотолж, түүнээс бидний авч болох зарим сургамжийг санал болгосон байдаг:

“Калебын үлгэр жишээнээс бид маш чухал сургамжууд авч болно. Өөрийн өвийг хүлээж авахын тулд Калеб тэмцэл хийж, үнэнч, итгэлтэй хэвээр үлдсэн шиг, Их Эзэн өөрийн хаант улсад бидэнд байр амласан болохоор, бид энэхүү шагналыг хүлээн авахуйц зохистой байхын тулд, бид цаг ямагт, бас итгэл бишрэлтэйгээр хичээн зүтгэх ёстой.

“Калеб хүсэлт болон сорилтыг агуулсан сэтгэл хөдөлгөсөн тунхаглал хийсэн нь зүрх сэтгэлийг минь талархлаар дүүргэдэг билээ. Анакимчууд, аварга биет хүмүүс амлагдсан нутагт оршин суусан хэвээр байсан бөгөөд тэднийг ялах хэрэгтэй байлаа. 85 нас хүрсэн Калеб, ‘Энэ уулыг надад өгөөч’ хэмээн хэлжээ (Иошуа 14:12).

“Энэ бол энэ үе дэх ажлын тухай миний бодрол. Бидний өмнө шийдвэрлэх ёстой агуу сорилтууд, үлэмж их боломжууд байна. Энэхүү сэтгэл татам хэтийн төлөвт би баяртай байж, ‘Энэ уулыг надад өгөөч,’ эдгээр сорилтуудыг надад өгөөч” хэмээн Их Эзэнд даруухнаар хэлмээр байна (Conference Report, 1979 оны 10-р сар, 115; *Ensign*, 1979 оны 11-р сар, 79).

4. “Хэнд үйлчлэхээ та нар өнөөдөр сонго”

Хэрэв *Хуучин Гэрээний Видео Танилцуулгууд* (53224) байдаг бол, өлсөж цангасан үедээ нэгэн араб азарга дуулгавартай байсан сорилтын тухай, “Хэнд үйлчлэхээ та нар өнөөдөр сонго” гэсэн зургаан минутын бичлэгийг үзүүлэхийг та хүсч болно.

Зорилго Сорилт бэрхшээл учруулагч дэлхийд сайн мэдээгээр амьдрахад нь тэднийг хүчирхэгжүүлэх нөлөөнүүдийг эрж хайхад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмжих.

- Бэлтгэл**
1. Дараах судруудыг залбирч судал:
 - а. Шүүгчид 2:6–23. Израилын хүүхдүүдийн өсвөр үеийнхэн Их Эзэнийг орхиж, эргэн тойрныхоо хүмүүсийн бурхдад үйлчилдэг болоход урвалтын мөчлөг үе эхэлсэн ажээ.
 - б. Шүүгчид 4:1–16. Изриалыг Канааны хаан Иабинаас чөлөөлөхийг Баракт зарлиглажээ (4:1–7). Хэрэв Дебора түүнтэй хамт явах юм бол тэрээр явахыг зөвшөөрөв (4:8–9). Дебора, Барак хоёр Израилыг канаанчуудаас чөлөөлөв (4:10–16).
 - в. Шүүгчид 6–7. Израилыг мидианчуудаас чөлөөлөхийг Гидеонд зарлиглав (6:1–24). Тэр болон бусад 10 хүн Баалын тахилын ширээг шөнөөр устгав (6:25–35). Их Эзэн Гидеонд хоёр тэмдэг соёрхсноор түүнд тусламж үзүүлэх болов (6:36–40). Гидеон болон бусад 300 эрчүүд Израилыг мидианчуудаас чөлөөлөв (7:1–25).
 - г. Шүүгчид 13–16. Түүнийг назир хүн болгон өсгөхийг тэнгэр элч Самсоны эцэг эхчүүдэд зааварлав (13:1–25). Самсон агуу эр зориг самбаа, хүч чадлаар үйлдсэн боловч назир хүний олон тангаргаа зөрчжээ (14–15). Самсон Делилагийн уруу таталтад автагдаж, үсээ хайчлуулан, тэгснээр тэр сул дорой болов; тэр филистинчүүдэд олзлогдож, тэдний ариун сүм нураахад алагджээ (16:1–31).
 2. Нэмэлт уншлага: Судруудын Удирдамж “Шүүгчид”, “Шүүгчдийн Ном”
 3. Та энэ хичээл дэх судрын нэг буюу түүнээс дээш шастирын хураангуйлсан нэгтгэн дүгнэлт гаргахыг ангийн гишүүдээс хүсч болно.


**Энэ хичээлийг
заах зөвлөмж**

Анхаарал
төвлөрүүлэх
үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагааг (эсвэл өөрийхөө нэг үйл ажиллагааг) ашиглахыг хүсч болно.

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хашаандаа нэг зулзган мод тариад, үүнийг шулуун ургуулахын тулд тулгууруудыг ашиглахыг хайхраагүй тухай өгүүлсэн байдаг. Хэсэг хугацааны дараа салхи модыг нэг тал руу нь бөхийлгөчихөв. Хэрэв тэрээр модыг тулгууруудад бэхэлж уясан бол, мод салхины хүчийг тэсэн даах болтлоо тулгууруудад бэхлэгдэх байсныг Ерөнхийлөгч Хинкли мэдсэн ажээ. (Conference Report, 1993 оны 10-р сар, 77–78; *Ensign*, 1993 оны 11-р сар, 59)

Зарим үед бид тэр зулзган мод шиг салхийг (Сатаны уруу таталтууд) өөрсдөө сөрөн зогсох чадваргүй байж болно гэдгийг тайлбарла. Шүүгчдийн номонд биднийг тулж чадах зарим “тулгуурын” тухай бид мэдэж болно. Дөрвөн тулгуурт бэхлэн уясан зулзган модыг самбар дээр зур. Энэ хичээл дэх судрын дөрвөн шастирыг дараалан үзэхдээ тулгуур тус бүрийг доорх байдлаар нэрлэ:



Судрын ярилцлага
ба хэрэглээ

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагауудаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

Иошуагаар удирдуулсан израилчууд амлагдсан нутгаас ихийг байлдан эзэлжээ. Иошуаг нас барсны дараа бошиглогч Самуел болон Хаан Саулын үеийг хүртэл нэг удирдагчийн гарт нэгдсэнгүй. Энэ хугацаанд, 12 шүүгч Израилын захирагчид болон цэргийн удирдагчдаар үйлчилж байв. Тэдний засаглалын ихэнх нь урвалт, боолчлол, наманчлал түүнчлэн олон удаагийн чөлөөлөлтөөс үүдэн Израилын хувьд эмгэнэлт үе болсон ажээ.


Энэ түүхийн эмгэнэлт хэсгүүдийг нөхсөн зүйл гэвэл урвагч дэлхийд хэрхэн итгэл бишрэл, эр зоригтой байхын хүчтэй үлгэр жишээг үзүүлж, үнэнч хэвээр үлдсэн хүмүүсийн түүхүүд юм. Дебора Гидеон хоёр бол Израилыг чөлөөлөхийн тулд Их Эзэн өсгөн бойжуулсан зөв шударга удирдагчид юм. Деборагийн итгэл бол ихэнхдээ Израилыг Канааны цэргээс чөлөөлөхийн төлөөх хариуцлага байлаа. Гидеон Их Эзэнд итгэл найдвар тавьдаг байсан 300 хүнтэй түүний цэрэг мидианчуудыг гайхамшигтайгаар бут ниргэх боломжийг олгосон юм.

1. Зөв шударга эцэг эхчүүдийн хүч чадал ба тэдний арга замуудыг мартагчдын хор уршиг

Шүүгчид 2:6–23-ыг зааж, ярилц.

- Шүүгчдийн номонд Израилын хүүхдүүд зөв шударга байдлын болон урвалтын хэд хэдэн мөчлөг үеийг туулжээ (89-р хуудсан дахь “Шүүгчдийн үе дэх Урвалтын мөчлөг үе” схем). Израилчуудын өсвөр үе урвалын мөчлөг үеийг хэрхэн эхэлсэн бэ? (Ялангуяа Шүүгчид 2:10, 12, 17, 20, 22-ыг үз. Эдгээр шүлгүүд дэх түлхүүр үгсийг ангийн гишүүдээр тэмдэглүүлэхийг хүс. Израилын хүүхдүүд Бурханыг орхиж, бас эцэг эхчүүдийнхээ замууд болон гэрээнүүдийг орхисныг тэмдэглэн хэл)

- Хүүхдүүд зарим үед яагаад эцэг эхчүүдийнхээ зөв шударга заадаг зүйлүүд болон арга замуудыг орхидог вэ? Эцэг эхчүүд хүүхдүүддээ итгэлтэй байхад нь хэрхэн тусалж чадах вэ? Таны эцэг эхчүүд буюу гэр бүлийн чинь бусад гишүүд зөв шударга амьдрахад чинь таныг хэрхэн хүчирхэгжүүлсэн бэ?
- Урвалтын эхэн үеийн шинж тэмдгүүдийг бид хэрхэн таньж болох вэ? Хувь хүн урвалтыг хэрхэн өөрчилж чадах вэ? Үнэнээс урваж магадгүй байгаа гэр бүлийн гишүүн буюу найздаа бид хэрхэн зохих ёсоор тусалж чадах вэ?



2. Дебора—зөв шударга найзын хүч чадал

Шүүгчид 4:1–16-гаас Дебора Барак хоёрын тухай түүхийг товчоор нэгтгэн дүгнэх буюу эсвэл даалгавар авсан ангийн нэг гишүүнээр үүнийг хийлгэ.

- Их Эзэн юу хийхийг Баракт зарлигласан бэ? (Шүүгчид 4:6–7-г үз) Энэ даалгаврын талаар Барак юу гэж бодсон бэ? Ямар нөхцөлд Барак Сисера болон түүний 900 морин тэрэгтний эсрэг тулалдахаар явахад бэлэн байсан бэ? (Шүүгчид 4:8-ыг үз) Яагаад Барак, хэрэв Дебора түүнтэй хамт явбал Сисератай тулалдахад бэлэн байсан гэж та нар боддог вэ?
- Деборагийн тухай та нарт ямар сэтгэгдэл төрдөг вэ? Баракт байгаагүй байж болох ямар шинж чанарууд тэр эмэгтэйд байсан бэ? (Шүүгчид 4:4–9, 14-ийг үз)
- Үнэнч анд найз байх талаар бид Деборагаас юу сурч болох вэ? (Бидний сурч болох нэг зүйл бол жинхэнэ найз нар Их Эзэнийг дуулгавартай дагахад бидэнд сүнслэгээр нөлөөлж, түүнчлэн зөвийг хийхэд бидэнд хүч чадал өгдөг.) Хүнд сорилтуудтай тулгарах буюу Их Эзэний зарлигуудыг дуулгавартай дагахад найз нар чинь та нарт хэрхэн тусалсан бэ? Бид бусдад хэрхэн илүү сайн найз нөхөд байж чадах вэ?

Найз нарынхаа нэрсийг бичиж (1) тэд өөрсдөө эдгээр найз нартаа Дебора шиг байдаг уу, (2) тэдгээр найз нар нь өөрсдөд нь Дебора шиг байдаг уу гэдгийг өөрсдөөсөө асуухыг ангийн гишүүдэд санал болго.

3. Гидеон—Бурханд итгэх итгэлийн хүч чадал

Шүүгчид 6–7-гоос Гидеоны тухай түүхийг товч нэгтгэн дүгнэх буюу эсвэл даалгавар авсан ангийн нэг гишүүнээр үүнийг хийлгэ.

- Их Эзэн юу хийхийг Гидеонд зарлигласан бэ? (Шүүгчид 6:14-ийг үз) Эхний удаа Гидеон юу гэж хариулсан бэ? (Шүүгчид 6:15-ыг үз)
- Их Эзэн Израилыг чөлөөлөхийг түүнд зарлигласнаа, түүнчлэн Өөрөө түүнтэй хамт байж, түүнд туслах болно гэдгийг Гидеонд хэрхэн итгүүлсэн бэ? (Шүүгчид 6:16–23, 36–40; 7:9–15-ыг үз)
- Израилыг чөлөөлөхийг Их Эзэн үнэхээр түүнд зарлигласанд Гидеон итгээд, тэрээр итгэлтэйгээр урагш одсон ажээ. Мидианчуудтай тулалдахын тулд 32,000 хүнтэй Гидеоны цэргийн тоог яагаад 300 хүртэл хорогдуулахыг Их Эзэн хүссэн бэ? (Шүүгчид 7:2-ыг үз. Израилчууд өөрсдийнхөө хүчинд бус, харин Түүнд итгэж, түүний хүчийг хүлээн зөвшөөрөхийг Их Эзэн хүсдэг байв.) Өнөөдөр Их Эзэн өөрт нь итгэж, өөрийнх нь хүчийг хүлээн зөвшөөрөхийг бидэнд хэрхэн заадаг вэ?
- Гидеон болон түүний 300 эрс мидианчуудтай тулгарахад юу тохиолдсон бэ? (Шүүгчид 7:16–23-ыг үз) Гидеон болон түүний хүмүүс яагаад, “Их Эзэний илд, Гидеоны илд” хэмээн хашгиралдаж байсан гэж та нар боддог вэ? (Шүүгчид 7:20-ийг үз. Их Эзэн өөрсөдтэй нь хамт байгааг Гидеон мэдэж— мөн түүний хүмүүс үүнийг мэдэхийг тэрээр хүсч байжээ.)
- Бид Гидеоноос юу сурч болох вэ? Их Эзэн та нараар хийлгэхийг хүссэн ямар нэг зүйл хүнд хэцүү байсан тохиолдолд Тэрээр та нарт хэрхэн тусалсан бэ? (Ангийн гишүүд туршлагаа хуваалцах үед, Их Эзэн бидэнд ямар нэг зүйл хийхийг зарлиглахдаа үүнийг хэрэгжүүлэхэд тэрээр бидэнд туслах болно гэдгийг гэрчил)

4. Самсон—гэрээнүүдийн хүч чадал мөн тэдгээрийг зөрчихийн үр дагаврууд

Шүүгчид 13–16-гаас Самсоны тухай түүхийг товч нэгтгэн дүгнэ, эсвэл даалгавар авсан ангийн нэг гишүүнээр үүнийг хийлгэ.

- Хүү хүссээр байсан Самсоны эх хүүтэй болно гэдгээ яаж мэдсэн бэ? (Шүүгчид 13:2–3-ыг үз) Түүний төрүүлэх хүүгийн талаар тэнгэр элч Самсоны эхэд юу гэж хэлсэн бэ? (Шүүгчид 13:4–5-ыг үз. Назирчууд өөрсдийгөө дэлхийн зүйлүүдээс тусгаарлаж, түүнд ариун болохын тулд Их Эзэнтэй гэрээ хийснийг тайлбарла. Назирчуудын тангараг Тооллого 6:2–6, 8-д дүрслэгдсэн байдаг.)
- Филистинчүүдээс Израилыг чөлөөлөх үүрэг зорилгоо хэрэгжүүлэхэд нь туслахын тулд Их Эзэн Самсонд ямар адислалууд өгсөн бэ? (Шүүгчид 13:24–25; 14:5–6, 19; 15:14–15-ыг үз. Их Эзэн түүнд бие бялдрын болон сүнсний хүч чадал өгсөн ажээ.)
- Самсон назир хүн болон Израилын удмын гишүүний хувьд Их Эзэнтэй гэрээ хийжээ. Гэвч тэрээр удалгүй назир хүний тангаргаа болон Израилын удмын гишүүний гэрээнүүдээ зөрчсөн байна. Тэр ямар тангаргууд болон гэрээнүүдийг зөрчсөн бэ? (Самсоны зөрчсөн зарим гэрээг дор жагсаав)
 - а. Тэрээр Израилын гэрээт удмаас гадуур гэрлэсэн байв (Шүүгчид 14:1–3).
 - б. Тэрээр янхан эмтэй ёс суртахуунгүй хэрэг үйлджээ (Шүүгчид 16:1).
 - в. Тэр үсээ хусуулав (Шүүгчид 16:4–20).

- Самсон гэрээнүүдээ зөрчсөний үр дагаврууд юу байсан бэ? (Шүүгчид 16:17–21-ийг үз. Тэрээр бие бялдрын болон сүнснийхээ хүчийг алдаж, филистинчүүд түүнийг сохлон, хүлсэн ажээ. Хэрэв шаардлагатай бол Самсоны үс түүний бие бялдрын хүч чадлын эх сурвалж байгаагүйг тайлбарла. Харин, түүний үс Их Эзэнтэй хийсэн гэрээнийх нь тэмдэг байв, иймээс түүний үсийг хусахад, гэрээ зөрчигдсөн учраас Их Эзэн түүний бие бялдрын хүчийг татан авсан ажээ.) Бид гэрээнүүдээ зөрчихөд юу тохиолддог вэ? Их Эзэнтэй хийсэн бидний гэрээнүүдэд ямар тэмдгүүд байдаг вэ?
- Их Эзэнтэй хийсэн бидний гэрээнүүд нь хүч чадал, удирдамж, шийдвэр төгс байдлын эх сурвалж байх ёстой. Бид Их Эзэнтэй ямар гэрээнүүд хийдэг вэ? Эдгээр гэрээнүүд та нарыг хэрхэн хүчирхэгжүүлсэн бэ? (Гэрээнүүд биднийг хүчирхэгжүүлдэг нэг хэлбэр бол биднийг харалган болгох буюу биднийг хүлдэг Сатаны хүч чармайлтуудыг эсэргүүцэхэд бидэнд тусалдаг явдал мөн.)
- Самсон агуу чадавхитай байв. Түүний төрөлтийг зарлан мэдэгдсэн тэнгэр элч, тэрээр филистинчүүдээс Израилыг чөлөөлж эхлэх болно гэж хэлжээ. Их Эзэн түүнийг олон бэлгээр, түүний дотор бие бялдрын агуу хүчээр адисалжээ. Дотоод сэтгэлийн ямар сул талууд түүнийг унахад хүргэсэн бэ? (Шүүгчид 15:7; 16:1; С ба Г 3:4-ийг үз. Хариултууд нь өөрийгөө өөгшүүлэн зоргоор нь тавьсан, ёс суртахуунгүй байдал, өс хонзон бодох, гэрээнүүдийг зөрчсөн нь байж болно.) Чадавхиа хэрэгжүүлэхээс биднийг хөндийрүүлдэг сул талуудаа бид хэрхэн даван туулж чадах вэ?

Дүгнэлт

Иошуагийн номонд израилчууд канаанчуудын эсрэг бие бялдрын олон тулалдаанд ялсныг тайлбарла. Гэвч, Шүүгчдийн номонд израилчууд, канаанчуудын дэлхийн дадал зуршил хийгээд хуурамч бурхдаар нөлөөлөгдөхөд өөрсдийгөө тавьж өгснөөр сүнсний тулалдаануудад ялагдаж эхэлсэн байлаа. Үүнтэй төстэй сүнсний тулалдаануудтай бид тулгардаг. (1) Бид зөв шударга эцэг эхчүүд болон өвөг дээдсийнхээ замуудыг дагаж, (2) сайн найз нартай байж, (3) Их Эзэнд итгэх итгэлээ өсгөн нэмэгдүүлж, (4) гэрээнүүдээ сахих юм бол бид эдгээр тулалдаануудад амжилт олж чадна гэдгийг гэрчил.

Нэмэлт заах санаанууд

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

1. Хүүхдүүдийн дэлхийн шинж чанарт эцэг эхчүүдийн оруулдаг хувь нэмэр (Шүүгчид 1:28)

- Итгэлтэй хэвээр үлдэх тухайд израилчуудын өсвөр үе бүтэлгүйтсэн нь бүхэлдээ тэдний буруу биш байлаа. Шүүгчид 1:21, 27–33 болон 2:1–4-д өгүүлснээр, хүүхдүүдийн бүтэлгүйтлийн үндэс суурь нь хэрхэн тавигдсан бэ? (Энэ нь канаанчуудыг хөөн гаргах талаарх эцэг эхчүүдийнх нь бүтэлгүйтлээр тавигдсан ажээ. Хэдийгээр эцэг эхчүүд өөрсдийнх нь эргэн тойрон дахь дэлхийн нөлөөнүүдийг эсэргүүцэх хангалттай хүчирхэг байсан ч, хүүхдүүд нь тийм байсангүй.)

- Өнөөдөр зарим эцэг эхчүүд хэрхэн хүүхдүүдээ нөлөөнүүдэд тавьж өгөн, израилчуудын “өсвөр үеийнхний” эцэг эхчүүдийнхтэй адил алдаа гаргадаг вэ? (Тодорхой жишээн дээрх хариултуудыг урамшуулан дэмж)

2. Манай өнөө үе дэх гайхамшгууд

- Их Эзэн өөрсдийнх нь үеийг бодвол өмнөх үеийнхэнд илүү олон гайхамшгийг үйлддэг байсан хэмээн яагаад зарим хүмүүс Гидеоны нэгэн адил боддог вэ? (Шүүгчид 6:13-ыг үз) Гайхамшгуудыг үйлдэхэд бидний үүрэг юу вэ? (Моронай 7:35–38-ыг үз) Өнөө үед Бурхан гайхамшиг үйлдэхээ үргэлжлүүлж байгааг та нар яаж мэддэг вэ? Бидний амьдрал дахь энгийн жижиг гайхамшгуудыг бид хэрхэн илүү сайнаар танин мэдэж чадах вэ?

3. “Израил миний эсрэг өөрсдөөрөө бардамнахгүйн тулд” (Шүүгчид 7:2)

- Мидианчуудтай тулгарахаас өмнө цэргийнхээ ихэнх хэсгийг гэр рүү нь явуулахыг Их Эзэн яагаад Гидеонд зарлигласан бэ? (Шүүгчид 7:2-ыг үз) Өнөөдөр бидний зарим нь хэрхэн “[өөрсдөөрөө] бардамнадаг вэ”? (Бидний адислалууд хийгээд хүч чадал Их Эзэнээс ирдгийг хүлээн зөвшөөрөхийн оронд бидний зарим нь өөрсдөдөө байгаа бүхнийг өөрсдийнхөө хүч чармайлтаар олж авсан гэж гэж мэдэгддэг) Энэ асуудлыг бид хэрхэн даван туулж чадах вэ?

4. Уруу таталтыг эсэргүүцэх нь

- Делила түүнээс гурван удаа урван тэрслэх гэж оролдсоныг Самсон мэдсээр байж, яагаад өөрийн хүч чадлын нууцыг түүнд ярьсан бэ? (Шүүгчид 16:15–1-г үз) Делилад өгсөн Самсоны хариултуудыг Потифарын эхнэрт өгсөн Иосефын хариултуудад сөргүүлэн тавь (Эхлэл 39:7–12). Байнгын уруу таталтуудыг бид хэрхэн эсэргүүцэх буюу даван туулж чадах вэ?

“Хотын бүх хүмүүс . . . чамайг онцгой сайн эмэгтэй гэдгийг мэднэ”

Рут; 1 Самуел 1

Зорилго

Рут, Наоми, Ханна нарын зөв шударга чанаруудыг дуурайхад ангийн гишүүдийг урамшуулан дэмжих.

Бэлтгэл

1. Дараах судруудыг залбирч судал:
 - а. Рут 1–2. Рут нөхрөө нас барсны дараа хадам эх Наомитай хамт Бетлехем уруу явахаар гэр орноо орхидог. Бетлехемд Рут өөрт нь найрсгаар хандсан Боазын талбайд ажилладаг.
 - б. Рут 3–4. Рут Боазын хөлд хэвтэхэд тэрээр түүнтэй гэрлэхийг амлав. Тэд гэрлэж, хүүхэдтэй болов. Тэдний үр удмын дотор Хаан Давид, Есүс Христ хоёр ордог.
 - в. 1 Самуел 1; 2:1–2, 20–21. Ханна хүүгээр адислагдаж, тэрээр амласан ёсоороо түүнийг Их Эзэн рүү илгээв. Тэр эмэгтэй хожим нь бүр олон хүүхдээр адислагдсан ажээ.
 2. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашиглах бол, ангийн гишүүн бүрийн тоогоор хэсэг цаас, харандаа буюу үзэг авчир.
 3. Хэрэв Хуучин Гэрээний Видео Танилцуулгууд (53224) байдаг бол, та “Ханнагийн итгэл” гурван минутын бичлэгийг хичээлийн нэг хэсэг болгон үзүүлж болно.
-

**Энэ хичээлийг
заах зөвлөмж**

Анхаарал
төвлөрүүлэх
үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагааг (эсвэл өөрийхөө нэг үйл ажиллагааг) ашиглахыг хүсч болно.

Ангийн гишүүн бүрд хэсэг цаас, үзэг буюу харандаа өг.

Рутын ном богинохон боловч, энэ нь Рут зөв шударга эмэгтэй байсныг тодорхой харуулдгийг тайлбарла. Тэгээд дараах асуултуудыг асууж, хариултуудыг ангийн гишүүн бүрд тарааж өгсөн цаасан дээр нь бичүүл:

- Хэрэв таны зан төлвийг хэдхэн үгээр дүрслэх юм бол, эдгээр үгс нь ямар үгс байхыг та хүсэх вэ? Энэ долоо хоногт таны хийж чадах, уг дүрслэлд тохирох нэг зүйл юу вэ?

Энэ хичээлээр Рут болон өөр хоёр эмэгтэй Наоми, Ханна нарын зөв шударга чанаруудыг ярилцах болно гэдгийг тайлбарла.

Судрын ярилцлага
ба хэрэглээ

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагаадаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Рут Наомитай хамт Бетлехем рүү явахын тулд гэр орноо орхив.

Рут 1–2-ыг зааж, ярилц.

- Наоми болон түүний гэр бүл яагаад Моабд амьдрахаар тийшээ явсан бэ? (Рут 1:1–2-ыг үз) Яагаад Наоми нөхөр, хөвгүүдээ нас барсны дараа Бетлехем рүү буцсан бэ? (Рут 1:6-г үз. Бетлехем түүний төрсөн нутаг бөгөөд тэнд өлсгөлөн зогссон байлаа.)
- Наоми Моабд амьдарч байхдаа Наомигийн хөвгүүд Моабын эмэгтэйчүүд асан Орпа, Рут нартай гэрлэжээ (Рут 1:4). Бэрүүд нь түүнтэй хамт Бетлехем рүү буцахыг санал болгоход Наоми тэднийг хайрладаг хайр, тэдний төлөө тавьдаг анхаарал халамжаа хэрхэн харуулсан бэ? (Рут 1:7–13-ыг үз) Бидний гэр бүлийн харилцаанд тусалж чадах, бэрүүдийнхээ төлөө тавьдаг Наомигийн анхаарал халамжаас бид юу сурч болох вэ?
- Наомигийн бэрүүдийн нэг Орпа төрхөмдөө буцсан боловч, нөгөө бэр Рут Наомитай хамт Бетлехем рүү явахыг шаргуу хүссээр байв. Рут 1:16–17-д Наомид өгсөн амлалтаас нь бид Рутын тухай юу мэдэж болох вэ? (Тэр бол хайраар дүүрэн, үнэнч мөн золиослол хийх хүсэлтэй эмэгтэй байв.) Бид гэрийнхэндээ туйлын үнэнч гэдгээ хэрхэн харуулж болох вэ? Рутынх шиг амь бие хайргүй чанарыг бид хэрхэн харуулж чадах вэ?
- Наомитай хамт Бетлехем рүү явснаараа Рут юугаа орхисон бэ? (Хариултууд нь эх нутаг, гэр бүл, найз нөхөд, шашин шүтлэг нь байж болно.) Наомитай хамт явснаараа Рут юу олж авсан бэ? (Есүс Христийн сайн мэдээ; нэг дэх нэмэлт заах санааг үз) Сайн мэдээний төлөө золиослол хийх талаар бид Рутээс юу сурч болох вэ?
- Рут Бетлехем рүү явсныхаа дараа өөрийгөө болон Наомиг хүнсээр хангахын тулд юу хийсэн бэ? (Рут 2:2-ыг үз. Тариа түүгч гэдэг бол ургац хураалтын дараа талбай дээр хаягдсан тариан түрүүг түүж, хадгалах зөвшөөрөл олгогдсон хүн гэдгийг та тайлбарлах хэрэгтэй байж болно.) Хэний талбайд Рут тариан түрүү түүж байсан бэ? (Рут 2:1, 3-ыг үз) Рут юуны учир Боазын сэтгэлийг татсан бэ? (Рут 2:5–7, 11-ийг үз. Рут шаргуу ажиллагч болохыг Боаз харжээ. Наомийн төлөө Рут бүхнийг хийснийг тэр бас мэдэж байв.) Боаз Рутэд хэрхэн нинжин сэтгэлээ харуулсан бэ? (Рут 2:8–9, 14–16-г үз)
- Тариан түрүү түүгээд буцаж ирэхдээ Рут амин хувиа хичээдэггүй чанараа хэрхэн харуулсан бэ? (Рут 2:14, 17–18-ыг үз. Рут гэртээ түүсэн тариан түрүүгээ Наомид авчирч, бас үдийнхээ хоолноос илүүчилсэн хэсэг хоолыг Наомид авчирч өгчээ.) Бусад хүмүүсийн амин хувиа хичээдэггүй чанараар та нар хэрхэн адислагдсан бэ?

2. Рут Боаз хоёр гэрлэж, хүүхэдтэй болов.

Рут 3–4-ийг зааж, ярилц.

- Рут Боаз хоёрын гэрлэлтэд нөлөөлж болно гэж өөрийн бодсон нэг ёслолыг Рут гүйцэтгэхийг Наоми түүнд зөвлөсөн ажээ (Рут 3:1–5). Боазын хөлд хэвтсэнээр, үр дүнд нь Рут түүнтэй гэрлэх санаагаа ойлгуулж болох байсан аж. Наомигийн зөвлөгөөнд Рут дуулгавартай байсан нь Наомигийн талаарх түүний бодол санааны хувьд юуг илчилсэн бэ?

- Боаз сэрээд, Рут хөлийнх нь дэргэд хэвтэж байхыг хараад үүнд хэрхэн хариулсан бэ? (Рут 3:8–15-ыг үз. “Бүтээлгээ . . . шивэгчнийхээ дээгүүр дэлгээч” гэж Рут хэлсэн нь “намайг хамгаалаач, намайг өмгөөлөөч, надад анхаарал халамж тавиаач” гэсэн утгатай байсныг анхаар) Ямар нөхцөлийн дор Боаз Руттэй гэрлэхийг зөвшөөрсөн бэ? (Рут 3:11–13-ыг үз. Рутын нөхөр нас барахад, нөхрийнх нь ойрын хамаатан эрэгтэй Руттэй гэрлэх байх гэж бодож байсныг тайлбарла. Боаз ойрынх нь эрэгтэй хамаатан биш байсан бөгөөд хэрэв ойрын эрэгтэй хамаатан нь ийнхүү гэрлэхийг хүсэхгүй бол Руттэй гэрлэхийг тэрээр зөвшөөрчээ.)
- Бетлехемийн хүмүүсийн дунд Рутын нэр хүнд ямар байсан бэ? (Рут 3:1-ийг үз) Энэхүү нэр хүнд нь Боазтай харилцах түүний харилцаанд хэрхэн сайн нөлөөг өөрт нь үзүүлсэн бэ? Бид ямар үнэт зүйлст итгэж, эрхэмлэн дээдэлдгийг бидний гэр бүлийн гишүүд, найз нөхөд, хөршүүд мэддэг байх нь яагаад чухал вэ?
- Боаз Руттэй гэрлэхээр амласныхаа дараа юу хийсэн бэ? (Рут 3:15; 4:1–8-ыг үз) Тэрээр зарчимтай шударга эр хүн гэдгээ Боаз хэрхэн харуулсан бэ? (Рут 4:9–10, 13-ыг үз. Тэрээр Рутэд өгсөн амлалтаа биелүүлж, тэр эмэгтэйтэй хожуу гэрлэсэн нөхрийн үүрэгтээ хүндэтгэлтэй ханддаг байв.)
- Израилын ямар алдарт хаан Рут Боаз нарын үр удам байсан бэ? (Давид Хаан тэдний ачинцаруудын нэг байв; Рут 4:17, 21–22-ыг үз) Өөр хэн Рут, Боаз хоёрын үр удам байсан бэ? (Есүс Христ; Матай 1:5–16; Иохан 7:42-ыг үз)
- Ахлагч Томас С.Монсон Рутыг баатар эмэгтэй гэж нэрлэжээ (Conference Report, 1974 оны 10-р сар, 156; *Ensign*, 1974 оны 11-р сар, 108). Ямар талаараа Рут баатар эмэгтэй гэж та нар боддог вэ? (Рут бол үнэнч итгэл, шударга зангийн үлгэр жишээ мөн хэмээн Ахлагч Монсон хэлжээ. Рут бол баатар эмэгтэй гэдгийн нэмэлт жишээнүүдийг ангийн гишүүд гарган хэлж болно.)

3. Ханна хүүгээр адислагдаж, тэрээр амласнаараа түүнийг Их Эзэнд илгээв.

1 Самуел 1-ийг зааж, ярилц.

- Элкенагийн эхнэр Ханна хүүхэдгүй байв. Тэрээр жил бүр ариун сүм дээр уйлж, хүү хайрлаач хэмээн залбирдаг байжээ (1 Самуел 1:1–7). 1 Самуел 1:11-д Ханна Их Эзэнд ямар амлалт өгсөн бэ? Энэ амлалтаас бид Ханнагийн тухай юу мэдэж болох вэ? (Тэрээр агуу итгэл бишрэлтэй эмэгтэй байв; ангийн гишүүд нэмэлт хариултууд санал болгож болно.)
- Ханна ариун сүмд залбирч байхыг хэн гэрчилсэн бэ? (1 Самуел 1:9–12-ыг үз) Их Эзэнд өгсөн түүний амлалтын талаар Ели Ханнад юу ярьсан бэ? (1 Самуел 1:17) Елигийн үгсийг сонссоны дараа Ханнад хэрхэн санагдсан вэ? (1 Самуел 1:18-ыг үз) Бидэнд асуудал бэрхшээл тохиолдоход Сүмийн удирдагчид бидэнд хэрхэн тусалж чадах вэ?
- Тэрээр “ЭЗЭНий өмнө сэтгэлээ илчилсэнээ” Ханна Елид хэлжээ (1 Самуел 1:15). Бид хувийн залбирлуудаа хэрхэн илүү чин сэтгэлийн хийгээд утга учир дүүрэн болгож болох вэ?
- Их Эзэнд өгсөн Ханнагийн амлалтын хариуд юу тохиолдсон бэ? (1 Самуел 1:19–20 үз) Самуелыг төрсний дараа Ханна амлалтаа хэрхэн

биелүүлсэн бэ? (1 Самуел 1:21–28-ыг үз) Бид Их Эзэнд ямар амлалтууд хийдэг вэ? (Хариултууд нь баптисмаар болон ариун сүмд бидний хийдэг гэрээнүүд байж болно.) Эдгээр амлалтууддаа хичээнгүй байхад бидэнд туслах юуг бид Ханнагаас сурч болох вэ?

- Самуелыг Их Эзэний үйлчлэлд өгөх тухайд Ханна ямар бодолтой байсан гэж та нар боддог вэ? Түүнд бид юу өгөхийг Их Эзэн биднээс хүсдэг вэ? Түүнд өгөх бидний хандлага, бодол санаа ямар байх ёстой вэ? (Бидэнд байдаг юм болгон Их Эзэнээс ирдгийг санан, бид хүсэлтэйгээр өгөх ёстой.)
- Ханна Самуелыг ариун сүмд авчрахдаа, тэрээр өргөл өргөж, Их Эзэнд зориулан магтуу дуулжээ (1 Самуел 1:24–25, 28; 2:1–2-ыг үз). Их Эзэн бидэнд өгсөн адислалуудын төлөө Түүнд талархахаар дурсан санах нь яагаад чухал вэ?
- Ханна хүүхдүүдээр адислагдахаасаа өмнө олон жил хүлээжээ (1 Самуел 1:2; 2:21). Библийн өөр ямар хүмүүс Их Эзэнийг тэвчээртэйгээр хүлээсний эцэст адислагдсан бэ? Бид хүссэн зүйлээ хүлээж авах ёстой болоход дэлхий юу гэж хэлдэг вэ? Их Эзэн юу гэж хэлдэг вэ? Их Эзэний цагт ирэх адислалуудыг тэвчээртэйгээр хүлээхийг бид хэрхэн сурч болох вэ?

Дүгнэлт

- Рут, Наоми, Ханна нар зөв шударга ямар чанаруудыг үлгэр жишээ болгон харуулсан бэ? (Эдгээр чанаруудыг самбар дээр жагсаан бич)

Рут, Наоми, Ханна нарын харуулсан зөв шударга чанаруудыг дуурайхад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж. Эдгээр чанаруудыг хөгжүүлэх нь бидний Аврагч Есүс Христэд биднийг илүү ойр дотно болгоно гэдгийг гэрчил.

Нэмэлт заах санаанууд

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

1. Хөрвүүлэгдсэн Харийнханыг Абрахамын гэрээнд хүлээн авах нь

Рут төрөлтөөрөө израил хүн биш байсныг тайлбарла. Тэрээр Моабыг орхин, Наомитай хамт Бетлехем уруу явахдаа, бас өөрийнхөө шашныг орхиж, Израилын Бурханыг даган, “Таны Бурхан миний Бурхан [байх болно]” гэж Наомид хэлжээ (Рут 1:16). Рут Боазтай гэрлэснээр Израилын хааны удмын шугамын хэсэг, Давид Хаан болон Есүс Христийн өвөг дээдэс болжээ.

- Рутын хөрвүүлэг болон Израилын удамд түүнийг хүлээн авсан нь түүний сүмд нэгдэх хүмүүсийн талаарх Сүмийн хандлагыг хэрхэн тусгаж байна вэ? (2 Нифай 26:33; Алма 19:36; 3 Нифай 21:6-г үз) Шинэ хөрвөгчид Сүмд баяртай байхад нь бид хэрхэн тусалж чадах вэ?

2. Зохих ёсоор шүүх нь

- Санваартан Ели Ханнаг ариун сүмд залбирч байхыг нь хараад түүнийг буруугаар бодож, “тэр согтуу байна” гэж бодсон ажээ (1 Самуел 1:13). Зөвхөн гадаад төрх байдлаар нь хүмүүсийг шүүхийн хор уршиг юу вэ? Шүүлтийн энэ хэлбэрээс бид хэрхэн зайлсхийж болох вэ?

- “Хэрэв би алдаа гаргалаа гэхэд [хүмүүсийг шүүхэд] тэдний хувьд нигүүлслийн талд нь байхыг хүсдэг” гэж Ерөнхийлөгч Хью Б.Браун хэлжээ (Южин Е.Камбалл мөн Ричард Д.Пулл, *Hugh B. Brown: His Life and Thought* [1975], 225). Бид энэ зарчмыг хэрхэн хэрэглэж болох вэ?

3. Сэтгэлийн зовнил болон гай зовлонг ариун сүмд явснаар шийдвэрлэх нь

- Их Эзэнд өгсөн амлалтаа Ханна хаана хийсэн бэ? (1 Самуел 1:9–11-ийг үз) Ариун сүмд явах нь бидний сэтгэлийн зовнил, гай зовлонг шийдвэрлэхэд хэрхэн тусалж болох вэ?

“Өөрт нь сэтгэлийн зовнил хийгээд гай зовлонтой байгаа завгүй хүн . . . , үүнийгээ өөр хаанаас ч илүүгээр Их Эзэний өргөөнд илүү сайнаар, бас илүү түргэнээр шийдвэрлэж чадна. Хэрэв тэрээр ариун сүмийн ажлыг өөрийнхөө төлөө болон өөрийн нас барагсдын төлөө хийх юм бол, өмнө нь талийгаач болсон хүмүүсийн дээр тэрээр хүчирхэг адислал хүртээх болно, мөн . . . түүн дээр өөр дээр нь адислал ирэх болно, учир нь огт хүсэн хүлээгээгүй агшнууд, ариун сүм дотор буюу түүнээс гадуур илчлэлт буюу амьдралыг нь тавгүйтүүлдэг асуудлуудын шийдэл болон түүнд ирэх болно. Энэ бол ариун сүмд зохих ёсоор ордог хүмүүст ирдэг бэлэг мөн” гэж Ахлагч Жон А.Видцоу хэлжээ (Давид Б.Хайтаас иш татжээ, *Conference Report*, 1990 оны 10-р сар, 76; *Ensign*, 11-р сар, 1990, 61).

Өөрийг нь хүндэлдэг хүмүүсийг Бурхан хүндлэх болно

Хичээл
21

1 Самуел 2–3; 8

Зорилго

Их Эзэнийг өөрсдөөсөө, бусдаас эсвэл дэлхийгээс илүүгээр хүндэлж, баярлуулахаас ирдэг адислалуудыг ойлгоход нь ангийн гишүүдэд туслах.

Бэлтгэл

1. Дараах судруудыг залбирч судал:
 - 1 Самуел 2:12–17, 22–25. Елигийн хөвгүүд зөрчил гаргаж, тэгээд эцэг нь тэдэнд зөвлөв.
 - 1 Самуел 2:27–36; 3:12–14. Бурханы нэгэн хүн түүний гэр бүл дэх ёс бус байдлын үр дагавруудын тухай Елид сэрэмжлүүлэв.
 - 1 Самуел 3. Их Эзэн Самуелыг дуудахад, тэрээр хариулав.
 - 1 Самуел 8. Тэд “бүх үндэстнүүдтэй адил” байхын тулд израилчууд хааныг хүсч байв. Ийм сонголтын аюулын талаар Самуел тэдэнд сэрэмжлүүлэв.
2. Самуелын дуудлагын талаарх шастирыг нэгтгэн дүгнэж бэлтгэхийг та ангийн нэг гишүүнээс хүсч болно (1 Самуел 3), мөн хаан хүсэгч Израилын тухай шастирыг нэгтгэн дүгнэж бэлтгэхийг та ангийн өөр нэг гишүүнээс хүсч болно (1 Самуел 8).
3. Хэрэв та *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* (34285) товхимлыг энэ хичээл дээр ашиглахыг хүсвэл, нэг хувийг нь хичээл дээр авчир.
4. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашиглах бол, Аврагчийн зургийг (62572; Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 240) авчир. Хэрэв та зургуудыг самбар дээр тогтоох хэрэггүй гэж үзвэл, толь, бусад хүмүүсийг төлөөлөх ямар нэг зүйл, түүнчлэн дэлхийг төлөөлүүлэхийн тулд газрын зураг, бөмбөрцөг буюу эсвэл өөр зүйл авчир.
5. Хэрэв Их Эзэнээр Дуудагдсан Хөвгүүн Самуел гэдэг зураг байдаг бол, үүнийг та хичээлийн үеэр ашиглахыг хүсч болно (62498; Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 111).

Энэ хичээлийг заах зөвлөмж


Анхаарал
төвлөрүүлэх
үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагааг (эсвэл өөрийхөө нэг үйл ажиллагааг) ашиглахыг хүсч болно.

Хичээлийн өмнө Аврагчийн зургийг үзүүлээд, далдал. Хуудас 97 дээрх гурван зургийг самбар дээр тоймлон зурж, тэдгээрийг дээгүүр нь бүтээж далдал (эсвэл “Бэлтгэлд” жагсаасан гурван зүйлийг үзүүлж, дараа нь далдал). Бүтээж далдалсан юм бүр нь бидний хүндэлдэг хүнтэй, бид түүнийг баярлуулахыг хичээдэг тэр хүнтэй ямар нэг байдлаар холбогдоно гэдгийг тайлбарла.

- 1 Самуел 2:30-д өгүүлснээр, Их Эзэн хэнийг хүндэтгэх вэ?

Их Эзэнийг хүндэтгэснээр ирдэг адислалуудыг энэ хичээлээр ярилцах болно гэдгийг ангийн гишүүдэд хэл. Бүтээж далдалсан зүйлүүдийг хичээлтэй холбогдох үед нь та ил гаргах болно гэдгийг тайлбарла.



Судрын ярилцлага
ба хэрэглээ

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагауудаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Елигийн хөвгүүд Их Эзэнээс илүүгээр өөрсдийгөө хүндэтгэдэг.

1 Самуел 2:12–17, 22–25-ыг зааж, ярилц.

Дээд санваартан Елигийн хөвгүүд Хофни, Финехас хоёр өөрсдөө ч бас дээд санваартнууд байв. Гэвч тэд ёс бус байлаа. Израилчууд тахил өргөхөөр асарт хүрч ирэхэд Хофни, Финехас хоёр тахилд өргөх малын махны өөхтэй хэсгүүдийг тахилын ширээн дээр шатаахаас өмнө тахилын малын махыг хүч түрэн авсан ажээ. Тахил өргөгч тахилын зоогт зориулан чанаж байсан хэсэг махыг тэд бас авчээ (1 Самуел 2:12–17). Энэ бол Бурханы хуулиудыг ноцтойгоор зөрчсөн явдал, Бурханыг дээрэмдсэнтэй эн тэнцүү хэрэг байлаа. Елигийн хөвгүүд бас асрын хаалган дээр цугласан эмэгтэйчүүдэд сээтэн хаяж, үлэмж ноцтой нүгэл үйлдсэн ажээ (1 Самуел 2:22).

- Елигийн хөвгүүдийн үйлдлүүд Израил дахь бусад хүмүүст ямар нөлөө үзүүлсэн бэ? (1 Самуел 2:17, 24-ийг үз)
- Тэд хэнийг хүндлэхээр сонгох ёстой тухайд Елигийн хөвгүүдийн үйлдлүүд юу өгүүлж байна вэ? (Эхний бичээс буюу толийг ил гарга) Бид амьдралынхаа аль хэсэгт зарим үед Их Эзэнээс илүүгээр өөрсдийгөө хүндэтгэж, баярлуулдаг вэ? Ангийн гишүүд доорх зүйлүүдийг нэрлэж болно:
 - а. Зугаа цэнгэл
 - б. Хүндэтгэлийн өдрийг сахих
 - в. Болзоо ба ёс суртахуун
 - г. Мацаг барилт
 - д. Сүмийн дуудлагууд
- Бид заримдаа яагаад Бурханаас илүүгээр өөрсдийгөө баярлуулахаар сонгодог гэж та нар боддог вэ? Өөрсдийгөө Бурханаас илүү хүндлэхийн үр дагаврууд юу вэ?

2. Ели өөрийн хөвгүүдийг Их Эзэнээс илүү хүндэтгэдэг байв.

1 Самуел 2:27–36; 3:12–14-ыг зааж, ярилц.

- Хөвгүүдийнхээ ёс бусыг мэдсэн үед Елигийн үүрэг хариуцлага юу байсан бэ? Тэр юу хийсэн бэ? (1 Самуел 2:22–25-ыг үз) Тэд үүнд яаж хариулсан бэ? (1 Самуел 2:25-ыг үз)
- Ели хөвгүүддээ сануулга өгсний дараа гэр оронд нь байсан болон асар т үйлдсэн аймшигтай нүглүүдийг залруулахын тулд өөр юу ч хийсэнгүй. Үүний дүнд, Бурханы нэгэн хүн ирж, түүнийг буруушаан зэмлэж, тэрээр хөвгүүдээ Бурханаас илүү хүндэлснийг түүнд хэлжээ (1 Самуел 2:27–29). Ели ямар байдлаар өөрийн хөвгүүдийг Бурханаас илүү хүндэлсэн бэ? Елигийн гэрт юу тохиолдоно гэж Бурханы хүн хэлсэн бэ? (1 Самуел 2:30–35-ыг үз)
- Ямар байдлаар бид заримдаа бусад хүмүүсийг Бурханаас илүү хүндэлдэг вэ? (Хоёр дахь бичээс буюу бусад хүмүүсийг төлөөлсөн зүйлийг ил гарга) Ангийн гишүүд доорх зүйлүүдийг нэрлэж болох юм:
 - a. Бурууг нь бид өөрсдөө мэддэг ямар нэг зүйлийг үе чацуутнууд маань бидэнд ятгах боломжийг бид тэдэнд олгодог.
 - b. Бусад хүмүүс бидний талаар юу гэж бодох бол гэж айдгаас бид шударга бус зүйл хийдэг.
 - c. Бид гэр бүлийн гишүүд буюу найз нөхөдтэйгөө сайн харилцааг хэвээр хадгалахыг хүсдэг учраас тэдний хийдэг буруу зүйлийг засч залруулдаггүй.

“Биднээс нэг нь ч хүүхдүүдээ хайрлах хайрандаа ийм өнгөц төдий, ийм ухаалаг бус, ийм эрх зоргоороо, ийм бодлогогүй байх ёсгүй, ийм байснаар бид тэдний эрх зоргоороо байдал, буруу зүйл болон зөв шударга ёсны зүйлүүдээс илүү ихээр дэлхийн зүйлүүдийг хайрлах мунхаг хайранд нь хяналт тавьж зүрхэлдэггүй, учир нь тэднийг гомдоохоос айдаг” гэж Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит сургажээ (*Gospel Doctrine*, 5 дахь хэвлэл. [1939], 286).

- Эрх зоргоороо хүүхдүүдийг хайрын сүнсэнд хүмүүжүүлэхэд эцэг эхчүүд ямар үүрэг хариуцлагатай вэ? Эцэг эхчүүд нь тэднийг зөв шударга ёсонд хөтлөхийг хичээн чармайж байгаа үед хүүхдүүд ямар үүрэг хариуцлагатай байх вэ?

3. Самуел Их Эзэнийг хүндэлдэг байв

1 Самуел 3-ыг зааж, ярилц. Та энэ бүлгийг даалгавар авсан ангийн нэг гишүүнээр товчхон нэгтгэн дүгнүүлж болно. Түүний ээж Ханна амласан ёсоороо өөрийг нь Их Эзэний үйлчлэлд өгсний дараа Самуел хөвгүүн ариун сүмд үйлчилж байсныг ангийн гишүүдэд сануул (1 Самуел 1).

- Хэн шөнөөр Самуелтай ярьсан бэ? (1 Самуел 3:4-ийг үз). Самуел эхлээд хэн өөрийг нь дуудсан гэж бодсон бэ? (1 Самуел 3:5–6, 8-ыг үз) Их Эзэн дуудсаныг Самуел яаж мэдсэн бэ? (1 Самуел 3:8–9-ийг үз)
- Их Эзэн бидэнтэй яаж харилцдаг вэ? (Тэрээр ихэнх тохиолдолд Ариун Сүнсний шивнээгээр дамжуулан харилцдаг. Тэрээр бидэнтэй харилцдаг өөр замуудын талаар ангийн гишүүд саналаа хэлж болно.) Их Эзэний харилцааг хүлээн авч ойлгоход бид өөрсдийгөө яаж бэлтгэж болох вэ?

- Самуел ямар замаар Их Эзэнийг хүндэлдэг байсан бэ? (Их Эзэний зургийг ил гарга) Та ярилцлагадаа дараах судрын хэсгүүдийг ашиглаж болно:
 “Миний сэтгэлд байгаа зүйлүүдийн дагуу үйлдэх итгэлтэй санваартныг би өөрийнхөө төлөө өсгөн бойжуулна.” (1 Самуел 2:35-ыг үз)
 “ЭЗЭН Самуелыг дуудахад, би энд байна гэж тэр хариулав.” (1 Самуел 3:4)
 “Тэгэхэд Самуел хариулсан нь, Айлдаж хайрла; зарц чинь сонсож байна.” (1 Самуел 3:10)
- Их Эзэн өөрийг нь хүндэлдэг хүмүүсийг хүндэтгэхээ амлав (1 Самуел 2:30). Их Эзэн Самуелыг хэрхэн хүндэтгэдэг байсан бэ? (1 Самуел 3:19-ийг үз)
 Хэрэв бид Самуелын нэгэн адил түүнийг хүндлэх юм бол Их Эзэн биднийг хэрхэн хүндэтгэнэ гэж та нар боддог вэ?

4. Израилчууд дэлхийг хүндэтгэдэг байв.

1 Самуел 8-ыг зааж, ярилц. Энэ хэсгийг товчхон нэгтгэн дүгнүүлэхийн тулд та ангийн нэг гишүүнийг томилж болно.

- Самуелын тохинууллын үед Израил засаглалын ямар хэлбэртэй байсан бэ? (1 Самуел 8:1-ийг үз. Израилчууд шүүгчдээр удирдуулж байв.) Израилчууд хэнийг өөрсдийн хаан гэж бодож байсан бэ? (1 Самуел 12:12-ыг үз)
- Яагаад Израилын хүүхдүүд хааныг хүсэх болсон бэ? (1 Самуел 8:5, 20-ийг үз). “Бүх үндэстнүүдтэй адил” хааныг хүссэнээр Израил хэнийг няцаасан бэ? (1 Самуел 8:7-г үз) Хаантай байх асуудлын талаар юу хэлэх ёстойг Их Эзэн Самуелд зааварласан бэ? (1 Самуел 8:9–18-ыг үз) Самуелын сэрэмжлүүлгүүдэд израилчууд хэрхэн хариулсан бэ? (1 Самуел 8:19–22-ыг үз)
- Хааныг хүссэнээр Израил хэнийг хүндэтгэсэн бэ? (Гурав дахь бичээсийг буюу дэлхийг төлөөлсөн зүйлийг ил гарга)
- Бид зарим үед ямар талаараа “бүх үндэстнүүдтэй адил” байхыг хүсдэг вэ? (1 Самуел 8:5-ыг үз)

Дэлхийн ёс бус арга замуудад оролцохгүйн тулд, бидэнд зориулан бий болгосон Их Эзэний жишгүүдийг ярилцахын тулд та *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* (34285) товхимлыг ашиглахыг хүсч болно. Эдгээр жишгүүд насанд хүрэгчдэд мөн түүнчлэн залуучуудад ч хамаатайг тайлбарла.

- Их Эзэн Есүс Христ израилчуудын үнэн хаан байсан лугаа адил бидний үнэн хаан мөн. (Дуулал 47:7; 89:18; 149:2) Энэ мэдлэг дэлхийн арга замуудад хандах бидний хандлагад хэрхэн нөлөөлөх ёстой вэ? Бид зарим үед Их Эзэнийг өөрсдийнхөө хааны хувьд хэрхэн эсэргүүцдэг вэ?

Дүгнэлт

Хичээл эхлэх үед үзүүлсэн дөрвөн зүйлд анхаарал хандуул. Бид бүгд хэнийг хүндэтгэхээ өдөр бүр сонгож байх ёстойг тайлбарла. Та Их Эзэнийг хүндэтгэсэнээр хүлээж авсан адислалууд хийгээд баяр баясгалангийнхаа тухай гэрчлэлээ хэл. Өөрсдийнхөө туршлагууд буюу гэрчлэлүүдийг хуваалцахад ангийн гишүүдийг урь.

Нэмэлт заах санаанууд

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

1. Бидний сонгодог зүйлүүдийн үнэ цэнэ

- Заримдаа бид их үнэ цэнэтэй зүйлүүдийг бага үнэ цэнэтэй зүйлүүдээр сольдог. Ели болон түүний хөвгүүд сонголтынхоо улмаас юуг орхисон бэ? Хэрэв тэд хааныг хүсэх юм бол тэд ямар зүйлүүдийг орхих болно гэж Самуел израилчуудад хэлсэн бэ? (1 Самуел 8:11–17-г үз) Их үнэ цэнэтэй ямар зүйлүүдийг бид зарим үед бүр бага үнэ цэнэтэй зүйлүүдийн төлөө орхидог вэ?

2. “Их Эзэн дуудсан хүнээ, Их Эзэн тэнцэхээр болгодог”

Өөрийг нь хүндэтгэдэг хүмүүсийг Их Эзэн хэрхэн хүндэтгэдгийг харуулахын тулд Ерөнхийлөгч Томас С.Монсон дараах мэдэгдлийг хийжээ:

“Та нарын зарим нь төрөлхийн ичимхий буюу эсвэл дуудлагыг гүйцэтгэх буюу үүнд үйлчлэхэд ‘за’ гэж хариулахад өөрсдийгөө тохирохгүй гэж үздэг байж болох юм. Энэ ажил бол та нарынх биш, харин минийх гэдгийг санагтун. Энэ бол Их Эзэний ажил бөгөөд бид Их Эзэний зараалд байгаа үед бид Их Эзэний тусламжийг авах эрхтэй байдаг. Их Эзэн дуудсан хүнээ Их Эзэн тэнцэхээр болгогдгийг санагтун.” (Conference Report, 1996 оны 4-р сар, 62; *Ensign*, 1996 оны 5-р сар, 44)

Тэгэхэд Ерөнхийлөгч Монсон дараах түүхийг ярьсан юм:

“Хэрэв бид аль нэг ажил үүргийг хэтэрхий хүнд буюу хэтэрхий их цаг шаарддаг гэж боддог бол, тухайн үедээ Зүүн Германд болж өнгөрсөн нэг үйл явдал—итгэлтэй нэгэн гэрийн багш болон түүний хамтрагч нарын туршлагыг та бүгдтэй хуваалцахыг надад зөвшөөрнө үү.

“Жоанн Денндорфер ах Германд хөрвүүлэгдсэн бөгөөд, Дэлхийн II Дайны дараа тэрээр чухамдаа өөрийнхөө төрөлх нутаг—Унгарын Дебресен хотод хоригдол болчихсон байжээ. Тэрээр ариун сүмд орохыг мөн ч их хүсч байжээ! Тэрээр сүнсний адислалуудыг хүлээн авахыг мөн ч их хүсч байлаа! Швейцарь дахь ариун сүм рүү явах хүсэлт бүрийг нь дараа дараалан зөвшөөрсөнгүй, ингээд бараг л цөхрөнгөө бараад байв. Тэгтэл нэг гэрийн багш хүрч ирэв. Волтер Крауз ах Германы зүүн хойд хэсгээс Унгар хүрэх бүх замыг туулжээ. Тэрээр гэрийн багшийн хамтрагчдаа, ‘Та энэ долоо хоногт надтай хамт гэрийн багшийн ажлаар явахгүй юү?’ гэж хэлсэн гэнэ.

“Бид хэзээ гарах вэ?” гэж хамтрагч нь асууж.

“Маргааш” гэж Крауз ах хариулав.

“Бид хэзээ эргэж ирэх вэ?” гэж хамтрагч нь асууж.

“Өө, долоо хоног орчмын дараа—хэрэв бид эргэж ирвэл шүү дээ!

“Ингээд тэд Денндорфер ахтай уулзахаар алсын замд гарчээ. Дайны өмнөх үеэс хойш түүн дээр гэрийн багш нар ирсэнгүй. Эдүгээ тэрээр Их Эзэний үйлчлэгчдийг хараад, сэтгэл нь ихэд догдолжээ. Тэрээр тэдэнтэй гар

барьсангүй; харин, унтлагынхаа өрөөнд орж, Сүмийн гишүүн болсон өдрөөс хойш мөн Унгарт эргэж ирснээс хойш хураан хадгалсан аравныхаа нэгийг нууц газраас гарган авчирсан аж. Тэрээр аравны нэгээ гэрийн багш нартаа гардуулж өгөөд: ‘Одоо би Их Эзэнтэй хамт байх боллоо. Одоо л би Их Эзэний үйлчлэгчидтэй гар барихуйц зохистой боллоо гэж бодож байна!’ гэж хэлжээ.

“Швейцарь дахь ариун сүмд орох хүслийнх нь талаар Крауз ах түүнээс асуув. ‘Хэрэггүй дээ. Би олон удаа хүссэн. Засгийн газар тэр ч байтугай, миний хамгийн үнэтэй баялаг—Сүмийн номнуудыг минь хурааж авсан’ гэж Денндорфер ах хэлэв.

“Патриарх Крауз ах Денндорфер ахад патриархын адислал өгсөн аж. Тэрээр адислалыг дуусгах үед ‘Швейцар руу явах талаараа засгийн газарт дахин ханд л даа’ гэж Денндорфер ахад хэлэв. Тэгээд Денндорфер ах хүсэлтээ эрх баригчдад дахин өргөн барьсан аж. Энэ удаад зөвшөөрөл ирж, тэгээд Денндорфер ах Швейцарийн ариун сүмд явж, тэнд сар болжээ. Тэрээр өөрийнхөө ариун сүмийн хишгийг хүртэж, нас барсан эхнэртэйгээ лацдан холбуулж, мөн өөрийн өвөг дээдэс хэдэн зуун хүний өмнөөс уг ажлыг гүйцэтгэх боломжтой болсон ажээ. Тэрээр бие сэтгэлээрээ шинэчлэгдэн гэртээ эргэж иржээ.” (Conference Report, 1996 оны 4-р сар, 64–65; *Ensign*, 1996 оны 5-р сар, 45–46)

1 Самуел 9–11; 13; 15–17

Зорилго Өөрсдийнхөө хувийн ойлголтонд биш, Их Эзэнд итгэхэд нь ангийн гишүүдийг урамшуулан дэмжих.

Бэлтгэл

1. Дараах судруудыг залбирч судал:
 - а. 1 Самуел 9–11. Саул бошиглогч Самуелаас удирдамж эрэлхийлэв (9:1–14, 18–24). Саул хаан байх болно гэж Их Эзэн Самуелд илчлэв (9:15–17). Самуел Саулд зөвлөгөө өгч, түүнийг Израилын анхны хаан болгон тослон адислав (9:25–27; 10:1–8). Саул сүнсний хувьд дахин төрж, тэгээд тэрээр бошиглов (10:9–13). Самуел Саулыг хүмүүст танилцуулав (10:17–27). Саул аммончуудтай хийсэн тулалдаанд Израилыг ялалтад хүргэв (11:1–11). Хүмүүсийг удирдах түүний чадварт эргэлзэж байсан хүмүүсийг шийтгэхээс тэрээр татгалзав (11:12–15).
 - б. 1 Самуел 13:1–14. Саул зохих эрх мэдэлгүйгээр шатаалт өргөл өргөв.
 - в. 1 Самуел 15. Амалекчууд болон тэдний бүх эзэмшлийг устгахаар Саул зарлиг буулгасан боловч, тэдний цөөхөн малыг тахилд өргөхийн тулд үлдээв (15:1–9). Саулыг хаан байхаас Их Эзэн татгалзахад, үүнийг дуулгавартай дагах нь тахилаас дээр гэдгийг Самуел Саулд хэлэв (15:10–35).
 - г. 1 Самуел 16. Саул хааныг залгамжлуулахын тулд залуу хоньчин хөвгүүн Давидыг Их Эзэн сонгов (16:1–13). Ариун Сүнс Саулаас зайлж, муу ёрын сүнс түүнийг эзэмдэв (16:14–16; муу ёрын сүнс Бурханаас *байгаагүйг* харуулахын тулд Иосеф Смитийн Орчуулга эдгээр шүлгүүдийг залруулсныг анхаар). Саул Давидыг өөртөө ятга тоглуулахаар мөн зэвсэг баригчаа болгохоор сонгов (16:17–23).
 - д. 1 Самуел 17. Давид Их Эзэний хүч чадлаар Голиатыг алав.
2. Нэмэлт уншлага: 1 Самуел 12; 14.
3. Их Эзэн Давидыг хаанаар сонгосон тухай шастирыг нэгтгэн дүгнэж бэлтгэхийг та ангийн нэг гишүүнээс (1 Самуел 16:1–13), мөн Давид Голиатыг алсан тухай шастирыг нэгтгэн дүгнэж бэлтгэхийг ангийн өөр нэг гишүүнээс хүсч болно (1 Самуел 17:1–54).
4. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх хоёр үйл ажиллагааг ашиглах бол, дараах судрыг самбар дээр буюу том цаасан дээр бич: “Бүх зүрхээрээ ЭЗЭНд итгэ: өөрийн ойлголтод бүү түшиглэ. Өөрийн бүх замаар түүнийг таньж мэд, тэгвэл тэр замыг чинь шулуун болгоно.” (Сургаалт Үгс 3:5–6) Хэрэв та анхаарал төвлөрүүлэх эхний үйл ажиллагааг ашиглах бол, ангийн гишүүдэд танил бус байж болох зарим үгсийг Судруудын Удирдамжаас сонгон авч самбар дээр буюу том цаасан дээр бич.
5. Хэрэв дараах үзүүлэнгүүд байдаг бол, та хичээлийнхээ хэсэг болгон тэдгээрийн заримыг ашиглаж болно:
 - а. “Их Эзэн . . . Намайг Чөлөөлөх Болно,” Давидын тухай дөрвөн минутын бичлэг, *Хуучин Гэрээний Видео Танилцуулгууд* (53224).
 - б. Давид Голиатыг алсан нь зураг (62073; Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 112).

Энэ хичээлийг заах зөвлөмж

Анхаарал
төвлөрүүлэх
үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагааг (эсвэл өөрийхөө нэг үйл ажиллагааг) ашиглахыг хүсч болно. Ангийн хувьд хамгийн тохиромжтой үйл ажиллагааг сонгож ав.

1. Самбар дээр буюу том цаасан дээр бичсэн мэдэхгүй үгсэд ангийн гишүүдийн анхаарлыг хандуул (дээрх “Бэлтгэлийг” үз). Үгийн тодорхойлолтыг тааж гаргахыг ангийн гишүүдээс хүс. Хэдэн тааврын дараа Судруудын Удирдамж дахь зөв тодорхойлолтыг ангийн гишүүдээр харуул.

Мэдэхгүй үгийн тодорхойлолтыг таах нь зөвхөн бидний өөрсдийн ойлголт дээр тулгуурлан шийдвэр гаргахтай адил болохыг тайлбарла. Сургаалт Үгс 3:5–6-гийн бичвэрийг харуул. Бид үгийн зөв тодорхойлолтыг мэдэхийн тулд баттай эх сурвалжид ханддагийн нэгэн адил, бид Их Эзэнд итгэж, амьдралдаа зөв шийдвэрүүд гаргахын тулд түүний тааллыг эрэлхийлэх хэрэгтэйг онцлон тэмдэглэ. Бид шийдвэр гаргах үедээ Их Эзэнд итгэж, түүний удирдамжийг эрэлхийлэхийн ач холбогдлыг заахын тулд энэ хичээл хоёр хүн, Давид, Саул хоёрын туршлагыг сөргүүлэн тавих болно.

2. Тэдний саяхан гаргасан чухал шийдвэрүүдээс заримынх тухай ярихыг ангийн гишүүдээс хүс. Эдгээр шийдвэрүүдийг гаргахад тэдэнд юу тусалсныг асуу.

Сургаалт Үгс 3:5–6-гийн бичвэрийг үзүүл (Энэ судрыг та ангийн гишүүдээр цээжлүүлэхийг хүсч болно). Бид шийдвэр гаргах үедээ Их Эзэнд итгэж, түүний удирдамжийг эрэлхийлэхийн ач холбогдлыг заахын тулд энэ хичээл хоёр хүн, Давид, Саул хоёрын туршлагыг сөргүүлэн тавих болно гэдгийг тайлбарла.

Судрын ярилцлага
ба хэрэглээ

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагуудаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж. Асуулт бүрийг асуух буюу эсвэл хичээл дэх бүх зүйлийг бүгдийг үзэх нь хэцүү байж болох учраас ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох зүйлүүдийг залбиран сонго. Жишээ нь, хэрэв та Давид, Голиат хоёр дээр анхаарал төвлөрүүлэхийг хүсвэл, та Саулын амьдралын тухай ярилцахад бага цаг зарцуулж болно.

1. **Саул Самуелаас удирдамж эрэлхийлж, хаан байхаар тослон адислагдав.**

1 Самуел 9–11-ийг зааж, ярилц.

- Израилчууд өөрсдийнхөө эргэн тойрон дахь үндэстнүүдтэй адилхан хаантай байхыг хүсч байлаа. Их Эзэн израилчуудын хүсэлтийг анхаарч, Саулыг Израилын анхны хаан болгохоор тослон адислахыг Самуелд айлджээ. Саул бол “шилдэг залуу бөгөөд, . . . Израилын хөвгүүдийн дотор түүнээс илүү сайхан залуу үгүй байв” (1 Самуел 9:2) Саул хаан болж тослон адислагдахаасаа өмнө, түүнчлэн үүний дараахан өөрийн сайн чанаруудыг харуулсан юу хийсэн бэ?

- а. Эцгийнхээ илжгүүдийг хайхад тэрээр хичээнгүй байв (1 Самуел 9:3–4).
- б. Тэрээр эцгийнхээ үйлчлэгчийн ухаалаг зөвлөгөөг сонсож, дагах хүсэлтэй байлаа (1 Самуел 9:5–10).
- в. Тэрээр бошиглогч Самуелд итгэж, түүнтэй дотносдог байв (1 Самуел 9:18–25).
- г. Тэр даруу байв (1 Самуел 9:20–21).
- д. Тэр сүнсээрээ дахин төрж, улмаар бошиглодог байв (1 Самуел 10:6–10).
- е. Тэр өөрийгөө шүүмжлэгчдийг уучилжээ (1 Самуел 11:11–13).
- ё. Аммончуудыг ялсан ялалт дахь Их Эзэний тусламжийг тэрээр хүлээн зөвшөөрчээ (1 Самуел 11:13).

2. Саул зохих эрх мэдэлгүйгээр шатаалт тахил өргөв.

1 Самуел 13:1–14-ийг зааж, ярилц.

- Саул хаан болж тослон адислагдсанаас хойш хоёр жилийн дараа филистинчүүд Израилын эсрэг тулалдахаар хүчирхэг цэрэг цуглуулжээ. Саулын хүмүүсээс олон нь ихэд айж, нуугдсан буюу тарж явсан аж. Энэ үед Саул яагаад Самуелыг өөр дээрээ хүрч ирэхийг хүссэн бэ? (1 Самуел 13:7–8-ыг үз. Хүмүүсийн нэрийн өмнөөс Самуел Их Эзэнд тахил өргөхийг Саул хүсчээ). Самуел болзсон цагтаа ирээгүй учир Саул юу хийсэн бэ? (1 Самуел 13:9-ийг үз. Саул тахил өргөх санваарын эрх мэдэлгүй байсан хэдий ч, өөрөө тахил өргөжээ.)

“Саул хэдийгээр хаан ширээг эзэлж, хааны титэм өмсөн, очирт таяг барьж байсан хэдий ч, Бурханы Санваарт . . . үйлдэх эрх [түүнд] байсангүй; ингээд үүний улмаас болон түүний шударга бус бусад үйлүүдийн учир тэрээр Бурханаар няцаагдаж, түүний оронд өөр хүн хаан болгогджээ” гэж Ахлагч Жеймс Талмейж бичжээ (*The Articles of Faith*, 12 дахь хэвлэл. [1924], 185).

- Саулын эрх мэдэлгүй тахил өргөлтөд Самуел хэрхэн хариулсан бэ? (1 Самуел 13:10–14-ийг үз)
- Саулын эрх мэдэлгүй тахил өргөлт түүний талаар юуг илчилсэн бэ? (Тэрээр цаашид “[ЭЗЭНий] Өөрийнх нь зүрх сэтгэлийн дагуух хүн” байж чадсангүй [1 Самуел 13:14]. Тэрээр тэвчээргүй нэгэн болж өсөн, Их Эзэнд итгэх итгэлээ алдаж, улмаар түүнийг дуулгавартай дагасангүй. Түүнээс гадна, тахил өргөх эрх мэдлийн тухайд түүний дураараа авирласан нь тэрээр өөрийнхөө хүч, ач холбогдлыг хэтрүүлэн үнэлдэг байсныг харуулдаг). Ямар байдлаар бид заримдаа Их Эзэн буюу түүний үйлчлэгчдийн хувьд тэвчээргүй ханддаг вэ? Ийм тэвчээргүй байдлын үр дагаврууд юу байж болох вэ? Бид Их Эзэнд хэрхэн бүрэн дүүрэн итгэлтэй байж чадах вэ?

3. Амалекчуудтай хийсэн тулалдаанд Саул Их Эзэнийг дуулгавартай дагасангүй, үүний улмаас хаан байхаас эсэргүүцэгдэв.

1 Самуел 15-ыг зааж, ярилц.

- Амалекчуудын хувьд юу хий гэж Их Эзэн Саулд зарлигласан бэ? (1 Самуел 15:1–3-ыг үз) Үүний оронд Саул юу хийсэн бэ? (1 Самуел 15:4–9-ийг үз) Саулын үйлдлүүд түүний талаар юуг илчилсэн бэ? (1 Самуел 15:11. Тэрээр Их Эзэний тааллыг гүйцэлдүүлэхээс илүүтгээр өөрийн шийдвэрийг дагасан ажээ.)

- Саул амалекчуудын шилдэг малыг амьд үлдээснээр өөрийн дуулгаваргүй байдлыг хэрхэн зөвтгөх гэж оролдсон бэ? (1 Самуел 15:13–15, 20–21, 24-ыг үз. Тэрбээр малыг амьд үлдээх гэснийх нь учир өөрийн хүмүүсийг буруутгасан юм.) Саулынхаар бол яагаад түүний хүмүүс амалекчуудын шилдэг малыг амьд үлдээхийг хүссэн бэ? (1 Самуел 15:15, 21-ийг үз) Ямар байдлаар бид заримдаа Их Эзэнийг дуулгавартай дагаагүйгээ зөвтгөхийг оролддог вэ? (“Энэ чинь өчүүхэн жижиг нүгэл шүү дээ” Би хуулийн үг үсгээс илүүгээр хуулийн санааг дуулгавартай дагадаг”, “Энэ нь хэнд ч гэм хоргүй шүү дээ”, “Би үүнийг ердөө ганцхан удаа л туршаад үзье”, “Бусад хүмүүс ингэдэг шүү дээ” гэх буюу эсвэл “Энэ зарлиг надад хамаагүй” гэж бид өөртөө хэлж мэдэх юм.) Нүглийг зөвтгөх буюу хаацайлах хандлагыг бид хэрхэн даван туулж чадах вэ?
- Амалекчуудын малыг амьд үлдээх гэсэн Саулын тайлбарт Самуел хэрхэн хариулсан бэ? (1 Самуел 15:22-ыг үз) Самуелын үгс бидэнд хэрхэн холбогдох вэ?
- Саул зөрүүдэлж, Их Эзэний үгийг эсэргүүцсэн учир “Захирагдахгүй байх нь . . . хиймэл шүтээн лугаа адил юм” гэж Самуел түүнд хэлжээ (1 Самуел 15:23). Зөрүүдлэх нь хэрхэн хиймэл шүтээнтэй адил вэ? Саул зөрүүдэлж, эсэргүүцсэний үр дүн нь юу байсан бэ? (1 Самуел 15:23, 26, 28-ыг үз) Заримдаа бид хэрхэн зөрүүдэлж, эсэргүүцдэг вэ? Бид зөрүүдэлж, эсэргүүцсэний үр дүн нь юу байдаг вэ? Эдгээр хандлагуудыг бид хэрхэн таньж, даван туулж болох вэ?

4. Их Эзэн Давидыг хаан болгон сонгов.

1 Самуел 16-г зааж, ярилц. Энэ шастирыг та даалгавар авсан ангийн нэг гишүүнээр товч хураангуйлан нэгтгэн дүгнүүлж болно. Самуел Давидыг хаан болгохоор тослон адисалсан хэдий ч, олон жилийн дараа Саулыг нас эцэслэх хүртэл Давид хаан болоогүйг тайлбарла.

- Иессигийн хөвгүүдээс хэн нь дараагийн хаан байхыг Самуел тодорхойлохдоо юу хийсэн бэ? (1 Самуел 16:6–7-г үз) Давидыг Их Эзэн сонгосон аргыг Тэрээр өнөөдөр удирдагчдыг сонгодог аргатай хэрхэн харьцуулсан бэ? Их Эзэн биднийг хэрхэн үнэлдэг тухай 1 Самуел 16:7 юу заадаг вэ?

Ахлагч Марвин Ж.Аштон хэлэхдээ:

“Бид . . . бусдыг бие бялдрын буюу гаднах төрх байдлаар нь: сайхан царай зүс, нийгмийн байдал, удам судар, боловсрол эсвэл эдийн засгийн байдлаар нь үнэлэх хандлагатай байдаг.

“Тэвч хүнийг хэмжих өөр жишиг Их Эзэнд байдаг. . . . Тэрээр хүний оюуны чадварыг тодорхойлохын тулд түүний толгойг тойруулан туузаар хэмжих буюу эсвэл хүнлэг чанарыг тодорхойлохын тулд цээжийг нь хэмждэггүй боловч, Тэрээр зүрх сэтгэлийг тухайн хүний чадвар болон бусдыг адислах чадавхийн үзүүлэлт болгон хэмждэг” гэжээ (Conference Report, 1988 оны 10-р сар, 17; or *Ensign*, 1988 оны 11-р сарын, 15).

- Бусадтай харилцах өөрсдийн харилцаанд бид гадаад төрх байдлыг биш, харин зүрх сэтгэлийг харах нь яагаад чухал вэ? Ингэснээр бид өөрсдийн чадвар, шийдвэр төгс байдлыг хэрхэн дээшлүүлж чадах вэ?

- Саул дуулгаваргүй байсан учраас Их Эзэний Сүнс түүнээс холдсон аж (1 Самуел 16:14). Түүн дээр ирсэн муу ёрын сүнснээс чөлөөлөгдөхийг Саул хэрхэн эрэлхийлсэн бэ? (1 Самуел 16:15–23-ыг үз) Өнөө үед хүмүүс зарим үед нүглээс ангижрах гэж хичээхдээ гадаад ямар эх сурвалжуудад ханддаг вэ? Бидний хувьд нүглээс ангижрах Их Эзэний зам юу вэ? (Матай 11:28–30; С ба Г 58:42-ыг үз)
- Удирдагч байхад тэнцэх ямар зан чанарууд Давидад байсан бэ? (1 Самуел 16:18).

5. Давид Их Эзэний хүч чадлаар Голиатыг алав.

1 Самуел 17-г зааж, ярилц. Та энэ шастирын товч хураангуйг даалгавар авсан ангийн нэг гишүүнээр хийлгэж болно.

- Голиаттай хийсэн тулалдаанд израилчууд юу хожих буюу юуг алдаж болох байсан бэ? (1 Самуел 17:8–9-ийг үз) Саул болон түүний цэрэг яагаад Голиаттай тулалдахаас айсан бэ? (1 Самуел 17:4–11-ийг үз. Голиатын биеийн хэмжээ, хүч чадал, хуяг дуулга, зэвсгийнх нь учир тэд түүнийг ялж чадахгүй гэж бодож байжээ.)
- Голиаттай тулалдах зоригийг Давид хэрхэн олж авсан бэ? (1 Самуел 17:32–37, 45–47-г үз. Түүнийг эцгийнхээ хонийг хариулж явахад арслан, баавгай хоёроос өөрийг нь Их Эзэн чөлөөлснийг Давид мэдэж байсан бөгөөд Голиаттай тулалдахад Их Эзэн түүнд тусална гэдэгт тэрээр итгэж байжээ.)
- Давид өөртэй нь тулалдахаар ирэхийг Голиат хараад юу гэж хэлсэн бэ? (1 Самуел 17:42–44-ийг үз) Давид хариуд нь юу гэж хэлсэн бэ? (1 Самуел 17:45–47-г үз) Биднийг хүмүүс шоолох буюу айлган сүрдүүлэхэд Давидын хариултыг санах нь бидэнд хэрхэн тусалж чадах вэ?
- Бага залуу байхдаа арслан, баавгай хоёрыг ялсан нь Голиаттай тулгарах илүү том сорилтод бэлтгэхэд нь түүнд тусалсан ажээ. Биднийг илүү том сорилтод бэлтгэх ямар сорилтууд эдүгээ бидэнд тулгарч болох вэ? Эдгээр сорилтуудад хариулах бидний хариултууд, хожим нь ирж болох Голиаттай тулалдах бидний чадварт хэрхэн нөлөөлж болох вэ? Бидний амьдрал дахь арслан, баавгайг ялснаараа, бид итгэлтэй байдал, зан төрх хийгээд бидэнд тулгарч болох Голиатыг ялах итгэлийг өөрсдөдөө хөгжүүлэх болно гэдгийг гэрчил.
- Өнөөдөр бид ямар Голиатуудтай тулгардаг вэ? Тэднийг даван туулах талаар бид Давидаас юу сурч болох вэ? (1 Самуел 17:45; Ефес 6:11–18-ыг үз) Та нарт тулгарсан Голиатуудыг даван туулахад Их Эзэн та нарт хэрхэн тусалсан бэ?

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хэлэхдээ:

“Та бүхний эргэн тойронд Голиатууд, та нарыг устгах бодол өвөрлөсөн аварга биетнүүд байдаг. Эд бол есөн тохой биетэй аварга хүмүүс биш, гэвч та нарыг сул дорой болгож, устгаж болох анхаарал татахуйц хийгээд хилэнцэт зүйлүүдийг хянадаг хүмүүс болон байгууллагууд ном. Эдгээрийн тоонд шар айраг, чихэрлэг дарс болоод тамхи орно. Эдгээр бүтээгдэхүүнүүдийг зах зээлд гаргадаг хүмүүс эдгээрийг хэрэглэхэд та

нарыг боолоо болгохыг хүсдэг. Олж авахад харьцангуй амархан янз бүрийн мансууруулах бодис олон ахлах сургуульд байдаг гэж надад хэлдэг. Эдгээрийг наймаалдаг хүмүүсийн хувьд энэ бол олон сая долларын бизнес, хилэнцийн аварга том сүлжээ юм. Уруу татагч, шохоорхол, сонирхлыг өдөөн даллагч порнографи байна. Энэ нь та нарын мөнгийг авч, та нарыг устгах үйл ажиллагаа уруу хөтлөхөд чиглэгдсэн сэтгүүлүүд, кино болон бусад материалуудыг үйлдвэрлэдэг аварга том бизнес болжээ.

“Эдгээр хүч чармайлтуудын цаана байдаг аваргууд бол сүрдмээр бас нэн чадварлаг юм. Тэд явуулж байгаа дайндаа их туршлага хуримтлуулсан юм. Тэд та нарыг урхидахыг хүсч байна.

“Тэдний бүтээгдэхүүнүүдэд татагдахаас нийтээрээ зайлсхийх нь бараг боломжгүй юм. Та нар эдгээр материалуудыг эргэн тойрондоо газар сайгүй хардаг. Гэвч хэрэв та нарын гарт үнэний илд байх юм бол та нар айх хэрэггүй. Та нарт зөвлөж, зааж бас зөвлөгөө өгсөөр байгаа шүү дээ. Та нарыг эзлэн түрэмгийлэхийг хүсч байгаа эдгээр дайснуудын эсрэг ашиглах ариун журам, нэр төр хийгээд шударга ёсны чулуу та нарт бий. Та нар санаа шулуудаж чадвал, зүйрлүүлэх хэллэгээр бол, тэдгээрийг ‘нүднийхээ булангаар ч’ харахгүй байж чадна. Та нар эдгээрээс зайлсхийхийн тулд өөрсдийгөө сахилгажуулснаар эдгээрийг ялж чадна. ‘Чи илд, бамбай, жад барьж над уруу ирж байгаа бол, харин би чиний доромжилсон Израилын бүх цэргийн Бурхан, түмний ЭЗЭНий нэрээр чам уруу ирж байна’ хэмээн Давид Голиатад хэлсэн шиг та нар эдгээр бүгдэд хэлж чадна.

“Ялалт та нарынх байх болно. . . . Та нарыг дэмжихийн тулд Түүний хүч та нарын дотор байдаг. Та нарыг хамгаалахаар та нарын дэргэд байдаг тохинуулагч тэнгэр элчүүдэд хандах эрх та нарт бий. Өөрсдийгөө айлгах боломжийг Голиатад бүү олго. Итгэл бишрэлээ хамгаалж, байр сууриа өндөрт өргөж яв, тэгвэл та нар ялах болно” гэжээ (Conference Report, 1983 оны 4-р сар, 66; *Ensign*, 1983 оны 5-р сар, 46, 51).

Дүгнэлт

Их Эзэнд итгэж, дуулгавартай байхад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж. Ингэснээр тэд илүү хүчирхэг болж, хувь хүнд учирч болох Голиатыг ялахад Их Эзэн тэдэнд туслах баттай найдвар тэдэнд байх болно гэдгийг амла. Их Эзэн бидний эд баялаг буюу байр суурийг, эсвэл нийтээр баримталдаг жишгүүдэд тохирч байгааг хардаггүй, харин бидний зүрх сэтгэлийг хардгийг ангийн гишүүдэд сануул.

Нэмэлт заах санаанууд

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

1. Нүглээ хаацайлах нь

Ахлагч Спенсер В.Кимбаллын дараах ишлэл амалекчуудын талаарх Саулын дуулгаваргүй байдлын тухай ярилцахад та нарт тустай байж болох юм:

“Саул нүглээ хаацайлж байлаа. Хаадын зан авирыг дагах нь түүний хувьд амар байв, учир нь байлдан дагуулагдсан хаан юунд хэрэгтэй юм бэ? Тарган

хонь, үхрийг авахгүй байх гэж үү? Түүний хаад дээдсийн шийдвэр дорд гаралт Самуелынхаас илүү дээгүүр биш байсан гэж үү? . . .

“Израилд өнөөдөр олон нь Саултай хичнээн адилхан байна вэ. Хэн нэг нь хааяа нэг аяга кофе уухаас бусдаар Их Эзэний илчлэлтийн дагуу амьдрах болно; тэр тамхи ч, бас чихэрлэг дарс ч хэрэглэдэггүй, эдгээрийг огт хүсдэггүй ч, ганц аяга тайвшруулагч цай уучих нь байх ёстой зүйл гэнэ.

“Тэрээр Сүмийн албан тушаалд үйлчлэх болно, учир нь түүнд таалагддаг үйл ажиллагаа энд байдаг, түүний хүсдэг нэр төр энд байдаг, . . . гэвч түүний хувьд их хэцүү байдаг аравны нэгийг төлөхгүй байх шалтаг олох нь хялбархан байх болно. Тэрээр үүнийг төлж чадаагүй. . . . Уг нь тэр үүнийг төлж болох л байсан, гэвч мөнгөөр үргэлж бялхаад байна ч гэж хаа байхав дээ, тэгээд түүний бүтэлгүйтлийг хэн мэдэх билээ?

“Өөр нэг нь зарим цуглаануудад оролцох болно, гэвч тэр өдрийн үлдсэн хэсгийн хувьд Саулын адил нүглээ хаацайлна. Тэр яагаад бөмбөг тоглохыг үзэж, цэцэрлэгтээ хэрэгтэй ажлаа хийх буюу ердийнх шигээ ажил хэргээ үргэлжлүүлж болохгүй гэж?

“Өөр нэг нь сүмийн үүргүүдээ гаднах байдлаараа сүсэглэнгүй гүйцэтгэх боловч гэр бүлийн асуудлууд буюу гэр бүлийн доторх санал зөрөлдөөний улмаас гэр бүл нь цуглахад их төвөгтэй байдгаас гэр бүлийн залбирал хийх санал зөвлөгөөг хэрэгсдэггүй.

“Саул ийм байсан юм. Тэр шаардлагатай зүйлүүдийг хийж чаддаг байсан ч, өөрийнх нь хүсэлд харшлах зүйлүүдэд тэрээр шалтаг олж чаддаг байв.”
(Conference Report, 1954 оны 10-р сар, 51)

2. Бидэнтэй тулгарах Голиатуудыг ялах нь

Голиатын өндөртэй ойролцоо, 3 метр утсан уяа хайчил. Уяа, мөн хэсэг наадаг тууз, хэдэн хуудас цаас болон тэмдэглэгчийг хичээлд авчир. Уяаг босоогоор нь нэг үзүүрийг нь хананы дээд ирмэгт, нөгөө үзүүрийг хананы сууринд туузаар нааж бэхэл (хэрэв хана хангалттай өндөр биш бол уяаны төгсгөлийн хэсгийг шалан дээр тавь). Уяа Голиатыг төлөөлж буйг ангийн гишүүдэд хэл. Өөрсдөд нь аюултай байж болох зүйлүүдийг нэрлэхийг ангийн гишүүдээс хүс (хариултууд нь бардамнал, порнографи, атаа жетөө, мансууруулах бодис байж болно). Аюул бүрийг хэсэг цаасан дээр бичиж, уг цаасыг ханан дээр уяаны дээрээс доош төгсгөлд нь хүртэл туузаар наа.

Голиатыг ялахын тулд бидэнд зэвсэг хэрэгтэйг тайлбарла. Голиатыг ялж чадах зэвсгүүдийг нэрлэхийг ангийн гишүүдээс хүс (хариултууд нь Их Эзэнд итгэх итгэл, залбирал, судруудыг судлах, үнэнийг мэдэх, ёс суртахууны хувьд цэвэр ариун байх, түүнчлэн сайн найз нараа сонгох явдал байж болно). Зэвсэг бүрийг ангийн гишүүд нэрлэсэн үед нэг цаасыг ав. Уяаны оройгоос эхэлж, цаас болон уяаг ханан дээр тогтоосон туузнаас ав. Уяаг дараагийн цаасан дээр болго. Бүх цаас болон туузыг авч дуусахад уяа шалан дээр унах бөгөөд ингэснээр Голиат ялагдах болно.

Зорилго

Ионатан, Давид нарын нэгэн адил найз нартаа үнэнч байх, Саул шиг атаа жөтөө хийгээд үзэн ядалтад автагдахгүй байхад ангийн гишүүдийг урамшуулан дэмжих.

Бэлтгэл

1. Дараах судруудыг залбирч судал:

- а. 1 Самуел 18:1–16. Ионатан, Давид хоёр нөхөрлөлийн гэрээ байгуулав (18:1–4). Тулалдаанд амжилт гаргасных нь төлөө израилчууд Давидыг хүндэтгэв (18:5–7). Саул Давидад атаархаж, түүнийг жадаар алах гэж оролдов (18:8–16; 1 Самуел 18:10-ын Иосеф Смитийн Орчуулга Саул дээр ирсэн муу ёрын сүнс Бурханаас *ирээгүйг* харуулдгийг анхаар).
- б. 1 Самуел 18:17–30; 19:1–18. Давид Саулын охинтой гэрлэх эрхийн төлөө филистинчүүдтэй тулалдахдаа, Давид тулалдааны талбарт алагдах болно хэмээн Саул найдаж байсныг мэдээгүй байжээ (18:17–25). Давид филистинчүүдийг ялж, Саулын охин Мехалтай гэрлэв (18:26–28). Ионатан Давидад нуугд хэмээн хэлж, түүнийг алахгүй байхад Саулыг ятгахаар оролдов (19:1–7). Саул Давидыг жадаар алах гэсэн бас нэг оролдлогодоо амжилт эс олов (19:9–10). Түүний амь насанд халдах гэсэн Саулын өөр нэг халдлагаас Мехал Давидыг аврав (19:11–18).
- в. 1 Самуел 20. Ионатан Давид хоёр нөхөрлөл, энх тайвны гэрээгээ шинэчлэв (энэхүү гэрээ зөвхөн Ионатан Давид хоёрын хооронд төдийгүй бас тэдний өрх гэрүүдийн хооронд байсныг анхаар). Саул Давидыг алах гэж дахин оролдоход Ионатан Давидад зугтаа хэмээн сэрэмжлүүлжээ.
- г. 1 Самуел 23–24. Давид филистинчүүдтэй тулалдахаа үргэлжлүүлж, Саул зугтав. Давид Саулыг олж, амийг нь аврав.

2. Нэмэлт уншлага: 1 Самуел 14:1–16; 2 Самуел 1.

Энэ хичээлийг заах зөвлөмж

Анхаарал
төвлөрүүлэх
үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагааг (эсвэл өөрийхөө нэг үйл ажиллагааг) ашиглахыг хүсч болно.

Дараах асуултыг ангийн гишүүдээс асуу:

- Найздаа байгаасай гэж та нарын боддог зарим чанар юу вэ? (Ангийн гишүүдийн хариултуудыг та самбар дээр бичиж болно. Хариултууд нь үнэнч чанар, шударга зарчимч байдал, амин хувиа хичээдэггүй зан, нинжин сэтгэл, энэрэл байж болно.)

Энэ хичээлийн нэг хэсэг нь үнэнч найз байхын ач холбогдлыг заадгийг тайлбарла.

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Ионатан Давид хоёр нөхөрлөлийн гэрээ байгуулав. Саул Давидад атаархаж, түүнийг алахыг хичээв.

1 Самуел 18:1–16-г зааж, ярилц.

Давид Голиатыг алсны удаа тургэн хугацаанд баатар болов. Хаан болон хаант улс бүхлээрээ түүнийг хүндэтгэх болов. Гэвч, хэн ч Саулын хүү Ионатан шиг тийм үнэнч байсангүй.

- Ионатан Давид хоёр бие биенийхээ талаар ямар бодолтой байсан бэ? (1 Самуел 18:1, 3) Ионатаны хувьд яагаад Давидад атаархаж болох нь амархан байсан бэ?
 - а. Саулын хүү байсан учир Ионатан хаан болох дараагийн хүн байв. Гэвч бошиглогч Самуел Давидыг дараагийн хаан байхаар тослон адисалжээ (1 Самуел 16:6–13).
 - б. Тулалдаанд амжилт гаргасных нь төлөө хүмүүс Давидыг ихэд хүндэлдэг байхад тулалдааны талбар дахь амжилтынх нь төлөө Ионатанд анхаарал бага хандуулдаг байв (1 Самуел 14:1–16).
- Яагаад Ионатан Давидад атаархдаггүй буюу эсвэл түүнд заналхийлдэггүй байсан гэж та нар боддог вэ? (1 Самуел 18:1, 3) Давидыг дэмждэгээ Ионатан хэрхэн харуулдаг байсан бэ? (1 Самуел 18:4. Тэр хааны орхимж болон зэвсгээ Давидад өгчээ.)
- Голиатыг алсны дараа Хаан Саул Давидын талаар ямар бодолтой болсон бэ? (1 Самуел 18:2, 5. Саул Давидыг гэртээ авчирч, түүнийг цэргийнхээ тэргүүн болгожээ.) Давид Хаан Саулд үнэнчээ хэрхэн харуулсан бэ? (1 Самуел 18:5) Давидын эсрэг эргэхэд нь Саулыг юу өдөөсөн бэ? (1 Самуел 18:6–9-ийг үз) Яагаад зарим үед бусдын амжилтад баяртай байх нь хэцүү байдаг вэ? Атаа жөтөө, бардамнал бидний сүнсний сайн сайхан байдалд хэрхэн нөлөөлдөг вэ?

Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон хэлэхдээ:

“Бардамналын улмаас Саул Давидын дайсан боложээ. Израилын цугласан олон эмэгтэйчүүд ‘Саул мянгыг алж, Давид түмийг алав’ хэмээн дуулсан учраас тэрээр атаархаж байжээ (1 Самуел 18:7; бас 18:6, 8-ыг үз).

“Бардамнал Бурханы шүүлтээс эмээхээс илүүгээр хүмүүний дүгнэлтээс эмээдэг. . . . ‘Бурхан миний тухайд юу гэж бодох бол?’ гэхээс илүүгээр ‘Хүмүүс миний тухай юу гэж бодох бол?’ гэдгийг илүү чухалд тооцдог. . . .

“Хүмүүний дүгнэлт шүүлтээс эмээх нь хүмүүний магтаал сайшаалын төлөөх өрсөлдөөн болгон өөрийгөө харуулдаг. Бардамнал нь ‘хүний алдрыг Бурханы алдраас илүү эрхэмлэдэг’ (Иохан 12:42–43). Бидний хийдэг зүйлийн төлөөх хөшүүрэг нүгэл байгаа газарт харагддаг. Тэрээр ‘Бурханд тааламжтай зүйлсийг үргэлж үйлддэг байсан’ хэмээн Есүс хэлсэн байдаг (Иохан 8:29). Бид өөрийгөө ах дүүгээсээ болон бусдаас дээгүүрт тавих гэж хичээхээс илүүгээр Бурханд тааламжигийг үйлдэх учиртай бус уу?

“Зарим бардам хүмүүс цалин нь тэдний хэрэгцээг хангахад хүрэлцэх үү, үгүй юү гэдгийг бодохоосоо илүүгээр, цалин нь өөр бусад хэн нэгнийхээс илүү байхад санаа тавьдаг. Тэдний шагнал бусад хүмүүсийнхээс арай илүү байдаг. . . .

“Бардамнал бидний зүрх сэтгэлийг өргөхөд бид дэлхийгээс тусгаар байдлаа алдаж, эрх чөлөөгөө хүмүүний дүгнэлт шүүлтгийн боолчлолд аваачдаг. Дэлхий Ариун Сүнсний шивнээнээс илүү чанга хашгирдаг. Хүмүүний дүгнэлт шүүлт Бурханы илчлэлтүүдийг алгасан харайж, бардамнал төмөр бариулаас алдууран гардаг” гэжээ (Conference Report, 1989 оны 4-р сар, 4–5; *Ensign*, 1989 оны 5-р сар, 5).

- Их Эзэн түүнийг тулалдааны талбар дахь амжилтаар адисалсны дараа Давид хэрхэн үйлдэх болсон бэ? (1 Самуел 18:5, 14–16) Түүний үлгэр жишээнээс бид юу сурч болох вэ? Бид амжилт олсон үедээ “[биеэ] ухаалгаар авч явах ёстой” гэдэг нь ямар утга учиртай гэж та нар боддог вэ?

2. Давидын амийг хөнөөх гэсэн өөр гурван оролдлогод Саул амжилт олсонгүй.

1 Самуел 18:17–30; 19:1–18-ыг зааж, ярилц.

- Хэрэв Давид филистинчүүдтэй тулалдах юм бол, охидынхоо нэгэнтэй нь гэрлэхийг зөвшөөрнө хэмээн Саул Давидад санал болгов. Энэ тухайд Саулын үнэн санаа юу байсан бэ? (1 Самуел 18:20–25. Давид филистинчүүдэд алуулна гэдэгт тэрээр найдаж байжээ.)
- Саул Давидыг алах гэж эрэлхийлж байхад Ионатан хэрхэн үнэнч найз нь байсан бэ? (1 Самуел 19:1–7) Үнэнч найз байх гэдэг нь юу гэсэн үг вэ? Ямар байдлаар найз нар чинь та нарт үнэнч байдаг вэ?
- Давидын талаарх Саулын санаа бодлыг өөрчлөх гэсэн Ионатаны чармайлтуудыг Саул үл хайхран Давидын амийг егүүтгэхийг оролдохоо үргэлжлүүлсээр байлаа (1 Самуел 19:9–10). Давидын эхнэр Мехал нөхөртөө үнэнч байснаа яаж харуулсан бэ? (1 Самуел 19:11–18-ыг үз)

3. Давид Ионатан хоёр нөхөрлөлийн гэрээгээ шинэчилж, Ионатан Давидын амийг аврав.

1 Самуел 20-ийг зааж, ярилц.

- Саулын үзэн ядалт хийгээд түүнийг хөнөөх гэсэн оролдлогуудад Давид хэрхэн хариу үйлдэл үзүүлж байсан бэ? (1 Самуел 20:1-ийг үз) Саул Давидын амийг эрэлхийлж байхад Ионатан нөхөрлөлөө хэрхэн харуулж, үргэлжлүүлж байсан бэ? (1 Самуел 20:2–4, 13–17, 23; түүнчлэн доор өгүүлсэн 1 Самуел 20:24–42-ыг үз)
- Бурханд итгэх итгэл нь Ионатан Давид хоёрын нөхөрлөлд хэрхэн нөлөөлдөг байсан бэ? (1 Самуел 20:23-ыг үз) Бурханыг хайрлах бидний хайр бусдыг хайрлах бидний хайранд хэрхэн нөлөөлдөг вэ?
- Хэрэв бид Бурханд үнэнч итгэлтэй байхыг амьдралдаа нэгдүгээрт тавьсан тохиолдолд, найз нар маань буруу юм хийж байвал бид яах ёстой вэ? (Найз нар маань өөрчлөгдөхөд туслахын тулд бид хайраар хичээх болно.)

Нийгмийн үр дагавруудыг нь харгалзахгүйгээр найз нар маань биднээс хийхийг хүссэн зүйлүүдийг бид хийх ёсгүй, түүнчлэн найз нар маань зөв шударга сонголтууд хийхэд бид тэдэнд нөлөөлөхийг хичээх болно.

- Саулын ордонд эргэж ирэх нь аюулгүй гэдгийг Ионатан Давидад яаж мэдэгдсэн бэ? (1 Самуел 20:5–7, 18–22) Давидыг байсангүйд, мөн Ионатан найзыгаа хамгаалсанд Хаан Саул хэрхэн хариулсан бэ? (1 Самуел 20:24–33-ыг үз) Саулаас зугтахыг Ионатан Давидад хэрхэн сэрэмжлүүлсэн бэ? (1 Самуел 20:35–42-ыг үз)

4. Саул Давидыг үзэн ядахад бүрэн автагдав. Давид Саулын амийг аврав.

1 Самуел 23–24-ийг зааж, ярилц.

- Давид тулалдааны талбар дахь амжилтаар үргэлжлэн адислагдсаар байв (1 Самуел 23:1–5). Тэрээр Кеила хотын хүмүүсийг филистинчүүдээс аварсны дараа Давид яагаад тус хотыг орхиж явах шаардлагатай болсон бэ? (1 Самуел 23:7–13-ыг үз)
- Давид Кеилад байгааг Саул мэдээд тэрээр хотыг бүхэлд нь устгахын тулд цэргээ бэлтгэж байв (1 Самуел 23:10). Зөв шударга хаанаас, нэг хүнийг алахын төлөө бүхэл бүтэн хотыг устгахыг хүссэн хүн болоход юу Саулыг хувиргасан бэ? Яагаад атаа жөтөө, үзэн ядалт ийм их байв? Атаа жөтөө буюу үзэн ядалтаас бид өөрсдийгөө хэрхэн хол байлгаж болох вэ?
- Давидыг Саулаас нуугдаж байхад Ионатан Давидтай уулзаж, “Бурханы дотор түүнийг зоригжуулжээ.” (1 Самуел 23:16) Энэ нь юу гэсэн утгатай гэж та нар боддог вэ? Бид найз нараа Бурханы дотор хэрхэн зоригжуулж болох вэ?
- Давидыг олж, алах гэсэн өөр нэг оролдлогынхоо үеэр Саул амрахаар нэг агуйд буусан аж (1 Самуел 24:1–3). Давидын хүмүүс Саултай уулзаад юу гэж хэлсэн бэ? (1 Самуел 24:4-ийг үз) Давид яасан бэ? (1 Самуел 24:4–5-ыг үз)
- Саулд хор хүргэхээс Давид яагаад татгалзсан бэ? (1 Самуел 24:6–12-ыг үз) Давидын үлгэр жишээ өс хонзон болон бидэнд хилэнцэтийг үйлддэг хүмүүст хариу үзүүлэх талаар бидэнд юу заадаг вэ? (1 Самуел 24:12–15; мөн түүнчлэн Мормон 8:20-ийг үз) Давид амийг нь аврахад Саул юу гэж хэлсэн бэ? (1 Самуел 24:16–19-ийг үз)

Дүгнэлт

Жинхэнэ нөхөрлөл, үнэн хайр биднийг найз нартаа болон Бурханд ойртуулдгийг Ионатан Давид хоёрын тухай түүх бидэнд сануулдгийг тэмдэглэн хэл. Атаа жөтөө, үзэн ядалт биднийг залгиж, биднийг найз нөхдөөс маань, бас Бурханаас холдуулдгийг Саулын түүх бидэнд сануулдаг. Найз нөхөддөө үнэнч байж, “ЭЗЭН чи бид хоёрын хооронд мөнхөд байна” гэж тэдэнд хандан хэлж чадахуйц байхад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж (1 Самуел 20:23).

Нэмэлт заах санаа Нөхөрлөлийн үнэлэмж

Хэрэв та үнэнч найз байхын ач холбогдлыг онцлон тэмдэглэхийг хүсвэл дараах үйл ажиллагааг ашигла.

Ангийн гишүүн бүрд хэсэг цаас, үзэг буюу харандаа өг. Тэд үнэнч найз нөхөд мөн үү гэдгийг тодорхойлоход нь туслахын тулд та тэднээс асуух гэж байгаагаа тайлбарла. Тэд хариултуудаа хуваалцахгүй гэдгийг мэдэгдэн, хариултуудыг нь ангийн гишүүдээр бичүүл. Тэгээд дараах асуултуудыг асуу:

1. Хэн нэгний төлөө та нарын сүүлчийн удаа хийсэн нинжин сэтгэлийн үйл юу вэ?
2. Нэг хүн өөр нэг хүний тухай найрсаг бусаар ярихыг сонссон үед та нар яадаг вэ?
3. Найз нараа илүү сайн хүмүүс байхад нь туслахын тулд та юу хийсэн бэ?

“Миний дотор цэвэр ариун зүрх сэтгэлийг бий болгооч”

Хичээл
24

2 Самуел 11–12; Дуулал 51

Зорилго Бодол санаа, үйл ажиллагаандаа цэвэр ариун байж, нүглүүдээ наманчлахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмжих.

- Бэлтгэл**
1. Дараах судруудыг залбирч судал:
 - а. 2 Самуел 11. Давид Уриагийн эхнэр Батшебатай садар самуун үйлдэв (11:1–5). Нүглээ нуух гэсэн Давидын оролдлого бүтэлгүйтэв (11:6–13). Тэрээр Уриаг тулалдаанд үхэхээр зохион байгуулав (11:14–17). Давид Батшебатай гэрлэж, тэд хүүтэй болов (11:26–27).
 - б. 2 Самуел 12:1–23. Бошиглогч Натан нэг сургаалт зүйрлэлийг Давидад ярьснаар Давидын нүглийн ноцтойг заажээ (12:1–6). Нүглийнхээ улмаас тэр шийтгэгдэх болно гэдгийг Давидад хэлэв (12:7–14; Иосеф Смитийн Орчуулга, шүлэг 13-т, “Их Эзэн чамайг үхэх хүртэл нүглийг чинь зайлуулахгүй” гэж мэдэгсэнийг анхаар). Давид, Батшеба хоёрын ууган хүү нялхдаа нас баржээ (12:15–23).
 - в. Дуулал 51. Наманчлагч Давид өршөөл эрэлхийлэв.
 2. Нэмэлт уншлага: 2 Самуел 2–10.
 3. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашиглах бол, дамартай утас, хайч авчир.

Энэ хичээлийг заах зөвлөмж

Анхаарал
төвлөрүүлэх
үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагааг (эсвэл өөрийхөө нэг үйл ажиллагааг) ашиглахыг хүсч болно.

Ангийн өмнө нэг гишүүнийг сайн дураар нь гаргаж, гарыг нь урагш сунган зогсоо. Түүний хоёр бугуйг хэсэг утсаар сулавтар ороож уя. Энэ утас цэвэр ариун биш санаа бодлыг төлөөлж байгааг тайлбарла. Тэгээд хоёр гараа гадагш нь огцом тэлэх замаар ангийн гишүүнээр утсыг тасдуул.

- Цэвэр ариун биш бодол санаа бидний оюунд орж ирэхэд бид яах ёстой вэ? (Бид үүнийг тэр даруйд дотроосоо зайлуулах ёстой.)

Гараа дахин сунгахыг ангийн гишүүнээс хүс. Түүний бугуйг нилээд хэдэн утсаар, таслахад илүү хэцүү байхаар ороож уя. Тэгээд утсыг таслахыг оролд гэж ангийн нөгөөх гишүүнээс хүс. Утсыг таслах нь боломжгүй болтол ангийн гишүүний бугуйг бөх ороож уяа хүртэл энэ үйл явцыг давт.

- Цэвэр ариун биш бодол санааг бид оюундаа байлгахыг хүлцвэл юу тохиолдох вэ?

Утсыг хайчаар хайчилж, ангийн гишүүний гарыг сулла. Цэвэр ариун биш бодол санаа өсөн нэмэгдэхийн хор уршгийг энэ хичээл авч үзэж байгааг тайлбарла. Энэ хичээл бас бид өөрсдийгөө цэвэр ариун биш санаа бодлоос ангижруулах арга замын талаар өгүүлдэг.

Судрын ярилцлага
ба хэрэглээ

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагауудаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж. Энэ хичээл дэх бүх асуултыг асуух буюу юм бүхнийг хамруулан заах нь хэцүү байж болох учраас ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох зүйлүүдийг залбиралтайгаар сонго. Та зарим асуултуудыг ангийн гишүүдийн нөхцөл байдалд тохируулан хялбаршуулж болно.

1 Самуел 25-аас 2 Самуел 10 нь энэ хичээлийн түүхийн талын тухай чухал мэдээллээр хангадаг. Эдгээр бүлгүүд энэ гарын авлагад ороогүй учраас та тэдгээрийг доорх байдлаар хураангуйлан нэгтгэж болно:

Давид Саулын амийг аварснаас хойш удалгүй Саул Давидын амийг хөнөөхийг бас дахин нэг оролдоод үзжээ. Хааныг алчих боломж Давидад бас дахин олдсон хэдий ч, тэрээр үүнээс татгалжээ. Иудей болон түүнийг тойрон хүрээлэгч үндэстнүүдийн хооронд дайн тулалдаанууд үргэлжилсээр байлаа, тийнхүү Саул, Ионатан хоёр эдгээр тулалдаануудын нэгэнд алагдав. Давид хаан болж Саулыг залгамжлан Израилын түүхэн дэх хамгийн агуу хаадын нэг болжээ. Тэрээр овгуудыг нэг үндэстэн болгон нэгтгэж, өөрийнх нь хүмүүст амлагдсан нутгийн эзэмшлийг баттай болгож, Бурханы хуулинд тулгуурласан засгийн газар байгуулжээ. Гэвч түүний амьдралын сүүлчийн 20 жил энэ хичээлд өгүүлэгдсэн нүгэлт шийдвэрүүдээр сэвтсэн ажээ.

1. Давид Батшебатай садар самуун үйлдэж, улмаар Батшебагийн нөхөр Уриагийн үхлийг зохион байгуулав.

2. Самуел 11-ийг зааж, ярилц.

- Давид дээвэр дээгүүрээ явж байгаад Батшебаг харж, тэгээд түүнтэй садар самуун үйлдэхэд уруу татагджээ (2 Самуел 11:2). Давид Батшебаг хараад яах ёстой байсан бэ? Түүнтэй нүгэл үйлдэхэд түүнийг хөтөлсөн юуг Давид үйлдсэн бэ? (2 Самуел 11:2–4) Бэлгийн харилцааны нүгэл үйлдэхэд уруу татагдах нь хүмүүсийг юунд хөтөлж болох вэ? Бэлгийн харилцааны нүгэл үйлдэхэд уруу татагдахаас зайлсхийхийн тулд бид юу хийж болох вэ?

Та ангийн гишүүдийн хариултуудыг доорх схемийг ашиглан самбар дээр жагсаан бичиж болно. Дараах зүйлүүд хариултууд байж болно:

Зайлсхийх зүйлүүд	Эдгээрээс яаж зайлсхийх вэ
Цэвэр ариун бус буюу ёс суртахуунгүй бодол санаа	Өөдрөг санаа бодлуудаар оюунаа дүүргэ.
Порнографийн буюу аль нэг талаараа порнографийн агуулгатай телевизийн үзүүлбэрүүд, кинонууд, сэтгүүлүүд, номнууд болон хөгжим	Сайныг үйлдэхэд танд сүнслэгээр нөлөөлөх олон нийтийн мэдээллийн хэрэгслийг сонго.
Эрүүл бус болзох үйл ажиллагаанууд	Хожмын үеийн бошиглогчдын заадаг болон <i>Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө</i> томхимолд томъёологдсон болзох жишгүүдийг баримтал.
Гэрлэлтийн дараа сээтэгнэх	Эхнэр буюу нөхрөө бүх зүрх сэтгэлээрээ хайрла. Эхнэр буюу нөхөртэйгөө “ойр дотно” хамтран ажилла (харилцаагаа улам бэхжүүлэн хөгжүүл).
Ариун Сүнсний байнгын нөхөрлөлтэй байх боломжийг танд олгохгүй газрууд буюу үйл ажиллагаанууд	Та нарын очдог газрууд, оролцдог үйл ажиллагаанууд Ариун Сүнсстэй байнга нөхөрлөх боломжийг та нарт олгодог байхад анхаар.

Цэвэр ариун бус бодол санаануудыг зайлуулах арга замуудыг ярилцахын тулд та эхний нэмэлт заах санааг ашиглаж болно.

- Батшеба хүүхэдтэй гэдгийг дуулаад Давид юу хийх гэж оролдсон бэ? (2 Самуел 11:6–13. Батшебагийн нөхөр Уриаг эхнэрийнхээ араас гэр рүү нь явуулах гэж тэрээр оролджээ. Төрөөгүй хүүхэд нь Уриагийнх болох нь мэдэгдэв) Давидын төлөвлөгөө яагаад бүтээгүй вэ? (2 Самуел 11:11-ийг үз. Уриа тулалдааны талбар дахь нөхөлдөө үнэнч байсан учраас тэрээр тэдэнтэй хамт байх ёстой гэж бодсон учраас гэр рүүгээ яваагүй ажээ.)
- Давид өөрийн ёс суртахуунгүй явдлыг нуух гэж оролдохдоо өөр ямар ноцтой нүгэл үйлдсэн бэ? (2 Самуел 11:14–17-г үз) Давид хэнээс нүглээ нууж чадна гэж бодож байсан гэж та нар бодож байна? Өнөөдөр хүмүүс яаж нүглээ нуухыг хичээдэг вэ? Бид нүглээ нуухыг хичээсэн үед юу тохиолддог вэ?

Ахлагч Ричард Г.Скотт хэлэхдээ:

“Өөрсдийнхөө зөрчлүүдийг бусад хүмүүс мэдээгүй гэдгээр бүү тайвшир. Энэ бол тэмээн хяруул толгойгоо элсэнд нуудагтай адилхан юм. Тэрээр зөвхөн харанхуйг харж, нуугдсан байхдаа ая тухыг мэдэрдэг. Бодит байдалд бол тэр инээд хүрэм илээс ил байдаг. Яг үүнчлэн бидний үйлдэл бүрийг Тэнгэр дэх бидний Эцэг болон Түүний Хайртай Хүү харж байдаг. Бидний тухай юм бүгдийг тэд мэддэг. . . .

“Хэрэв та ноцтой зөрчил гаргасан бол, үйлдсэн тэр зүйлдээ сэтгэл ханамж, тайтгарлыг урт удаан хугацаанд олж эс чадна. Уучилж болох зөрчлийг арилгаснаар асуудлыг зохицуулж болох хэдий ч, ингэдэггүй. Уруу татагч таны хамгийн ичгүүртэй үйлдлийг хамгийн эмзэг цагт нийтэд дэлгэн мэдүүлэх санаа өвөрлөж байдаг. Худал хуурмаг зүйл илүү ихээр

хязгаарлагч загвар болон сүлжилдэж, Сатан таныг хохироон барьж авахаар үсрэх хавх болдог” гэжээ (Conference Report, 1995 оны 4-р сар, 103; *Ensign*, 1995 оны 5-р сар, 77).

Бид нүглүүдээ нуухаар оролдохын аюулыг харуулахын тулд та хоёр дахь нэмэлт заах санааг ашиглаж болно.

2. Нүглийнхээ улмаас тэрээр шийтгэгдэх болно гэдгийг Давидад хэлжээ.

2 Самуел 12:1–23-ыг зааж, ярилц.

- Их Эзэн Давидад хэрхэн дургүйцсэнийг харуулахын тулд бошиглогч Натан ямар сургаалт зүйрлэл ярьсан бэ? (2 Самуел 12:1–4-г үз). Уг сургаалт зүйрлэл дэх ядуу хүний эсрэг баян хүний үйлдлүүдийн талаар Давид юу бодсон бэ? (2 Самуел 12:5–6-г үз) Давидын үйлдлүүд баян хүнийхтэй хэрхэн адилхан байсан бэ? (2 Самуел 12:7–9) Давид Их Эзэний зэмлэлд яаж хариу үйлдэл үзүүлсэн бэ? (2 Самуел 12:13-ыг үз)
- Сургаалт зүйрлэлд Давид баян хүнийг төлөөлснөө яагаад мэдээгүй гэж та нар боддог вэ? Яагаад бид зарим үед өөрсдийнхөө нүгэлт байдлыг мэдэх чадваргүй байдаг вэ?
- Давидын нүглүүдийн үр дагаврууд юу байсан бэ? (2 Самуел 12:10–14-ийг үз. Эдгээр бошиглоуудын гүйцэлдэлт 2 Самуелын шүлэг 15–23 болон удаах шүлгүүд Хаадын Дээд; мөн тэрчлэн С ба Г 132:39-д байдаг. Садар самууныг үйлдэх нь ноцтой нүгэл гэдгийг, гэвч Давид Уриаг алсны төлөө хариуцлага хүлээнэ гэж Их Эзэн хэлсэн учраас тэрээр өргөмжлөлөө алдсаныг анхаар)

Ерөнхийлөгч Марион Г.Ромни хэлэхдээ: “Давид, . . . хэдийгээр Их Эзэний өндөр ээл хишгийг хүртсэн ч гэсэн (тэр бол Бурханы өөрийнх нь зүрх сэтгэлийн дагуух хүн байв), уруу таталтад автагдсан ажээ. Түүний ариун бус явдал аллага уруу хөтөлж, үүний уршгаар тэрээр гэр бүлээ болоод өргөмжлөлөө алдсан юм” гэжээ (Conference Report, 1979 оны 4-р сар, 60; *Ensign*, 1979 оны 5-р сар, 42).

- Өнөө үед ёс суртахуунгүй байдлын зарим шууд үр дагавар юу вэ? Наманчилдаггүй хүний хувьд урт хугацааны зарим уршиг нь юу вэ?

3. Наманчлагч Давид өршөөл эрэлхийлсэн нь.

Дуулал 51-ийг зааж, ярилц.

Давид Их Эзэнд өргөсөн дуулалд, наманчлахад нь бусдад туслах хүслээ илэрхийлж, “Би зөрчигчдөд таны замуудыг заах [болно]; тэгээд нүгэлтнүүд Тань уруу буцаж эргэх” (Дуулал 51:13) Давид Уриагийн үхлийг зохион байгуулсан учир тэрээр өргөмжлөлөө алдсан хэдий ч, садар самуун үйлдсэн нүглийнхээ төлөө өршөөл эрэлхийлсэн түүний наманчлагч санаа бодлоос бид сурч болно. Дуулал 51 дэх түүний үгс үнэн наманчлалын олон талыг заадаг. Та уг дууллыг ангийн гишүүдтэй хамт судлахдаа Давидын наманчлагч үлгэр жишээг бид амьдралдаа хэрхэн хэрэглэж болох тухай ярилц.

- Дуулал 51-д Давид анх удаа Бурхан хийгээд Түүний нигүүлслийг танин мэджээ (Дуулал 51:1). Давид бас өөрийнхөө нүгэлт байдлыг хүлээн зөвшөөрсөн ажээ (Дуулал 51:1–3). Бид нүглээ наманчлахдаа яагаад Бурханы аугаа их чанарыг болон өөрсдийн нүглийг хүлээн зөвшөөрөх нь чухал вэ?

- Нүглүүдээ уучлалыг хүлээн авахын тулд бид ямар золиослол хийх ёстой вэ? (Дуулал 51:16–17-г үз) “Харууссан бөгөөд гэмшсэн зүрхтэй” байх гэдэг нь ямар утга учиртай гэж та нар боддог вэ?
- Бид өршөөгдөхөөс өмнө хэрхэн бидний нүглүүд “үргэлж [бидний] өмнө” байдаг вэ? (Дуулал 51:3) Биднийг өршөөгдсөний дараа ямар өөрчлөлт гардаг вэ? (Дуулал 51:10; Алма 36:17–19-ийг үз) Бурхан биднийг өршөөснийхөө дараа бидний өнгөрсөн үеийн нүглүүдийг хэрхэн үздэг вэ? (Дуулал 51:9; Исаиа 43:25; С ба Г 58:42-ыг үз)
- Уучлалыг Давид цэвэршүүлэлт (Дуулал 51:1–2, 7, 9–10-ыг үз), сэргээлт (Дуулал 51:12), түүнчлэн чөлөөлөлт гэж дүрсэлсэн байдаг (Дуулал 51:14). Адислалын эдгээр дүрслэлүүд яагаад Бурханы өршөөл байдаг вэ?

Дүгнэлт

Бид хичнээн амжилттай буюу хүч чадалтай байж болох ч гэсэн, уруу таталтаас дээгүүр байдаггүй. Бодол санаа үйл ажиллагаандаа цэвэр ариун байхад нь тэдэнд туслах зайлшгүй шаардлагатай аливаа өөрчлөлтүүдийг амьдралдаа хийхэд нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж. Есүс Христийг хайрлах хайраа болон түүний Цагаатгалын төлөөх талархлаа илэрхийл. Цагаатгалын улмаас бид нүглүүдээ өршөөгдөж болно гэдгийг гэрчил.

Нэмэлт заах санаанууд

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

1. Бузар муу бодлуудыг оюун санаанаасаа зайлуулах нь

Бидний оюун санаанд урилгагүйгээр орж ирсэн бузар муу бодлуудыг хэрхэн зайлуулах тухай Ахлагч Бонд К.Пакерын дараах мэдэгдлийг өөрийнхөө үгээр хуваалц:

“Оюун санаа бол тайзтай адилхан юм. Хэрэв бид унтаж байгаа л биш бол, хөшиг үргэлж нээлттэй байдаг. Уг тайзан дээр жүжиг үргэлж тавигдаж байдаг. Энэ нь инээдмийн жүжиг байж болно, эмгэнэлт жүжиг байж болно, сонирхолтой буюу уйтгартай, сайн буюу муу байж болно; харин оюун санааны тайзан дээр жүжиг үргэлж тавигдаж байдаг.

“Та нарын хувьд аливаа бодит санаа бодолгүйгээр, бараг л бүх тоглолтын дундуур, бяцхан шударга бус бодол хажуугаас зүрсхийн орж ирэн, анхаарлыг чинь татдагийг та нар ажигласан уу? Эдгээр уршигт бодлууд хүн бүрийг тайзан дээр гаргах гэж оролдох болно. Хэрэв та тэдгээрт цааш ахих боломж олгох юм бол, ариун журмын аливаа бодлууд тайзыг орхин алга болно. Та үүнд, зөв шударга бус бодлуудын нөлөөнд зөвшөөрөл олгосон учраас, таныг орхин одох болно.

“Хэрэв та тэдгээрт бууж өгөх юм бол, тэдгээр нь таны өмнөөс, таны оюун санааны тайзан дээр, тэвчээрийн чинь хязгаар уруу нэвтрэх тоглолт хийх болно. Эдгээр нь гашуун хоронгийн, атаа жөтөөний, тэрчлэн үзэн ядалтын сэдвээр таныг жүжиг тавиулж болно. Энэ нь бүдүүлэг, ёс суртахуунгүй, тэр ч байтугай, бузар булай байж болдог. Та тэдгээрт боломж олгож, тайзан дээр гаргах юм бол, тэдгээр нь таны анхаарлыг татах хамгийн үнэмшилтэй нотолгоо мэт санагдах болно. Эдгээр нь үүнийг сонирхолтой, дажгүй сайн

болгож, тэр ч байтугай, энэ бол гэм хоргүй, зүгээр л бодол шүү дээ хэмээн ятгаж чадна.

“Оюун санааны чинь тайз бузар муу бодлын бяцхан буг чөтгөрөөр эзлэгдсэн үед, энэ нь бараг цэвэр ариун мэт саарал ч байна уу, эргэлзээнд зай үлдээхээргүй бузар бусармаг ч байна уу, ялгаагүй ийм үед та нар яадаг вэ? Хэрэв та өөрийнхөө бодлуудыг хянаж чаддаг бол, та дадал зуршлуудаа, тэр ч байтугай хувийн муу дадал зуршлуудаа даван туулж чадна. Хэрэв та тэдгээрийг захирч сурах юм бол, аз жаргалтай амьдрал танд байх болно.

“Энэ бол та нарт миний заахыг хүссэн зүйл. Сүмийн ариун хөгжмийн дотроос үг нь сэтгэл санааг өргөгч, хүндэтгэлтэй, сүнслэг нөлөөг мэдрэхэд та нарыг хөтөлдөг дуртай дууллаа сонго. Үүнийг оюун ухаандаа сайтар тунгаан бод. Дууллыг цээжил. Та бүр хөгжмийн боловсролгүй байж болох ч гэсэн, дууллаар дамжуулан тунгаан бодож чадна шүү дээ.



“Эдүгээ, бодлууд тань очих байр болгон энэ дууллыг ашигла. Үүнийг эрч хүчнийхээ суваг болго. Оюун санааны чинь тайзанд эдгээр зохисгүй бодлууд хажуугаас орж ирснийг мэдсэн үедээ та үүний бичлэгийг тавьж сонс. Хөгжим эхлэнгүүт үгийг нь оюун санаандаа дүрслэн бод, зохисгүй бодлууд ичгүүрийг дагуулан арилгах болно. Энэ нь таны оюун санааны тайзан дээрх бүх байдлыг өөрчлөх болно. Энэ нь сэтгэл санааг өргөгч хийгээд цэвэр ариун учраас олиггүй бодлууд арилан алга болно. Учир нь сонголтоор бий болсон ариун журам бузар булай зүйлтэй нийцдэггүй бол, хилэнц нь гэрлийн дэргэд тэсч чаддаггүй.

“Зохих цагт та нар тодорхой үйл явдлаар, дотроо хөгжим аялан байгаагаа мэдрэх болно. Та бодлуудаа эргээд харахад, дэлхийн зарим нөлөө оюун санааны тань тайз уруу зохисгүй бодол нэвтрэхэд таныг түлхдэгийг, мөн энэ үед хөгжим бараг аяндаа эхэлдгийг та мэдэх болно.

“Та оюун санааныхаа тайзыг зохисгүй бодлуудаас цэвэрлэхийг нэгэнт мэдсэн учраас үүнийг үнэ цэнэтэй зүйлүүдээр дүүргэн, суралц. Сайн сайхан бөгөөд сэтгэл санаа өргөсөн зүйлүүд таны эргэн тойронд байж, сүнслэгээр нөлөөлж байхаар орчноо өөрчил. Зөв шударга зүйлүүдээр өөрийгөө завгүй байлга.” (Conference Report, 1976 оны 10-р сар, 99–100)

2. Нүглээ нуух гэж оролдохын аюул

Давид садар самууны нүглээ нуух гэж оролдсоноор бүр илүү их нүгэл үйлдсэн юм. Нүглээ нуух гэж оролдохын аюулын тухай ярилцахдаа, нүглийг овоолсон шороотой харьцуул. Энэ харьцуулалтыг доорх эхний зурагт харуулснаар самбар дээр зурж харуул.



- Хэрэв бид овоолсон багахан шороог нуух гэж оролдвол юу болох вэ? (Тэгвэл овоолсон жижиг шороо улам том болж, бүр илүү тод харагдах болно. Энэ харьцуулалтыг дээрх хоёр дахь зурагт харуулснаар зурж харуул.)
- Бид нүглээ нуух нь овоолсон шороог булахтай хэрхэн адилхан бэ? (Бид нүглээ нуух гэж оролдоход бидний нүгэл илүү их, илүү ноцтой болдог)
- Хэрэв хүмүүс овоолсон шороог харахгүй байхыг бид хүсвэл, бид юу хийх ёстой вэ? (Бид овоолсон шороог булахын оронд үүнийг зөөж зайлуулах ёстой.) Бид нүглийг амьдралаасаа яаж зайлуулах вэ?

3. “Дараа нь Аммон түүнийг маш ихээр үзэн ядав” (2 Самуел 13:15)

2 Самуел 13 Давидын хүү Аммон, Давидын охин Тамар хоёрын тухай түүхийг агуулдаг. Аммон Тамарт сэтгэл нь татагдаж, өөртэйгөө завхайрахад түүнийг албадав.

- 2 Самуел 13:1-т Аммон Тамарт хайртай болсон тухай өгүүлдэг. Аммон түүний эсрэг нүгэл үйлдсэний дараа Тамарын талаарх түүний бодол санаа хэрхэн өөрчлөгдсөн бэ? (2 Самуел 13:15) Яагаад хайр биш, үзэн ядалт ёс суртахууны зарчмуудыг зөрчдөг хүмүүсийн хооронд олонтаа үүсэн бий болдог вэ?

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хэлэхдээ: “Ёс суртахууны зарчмуудыг зөрчдөг залуу эрэгтэй, залуу эмэгтэй хоёр удалгүй бие биенээ үзэн ядаж, төгсгөлд хүрдгийг би ажиглаж мэдсэн гэж Ахлагч Жон А.Видцоу . . . хэлснийг би сонссон. Яг ийм зүйлийг би ажигласан. Хайрын үгсээр эхэлсэн байж болдог, гэвч хожим нь уур хилэнгийн хийгээд гашуун хоронгийн үгс гарч ирэх болно” гэжээ (“True to the Faith,” *Ensign*, 1996 оны 6-р сар, 5).

4. Наманчлагчийн төлөөх найдвар

Хэрэв та наманчлах нь хэзээ ч оройтдоггүйг онцгойлон анхаарах ном бол, Ахлагч Боид К.Пакерын дараах мэдэгдлийг хуваалцаж болно:

“Алдаа (цуврал алдаанууд ч гэсэн) гаргасан л бол үүнийг наманчлах буюу уучлах нь ямагт хэтэрхий оройтсон байдаг гэдэг гутрангүй үзэл санаа Их Эзэнээс ирдэггүй. Хэрэв бид наманчлах ном бол, Тэр бидний зөрчлүүдийг зөвхөн өршөөх төдийгүй, бас Тэр тэдгээрийг мартаж, бидний нүглүүдийг дахин санахгүй гэж Тэр хэлсэн билээ. . . . Наманчлал бол саван лугаа адил ном; энэ нь нүглийг угаан арилгадаг. Хувцасны гүнд шургасан хирийг угааж арилгахын тулд хүчтэй угаагч бодис хэрэглэх шаардлагатай боловч, тэдгээр нь ил гарч ирдэг.” (Conference Report, 1989 оны 4-р сар, 72; *Ensign*, 1989 оны 5-р сар, 59)

Зорилго

Аврагчийн төлөө түүнчлэн Тэр болон бидний Тэнгэрлэг Эцэг бидэнд өгсөн олон адислалын төлөө талархлаа харуулахад нь ангийн гишүүдэд туслах.

Бэлтгэл

1. Хичээл дээр ярилцсан судруудыг, түүнчлэн Дууллын номноос өөрсдийн боломжийн хэрээр аль болох ихийг залбирч, судал.
2. Хичээлийг судалж, ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох судрууд, сэдвүүд болон асуултуудыг залбиран сонго. Энэ хичээл Дууллын номыг бүгдийг нь хамрахгүй. Харин энэ нь уг номыг бүхэлд нь хамарсан чухал сэдвүүдээс хэдийг нь үздэг.
3. Хэрэв та эхний анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашиглах бол, Аврагчийн нэг зураг, түүнчлэн судрууд, өөрийн нэг хайртай хүний зураг, өөрийнхөө авьяасыг харуулсан ямар нэг юм, эсвэл нэг хүнсний зүйл зэрэг өөрөө талархалтай байдаг дөрөв юм уу таван юм авчир. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх хоёр дахь үйл ажиллагааг ашиглах бол, дуртай нэг дууллаа хуваалцаж, уг дуулал яагаад түүний хувьд чухал болохыг ярихаар бэлтгэхийг ангийн нэг буюу хоёр гишүүнээс хүс.
4. Нэг буюу түүнээс дээш ариун сүмийн зураг авчир.

Энэ хичээлийг заах зөвлөмж

Анхаарал
төвлөрүүлэх
үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагааг (эсвэл өөрийнхөө нэг үйл ажиллагааг) ашиглахыг хүсч болно. Ангийн хувьд хамгийн тохиромжтой үйл ажиллагааг сонгож ав.

1. Аврагчийн зургийг үзүүлж, түүний амьдрал, үүрэг зорилгын төлөө талархлаа илэрхийл. Та өөрөө тэдгээрийн төлөө талархалтай байдаг бусад зүйлүүдийг төлөөлсөн юмсыг үзүүл. Тэдгээрийн тус бүрийнх нь төлөө нэг бүрчлэн талархлаа илэрхийл. Тэгээд дараах асуултуудыг асуу:
 - Их Эзэнээс ирсэн ямар бэлгүүд хийгээд боломжуудын төлөө та нар онцгой талархалтай байдаг вэ? Эдгээр адислалууд байхгүй байсан бол таны амьдрал хэрхэн өөр байж болох байсан бэ?Дууллаадаас олон нь Их Эзэний өгсөн адислалуудын төлөө талархал илэрхийлдгийг тайлбарла. Энэ хичээлийн нэг хэсэг нь тэдгээр адислалуудын төлөө бид талархлаа хэрхэн харуулж болоход анхаарал төвлөрүүлдэг.
2. Дуулал 23-ыг чанга уншихыг ангийн нэг гишүүнээс хүс. Тэгээд дараах асуултуудыг асуу:
 - Энэ дуулалд ямар бодлууд илэрхийлэгдсэн байна бэ? Үүнийг уншихад буюу сонсоход та нарт ямар бодол төрдөг вэ?

Дуртай дууллаа хуваалцахыг болон энэ нь яагаад тэдний хувьд чухал ач холбогдолтойг ярихыг урьдчилан даалгавар авсан ангийн нэг буюу хоёр гишүүнээс хүс.

Судрын ярилцлага
ба хэрэглээ

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагауудаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

Дууллын ном бол Бурханд өргөх магтуу хийгээд гуйлт болон анх дуулагдаж байсан яруу найргийн түүвэр юм гэдгийг тайлбарла. Ихэнхийг нь Давид бичжээ. Энэ ном эртний Израилын сүмийн дууллын түүвэртэй адил юм. Үүний утга уянгын зохиолууд нь Их Эзэнд итгэх итгэл хийгээд зөв шударгаар амьдрах чин хүслийг илэрхийлсэн, сүнслэг нөлөө бүхий дэлхийн шилдэг зарим уран зохиолын бүтээл юм.

1. Есүс Христийн амьдрал, үүрэг зорилгын тухай бошиглолууд

Олон дуулал Мессиа болох Христийн үүрэг зорилгын тухай бошиглодог. “Мосегийн хууль, түүнчлэн бошиглогчид болоод Дуулал дахь, миний тухай бичигдсэн бүхэн биелэгдэх ёстой” (Лук 24:44) гэж амилсан Аврагч мэдэгджээ. Дууллын номонд бичигдсэн Христийн тухай дараах нилээд бошиглолын биелэлтийн тухай ярилц:

Бошиглол *Биелэлт*

Дуулал 107:23–30	Матай 8:23–27. Есүс шуурга болон тэнгисийн давалгааг намжаав.
Дуулал 69:8	Иохан 1:11; 7:5. Өөрийнх нь хүмүүс Есүсийг хүлээн авсангүй.
Дуулал 41:9; 55:12–14	Иохан 13:18, 21. Нэг найз нь Есүсээс урвав.
Дуулал 69:20	Марк 14:32–41. Есүс Гетсеманид ганцаар зовов.
Дуулал 22:7–8	Матай 27:39–43. Есүсийг шоолон доромжлов.
Дуулал 22:16	Марк 15:25. Есүс цовдлогдов.
Дуулал 22:18	Матай 27:35. Цэргүүд Христийн хувцасны төлөө шодоцгоов.
Дуулал 22:1	Матай 27:46. Эцэг нь яагаад өөрийг нь орхисныг Есүс асуув.
Дуулал 69:21	Иохан 19:28–30. Цангасан Есүст цуу өгөв.
Дуулал 34:20	Иохан 19:33–36. Есүсийн ясыг хугалсангүй.
Дуулал 31:5	Лук 23:46. Есүс сүнсээ Эцэгт даатгаад, наснаас халив.
Дуулал 16:10	Үйлс 2:31–32; 13:34–35. Аврагчийн махан бодь ялзралыг үзэлгүй, Амилалтад босч ирэв.

- Есүс Христ бол төрөлт, амьдрал, үхэл хийгээд амилалт нь түүнийг төрөхөөс өмнө бошиглогдсон цорын ганц хүн юм. Яагаад Аврагчийн амьдралын тухай тийм нарийн тодорхой бошиглогдсон гэж та нар боддог вэ? (Есүс бол амлагдсан Мессиа, дэлхийн Аврагч байсныг эдгээр бошиглолууд тодорхой харуулсан юм.) Эдгээр бошиглолуудыг хүлээн авсан хүмүүст тэдгээр нь хэрхэн адислал болсон бэ? (Эдгээр бошиглолууд бүр түүнийг төрөхөөс өмнө Аврагчийн тухай мэдэж, түүний тухай гэрчлэлтэй болоход нь хүмүүст тусалсан юм [Мозая 3:13-ыг үз]. Уг бошиглолууд түүнийг ирсэн үед танихад нь зарим хүмүүст бас тусалжээ.)

2. “ЭЗЭН чамд их өгөөмөр хандсан юм” (Дуулал 116:7)

Аврагчийн амьдрал, үүрэг зорилгыг бошиглохоос гадна олон дуулал нь тэнгэр ба газрын бүтээлт, Аврагчийн нигүүлсэл, өршөөл, хайр, судрууд болон ариун сүм зэрэг адислалуудын төлөө талархал илэрхийлдэг.

Тэнгэр ба Газрын бүтээлт

Тэнгэр ба газрыг бүтээснийх нь төлөө Их Эзэнд талархал илэрхийлдэг дараах дуулуудын тухай ярилц:

Дуулал 19:1

Дуулал 104:5–7, 14, 24

Дуулал 136:3–9

- Тэнгэр, газрын бүтээлт Бурханы хүч хийгээд хайрыг хэрхэн гэрчилдэг вэ? (Алма 30:44; Мосе 6:63-ыг үз) Бүтээлтийн бэлгийн төлөө бид талархлаа хэрхэн харуулж болох вэ?

Аврагчийн нигүүлсэл, өршөөл хийгээд хайр

Нигүүлсэл, өршөөл хийгээд хайрынх нь төлөө Аврагчид талархал илэхийлдэг дараах дуулуудын заримынх нь тухай ярилц:

Дуулал 23 (Хэрэв та энэ дууллыг анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаанд ашигласан бол үүний тухай ярилцах хэрэггүй байж болно.)

Дуулал 51 (Хэрэв та энэ дууллыг хичээл 24-т ашигласан бол үүний тухай ярилцах хэрэггүй байж болно.)

Дуулал 59:16

Дуулал 78:38

Дуулал 86:5, 13

Дуулал 100:4–5

Дуулал 103:2–4, 8–11, 17–18

- Эдгээр дуулуудаас бид Их Эзэний тухай юу мэдэж болох вэ? Их Эзэний нигүүлсэл, өршөөл хийгээд хайрын тухай тэд хэрхэн мэдсэн тухай яриулахаар ангийн гишүүдийг урь.
- Дуулал 51 дэх өршөөлийн тухай Давидын гуйлт та нарт ямар сэтгэгдэл төрүүлдэг вэ? Энэ дуулал наманчлал болон өршөөлийн (уучлал) тухай бидэнд юу заадаг вэ? (шүлэг 2, 7, 12 дахь “намайг угаагаач”, “намайг цэвэршүүлээч”, “надад сэргээж өгөөч” гэсэн үгсийг анхаар. Эдгээр үгс наманчлалын чухал талуудыг дүрсэлдэг. Тэрчлэн шүлэг 17 дахь “эмтэрсэн, гэмшдэг зүрх” гэдэг үг бид үнэнхүү наманчлах ёстой нөхцөлийг дүрслэн харуулдаг.)

Судрууд

Судруудын төлөө Их Эзэнд талархал илэрхийлдэг дараах дуулуудын тухай ярилц:

Дуулал 19:7–11

Дуулал 119

- Давид судруудыг дүрслэхийн тулд Дуулал 19:7–10-г ямар үгс ашигласан бэ? (Судрууд дахь утга адил үгст *хууль*, *гэрчлэл*, *тушаал*, *зарлиг*, *шүүлтүүд* багтана. Судруудыг дүрсэлсэн тэмдэг нэрүүдэд *төгс*, *баттай*, *зөв*, *цэвэр*, *үнэн*, *зөвт* гэсэн үгс багтана. Түүнчлэн судруудыг алтнаас илүү хүсүүштэй, зөгийн балнаас илүү чихэрлэг хэмээн дүрсэлсэн байдаг.)

- Дуулал 19:7–11-д цэдэглэгдсэнээр судрууд бидний амьдралд ямар адислалууд авчирч болох вэ? Та эдгээр адислалуудыг самбар дээр жагсаан бичиж болно:
 - а. Тэдгээр нь бидний сэтгэлийг сэргээдэг (шүлэг 7).
 - б. Тэдгээр нь гэнэнийг ухаантай болгодог (шүлэг 7).
 - в. Тэдгээр нь бидний зүрхийг баярлуулдаг (шүлэг 8).
 - г. Тэдгээр нь бидний нүдийг нээж өгдөг (шүлэг 8).
 - д. Тэдгээр нь бидэнд сануулга өгдөг (шүлэг 11).
- Эдгээр болон бусад байдлаар судрууд та нарын амьдралыг хэрхэн адисалсан бэ?
- “Өө, Таны хуулийг би ямар их хайрладаг вэ! Тэр нь бүх өдөржингөө миний бясалгал байдаг” хэмээн Дууллыг зохиогч Их Эзэнд хандан дуу алдсан байдаг (Дуулал 119:97; мөн түүнчлэн шүлэг 15–16, 33–35, 40, 47–50, 72, 92, 104, 174). Судруудыг хайрлах ийм хайрыг бид хэрхэн хөгжүүлж чадах вэ?
- Судрууд хэрхэн “[бидний] хөл дэх дэнлүү, [бидний] зам дахь гэрэл байдаг вэ”? (Дуулал 119:105).

Ариун сүм

Ариун сүмийн тухай дараах дууллаудаас заримыг нь ярилц. Эдгээр дууллаудыг ангийн гишүүд уншиж байх үед та нэг буюу хэд хэдэн ариун сүмийн зургийг үзүүлж болно:

Дуулал 5:7

Дуулал 15:1–3

Дуулал 24

Дуулал 27:4

Дуулал 65:4

Дуулал 84:1–2, 4, 10–12

Дуулал 122

Дуулал 134

- Эдгээр дууллаудаас бид ариун сүмийн тухай юу мэдэж болох вэ? Бид ариун сүмд явахад өөрсдийгөө бэлтгэх талаар юу мэдэж болох вэ?
- 3. “Надад өгсөн бүх ашиг тусынх нь төлөө би ЭЗЭНд юугаар хариулах билээ?” (Дуулал 116:12)**
- “Надад өгсөн бүх ашиг тусынх нь төлөө би ЭЗЭНд юугаар хариулах билээ?” хэмээн Давид Дуулал 116:12-т асуусан байдаг. Энэ асуултад Давид хэрхэн хариулсан бэ? Та Давидын мэдэгдэл бүрийг дор харуулснаар жагсаан бичиж болно:
 - а. “Би авралын аягыг өргөнө” (116:13).
 - б. “Би . . . ЭЗЭНий нэр дээр дуудна” (116:13).
 - в. “Өө, ЭЗЭН, би үнэхээр Таны зарц” (116:16).
 - г. “Танд би талархлын тахил өргөнө” (116:17).
 - д. “Би бүх ард түмнийх нь өмнө ЭЗЭНд тангарагласнаа биелүүлнэ, ЭЗЭНий өргөөний хашаанд би тангарагласнаа биелүүлнэ” (116:18–19).
 - Бид Давидын хариултуудыг Их Эзэнд өргөх талархлаа харуулахын тулд хэрхэн хэрэглэж болох вэ?

4. “ЭЗЭНд итгэ” (Дуулал 4:5)

- “Эзэнд итгэ” гэсэн нь Дууллын номон дахь хамгийн олон тохиолддог зөвлөгөөнүүдийн нэг юм (Дуулал 4:5; 5:11; 9:10; 18:2; 56:11; 62:8; 118:8–9). Бид итгэлээ Их Эзэнд хэрхэн хүлээлгэдэг вэ? Түүнд итгэснээр та нар хэрхэн адислагдсан бэ?

Дүгнэлт

Дууллауд Есүс Христийн бурханлиг үүрэг зорилгын тухай хүчирхэг гэрчлэлийг агуулдаг. Есүс Христ болон бидний Тэнгэрлэг Эцэг бидэнд өгсөн агуу адислалуудын тухай эдгээр дууллауд бас бидэнд сануулдаг. Мөн тэдгээр нь эдгээр адислалуудын төлөө бид хэрхэн талархал илэрхийлэх арга замуудыг санал болгодог.

Та Дууллын номны захиасыг хураангуйлан дүгнэхийн тулд сүүлчийн дууллыг (Дуулал 150) уншуулахаар ангийн гишүүдийг урьж болно. Магтаал, талархлын тухай өөрийнхөө гэрчлэлийг нэм.

Нэмэлт заах санаанууд

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

1. Хуучин Гэрээний дууллаудаар сүнслэгээр нөлөөлөгдсөн хожмын үеийн дууллауд.

Сүмийн дууллын номыг дууллаудын хожмын үеийн эн тэнцүү хувилбар хэмээн үзэж болно гэдгийг тайлбарла. Та Хуучин Гэрээний дууллаар сүнслэгээр нөлөөлөгдсөн хожмын үеийн нэг дууллыг ангийн гишүүдээр дуулуулж болно.

2. Дууллауд дуулснаас ирдэг адислалууд

- Манай хожмын үеийн дууллаудын зарим гол сэдэв юу вэ? (Хариултуудад Аврагч, Сүмийн гишүүд бидний үүргүүд, эцсээ хүртэл тэвчих, итгэл, гэр орон ба гэр бүл, хайр, номлолын ажил, залбирал, санваар, бошиглогчид, сайн мэдээний сэргээлт, ариун ёслол, үйлчлэл, тэвчих сорилтууд, Сион багтаж болно). Дууллауд дуулах нь биднийг хэрхэн адисалдаг вэ? (С ба Г 25:12-ыг үз)

Дууллауд дуулах нь биднийг адисалж болох дараах зарим арга замуудыг ярилц:

- а. Дууллауд бидний сэтгэл санааг өргөдөг.
 - б. Илүү зохистойгоор амьдрахад дууллауд бидэнд сүнслэгээр нөлөөлдөг.
 - в. Бидний адислалуудын талаар дууллауд бидэнд сануулдаг.
 - г. Их Эзэнд магтуу дуулах боломжийг дууллауд бидэнд олгодог.
 - д. Гэрчлэл хэлэх арга замыг дууллауд бидэнд олгодог.
 - е. Их Эзэнд өөрсдийгөө зориулахад дууллауд бидэнд тусалдаг.
 - ё. Сүнснийг мэдрэхэд дууллауд бидэнд тусалдаг.
 - ж. Тэнгэрлэг Эцэгтэйгээ илүү нийцтэй байхад дууллауд бидэнд тусалдаг.
3. Сайн мэдээг сурч, заахад дууллауд бидэнд тусалдаг.

Тэргүүн Зөвлөл хэлэхдээ:

“Сүнслэгээр нөлөөлөгдсөн хөгжим бол сүмийн цуглаануудын зайлшгүй чухал хэсэг юм. Дууллууд Их Эзэний Сүнсийг урьж, хүндэтгэлийн мэдрэмжийг бий болгон, гишүүд биднийг нэгтгэн, Их Эзэнд магтуу өргөх арга замаар биднийг хангадаг.

“Хамгийн агуу номлолуудын зарим нь дууллууд дуулснаар номлогддог. Дууллууд наманчлал болон сайн үйлүүд уруу биднийг өдөөж, гэрчлэл, итгэлийг төлөвшүүлэн, ядарч зүдэрсэн хүмүүсийг тайтгаруулан, уй гашуу бологсдыг тайвшруулж, эцсээ хүртэл тэвчихэд бидэнд сүнслэгээр нөлөөлдөг” гэжээ (*Hymns*, ix).

- Нилээд хэдэн дуулал “ЭЗЭНд баясалтайгаар хашгирагтун” хэмээн дуулах тухай өгүүлсэн байдаг (Дуулал 98:4; 100:1; мөн 66:1; 95:1–2-ыг үз). Сүмийн цуглаанууд дээр болон гэр орондоо дуулал дуулахыг илүү сайн ашиглах замаар бид үүнийг хэрхэн баяр хөөртэй, утга учиртай болгож чадах вэ?
- Сүүлчийн Зоог дээр Есүс болон түүний Төлөөлөгчид дуулал дуулж байсан ажээ (Матай 26:30). Дуулал дуулсан нь, өөрсдийнхөө өмнөх ажлыг гүйцэлдүүлэхэд бэлтгэхэд нь Есүс болон түүний Төлөөлөгчдөд хэрхэн тусалсан гэж та нар боддог вэ?
- Бошиглогч Иосеф Смит Картежийн шоронд хороогдох гэж байх тэр үедээ Жон Тейлороос өөрт нь дуулж өгөхийг хүсэж байжээ. Дуу дуулж өгсөн нь түүнд хэрхэн тус болсон гэж та нар бодож байна?

3. Дууллууд дахь яруу найргийн адил төстэй давталтууд

Дууллуудыг та нар судлах нь Давид болон бусад еврей яруу найрагчдын ашигласан яруу найргийн арга техникийг ойлгосноор баяжигдаж болно. Эдгээр арга техникүүдийн нэг нь адил төстэй давталт юм. Давталтын нэг нийтлэг шинж бол өөр өөр үгсээр нэг утга санааг давтах давталт юм. Ийм давталт аль нэг санааны утгыг өргөжүүлэх буюу эрчимжүүлдэг байна. Адил төстэй давталтын энэ төрлийн нэг жишээ бол адил санааг өөр өөр үгээр таван удаа илэрхийлсэн (“миний залбирлыг сонсооч”, “миний хашгиралт Танд хүрэг”, “надаас нүүрээ бүү нуугаач”, “над уруу чихээ хандуулаач”, “миний дуудах өдөр надад хурдан хариулаач”) Дуулал 102:1–2 юм. Давталт захиасыг хэрхэн эрчимжүүлж байгааг тэмдэглэн хэл.

Зорилго

Адислалуудаа ухаалгаар ашиглах болон ариун сүмд зохистойгоор ороход нь ангийн гишүүдийг урамшуулан дэмжих.

Бэлтгэл

1. Дараах судруудыг залбирч, судал:

- а. Хаадын Дээд 3:5–28. Соломон өөрийн эцэг Хаан Давидыг залгамжилж, Их Эзэнийг дагав. Ойлгогч зүрх сэтгэлээр адислагдахыг гуйсан Соломонд Их Эзэн үзэгдэв (3:5–9). Их Эзэн Соломоныг мэргэн ухаан, эд баялаг, алдар хүндээр адислав (3:10–15). Хоёр эмэгтэй нэг хүүхдийг Соломонд авчрахад тэрээр аль эмэгтэй нь хүүхдийн эх болохыг мэргэнээр тогтоон хэлэв (3:16–28).
- б. Хаадын Дээд 5–6; 7:1–12. Соломон Хаан агуу ариун сүмийн барилгын ажлыг чиглүүлэв (5–6). Тэрээр өөртөө ордон бариулав (7:1–12).
- в. Хаадын Дээд 8:22–66; 9:1–9. Соломон ариун сүмийг онцгойлон адисалж, израилчуудыг сүнсний болон цаг зуурын цэцэглэн хөгжилтөөр адислахыг Их Эзэнээс гуйв (8:22–53). Хүмүүс 14 өдрийн турш шүтэн бишрэв (8:54–66). Их Эзэн Соломонд дахин үзэгдэж, хэрэв тэд өөрт нь үйлчлэх юм бол израилчуудыг адислахаа, харин хэрэв тэд өөр бурхад уруу эргэх юм бол тэднийг зүхэхээр Их Эзэн амлажээ (9:1–9).
- г. Хаадын Дээд 10–11. Эд баялаг хийгээд мэргэн ухааныхаа улмаас Соломон улам алдаршсаар байв (10:1–13, 24–25). Тэр үлэмж баян чинээлэг болов (10:14–23, 26). Тэр хуурамч бурхдыг шүтэн бишрэхэд өөрийг нь ятгасан израил биш олон эмэгтэйтэй гэрлэжээ (11:1–10). Их Эзэн Соломоны эсрэг бэршээлүүдийг босгов (11:11–25). Соломоны ёс бусаас болж Израилын хаант улс хуваагдах болно гэдгийг нэг бошиглогч угтан хэлжээ (11:26–40).

2. Нэмэлт уншлага: Хаадын Дээд 2:1–12; 4:29–34; 7:13–51; Шастирын Дээд 29; Сургаал ба Гэрээ 46.

3. Эрт үед ашиглагдаж байсан ариун сүмийн зураг байдаг бол, та үүнийг хичээл дээр ашиглаж болно (62300; Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 118).

Энэ хичээлийг заах зөвлөмж

Анхаарал
төвлөрүүлэх
үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагааг (эсвэл өөрийхөө нэг үйл ажиллагааг) ашиглахыг хүсч болно.

Ахлагч Даллин Х.Өүксийн дараах мэдэгдлийг унших буюу ангийн нэг гишүүнээр уншуул:

“Бидний сул тал руу дайран довтлогч Сатаны талаар бид ерөнхийдөө боддог. . . . Гэвч сул тал бол бидний цорын ганц эмзэг зүйл биш. Бид

өөрсдийгөө хүчтэй гэж боддог тэр газруудаар—бид өөрсдийнхөө хүч чадалд бардамнадаг тэр газруудаар биднийг бас давтолж чадна. Бидний эзэмшдэг хамгийн агуу авьяас билгүүд хийгээд сүнсний бэлгүүдээр дамжуулан тэрээр бидэн рүү ойртон ирэх болно. Хэрэв бид хянуур болгоомжгүй байх юм бол, бидний хүч чадлаар дамжуулан биднийг ялзруулах замаар, мөн түүнчлэн бидний сул талуудыг ашиглах замаар Сатан биднийг сүнслэг байдлын хувьд уналтад хүргэж чадна.” (“Our Strengths Can Become Our Downfall,” *Ensign*, 1994 оны 10-р сар, 12)

- Бидний уналт болж мэдэх зарим хүч чадал юу вэ?

Энэ хичээл бол Бурханаас агуу бэлгүүд хүлээн авсан боловч, эцэстээ эдгээр бэлгүүдийг зөв шударга бусаар ашигласан Соломон Хааны тухай байх болно гэдгийг тайлбарла. Соломоныг алгуураар доройтоход хүргэсэн хэрэг явдлуудыг эрж хайхыг ангийн гишүүдэд санал болго. Бид түүнийг шүүмжлэхийн тулд биш, харин алдаанаас нь сургамж авахын тулд түүний алдааг эрж олох ёстойг онцлон тэмдэглэ.

Судрын ярилцлага
ба хэрэглээ

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагауудаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

Давидыг наснаас халихын яг өмнөхөн санваартан Задок, бошиглогч Натан хоёр Соломоныг шинэ хаанаар тослон томилжээ. Давид, Батшеба хоёрын хүү асан Соломон эцгээсээ дараах зөвлөгөө хүлээн авсан ажээ: “Хүчтэй байж . . . , эр хүн гэдгээ харуул, чи юу хийсэн ч, хаа явсан ч бүх зүйлд амжилт олохын тулд Бурхан ЭЗЭНийхээ замаар алхалж . . . , түүний тогтоол, тушаал, зарлиг болон гэрчлэлүүдийг сахихын тулд Түүний зааврыг дага; ингэснээр чи хийх бүх зүйлдээ цэцэглэн хөгжих болно.” (Хаадын Дээд 2:2–3)

1. Их Эзэн Соломоныг мэргэн ухаан, эд баялаг, алдар хүндээр адисалжээ.

Хаадын Дээд 3:5–28-ыг зааж, ярилц.

- Соломоныг хаан болсны дараахан удалгүй Их Эзэн түүний зүүдэнд үзэгдэж, “Чи надаас юу авахыг хүсч байгаагаа надаас асуугтун” гэж хэлжээ (Хаадын Дээд 3:5). Соломон юу гуйсан бэ? (Хаадын Дээд 3:9-ийг үз) “Ухааран ялгах чадвартай” байх гэсэн нь юу гэсэн үг вэ? (Хаадын Дээд 3:28; 4:29-ийг үз) Яагаад Соломон энэ адислал түүнд онцгой хэрэгтэй гэж бодсон бэ? (Хаадын Дээд 3:7–8-ыг үз) “Бурханы мэргэн ухаантай байх нь” гэр орон, ажил, сургууль, Сүм дээрх бидний үүрэг хариуцлагуудад бидэнд хэрхэн тусалдаг вэ? Энэхүү мэргэн ухааныг бид хэрхэн хүлээж авч болох вэ?
- Ухааран ялгах чадвартай байх Соломоны хүсэлтэд Их Эзэн яагаад баярласан бэ? (Хаадын Дээд 3:11–12. Амин хувиа хичээсэн зорилго бүхий бэлгийг бус, харин бусдад үйлчлэхэд түүнд туслах бэлгийг Соломон гуйсан байлаа.) Бидний эрэлхийлж болох зарим сүнслэг бэлэг юу вэ? (С ба Г 46:13–26-г үз) Ямар нөхцөлд Их Эзэн Сүнсний бэлгүүдийг өгдөг вэ? (Хаадын Дээд 3:14; С ба Г 46:8–12-ыг үз) Бид бусдад үйлчлэхийн тулд эдгээр бэлгүүдийг хэрхэн ашиглах вэ?
- Өөр ямар адислалуудыг Их Эзэн Соломонд соёрхсон бэ? (Хаадын Дээд 3:13–14-ийг үз) Бусдыг адислахын тулд эдгээр бэлгүүд хэрхэн ашиглагдаж болох вэ?

- Соломон Хаанаас шүүлт шаардсан анхны нөхцөл байдал юу байсан бэ? (Хаадын Дээд 3:16–22-ыг үз) Энэ асуудлыг Соломон хэрхэн шийдвэрлэсэн бэ? (Хаадын Дээд 3:23–28-ыг үз) Их Эзэн түүнийг мэргэн ухаанаар адисалсныг Соломоны шийдвэр хэрхэн харуулсан бэ?

2. Соломон Хаан ариун сүмийн агуу барилгын ажлыг чиглүүлж, өөртөө ордон бариулав.

Хаадын Дээд 5–6; 7:1–12-ыг зааж, ярилц.

- Их Эзэний зарлигласнаар Соломон энэ ариун сүмийг бариулахаар чиглүүлэгджээ. (Ариун сүмийн уран нарийн хийцийг онцлон анхаарахын тулд Хаадын Дээд 5:1–6, 17–18; 6:15–36-г товч нэгтгэн дүгнэхийг та хүсч болно.) Ариун сүм барихын тулд Соломон яагаад дээд зэргийн материал ашигласан гэж та нар бодож байна вэ?
- Барилгачид барилгын ажлын явцад ариун сүмийн барилгад хэрхэн хүндэтгэл үзүүлдэг байсан бэ? (Хаадын Дээд 6:7-г үз)
- Ариун сүмийн барилга зохих ёсоороо баригдахын тулд Соломон мэргэн ухаан, эд баялаг, алдар хүндээ хэрхэн ашигласан бэ? (Хаадын Дээд 5:1–12-ыг үз. Тэрээр хүч чадлынхаа улмаас барилгын материалууд олох болон ариун сүмийг барихад чадварлаг ажилчдыг элсүүлэх боломжтой байв.)
- Ариун сүмийн талаар Их Эзэн Соломонд ямар амлалт өгсөн бэ? (Хаадын Дээд 6:11–13-ыг үз) Өнөөдөр Их Эзэн үүнтэй төстэй ямар амлалтыг бидэнд өгдөг вэ? (С ба Г 97:15–17-г үз)
- Соломон бас өөртөө өргөө бариулсан ажээ. Түүний өргөөний хэмжээг Их Эзэний өргөөний хэмжээтэй хэрхэн харьцуулсан бэ? (Хаадын Дээд 6:2–3; 7:2, 6–7-ыг үз. Үнэт баялгуудыг ийнхүү ашигласан нь Соломон алгуураар доройтсоныг хэрхэн харуулдаг вэ?)

3. Соломон ариун сүмийг онцгойлон адислав.

Хаадын Дээд 8:22–66; 9:1–9-ийг зааж, ярилц.

- Долоон жил барьсны дараа ариун сүмийг онцгойлон адислав. Онцгойлон адислах залбиралдаа Соломоны залбирсан зарим зүйлүүд юу вэ? (Хаадын Дээд 8:22–53-ыг үз)

Ангийн гишүүдийн хариултуудыг та самбар дээр жагсаан бичиж болно. Дараах хариултууд байж болно:

- Залбирлуудын хариу (Хаадын Дээд 8:28–30, 49–52)
- Өршөөл (уучлал) (Хаадын Дээд 8:33–39)
- Бороо (Хаадын Дээд 8:35–36)
- Өлсгөлөн, өвчин тахлын үеэрх тусламж (Хаадын Дээд 8:37)
- Тулалдаанд үзүүлсэн тусламж (Хаадын Дээд 8:44–45)

- Онцгойлон адислалтын энэхүү залбиралд Соломон түүний хүмүүст олон хүнд асуудалд нь туслахыг Их Эзэнд хандан залбирчээ. Асуудлууд бидний санааг зовоосон үед ариун сүмд орох нь бидэнд хэрхэн тусалж чадах вэ?

“Эдгээр сайхан ариун сүмүүдийн амар амгаланд бид заримдаа амьдралын ноцтой асуудлуудын шийдлийг олох нь байдаг. Сүнсний нөлөөн дор тэнд заримдаа бидэнд цэвэр мэдлэг урсан ирдэг. Ариун сүмүүд бол хувь хүний

илчлэлтийн газар юм. Асуудал буюу бэрхшээл миний санааг зовоосон үед би хариулт авахаар зүрх сэтгэлийнхээ залбиралтайгаар Их Эзэний өргөөнд очдог. Эдгээр хариултауд тодорхой бөгөөд андуурах аргагүй арга замаар ирдэг” гэж Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон хэлжээ. (“What I Hope You Will Teach Your Children about the Temple,” *Ensign*, 1985 оны 8-р сар, 8)

- Ариун сүмд үл итгэгчдийг Их Эзэн рүү хөглөхийн тулд Соломон залбирчээ (Хаадын Дээд 8:41–43). Ариун сүм үүнийг яаж гүйцэтгэх вэ? (Ариун сүмийг сонирхсоныхоо улмаас тэд болон бусад хүмүүс хэрхэн Сүмийг сонирхдог болсон туршлагаас хуваалцахад ангийн гишүүдийг урь)
- Соломон онцгойлон адислах залбирал өргөсний дараа, тэрээр өөрийн хүмүүст, “Та нарын зүрх сэтгэл . . . ЭЗЭН Бурхандаа бүрэн зориулагдах болтугай” хэмээн зөвлөжээ (Хаадын Дээд 8:61). “ЭЗЭНд бүрэн зориулагдах” зүрх сэтгэлтэй байх гэдэг нь ямар утгатай гэж та нар боддог вэ? Ариун сүмд орох нь төгс зүрх сэтгэлтэй байхад бидэнд хэрхэн тусалж чадах вэ?
- Ариун сүмийн нөлөөг амьдралдаа хүчтэй байлгахын тулд бид юу хийж болох вэ? (Хариултауд нь: Боломжтой газарт ариун сүмд байнга орох, ариун сүмийн зөвшөөрлийн бичигтэй байх, ариун сүмүүдийн зургийг бид гэр орондоо байлгах)
- Ариун сүм онцгойлон адислагдсаны дараа хүмүүс юу хийсэн бэ? (Хаадын Дээд 8:62–66-г үз) Ариун сүмийн онцгойлон адислалт болон 14 хоног шүтэн биширсний дараа хүмүүсийн хандлага ямар байсан бэ? (Хаадын Дээд 8:66-г үз) Ариун сүмээс гэртээ эргэж ирсний дараа та нарт ямар санагддаг вэ?
- Ариун сүмийн онцгойлон адислалтын дараа тэрээр Соломон дээр айлчлан ирэх үед Их Эзэний захиас юу байсан бэ? (Хаадын Дээд 9:3–9, түүнчлэн Хаадын Дээд 6:11–13-ыг үз. Их Эзэн ариун сүмийн барилгын явцад мөн ийм мэдэгдэл хийснийг анхаар) Түүний гэрээнүүдийн талаар Соломонд сануулах нь яагаад хэрэгтэй байсан гэж та нар бодож байна вэ? Бидний гэрээнүүдийн талаар Их Эзэн бидэнд хэрхэн сануулдаг вэ?

4. Соломон үлэмж баян болж, хиймэл шүтээнүүдийг шүтэн бишрэхэд түүнийг ятгасан израил биш олон эмэгтэйтэй гэрлэжээ.

Хаадын Дээд 10–11-ийг зааж, ярилц.

- Ариун сүм баригдсаны дараа Соломоны эд баялаг, алдар нэр хэрхэн өссөн бэ? (Хаадын Дээд 10:1–15, 24–25-ыг үз) Соломон эдгээр адислалуудыг хэрхэн буруугаар ашигласан бэ? (Хаадын Дээд 10:16–23, 26–29-ийг үз. Тэрээр эдгээр адислалуудыг Бурханы хаант улсыг биш, харин өөрийнхөө хаант улсыг байгуулахын тулд ашигласныг тэмдэглэн хэл) Мэргэн ухаан, эд баялаг болон алдар хүндийг хэрхэн ашиглах ёстой вэ? (Иаков 2:18–19-ийг үз)
- Соломон эхнэрүүдээ сонгосон нь тэрээр Бурханаас холдон эргэснийг хэрхэн харуулсан бэ? (Хаадын Дээд 11:1–2-ыг үз. Тэр гэрээнээс гадуур гэрлэсэн байлаа.) Соломоны израил биш эхнэрүүд юу хийхэд нь түүнд нөлөөлсөн бэ? (Хаадын Дээд 11:3–8-ыг үз Иосеф Смитийн Орчуулга, шүлэг 4-т Соломоны зүрх сэтгэл “түүний эцэг Давидын зүрх сэтгэл шиг болсон” мөн шүлэг 6 -д “Соломон эцэг Давидынхаа нэгэн адил Их Эзэний мэлмийд хилэнц үйлдэв” хэмээн өгүүлжээ.)

- Соломон гэрээнүүдээ зөрчиж, холдон эргэхэд Их Эзэн юу хийсэн бэ? (Хаадын Дээд 11:9–14, 23–25, 33–36-г үз)
- Мэргэн ухаан, эд баялаг, алдар хүнд Соломоны уналтад хэрхэн нэмэр оруулсан гэж та нар боддог вэ? Эдгээр хүч чадлууд өнөө үеийн хүмүүсийн уналтад хэрхэн нэмэр болдгийг та нар харсан бэ? Бидний хүч чадал бидний хувьд уналт болохгүйн төлөө бид хэрхэн анхаарч болох вэ? (Хаадын Дээд 8:61; С ба Г 88:67-г үз)

Ахлагч Даллин Х.Өүкс хэлэхдээ:

“Бидний хүч чадал . . . бидний уналт болохоос бид хэрхэн урьдчилан сэргийлдэг вэ? Бидний төлөвшүүлэх ёстой чанар бол даруу байдал. Даруу байдал бол агуу хамгаалагч юм. Даруу байдал бол бардамналын эсрэг ерөндөг юм. Даруу байдал бол бүх суралцахуйн хувьд, ялангуяа сүнсний зүйлүүдийн хувьд ялгагч юм. Их Эзэн бошиглогч Моронайгаар дамжуулан даруу байдлын үүргийн тухай агуу ойлголтыг бидэнд өгсөн билээ: ‘Тэд даруу байж болохын тулд би хүмүүст сул доройг өгдөг; мөн миний өмнө өөрсдийгөө даруусгадаг бүх хүмүүст миний ач ивээл хангалттай юм; учир нь хэрэв тэд миний өмнө өөрсдийгөө даруусгаж, мөн надад итгэлтэй байх аваас, тэгвэл би тэдэнд сул дорой зүйлүүдийг нь хүчирхэг болгож өгнө.’ (Ифер 12:27)

“Хэрэв эрэгтэйчүүд, мөн эмэгтэйчүүд Бурханы өмнө өөрсдийгөө даруусгах юм бол, тэдний хүч чадал сул дорой байдал болж хувиран, дайсан тэднийг устгахын тулд үүнийг ашиглаж болохоос урьдчилан сэргийлэхэд тэрээр тэдэнд туслах болно гэж бид бас хэлж болно. . . .

“. . . Хэрэв бид даруу, үг дууламттай, Бурханы зарлигууд, удирдагчдын зөвлөгөө болон түүний Сүнсний өдөөлтүүдийг анхааран сонсдог байх юм бол, бид өөрсдийн бэлгүүд, амжилт ололтууд болон өөрсдийн бусад бүх хүч чадлыг зөв шударга ёсны төлөө хэрхэн ашиглахад бид удирдагдаж чадна. Ийнхүү бидний хүч чадлыг бидний уналт болгон ашиглах Сатаны хүч чармайлтуудаас хэрхэн зайлсхийхэд бид удирдагдаж чадна.

“Энэ бүгдэд бид: ‘Чи даруу бай; тэгвэл чиний Бурхан Их Эзэн чамайг гараас чинь хөтөлж мөн залбирлуудад чинь чамд хариу өгөх болно’ (С ба Г 112:10) гэсэн Их Эзэний чиглүүлэл болон амлалтыг санаж, үүнд түшиглэх ёстой” гэжээ (“Our Strengths Can Become Our Downfall,” *Ensign*, 1994 оны 10-р сар, 19).

Дүгнэлт

Их Эзэн өөрт чинь өгсөн сүнсний болон материаллаг адислалуудын төлөө түүнчлэн ариун сүмийн төлөө талархлаа илэрхийл. Тэд өөрсдийн адислалуудыг ухаалгаар ашиглаж, ариун сүмд зохистойгоор орж болохын тулд Их Эзэний өмнө өөрсдийгөө даруусгахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

Нэмэлт заах санаанууд

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

**1. “Түүний зүрх ах дүү нараасаа дээгүүр өргөгдөхгүйн тулд”
(Дэд Хууль 17:20)**

- Дэд Хууль 17:14–20-ийг ангийн нэг гишүүнээр уншуул. Энэ судрыг хэрэглэсэн нь Соломоны амьдралыг болон түүний хаант улс дахь хүмүүсийн амьдралыг хэрхэн өөрчилсэн бэ?

2. Ариун сүмүүдийн онцгойлон адислалтын залбирлууд

Ариун сүмийн онцгойлон адислалтад оролцсон ангийн гишүүд байвал, өөрсдийнхөө туршлагын талаар ярихыг тэдний нэг буюу хоёроос нь хүс. Хожмын үеийн ариун сүмийн онцгойлон адислалтын талаарх хоёр буюу гурван ойлголтыг хуваалцахаар бэлтгэхийг та ангийн нэг гишүүнээс хүсч болно. (Сургаал ба Гэрээ 109 нь Көртландын Ариун сүмийн онцгойлон адислалт дээр хэлсэн залбирлыг агуулдаг.)

- Онцгойлон адислах залбирлууд бидний хувийн амьдралд хэрхэн нөлөөлөх учиртай вэ?

“Бид Их Эзэний өргөөг онцгойлон адислах үед бидний жинхэнэ хийдэг зүйл бол уг өргөөг ашигладаг Түүний замаар бид үүнийг ашиглах болно гэсэн гэрээтэйгээр Их Эзэний үйлчлэлд бид өөрсдийгөө онцгойлон адисалдаг явдал мөн” гэж Ерөнхийлөгч Иосеф Фиелдинг Смит хэлжээ (*Church News*, 1972 оны 1-р сарын 22, 3).

Ёс бус хийгээд зөв шударга удирдагчдын нөлөө

Хаадын Дээд 12–14; Шастирын Дэд 17; 20

Зорилго

Зөв шударгаар амьдрахад нь тэд бусдад нөлөөлж болохын тулд удирдлагын сайн чанаруудыг хөгжүүлэхэд нь ангийн гишүүдийг урамшуулан дэмжих.

Бэлтгэл

1. Дараах судруудыг залбирч судал:

- а. Хаадын Дээд 12:1–20. Рехобоам Израилын арванхоёр овгийн хаан болж, эцэг Соломоныгоо залгамжлав. Тэрээр өөрийн хүмүүст үйчлэх тухай ухаант хүмүүсийн зөвлөгөөг няцааж, үүний оронд тэдэн дээр илүү их ачаа үүрүүлэхийг эрэлхийлж байв (12:1–15). Хаант улс бослого гаргагч арван овогт хуваагдав (12:16–19; Арван овог Израилын хаант улс гэдэг нэр авсан бол, Иуда, Бениамин хоёр Рехобоамын захиргаан дор үлдэж, Иудейн хаант улс гэж нэрлэгдэв). Израилын хаант улс Соломоны хаант улсын хаан, захирагч асан Иеробоамыг сонгожээ (12:20).
- б. Хаадын Дээд 12:25–33; 13:33–34; 14:14–16, 21–24. Иеробоам өөрийн хүмүүсийг хиймэл шүтээн шүтэхэд удирдан, санваартнуудыг левичүүд биш хүмүүсээр сольжээ (12:25–33; 13:33–34; модон шон болон мөргөлийн өндөрлөгүүдийн тухай тайлбарыг хоёр дахь нэмэлт заах санаанаас үз). Иеробоамын гэр бүлийн устгал хийгээд Израилын тараагдалтыг нэг бошиглогч угтан хэлэв (14:14–16). Рехобоам Иудейн хаант улсыг хиймэл шүтээн уруу удирдав (14:21–24).
- в. Шастирын Дэд 17:1–10; 20:1–30. Рехобоамын ачинцар Иехошафат модон шон болон мөргөлийн өндөрлөгүүдийг устган, Их Эзэний хуулийг заалгахаар левичүүдийг Иудейн хаант улс даяар илгээж, Иудейн хаант улсад зөв шударгаар хаанчилж байв (17:1–10). Иудейн дайснууд тэдний эсрэг ирэхэд, Иехошафат болон түүний хүмүүс мацаг барьж залбирав. Тулалдаан тэднийх биш, харин түүнийх гэж Их Эзэн тэдэнд хэлэв. Тэднийг довтлогчид өөр хоорондоо дайтаж, бие биенээ устгажээ (20:1–30).

2. Нэмэлт уншлага: Хаадын Дээд 11:26–40; Хаадын Дэд 17:20–23.

3. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашиглах бол, хэсэглэн урж болох хуучин даавуу буюу эсвэл даавууны хэсгүүд хэлбэрээр хайчилж болох том цаас авчир.

Энэ хичээлийг заах зөвлөмж

Анхаарал
төвлөрүүлэх
үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагааг (эсвэл өөрийхөө нэг үйл ажиллагааг) ашиглахыг хүсч болно.

Хуучин даавуу буюу даавууны хэсгүүд хэлбэрээр хайчлах цаасыг 12 хэсэг болгон ур. Соломоны амьдралын төгсгөл хирд татвар, хөдөлмөр хариуцсан Соломоны арванхоёр хянагчийн нэг Иеробоам Израил үндэстний ихээхэн хэсгийг өөртөө авах болно хэмээн бошиглогч Ахиа бошигლოსныг тайлбарла.

Ахиа үүнийг харуулахын тулд өөрийнхөө шинэ хувцсыг авч, 12 хэсэг болгон урж, тэдгээрийн 10-ыг Иеробоамд өгчээ (Хаадын Дээд 11:29–32; Библийн Хожмын үеийн Гэгээнтний англи хэл дээрх хэвлэлийн шүлэг 32-г Хуучин Гэрээний грек хэлний орчуулга Септуагентэд өгүүлснээр, нэг биш, харин хоёр овог Давидын үр удмаар захирагдсан хаант улсад үлдсэн гэжээ).

“Аливаа хаант улс дотроо хуваагдвал сүйрнэ” (Матай 12:25) гэж Аврагч заасан байдаг. Чухам энэ бол Соломоныг нас эцэслэсний дараа Израилын хаант улсад тохиолдсон зүйл мөн гэдгийг тайлбарла. Энэ хичээл бол хуваагдсан Израилын хаант улс дахь ёс бус хийгээд зөв шударга удирдагчдын нөлөөний тухай юм.

Судрын ярилцлага
ба хэрэглээ

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагауудаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Голчлон Рехобоамын таагүй удирдлагын улмаас Израилын хаант улс хуваагджээ.

Хаадын Дээд 12:1–20-ийг зааж, ярилц.

Та дараах нотолгоог самбар дээр бичиж болно:

Сайн удирдагч:

1. Үйлчлэл үзүүлдэг.

- Соломоныг нас эцэслэсний дараа түүний хүү Рехобоам Израилын хаан болжээ. Түүний эцэг захирч байсан арга замаас ямар өөрчлөлтүүд хийхийг израилчууд Рехобоамаас хүсч байсан бэ? (Хаадын Дээд 12:3–4-ийг үз) Амжилттай засаглах талаар ахмад хүмүүс Рехобоамд ямар зөвлөгөө өгсөн бэ? (Хаадын Дээд 12:6–7; Шастирын Дэд 10:7-г үз) Найрсаг бөгөөд бидэнд үйлчилдэг удирдагч яагаад бидэнд илүү их нааштайгаар нөлөөлдөг вэ? Энэ зөвлөгөөг бид гэр орондоо, сургууль дээр, ажил дээрээ хэрхэн хэрэглэж болох вэ? (С ба Г 121:41–46-г үз) Энэ зөвлөгөөг амжилттай хэрэглэдэг эцэг эхчүүд буюу бусад удирдагчдын ямар зарим жишээг та нар харсан бэ?
- Ахмад хүмүүсийн зөвлөгөөнөөс татгалзсаны дараа Рехобоам өөрийнхөө идэр залуу байхаас таних залуу хүмүүст ханджээ. Тэд юу гэж зөвлөсөн бэ? (Хаадын Дээд 12:8–11-ийг үз) Тэдний зөвлөгөөг дагах гэсэн Рехобоамын шийдвэрийн үр дүн нь юу байв? (Хаадын Дээд 12:12–17-г үз. “Израил майхнууд уруугаа явав” гэсэн өгүүлбэр арван овог өөрсдийгөө Рехобоамын хаант улсаас тусгаарласныг хэлж байгааг тайлбарла) Хэрэв Рехобоам ахмад хүмүүсийн зөвлөгөөг дагасан бол эдгээр үр дүнгүүд хэрхэн өөр байх байсан бэ? (Хаадын Дээд 12:7-г үз)
- Иеробоам татвар ба хөдөлмөр хариуцсан Соломоны 12 хянагчийн нэг байлаа. Соломоны хаанчлалын төгсгөл хавьд Иеробоам Израилын олон овгийн хаан болно хэмээн бошиглогч Ахиа бошигложээ (Хаадын Дээд 11:29–31; анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг мөн үз). Энэ бошиглол хэрхэн гүйцэлдсэн бэ? (Хаадын Дээд 12:20-ийг үз. Иуда, Бениамин хоёрын овог Өмнөд Хаант Улс буюу Иудейн хаант улсад Рехобоамтай хамт үлдэв. Үлдсэн арван овог Умард Хаант Улс буюу Израилын Хаант улсад Иеробоамыг дагажээ)

2. Иеробоам, Рехобоам хоёр өөрсдийн хаант улсуудыг хиймэл шүтээн шүтэхэд удирдав.

Хаадын Дээд 12:25–33; 13:33–34; 14:14–16, 21–24-ийг зааж, ярилц.

Та самбар дээр бичсэн дараах нотолгоон дээр нэмэхийг хүсч болно:

Сайн удирдагч:

1. *Үйлчлэл үзүүлдэг.*

2. *Их Эзэнд итгэж, түүнийг дуулгавартай дагадаг.*

- Хэрэв тэрээр Их Эзэний замуудаар алхлах юм бол, түүнд “мөнхийн гэр” (бат бөх хаант улс) өгөгдөх болно хэмээн Их Эзэн бошиглогч Ахиагаар дамжуулан амлажээ (Хаадын Дээд 11:38). Энэ амлалтын адислалуудыг Иеробоам хэрхэн хөсөрдүүлсэн бэ? (Хаадын Дээд 12:25–33-ыг үз). Яагаад Иеробоам алтан тугалууд, мөргөлийн өндөрлөгүүд бий болгож, хуурамч санваартнуудыг томилсон бэ? (Хаадын Дээд 12:26–33; 13:33–34-ийг үз)

Хэрэв өөрийнх нь хүмүүс шүтэн бишрэхээр Иерусалим уруу явах юм бол, тэд Рехобоам уруу эргэн очиж магадгүй хэмээн Иеробоам айж байжээ гэдгийг тайлбарла. Өөрийн хүмүүст хяналт тавьж, тэдний үнэнч байдлыг хадгалахын тулд тэрээр Умард Хаант Улс дахь Бетел, Дан хоёр хотод алтан тугалууд хийж, эдгээр хотуудын хүмүүсийг шүтэн бишрэхэд урьсан ажээ. Үүнийг хийснээрээ тэрээр Их Эзэний амлалтуудад итгэх итгэлээ хөсөрдүүлж, ялагдлаас айх айдаст боломж олгожээ. Ухаалаг удирдагч Их Эзэнд итгэж, айдас буюу хувийн бодол санаанд түшиглэн буруу шийдвэр гаргадаггүйг тэмдэглэн хэл.

- Хүү нь өвдөхөд Иеробоам бошиглогч Ахиагаас тусламж хүссэн аж. Иеробоамын гэр орон (гэр бүл) болон хаант улсын талаар Ахиа ноу бошиглосон бэ? (Хаадын Дээд 14:14–16. Энэ бошиглолын биелэлт Хаадын Дэд 17:20–23-т байдаг.)
- Иеробоамын нэгэн адил Рехобоам бас хүмүүсийг хиймэл шүтээн бишрэхэд удирдсанаар Бурханыг дуулгавартай дагаагүй ажээ (Хаадын Дээд 14:21–24). Энэ хоёр хааны ёс бус удирдлага урт удаан хугацаанд хор уршигтай байв. Хоёр хаант улс хоёул тараагдаж, олон жилийн дараа боолчлолд аваачигджээ, (Израил ассиричуудаар, Иудей вавилончуудаар) учир нь тэд ёс бус уламжлалуудаа үргэлжлүүлсээр байжээ. Ёс бус ганцхан удирдагч хэрхэн өдий олон хүмүүст өгүүлшгүй их хор уршиг тарьж болох вэ?

Израил болон Иудейн хүмүүс өөрсдийн ёс бус удирдагчдын үйлдлүүдийг даган дуурайж байсан шиг бид үүнийг дагах буюу хуулбарлах шаардлагагүйг тэмдэглэн хэл. Бурхан бидэнд сонгох эрх өгсөн, иймээс бүр удирдагчид хилэнцийг сонголоо ч гэсэн, бид энэ хүчийг сайныг сонгоход ашиглаж чадна (Хиламан 14:30–31).

3. Иехошафат Их Эзэнийг болон Түүний бошиглогчдыг дагахаар Иудейн хаант улсыг удирдав.

Шастирын Дэд 17:1–10; 20:1–30-ыг зааж, ярилц.

Та самбар дээрх жагсаалт дээр доорх зүйлүүдийг дахин нэмэхийг хүсч болно:

Сайн удирдагч:

1. Үйлчлэл үзүүлдэг.
2. Их Эзэнд итгэж, түүнийг дуулгавартай дагадаг.
3. Бурханд итгэх итгэлтэй байдаг.
4. Судруудаас заадаг.
5. Бошиглогчдыг дагадаг.

- Рехобоамаас хойш гурван үеийн дараа, түүний ачинцар Иехошафат Иудейн хаант улсад хаанчилж байв. Иехошафат өөрийн зөв шударга байдлыг хэрхэн харуулсан бэ? (Шастирын Дэд 17:3–4, 6) Бидний хувийн бүхнээ зориулсан байдал бусдыг удирдах бидний чадварт хэрхэн нөлөөлдөг вэ?
- Иехошафат “мөргөлийн өндөрлөгүүд болон модон шонг Иудейгаас зайлуулсан ажээ” (Шастирын Дэд 17:6). Үүнээс хүмүүс ямар сургамж авсан гэж та нар боддог вэ? (Шастирын Дэд 20:12–13, “Бүх иудейчүүд өөрсдийн нялх үрс, эхнэрүүд хүүхдүүдийнхээ хамт ЭЗЭНий өмнө зогсож байсныг” тэмдэглэн хэл) Бид бүхнээ зориулах агуу байдлаар Бурханыг шүтэн бишрэхийн тулд өөрсдийн гэр орон, хувийн амьдралаасаа юуг зайлуулж болох вэ?
- Иехошафат “ЭЗЭНий хуулийн номноос” (Шастирын Дэд 17:9) хүмүүст заахын тулд левичүүдийг хаант улс даяар илгээв. Судруудаас заалгасан нь Иудейн хүмүүст хэрхэн нөлөөлсөн гэж та нар боддог вэ? Хувиараа болон гэр бүлээрээ судар судалсан нь та нарт хэрхэн тусалсан бэ? Гэр орондоо судар судлах нь бидний гэр бүлүүдэд хийгээд Сүмд бүхэлд нь хэрхэн нөлөөлдөг вэ?

“Манай гадсуудад бид үйл ажиллагааны түвшинг дээшлүүлэхийг хичээн, их хүч чармайлт гаргах нь олонтаа байдаг. Ариун ёслолын цуглаануудад оролцогчдын хувь хэмжээг нэмэгдүүлэхийн төлөө бид хичээнгүйлэн ажилладаг. Номлолд үйлчлэх манай залуу хүмүүсийн тоог өндөр хувь хэмжээнд хүргэхийн төлөө бид хөдөлмөрлөдөг. Ариун сүмд гэрлэгчдийн тоог өсгөхийг бид хичээдэг. Энэ бүхэн бол магтууштай чармайлтууд бөгөөд хаант улсыг өсч хөгжихөд чухал юм. Гэвч гишүүд хувиараа хийгээд гэр бүлүүд судруудыг тогтмол, байнга бас сонирхолтойгоор судалдаг болсон тохиолдолд, үйл ажиллагааны эдгээр бусад талууд аяндаа гарч ирэх болно. Гэрчлэлүүд өсөн нэмэгдэх болно. Шийдвэр төгс байдал бэхжих болно. Гэр бүлүүд бэхжин хүчирхэгжих болно. Хувь хүнд илчлэлт ирэх болно” гэж Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон сургажээ (*The Teachings of Ezra Taft Benson* [1988], 44).

- Шастирын Дэдийн 20 нь гурван үндэстэн тэдэнд дайн зарлахад Иудейн хүмүүсийн хувьд аймшигт түгшүүрийн үе эхэлсэн тухай өгүүлдэг. Иехошафат Хаан болон тоогоор үлэмж давамгайллуулсан түүний хүмүүсийн хувьд болох дайны үр дүн бараан баргар байлаа. Тусламж хүлээж авахын тулд Иехошафат юу хийсэн бэ? (Шастирын Дэд 20:3–13-ыг үз) Энэхүү даруухан залбиралд Их Эзэн юу гэж хариулсан бэ? (Шастирын Дэд 20:14–17. Энэ хариулт бошиглогч Иахазиелаар дамжин ирснийг анхаар) Иехошафат өөрийн хүмүүст ямар зөвлөгөө өгсөн бэ? (Шастирын Дэд 20:20-ийг үз) Хожмын үеийн Гэгээнтнүүдийн хувьд бид эртний Иудейн хүмүүс тооны хувьд давамгайлуулж байсны нэгэн адил

өнөөдөр бид тооны хувьд хэрхэн давамгайлуулж болох вэ? Иехошафатын зөвлөгөө бидэнд хэрхэн холбогдох вэ?

- Тулалдаан Бурханых байх болно гэсэн бошиглогч Иахазиелын баталгааг Иехошафат санан, тулалдахын оронд Их Эзэнийг магтан дуулах дуучдыг томилжээ. Тэднийг дуулж эхлэхэд, довтлогчдыг нь Их Эзэн өөр хооронд нь дайтуулж, бие биенээ устгахад хүргэн тэднийг хамгаалжээ (Шастирын Дэд 20:21–24). Бид амьд бошиглогчийг санаж, түүний үгсийг дуулгавартай дагахад бид хэрхэн хамгаалагддаг вэ?
- Өөрсдийн хүмүүсийг хиймэл шүтээн бишрэхэд удирдсан Иеробоам, Рехобоам хоёроос эсрэгээр Иехошафат Их Эзэний өмнө өөрсдийгөө даруусгахад нь Иудейн хүмүүст нөлөөлсөн юм (Шастирын Дэд 20:3–4). Зөв шударга удирдагчдын нөлөөний ямар жишээнүүдийг та нар харсан бэ? Бид өөрсдийнхөө үйлчилдэг хүмүүст зөв шударгаар амьдрахад нь туслахын тулд юу хийж болох вэ?

Дүгнэлт

Удирдагчид хүмүүсийг ёс бусад эсвэл зөв шударга ёсонд удирддаг хүчний тухай гэрчил. Сүмийн дуудлагууддаа, хамт олны дунд, ажил дээрээ, түүнчлэн гэр орондоо бидний удирдах үүрэг хариуцлагуудын тухай ангийн гишүүдэд сануул. Үйлчлэл үзүүлж, Их Эзэнд итгэж, түүнийг дуулгавартай дагаж, түүнд итгэх итгэлтэй байж, судруудаас зааж, бошиглогчдыг дагах замаар сайн удирдагчид байхад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

Нэмэлт заах санаанууд

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

1. Үе чацууднуудын сөрөг дарамт шахалтыг даван туулах нь

- Израилын хаант улс хуваагдсан нь ихэнхдээ Рехобоам өөрийн үе чацуутнуудын ухаалаг бус зөвлөгөөг дагахаар сонгосноос болсон ажээ (Хаадын Дээд 12:9–16). Бид үе чацуутнуудынхаа ухаалаг бус зөвлөгөөг дагадаг уруу таталтыг хэрхэн эсэргүүцэж чадах вэ?

Ахлагч Мальколм С.Жеппсен хэлэхдээ:

“Та нараас олон нь . . . хэзээ нэгэн цагт, хийх ёсгүйг нь та нарын мэддэг ямар нэг зүйлийг хийлгэхээр нэг юм уу, эсвэл илүү олон найз чинь та нарыг уруу татахтай учрах болно. . . .

“ ‘Хэн ч мэдэхгүй шүү дээ’, ‘Түүнээс гадна, ингэлээ гээд юу нь болохгүй гэж?’ хэмээн найз нар гэгддэг хүмүүс та нарт хэлэх болно.

“. . . Буруу зам дээр байгаа найз нараа та нар бүү эсэргүүц; тэр ч байтугай та нар тэднээс нүүр буруулах ч шаардлагагүй. Та нар тэдний төлөө санаа тавигч найз нь байж, туслуулахад бэлэн байгаа үед нь тэдэнд туслахад бэлэн бай. Та тэдэнд хандан ярьж, тэднийг өргөн, тэдэнд гэрчлэлээ хэл. Үлгэр дуурайлаар тэднийг хөглөн дагуул.

“Тэвч чиний найз байхын тулд болзол тавин хүсч мэдэх найз нараараа Тэнгэр дэх Эцэгийнхээ таалалд үл нийцэх зүйл рүү хэзээ ч бүү хөтлөгд, чи тэдний зам, Их Эзэний замын хоорондоос сонголт хийх ёстой.

“Хэрэв ингэх боллоо гэхэд, Их Эзэний замыг сонгож, тэгээд шинэ найз нарыг эрж хай” гэжээ (Conference Report, 1990 оны 4-р сар, 59; *Ensign*, 1990 оны 5-р сар, 45).

2. Мөргөлийн өндөрлөгүүд ба модон шонгийн тухай

Иеробоам, Рехобоам нарын нэвтрүүлсэн хуурамч шүтээнийг тайлбарлахад дараах тодорхойлолтууд танд туслах болно.

Мөргөлийн өндөрлөгүүд (Хаадын Дээд 12:31): толгойн орой дээр барьсан тахилын ширээнүүд. Хүмүүс хиймэл шүтээн тахих болсон үед тэд эдгээр тахилын ширээнүүдийг хиймэл шүтээнийг биширч, ариун шүтээнийг бузарлахад ашигладаг байжээ.

Модон шонгууд (Хаадын Дээд 14:15): хүмүүс зарим үед ёс суртахуунгүй зан үйл үзүүлдэг бөө мөргөлийн газрууд.

3. “Тэгээд . . . та нар хүний гарын бүтээл болох бурхдад үйлчлэх болно” (Дэд Хууль 4:28)

- Иеробоам алтан тугалуудыг бий болгож, хүмүүс мөргөлийн өндөрлөгүүд болон модон шонгууд дээр шүтэн бишрэхдээ 500 жилийн тэртээ өгөгдсөн Мосегийн сэрэмжлүүлгүүдийг тэр болон түүний хүмүүс үл хайхарчээ (Дэд Хууль 4:25–28). Тэд өөрсөд дээрээ ямар сүйрлийг бий болгосон бэ? Тэд хуурамч бурхдын оронд Их Эзэн рүү эргэсэн бол юу амлагдсан байсан бэ? (Дэд Хууль 4:29–31)

4. Удирдлагын үзүүлэнт хичээл

Хоёр адилхан өрдөг тоглоомын цуглуулгыг (эсвэл өөр зүйл) ангид авчир. Дараах зүйлийг хийж үзүүлэхэд оролцохыг ангийн хоёр гишүүнээс хүс. Оролцогч тус бүрд өрдөг тоглоомын цуглуулгыг өг. Ангийн нэг гишүүнийг удирдагч, нөгөөг нь түүнийг дагагч болго. Ангийн хоёр гишүүнийг бие биенийхээ өрдөг тоглоомыг харж чадахааргүйгээр нуруугаар нь нийлүүлэн хоёр тийш нь харуулж зогсоо. Удирдагчаар өрдөг тоглоомоор нь ямар нэг зүйлийг түргэн хийлгэж, тэгээд үүнтэй яг ижил зүйл хэрхэн барихыг дагагчид заавар өгүүл. Дагагч зааврыг баримтлах үед асуулт асуух ёсгүй. Төсөл дуустал оролцогчид аль аль нь бие биенийхээ хийж байгаа зүйлийг харах ёсгүй.

Дагагчийг хийсэн зүйлээ дуусгахад, удирдагчдын хувьд тодорхой зааврууд өгөх нь, дагагчдын хувьд анхааралтай сонсох нь хичнээн чухал болох тухай ярилц. Хэрэв дагагч удирдагчийн хийсэн зүйлтэй яг ижил хийсэн байвал, хоёр оролцогчийг хоёуланг нь магтаж, тэд яагаад амжилттай байсныг ангийн бусад гишүүдээр тайлбарлан яриулахыг хүс. Хэрэв тэдний хийсэн зүйлүүд өөр байвал, дараах асуултуудыг асуу:

- Удирдагч заавраа илүү тодорхой өгч болох байсан уу? Дагагч илүү анхааралтай сонсож болох байсан уу? Удирдагчийн хийсэн зүйлийг дагагч харахыг зөвшөөрөх нь ямар ашиг тустай байх вэ?
- Энэ үзүүлбэрээс сурсан зүйлээ бид Сүмийн дуудлагууд болон гэр орондоо хэрхэн хэрэглэж болох вэ?

Зорилго

Амьдралдаа Бурханыг нэгдүгээрт тавьж, амьд бошиглогчийн үгс болон Ариун Сүнсний шивнээнээс удирдамж хийгээд тайтгарлыг олоход нь ангийн гишүүдийг урамшуулан дэмжих.

Бэлтгэл

1. Дараах судруудыг залбирч судал:
 - а. Хаадын Дээд 17. Елиа бороо оруулахгүйн тулд тэнгэрийг лацдаж, Ахаб, Иезебел хоёроос зугтааж, аглаг буйдад гайхамшигтайгаар тэтгэгдэв (17:1–6). Түүнд хоол, ус өгсөн эмэгтэй рүү Елиаг Их Эзэн илгээв (17:7–16). Елиа бэлэвсэн эмэгтэйн хүүг үхэгсдээс босгов (17:17–24).
 - б. Хаадын Дээд 18. Хоёр жил гаруй үргэлжилсэн өлсгөлөнгийн дараа Елиа Ахабтай уулзаж, тэдний тахилыг шатаахын тулд тэнгэрээс гал доош нь дуудахад Баалын санваартнуудыг хүргэв (18:1–2, 17–24). Баалын санваартнууд өөрсдийн оролдлогод бүтэлгүйтэж, харин Елиа залбиран, тэгээд түүний бэлтгэсэн тахилыг шатаахын тулд Их Эзэн доош нь гал илгээв (18:25–40). Өлсгөлөнг дуусгахын тулд Елиа залбирч, Их Эзэн бороо илгээжээ (18:41–46).
 - в. Хаадын Дээд 19. Иезебел Елиаг алах гэж оролдов (19:1–2). Елиа аглаг буйд уруу зугтааж, тэнгэр элчээр тэжээгдэв (19:3–8). Елиа Хороб Уул руу очиж, тэнд тэрээр Ариун Сүнсээр тайтгаруулагдаж, Бурханы ажлыг үргэлжлүүлэхээр зааварлагдав (19:9–19).
2. Елиа болон Баалын санваартнуудын зөрчилдөөний тухай товч илтгэл бэлтгэхийг ангийн нэг гишүүнээс хүс (Хаадын Дээд 18:17–40).

Энэ хичээлийг заах зөвлөмж

Анхаарал
төвлөрүүлэх
үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагааг (эсвэл өөрийхөө нэг үйл ажиллагааг) ашиглахыг хүсч болно.

Ахлагч Томас С.Монсоны ярьсан дараах түүхийг хуваалц:

“Ядуу тарчиг байдалд төрсөн хэдий ч, итгэлээр тэжээгдсэн [Хосе Гарсиа] номлолын дуудлагадаа бэлтгэжээ. Түүний зөвлөмжийг хүлээн авсан тэр өдөр би тэнд байлаа. ‘Гарсиа Ах гэр бүлдээ их золиослол хийн, номлолд үйлчлэх болно, учир нь тэр бол гэр бүлээ их хэмжээгээр тэтгэдэг байжээ. Түүнд ердөө ганцхан өмч байдаг нь—маркны үнэт цуглуулга бөгөөд, хэрэв шаардлага гарвал, номлолдоо санхүүгийн дэмжлэг олохын тулд үүнийг зарахад бэлэн байв’ гэсэн үгс байлаа.

“Ерөнхийлөгч [Спенсер В.] Кимбаллд энэ үгсийг уншиж өгөхөд тэрээр анхааралтай сонсоод: ‘Маркийнх нь цуглуулгыг түүгээр заруул. Ийм золиослол түүний хувьд адислал болох болно’ гэж тэр хариулж билээ.”

Их Эзэнд үйлчлэхийн тулд эзэмшдэг бүх зүйлээ орхихыг тэднээс хүсвэл тэд хэрхэн хариу үйлдэл үзүүлэхийг ангийн гишүүдээс асуу. Дараа нь түүхийг үргэлжлүүл:

“Тэгээд, хайраар дүүрэн энэ бошиглогч нүдээ ирмэн, нүүрэнд нь инээмсэглэл тодорч, ‘Сүмийн төв байранд бид дэлхийн бүх хязгааруудаас сар бүр мянга мянган захидал хүлээж авдаг. Бид эдгээр маркуудыг цуглуулж, номлолоо дуусгах үед нь Хосед өгье. Тэр Мехико дахь ямар ч залуу хүний хувьд хамгийн сайхан маркийн цуглуулгыг үнэгүйгээр хүлээж авах болно’ хэмээн хэлэв.” (Conference Report, 1978 оны 10-р сар, 83; *Ensign*, 1978 оны 11-р сар, 56)

Бид амьдралдаа Бурханы зүйлүүдийг нэгдүгээрт тавьснаар, бид золиослол хийж хүлээн авч болох ямар ч зүйлээс илүү агуу шагнал хүлээж авах болно гэдгийг тайлбарла. Тэр ч байтугай энэ нь их хэцүү байсан ч гэсэн Бурханыг дагахыг хүссэнийхээ учир, агуу адислалуудыг хүлээн авсан Елиа, бэлэвсэн эмэгтэй Зарифат хэмээх хоёр хүний тухай энэ хичээл өгүүлэх болно.

Судрын ярилцлага
ба хэрэглээ

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагауудаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

Иеробоам Израилын хаант улсыг хиймэл шүтээн бишрэхэд удирдсаны дараа тэр болон түүний үр удам устгагджээ. Тэдний дараа хиймэл шүтээн бишрэгч өөр хаад залгамжилсан аж. Тэдгээр захирагчдаас Ахаб “өөрийн өмнөх Израилын бүх хаадаас ч илүүгээр Израилын Бурхан ЭЗЭНийг хилэгнүүлсэн ажээ” (Хаадын Дээд 16:33) Тэрээр Иезебелтэй гэрлэж, Баалыг шүтэн бишрэх түүний дадал зуршлыг хүлээн авч, улмаар өөрийн хүмүүсийг энэхүү хуурамч бурхныг шүтэн бишрэхэд нэгдэхэд нь урамшуулан дэмжиж байжээ. Бошиглогч Елиа сэрэмжлүүлгийн үгсийг Ахаб болон түүний хаант улсад хүргэж байв.

1. Елиа тэнгэрийг лацдаж, гайхамшгаар тэтгэгдэн, бэлэвсэн эмэгтэйн хүүг үхэгсдээс босгов.

Хаадын Дээд 17-г зааж, ярилц.

- Ахаб болон түүний хүмүүсийн ёс бусын улмаас, Елиа, “Намайг тушаахаас нааш энд хэдэн жилийн турш бороо ч орохгүй, шүүдэр ч буухгүй” (Хаадын Дээд 17:1; налуу бичлэг нэмэгдэв) хэмээн мэдэгджээ. Елиа яагаад ийм мэдэгдэл хийх боломжтой байсан бэ? (Та Елиаг мөн ийм хүч өгөгдсөн байсан, Хиламаны хүү Нифайтай харьцуулж болно. Нифайн үгсийн дагуу бүх зүйл хийгдэхийг зөвшөөрсөн Их Эзэний шалтгаанууд Хиламан 10:4–5-д байдаг.)
- Хаант улсад бороо орохгүй гэж Елиаг мэдэгдсэний дараа, зугтаахыг Их Эзэн түүнд зарлиглажээ. Елиа Их Эзэний зарлигт хэрхэн хариулсан бэ? (Хаадын Дээд 17:2–5-ыг үз) Елиагийн хариултаас бид юу сурч болох вэ?

Ахлагч Гордон Б.Хинкли хэлсэн нь:

“Уг нутагт ирэх ган гачиг, өлсгөлөнгийн тухай Ахаб Хааныг сэрэмжлүүлсэн Бошиглогч Елиагийн энгийн мэдэгдлээс би хүч чадал олж авдаг. Харин Ахаб доог тохуу хийсэн аж. Елиаг явж, Черит горхины тэнд нуугд гэж Их Эзэн түүнд хэлсэн нь тэрээр тэнд уг горхиноос ундаалж, хэрээнүүд түүнийг

тэжээхийн учир байжээ. Түүнчлэн: ‘Тэгээд тэрээр явж ЭЗЭНий үгийн дагуу үйлдлээ’ (Хаадын Дээд 17:5) гэсэн энэхүү энгийн бөгөөд гайхамшигтай мэдэгдлийг сударт цэдэглэсэн байдаг.

“Елиа явах тухайдаа Их Эзэнтэй маргасангүй. Энд шалтаг заах юм байсангүй. Тэрээр худал хэлсэнгүй. Елиа ердөө л ‘явж, Их Эзэний үгийн дагуу үйлджээ.’ Тэгээд доог дохуу хийж, марган, эргэлзэж байсан хүмүүсийг дайрсан аймшигт гай гамшгаас тэрээр аврагдсан юм” (Conference Report, 1971 оны 10-р сар, 159; *Ensign*, 1971 оны 12-р сар, 123–24).

- Ган эхэлсний дараа Елиа аглаг буйдад хэрхэн амьд гарсан бэ? (Хаадын Дээд 17:4, 6-г үз) Их Эзэн та нарыг бие махбодь буюу сүнслэг байдлын хувьд тэтгэн дэмжсэн ямар туршлагаууд та нарт тохиолдсон бэ?
- Аглаг буйд дахь горхи хатсаны дараа Елиад туслахын тулд Их Эзэн хэнийг бэлтгэсэн бэ? (Хаадын Дээд 17:7–13-ыг үз) Гачигдалтай хүмүүст Их Эзэн хэрхэн тусалдаг тухай энэ нь бидэнд юу зааж болох вэ? (Их Эзэн бусад хүмүүсийн үйлчлэлээр дамжуулан гачигдсан хүмүүст олонтаа тусалдгийг тайлбарла) Их Эзэн бусад хүмүүсийн үйлчлэлээр дамжуулан гачигдсан хүмүүст хэрхэн тусалдгийг та нар үзсэн үү? Гачигдсан бусад хүмүүст туслахын тулд бид юу хийж болох вэ?

Ахлагч Жеффри Р.Холланд хэлэхдээ: “Бидний хүн нэг бүр ямар нэг юм хийж чадахыг би мэднэ, гэвч энэ нь өчүүхэн зүйл мэт санагдаж болно. Бид аравны нэгээ шударгаар төлж, мацгийн хийгээд сайн дурын өглөгүүдээ өгч чадна. . . . Мөн бид туслах бусад арга замуудыг эрж хайж болно. Хэрэв бидэнд мөнгө байхгүй байвал, бид цаг заваа зориулж болно, бидэнд цаг зав байхгүй байвал, бид хайраа зохистой зорилгууд хийгээд гачигдсан хүмүүст өгч болно. Бид өөрсөддөө байгаа булан талхыг хуваалцаж, тосны сав дундрахгүй байхын тулд Бурханд итгэж болно” гэжээ (Conference Report, 1996 оны 4-р сар, 41; *Ensign*, 1996 оны 5-р сар, 31).

- Уух ус хүссэн Елиагийн хүсэлтэд бэлэвсэн эмэгтэй хэрхэн хариулсан бэ? (Хаадын Дээд 17:10–11-ийг үз. Тэр эргэлзэлгүйгээр явсан) Елиа түүнээс идэх юм гуйхад бэлэвсэн эмэгтэй юу гэж хариулсан бэ? (Хаадын Дээд 17:11–12-ыг үз) Елиа түүнд юу амласан бэ? (Хаадын Дээд 17:13–14-ийг үз) Тэгэхэд бэлэвсэн эмэгтэй яасан бэ? (Хаадын Дээд 17:15-ыг үз) Бэлэвсэн эмэгтэйн хариултаас бид юу сурч болох вэ?

Елиаг түүнээс идэх юм хүсэхэд бэлэвсэн эмэгтэйн өгсөн хариулт бол “тухайн нөхцөл байдалд агуу итгэлийн илэрхийлэл байсныг судруудаас би мэддэг. . . . Тэр эмэгтэйн итгэлийн үнэ цэнэ юу байж болох нь тодорхой биш байж болно л доо . . . , тэр эхлээд жижигхэн зүсэм талхаа Елиа уруу авч очихдоо, юу ч цаана нь үлдээгүйг, адаглаж л цэвэр энэрлийн энэхүү үйлдлийн улмаас тэрээр өөрөө болон хүү нь өлсөж үхэж болно гэдгийг тов тодорхой мэдэж байсан нь лавтай” гэжээ (Conference Report, 1996 оны 4-р сар, 39; *Ensign*, 1996 оны 5-р сар, 29).

- Тэр эмэгтэйд өчүүхэн бага зүйл байхад яагаад Их Эзэн Елиад идэх юм өгөхийг бэлэвсэн эмэгтэйд зарлигласан бэ? Бэлэвсэн эмэгтэй дуулгавартай байдлынхаа төлөө ямар адислал хүлээж авсан бэ? (Хаадын Дээд 17:16-г үз) Хүнд хэцүү байж болох зарим ямар зүйлийг Бурхан биднээс хүсдэг вэ? Бид Бурханыг нэгдүгээрт тавьж, хичнээн хүнд хэцүү байлаа ч гэсэн, түүний хүссэнийг хийх юм бол бид ямар замуудаар адислагддаг вэ?

Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон сургахдаа:

“Бид Бурханыг нэгдүгээрт тавьсан үед, бусад бүх зүйл өөрийн зохих байрандаа орох буюу эсвэл бидний амьдралаас гээгддэг. Их Эзэнийг хайрлах бидний хайр бидний сэтгэл хөдлөлийн шаардлагууд, бидний цаг зав, бидний эрхэмлэдэг ашиг сонирхол хийгээд бидний эн тэргүүнд тавьдаг зүйлүүдийн дарааллыг удирдан чиглүүлэх болно. . . .

“[Түүнийг] нэгдүгээрт тавьснаар, үүний үр дүнд, энэ амьдралд мөн ирэх амьдрал дахь бүрэн баяр баясгалан бүхий мөнх амьдралд амар амгаланг хадаж авахаар Бурхан биднийг адислах болтугай” гэжээ (Conference Report, 1988 оны 4-р сар, 3, 6; *Ensign*, 1988 оны 5-р сар, 4, 6).

- Бэлэвсэн эмэгтэйн хүү өвчилж, нас барахад Елиа юу хийсэн бэ? (Хаадын Дээд 17:17–22) Бэлэвсэн эмэгтэйн хүүг Елиа ямар хүчээр амьдралд эргүүлэн авчрах боломжтой байсан бэ? Та нарын амьдрал санваарын хүчээр дамжин хэрхэн адислагдсан бэ?

2. Елиа Баалын санваартнуудыг сорьж, бороо оруулахаар тэнгэрийг нээв.

Хаадын Дээд 18-ыг зааж, ярилц.

- Өлсгөлөнгийн гурав дахь жилд Их Эзэн, “Явж, Ахабтай уулз; би газрын гадарга дээр бороо оруулах болно” гэж Елиад зарлиглав (Хаадын Дээд 18:1). Ахаб Елиаг хараад ямар хариу үйлдэл үзүүлсэн бэ? (Хаадын Дээд 18:17-г үз. Ахаб Елиаг өлсгөлөнд буруутгасныг тэмдэглэн хэл) Өлсгөлөнгийн жинхэнэ шалтгаан юу байсан бэ? (Хаадын Дээд 18:18-ыг үз)

- Елиагийн хүссэнээр Ахаб бүх Израилыг түүнчлэн 850 хуурамч санваартныг Кармел Уулан дээр цуглуулав (Хаадын Дээд 18:19–20). Елиагийн ярихыг сонсохоор хүмүүс цуглахад, “Та бүхэн хэдий болтол хоёр замын хооронд тээнэгэлзэх юм бэ?” (Хаадын Дээд 18:21). Хоёр замын хооронд гэсэн нь юу гэсэн утгатай гэж та нар бодож байна? Заримдаа бид хэрхэн хоёр замын хооронд байдаг вэ? (Матай 6:24-ийг үз. *Эд баялаг* гэдэг үг дэлхий (дэлхийн шинж чанар) гэсэн утгатайг анхаар)

Ахлагч Нийл А.Максвелл: “Янз бүрийн бошиглогчдын сэтгэл гижигдсэн үгс . . . зогсохыг биш, сонгохыг, шийдэхийг бидэнд шавдуулдаг. . . . Елиагийн захиас өнөө үед нэн ихээр холбогдоно, учир нь хүн бүгд эцсийн эцэст энэ дэлхийн бурхад эсвэл үүрд мөнхийн Бурханы аль нэгийг сонгох ёстой” хэмээн хэлжээ (*That My Family Should Partake* [1974], 22).

Баалын санваартнуудтай Елиагийн зөрчилдсөн тухай, даалгавар авсан нэг гишүүнээр товч илтгэл тавиулахаар бэлтгүүл (Хаадын Дээд 18:17–40).

- Баалын санваартнуудыг сорилтод оруулах Елиагийн зорилго юу байсан бэ? (Хаадын Дээд 18:36–37-г үз) Их Эзэний хүчийг үзүүлэхэд хүмүүс хэрхэн хариу үйлдэл үзүүлсэн бэ? (Хаадын Дээд 18:38–39-ийг үз) Их Эзэнийг болон түүний хүчийг хүлээн зөвшөөрснөөр тэд хэрхэн адислагдсан бэ? (Хаадын Дээд 18:45-ыг үз) Бид Их Эзэнийг болон түүний хүчийг хэрхэн илүү бүрэн дүүрнээр хүлээн зөвшөөрч чадах вэ? (1 Тесалоник 5:16–18; Алма 34:38; Моронай 7:33–39-ийг үз)

3. Елиа Ариун Сүнсээр тайтгаруулагдаж, Бурханы ажлыг үргэлжлүүлэхээр зааварлагдав.

Хаадын Дээд 19-ийг зааж, ярилц.

Баалын санваартнуудыг ялсан Елиагийн ялалтад уурссан Иезебел түүнийг алахаар эрэлхийлэв. Елиа аглаг буйд уруу зугтаж очоод, “Одоо хангалттай; Ай ЭЗЭН минь, одоо миний амийг аваач” гэж хэлжээ (Хаадын Дээд 19:4). Хүнс, устай тэнгэр элч илгээснээр Их Эзэн Елиаг адисалжээ. Бүр бошиглогчид ч гэсэн цөхөрч, зөвхөн Бурхан хангаж чадах тайтгарал хийгээд удирдамж тэдэнд хэрэгтэй байж болно гэдгийг та тэмдэглэн хэлэхийг хүсч болно.

- Елиа яагаад цөхөрсөн бэ? (Хаадын Дээд 19:10, 14. Бурханы хүчийг сонирхол татахуйцаар харуулсанд хүмүүсийн хариулт байсан ч гэсэн Елиа өөрийгөө үнэн Бурханыг шүтэн биширч үлдсэн цорын ганц израил хүн гэж бодож байв) Амар амгаланг олохын тулд тэр юу хийсэн бэ? (Хаадын Дээд 19:4, 8. Тэр залбирч, мацаг барьсан.) Хэрэв бид цөхөрч, гутрах буюу санаагаар унавал, өөрсөддөө туслахын тулд Елиагийн туршлагаас юу сурч болох вэ?
- Бурхан Хороб Уулан дээр Елиаг хэрхэн тайтгаруулсан бэ? (Хаадын Дээд 19:9–13-ыг үз) Бурхан бидэнтэй хэрхэн харилцдаг талаар бид үүнээс юу сурч болох вэ? Бурхан яагаад чанга дуугаар, хүчийг онцгойлон харуулах байдлаар биш, Ариун Сүнсний “намуухан зөөлөн дуу хоолойгоор” илүү олонтаа харилцдаг гэж та нар боддог вэ? Ариун Сүнсний шивнээг бид хэрхэн ялган таньж болох вэ?

Нэгэн сонины сурвалжлагч Ерөнхийлөгч Хинклигээс, та Бурхантай яаж харилцдаг вэ гэж асуухад, “Энэ үйл явцыг миний дүрсэлж чадах хамгийн шилдэг арга зам бол үүнийг Хаадын Дээд номонд дүрсэлсэн Елиагийн туршлагатай адилтгах явдал гэж би боддог. Елиа Бурханд хандан ярихад салхи, агуу салхи дэгдсэн хэдий ч, Их Эзэн салхин дотор байсангүй. Мөн газар хөдөлсөн боловч, Их Эзэн газар хөдлөлт дотор байсангүй. Мөн тэнд гал байв, Их Эзэн гал дотор мөн байсангүй. Галын дараа, үүнийг би Сүнсний шивнээ хэмээн дүрсэлдэг намуухан зөөлөн дуу хоолой гарчээ” гэж бошиглогч хариулсан байдаг (Conference Report, 1996 оны 10-р сар, 71; *Ensign*, 1996 оны 11-р сар, 51).

“Та Сүнсний өдөөлтүүдийг сонсоход цаг гаргадаг уу? Залбирлын хариу ихэвчлэн намуун зөөлхөн дуу хоолойгоор олонтаа ирдэг бөгөөд бидний гүн гүнзгий дотоод *мэдрэмжээр* танигддаг. Хэрэв та залбирч, сонсох цаг гаргадаг бол өөрийнхөө талаарх Бурханы тааллыг та мэдэж болно гэдгийг би та нарт хэлье” хэмээн Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон сургажээ (Conference Report, 1977 оны 10-р сар, 46; *Ensign*, 1977 оны 11-р сар, 32).

- Ариун Сүнс бол Тайтгаруулагч мөний зэрэгцээгээр бас багш юм (Иохан 14:26; 2 Нифай 32:5). Их Эзэн Ариун Сүнсээр дамжуулан юу хийхийг Елиад зааварласан бэ? (Хаадын Дээд 19:15–16-г үз) Их Эзэнд үйлчлэх нь биднийг санаагаар унаж цөхөрсөн үед бидэнд хэрхэн тусалдаг вэ?
- Их Эзэн Елиаг тайтгаруулсан нэг зам бол Баалын шүтээнийг хүлээн аваагүй израилчууд бас олон байсныг түүнд хэлсэн явдал юм (Хаадын Дээд 19:18). Итгэлтэй Хожмын үеийн бусад Гэгээнтнүүдтэй нөхөрлөх нь биднийг хэрхэн тайвшруулдаг вэ? Та ганцаараа биш гэдгийг мэдэхэд танд туслах тийм ямар нөлөөг та эргэн тойрныхоо хүмүүст үзүүлдэг вэ?

Дүгнэлт

Бид Бурханыг нэгдүгээрт тавьж, Ариун Сүнсний шивнээнд анхаарал тавьсан үед бид тайтгаруулагдаж, удирдагдах болно гэдгийг гэрчил.

Нэмэлт заах санаа Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

Елиагийн Сүнс

Хожмын үеийн Гэгээнтнүүд Елиагийн Сүнсний тухай олонтаа ярьдаг. “Эцгүүдийн зүрх сэтгэлийг хүүхдүүд уруу нь, мөн хүүхдүүдийнхийг эцгүүд уруу нь эргүүлэхийн” (С ба Г 110:15) тулд бидний хийдэг ажилд энэ өгүүлбэр холбогддог. Энэ ажил нь гэр бүлийн түүхийн судалгаа болон амьд байгаа хүмүүс хийгээд нас барагсдын төлөөх ариун сүмийн ажлыг багтаадаг. Елиа санваарын лацдах хүчний түлхүүрүүдийг Иосеф Смитэд сэргээн өгсөн учраас бид үүнийг Елиагийн Сүнс хэмээн нэрлэдэг (С ба Г 110:13–16). Энэ хүчээр дамжин, гэр бүлүүдийг үүрд мөнхөд лацдах ёслолууд гүйцэтгэгдэж болдог.

Иосеф Смит хэлэхдээ:

“Елиагийн Сүнс, хүч болон дуудлага бол, та нарын атгадаг илчлэлийн, ёслолуудын, зөн билгийн, Мелкизедек санваарын болон газар дээрх Бурханы хаант улсын бүрэн байдлын хүчнүүдийн болон ариун сүмийн хишгийн түлхүүрүүд; түүнчлэн Бурханы хаант улсад хамаардаг бүх ёслолуудыг хүлээн авах, олж авах, түүнчлэн гүйцэтгэх, бүр эцгүүдийн зүрх сэтгэлийг хүүхдүүд уруу нь, мөн хүүхдүүдийн зүрх сэтгэлийг бүр тэнгэрт байгаа эцгүүд уруу нь эргүүлэх түлхүүрүүд юм. . . .

“Энэ сэдвийг та нар ойлгоосой гэж би хүсч байна, учир нь энэ бол чухал юм; хэрэв та нар үүнийг хүлээн авах юм бол, энэ бол бид өөрсдийн нас барагсдыг гэтэлгэдэг, биднийг тэнгэр дэх эцгүүдтэй маань холбодог, түүнчлэн бидний нас барагсдыг эхний амилуулалтад босч ирэхэд нь лацаддаг Елиагийн сүнс юм; үүгээр бид газар дээр амьдардаг хүмүүсийг тэнгэрт оршдог хүмүүстэй лацдан холбодог Елиагийн хүчийг хүсдэг билээ. Энэ бол Елиагийн хүч, Иеховагийн хаант улсын түлхүүрүүд юм” гэжээ (*Teachings of the Prophet Joseph Smith*, эмхтгэсэн. Иосеф Фиелдинг Смит [1976], 337–38).

Зорилго Эрх мэдэл (нөмрөг) хэрхэн нэг бошиглогчоос нөгөөд шилждэг байсныг ойлгоход нь, бошиглогчдын үгсийг дуулгавартай дагахад нь, Бурханы хүч бол бусад ямар ч хүчнээс илүү агуу гэдэгт итгэхэд нь ангийн гишүүдэд туслах.

- Бэлтгэл**
1. Дараах судруудыг залбирч судал:
 - а. Хаадын Дэд 2:1–18. Елиа Елишаг шинэ бошиглогч болоход нь бэлтгэв (2:1–10). Елиа тэнгэрт аваачигдав. Елиша Елиагийн нөмрөгийг авч, бошиглогч болов (2:11–15). Тэд үүнийг хийх хэрэггүй гэж зөвлөсөн Елишагийн зөвлөгөөг үл хайхран, тавин хүн Елиаг гурван өдөр хайв (2:16–18).
 - б. Хаадын Дэд 5. Елиша Нааманыг уяман өвчнөөс нь эдгээв (5:1–14). Нааман Бурханыг магтаж, Елишад шагнал санал болгоход Елиша татгалзав (5:15–19).
 - в. Хаадын Дэд 6:8–18. Сиритэй хийсэн дайнд Елиша Израилын хааныг удирдав (6:8–10). Сирийн хаан Елишаг баривчлахыг өөрийн хүмүүст зарлиглаж, цэрэг нь Дотаны хотыг бүслэв (6:11–14). Елиша айлгүй залбирч, морьд болон галт тэргүүдээр дүүрэн уулыг Их Эзэн илчилж, тэгээд Сирийн цэргүүдийн нүдийг сохлон бут цохьжээ (6:15–18).
 2. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашиглах бол, нөмрөг болгон хэрэглэх хэсэг даавуу авчир.

Энэ хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагааг (эсвэл өөрийхөө нэг үйл ажиллагааг) ашиглахыг хүсч болно.

Хэсэг даавууг мөрөн дээгүүрээ нөмөр (эсвэл ангийн нэг гишүүний мөрөн дээгүүр нь нөмөргө). Бошиглогч Елиа нөмрөг нөмөрдөг байсныг тайлбарла. Нөмрөг ямар харагддаг байсныг бид яг тодорхой мэдэхгүй, гэвч энэ нь даавуугаар хийсэн хувцас байсан бололтой. Нөмрөгийг Елиагаас Елишад дамжуулсан нь бошиглолын эрх мэдлийг Елишад дамжуулсныг бэлэгдсэн ажээ.

Өнөө үед бид заримдаа бошиглогч томилогдож, онцгойлон адислагдах үед түүний хүлээн авдаг эрх мэдлийн “нөмрөгийн” тухай ярьдаг. Өнөөдөр бошиглогч хэдийгээр хувцас буюу хэсэг даавуу авч явдаггүй ч гэсэн, Бурхан санваарын түлхүүрүүдийг түүнд олгодог. Эдгээр түлхүүрүүд газар дэлхий дээрх Сүмийн удирдагчийн хувьд Бурханы нэрээр үйл ажиллагаа явуулах хүчийг түүнд олгодог. Бошиглогч нас барахад эрх мэдлийн энэ нөмрөг шинэ бошиглогчид олгогддог.

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагауудаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Елиша бошиглогч болж, Елиаг залгамжлав.

Хаадын Дэд 2:1–18-ыг зааж, ярилц.

- Елиа, Елиша хоёрын хооронд ямар холбоо байсан бэ? (Хаадын Дэд 2:2–10) Елиша яагаад Елиатай хамт байх тийм их сонирхолтой байсан гэж та нар боддог вэ? Елиаг тэнгэрт аваачигдсаны дараа Елиша юу хийсэн бэ? (Хаадын Дэд 2:11–13. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг хэрэглээгүй бол, Елиагийн нөмрөг гэж юу байсан, мөн энэ нь юуг төлөөлдөг байсныг тайлбарлахад үүнийг хэл)
- Өнөөдөр бошиглогчийн нөмрөг хэнд байдаг вэ? (Сүмийн одоогийн ерөнхийлөгчид) Бошиглогч нас барахад энэ нөмрөг хэрхэн дамжуулагддаг вэ?

Ерөнхийлөгч Иосеф Фиелдинг Смит тайлбарлахдаа:

“Сүмийн Ерөнхийлөгчийг залгамжлах хүнийг сонгох тухайд нууц юм байдаггүй. Их Эзэн үүнийг бүр эрт дээр үед тогтоосон бөгөөд *хамгийн ахмад төлөөлөгч аяндаа Сүмийн тэргүүлэх ажилтан болдог*, мөн тэрээр Тэргүүн Зөвлөл байхгүй тохиолдолд тэргүүлэх байгууллага болдог Арванхоёрын Зөвлөлөөр дэмжин батлагддаг. Ерөнхийлөгч *сонгогддоггүй*, харин тэрээр Зөвлөлийн ах нараараа, бас Сүмийн гишүүдээр хоёулангаар нь *дэмжин батлагддаг*” гэжээ (*Doctrines of Salvation*, эмхтгэсэн. Брус Р.МкКонки, 3 боть. [1954–56], 3:156).

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли Ерөнхийлөгч Ховард В.Хантерыг нас эцэслэсний дараа тэрээр бошиглогч болон Сүмийн Ерөнхийлөгчөөр томилогдож, онцгойлон адислагдах үед энэ журам хэрхэн мөрдөгдсөнийг тайлбарлахдаа:

“Ерөнхийлөгч Хантерыг талийгаач болоход, Тэргүүн Зөвлөл тарав. Түүний зөвлөхүүдээр үйлчилж байсан Монсон Ах бид хоёр Сүмийн тэргүүлэх эрх мэдэл болсон Арванхоёрын Чуулгад өөрсдийн байрыг эзэллээ.

“[Хэдэн өдрийн дараа] амьд байгаа томилогдсон бүх төлөөлөгчид ариун сүмийн дээд өрөөнд мацаг барилт хийгээд залбирлын сүнсэнд цугларав. Энд бид нэг ариун дуулал дуулж, хамтдаа залбирав. Бид Их Эзэний үдшийн зоогны ариун ёслолоос хүргэж, бидний бурханлиг Гэтэлгэгч болох Түүнтэй хийсэн өөрсдийн гэрээнүүд болон харилцаа холбоогоо энэхүү ариун, бэлэгдлийн гэрээнд шинэчлэв. Тэгээд Тэргүүн Зөвлөл дахин зохион байгуулагдахад өнгөрсөн үеийнхнээр дамжин сайн зохион байгуулагдсан урьдах хэлбэрийг баримталсан байлаа [энэхүү урьдах хэлбэрийг өмнөх мэдэгдэлд Ерөнхийлөгч Иосеф Фиелдинг Смит тайлбарлажээ]. Энд албан тушаалын төлөөх ямар нэгэн кампаничлал, тэмцэл, санаархал байсангүй. Энэ нь нам гүм, амар амгалан, энгийн хийгээд ариун байлаа. Энэ нь Их Эзэний Өөрийнх нь бий болгосон загварын дагуу хийгдсэн билээ” гэжээ (*Conference Report*, 1995 оны 4-р сар, 92; *Ensign*, 1995 оны 5-р сар, 69).

Аврагч эрт дээр үеийн нэгэн адил санваарын түлхүүрүүдийг хожмын үеийн Төлөөлөгч нэг бүрд өгснийг та тэмдэглэн хэлж болно. Гэвч, амьд

байгаа хамгийн ахмад настай Төлөөлөгч болох Сүмийн Ерөнхийлөгч л зөвхөн эдгээр түлхүүрүүдийг бүхэл Сүмийн нэрийн өмнөөс ашиглаж болно (эсвэл эдгээр түлхүүрүүдийг ашиглах эрхийг бусдад олгож болно) (С ба Г 132:7-г үз).

- Елиша Иордан голын усыг салгаж, Елиагийн гайхамшигийг давтахыг хараад хүмүүс хэрхэн хариу үйлдэл үзүүлсэн бэ? (Хаадын Дэд 2:14–15-ыг үз) Шинээр томилогдсон Сүмийн Ерөнхийлөгчийг бид тэр дауид хүлээн авч, дэмжин батлах нь яагаад чухал вэ? (С ба Г 43:2–3, 7-г үз)
- Елиаг тэнгэрт аваачигдсаны дараа удалгүй түүнийг эрэхийн тулд 50 хүчирхэг хүнийг илгээхийг хүмүүс хүсчээ. Елиша хүмүүст юу гэж хэлсэн бэ? (Хаадын Дэд 2:16-г үз) Елишагийн хариултад хүмүүс хэрхэн хариулсан бэ? (Хаадын Дэд 2:17. Тэд хүмүүсийг явуулахыг зөвшөөрөөч гэж Елишагаас гуйж байв.)
- 50 хүн Елиаг ололгүй эргэж ирэхэд нь Елиша юу гэж хэлсэн бэ? (Хаадын Дэд 2:18-ыг үз) 50 хүний туршлагаас бид юу сурч болох вэ? (Бид бошиглогчийн зөвлөгөөг анх сонссон үедээ дагаж байх ёстой.) Яагаад бид зарим үед бошиглогчийн зөвлөгөөг дагахаасаа өмнө тэрээр үүнийг давтан хэлэхийг хүсдэг вэ? Саяхны жилүүдэд Сүмийн удирдагчид бидэнд ямар зөвлөгөө өгсөн бэ? Энэ зөвлөгөөг дагаснаар та нар хэрхэн адислагдсан бэ?

2. Елиша Нааманыг уяман өвчнөөс нь эдгээв.

Хаадын Дэд 5-ыг зааж, ярилц.

- Нааман гэж хэн байсан бэ, түүний зовлон юу байв? (Хаадын Дэд 5:1). Тэр яагаад Елиша уруу очсон бэ? (Хаадын Дэд 5:2–9-ийг үз) Эдгэрэхийн тулд юу хийх ёстой гэж Елиша Нааманд хэлсэн бэ? (Хаадын Дэд 5:10-ыг үз) Яагаад Нааман эхлээд Елишагийн зааврыг дагахаас татгалзсан бэ? (Хаадын Дэд 5:11–12-ыг үз)
- Елишагийн хий гэснийг хий хэмээн Нааманы зарц нар түүнд хэрхэн ятгасан бэ? (Хаадын Дэд 5:13-ыг үз) Нааман Иордан голд долоон удаа шунгахад юу тохиолдсон бэ? (Хаадын Дэд 5:14-ийг үз)
- Бошиглогчийн зөвлөгөөнд бид дургүй байх буюу ойлгохгүй байх, эсвэл энэ нь жижигхэн, энгийн зүйлүүдээр байлаа ч гэсэн, үүнийг дагах талаар Нааманы түүх бидэнд юу зааж чадах вэ? Бошиглогч буюу Сүмийн бусад удирдагчид биднээс хийхийг хүсдэг жижиг, энгийн зарим зүйлүүд юу вэ? Яагаад эдгээр зүйлүүд зарим үед хийхэд хэцүү байдаг вэ? Сүмийн удирдагчдын зөвлөгөөг дагах хүслээ бид хэрхэн дээшлүүлж чадах вэ?

“Бид зарим үед Нааман шиг, бидний амьдралыг өөрчилж, биднийг зовлонгуудаас маань илааршуулж чадах жижиг зүйлүүдийн дэргэдүүр өнгөрөн, илүү том буюу чухал зүйлүүдийг хийхээр эрж хайдаггүй гэж үү?” хэмээн Ахлагч Рекс Д.Пинегар асуусан байдаг (Conference Report, 1994 оны 10-р сар, 106; *Ensign*, 1994 оны 11-р сар, 80).

Ахлагч Гордон Б.Хинкли Нааманы тухай түүхийг эргэн санаж, хэлэхдээ: “Сайн мэдээний арга зам бол энгийн юм. Шаардлагуудын зарим нь та нарт энгийн бөгөөд хэрэгтэй биш ч юм шиг санагдаж болно. Тэдгээрийг бүү үл ойшоо. Өөрсдийгөө даруусгаж, дуулгавартай байдалд алхал. Дараа нь гарах үр дүн нь харахад гайхамшигтай, биеэр амсаж туулахад сэтгэл ханамжтай байх болно гэдгийг би амлаж байна” гэжээ (Conference Report, 1976 оны 10-р сар, 143; *Ensign*, 1976 оны 11-р сар, 96).

- Нааман өөрийнхөө эдгэрэлтээс юу сурсан бэ? (Хаадын Дэд 5:15-ыг үз) Энгийн зүйлүүдэд дуулгавартай байх нь бидний гэрчлэлийг хэрхэн бэхжүүлдэг вэ?
- Эдгэрснийхээ дараа Нааман Елишад юу өгөх гэж оролдсон бэ? (Хаадын Дэд 5:15-ыг үз) Елиша яагаад Нааманы саналаас татгалзсан гэж та нар бодож байна? Дэлхийн шагналуудын төлөө санаархалгүйгээр үйлчлэх нь яагаад чухал вэ?

3. Сиритэй хийсэн дайнд Елиша Израилыг удирдав.

Хаадын Дэд 6:8–18-ыг зааж, бэлтгэв.

- Сирийн эсрэг хийсэн дайнд Елиша Израилын хаанд хэрхэн тусалсан бэ? (Хаадын Дэд 6:8–10-ыг үз) Елишагийн хийснийг мэдээд Сирийн хаан яасан бэ? (Хаадын Дэд 6:11–14-ийг үз)
- Хотыг бүсэлсэн Сирийн морьд болон сүйх тэргүүдийг хараад Елишагийн зарц үүнд хэрхэн хариулсан бэ? (Хаадын Дэд 6:15-ыг үз) Елиша хэрхэн хариулсан бэ? (Хаадын Дэд 6:16-г үз) “Бидэнтэй хамт байгчид тэдэнтэй хамт байгчдаас илүү олон” гэж Елиша зарцдаа хэлсэн нь юу гэсэн үг вэ? (Хаадын Дэд 6:16) Елишагийн үг өнөөдөр ч гэсэн үнэн байгааг та нар хэрхэн харж байна вэ?
- Өнөө үеийн ямар нөхцөл байдлууд, бид дэлхийн хилэнцүүдийн эсрэг хүчин мөхөсдөж байгаа гэдэгт итгэхэд бидний заримыг хөтөлж болох вэ? “Бидэнтэй хамт байгчид тэдэнтэй хамт байгчдаас илүү олон” гэсэн итгэл, эдгээр хилэнцүүдийн эсрэг тулалдахад бидэнд хэрхэн тусалж чадах вэ?
 “Би хөвгүүн байхдаа энэ гайхамшигтай түүхийг уншаад, Елишагийн залуу зарцгай адилхан байхыг ямагт хүсдэг байж билээ. Би Их Эзэний үйлчлэлд байх үед, хэдийгээр би хилэнцийн хүчнүүдээр хүрээлэгдлээ ч гэсэн, Их Эзэн нүдийг минь нээнэ гэж би боддог байв, бид Их Эзэний ажилд байгаа цагт, бидэнтэй хамт байгаа хүмүүс биднийг эсэргүүцдэг хүмүүсээс ямагт илүү хүчирхэг байдгийг ойлгох итгэлийг надад төрүүлэх болно гэдэгт би найддаг” гэж Ахлагч Даллин Х.Өүкс хэлжээ (Conference Report, 1992 оны 10-р сар, 54; *Ensign*, 1992 оны 11-р сар, 39).
- “Бидэнтэй хамт байгчид тэдэнтэй хамт байгчдаас илүү олон” гэсэн итгэл нь бид сайн мэдээг бүх хүмүүст хүргэхэд бидэнд хэрхэн тусалдаг вэ? (С ба Г 84:87–88-ыг үз)
 “Бид сайн мэдээг үндэстэн, ястан, хэлтэн, хүмүүс бүрд хараахан хүргээгүй байна. Гэвч бид том алхам хийгээд байна. Хүрч очихыг бидэнд зөвшөөрдөг тэр газруудад бид хүрч очлоо. Бурхан залууртаа байна, мөн Түүний бурханлиг тааллын дагуу Түүний хүчээр хаалганууд нээгдэх болно. Энэ тухайд би итгэлтэй байна. Энэ тухайд би эргэлзэхгүй байна” хэмээн Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хэлжээ (Conference Report, 1995 оны 10-р сар, 93; *Ensign*, 1995 оны 11-р сар, 70–71).
- Зарцынхаа өмнөөс хийсэн Елишагийн залбирал юу байсан бэ? (Хаадын Дэд 6:17-г үз) Уул бүхэлдээ Бурханы илгээсэн галт морьд, тэргээр дүүрснийг яагаад зарц эхлээд хараагүй вэ? Бидний амьдрал дахь болон дэлхий дээрх Бурханы хүчийг илүү бүрэн дүүрнээр харахын тулд бид нүдээ хэрхэн нээж чадах вэ?

Сүмийн Ерөнхийлөгч бол Бурханы бошиглогч гэдгийг гэрчил. Сүмийн шинэ удирдагчдыг дэмжихэд нь болон бошиглогчдын зөвлөгөөг дагахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж. Бурханы хүч бусад аливаа хүчнээс илүү агууг гэрчил.

Нэмэлт заах санаанууд

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

1. Елишагийн гайхамшгууд

Елиша хүмүүсийн төлөөх өрөвч сэтгэл хийгээд өөрийгөө Елиагийн эрх олгогдсон залгамжлагч болохыг нотлон харуулж, олон агуу гайхамшгуудыг үйлдсэн ажээ. Тэрээр Иордан голын усыг салгаж, Иерихогийн усыг эдгээж, бэлэвсэн эмэгтэйн тосыг арвижуулан, нэг хөвгүүнийг үхэгсдээс босгож, хордсон хүмүүсийг эдгээж, өлсгөлөн хүмүүсийг хооллож, Нааманы уяман өвчнийг эдгээн, сүхийг усанд хөвөх болгож, хаадыг дайнд удирдаж байв. Та Хаадын Дэд 2–6-гаас эдгээр гайхамшгуудын заримыг нь нэгтгэн дүгнэж болно.

- Манай өнөө үед гайхамшгууд Елишагийн үед тохиож байсантай адил хэмжээгээр тохиодог гэж та нар боддог уу? Зөвхөн ер бусын онцгой гайхамшгуудыг хүсэн хүлээхийн аюул юу вэ? Жижигхэн юм шиг санагддаг ямар гайхамшгууд бидний амьдралд тохиодог вэ?

2. Нэгэн залуу израил охин Елишагийн тухай Нааманд хэлэв

- Елиша болон түүний эдгээгч хүчний талаар Нааман яаж мэдсэн бэ? (Хаадын Дэд 5:2–4-ийг үз. Сиричүүдэд олзлогдсон нэг залуу израил охин Нааманыг эдгээж чадах нэгэн бошиглогч Израилд байдгийг Нааманы эхнэрт ярьжээ.) Энэ залуу израил охин бидэнд хэрхэн үлгэр жишээ болж чадах вэ? (Бид нас, Сүм дэх нөхцөл байдал буюу Сүмийн дуудлагаасаа үл хамааран, хүмүүсийг бошиглогчдод, түүнчлэн Их Эзэнд хандахад чиглүүлснээр сайн зүйл ихийг хийж чадна.)

Шастирын Дэд 29–30; 32; 34

Зорилго Ариун сүмийн ажлаас болон судрууд судлахад ирдэг амлагдсан адислалуудыг хүлээж авахад нь ангийн гишүүн бүрд сүнслэгээр нөлөөлөх.

- Бэлтгэл**
1. Дараах судруудыг залбирч судал:
 - а. Шастирын Дэд 29–30. Иудейн хаан Хезекиа ариун сүмийн хаалгуудыг нээж, шүтэн бишрэхэд зориулан үүнийг цэвэршүүлж, ариусгахыг санваартнууд болон левичүүдэд зааварлав (29:1–19). Ариун сүм цэвэршигдэхэд, Хезекиа болон түүний хүмүүс Их Эзэнийг шүтэн биширч, магтав (29:20–36). Хезекиа бүх Израилыг Иерусалим дахь Их Эзэний өргөөнд ирэхийг урив (30:1–9). Зарим хүмүүс уг урилгыг шоолж, тохуурсан хэдий ч, Израилын итгэлтнүүд Иерусалимд Их Эзэнийг шүтэн бишрэв (30:10–27).
 - б. Шастирын Дэд 32:1–23. Ассирийн хаан Сеннахериб Иудейг довтлон, Их Эзэний талаар доромжилсон үг хэлжээ (32:1–19). Исаиа, Хезекиа хоёр тусламжийн төлөө залбирч, Их Эзэний тэнгэр элч Ассирийн цэргээс олныг нь устгав (32:20–23).
 - в. Шастирын Дэд 34. Хезекиагийн хүү, ач хүү ёс бусаар захирсны дараа Хезекиагийн ачинцар Иосиа Иудейн хаан болов. Иосиа хаант улс дахь хиймэл шүтээнүүдийг устгаж, ариун сүмийг засварлажээ (34:1–13). Ариун сүмээс хуулийн номыг олж, Иосиад уншиж өгөхөд, хүмүүс хуулиас хичнээн их холдсоныг мэдээд тэрээр уйлжээ (34:14–21). Эмэгтэй бошиглогч Хулда айсуй яваа Иудейн эзгүйрлийн тухай өгүүлсэн хэдий ч, Иосиа үүнийг гэрчлэхгүй хэмээн бошиглов (34:22–28). Иосиа болон түүний хүмүүс Их Эзэнд үйлчлэхээр гэрээнд оров (34:29–33).
 2. Нэмэлт уншлага: Шастирын Дэд 31; 33; Хаадын Дэд 18–19; 22–23; Исаиа 37:10–20, 33–38.
 3. Хэрэв дараах зургууд байдаг бол та тэдгээрийг хичээлийнхээ үеэр ашиглаж болно: Эрт үед ашиглагдаж байсан ариун сүм (62300), мөн хожмын үеийн нэг ариун сүмийн зураг.

**Энэ хичээлийг
заах зөвлөмж**

Анхаарал
төвлөрүүлэх
үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагааг (эсвэл өөрийхөө нэг үйл ажиллагааг) ашиглахыг хүсч болно.

Иерусалимыг ассиричуудын довтолгооноос хамгаалахад туслахын тулд Хезекиа Хаан Гихон булгийн усыг Силоамын цөөрөм уруу хотын хэрэмний дотор тал уруу урсахаар тасалсныг тайлбарла (Шастирын Дэд 32:2–4, 30). 540 метр орчим урт шохойн чулуун дундуур урсах усанд зориулж хонгил ухах замаар үүнийг хийсэн ажээ. Тэгээд ассиричуудыг усанд хүрэх боломжгүй болгохын тулд хотын гаднах оргилууруудыг булж дарахыг

Хезекиа тушаажээ. Хотын хэрмэн доторх энэ усгүйгээр Иерусалимын хүмүүс ассиричуудын бүслэлтийг тэсэн гарч чадахгүй байсан юм.

Ассиричуудтай хийсэн тэдний тулалдааны үед Гихон булгийн ус Хезекиагийн хүмүүсийг тэсэн амьд үлдэхэд амин чухал байсны нэгэн адил амьдралын ус нь Сатантай хийдэг бидний тэмцэлд бид сүнслэг байдлын хувьд тэсэн гарахад амин чухал юм.

- Амьдралын ус гэж юу вэ? (Иохан 4:10–14-ийг үз)

Амьдралын ус бол “мөнх амьдралын үгс, авралын захиас, Бурхан болоод түүний хаант улсын тухай үнэнүүд юм; энэ бол сайн мэдээний сургаалууд” гэж Ахлагч Брус Р.МкКонки тайлбарласан байдаг (*Doctrinal New Testament Commentary*, 3 боть. [1966–73], 1:151).

- Амьдралын ус бидний амьдралд урсан орж ирэхийн тулд бид Их Эзэнд хүрэх хонгилыг хэрхэн нээж болох вэ?

Амьдралын усыг хүлээж авах нэг арга зам бол бид хүч хийгээд ойлголтоор ариун сүмийн хишиг хүртэж, Их Эзэнээр зааварлагдан, амар амгалан болоод баяр баясгаланг мэдэрдэг Их Эзэний өргөө, ариун сүмд орох явдал мөн.

Ариун сүм дэх шүтлэг бол Хезекиагийн үед израилчуудын хувьд чухал хамгаалалт байсан бөгөөд энэ нь бас манай өнөө үед бидний хувьд чухал хамгаалалт байж чадна гэдгийг тэмдэглэн хэл.

Судрын ярилцлага
ба хэрэглээ

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагуудаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Их Эзэний өргөөг ариусгахыг Хезекиа тушаав.

Шастирын Дэд 29–30.

- Хезекиагийн эцэг Ахаз бол Их Эзэний өргөөг бузарлаж, “[үүний] хаалгуудыг хаасан” (Шастирын Дэд 28:24) ёс бус хаан байв. МЭӨ 715 онд тэрээр Иудейн (Өмнөд Хаант Улс) хаан болсон үедээ түүний хийсэн анхны зүйлүүдийн нэг нь ариун сүмийн хаалгуудыг нээж, үүнийг ариусгахыг санваартнууд болон левичүүдэд тушаасан явдал байв (Шастирын Дэд 29:3–5). Хезекиагийнхаар бол, яагаад ариун сүмийг ариусгах хэрэгтэй байсан бэ? (Шастирын Дэд 29:6–7-г үз) Бас ямар байдлаар [бид] Их Эзэний заншлуудаас “[нүүрээ] буруулж болох вэ?” Ариун сүмийг гутаан доромжилсны улмаас Иудейн хүмүүст юу тохиосон бэ? (Шастирын Дэд 29:8–9-ийг үз)
- Ариун сүмийг цэвэршүүлж, үүнийг шүтлэг бишрэлийн төлөө дахин бэлтгэснээр юунд хүрнэ гэж Хезекиа найдаж байсан бэ? (Шастирын Дэд 29:10-ыг үз) Цэвэр ариун бус зүйлүүдийг ариун сүмээс хол байлгах нь яагаад чухал вэ? (С ба Г 97:15–17) Цэвэр ариун бус зүйлүүдийг ариун сүмд оруулахгүй байлгах бидний үүрэг хариуцлага юу вэ? (С ба Г 109:20–21-ийг үз. Бид ариун сүм рүү явахдаа цэвэр ариун байх ёстойг анхаарах хэрэгтэй.)
- Ариун сүм цэвэршигдэхэд Хезекиа болон Иерусалим дахь түүний хүмүүс юу хийсэн бэ? (Шастирын Дэд 29:20–21, 29–31, 36-г үз) Дээгүүр Өнгөрсний Баярыг тэмдэглэхийн тулд Их Эзэний өргөөнд ирэхэд хэнийг Хезекиа

урьсан бэ? (Шастирын Дэд 30:1, 6) Энэ урилга хэрхэн хүлээн авагдсан бэ? (Шастирын Дэд 30:10–11-ийг үз)

- Ариун сүмд ирэхийг татгалзсанаараа Израилын хүмүүс ямар адислалуудаа алдсан бэ? (Шастирын Дэд 30:6–9-ийг үз. Хезекиагийн хаанчлалын үед Израилын хаант улсын [Умард Хаант Улс] ихээхэн хэсэг ассиричуудын боолчлолд аваачигдсаныг тайлбарла. Хэрэв тэд “Их Эзэнд дахин эргэх” юм бол, боолчлолоос чөлөөлөгдөх болно гэдгийг Хезекиа үлдсэн израилчуудад амлажээ. Гэвч ингэхийн оронд Израилын ихэнх хүмүүс Хезекиагийн урилгыг эсэргүүцсэн ажээ. Хүмүүсийн ёс бусын улмаас, Израилын хаант улсаас үлдсэн нь хэдэн жилийн дараа боолчлолд аваачигдсан билээ. [Шастирын Дэд 18:10–12] Боолчлолд аваачигдсан израилчууд алдагдсан арван овог болжээ.)

2. Ассиричууд Иудейн хаант улсад халдан довтлов. Исаиа, Хезекиа нар тусламж хүсэн залбирч, Их Эзэн Ассирийн цэргээс олныг нь устгав.

Шастирын Дэд 32:1–23-ыг зааж, судал.

- Израилын хаант улс боолчлолд аваачигдсаны дараа ассиричууд Иудейн хаант улсыг довтолж эхлэв (Шастирын Дэд 32:1). Сеннахерибийн цэрэг Иерусалимд халдан довтлохыг Хезекиа хараад тэрээр юу хийсэн бэ? (Шастирын Дэд 32:2–5-ыг үз) Хезекиа дайны бэлтгэлүүдийг хийсний дараа заналхийлсэн довтолгооны талаар өөрийн хүмүүст юу гэж хэлсэн бэ? (Шастирын Дэд 32:6–8-ыг үз) Өөрсдийнхөө хүчинд итгэх, Их Эзэнд итгэх хоёрын хоорондох зохих харьцааны талаар бид Хезекиагаас юу сурч болох вэ?
- Иерусалим дахь хүмүүст яриулахын тулд Сеннахериб өөрийн зарц нарыг явуулжээ. Зарц нар юу гэж хэлсэн бэ? (Шастирын Дэд 32:9–17-г үз) Тэд яагаад эдгээр зүйлүүдийг хэлсэн бэ? (Шастирын Дэд 32:18-ыг үз) Бурхан бидэнд тусалж чадахгүй буюу туслахгүй гэдгийг Сатан бидэнд ямар арга замуудаар ятгах гэж оролддог вэ?
- Хезекиа болон бошиглогч Исаиа Сеннахерибийн зарц нарын үгст хэрхэн хариулсан бэ? (Шастирын Дэд 32:20; Исаиа 37:14–20-ийг үз) Хезекиагийн болон Исаиагийн залбирлуудад Их Эзэн хэрхэн хариулсан бэ? (Шастирын Дэд 32:21–22; Исаиа 37:33–38-ыг үз)
- Ариун сүм дэх тэдний шүтлэг бишрэлээр харагдсан, тэдний зөв шударга байдлын учир Хезекиа болон түүний хүмүүс Их Эзэний хамгааллыг хүлээн авсан юм. Ариун сүмд орох нь хэрхэн бидний хамгаалалт болох вэ? (С ба Г 109:24–28-ыг үз) Ариун сүмийн зохистой байдал хийгээд үүнд орохыг бид хэрхэн амьдралынхаа эн тэргүүнд тавих зүйл болгож чадах вэ?

Ерөнхийлөгч Ховард В.Хантер:

“Ариун сүмд ордог хүмүүс байцгаая. Хувийн нөхцөл байдалд боломж олгохын хэрээр ариун сүмд аль болох олон удаа орогтун. Хүүхдүүд чинь харж болох газарт ариун сүмийн зургийг гэр орондоо байлга. Их Эзэний өргөөний зорилгуудын тухай тэдэнд заа. Тэднийг бага наснаас нь ариун сүмд очуулахаар төлөвлөж, энэхүү адислалыг хүртэхүйц зохистой байлга.

“Хэрэв ариун сүмд төлөөлөн хийлгэх ёслол нь байнга тийшээ явах боломж олгохгүй байвал, гэр бүлийнхээ түүхийг цуглуулж, зөвхөн ариун сүмд

гүйцэтгэдэг ариун ёслолуудад зориулж, нэрс бэлтгэ. Гэр бүлийн энэхүү судалгаа ариун сүмүүдийн ажилд нэн чухал бөгөөд энэ ажлыг хийдэг хүмүүст адислалууд ирэх нь дамжиггүй” хэмээн урамшуулан дэмжжээ (Conference Report, 1994 оны 10-р сар, 8; *Ensign*, 1994 оны 11-р сар, 8).

3. Иосиа болон түүний хүмүүс Их Эзэнд үйлчлэх гэрээнд оров.

Шастирын Дэд 34-ийг зааж, ярилц.

Хезекиаг түүний хүү Манассе, ач хүү Амон нар (Шастирын Дэд 33) залгамжлав. Манассе ариун сүмд хиймэл шүтээнүүдийг байрлуулан, хүмүүсийг нүгэлд удирдаж, Иудейг ёс бусаар захирав. Эцсийн эцэст Манассе өөрийгөө даруусгаж, нас эцэслэхийнхээ өмнө наманчилсан ажээ. Манассегийн хүү Амон эцгийнхээ хийсэн хиймэл шүтээнүүдийг шүтэн биширч, бас ёс бусаар захирч байжээ. Амон наманчилсангүй, тэгээд тэр зарц нартаа алагджээ. Амоны хүү Иосиа найман настайдаа Иудейн хаан болгогдов. Тэрбээр эцгийнхээ болон өвөг эцгийнхээ ёс бус замуудыг эсэргүүцсэн зөв шударга хаан болжээ.

- Иосиа Хаан ямар хүн байсан бэ? (Шастирын Дэд 34:1–2; Шастирын Дэд 23:25-ыг үз. Шастирын Дэд 34:2-г дурдагддаг Давид бол Иосиагийн өөрийнх нь эцэг биш, харин Иосиагийн өвөг дээдэс Давид Хаан гэдгийг анхаар)
- Иосиа хаан болж залагдсан эхний жилүүдэд ямар сайн зүйлүүд хийсэн бэ? (Шастирын Дэд 34:3–8-ыг үз. Тэр үнэн Бурханыг эрэлхийлж, хаант улс дахь хиймэл шүтээнийг устгаж, ариун сүмийг засуулахаар хүмүүс явуулжээ. Иосиа эдгээр чухал өөрчлөлтүүдийг хийж эхлэх үед тэрээр дөнгөж 15 буюу 16 настай байсныг тэмдэглэн хэл)
- Ариун сүмийг шинэчлэх үед дээд санваартан Хилка ямар чухал нээлт хийсэн бэ? (Шастирын Дэд 34:14-ийг үз. Тэрээр Их Эзэний хуулийн ном буюу судруудыг олжээ. Иудейн түүхэн дэх энэ үед тэрхүү бичмэл хууль алдагдаж, чухам яасан нь мэдэгдэхгүй байсныг анхаар) Хуулийн номыг түүнд уншиж өгөхөд Иосиа хэрхэн хариу үйлдэл үзүүлсэн бэ? (Шастирын Дэд 34:19-ийг үз. Уй гашуу буюу их гунигийг харуулахын тулд хувцсаа урж, тасчдаг нь эртний Израил дахь заншил байсныг анхаар) Хуулийн номонд юу агуулагдаж байсныг сонссон Иосиа яагаад тийм ихээр гутарсан бэ? (Шастирын Дэд 34:21-ийг үз)
- Хүмүүс Их Эзэний үгийг сахиагүйн улмаас, түүнчлэн судруудын заадаг зүйлүүдийг хийгээгүйн улмаас Иудейд юу тохиолдох болно хэмээн эмэгтэй бошиглогч Хулда хэлсэн бэ? (Шастирын Дэд 34:22–25-ыг үз) Хэрэв бид судрууд уншихгүй, судруудын заадаг зүйлүүдийг хэрэглэхийг эс хайхарвал бидэнд юу тохиолдох вэ?

Бидний судрын номны нэг Мормоны Номыг уншихыг эс хайхрахын аюулыг Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон дүрслэхдээ:

“1829 онд Их Эзэн ариун зүйлүүдийг тоомсорлохгүй байж болохгүйг Гэгээнтнүүдэд сэрэмжлүүлсэн юм (С ба Г 6:12-ыг үз). Мормоны Ном ариун зүйл гэдэг нь тодорхой, гэтэл олон хүн үүнийг үл тоомсорлодог, өөрөөр хэлбэл, үүнд хөнгөн хуумгай хандаж, үүнийг өчүүхэн ач холбогдолтой зүйл мэтээр үздэг.

“1832 онд эхэн үеийн зарим номлогчид хөдөлмөрийн талбараасаа эргэж ирэхэд Их Эзэн тэднийг Мормоны Номыг унших тухайд хөнгөмсөг хандсаных нь төлөө зэмлэжээ. Энэ хандлагын үр дүнд тэдний оюун харанхуйлсныг тэрээр хэлсэн ажээ. Энэхүү ариун номонд хөнгөмсгөөр хандсан нь зөвхөн тэдэнд өөрсдийнх нь хувьд гэрлийн алдагдал болсон төдийгүй, нийт Сүмийг, тэр ч байтугай Сионы бүх хүүхдүүдийг буруушаалт дор авчирсан юм. Тэр үед Их Эзэн, ‘Мөн тэд наманчилж, мөн тэрхүү шинэ гэрээ, бүр Мормоны Номыг дурсан санах хүртэл тэд энэхүү буруушаалт дор орших болно’ хэмээн хэлжээ (С ба Г 84:54–57). . . .

“Хэрэв эхэн үеийн Гэгээнтнүүд Мормоны Номонд хөнгөмсгөөр хандсаны учир зэмлүүлж байсан бол, хэрэв бид мөн ингэвэл, бид илүү бага буруушаалт дор байна гэж үү?” (Conference Report, 1986 оны 10-р сар, 3–4; *Ensign*, 1986 оны 11-р сар, 4–5)

- Иосиад юу тохиолдоно гэж Хулда хэлсэн бэ? (Шастирын Дэд 34:26, 28-ыг үз. Энэ амлалтын биелэлт Шастирын Дэд 35:20–24-т дүрслэгдсэн байдаг) Их Эзэн яагаад энэ амлалтыг Иосиад хийсэн бэ? (Шастирын Дэд 34:27-г үз)
- Түүний хүмүүс судруудын зааварласны дагуу үйлдээгүйн улмаас тэд буруушаалт дор байх болно гэдгийг Иосиа мэдсэний дараа, тэрээр бүх хүмүүсийг ариун сүмд дуудаж, судруудыг тэдэнд уншиж өгчээ (Шастирын Дэд 34:29–30). Тэр яагаад ингэсэн гэж та нар бодож байна? (Хэрэв хүмүүс Бурханы хуулиудыг мэдэхгүй бол, тэдгээрийг дагаж чадахгүй) Эцэг эхчүүд Иосиагийн жишээг хэрхэн дагаж, хүүхдүүддээ сайн мэдээний хуулиудыг хэрхэн зааж болох вэ? (С ба Г 68:25, 28-ыг үз)
- Судруудыг үнэлдэг үнэ цэнээ бид хэрхэн харуулж болох вэ? Эртний израилчуудад байснаас хавьгүй илүү олон судар бидэнд байдгийг, түүнчлэн судрууд бидэнд ямагт хүртээмжтэй байдгийг тэмдэглэн хэл. Эдгээр адислалуудын учир бидэнд ямар үүрэг хариуцлага ноогддог вэ?
“Их Эзэн эдгээр зүйлүүдийг бидэнд өгөхдөө ямар нэг зорилгогүйгээр ханддаггүй, учир нь ‘хэнд их нь өгөгдсөн байна, түүнээс ихийг шаардана’ (Лук 12:48). Эдгээр зүйлүүдэд нэвтэрнэ гэдэг нь эдгээрийн төлөө хариуцлага хүлээнэ гэсэн үг, (3 Нифай 23:1–5-ыг үз); тиймээс бид өөрсдийн амьдралыг эдгээр зүйлүүдээр удирдуулах болгодог” гэж Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл хэлжээ (“How Rare a Possession—the Scriptures!” *Ensign*, 1976 оны 9-р сар, 5).
- Иосиа болон түүний хүмүүс ариун сүмд байх үедээ тэд Их Эзэнтэй гэрээ хийжээ. Тэд юу хийхээр гэрээнд орсон юм бэ? (Шастирын Дэд 34:31–33-ыг үз) Ариун сүмд бид Их Эзэнтэй ариун гэрээнүүдийг хийдэг, тэдгээрийн биелэлт нь бидэнд дэлхийн адислалууд хийгээд мөнхийн өргөмжлөлийг авчирдаг. Ариун сүмийн эдгээр ариун гэрээнүүдийг хийхэд бид хэрхэн бэлтгэдэг вэ? Бид эдгээр гэрээнүүдийг нэгэнт хийснээс хойш, ариун сүмд аль болох олон дахин очих нь яагаад чухал байдаг вэ?

Дүгнэлт

Иудейн хаант улс дахь хүмүүс эцэстээ ёс бус болж, ингээд Их Эзэн тэднийг боолчлолд аваачигдахаар болгосон ажээ (Шастирын Дэд 36:14–21). Гэвч тэдний хаанчлалын үед Хезекиа Иосиа нар хүмүүсийн анхаарлыг ариун сүм болон судруудад хандуулах замаар тэднийг хүчирхэгжүүлэхээр эрэлхийлж байв. Бид Их Эзэний зарлигуудыг дуулгавартай дагах болон ариун сүмд

орохоор зохистой байхад анхаарал төвлөрүүлсэн тохиолдолд, бид сүнсний хүч чадал хийгээд баяр баясгалангаар адислагдах болно гэдгийг гэрчил. Зохистой амьдарч, ариун сүмд аль болох олон удаа орж, адислалуудыг нь хүртэхэд ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

Нэмэлт заах санаанууд

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгонд эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

1. “Их Эзэнээс авсан зээлийн карт”

Энэ хичээлийг заахаас долоо хоногийн өмнө Ерөнхийлөгч Гордон Б.Хинклийн хэлсэн үгний доорх хэсэгтэй танилцаж, үүнийг ангийнхантай хуваалцахаар бэлтгэж ирэхийг ангийн нэг гишүүнээс хүс:

“Би та нарын өмнө зээлийн хоёр карт барьж байна. Та нарын ихэнх нь ийм картуудыг мэднэ.

“Нэг дэх нь банкны зээлийн карт. Энэ картаар би эд юмсыг зээлээр худалдан авч, дараа нь төлбөрөө нэгмөсөн хийж болно. Энэ бол үнэ цэнэтэй бөгөөд хадгалж хамгаалж явах ёстой зүйл. Хэрэв энэ нь хулгайлагдаж, буруугаар ашиглагдсан тохиолдолд надад их хохирол учруулж, бас үлэмж ихээр ичиж зовоход хүргэнэ. Би үүнийг банкнаас авахдаа гэрээ хийж, үүрэг хүлээн, тохиролцдог. Карт хүлээж авахдаа би үүнийг олгосон нөхцөлүүдийг биелүүлэхээр тохиролцдог.

“Үүнийг зөвхөн нэг жилийн хугацаагаар олгодог бөгөөд хэрэв үүгээр худалдан авах боломж нь нь надад таалагдах юм бол картыг жил бүр дахин авч болно. Үнэндээ энэ бол минийх биш. Өмчлөлийг банк өөртөө үлдээдэг. Хэрэв би үүний шаардлагуудыг биелүүлэхгүй бол, банк зээлийн картыг хааж, үүнийг буцаан авна.

“Надад байгаа өөр нэг картыг бид ариун сүмийн зөвшөөрлийн бичиг гэж нэрлэдэг. Энэ нь Их Эзэнээс авсан зээлийн картыг төлөөлдөг бөгөөд Түүний олон агуу бэлгүүдийг хүртэх боломжийг надад олгодог. Банкны карт дэлхийн зүйлүүдтэй, ариун сүмийн зөвшөөрлийн бичиг Бурханы зүйлүүдтэй холбоотой байдаг.

“Ариун сүмийн зөвшөөрлийн бичиг олж авахын тулд хүлээн авагч нь бас үүнд тавигдах шаардлагыг хангаснаа харуулсан байх ёстой, энэ шаардлага нь хувь хүний зохистой байдал дээр тулгуурладаг. Нэгэнт олгогдсон бол, энэ нь мөнхөд хүчинтэй байдаггүй, харин жил бүр дахин олгогддог. Түүнээс гадна, хэрэв эзэмшигч нь үүний онцгой боломжуудад өөрийгөө тохирохгүй болгох юм бол, ариун сүмийн зөвшөөрлийн бичиг алдагдах буюу буцаан авагдаж болно.

“Ариун сүмийн зөвшөөрлийн бичигт тавигддаг шаардлага нь санхүүгийн үнэ цэнэ дээр тулгуурладаггүй. Үүгээр бүтээх хэрэг байдаггүй. Энэ нь хувь хүний байнгын зан төлөв, хүний амьдралын сайн сайхан дээр тулгуурладаг. Энэ нь мөнгө санхүүгийн асуудлуудтай биш, харин үүрд мөнхийн зүйлүүдтэй холбоотой юм.

“Банкны карт санхүүгийн зээлийн үүд хаалгыг нээдэг. Ариун сүмийн зөвшөөрлийн бичиг Их Эзэний өргөөний үүд хаалгыг нээдэг. Энэ нь

ариун хийгээд бурханлиг ажил хийхийн тулд ариун газруудад орохтой холбоотой. . . .

“ . . . Надад байгаа бас та нарын олонхид нь байгаа ариун сүмийн зөвшөөрлийн энэ бичиг бол үнэ цэнэтэй бөгөөд гайхамшигтай зүйл юм. Энэ нь ханан дээрээ 'Их Эзэнд Ариун—Их Эзэний Өргөө' гэж бичсэн өргөөнд орох онцгой боломж— тэрхүү үлэмжийн онцгой, гайхамшигт боломжид хүнийг тохирох болгодог. Энэ өргөөнд үйлчлэхээр зохистой амьдрагтун. Үүнийг ариун байлга. Аливаа цэвэр ариун бус буюу бузарлагч нөлөө буюу хүнийг Их Эзэний өргөөнөөс хол байлгахад өөрийнхөө хийх ёстой зүйлийг хий. Үүний эрхэм сайхныг хүрт. Тэнд хэлэгддэг зүйлүүдийн гайхамшигийг, тэнд гүйцэтгэгддэг ёслолуудын эрхэм сайхныг хийгээд адислалыг хүртэгтүн.

“Ариун сүмд хараахан ороогүй байгаа хүмүүсийн хувьд гэвэл, нас барагсдын өмнөөс баптисм хүртэх боломжийн давуу тал та нарт байгааг би санал болгож байна. Тэгээд энэхүү ариун туршлагыг амьдралынхаа гол түшиг тулгуур болго, энэ нь та нар бүхий л цаг үед, бүх нөхцөл байдалд өөрсдийгөө авч явахдаа, зохих цагт Их Эзэний энэхүү онцгой, хязгаарлагдмал зээлийн картыг, бүр Түүний ариун өргөөнд орох зөвшөөрлийн бичгийг олж аван, тэнд үүний бүх адислалууд болоод онцгой боломжуудыг хүртэгтүн.” (Conference Report, 1990 оны 4-р сар, 65, 69; *Ensign*, 1990 оны 5-р сар, 49, 52)

2. Ариун сүмүүдийн зорилго

Хожмын үеийн хэд хэдэн ариун сүмийн зураг авчир (хэрэв боломжтой бол уран барилгын өөр өөр шийдэлтэй). Эдгээр ариун сүмүүд гадна талаасаа өөр өөр харагддаг хэдий ч, эдгээр ариун сүмүүд дотор гүйцэтгэгддэг ёслолууд болон хийгддэг гэрээнүүд ижил байдгийг тэмдэглэн хэл.

Эртний Израилын ариун сүм дэх дадал зуршлуудын зарим нь хожмын үеийн ариун сүмд бидний үйлддэгээс ялгаатай байсан хэдий ч, (Жишээ нь, бид малаар тахил өргөдөггүй эсвэл утлага сан болгож лаа асаадаггүй), эртний болон хожмын үеийн ариун сүмүүдийн зорилго нь ижил: Их Эзэний оршихуйд очиход биднийг бэлтгэх болон түүнтэй адилхан байх явдал мөн.

Та *Хуучин Гэрээний Видео Танилцуулгуудын* (53224)-ын “Эртний ариун Сүмүүд” гэсэн Мосегийн асрыг болон тэнд болдог байсан үйл ажиллагаануудыг дүрсэлсэн есөн минутын бичлэгийг үзүүлж болно.

3. Судруудыг судлах нь

- Судруудыг судлах нь бидэнд зарим үед яагаад хүнд байдаг вэ?

Ангийн гишүүдийн хариултуудыг самбар дээр нэг багана болгон жагсааж бич. Дараа эдгээр хүндрэлүүдийг бид даван дуулах арга замуудыг ярилц. Жишээ нь, хэрэв бид уншсан зүйлээ ойлгохгүй бол, ойлгохын төлөө залбирах буюу өөрсдийн уншиж байгаа судруудын талаар бошиглогчид болон төлөөлөгчид ноу гэж хэлснийг судалж болно; хэрэв бид судруудыг шөнө уншихад нойр хүрдэг бол, өдрийн цагаар унших өөр цаг олж болно Эдгээр шийдлүүдийг өөр багананд жагсаан бич.

Судруудыг судлахад өөрсдийгөө илүү ихээр зориулахыг ангийн гишүүдийн зорилго болго.

“Мэргэн ухааныг олдог хүн баяр хөөртэй”

Сургаалт үгс ба Номлогчийн үгс

Зорилго Сургаалт үгс болон Номлогчийн үгс номнууд дахь ухаалаг зөвлөгөөнүүдийг хэрэглэснээр Христтэй илүү адилхан болоход нь ангийн гишүүдэд сүнслэгээр нөлөөлөх.

Бэлтгэл

1. Хичээлийн төлөвлөгөөнд ярилцсан судруудыг түүнчлэн Сургаалт Үгсийн болон Номлогчийн Үгс номнуудаас аль болох ихийг залбирч судлах.
2. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашиглах бол, дараах өгүүлбэрүүдийг том цаасан дээр буюу ангийн өмнө самбар дээр бич:
 - а. Сүйрлийн өмнө _____ явдаг.
 - б. Явах ёстой замаар нь замнуулахын тулд _____ сурга.
 - в. Тэнгэрийн доорх бүх юмс _____ бөгөөд бүх юм тогтоогдсон _____ ажээ.
 - г. Бүх зүрхээрээ ЭЗЭНд _____.
 - д. _____ уур хилэнг зайлуулна.
 - е. Учир нь тэр дотроо _____ адил юм.

Хэрэв та анхаарал төвлөрүүлэх хоёр дахь үйл ажиллагааг ашиглах бол, Сургаалт Үгс болон Номлогчийн Үгсээс дуртай хэсгээ хуваалцахаар бэлтгэж ирэхийг ангийн нэг буюу хоёр гишүүнээс хүч, энэ нь тэдний хувьд яагаад чухлыг хэлүүл.

3. Хэрэв *Хуучин Гэрээний Видео Танилцуулгууд* (53224) байдаг бол, хичээлийнхээ нэг хэсэг болгон “Их Эзэнд итгэх нь” таван минутын бичлэгийг үзүүл.

Энэ хичээлийг заах зөвлөмж

Анхаарал
төвлөрүүлэх
үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагааг (эсвэл өөрийнхөө нэг үйл ажиллагааг) ашиглахыг хүсч болно. Ангийн хувьд хамгийн тохиромжтой үйл ажиллагааг сонгож ав.

1. Цаасан дээр буюу самбар дээр бичсэн өгүүлбэрүүдэд ангийн гишүүдийн анхаарлыг төвлөрүүл (дээрх “Бэлтгэлийг” үз). Ихэд дэлгэрсэн эдгээр өгүүлбэрүүдийг Сургаалт Үгс болон Номлогчийн Үгс Номнуудаас авсныг тайлбарлаж, зураасын оронд тохирох үгсийг нөхөхийг ангийн гишүүдээс хүс. Хэрэв шаардлагатай бол, тэд мэдэхгүй үгсээ судруудаас харж болохын тулд дараах ишлэлүүдийг ангийн гишүүдэд өг.

- а. Сургаалт Үгс 16:18 (Бардам зан)
- б. Сургаалт Үгс 22:6 (хүүхэд)
- в. Номлогчийн Үгс 3:1 (цаг хугацаатай, цаг мөчтэй)
- г. Сургаалт Үгс 3:5 (итгэ)
- д. Сургаалт Үгс 15:1 (ээлдэг хариулт)
- е. Сургаалт Үгс 23:7 (боддогтойгоо)

2. Сургаалт Үгс болон Номлогчийн Үгсээс дуртай хэсгээ хуваалцахыг даалгавар авсан ангийн нэг буюу хоёр гишүүнээс хүсч, энэ нь тэдний хувьд яагаад чухал болохыг хэлүүл.

Судрын ярилцлага болон хэрэглээ

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж. Энэ хичээл дэх бүх асуултыг асуух буюу юм бүхнийг хамруулан заах нь хэцүү байж болох учраас ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох зүйлүүдийг залбирч, сонго. Та зарим асуултуудыг ангийн гишүүдийн нөхцөл байдалд тохируулан хялбаршуулж болно.

Сургаалт үгс бол ерөнхийдөө зөв шударгаар амьдрах тухай зөвлөгөө өгдөг товч зүйр цэцэн хэллэг юм. Соломон “гурван мянган сургаалт үг хэлснийг” Хуучин Гэрээнд цэдэглэсэн байдаг (Хаадын Дээд 4:32). Эдгээр зүйр цэцэн хэллэгүүдийн зарим нь Сургаалт Үгсийн номонд оржээ. Соломон болон энэ номны бусад зохиогчид бошиглогчид биш ч гэсэн тэдний бичсэн зүйлүүдээс олон нь Их Эзэнээс сүнслэгээр нөлөөлөгдсөн ажээ. Тэдний бичээсүүд үнэн мэргэн ухаан Бурханаас ирдэг гэдэгт итгэх итгэлийг ерөнхийдөө тусгадаг.

Номлогчийн Үгс ном нь бас зүйр цэцэн хэллэгүүдийг агуулдаг бөгөөд үүний зохиогч нь Соломон гэдэгт зарим хүмүүс итгэдэг. Амьдрал гагцхүү Бурханаар дамжсан үед утга учиртай байна гэдэг нь Номлогчийн Үгсийн захиас юм.

Энэ хичээл Сургаалт Үгс болон Номлогчийн Үгс дэх чухал сэдвүүдэд анхаарал төвлөрүүлсэн долоон хэсэгт хуваагддаг. Та өөрийнхөө хувийн судалгаагаар, бусад сэдвүүдийг олж ангид ярилцаж болно.

1. Мэргэн ухаан

Сургаалт Үгс болон Номлогчийн Үгсээс дараах хэсгүүдийг зааж, ярилц.

- Сургаалт Үгс болон Номлогчийн Үгс номнууд мэргэн ухааны ач холбогдлыг онцгойлон авч үздэг. Суралцсан байх, ухаалаг байх хоёрын хооронд ямар ялгаа байдаг вэ? (Сургаалт Үгс 1:7; 9:9–10; 2 Нифай 9:28–29-ийг үз. Библийн хэлээр Их Эзэнээс эмээх, түүнийг хүндэтгэж, дуулгавартай дагах гэсэн утгатай. Мэргэн ухаан бол мэдлэгээс илүү зүйл мөн; энэ бол мэдлэгийг зохих ёсоор хэрэглэнэ гэсэн үг. Израилчуудын хувьд мэргэн ухаан нь Бурханы хуулиудад дуулгавартай байх явдал мөн.)
- Бурханы тухай мэдлэг хэрхэн олж авах тухай Сургаалт Үгс 2:2–6-гаас бид юу сурч болох вэ? Энэ мэдлэгийг олж авахад яагаад хичээл зүтгэл шаардагдана гэж та нар боддог вэ?
- Мэргэн ухааны үнэ цэнийг дэлхийн баялгуудын үнэ цэнэтэй хэрхэн харьцуулж болох вэ? (Сургаалт Үгс 3:13–18; Номлогчийн Үгс 7:12-ыг үз. Сургаалт Үгс 3:15–18 дахь *тэр нь, түүнээс* гэдэг нь мэргэн ухааныг хэлж буйг анхаар) Мэргэн ухаан, аз жаргал амар амгаланг хэрхэн авчирдаг вэ?
- Сургаалт Үгс 3:18-д мэргэн ухаан бол энэ нь тэдэнд байдаг хүмүүсийн хувьд “амийн (амьдралын) мод мөн” хэмээн өгүүлсэн байдаг. Энэ бэлэгдэл мэргэн ухааны үнэ цэнийн талаар бидэнд юу заадаг вэ? (1 Нифай 11:8–11, 21–25, амьдралын мод бол Бурханы хайрын бэлэгдэл гэдгийг анхаар)

- Ухаалаг хүмүүсийн ямар шинж чанаруудыг Сургаалт Үгс 9:9–10, 15:31–33-д жагсаасан бэ? Эдгээр шинж чанарууд мэргэн ухааныг хуримтлуулахад яагаад чухал вэ?

2. Их Эзэнд итгэх итгэл

Сургаалт Үгс 3:5–7-г зааж, ярилц.

- Сургаалт Үгс 3:5–7-д ямар зөвлөгөө өгсөн байна вэ? Их Эзэн бидний замыг хэрхэн чиглүүлдэг вэ? Ямар туршлагауд Их Эзэнд итгэхийг та нарт заасан бэ?
- Бурханыг танин мэдэх гэсэн нь юу гэсэн үг вэ? (Сургаалт Үгс 3:6; Алма 34:38; С ба Г 59:21-ийг үз) Түүнийг танин мэдсэнээрээ бид хэрхэн адислагддаг вэ?

3. Бидний ярьдаг үгс

Сургаалт Үгсээс дараах хэсгүүдийг зааж, ярилц.

- Сургаалт Үгс 6:16–19-д Их Эзэн ихэд дургүйцдэг долоон зүйлийг жагсаасан байдаг. Эдгээр зүйлээс гурав нь—худал хэлэх, худал гэрчлэх, зөрчил үүсгэх нь—бидний ярьдаг үгст хамаатай. Бидний ярьдаг үгст Их Эзэн яагаад ийм их анхаарал санаа тавьдаг вэ? (Сургаалт Үгс 16:27–28; 18:8; 25:18; Матай 12:36–37-г үз) Худал хэлэх, хов жив хөөцөлдөх, бусдыг муулан ярих асуудлуудыг бид хэрхэн даван туулж чадах вэ?
- Сургаалт Үгс 16:24-д “тааламжит үгс зөгийн балтай сархинаг, сэтгэлд амтат бурам ажгуу” хэмээн өгүүлсэн байдаг. Энэ яагаад үнэн бэ? Найрсгаар ярихын үр дүн юу вэ? (Сургаалт Үгс 12:25; 15:1; 16:24-ийг үз) Бусдын найрсаг үг та нарт хэрхэн тусалсан бэ?
- Санал зөрөлдөх үед эелдгээр ярих нь ямар ашигтай вэ? (Сургаалт Үгс 15:1-ийг үз)

Ахлагч Гордон Б.Хинкли: “Бид эелдгээр ярьсан тохиолдолд эвгүй байдалд орох нь ховор байдаг. Бид дуугаа өндөрсгөх үед оч үсэрч, жижигхэн толгод зөрчлийн агуу том уул болж өсдөг” хэмээн хэлжээ (Conference Report, 1971 оны 4-р сар 1, 82; *Ensign*, 1971 оны 7-р сар, 72).

Эелдэг үгсээр ярихын ач холбогдлыг нэмэгдүүлэхийн тулд, та “Let Us Oft Speak Kind Words” дууллыг (*Hymns*, no. 232) ангийн гишүүдээр дуулуулж болно.

4. Бардам зан

Сургаалт Үгс 8:13; 13:10; 16:18–19-ийг зааж, ярилц.

- Сургаалт Үгс 8:13 Их Эзэн бардам занг үзэн яддагийг нотолдог. Бардам зан яагаад тийм ноцтой нүгэл байдаг вэ?

Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон:

“Бардам зангийн гол онцлог нь дайсагнал—Бурханд болон бидний нөхдөд дайсагнан хандах явдал мөн. *Дайсагнал* гэдэг нь ‘үзэн ядах, өшөөрхөх, эсвэл эсэргүүцэх чанар юм.’ Энэ бол Сатан биднийг эзэмдэхийг хүсдэг хүч юм.

“Бардам зан төрөлх мөн чанараараа өрсөлдөгч шинжтэй. Бид өөрсдийн хүслийг Бурханы эсрэг тавьдаг. Бид бардам зангаа Бурханы эсрэг чиглүүлсэн үед энэ нь, ‘таны хүсэл бус, харин миний хүсэл биелэгдэг’

гэсэн санаанд байдаг. Паулын хэлсэнчлэн, ‘тэд Есүс Христийнхийг биш, өөрсдийн сонирхлыг эрдэг’ (Филиппой 2:21).

“Бидний хүсэл Бурханы хүсэлтэй өрсөлдсөн үед хазаарлагдашгүй хүсэл, дур сонирхол хийгээд дур тачаалд хүргэдэг (Алма38:12; 3 Нифай 12:30-ийг үз).

“Бардам зан өөрсдийнх нь амьдралд чиглүүлэл өгдөг Бурханы эрх мэдлийг хүлээн авдаггүй (Хиламан12:6-г үз). Тэд үнэний тухай өөрсдийн санаа бодлыг Бурханы агуу үнэний эсрэг сөргүүлэн тавьж, тэдний чадвар Бурханы санваарын хүчний эсрэг чиглэн, тэдний амжилт Түүний хүчирхэг ажлын эсрэг байдаг.

“Бурхан өөд чиглэсэн бидний дайсагнал эсэргүүцэл, зүрх сэтгэлийн хатуурал, гөжүүд зан, наманчилдаггүй, ихэмсэглэх, амархан гомддог, тэрчлэн тэмдэг эрэлхийлдэг гэх зэрэг олон янзын нэр, хаягтай байдаг. Тэд өөрсдийн санаа бодлыг Бурханыхтай нийцүүлэн өөрчлөх сонирхолгүй байдаг. . . .

“Бардам зан бол энэ үгийн жинхэнэ утгаар бол ял хүлээгч нүгэл юм. Бардам зан өсөлт хөгжилтийг хязгаарладаг буюу зогсоодог (Алма12:10–11-ийг үз). Бардамнагчдад заахад амар байдаггүй (1 Нифай 15:3, 7–11). Үнэнийг хүлээн авахын тулд тэд оюун бодлоо өөрчилдөггүй, учир нь ингэхийг тэд буруу гэж боддог” гэж хэлжээ (Conference Report, 1989 оны 4-р сар, 3–5; *Ensign*, 1989 оны 5-р сар, 4, 6).

- Сургаалт Үгс 13:10, 16:18 нь бардам зан зөрчилдөөн, сүйрэл уруу хөтөлдөг гэж заасан байдаг. Бардам зан хэрхэн ийм байдалд хүргэдэг вэ?

Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон хэлэхдээ:

“Бардам зангийн өөр нэг тал нь зөрчил сөргөлдөөн юм. Маргаан, тэмцэл, зөв шударга бусаар эзэгнэх, эцэг эх хүүхдүүдийн хооронд харилцаа холбоо сул байх, гэр бүл салалт, эхнэр буюу нөхөртэйгөө зүй бусаар харьцах, үймээн болон сэтгэлийн түгшүүр энэ бүгд бардам зангийн төрлүүдэд хамаардаг.

“Манай гэр бүлүүд дэх зөрчил Их Эзэний Сүнсийг холдуулдаг. Энэ нь бас манай гэр бүлийн олон гишүүнийг холдуулдаг. . . .

“Бардам зан бидний харилцааны бүх талд—Бурхантай болон Түүний үйлчлэгчидтэй харилцах харилцаа, эхнэр нөхөр хоёрын хоорондох харилцаа, эцэг эх, хүүхэд хоёрын хоорондох бидний харилцаанд сөргөөр нөлөөлдөг” гэжээ (Conference Report, 1989 оны 4-р сар, 5; *Ensign*, 1989 оны 5-р сар, 6).

- Бардам занг бид хэрхэн даван туулж чадах вэ? (Сургаалт Үгс 16:19-ийг үз). Гэр бүлийнхээ гишүүдтэй болон Бурхантай харилцах харилцаандаа бид хэрхэн илүү даруу байхын тулд бид юу хийж болох вэ?

5. Нөхөрлөл

Сургаалт Үгс, Номлогчийн Үгсийн дараах хэсгүүдийг зааж, ярилц.

- Шударга бус найз нөхдөөс юуны учир биднийг сэрэмжлүүлдэг вэ? (Сургаалт Үгс 13:20; 22:24–25-ыг үз)
- Сайн найзуудын зан төлвийн зарим шинж чанар юу вэ? (Сургаалт Үгс 17:17; 27:9-ийг үз) Хүнд үед сайн найз нар чинь та нарт хэрхэн тусалсан бэ?

- Жинхэнэ сайн найзуудтай болохын тулд бид юу хийж болох вэ? (Сургаалт Үгс 18:24. Сайн найзуудтай болохын тулд бид өөрсдөө сайн найзууд байх ёстойг тэмдэглэн хэл)
- Биднийг ухаалаг бус сонголт хийхэд жинхэнэ найзууд хэрхэн хариу үйлдэл үзүүлдэг вэ? (Номлогчийн Үгс 4:9–10)

Ахлагч Марвин Ж.Аштон хэлэхдээ:

“Найз гэдэг бол миний байгаа зам дээр намайг аваачихыг хүсдэг тэр хүн’ гэж нэг хүн хэлсэн байдаг. Үүнийг энэ үгийн нэг тодорхойлолт болгон хүлээж авахын хамт, хэрэв бид хүнийг бидний мэдэх тэр замд нь орхих юм бол, бид жинхэнэ найз нараас доогуур байх болно гэдгийг тэр даруйд хэлэх сэн. . . .

“Биднийг үйлчлэх үед ‘Найз минь байгаагийн төлөө танд баярлалаа’ гэж бидний хэн нэгэнд нь чин сэтгэлээсээ хэлэхээс илүү агуу шагнал гэж үгүй. Тусламж хэрэгтэй байгаа хүмүүс бидэнтэй хамт, биднээр дамжуулан замаа олбол, энэ нь нөхөрлөл үйл ажиллагаанд байгаа нь тэр. Бидний амьдралаар дамжин сул дорой хүмүүс хүчтэй болж, хүчтэй нь улам хүчирхэг болж байвал үнэнхүү нөхөрлөл байгаа нь тэр. Хэрэв хүн найз нараараа шүүлгэн дүгнүүлж байвал, тэрээр бас найз нар нь сүнслэг байдлын хувьд хэр зэрэг сайн болохоор хэмжигддэг. . . .

“Тийм ээ, найз гэдэг бол миний байгаа зам дээр намайг аваачихыг хүсдэг тэр хүн, бас намайг байгаагаас минь илүү дээр болгохыг хүсдэг, мөн ийм чадвартай хүн” гэжээ (Conference Report, 1972 оны 10-р сар, 32, 35; *Ensign*, 1973 оны 1-р сар, 41, 43).

- Гэр бүлийн гишүүдийн хоорондох нөхөрлөлийг бид хэрхэн бэхжүүлж болох вэ?
- Есүс Христ өөрийн дагалдагчдыг найз нараа гэж олонтаа нэрлэдэг байв (С ба Г 88:62; 93:45). Тэрээр бидний найз гэдгээ хэрхэн харуулсан бэ? (Иохан15:13-ыг үз) Бид түүний найз нар гэдгээ хэрхэн харуулдаг вэ? (Иохан15:14-ийг үз) Түүний нөхөрлөлийг та нар хэрхэн мэдэрдэг вэ?

6. Хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх нь

Сургаалт Үгсээс дараах хэсгүүдийг зааж, ярилц.

- Сургаалт Үгс 22:6-т “явах ёстой замаар нь замнуулахын тулд хүүхдийг сурга” хэмээн өгүүлсэн байдаг. Энэ зөвлөгөөг дагахын тулд эцэг эхчүүд юу хийх ёстой вэ? (С ба Г 68:25–28-ыг үз) Сайн мэдээний зарчмуудыг бид хүүхдүүдэд хэрхэн илүү үр ашигтайгаар зааж, тэдний гэрчлэлийг өсгөн нэмэгдүүлж чадах вэ?

“Гэр бүлд төвлөрсөн үйл ажиллагааны төлөө та нар хувийн хүсэл таашаал хийгээд хувийн сонирхлыг орхих хүсэлтэй байж, хүүхдийг хөгжүүлэх сайн орчныг бүрдүүлэх гол үүргийг сүм, сургууль буюу нийгэмд тохохгүй байх ёстой. ‘Явах ёстой замаар нь замнуулахын тулд хүүхдийг сургах нь’ цаг хугацаа, их хүч чармайлт түүнчлэн хувь хүнээс үлэмж золиослол шаардана. Гэвч ажлаа сайн хийсний төлөө илүү агуу шагналыг та нар хаанаас олж чадах вэ?” гэж Ахлагч Ричард Г.Скотт хэлжээ (Conference Report, 1993 оны 4-р сар, 43; *Ensign*, 1993 оны 5-р сар, 34).

- Яагаад хүүхдүүдэд дүрэм журам, хязгаарлалтууд, хайрын залруулга хэрэгтэй байдаг вэ? (Сургаалт Үгс 19:18; 29:17-г үз) Хүүхдүүд эцэг эхчүүдийнхээ зөв шударга зөвлөгөөнд хэрхэн хариулах ёстой вэ? (Сургаалт Үгс 6:20–23-ыг үз). Эцэг эхчүүд залруулгыг хэрхэн хийх ёстой вэ? (С ба Г 121:41–44-ийг үз)

7. Баяр хөөр ба сайн хошин шог

Сургаалт Үгс 15:13, 17:22-ыг зааж, ярилц.

- Баяр хөөртэй харьцаа хандлага хийгээд сайн хошин шогийн мэдрэмжийг хөгжүүлэх нь яагаад чухал вэ? (Сургаалт Үгс 5:13; 17:22-ыг үз)

Ерөнхийлөгч Хью Б.Браун хэлэхдээ: “Эцсийн эцэст, ямраар ч ирсэн байлаа гэсэн, хошин шогийн мэдрэмжийг бид хадгалах ёстой учраас би та нарыг инээмсэглэхийг хүсмээр байна. Дэлхий дээрх бүх хүмүүсээс хамгийн аз жаргалтай нь бид байх учиртай гэж би боддог. Дэлхий дээрх хамгийн агуу хийгээд хамгийн баяр хөөртэй захиас бидэнд бий. Бид нөгөө тал дээр гарахад, хэн нэг нь биднийг инээмсэглэн угтах болно (хэрэв бид буруу газарт гарч, тэгээд хэн нэг нь биднийг шоолон инээмсэглэхгүй бол), иймээс баяр хөөртэй байцгаая. Гэвч бидний баяр хөөр жинхэнэ баяр хөөр байг—энэхүү баяр хөөр дотоод сэтгэлийн гүнээс гараг” гэжээ (*The Abundant Life* [1965], 83).

- Гэр бүлүүдээ сэтгэл санаа өргөсөн хошин шогийг урамшуулан дэмжихийн тулд бид юу хийж болох вэ? (Гэр бүлд нь асуудлыг шийдвэрлэх болон бие биенээ хайрлах хайр нь өсөхөд хошин шог тусалсан тохиолдлуудын талаар ярихыг та ангийн гишүүдээс хүсч болно.)

Дүгнэлт

Та ярилцсан сэдвүүдийн талаарх бодол санаагаа хуваалц. Сургаалт Үгс, Номлогчийн Үгс дэх зөвлөгөөг санаж, дагахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж. Эдгээр номнуудын нэгнээс дуртай хэсгээ цээжлэхэд нь та бас тэднийг урамшуулан дэмжиж болно.

Нэмэлт заах санаанууд

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

1. Сургаалт Үгсийн үйл ажиллагаа

Сургаалт Үгсийн номноос хэдэн ишлэлийг зурвас цаасан дээр бичиж, тэдгээрийг аяганд хий. Аяган дахь зурвас цаасыг ангийн гишүүдээр ээлжлэн сонгуулж, зурвас цаасан дээр иш татагдсан судрын хэсгийг уншуулж, энэ хэсэг бидний амьдралд хэрхэн хэрэглэгддэгийг тайлбарлуул.

2. Судрын хэрэглээ

Хүний биеийг самбар дээр зур. Дараах шүлгүүдийг ангийн гишүүдээр олуулж, ишлэлүүдийг биеийн холбогдох эрхтний ар талд бич. Шүлгүүдийг хамтдаа уншиж, тэдгээр нь бидний амьдралд хэрхэн хэрэглэгддэгийг ярилц.

- Сургаалт Үгс 2:2 (чих, зүрх)
- Сургаалт Үгс 3:5 (зүрх)
- Сургаалт Үгс 3:7 (нүд)
- Сургаалт Үгс 3:27 (гар)

- д. Сургаалт Үгс 4:26–27 (хөл)
- е. Сургаалт Үгс 8:7 (ам)
- ё. Сургаалт Үгс 10:4 (гар)
- ж. Сургаалт Үгс 12:15 (нүд)

3. “Арван хуруу тэгш эмэгтэй” (Сургаалт Үгс 31:10)

Сургаалт Үгс 31:10–31-ийг ангийн гишүүдээр нэгтгэн дүгнүүлж, арван хуруу тэгш эмэгтэйн шинж чанаруудыг жагсаан бичүүл. Эдгээр шинж чанарууд бол эрэгтэй, эмэгтэй ялгаагүй бид бүгдийн хөгжүүлэхээр чармайх ёстой шинж чанарууд гэдгийг тэмдэглэн хэл. Та ангийн гишүүдийн хариултуудыг самбар дээр бичиж болно. Хариултууд нь дараах зүйлүүд байж болно:

<i>Шүлэг</i>	<i>Шинж чанар</i>
11	Итгэж болох
13	Хүсэлтэйгээр ажилладаг
20	Өрөвч сэтгэлтэй
25	Тууштай хийгээд хүндэтгэл хүлээдэг
26	Мэргэн ухаанаар болоод нинжин сэтгэлээр ярьдаг байх
28	Нэгэн үзүүрт сэтгэлт гэргий бөгөөд эх
30	Их Эзэнийг дуулгавартай дагадаг

Эдгээр шинж чанаруудыг эзэмшсэн өөрсдийн таньдаг хүмүүсийн тухай ярихыг ангийн хэдэн гишүүнээс хүс.

“Миний Гэтэлгэгч амьд гэдгийг би мэднэ”

Хичээл
32

Иов 1–2; 13; 19; 27; 42

Зорилго

Их Эзэнд итгэж, түүний тухай гэрчлэлүүдийг бий болгон хөгжүүлснээр, түүнчлэн хувийн зарчимч шударга чанарыг хөхүүлэн дэмжсэнээр бэрхшээлийг сөрөн зогсох хүч чадлыг хөгжүүлэхэд нь ангийн гишүүдэд туслах.

Бэлтгэл

1. Дараах судруудыг залбирч, судал
 - а. Иов 1–2. Шударга, итгэлтэй хүн Иов их хүнд сорилтуудыг туулдаг. Тэрээр эзэмшил хөрөнгө, хүүхдүүд болон эрүүл мэндээ алдсан хэдий ч, Их Эзэнд итгэлтэй хэвээр үлдсэн билээ.
 - б. Иов 13:13–16; 19:23–27. Их Эзэнд итгэх итгэлд түүнчлэн Аврагчийн тухай өөрийн гэрчлэлд Иов хүч чадал олдог байв.
 - в. Иов 27:2–6. Өөрийн зөв шударга, зарчимч байдалд Иов хүч чадал олдог байв.
 - г. Иов 42:10–17. Иов өөртөө тохиолдсон хүнд сорилтуудыг итгэлтэйгээр тэвчсэний дараа Их Эзэн түүнийг адисалжээ.
2. Нэмэлт уншлага: Иовын бусад бүлгүүд; Сургаал ба Гэрээ 121:1–10.

Энэ хичээлийг заах зөвлөмж

Анхаарал
төвлөрүүлэх
үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагааг (эсвэл өөрийхөө нэг үйл ажиллагааг) ашиглахыг хүсч болно.

Дараах өгүүллийг ангийн гишүүдтэй хуваалц (эсвэл үүнийг хуваалцахаар бэлтгэхийг ангийн нэг гишүүнээс хүс):

Баруун хойд Мексикийн халуун цөлд “ганд ер бусын тэсвэртэй олон зүйлийн эрдэнэ шиш, буурцаг ургуулдаг фермерүүдийн тухай Ахлагч Иосеф Б.Вортлин нэг удаа ярьжээ. Бусад ургамлууд гандаж, үхдэг газарт эдгээр үүдрүүд хатуу ширүүн уур амьсгалыг тэсэн гарч, цэцэглэн ургадаг ажээ. Эдгээр ургамлуудын нэг нь цагаан залаат буурцаг юм. Маш бага бороо орсон үед ч үүний үр нахиалж, ургадаг. Энэ ургамал өөртөө хэрэгтэй чийгийг олж авахын тулд үндсээ хадархаг, элсэнцэр хөрсөнд зургаан тохой гүн шигтгэн суулгадаг ажээ. Энэ ургамал жилд ганцхан удаа бороо ордог цөлийн 115 хэм (Фаренгейтийн) халуунд цэцэглэж, үр жимсээ өгдөг ажээ. Үүний навчис маш бага ус чийгтэй байдаг Долдугаар сарын дунд үеийн аагим халуунд ч гайхмаар ногоон өнгөтэй байдаг.”

- Бэрхшээлийг тэсвэрлэн туулахад бидэнд тусалж чадах энэ өгүүллээс бид юу сурч болох вэ?

“Сүмийн гишүүд эдгээремаш их тэсвэртэй ургамлуудын жишээг даган дуурайж болох юм. Бид үндсээ сайн мэдээний хөрсөнд гүн суулгах ёстой. Бидэнд тулгарч болох хилэнц, уруу таталт буюу шүүмжлэлийг бид эс

хайхран, өсч хөгжиж, цэцэглэн, сайн үр жимсийг элбэг дэлбэгээр өгөх ёстой. Бэрхшээлийн халуун дотор дэвжин хөгжихийг бид сурах ёстой” хэмээн Ахлагч Вертлин өгүүлжээ (Conference Report, 1989 оны 4-р сар, 7; *Ensign*, 1989 оны 5-р сар, 7).

Энэ хичээл бол итгэл, зөв шударга байдал нь асар хүнд бэрхшээлийг тэсэн гарахад нь түүнд тусалсан хүн, Иовын тухай юм гэдгийг тайлбарла.

Судрын ярилцлага
ба хэрэглээ

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагауудаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Иов гашуунаар соригдов.

Иов 1–2-ыг зааж, ярилц.

- Иов ямар хүн байсан бэ? Та дараах зан чанаруудаас заримыг нь самбар дээр жагсаан бичиж болно. Холбогдох ишлэлүүдээс олон нь унших даалгаварт байхгүй байгаа, иймээс та эдгээрийг олж үзэн, ямар зан чанарууд дүрслэгдсэнийг ярихыг ангийн зарим гишүүдээс хүсч болно.
 - а. Тэрээр Бурханаас эмээдэг, бузар муугаас зайлдаг сайн хүн байв (Иов 1:1).
 - б. Тэр баян чинээлэг байсан боловч, эд хөрөнгөндөө хамаг санаа нь чиглэдэггүй нэгэн байв (Иов 1:3, 21).
 - в. Тэрээр үнэнч шударга нэгэн байв (Иов 2:3).
 - г. Тэрээр сул дорой хүмүүсийг хүчирхэгжүүлэв (Иов 4:3–4).
 - д. Тэр Их Эзэний замуудаар алхалж, Их Эзэний үгсийг эрхэмлэн дээдэлдэг байв (Иов 23:10–12).
 - е. Тэрээр бэлэвсэн эмэгтэйчүүд, ядуус, хазгар доголлон хүмүүс, түүнчлэн хараагүй хүмүүст өрөвч сэтгэлээр ханддаг байв (Иов 29:12–16).
 - ё. Тэр дайснуудынхаа төлөө санаа тавьж, тэднийг уучилдаг байв (Иов 31:29–30).
- Иов ямар хүнд сорилтууд туулсан бэ? Та эдгээр хүнд сорилтуудын заримыг самбар дээр жагсаан бичиж болно. Холбогдох ишлэлүүдээс олон нь унших даалгаварт байхгүй байгаа, иймээс та эдгээрийг олж үзэн, ямар зан чанарууд дүрслэгдсэнийг ярихыг ангийн зарим гишүүдээс хүсч болно.
 - а. Зарц нар, өмч хөрөнгө, орлогоо алдав (Иов 1:13–17).
 - б. Хүүхдүүдээ алдав (Иов 1:18–19).
 - в. Биеийн өвчин зовлон (Иов 2:7; 7:5; 16:16).
 - г. Хар дарж зүүдлэн нойргүй хонов (Иов 7:4, 13–14).
 - д. Харгис хатуугаар ял тулгагдаж, найз нарынхаа болон гэр бүлийнхээ дэмжлэгийг алдав (Иов 2:9; 4:1, 7–8; 11:1–6; 19:13–22).
 - е. Эдгээр хүнд сорилтууд туулахыг яагаад түүнээс хүссэн талаарх эндүүрэл (Иов 10:15).
 - ё. Түүний уналтад баярласан хүмүүс түүгээр доог тохуу хийсэн нь (Иов 16:10–11; 30:1, 8–10).
 - ж. Бурхан түүнийг мартсан буюу эсвэл түүнийг сонсохгүй байгаа мэт бодол (Иов 19:6–8; 23:3–4; Иов 23:3–4 дэх *түүний, түүнийг* гэдэг үгс Бурханыг хэлж байгааг анхаар).

- Иовын хүнд сорилтуудыг манай өнөө үед хүмүүсийн туулдаг сорилтуудтай хэрхэн харьцуулж болох вэ? (Сорилтууд адилхан юм: өмч хөрөнгөө алдах, хүүхдүүдээ алдах, эрүүл мэндээ алдах, түүнчлэн найз нөхөд гэр бүлийнхээ хайр, үерхэл, нөхөрлөлийг алдах)
- Иовын зөв шударга байдлын шалтгааныг Сатан юу гэж мэдэгдсэн бэ? (Иов 1:9–10-ыг үз) Түүний эрүүл мэндийн болон бусад адислалууд авагдахад Иов үүнд яаж хариу үйлдэл үзүүлнэ гэж Сатан урьдчилан хэлж байсан бэ? (Иов 1:11; 2:4–5-ыг үз) Энэ нь тохиоход Иов хэрхэн хариу үйлдэл үзүүлсэн бэ? (Иов 1:20–22; 2:10-ыг үз) Эдгээр хариу үйлдлүүдээс бид юу сурч болох вэ?
- Бэрхшээл тохиолдсон ч гэсэн, Иов “Нүгэл хийсэнгүй, Бурханыг ч буруутгасангүй” (Иов 1:22). Уй гашуу, азгүйтэл буюу эмгэнэлт явдал тохиолдоход зарим хүмүүс хэрхэн Бурханыг буруутгадаг вэ? (Тэд Бурханы буруутгах буюу түүний мэргэн ухаан, зөн билгийн талаар эргэлзэж, тэрээр тэднийг ойлгодоггүй буюу хайрладаггүй гэж боддог Тэр ч байтугай зарим нь тэрээр оршдог эсэх талаар ч эргэлздэг.)

2. Иов Их Эзэн дотор хүч чадал олов.

Иов 13:13–16; 19:23–27-г зааж, ярилц.

- Их Эзэнд итгэх Иовын итгэл өөрийнх нь хувьд сүнслэг хүч чадлын агуу эх сурвалж байв (Иов 13:13–16-г үз). Их Эзэнд итгэх гэсэн нь юу гэсэн үг вэ? Биднийг хүнд сорилтын үед дэмжих Их Эзэнд итгэх итгэлийг бид хэрхэн хөгжүүлж болох вэ? (Ром 8:28; 2 Нифай 2:2, 11, 24; С ба Г 58:2–4; 122:5–9-ийг үз) Их Эзэн биднийг хайрладаг учраас, бид итгэлтэй байх юм бол бүх зүйл бидний сайн сайхны төлөө байж, өсч хөгжихөд маань бидэнд туслах болно гэдэгт биднийг итгүүлдэг.
- Бүлэг 19-д, Иов өөрт нь тохиолдсон хүнд сорилтуудыг дүрсэлж, дараа нь Аврагчийн тухай гэрчилсэн байдаг. Аврагчийн тухай Иовын гэрчлэл түүнд тохиолдсон хүнд сорилтуудыг тэсэн гарахад нь түүнд хэрхэн тусалсан бэ? (Иов 19:25–27-г үз) Аврагчийн тухай гэрчлэл бэрхшээлийн үед бидэнд хэрхэн хүч чадал өгч чадах вэ?

“Би Гэтэлгэгч амьдыг Мэднэ” дууллыг (*Сүмийн Дуулал болон Хүүхдийн дуу*, х. 38) та ангийн гишүүдээр дуулуулах буюу энэ дууллын бичлэгийг тоглож болно.

3. Иов өөрийн хувь хүний зөв шударга болон зарчимч байдалд хүч чадал олдог байв.

Иов 27:2–6-г зааж, ярилц.

- Иовын зарчимч байдал түүнд тохиолдсон гай зовлонгуудын үед сүнсний хүч чадлын өөр нэг эх сурвалж болдог байв (Иов 27:2–6). Зарчимч байдал гэж юу вэ? Хувь хүний зарчимч байдал нь түүнд тохиолдсон хүнд сорилтуудын үед Иовыг хэрхэн хүчирхэгжүүлсэн бэ? Хувь хүний зарчимч байдал хүнд сорилтын үед бидэнд хэрхэн тусалдаг вэ? (Бид зарчимч байдлаа хадгалсан үед, бидний амьдралын замнал Их Эзэний таалалд нийцдэгийг мэдэхээс ирдэг хүч чадлыг бид олж авч чадна.)

Ахлагч Иосеф Б.Вортлин *зарчимч байдал* гэдгийг, “шууд үр дагавруудыг нь харгалзалгүйгээр ямагт зөвийг, бас сайныг үйлдэх явдал. Энэ бол бид зөвхөн

үйл ажиллагаандаа төдийгүй, бүр сэтгэлийнхээ угаас, бүр илүү чухал нь, бодол санаа хийгээд зүрх сэтгэлдээ зөв шударга байх явдал гэсэн үг юм. Хувь хүний зарчимч байдал нь итгэлд буюу гэрээний тухайд биднийг хуурамч байхад аргагүйд хүргэдэг итгэл даахуйц зохистой байдал, ялзрал доройтолд өртөшгүй байдлыг өөртөө багтаадаг” гэж тодорхойлжээ (Conference Report, 1990 оны 4-р сар, 38; *Ensign*, 1990 оны 5-р сар, 30).

4. Иов өөрт нь тохиолдсон хүнд сорилтуудыг тэсэн гарсны дараа Их Эзэн түүнийг адислав.

Иов 42:10–17-г зааж, ярилц.

- Иов өөрт нь тохиолдсон хүнд сорилтуудыг итгэлтэйгээр тэсэн гарсны дараа, Их Эзэн түүнийг хэрхэн адисалсан бэ? (Иов 42:10–15; Иаков 5:11-ийг үз) Хүнд сорилтуудыг бид итгэлтэйгээр тэвчихэд Их Эзэн биднийг хэрхэн адисалдаг вэ? (Иов 23:10; 3 Нифай 15:9-ийг үз. Хувийн туршлагаадаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж. Их Эзэн Иовыг хэдийгээр “урьд байсан бүхнээс хоёр дахин илүү” адисалсан хэдий ч, биднийг итгэлтэйгээр тэвчихэд Их Эзэн бидэнд өгдөг сүнсний адислалууд цаг зуурын адислалуудаас бүр ч илүү их юм гэдгийг та тэмдэглэн хэлэхийг хүсч болно.)

Ахлагч Оорсон Ф.Витней хэлэхдээ: “Бидэнд тохиолддог зовлон ч, бидний туулдаг хүнд сорилт ч алга болдоггүй. Энэ нь бидний хүмүүжилд үйлчлэн, тэвчээр, итгэл, сэтгэлийн хат, даруу байдал зэрэг чанаруудыг бидэнд хөгжүүлдэг. Бидний туулж өнгөрүүлдэг бүх зүйл, бидний тэвчдэг бүхэн, ялангуяа бид үүнийг тэвчээртэйгээр тэсэн гарахад, бидний зан чанарыг төлөвшүүлж, бидний зүрх сэтгэлийг ариусгаж, бидний сэтгэл санааг уужруулж, биднийг илүү эелдэг зөөлөн, энэрэнгүй, Бурханы хүүхдүүд гэж дуудагдахад илүү зохистой болгодог . . . бөгөөд уй гашуу хийгээд зүдгүүр, гай зовлон хийгээд зовлон бэрхшээлүүдээр дамжуулан бид тэнгэр дэх өөрсдийн Эцэг, Эхтэй илүү адилхан болохын тулд бид энд ирснээр боловсрол хүмүүжил олдог билээ” гэжээ (Спенсер В.Кимбаллын, *Faith Precedes the Miracle*, 98-аас иш татжээ).

“Би өндөр уулнаас тасран өнхөрсөн том, барзгар чулуутай адилхан юм; миний хүлээж авдаг цорын ганц өнгөлөлт бол намайг өөр ямар нэг зүйлтэй хавиралдахад зарим өнцөг нь энд, зарим өнцөг нь тэнд үрэгдэн мөлийдөг. Тийнхүү би Бүхнийг Чадагчийн саадгийн ишин дотор өнгөлөгдөн мөлгөр болох болно” гэж Бошиглогч Иосеф Смит хэлжээ (*Teachings of the Prophet Joseph Smith*, эмхтгэсэн. Иосеф Фиелдинг Смит [1976], 304).

Дүгнэлт

Иовын номны тухай ярилцлагаа нэгтгэн дүгнэхдээ, Их Эзэнд итгэж, түүний тухай гэрчлэлүүдээ төлөвшүүлж, бидний амьдрал түүний таалалд нийцэхүйц байхын тулд бид зарчимч байдлаа хадгалснаар өөрсдөдөө тохиолдсон хүнд сорилтуудыг тэсэн гарах хүч чадлыг олж авч чадна гэдгийг онцлон тэмдэглэ. Бэрхшээл тохиолдсон үед хүч чадал хүлээн авсан тохиолдлуудынх нь талаар та ангийн гишүүдээр яриулахыг хүсч болно. Бэрхшээлийг тэсэн гарахад өөртөө туслахын тулд тэд энэ хичээлээр ярилцсан зарчмуудыг тэд хэрхэн хэрэглэж болох тухай эргэцүүлэн бодохыг ангийн гишүүдэд санал болго.

Нэмэлт заах санаанууд

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

1. Иовын найз нар

- Иовын хоёр найз Елифа, Билдад нар түүний зовлонг хэрхэн тайлбарласан бэ? (Иов 4:7–8; 8:6-г үз. Иовын зовлон бол тэрээр нүгэл үйлдсэн учраас Бурханаас ирсэн шийтгэл гэж тэд бодож байжээ) Бүх зовлон бидний нүглүүдийн улмаас Бурханаас ирдэг гэж итгэхийн аюул юу вэ?
- Иовын найз нарын алдаа зовлон бэрхшээл амссан хүмүүст туслах талаар бидэнд юу заадаг вэ?

2. Бэрхшээл зовлонгийн үед асуух асуултууд

“Та нар бэрхшээлтэй тулгарсан үед, олон асуулт руу хөтлөгдөж болно. Зарим хүмүүс ашигтай зорилгод үйлчилдэг байхад, бусад нь тэгдэггүй. Энэ явдал яагаад надад тохиолдох болов? Яагаад энэ нь одоо надад тохиолдох болов? Ингэхэд хүргэсэн юуг би хийсэн билээ? гэж асуух нь таныг гарцгүй мухар гудамж уруу хөтлөх болно. Бурханы тааллын эсрэг чиглэсэн асуултууд асуух нь үнэхээр сайн биш л дээ. Харин, Би юу хийх ёстой вэ? Энэ туршлагаас би юу сурах ёстой вэ? Би юуг өөрчлөх ёстой вэ? Би хэнд туслах ёстой вэ? Хүнд сорилтын цагт би өөрийн олон адислалыг хэрхэн санаж болох вэ?” гэж Ахлагч Ричард Г. Скотт хэлсэн байдаг (Conference Report, 1995 оны 10-р сар, 18; *Ensign*, 1995 оны 11-р сар, 17).

3. Бэрхшээл зовлонгийн үед алсын хараатай байх нь

Ерөнхийлөгч Спенсер В. Кимбалл:

“Хэрэв бид үхэшгүй байдлыг бүхэл оршихуйн хувьд нь харсан бол, өвчин зовлон, уй гашуу, бүтэлгүйтэл хийгээд богинохон амьдрал нь гай зовлон байхсан. Гэвч, бид амьдралыг үхэшгүй байдлын өмнөх үед, түүнчлэн үхлийн дараах мөнхийн ирээдүйд хамаарах мөнхийн зүйл гэдгээр нь харах юм бол, тохиодог бүх зүйлүүд зохих ёсоор хэтийн төлөвт тавигдаж болно.

“. . . Бид өөрсдийн хүч чадал, тэвчээрт суралцаж болох өвчин, бид үхэшгүй байдалтай болж, алдар сууд хүрэх үхлийг сориулахаар уруу таталтуудад тавигддаггүй гэж үү?

“Хэрэв тэдний төлөө бид залбирдаг бүх өвчтөнүүд эдгэрдэг бол, хэрэв зөв шударга бүх хүмүүс хамгаалагдаж, ёс бусыг үйлдэгчид устгагддаг бол, Эцэгийн бүхэл хөтөлбөр хүчингүй болж, сайн мэдээний үндсэн зарчим, чөлөөтэйгөөр сонгох эрх дуусгавар болох байсан. Хэн ч итгэлээр амьдрах шаардлагагүй болох байсан” гэж хэлжээ (*Faith Precedes the Miracle* [1975], 97).

4. Ёс бусыг үйлдэгчид цэцэглэн хөгжих нь түр зуурынх байдаг

- Заримдаа ёс бусыг үйлдэгчид цэцэглэн хөгжиж байхад зөв шударга хүмүүс зовж байх шиг санагддаг. Ёс бусыг үйлдэгчид цэцэглэн хөгжиж байгаа мэт санагддаг талаар Иовын ном бидэнд юу заадаг вэ? (Иов 21; 24-ийг үз)

Зорилго Хожмын үеийн Израилын хувьд, дэлхийн бүх хүмүүсийг хайрлаж, сайн мэдээний адислалуудыг тэдэнтэй хуваалцах үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэхэд нь ангийн гишүүдийг урамшуулан дэмжих.

Бэлтгэл Дараах судруудыг залбирч судал:

- а. Иона 1–2. Их Эзэн Ниневегийн хүмүүст наманчлалыг тунхаглуулахаар Ионаг дуудав. Иона Их Эзэнээс завиар зугтахыг оролдоод, аварга загасанд залгиулж, залбиран, тэгээд загасны гэдсэн дотроос суллагджээ.
- б. Иона 3–4. Иона Ниневегийн уналтыг бошиглосон бөгөөд Ниневегийн хүмүүс наманчилж, Их Эзэн хотыг авраhad уурлажээ (Иона 3:9–10-ын Иосеф Смитийн Орчуулга, Бурхан биш, хүмүүс наманчилсныг тайлбарладаг). Тэрээр бүх хүмүүсийг хайрлах ёстойг Ионад заахын тулд Их Эзэн хулуу, өгийг ашиглажээ.
- в. Мика 2:12–13; 4:1–7, 11–13; 5:2–4, 7–8; 6:6–8; 7:18–20. Мика эцсийн өдрүүд дэх Израилын үүрэг зорилгын тухай бошиглодог.

Энэ хичээлийг заах зөвлөмж

Анхаарал
төвлөрүүлэх
үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагааг (эсвэл өөрийхөө нэг үйл ажиллагааг) ашиглахыг хүсч болно.

- Сүм дэх хичнээн олон залуу хүмүүсийг бүрэн цагийн номлолд үйлчлэхийг Их Эзэн хүсдэг вэ? (Бүх зохистой, чадварлаг эрэгтэйчүүдийг) Эдгээр залуу хүмүүс нэг бүр энэ дуудлагад хариулах нь яагаад чухал вэ? Өөр хэн бүрэн цагийн номлолд үйлчилж болох вэ? (21 настай ганц бие эгч нар эсвэл нөхцөл байдал нь боломжтой гэр бүлийн ахмад хосууд)

1979 онд Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл дэлхийн бүх хэсгүүдэд сайн мэдээг номлож чадах улам олон номлогчид хэрэгтэй байгаа тухай ярьжээ. “Их Эзэн өөрийн оюунд төлөвлөсөн юуг ч гэсэн хийж чаддагт би итгэдэг. Гэвч дотогш ороход бид бэлтгэгдээгүй хаалгуудыг Их Эзэн яагаад нээдгийн учир шалтгааныг би сайн ухаардаггүй” хэмээн тэрээр мэдэгджээ (“The Uttermost Parts of the Earth,” *Ensign*, 1979 оны 7-р сар, 9).

Иона, Мика нарын амьдрал, бичсэн зүйлүүд бүх хүмүүсийг хайрлаж, сайн мэдээний адислалуудыг тэдэнтэй хуваалцах үүрэг хариуцлагаа ойлгоход бидэнд хэрхэн тусалж чадах тухай энэ хичээлээр ярилцах болно.

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагауудаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Иона Ниневед номлохоор дуудагдсан боловч, тэр зугтаав.

Иона 1–2-ыг зааж, ярилц.

- Их Эзэн яагаад Ионаг Ниневе уруу явахыг хүссэн бэ? (Иона 1:2-ыг үз) Яагаад Иона Ниневед номлолын дуудлага хүлээн авахад дургүй байсан байж болох вэ? (Ниневегийн ихэд ёс бус хийгээд харгис хэрцгий байдлыг дүрсэлсэн Нахум 3:1–5-ыг үз. Ассирийн нийслэл Ниневегийн хүмүүс Израилын дайсан байв.)
- Иона яагаад Таршиш уруу явсан бэ? (Иона 1:3-ыг үз) Ямар байдлаар бид заримдаа Их Эзэний оршихуйгаас буюу бидэнд түүний төлөөлөгчдийн өгсөн дуудлагаас зайлсхийхийг хичээдэг вэ? Ийм хүч чармайлтын үр дүн юу вэ?
- Ионаг наманчлахад Их Эзэн хэрхэн нигүүлсэл үзүүлж, тусалсан бэ? (Иона 1:4–2:10-ыг үзүүл) Иона аварга загасны дотор байхдаа юу мэдэж авсан бэ? (Иона 2:1–9-ийг үз) Наманчлахад болон түүний замд эргэж ороход Их Эзэн бидэнд хэрхэн тусалдаг вэ?
- Аврагч дэлхий дэх тохинууллынхаа үед “бошиглогч Ионасын [Иона] тэмдгийн” тухай хэлсэн байдаг (Матай 12:39). Энэ тэмдэг ямар учиртай байсан бэ? (Матай 12:39–41-ийг үз. Иона аварга загасны гэдсэнд гурван шөнө, гурван өдрийг өнгөрүүлж, тэгээд дараа нь амьд гарчээ. Аврагч дэлхийд гурван өдөр, гурван шөнө оршуулагдаад дараа нь амилах учиртай байв.)
- Их Эзэн өөрийн бошиглогчдоор дамжуулан зохистой, чадварлаг залуу эрэгтэй хүн бүрийг бүрэн цагийн номлолд үйлчлэхийг дахин давтан зарлигласаар байна. Тэрээр бас боломжтой бол ахмад гэр бүлийн хосуудыг бүрэн цагийн номлолд үйлчлэхийг нь урамшуулан дэмждэг. (Нэмэлт заах санаануудыг үз) Зарим залуу эрэгтэйчүүд, ахмад гэр бүлийн хосууд номлолд үйлчлэхгүй байхаар сонгодгийн зарим шалтгаан юу вэ? (Шийдвэр төгс байдал ба итгэл дутуу байх, зохисгүй байдал, гэр орон, гэр бүлийнхээ ая тухыг орхихыг хүсэхгүй байх, тэднийг хүлээж байгаа зүйлүүдээс эмээх) Их Эзэнийг дуулгавартай дагах болон сайн мэдээг хуваалцахад эрс шийдэмгий байхад бидэнд тусалж чадах Ионагийн түүхээс бид юу сурч болох вэ?

2. Ниневегийн хүмүүс Ионагийн захиаст хариулж, наманчлав.

Иона 3–4-ийг зааж, ярилц.

- Ионаг наманчилсны дараа Их Эзэн түүнийг Ниневегийн хүмүүст номлохоор дахин дууджээ. Ионагийн захиаст Ниневегийн хүмүүс хэрхэн хариулсан бэ? (Иона 3:5–9-ийг үз. Эрт үед хүмүүс өөрсдийгөө даруу бөгөөд наманчилдаг гэдгээ харуулахын тулд таар гэж нэрлэгддэг бүдүүн ширхэгтэй даавуун хувцас, өмсөж, үнсэн дээр суудаг байжээ.) Хүмүүст гарсан өөрчлөлтөд Бурхан хэрхэн хариулсан бэ? (Иона 3:10-ыг үз)

- Иона Ниневегийн уналтыг бошиглов (Иона3:4). Их Эзэн Ниневегийн хүмүүсийг уучлахад Иона хэрхэн хариулсан бэ? (Иона 4:1–3-ыг үз. Их Эзэн хүмүүст нигүүлсэнгүй хандсанд тэрээр ууртай байв.)
- Хулуу өсч, сүүдэр, ая тух өгөөд дараа нь үхсэнээр Их Эзэн Ионад юу заасан бэ? (Иона 4:4–11-ийг үз. Бурхан өөрийн бүх хүүхдэд хайртай. Тэрээр нигүүлслээ Ионад харуулсан лугаа адил, тэрбээр Ниневегийн наманчлагч хүмүүст нигүүлсэл үзүүлэх хүсэлтэй байжээ.) Бусад хүмүүсийг хайрлах талаар Ионагийн туршлага бидэнд юу заадаг вэ?

3. Хожмын үеийн Израилын үүрэг зорилгын тухай Мика бошиглов.

Микагаас дараах хэсгүүдийг зааж, ярилц.

Өөрсдийнхөө ёс бусыг наманчилж, Их Эзэнд эргэхэд бошиглогч Мика Израилын хүмүүсийг уриалав. Иаков (Израил) Иудей хоёрын устгалыг тэрээр бошиглов. Тэр бас хожмын үеийн Израил (Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм) агуу их хүч чармайлтаар Их Эзэний зорилгуудыг хэрэгжүүлэх болно гэдгийг бошиглосон ажээ.

- Мика 2:12–13-т Их Эзэн ямар амлалтууд өгсөн бэ? (Тэрээр Израилын үлдэгдлийг цуглуулах болно гэдгээ, тэд агуу олон тоотой болно гэдгийг, мөн тэрээр тэднийг удирдах болно гэдгийг амлажээ.) Өнөөдөр эдгээр амлалтууд хэрхэн хэрэгжиж байна вэ?
- Хожмын өдрүүдийн тухай Микагийн агуу бошиглолуудын зарим нь Мика 4:1–7-д цэдэглэгдсэн байдаг. Хожмын үеийн ариун сүмийн тухай Мика юу гэж бошиглосон бэ? (Шүлэг 1–2-ыг үз) Мянган Жилийн тухай тэр юу бошиглосон бэ? (Шүлэг 3–7-г үз) Эдгээр бошиглолууд яагаад бидний хувьд ач холбогдолтой вэ?
- Хожмын үеийн Израилын хувь заяаны талаар бид Мика 4:11–13-аас юу сурч болох вэ? (Эртний дэлхийд тариа цайруулахад шаруудыг (эр үхэр) олонтаа хэрэглэдэг байжээ. Тэд тариан дээгүүр гишгэлж, үрийг нь хальснаас салгадаг байв. Хальс салхинд хийсч, үр нь үлддэг байжээ. Сионыг эсэргүүцдэг үндэстнүүд тариан боодол лугаа адил цуглуулагдаж, тэгээд Израилаар цохигдох болно.) Үрээс хальсыг ийнхүү салгах нь номлолын ажлыг дэлхий даяар хийх хожмын үеийн Израилын үүрэг хариуцлагатай хэрхэн харьцуулагдаж болох вэ? (С ба Г 29:7; 33:5–7-г үз)
- Мика 5:2–4-д тэрээр хэний тухай бошиглосон бэ? (Энэ бошиглолыг Матай 2:4–6 дахь үүний биелэлттэй харьцуул)
- Мика 5:7-д Их Эзэний хүмүүс юутай зүйрлэгдсэн бэ? Ногоон дээрх шүүдэр болон аадар борооны дүрслэл нь Сүмийн гишүүдээс дэлхийн хүмүүст үзүүлэх нөлөөтэй хэрхэн зүйрлэгдэж болох вэ? Эдгээр аадар бороонууд “хүний хөвгүүдийг” хүлээхгүй гэж Мика хэлсэн нь ямар учиртай гэж та нар боддог вэ? (Мөнх бус хүмүүс шүүдэр үүсэх буюу аадар бороо орохыг зогсоож чадахгүйн адил, Их Эзэний ажил дэлхий даяар өсөн нэмэгдэхийг юу ч зогсоож чадахгүй.)
- Мика 5:8-д Их Эзэний хүмүүс юутай зүйрлэгдсэн бэ? Энэ дүрслэл Их Эзэний ажлын хүч чадал хийгээд хүчний тухай юу өгүүлдэг вэ? (Хонин сүрэг залуу арсланг зогсоох хүчгүй байдаг шиг, Их Эзэний ажлыг саатуулах ямар ч хүч дэлхий дээр байхгүй байх болно.)

1842 онд Бошиглогч Иосеф Смит, “Ариусгагдаагүй гар уг ажлыг өсөлтөөс нь зогсоож чадахгүй; мөрдлөг хавчлага гаарч болно, танхайрагчид сүлбэлдэж болно, цэрэг хуралдан цугларч мэднэ, гүтгэж нэр төр гутааж болно, гэвч Бурханы үнэн тив бүхэнд нэвтэрч, уур амьсгал бүхэнд хүрч, улс орон бүрийг шүүрдэн, чих болгонд сонсогдож, Бурханы зорилгууд гүйцэлдэх хүртэл зоримгоор, эрхэмсгээр бас бие даасан байдалтайгаар урагш ахих болно, мөн Агуу Их Иехова уг ажил хийгдлээ гэж хэлэх болно” хэмээн мэдэгджээ (*History of the Church*, 4:540).

- Бид өөрсдөөсөө хүсэн хүлээгддэг бүхнээр хэт дарагдсан гэж бодогдох үед Мика 6:6–8 бидэнд хэрхэн тусалж чадах вэ?
- Хожмын өдрүүд дэх Их Эзэний ажлын талаар бошиглосныхоо дараа Бурханы мөн чанарын талаар Мика ямар дүгнэлтэд хүрсэн бэ? (Мика 7:18–20-ийг үз) Эдгээр шүлгүүд дэх ямар өгүүлбэрүүд Ниневегийн хүмүүстэй харилцсан Их Эзэний харилцаанд холбогдох вэ? Эдгээр өгүүлбэрүүдээс аль нь бидэнтэй харилцах Их Эзэний харилцаанд холбогдох вэ?

Дүгнэлт

Их Эзэн өөрийн бүх хүүхдэд хайртай бөгөөд хожмын үеийн Израил — бид түүний хайрыг болон сайн мэдээний үнэнүүдийг бүх хүмүүстэй хуваалцах агуу үүрэг хариуцлагатай тухай гэрчлэлийг хэл. Иона, Мика нараас сурсан зүйлээ хуваалцахыг ангийн гишүүдээс хүс.

Нэмэлт заах санаанууд

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

1. Зохистой чадварлаг залуу эрэгтэй хүн бүр номлолд үйлчлэхээр бэлтгэх ёстой

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбаллын дараах мэдэгдлийн тухай ярилц:

“Би илүү олон номлогчдыг хүсэхдээ, гэрчлэлгүй буюу зохистой бус баахан номлогчд хэрэгтэй гэж хэлээгүй байна. Бид эртнээс эхэлж, манай номлогчдыг дэлхий дэх илүү сайн салбарт, илүү сайн хэсэгт бэлтгэхийг хүсч байна. Номлолд явна гэдэг бол агуу онцгой боломж гэдгийг, тэд бие бялдын хувьд сайн, сэтгэц мэдрэлийн хувьд сайн байх ёстойг, Их Эзэн нүглийг өчүүхэн төдийн хэмжээгээр чгэсэн хүлээн зөвшөөрч, харж чаддаггүйг залуу хүмүүс ойлгох учиртай нь өөр нэг сорилт юм’ . . .

“Залуу эрэгтэй хүн бүр номлолд явах ёстой юу? гэдэг асуултыг байнга давтан асуудаг. Харин хариулт нь ‘Тийм ээ’ гэдэг үг бөгөөд энэ нь Их Эзэнээр өгөгдсөн юм. Залуу эрэгтэй хүн бүр номлолд явах ёстой.”
(“When the World Will Be Converted,” *Ensign*, 1974 оны 10-р сар, 7–8)

2. Гэр бүлийн хос номлогчдын хэрэгцээ

Ахлагч Давид Б.Хейтийн дараах мэдэгдлийн тухай ярилц:

“Номлолд үйлчлэх асуудлыг нухацтай авч үзэхийг тэтгэвэрт гарсан гэр бүлийн хосуудад Ах нарын нэрийн өмнөөс уриалж байна. Бидний хэрэгцээг хангахын тулд туслах илүү олон ахмад гэр бүлийн хос бидэнд чухал хэрэгтэй байна. . . .

Манай номлолын ерөнхийлөгчдөөс ахмад гэр бүлийн хос номлогчид хүсдэг хүсэлтийн тавиас доош хувийг л биелүүлж байна. . . .

“Олон, бүр илүү олон гэр бүлийн хос Сүмд бүрэн цагийн номлолд өөрсдийгөө бэлэн болгох болно гэдэгт Ах нар найддаг. Хэрэгцээ үнэхээр их байна! Сүмд жил бүр хэдэн зуун мянган шинэ гишүүн нэгдэж байна, тэд дэмжлэгийн нөхөрсөг дуу хоолой хийгээд тайтгарлыг туршлагатай гишүүдээс сонсож байх хэрэгтэй.

“Намайг та хаашаа явахыг хүснэ, тийшээ би явна, эрхэм дээд Эзэн минь! (Hymns, 1985, дугаар. 270) гэсэн дууллын дахилт бол, Ням гарагт бидний дуулдаг нэг дуулаас илүү зүйл юм. Энэ бол бид Их Эзэнд хэрэгтэй газарт нь үйлчилж байгаа үед бидний итгэлийн залбирал байх ёстой.” (“Couple Missionaries: ‘A Wonderful Resource,’ ” *Ensign*, 1996 оны 2-р сар, 7, 12)

“Би зөвт байдалд чамтай сүй тавина”

Хичээл
34

Хосеа 1–3; 11; 13–14

Зорилго	Их Эзэн бол хайраар дүүрэн, нигүүлсэнгүй бөгөөд бид наманчилж түүнд эргэж ирэхэд Тэрбээр биднийг өршөөх болно гэдгийг ойлгоход нь ангийн гишүүдэд туслах.
----------------	---

Бэлтгэл	<ol style="list-style-type: none">Дараах судруудыг залбирч, судал:<ol style="list-style-type: none">Хосеа 1–3. Итгэлтэй нөхөр ба садар самууныг үйлдэгч эхнэр хоёрын зүйрлэлийг ашиглан, Хосеа Их Эзэн, Израил хоёрын хоорондын харилцааг дүрсэлжээ.Хосеа 11; 13–14. Их Эзэн өөрийн хүмүүсийг хайрладаг учраас наманчилж, түүнд эргэж ирэхэд Израилыг урьсаар байдаг.Нэмэлт уншлага: Хосеагийн номны үлдсэн хэсэг.Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг хэрэглэх бол, дараах өгүүлбэрүүдийг тус тусад нь хэсэг цаасан дээр бичиж ангийн өмнө байрлуул. Хэрэв танай анги цөөхөн хүнтэй бол ангийн гишүүн бүрд нэг цаас бэлтгэ.<p>“Израилын хүүхдүүд далайн элс мэт олон байх болно” (Хосеа 1:10) “Тэдний дээр би уур хилэнгээ ус мэт цутгах болно” (Хосеа 5:10) “ЭЗЭН . . . бидэн дээр бороо мэт ирнэ” (Хосеа 6:3) “Тэрээр бүргэд мэт ирэх болно” (Хосеа 8:1) “Израил бол саглагар усан үзмийн мод юм” (Хосеа 10:1) “Шүүлт нь тариан талбайн шан дахь хортой зэрлэг ургамал шиг соёолж байна” (Хосеа 10:4) “Тэд . . . яндангаас гарах утаа шиг байх болно” (Хосеа 13:3) “Бамбаруушнуудаа булаалгасан баавгай шиг би тэдэнтэй тулгарах болно” (Хосеа 13:8) “Би бол саглагар нарстай адил юм” (Хосеа 14:8)</p>
----------------	---

Энэ хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа	<p>Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагааг (эсвэл өөрийхөө нэг үйл ажиллагааг) ашиглахыг хүсч болно.</p> <p>Өөрийнхөө бэлтгэсэн цааснуудыг ангийн гишүүдийн дунд тавьж өг (Дээрх “Бэлтгэлийг” үз). Эдгээр өгүүлбэр тус бүр нь Хосеагийн номноос авсан зүйрлэл юм. Цаас хүлээн авсан ангийн гишүүн нэг бүрээр уг өгүүлбэрийг чангаар уншуулж, зүйрлэлийн боломжит нэг утгыг хэлүүл. Жишээ нь, хүнийг “арслан шиг” гэж хэлэх нь хүч чадал хийгээд догшин хэрцгийг илтгэн харуулдаг.</p> <ul style="list-style-type: none">Хосеа болон бусад бошиглогчид яагаад зүйрлэлүүд ашигладаг байсан гэж та нар боддог вэ? (Төвөгтэй буюу танил биш санааг илүү энгийн бөгөөд
------------------------------------	---

танил зүйлтэй зүйрлүүлэх нь заалгаж байгаа хүмүүст илүү ойлгомжтой байдаг. Зүйрлэлүүд нь бас олон нарийн зүйлийг хэдхэн үгээр илэрхийлэхэд бас тусалдаг)

Хосеа эдгээр жижиг зүйрлэлүүдээс гадна бас метафор (зүйрлэл) буюу ижил төс хэмээн нэрлэгддэг том хэмжээний харьцууллуудыг бас ашигласан байдаг (*ижил төс* гэдэг үг судруудад хэрэглэгддэг). Есүс Христ болон түүний хүмүүсийн хоорондын харилцааг ойлгоход бидэнд туслах хэд хэдэн зүйрлэлийг Хосеагийн ном агуулдаг.

Судрын ярилцлага
ба хэрэглээ

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагауудаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Итгэлтэй нөхөр, садар самууныг үйлдэгч эхнэр хоёрын тухай зүйрлэлийг ашиглан Хосеа Их Эзэн, Израил хоёрын хоорондын харилцааг дүрсэлжээ.

Хосеа 1–3. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашиглаагүй бол, ярилцлагыг эхлэхийн өмнө ижил төс гэж юу болохыг тайлбарла.

Ижил төстэй байдлыг судруудад хамгийн өргөн хэрэглэсний нэг жишээ бол Их Эзэнийг хүргэн хүү (эсвэл нөхөр), мөн түүний гэрээт хүмүүсийг түүний сүйт бүсгүй (эсвэл эхнэр) хэмээн дүрсэлсэн явдал мөн. Хосеа 1–3 Израил хиймэл шүтээн шүтдэгийг садар самууныг үйлдэхтэй зүйрлүүлэн, энэхүү ижил төстэй байдлыг хүчтэйгээр ашигласан байдаг. Эдгээр бүлгүүдэд бошиглогч Хосеа Их Эзэнийг нөхөр болгон төлөөлдөг бол, Гомер Израилыг эхнэр болгож төлөөлдөг.

- Хосеагийн номонд, Израилтай (өнөөдөр бол Сүмтэй) харилцах харилцаанд Их Эзэний харилцаа нөхөр, эхнэр хоёрын хоорондох харилцаатай зүйрлэгдсэн байдаг. Энэ зүйрлэл биднээс Их Эзэн хүсэн хүлээдэг бидний шийдвэр төгс хийгээд бүхнээ зориулсан байдлын түвшингийн талаар бидэнд юу заадаг вэ?
- Израил ямар байдлаар эртний Израил “завхай эхнэр” хэмээн дүрслэгдсэн Гомертой зүйрлэгдсэн бэ? (Хосеа 1:2–3; 2:5, 13-ыг үз. Гомер өөрийнхөө амрагуудын улмаас нөхрөө хаядаг; Израил Их Эзэнийг мартаж, улмаар ёс бус болсон билээ)
- Хүхмүүсийг Их Эзэнээс холдож, эргэхэд хүргэсэн “амрагууд” буюу юмс нь хэн, бас юу байсан бэ? (Бусад бурхад, эд материалын бурхад түүнчлэн дэлхийн дадал зуршлууд) Аврагчийг дагахад бүхнээ зориулахад ямар зүйлүүд бидний чигийг өөрчлөн холдуулдаг?
- Садар самууныг үйлдэгч эхнэр хоол хүнс, хувцасныхаа хэрэгцээг хэнд түшиглэн даатгадаг байсан бэ? (Хосеа 2:5-ыг үз) Израилчууд өөрсдийн амьдардаг байсан үржил шимтэй газрыг хэнийх гэж үздэг байсан бэ? (Хосеа 2:5, 12-ыг үз; өөрсдийн хуурамч бурхад буюу хиймэл шүтээнүүдийнх гэж үздэг байв.) Өнөө үеийн хүмүүс өөрсдийн хүлээж авсан адислалуудыг хэрхэн хуурамч бурхдад ноогдуулдаг вэ?
- Түүнийг хоол хүнс, ундаа бусад эд юмсаар амрагууд нь бус, харин нөхөр нь хангадгийг тэр эхнэртээ хэрхэн сануулсан бэ? (Хосеа 2:8–9-ийг үз)

Ямар арга замуудаар Их Эзэн та нарыг материаллаг болон сүнсний адислалуудаар хангадаг вэ? Их Эзэн бидэнд өгсөн адислалуудын төлөө бид Түүнд талархлаа хэрхэн харуулж чадах вэ?

- Хосеа 2:6–13-т нөхөр нь итгэлгүй эхнэртээ хэрхэн хандаж байсан бэ? Энэ хандлага 14–23-д юугаараа өөр байна вэ? (Тэр ч байтугай, эхнэр нь итгэлгүй байсан ч гэсэн, нөхөр нь түүнд хайртай хэвээр байж, өөртөө эргэж ирэхийг түүнээс хүсч байв. Үүнчлэн, Их Эзэн замаасаа гажиж явсан өөрийн хүмүүсийг хайрласан хэвээр байдаг бөгөөд тэрээр тэднийг өөртөө эргэж ирэхийг хүсдэгийг тэмдэглэн хэл)

Ахлагч Хенри Б.Айринг тайлбарлахдаа: “Энэ бол нэг хайрын түүх юм. Энэ бол хайраар, тууштай хайраар холбогдсон гэрлэлтийн гэрээний тухай түүх юм. . . . Түүнтэй миний бие гэрээ хийх ёстой Их Эзэн намайг адисалж, намайг, бас таныг хайрладаг, . . . тууштай шаргуу байдлынх нь тухайд би үргэлж гайхан биширдэг бөгөөд бүх зүрх сэтгэлээрээ эрхэмлэн дуурайхыг хүсдэг” гэжээ (*Covenants and Sacrifice* [Сүмийн Боловсролын Системийн Симпозиум дээр хэлсэн үг, 1995 оны 8-р сарын 15], 2).

- Хэрэв тэрээр өөрт нь эргэж ирвэл, нөхөр нь түүнд юу амласан бэ? (Хосеа 2:19-ийг үз) Хэрэв тэд наманчилж, өөрт нь эргэж ирэх юм бол, Их Эзэн өөрийн хүмүүст юу амласан бэ? (Хосеа 2:20, 23-ыг үз) Энэ амлалт яагаад чухал вэ?
- Хосеа 3:1–2, нөхөр нь эхнэрээ амрагаас нь худалдаж авдаг (Хуучин Гэрээний үеийн заншлаар, эмэгтэйчүүдийг өмч хөрөнгө гэж тооцон, худалдах буюу худалдан авч болдог байсныг та тайлбарлаж болно). Нөхөр нь эхнэрээ худалдаж авсны дараа түүнээс юу шаардсан бэ? (Хосеа 3:3-ыг үз) Тэрээр түүнд юу амласан бэ? Ямар утгаараа Есүс Христ бидний хүн бүрийг “худалдаж авсан бэ?” (1 Петр 1:18–19-ийг үз) Христ хариуд нь биднээс юу шаарддаг вэ?

2. Өөрийн хүмүүсийг хайрлах хайрынхаа улмаас Их Эзэн, наманчилж, өөртөө эргэж ирэхэд Израилыг үргэлж урьсаар байдаг.

Хосеа 11; 13–14-ийг зааж, ярилц.

Хосеагийн номны эхнээс эцэс хүртэл, Их Эзэн тэдний их нүглүүдийн учир израилчуудыг зэмлэн буруутгасан байдаг. Их Эзэн Хосеагаар дамжуулан, Израилын ёс бусаас болж тохиох боолчлол хийгээд устгалыг дүрсэлсний дараа тэрээр өөрийн хүмүүсийг наманчилж, өөрт нь эргэж ирэхэд дахин урьжээ.

- Их Эзэн болон түүний хүмүүсийн хоорондын харилцааг дүрслэхийн тулд судруудад олонтаа хэрэглэгддэг өөр нэг ижил төстэй байдал бол эзэн— малын харилцаа юм. Энэхүү ижил төсийг Хосеа 11:4-т товчхон хэрэглэсэн байдаг. Энэ зүйрлэлээр дамжуулсан, өөрийн хүмүүсийн талаарх Их Эзэний бодол санаануудын талаар бид юу сурч болох вэ? (Хосеа 11:7–9-ийг мөн үз. Шүлэг 8-ын Иосеф Смитийн Орчуулгад “миний зүрх сэтгэл миний өөрийн дотор эргэхийн” оронд “миний зүрх сэтгэл чам уруу эргэдэг” хэмээн өгүүлжээ.)
- Тэдний өвөг дээдэс Египет дахь боолчлолоос хэрхэн чөлөөлөгдсөнийг Их Эзэн израилчуудад хэдэнтээ сануулжээ (Хосеа 11:1; 12:9, 13; 13:4–5). Энэ үйл явдал юутай ижил төстэй байж болох вэ? (Хосеа 13:14-ийг үз. Их Эзэн

Израилын хүүхдүүдийг Египет дахь боолчлолоос чөлөөлсний нэгэн адил, бас түүнд ирдэг бүх хүмүүсийг нүгэл болоод үхлээс тэрээр бас чөлөөлөх болно.)

- Израилчууд Их Эзэнд эргэж ирэн, чөлөөлөлтийг хүлээж авахын тулд юу хийх хэрэгтэй байсан бэ? (Хосеа 12:6; 14:2–3-ыг үз. Тэд нүглүүдээ наманчилж, өөрсдийн шүтдэг байсан бусад бурхдыг орхих хэрэгтэй байлаа) Хэрэв тэд наманчилбал Их Эзэн юу хийхээр амласан бэ? (Хосеа 14:4–7-г үз) Хэрэв бид нүглүүдээ наманчлах юм бол Их Эзэн юу хийнэ гэж амладаг вэ?
- Хосеагийн номон дахь ижил төстэй байдлууд Аврагч таны тухайд ямар бодол санаатай байдгийг ойлгоход та нарт хэрхэн тусалдаг вэ?

Дүгнэлт

Зарлигуудыг сахьдаг хүмүүс Их Эзэний адислалуудыг хүлээн авдаг бол, түүний хайр бүх хүмүүст хүрдэг бөгөөд байнгын юм гэдгийг гэрчил. Тэр ч байтугай бид нүглийн улмаас түүнээс холдож эргэсэн байлаа ч гэсэн, Их Эзэн биднийг хайрлаж, наманчилж, түүнд эргэж очихыг хүсдэг. Их Эзэнд итгэлтэй байхад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

Нэмэлт заах санаанууд

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгонд эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

1. “Би тахилаас илүүгээр хайр энэрэлд баярладаг” (Хосеа 6:6)

Хосеа 6:6-д “Би тахилаас илүүгээр хайр энэрэлд, шатаалт тахилаас илүүгээр Бурханыг мэдэх мэдлэгт баярладаг” гэж Их Эзэн Израилд хэлсэн байдаг. Христ дэлхийн тохинууллынхаа үед фарисайчуудын шүүмжлэлийн хариуд энэ шүлгийг хоёр удаа хэлжээ (Матай 9:13; 12:7). Энэ хоёр ишлэлийн эх бичвэрийг шалгасны дараа (Матай 9:10–13; 12:1–8), энэ шүлэг ямар утгатайг ярилц.

2. “Ай Израил, чи өөрийгөө устгалаа” (Хосеа 13:9)

Хосеагийн тохинууллын үед Умард Хаант Улсыг (Израил) ассиричууд довтолж, эцэстээ тэд хаант улсыг устган, хүмүүсийг нь боолчлолд оруулжээ. Яг хэрэг дээрээ бол, Израилыг устгасны төлөөх хариуцлага ассиричуудад ноогддог байв. Гэвч Их Эзэн, “Ай Израил, чи өөрийгөө устгалаа” (Хосеа 13:9) гэж хэлжээ.

- Ямар утгаар Израил өөрийгөө устгасан бэ? Тэд улс үндэстний хувьд устгагдсаны дараа авралын төлөөх Израилын цорын ганц найдвар юу байсан бэ? (Хосеа 13:9–10; 14:1-ийг үз) Есүс Христийг дагах нь биднийг цаг зуурын болон сүнсний устгалаас хэрхэн хамгаалж чадах вэ?

3. Наманчлал

“Наманчлал: Хэзээ ч хожимддоггүй” зургаан минутын видео бичлэг (*Family Home Evening Video Supplement 2* (53277)) байдаг бол, та үүнийг үзүүлж болно.

Бурхан Өөрийн Нууцуудыг Бошиглогчиддоо илчилдэг

Хичээл
35

Амос 3; 7–9; Иоел 2–3

Зорилго

Хожмын өдрүүдэд Их Эзэн өөрийн нууцуудыг бошиглогчиддоо илчилж, өөрийн Сүнсийг бүх хүмүүс дээр юүлж байгааг ангийн гишүүдэд заах.

Бэлтгэл

1. Дараах судруудыг залбирч, судал:
 - а. Амос 3:6–7. Их Эзэн өөрийн нууцуудыг өөрийн үйлчлэгчид бошиглогчдод илчилдгийг Амос заадаг.
 - б. Амос 7:10–17; 8:11–13; 9:8–15. Амос бошиглогч байхаар Бурханаас дуудагдав (7:10–15). Израилын боолчлол болон тараагдалтын тухай тэрээр бошиглов (7:16–17; 9:8–10). Их Эзэний үгийг сонсохын төлөө өлсгөлөн байх болно хэмээн тэрээр бошиглов (8:11–13). Эцсийн өдрүүдэд Израил агуу хийгээд цэцэглэн хөгжсөн хүмүүс болж үндэслэгдэх болно хэмээн тэрбээр бошигложээ (9:11–15).
 - в. Иоел 2; 3:16–17. Эцсийн өдрүүдийн дайнууд хийгээд сүйрлүүдийг Иоел бошиглов (2:1–11). Тэрээр хүмүүсийг наманчлахад дуудав (2:12–14; Шүлэг 13, 14-ийн Иосеф Смитийн Орчуулга Их Эзэн биш, харин хүмүүс наманчлах ёстой байсныг тайлбарладаг). Бурхан эцсийн өдрүүдэд өөрийн хүмүүсийг адисалж, тэдэн дээр өөрийн Сүнсийг юүлэх болно хэмээн Иоел бошиглож байв (2:15–32; 3:16–17).
2. Нэмэлт уншлага: Иосеф Смит—Түүх 1:41; Сургаал ба Гэрээ 1:14–28, 37–38.
3. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх хоёр дахь үйл ажиллагааг ашиглах бол, уг дууллыг хөгжмөөр ая хамтран тоглохыг зохион байгуулж болно. Бошиглогчийн саяхны зарим зөвлөгөөг товч хуваалцахад та ангийн нэг гишүүнийг урьж бас болно.
4. Боломжтой бол амьд бошиглогчийн нэг зураг олж ав.

Энэ хичээлийг заах зөвлөмж

Анхаарал
төвлөрүүлэх
үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагаануудын аль нэгийг (эсвэл өөрийнхөө үйл ажиллагаануудын нэгийг) ашиглахыг хүсч болно. Ангийн хувьд хамгийн тохиромжтой үйл ажиллагааг сонгож ав.

1. Дараах түүхийг ангийн гишүүдтэй хуваалц:

“Намайг залуу эхнэр болон эх байх үед нөхөр маань агаарын цэргийн хүчинд хоёр жилийг өнгөрөөсөн юм. Бид Нью-Йоркийн Лонг Айланд дахь цэргийн байранд амьдардаг байлаа. Бага насны хүүхдүүдээ харахдаа би улс орны өнцөг булан бүрээс ирсэн хөршүүдтэйгээ олонтаа уулзаж, учирдаг байв. Нэг өдөр би хөрштэйгөө өөрсдийнхөө итгэлийн тухай ярилцаж байтал, тэрээр Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм ямар ялгаатайг ихэд сонирхов.

“Би Сэргээлтийн тухай түүнд товч ярьж, мөн Есүс Христийн сэргээгдсэн Сүмд өнөөдөр амьд бошиглогч байдгийг тайлбарлав. Энэ нь үнэхээр түүний анхаарлыг татаж, тэгээд тэрээр бошиглогч юу гэж хэлснийг мэдмээр байна гэв. Намайг түүнд Сургаал ба Гэрээ болон орчин үеийн илчлэлтийн тухай ярихад тэрээр, ‘Тэвч тэр хамгийн сүүлд юу гэж хэлсэн юм бэ?’ гэж асуув. Би түүнд ерөнхий чуулганы тухай бас бошиглогчийн захиасыг нийтэлдэг сар тутмын хэвлэлийн тухай ярилаа. Тэгэхэд тэр ихэд сонирхож байлаа. Би тухайн үед гарсан захиасыг уншаагүйдээ ихэд ичиж билээ. ‘Та амьд бошиглогчтой хэрнээ түүний юу хэлснийг мэдэхгүй байна гэсэн үг үү?’ гэж тэрээр хэлснээр бидний яриа өндөрлөв.” (Жаннет Хейлс Бекман, “Sustaining the Living Prophets,” *Ensign*, 1996 оны 5-р сар, 84)

- Хэрэв хэн нэгэн, амьд бошиглогч саяхан юу гэж хэлсэн бэ гэж танаас асуувал, та энэ асуултад хариулж чадах уу?

Энэ хичээл амьд бошиглогчийг сонсож, дагахын ач холбогдлыг онцлон тэмдэглэдгийг тайлбарла.

2. “Бурхан Минь Бошиглогч Илгээсэн Танд Талархъя” (*Сүмийн Дуулал ба Хүүхдийн Дуу*, д. 36) Амьд бошиглогчийн зөвлөгөөг судлах нь бидний хувьд чухал ач холбогдолтойг тайлбарла. Түүний саяхан өгсөн зарим зөвлөгөөг хуваалцахад ангийн гишүүдийг урь эсвэл бошиглогчийн саяхан өгсөн зарим зөвлөгөөг товч нэгтгэн дүгнэж яриулахаар даалгавар авсан ангийн нэг гишүүнийг урь.

Судрын ярилцлага
ба хэрэглээ

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагауудаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

Амос бол Иерусалимаас өмнө зүгт орших жижигхэн хот Текоад хоньчин байжээ. Тэрээр МЭӨ 800-гаас 750 оны үед Израилын хаант улсын хүмүүст тохинуулж байв. Эдгээр хүмүүсийн ихэнх нь урвасан ажээ. Тэд эд баялагт дурлаж, ядуусыг дарлан, бүр өлсгөлөн хийгээд өвчин тахал ч тэднийг даруусгаж чадахгүй болглоо хатуурсан байлаа. Амос хүмүүстэй тэдний нүглүүдтэй тийн тулгарч, тэрээр бүр илүү аймшигтай шийтгэлүүдийг бошиглов. Гэсэн хэдий ч, тэрээр “Та нар амьдрахын тулд ЭЗЭНийг хай” (Амос 5:6) хэмээн ухуулж, наманчлах хэнийг ч гэсэн Бурхан ариусгахыг хүсдэгийг онцгойлон тэмдэглэдэг байв. Амос бас хожмын өдрүүдийн тухай бошиглодог байжээ.

Бошиглогч Иоел Иудейн хаант улсын хүмүүст тохинуулдаг байжээ. Тэрээр хэдийд амьдарч байсныг бид яг тодорхой мэдэхгүй, гэвч түүний бошиглолууд бидэнд онцгой чухал ач холбогдолтой, яагаад гэвэл тэдгээрээс олон нь хожмын өдрүүдтэй холбоотой юм. Хожмын өдрүүдэд их цэрэг болон Бурханы шүүлтүүдийн авчрах сүйрлийг бэлэгдэн харуулахын тулд цөлмөн хоослогч үй түмэн царцааны асар хүчтэй дүрслэлийг Иоел ашиглажээ. Иоел Их Эзэн “[Өөрийнхөө] Сүнснийг бүх хүн төрөлхтөн дээр цутгахыг” угтан харж, хожмын өдрүүд дэх агуу адислалуудыг бас бошиглосон ажээ (Иоел 2:28).

1. Их Эзэн өөрийн нууцуудыг өөрийн үйлчлэгчид бошиглогчдод илчилдгийг Амос заадаг.

Амос 3:6–7-г зааж, ярилц.

- Манай өнөө үед бид Бурханы үгийг хэрхэн сонсдог вэ? Бошиглогчдын ач холбогдлын талаар Амос юу заадаг байсан бэ? (Амос 3:7) Амос 3:6–7-гийн Иосеф Смитийн Орчуулгад ямар хоёр үг өөрчлөгдсөн бэ? Эдгээр өөрчлөлтүүд хэсгийн утгыг хэрхэн тодосгодог вэ? Иосеф Смитийн Орчуулга нь өөрөө, бидний ашиг тусын тулд бошиглогчид мэдүүлэгдсэн Их Эзэний нууцуудын нэг жишээ мөн гэдгийг тэмдэглэн хэл.
- Бошиглогчдын захиаст бид хүндэтгэлтэй хандах ёстой талаар Сургаал ба Гэрээ 1:37–38 юу заадаг вэ? (Амьд бошиглогчийн зургийг үзүүл) Сургаал ба Гэрээ 21:4–5-д цэдэглэснээр, Сүм зохион байгуулагдсан өдөр Их Эзэн Гэгээнтнүүдэд ямар зөвлөгөө болон зарлиг өгсөн бэ? Хэрэв Гэгээнтнүүд үүнийг биелүүлэх ном бол тэрээр ямар адислалууд амласан бэ? (С ба Г 21:6-г үз) Та нар бошиглогчдын зөвлөгөөг дагаснаар амьдралд тань энэ амлалт хэрхэн биелэгдсэнийг харсан бэ?

2. Эртний болоод хожмын үеийн Израилын тухай Амос бошиглов.

Амос 7:10–17; 8:11–13; 9:8–15-г зааж, ярилц.

- Израилын хаант улс дахь санваартан Амазия яагаад энэ нутгийг орхин явахыг Амосаас хүссэн бэ? (Амос 7:10–17-г үз. Хилэнц уг хүмүүс дээр болон тэдний хаан дээр ирэхийг Амос бошиглосон ажээ. Амазия болон түүний хүмүүс өөрсдийн хилэнцэт үйлсийн тухай үнэнийг сонсохыг хүсэхгүй байв.) Шүлэг 14–17 бошиглогч Амосын тухай бидэнд юу заадаг вэ? (Тэр зарчимч шударга, эрэлхэг зоригтой байв. Их Эзэн өөрт нь хэлснийг тэрээр өөрчлөхийг хүссэнгүй, харин хэрэв тэд наманчлахгүй бол хилэнц тэдэн дээр ирэх болно гэж бошиглохоо үргэжлүүлсээр байв.)
- Цаг хугацааны бүх үед, яагаад өдий олон хүмүүс бошиглогчдын захиасыг эсэргүүцэх буюу үл тоомсорлосоор ирсэн ном бэ? Хэрэв Израил бошиглогчдын зөвлөгөөг эсэргүүцээгүй бол Амосын бошиглолын үр дүн юу байх байсан бэ? (Амос 8:11–13. Сүнсний өлсгөлөн, эсвэл урвалт үр дүн нь байв.) Хэрэв бид бошиглогчдын зөвлөгөөг эсэргүүцвэл бидний нэг бүрийн хувьд үр дүн нь юу байх вэ?

Сүнсний өлсгөлөнгийн тухай Амосын бошиглол Хуучин Гэрээний сүүлчийн бошиглогч Малахийн үеийн дараа Израилын хүүхдүүдийн дунд гүйцэлдсэн ном. Есүс Христэд зориулж зам бэлтгэхээр Иохан Баптист дуудагдсанаас хойш ойролцоогоор 400 жилийн дараа энэ үе төгсгөл болсон юм. Амосын бошиглол нь түүнчлэн Аврагчийн Төлөөлөгчид егүүтгэгдсэний дараа үргэлжилсэн сүнсний харанхуйн олон зуун жил—Их Урвалтад бас холбогддог бөгөөд Бошиглогч Иосеф Смитээр дамжсан сайн мэдээний сэргээлтээр төгсгөл болсон билээ.

- Их Эзэний үг байхгүй байх нь ямар талаараа өлсгөлөнтэй зүйрлэгдэж болох вэ? Өнөөдөр хүмүүс Их Эзэний үгийг эрэн “далайгаас далайд” тэнүүчилж яваагийн ямар нотолгоог та нар хардаг вэ? Сэргээгдсэн сайн мэдээний адислалуудтай байх нь найртай хэрхэн зүйрлэгдэж болох вэ?

- Найдварын ямар захиасыг Амосын ном агуулдаг вэ? (Амос 9:8–15-ыг үз. Израилын хүүхдүүд бүрмөсөн устгагдахгүй, тэд бүх үндэстнүүдийн дунд тараагдах болно, тэгээд тэд эцсийн өдрүүдэд агуу хийгээд цэцэглэн хөгжсөн хүмүүс болж дахин үндэслэгдэн байгуулагдах болно. Шүлэг 9-ийн төгсгөлд, тэрээр Израилын удмын гишүүн бүрийн төлөө санаа тавьдгаа Их Эзэн тодорхой харуулсан байдаг.)

3. Бурхан өөрийн хүмүүсийг хожмын өдрүүдэд адисалж, өөрийн Сүнснийг тэдэн дээр цутгах болно гэдгийг Иоел бошигложээ.

Иоел 2; 3:16–17-г зааж, ярилц.

Хоёр дахь Ирэлтийн өмнө тохиох хожмын өдрүүдийн зарим үйл явдлуудыг бошиглогч Иоел дүрсэлжээ. Хүмүүсийн ёс бусын улмаас агуу устгалд хүргэх их цэргийн аяныг тэрээр дүрсэлсэн байдаг (Иоел 2:1–11). Наманчлах болоод Их Эзэнд эргэхэд тэрээр Израилыг уриалан дуудаж, Бурхан тэдний дунд байх болно гэдгийг амлаж, Израилын эцсийн агуу их ялалт хийгээд гэтэлгэлийг дүрсэлжээ (Иоел 2:12–32).

- *Иоел 2:12–32, Иоел 3:16–17* гэж самбар дээр бич. Эдгээр хэсгүүдийг нэгтгэн дүгнэж, дараах асуултын хариултуудыг хайхыг ангийн гишүүдээс хүс: Хожмын өдрүүдэд амьдрах хүмүүст Их Эзэн ямар урилгууд өгсөн бэ?

Урилгууд гэдэг үгийг самбар дээр бич. Ангийн гишүүд өгүүлбэрүүд хэлэх хооронд урилга тус бүрийн түлхүүр үгсийг самбар дээр бич. Эдгээр өгүүлбэрүүдийг судрууддаа тэмдэглэхэд нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж. Дурдаж болох зарим урилгуудыг доор өгөв:

Урилгууд

- а. “Та нар бүх зүрхээрээ над уруу эргэгтүн” (Иоел2:12)
 - б. “Зүрх сэтгэлээ тастан урагтун” (Иоел 2:13, зүрх сэтгэлээ тастан ураг гэдэг нь даруу байх гэсэн утгатай)
 - в. “Өөрсдийн Бурхан ЭЗЭН уруу эргэгтүн” (Иоел 2:13)
 - г. “Цуглааныг ариусга” (Иоел 2:16)
 - д. “Газар аа, бүү айгтун, хөгжин, баясагтун” (Иоел 2:21)
- Их Эзэнд бид бүх зүрх сэтгэлээрээ эргэхийн ач холбогдлын талаар эдгээр урилгууд юу өгүүлж байна вэ? Бид Их Эзэний амласан адислалуудад зохистой байхын төлөө өөрсдийгөө ариусгахын тулд юу хийж болох вэ?
 - Дараах асуултанд хариултууд эрж, Иоел 2:12–32, Иоел 3:16–17 дахин нэгтгэн дүгнэхийг ангийн гишүүдээс хүс: Хожмын өдрүүдэд өөрийг нь дагасан хүмүүст Их Эзэн ямар адислалууд амласан бэ?

Адислалууд гэдэг үгийг самбар дээр бич. Ангийн гишүүд өгүүлбэрүүд хэлэх үед, адислал бүрийн түлхүүр үгсийг самбар дээр бич. Ангийн гишүүд бас эдгээр өгүүлбэрүүдийг судрууд дээрээ тэмдэглэж болно. Дурдаж болох зарим адислалуудыг доор өгөв:

Адислалууд

- а. “Их Эзэн энэрэлтэй, нигүүлсэнгүй, уурлахдаа удаан, агуу нинжин сэтгэлтэй бөгөөд тэрбээр хилэнцийг та нараас зайлуулах болно.” (Иосеф Смитийн Орчуулга, Иоел 2:13)
- б. ЭЗЭН “өөрийн ард түмнийг өрөвдөх болно” (Иоел 2:18)

- в. ЭЗЭН хойд зүгийн цэргийг (шүлэг 1–11-д дүрслэгдсэн) хатсан зэлүүд газар уруу шахна (Иоел 2:20).
- г. “Та нар идэх юмаар хангалуун, цатгалан байх болно” (Иоел 2:26)
- д. “Би Израилын дунд байна, . . . мөн миний ард түмэн хэзээ ч ичгүүрт унахгүй” (Иоел 2:27)
- е. “Би өөрийн Сүнсийг бүх хүн төрөлхтөнд цутгана” (Иоел 2:28; мөн түүнчлэн шүлэг 29-ийг үз)
- ё. Залуус, хөгшид бошиглон, зүүд зүүдэлж, үзэгдлүүд үзнэ (Иоел 2:28).
- ж. “ЭЗЭНий нэрийг дуудагч хэн боловч аврагдах болно” (Иоел 2:32)
- з. “ЭЗЭН Сионоос хүрхэрч, Иерусалимаас дуугаа гаргах болно” (Иоел 3:16)
- и. “ЭЗЭН бол ард түмнийхээ найдвар байх болно” (Иоел 3:16)
- й. “ЭЗЭН . . . Израилын хүүхдүүдийн хүч чадал байх болно” (Иоел 3:16)
- к. “Тэгэхэд та нар намайг Сионд оршигч өөрийнхөө ЭЗЭН Бурхан гэдгийг мэдэх болно” (3:17)
- Эдгээр адислалууд өөрийн гэрээт хүмүүсийн талаарх Их Эзэний шийдвэр төгс байдлын тухай, өөрийн Гэгээнтнүүдийн талаарх түүний хүчний тухай, эцсийн өдрүүд дэх бидний боломжуудын тухай юу заадаг вэ?
 - Хожмын өдрүүдэд Их Эзэн өөрийн Сүнсийг бүх хүмүүс дээр цутгах болно (Иоел 2:28–29) гэсэн Иоелын мэдэгдэл Амосын дүрсэлсэн өлсгөлөнтэй эрс эсрэг тэсрэг юм (Амос 8:11–12). Тэнгэр элч Моронай Иоелын бошиглолыг Иосеф Смитэд иш татаж, энэ нь хараахан гүйцэлдээгүй ч гэсэн удахгүй гүйцэлдэх болно гэж түүнд хэлжээ (Иосеф Смит—Түүх 1:41). Залуус хийгээд насанд хүрэгчдийн амьдрал дахь энэхүү цутгалтын ямар жишээнүүдийг та нар өнөөдөр харж байна вэ?

Дүгнэлт

Олон бошиглол гүйцэлдэж байгаа, амьд бошиглогчийн удирдамж бидэнд байгаа хожмын өдрүүдэд амьдарна гэдэг нь агуу адислал болохыг онцлон тэмдэглэ. Амьд бошиглогчийн үгсийг залбиран судалж, түүний зөвлөгөөг амьдралдаа хэрэглэхэд нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

Нэмэлт заах санаанууд

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

1. Сионд тайван байгчид

- “Сионд тайван” байхыг Амос хүмүүст сэрэмжлүүлж байв (Амос 6:1). Сионд тайван байх гэдэг нь юу гэсэн үг вэ? (2 Нифай 28:19–24, 27, 29–30-ийг үз) Өнөөдөр бид ямар байдлаар Сионд тайван байж болох вэ? Үүнийг бид хэрхэн хамгаалж чадах вэ?

2. “Би өөрийн Сүнсийг бүх хүн төрөлхтөнд цутгана” (Иоел 2:28)

- Орчин үеийн аялал болон харилцаа холбооны бүх шинэ бүтээл сайн мэдээ сэргээгдсэнээс хойш гарсан юм. Эдгээр хөгжлүүд Иоел 2:28–29 дахь Иоелын бошиглол гүйцэлдэхэд хэрхэн тусалдаг вэ? Эдгээр хөгжлүүд манай өнөө үед Их Эзэний ажлыг урагш ахиулахад хэрхэн тусалдаг вэ?

Их Эзэний ажлыг гүйцэтгэхэд эдгээр шинэ бүтээлүүд агуу ашиг тустайг ойлгоход нь ангийн гишүүдэд туслахын тулд та Ахлагч Иосеф Фиелдинг Смитийн дараах мэдэгдлийг уншиж болно:

“Хэрэв сайн мэдээний сэргээлт байгаагүй бол, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм зохион байгуулагдаагүй бол, радио бий болохгүй байсан; нисэх онгоц бий болохгүй байсан, мөн анагаах ухаан, хими, цахилгаан эрчим хүч болон дэлхий дэх бусад олон зүйлүүд эдгээр нээлтүүдийн ашиг тусыг үзэхгүй байсан гэдэгт би бат итгэдэг. Ийм нөхцөл байдал бүрдээгүй байсан бол эдгээр адислалууд хойш тавигдах байсан, учир нь эдгээр нь сайн мэдээний сэргээлт хийгээд Сүмийн зохион байгуулалтад гол суурь эзэлдэг, үүнээс Их Эзэний Сүнс дэлхий даяар цацардаг Цаг Хугацааны Бүрэн Байдлын Эрин Үед харьяалагддаг билээ. Их Эзэний бурханлиг нөлөө гадагш цацарч, тэд үүнийг мэдэхгүй байлаа ч гэсэн хүмүүний оюунд нөлөөлж, энэ нь Их Эзэнээр чиглүүлэгддэг билээ. Ийм байдлаар тэрээр тэднийг өөрийн үйлчлэлд оруулдаг, ингээд түүний зорилгууд болон түүний зөв шударга байдал зохих цагт дэлхий дээр гаргуун болж болно.

“... Эдгээр нээлтүүд нэгэн цаг үед тохиолдлоор гарч ирсэн гэдэгт, мөн өнөөгийн хүмүүс өнгөрсөн үеүдэд амьдарч байсан хүмүүсээс гаргуун оюун ухаантай учраас эдгээр нээлтүүд гарч ирсэн гэдэгт би итгэдэггүй. Цаг нь болсон учраас, Их Эзэн үүнийг хүссэн учраас, тэрчлэн тэрбээр өөрийн Сүнсийг бүх хүн төрөлхтөн дээр цутгасан учраас эдгээр нээлтүүд ирсэн бөгөөд бас ирж байгаа юм.” (Чуулганы илтгэлд, 1926 оны 10-р сар, 117)

Сионы алдар суу хамгаалалт байх болно

Хичээл
36

Исаиа 1–6

Зорилго Ариун газруудад зогссоноор дэлхийн хилэнцээс зайлхийхэд нь түүнчлэн Исаиагийн үйлчлэх хүслээс хүч чадал олж авахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмжиж, тэдэнд туслах.

Бэлтгэл 1. Энэ хичээлээр ярилцах Исаиа 1–6-гийн хэсгүүдийг залбирч судал.
2. Нэмэлт уншлага: 2 Нифай 11.

**Энэ хичээлийг
заах зөвлөмж**

Анхаарал
төвлөрүүлэх
үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагааг (эсвэл өөрийхөө нэг үйл ажиллагааг) ашиглахыг хүсч болно.

Их Эзэн нэг ижил санааг бүх судруудад олон удаа давтсан нь олонтаа тохиолддогийг тайлбарла. Дараах ишлэлүүдийг самбар дээр бичиж, эцсийн өдрүүдийн хүнд сорилтуудыг тэсэн гарахад Их Эзэний өгсөн ямар зөвлөгөө бидэнд туслахыг нээж олохыг ангийн гишүүдээс хүс:

Сургаал ба Гэрээ 45:32

Сургаал ба Гэрээ 87:8

Сургаал ба Гэрээ 101:22

“Ариун газруудад зогсогтун та нар, тэгээд бүү нүүлгэгд” гэж самбар дээр бич.

- Энэ өгүүлбэр ямар утгатай гэж та нар бодож байна вэ? (Хариултауд нь бүх цаг үед зохистой байх ариун газруудад байнга байх хүсэлтэй байх, ариун бус газруудад очихгүй байхаар сонгох, Бурхан таныг удирдах болно гэдэгт итгэлтэй байх түүнчлэн үнэн ба цэвэр ариун байдлын төлөө тэмцэх нь байж болно.)

Энэ хичээлээр, ариун газруудад зогсохыг Их Эзэн яагаад бидэнд зарлигладгийг мөн ариун газрууд гэж юу болохыг ангийн гишүүд мэдэх болно гэдгийг тайлбарла.

Судрын ярилцлага
ба хэрэглээ

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагауудаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

Аврагч Исаиагийн бошиглолуудыг судлахыг нифайчуудад зарлиглахдаа “Исаиагийн үгс агуу их” хэмээн тэрээр тунхаглажээ (3 Нифай 23:1). Шинэ Гэрээ, Мормоны Ном болон Сургаал ба Гэрээнд бусад аль ч бошиглогчийн үгсээр Исаиагийн бошиглолууд илүү ихээр иш татагдсан байдаг. Дэлхий дээрх Аврагчийн үүрэг зорилгын тухай, Израилын ёс бусыг дагалдах устгалын тухай түүнчлэн хожмын үеийн Израилын үүрэг зорилго хийгээд хувь тавилангийн тухай олон зүйлийг тэрээр бошигложээ.

1. Эцсийн өдрүүд дэх дэлхийн нөхцөлийг Исаиа дүрслэв.

- Исаиагийн олон сэрэмжлүүлэг хийгээд бошиглолууд нь ихэд ёс бус байсан түүний үе, манай үе хоёрын аль алинд нь хамаатай. Дараах судруудад дүрслэгдсэн үйл явдал өнөөдөр дэлхийд ямар байдалтай байна вэ? (Та ишлэлүүдийг самбар дээр бичиж, мөн тэдгээрийг ангийн гишүүдээр олуулж болно.)
 - а. Исаиа 1:3–5 (Их Эзэнийг эсэргүүцсэн нь)
 - б. Исаиа 1:11–15 (Утга учиргүй буюу итгэл бишрэлгүй шашны ёслолууд)
 - в. Исаиа 2:7–8 (Их Эзэний оронд дэлхийн зүйлүүд хийгээд цэргийн аюулгүй байдлыг шүтэн бишрэв; морьд болон сүйх тэрэгнүүд эрт дээр үед дайны зэвсгүүд болон хэрэглэгддэг байсныг анхаар)
 - г. Исаиа 2:11–12 (Бардам зан)
 - д. Исаиа 3:5 (Бусад хүмүүсийг дарлаж, бусад хүмүүсийг хүндэтгэхгүй байх)
 - е. Исаиа 3:9 (Нүглийнхээ төлөө ичихгүй байх)
 - ё. Исаиа 3:14–15 (Ядуусаас давамгай байдалтай болж, тэдний төлөө анхаарал халамж тавихгүй байх)
 - ж. Исаиа 3:16–24 (Зөв шударгын болон сайн зан төлвийн үнэ цэнээр гадаад төрх байдлын гоё сайхныг онцлон анхаарах)
 - з. Исаиа 5:8 (Улам улам их материаллаг зүйлүүдийг эзэмших шунал хүсэл)
 - и. Исаиа 5:11–12 (Их Эзэн болон түүний ажлыг эрэлхийлэхийн оронд дэлхийн таашаалуудыг байнга эрэлхийлэх)
 - й. Исаиа 5:20 (Хилэнцэт зүйлүүдийг сайн, сайн зүйлүүдийг хилэнцэт гэж нэрлэх)
 - к. Исаиа 5:21 (Бурханд итгэхийн оронд өөртөө итгэх)
 - л. Исаиа 5:24 (Бурханы зарлигууд болон үгийг үл тоомсорлох)
- Эдгээр бошиглолууд өнөөдөр хэрхэн гүйцэлдэж байна вэ? (Эдгээр бошиглолуудын заримыг нь дэлгэрүүлэн ярилцахын тулд нэмэлт заах санааг үз)

2. Ариун газруудад зогсохыг Исаиа итгэлтнүүдэд зөвлөдөг байв.

- Ямар газрууд Исаиагийн дурдсан дэлхийн нөхцөлүүдийн хувьд аюулгүй байдлыг санал болгодог вэ? Исаиа 4:5–6-д дурдагдсан гурван ариун газар юу вэ?
 - а. Сион ууланд орших газар бүр (гэр орон)
 - б. Цуглааны газрууд (гадсууд, хэсгүүд түүнчлэн салбарууд; мөн түүнчлэн С ба Г 115:5–6-г үз)
 - в. Асар (ариун сүмүүд)
- Гэр орон хэрхэн дэлхийн ёс бусаас хоргодох ариун газар байж чадах вэ? Гадас, хэсэг, салбарууд хэрхэн ариун газар, мөн хоргодох газар байж чадах вэ? Ариун сүм хэрхэн ариун газар бас хоргодох газар байж чадах вэ? Эдгээр гурван ариун газар дэлхийн хилэнцүүдээс та нарыг хамгаалахад хэрхэн тусалсан бэ?

Та *Ариун Газруудад Зогсох* гэсэн үгсийг самбар дээр бичээд доор нь 1. *Гэр орон*; 2. *Гадас, хэсэг, салбарууд*; 3. *Ариун сүмүүд* гэж бич. Гарчиг бүрийн дор ангийн гишүүдийн тайлбаруудыг жагсаан бич.

- Эдгээр ариун газрууд биднийг хэрхэн хамгаалдгийг дүрслэхийн тулд ямар илэрхийллүүд Исаиа 4:5–6-д хэрэглэгдсэн байна вэ?
 - а. “Өдрийн аагим халуунаас хамгаалах сүүдэр”
 - б. “Хоргодох газар”
 - в. “Шуурга, борооноос [нуугдах буюу толгой хоргодох газар] хамгаалах хоргодох газар”
- Исаиагийн бичээсүүдээс олон нь Мормоны Номонд оржээ. Исаиа 4:5-д ямар үгс нэмэгдсэнийг олж мэдэхийн тулд 2 Нифай 14:5-ыг ангийн гишүүдээр уншуул. (*Сионы тухай үгс нэмэгдсэн байна*) Энэ шүлгийг ойлгох бидний ойлголтод эдгээр үгс юу нэмдэг вэ?
- Эцсийн өдрүүд дэх ариун сүмүүдийн тухай ямар бошиглол Исаиа 2:2–3-т байдаг вэ? (Их Эзэний өргөө болох ариун сүмд олон хүмүүс ирж, Бурханы зарлигуудыг мэдэж, түүний замуудаар алхахыг хүсэх болно.) Исаиа яагаад ариун сүмийг “Их Эзэний уул” гэж дүрсэлсэн гэж та нар боддог вэ? (Их Эзэнтэй харилцаж, түүнээс зөвлөгөө хүлээн авахын тулд эртний бошиглогчид уулс уруу олонтаа очдог байжээ. Тэнд Тэрбээр юмсыг тэдэнд илчилдэг байв. Өнөөдөр бид ариун сүмд үүнтэй адил туршлагатай байж болно.)

3. Хожмын өдрүүд дэх Израилын цугларалтыг Исаиа дүрслэв.

Исаиа 5:26–29-т Исаиа хожмын үеийн Израилын цугларалтыг дүрсэлдэг. Өргөгдөж байгаа туг бол Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм юм. “Исгэрэх” гэдэг нь шивнэх буюу зарлах гэсэн утгатай бөгөөд дэлхийн үндэстнүүдийг Сүмд цугларах урилгыг төлөөлдөг. Энэ цугларалт шуурхай бөгөөд хүчтэй байх болно.

- Үндэстнүүд Сүмд цугларах тухай бошиглол өнөөдөр хэрхэн гүйцэлдэж байна вэ? (Сайн мэдээг зааж, хүмүүсийг үнэнд цуглуулахын тулд номлогчид дэлхий даяар явж байна.) Энэ бошиглолыг гүйцэлдүүлэхэд туслахын тулд бидний хүн нэг бүр юу хийж чадах вэ?

4. Бошиглогч байх өөрийн дуудлагад Исаиа хүсэлтэйгээр хариулав.

Исаиа Их Эзэнийг алдар суунд нь харсан үзэгдлээр дамжуулан Их Эзэн Исаиаг бошиглогч болгохоор дуудсан билээ. Энэ үзэгдэл Исаиа 6-д цэдэглэгдсэн байдаг.

- Их Эзэний алдар сууг Исаиа хэрхэн дүрсэлсэн бэ? (Исаиа 6:1–4-ийг үз) Исаиа Их Эзэнийг хараад хэрхэн хариулсан бэ? (Исаиа 6:5-ыг үз. Их Эзэний оршихуйд байх нь Исаиад эвгүй байв) Исаиа түүний өмнө цэвэр ариун байсныг Их Эзэн бэлэгдлээр хэрхэн харуулсан бэ? (Исаиа 6:6–7-г үз) Их Эзэн түүнийг бошиглогч болгохоор дуудахад Исаиа хэрхэн хариулсан бэ? (Исаиа 6:8-ыг үз)
- Исаиа өөрийн дуудлагыг хүлээж авах үед, өөрийн хүүхдүүдийн авралд зориулсан Тэнгэр дэх бидний Эцэгийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэг хариуцлагыг Аврагч хүлээж авах үед Тэрээр хэлсэн яг тэр үгсийг ашигласан ажээ (Абрахам 3:27). Бид бас ийм үгсээр Их Эзэнд хариулах хэрэгтэй зарим нөхцөл байдлууд юу вэ? (Хариултууд нь бид номлолд үйлчлэхээр дуудагдах, Сүмд үйлчлэхийг биднээс хүсэх, хүнд сорилтуудыг тэвчихийг биднээс хүсэх тохиолдлууд байж болно.)

- Исаиагийн олон бүлэг, түүний дотор бүлэг 2-6 нь Мормоны Номонд цэдэглэгдсэн байдаг. Исаиагийн бичээсүүдийг өөрийн цэдэгт оруулснаа Нифай ямар учир үндэслэлүүдээр тайлбарласан бэ? (2 Нифай 11:8-ыг үз)
- Исаиагийн эдгээр бүлгүүдийн ямар захиасууд таныг баярлуулдаг вэ? Эдгээр бүлгүүдийн ямар захиасуудыг өөртэйгөө адилтгах нь хамгийн чухал гэж та боддог вэ?

Дүгнэлт

Исаиагийн үгс хожмын өдрүүдийн тухай олон зүйлийг бидэнд заадаг. Бид Исаиагийн зөвлөгөөг судалснаар ариун газруудад хэрхэн зогсох хийгээд дэлхийн хилэнцүүдээс хэрхэн зайлсхийхийг мэдэж чадна. Түүний жишээг дагаснаар бид Тэнгэр дэх Эцэгийнхээ илүү хүсэл эрмэлзэлтэй үйлчлэгчид байж чадна.

Нэмэлт заах санаанууд

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та үүнийг хичээлийнхээ нэг хэсэг болгон ашиглаж болно.

Исаиа 1–6 дахь Исаиагийн бошиглолуудыг дэлгэрүүлэн ярилцах нь

Өөрсдийн машны зан үйлүүдийг Их Эзэнд хүлээн авагдахуйц болгох нь

- Исаиа 1:11, 16–17-д өгүүлснээр, израилчуудын золиослолууд яагаад Их Эзэнд хүлээн авагдахуйц байгаагүй вэ? (Хэдийгээр израилчууд гаднах байдлаараа сүсэг бишрэлтэй байхыг хичээдэг байсан ч, тэдний зүрх сэтгэл Бурханаас хол байлаа. Мөн түүнчлэн Матай 5:23–24; Моронай 7:6–9-ийг үз) Яагаад зарим хүмүүс зүрх сэтгэл нь Бурханаас хол байхад гаднах байдлаараа сүсэг бишрэлтэй мэт байхыг хичээдэг вэ? Хоёр нүүр гаргахын энэ төрөл яагаад Бурханыг гомдоодог вэ?

Уучлалын адислалууд

- Наманчилдаг хүмүүсийг Их Эзэн хэрхэн төгс уучилдгийг ойлгоход бидэнд туслах хоёр сайхан дүрслэлээр Исаиа хангадаг. “Та нарын нүглүүд час улаан мэт боловч, цас шиг цагаан болно; тэдгээр нь хүрэн улаан боловч, ноос шиг болох болно” (Исаиа 1:18) Бид нүгэл үйлдэж, Их Эзэнээс холдсон гэж бодогдох үед эдгээр дүрслэлүүд бидэнд хэрхэн тусалж чадах вэ? (Мөн С ба Г 58:42-ыг үз)

Гаднах төрхөөрөө дэлхийн шинж чанараас зайлсхийх нь

- Исаиа 3:16–24 дэх бошиглол нь өнөөгийн Сүмийн гишүүд, “эрэгтэйчүүд мөн түүнчлэн эмэгтэйчүүдэд хамаатай” гэж Ахлагч Иосеф Фиелдинг Смит хэлжээ (*Answers to Gospel Questions*, эмхтгэсэн. Joseph Fielding Smith Jr., 5 боть. [1957–66], 5:174). Бидний хувцасны маяг бидний сүнсний сайн сайхан байдлыг хэрхэн тусгадаг буюу үүнд хэрхэн нөлөөлдөг вэ? Даруу хувцаслах гэдэг нь юу гэсэн үг вэ? Хувцас болон гадаад байдалдаа хэт их санаа тавихын аюул юу вэ? (Алма 31:27–28-ыг үз) Гаднах төрхөөрөө дэлхийн шинж чанараас зайлсхийхийг бид хүүхдүүддээ хэрхэн зааж болох вэ?

Мууг сайн, сайныг муу гэж нэрлэх нь

- Сайн ба мууг ялган таних израилчуудын чадвар яагаад муудсан бэ? (Исаиа 5:20-ийг үз) Өнөөдөр хүмүүс ямар байдлаар сайныг муу, мууг сайн гэж нэрлэдэг вэ? Сайн ба муугийн ялгааг баттай танин мэдэхийн тулд бид юу хийж болох вэ? (2 Нифай 32:5; С ба Г 45:57-г үз)

“Өөрийнхөө нүдэнд мэргэн”

- “Өөрийнхөө нүдэнд мэргэн, мөн өөрсдийнхөө бодолд ухаалаг” байхгүйг Исаиа хүмүүст сэрэмжлүүлсэн нь ямар утгатай вэ? (Исаиа 5:21) Энэ асуудал юунд хүргэдэг вэ? Яагаад энэ нь аюултай вэ? Үүнээс бид яаж хамгаалж болох вэ?

“Түүний мутар сунгаастай хэвээр байна”

- Исаиа 5:25, 9:12, 9:17, 9:21, түүнчлэн 10:4-т Исаиа ямар захиасыг онцгойлон авч үзсэн бэ? Энэ захиас яагаад чухал вэ? Энэ захиасын үнэнийг та нар хэрхэн мэдсэн бэ?

Зорилго Түүний гүйцэтгэсэн гайхамшигт зарим зүйлүүдийг танин мэдэх замаар Христэд ирэхэд нь ангийн гишүүдэд туслах.

Бэлтгэл Дараах судруудыг залбирч судал:

- а. Исаиа 22:22. Аврагч Тэнгэрлэг Эцэгийн оршихуйд хаалгуудыг нээдэг.
- б. Исаиа 24:21–22. Аврагч сүнсний шорон дахь хүмүүст нигүүлсэл үзүүлдэг.
- в. Исаиа 25:1–4; 32:1–2. Аврагч бол хүч чадал хийгээд хоргодох байр.
- г. Исаиа 25:6–9. Аврагч найрыг бэлтгэж, “хөшгийг” устгах болно
- д. Исаиа 25:8. Аврагч бидний нулимсыг арчина.
- е. Исаиа 26:19. Аврагч Амилуулалтыг тохиолгон авчрах болно.
- ё. Исаиа 28:16. Аврагч бол бидний бат бөх суурь.
- ж. Исаиа 29:4, 9–14, 18, 24. Аврагч сайн мэдээг дэлхийд сэргээх болно.
- з. Исаиа 30:19–21. Аврагч бидний сорилтуудыг мэддэг, бас бидний замыг чиглүүлдэг.

**Энэ хичээлийг
заах зөвлөмж**

Анхаарал
төвлөрүүлэх
үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагааг (эсвэл өөрийхөө нэг үйл ажиллагааг) ашиглахыг хүсч болно.

Өөрт чинь зориулж гайхамшигтай зүйл хийсэн гэр бүлийнхээ нэг гишүүн буюу найзынхаа тухай ангийн гишүүдэд ярь. Тэрний тулд гайхамшигтай зүйлүүдийг хийсэн хүмүүсийн тухай ярихад ангийн гишүүдийг урь. Тэдгээр хүмүүсийн талаарх бодлуудаа товч дүрслэн ярихыг тэднээс хүс. Энэ хичээл Аврагчийн хийсэн гайхамшигтай зүйлүүдээс заримыг нь онцлон авч үзэх болно гэдгийг тайлбарла.

Судрын ярилцлага
ба хэрэглээ

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

Бошиглогч Исаиа өөрийн заасан зүйлүүдийн ихээхэн хэсгийг бэлэгдлийн хэлээр илэрхийлснийг тайлбарла. Энэ хэл шууд заадаггүй, тиймээс тэдгээрийн заадаг үнэнүүдийг ойлгохдоо бид Исаиагийн үгсийг сайтар шүүж, тунгаан бодох ёстой.

Исаиагийн хамгийн сайхан, гарамгай бэлэгдлийн хэлний нэг хэсэг нь энэ хичээл анхаарал хандуулж буй Аврагчийн тухай юм. “Түүний нэрийг Гайхамшигт гэж дуудна” (Исаиа 9:6) гэсэн үгсийг та самбар дээр бичиж болно. Та Аврагчийн тухай дараах бошиглолуудыг ярилцахдаа тэдгээрийг нэг бүрчлэн самбар дээр хураангуйлан дүгнэ.

1. Аврагч Тэнгэрлэг Эцэгийн оршихуйд хаалгыг нээдэг.

Исаиа 22:22-ыг ярилц.

- Исаиа 22:22-т “Давидын өргөөний түлхүүр” Мессиад байдаг хэмээн өгүүлсэн байдаг. Энэ бол хэнийг ч гэсэн Тэнгэрлэг Эцэгийн оршихуйд оруулах буюу түүнээс гаргах хүч Аврагчид байдгийг өгүүлэх бэлэгдлийн хэлбэр юм. (Мөн түүнчлэн Илчлэлт 3:7–8; 2 Нифай 9:41-ийг үз) Аврагч энэ хаалгыг бидний төлөө нээхийн тулд юу хийсэн бэ? Үүнд орох боломжтой байхын тулд бид юу хийх ёстой вэ? (2 Нифай 9:45-ийг үз)

2. Аврагч сүнсний шорон дахь хүмүүст нигүүлсэл үзүүлэв.

Исаиа 24:21–22-ыг ярилц.

- Ямар шорон Исаиа 24:21–22-т дурдагдсан байдаг вэ? (Сүнсний шорон, нас барсан зарим мөнх бус хүмүүсийн сүнс Амилуулалт хүртэл хүлээдэг газар) Нас барсан зарим мөнх бус хүмүүсийн сүнс яагаад сүнсний шоронд байдаг вэ? (С ба Г 138:32-ыг үз. Тэдний зарим нь дэлхий дээр байхдаа сайн мэдээг хүлээж аваагүй, бусад нь өөрсдийн гэрчлэлд хүчтэй байгаагүй ажээ.)
- Шорон дахь сүнснүүдийн төлөө Аврагч юу хийсэн бэ? (Исаиа 42:5–7; С ба Г 138:29–37-г үз. Тэрээр зөв шударга сүнснүүдийг зохион байгуулж, тэдэнд сайн мэдээг заажээ) Энэ нь Аврагчийн хайр, нигүүлслийг хэрхэн харуулсан бэ? (Исаиа 49:9–10-ыг үз)

3. Аврагч бол хүч чадал хийгээд хоргодох газар мөн.

Исаиа 25:1–4; 32:1–2-ыг ярилц.

- Шуурга, хуй салхи, цөл болон бидний амьдралын аагим халууны үед Аврагч биднийг хүчирхэгжүүлдэг тухай Исаиа бичжээ. Бидэнд ийм сорилтууд тулгарсан үед Аврагч бидэнд хэрхэн тусалдаг дараах дүрслэлүүд юу заадаг вэ?
 - а. Тэр бол шуурганаас хоргодох газар мөн (Исаиа 25:4).
 - б. Тэр бол аагим халуунаас хамгаалах сүүдэр мөн (Исаиа 25:4).
 - в. Тэр бол салхинаас нуугдах газар мөн (Исаиа 32:2).
 - г. Тэр бол хуй салхинаас хамгаалах халхавч мөн (Исаиа 32:2).
 - д. Тэр бол хуурай газар дахь усны суваг мөн (Исаиа 32:2).
 - е. Тэр бол ангасан газар дахь том хадны сүүдэр юм (Исаиа 32:2).

4. Аврагч найрт бэлтгэж, “хөшгийг” устгах болно.

Исаиа 25:6–9-ийг ярилц.

- Исаиа 25:6–7-гийн нэг тайлбар бол, уул нь ариун сүмийн бэлэгдэл юм (мөн Исаиа 2:2; С ба Г 58:8–9-ийг үз). Исаиа 25:6-д дурдагддаг найр юу вэ? (Христийн үгс болон заадаг зүйлүүдийн найр) Ариун сүмд орох нь хэрхэн найртай адил байж болох вэ?
- Гивлүүр бол нимгэхэн бүтээлэг. Бэлэгдлээр энэ нь Христэд үнэнээр ирэхээс хүмүүсийг холдуулан зайлуулдаг итгэл бишрэлгүй байдлыг төлөөлдөг (Моше 7:26). Дэлхий дээгүүрх “гивлүүр” хэрхэн устгагдах вэ? (Исаиа 25:7–9-ийг үз)

5. Аврагч бидний нулимсыг арчина.

Исаиа 25:8-ыг ярилц.

- Өөрийн чинь хайртай хүн уйлж байвал та яах вэ? Их Эзэн “[бидний] нулимсыг” яаж арчдаг вэ? (Хүүхдийн нүүрнээс нулимсыг нь арчиж байгаа эцэг эхийг дүрслэн зураглахыг ангийн гишүүдэд санал болго. Энэ үйлдэлд нэн ойр дотно харьцааны мэдрэмж байх учиртай. Энэ бол зөвхөн бие биенээ гүнээ хайрлаж, итгэдэг хүмүүсийн хуваалцдаг нэн ойр дотно харилцааны дохио тэмдэг мөн.)
- Илчлэлт 21:4-г дурдагддаг ямар нөхцөлүүд нулимс гаргахад хүргэдэг вэ? Эдгээр нөхцөлүүдээр урссан нулимсыг Их Эзэн хэрхэн арчих вэ?

6. Аврагч Амилуулалтыг тохиолгон авчрах болно.

Исаиа 26:19-ийг ярилц.

- Мессиа хэзээ ирэхийг, тэрээр хэзээ үхэж, мөн хэзээ амилагдахыг Исаиа бошигложээ (Исаиа 25:8). Өөр ямар хүмүүс бас амилуулагдах вэ? (Исаиа 26:19; 1 Коринт 15:20–22; Алма 11:43–44. Дэлхий дээр амьдарсан Бурханы бүх хүүхэд амилуулагдах болно) Амилуулагдсан үедээ бид ямар бодол санаатай байх тухайд Исаиа 26:19 юу өгүүлдэг вэ? (Мөн С ба Г 138:12–16, 50-ийг үз)

“Уг дуу хоолой нас барагсдыг босгохоор дуудсан үед, . . . зүрх сэтгэлийн минь анхны баяр хөөр ямар байх бол? Дэргэдээ байгаа аавтайгаа, ээжтэйгээ, ахтайгаа, эмэгтэй дүүтэйгээ уулзахад, би тэднийг, тэд намайг тэврэн авна” гэж Бошиглогч Иосеф Смит хэлжээ (*Teachings of the Prophet Joseph Smith*, эмхтгэсэн. Иосеф Фиелдинг Смит [1976], 295–96).

7. Аврагч бол бидний бат бөх суурь.

Исаиа 28:16-г ярилц.

- Түүнийг “туршигдсан хад” (Моше 7:53-ыг үз) гэж нэрлэснээр Исаиа Аврагчийн тухай бидэнд юу заадаг вэ? Есүс Христ хэрхэн бидний “бат бөх суурь” байдаг вэ? (Хиламан 5:12-ыг үз) Энэ суурин дээр барихын тулд бид юу хийж болох вэ? Хэрэв бид энэ суурин дээр барих юм бол Их Эзэн бидэнд юу амладаг вэ? (С ба Г 50:44-ийг үз)

8. Аврагч сайн мэдээг дэлхийд сэргээх болно.

Исаиа 29:4, 9–14, 18, 24-ийг ярилц.

- Сайн мэдээний хожмын үеийн сэргээлтийн тухай юуг Исаиа угтан харсан бэ? (Исаиа 29:4, 9–14-ийг үз. Сүнсний харанхуйн үед сайн мэдээ ирэхийг тэрээр угтан харсан билээ. Тэр бас Мормоны Ном ирэхийг угтан харжээ.)

Исаиа 29-ийн дараах шүлгүүдийг Мормоны Ном, Агуу Үнэт Сувд, Сургаал ба Гэрээн дэх холбогдох хэсгүүдтэй харьцуулж, Исаиагийн зарим бошиглолууд хэрхэн биелэгдсэнийг хар:

- | | |
|----------------------|---------------------------|
| а. Исаиа 29:4 | Моронай 10:27 |
| б. Исаиа 29:9–10, 13 | Иосеф Смит—Түүх 1:18–19 |
| в. Исаиа 29:11–12 | Иосеф Смит—Түүх 1:63–65 |
| г. Исаиа 29:14 | Сургаал ба Гэрээ 4:1; 6:1 |

- Уруулаараа Их Эзэнд ойр байдаг хэдий ч зүрх сэтгэлээрээ Түүнээс хол байдаг хүмүүсийн тухай Исаиа ярьдаг байв (Исаиа 29:13). Бодол санаа, үйл хэрэг, мөн түүнчлэн үг хэлээрээ бид Их Эзэнтэй хэрхэн ойр байж болох вэ?
- Мормоны Ном сүнсний хувьд дүлий хийгээд харалган хүмүүст сонсох, харахад нь туслах болно хэмээн Исаиа хэлжээ (Исаиа 29:18, 24). Энэ бошиглол хэрхэн биелэгдсэн бэ? Сүнслэг байдлын хувьд илүү сайн харж сонсоход чинь Мормоны Ном та нарт хэрхэн тусалсан бэ?

9. Аврагч бидний хүнд сорилтуудыг мэддэг бас бидний замыг чиглүүлдэг.

Исаиа 30:19–21-ийг ярилц.

- Бэрхшээлийн тухай Исаиа 30:19–21 юу заадаг вэ? Бэрхшээл тулгарсан үед Аврагч бидний төлөө юу хийх болно гэдгийг эдгээр шүлгүүд заадаг вэ? (Мөн Алма 37:37-г үз)

Дүгнэлт

Аврагчийн тухай гэрчлэлээ хэлж, бидний төлөө түүний хийсэн гайхамшигтай зүйлүүдийн төлөө талархал илэрхийл. Самбар дээрх жагсаалтыг нэгтгэн дүгнэх, түүнчлэн тэд эдгээр зүйлүүдийн тухай ямар бодолтой байдгаа илэрхийлэхэд ангийн гишүүдийг урь. Хариуд нь бид юу хийж болох тухай ярилц. (Зарим саналын төлөө Исаиа 35:3–4-ийг үз) Та бас “Би Гайхширна” дууллыг ангийн гишүүдээр дуулуулахыг хүсч болно (*Сүмийн Дуулал ба Хүүхдийн Дуу*, д. 22).

Нэмэлт заах санаанууд

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

1. Исаиагийн зарим дүрслэлүүдийг төлөөлдөг юмс

Түлхүүр, чулуу, эсвэл цөл дэх сүүдрийн зураг гэх мэт Исаиагийн дүрслэлүүдийг төлөөлөх зарим юмс буюу зургийг үзүүлж, эдгээр дүрслэлүүдийн тухай ярилц.

2. Ханделын хөгжим дэх *Мессиа*

Жорж Ханделын *Мессиа*, “Бидний Төлөө Хүүхэд Төрөв” Исаиа 9:6-гийн хөгжимд оруулсан бичлэгийг тоглож сонго.

3. “Эзэний Мутрын Хүрэлт”

Хэрэв *Family Home Evening Video Supplement (International)* (53277) байдаг бол, та хичээлийнхээ нэг хэсэг болгон “The Touch of the Master’s Hand (Эзэний Мутрын Хүрэлт)” 18 минутын бичлэгийг үзүүлж болно.

Зорилго

Есүс Христ өөрийн хүмүүст бүхнээ зориулсан байдлаараа хэнтэй ч зүйрлүүлшгүй бөгөөд тэдний төлөө хийх агуу ажил түүнд бий гэдгийг ойлгоход нь ангийн гишүүдэд туслах.

Бэлтгэл

1. Энэ хичээлээр ярилцах Исаиа 40–49-ийн хэсгүүдийг залбирч, судал.
2. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашиглах бол, дараах ишлэлүүдийг том цаасан дээр буюу самбар дээр ангийн өмнө бич:
 - а. “Та нар Христийн тухай юу гэж боддог вэ?” (Матай 22:42)
 - б. “Та нар ямархуу маягийн хүмүүс байвал зохих билээ?” (3 Нифай 27:27)
 - в. “Хүмүүс Хүний Хүүг хэн гэж ярьж байна? . . . Та нар намайг хэн гэж хэлэх вэ?” (Матай 16:13, 15)
 - г. “ЭЗЭНий төлөө хэн байна вэ?” (Египетээс Гарсан нь 32:26)
 - д. “Та нар түүний дүр төрхийг царай төрхөндөө хүлээж авсан уу?” (Алма 5:14)
3. Хэрэв *Family Home Evening Video Supplement (International)* (53277) байдаг бол, та хичээлийнхээ нэг хэсэг болгон “Та нар Христийн тухай юу гэж боддог вэ,” 5 минутын бичлэгийг үзүүлж болно.

Энэ хичээлийг заах зөвлөмж

Анхаарал
төвлөрүүлэх
үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагааг (эсвэл өөрийхөө нэг үйл ажиллагааг) ашиглахыг хүсч болно.

Цаасан дээр буюу самбар дээр өөрийнхөө бичсэн ишлэлүүдэд ангийн гишүүдийн анхаарлыг хандуул (дээрх “Бэлтгэлийг” үз). Тэгээд дараах асуултуудыг асуу:

- Эдгээр ишлэлүүд юугаараа нийтлэг вэ? (Эдгээр нь бүгдээрээ, Аврагчийн тухай гэрчлэлээ, тэрчлэн түүний шавь нар байх шийдвэр төгс байдлаа хөгжүүлэхэд бидэнд туслах, судруудаас авсан асуултууд юм.) Яагаад судруудад эдгээртэй адил өдий төдий асуултууд байдаг гэж та нар боддог вэ?

Энэ хичээл нэг хэсэг бол Аврагчийн аугаа чанарыг онцгойлон үздэг судрын асуултуудад анхаарал төвлөрүүлэх болно гэдгийг тайлбарла.

Судрын ярилцлага
ба хэрэглээ

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагаадаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Аврагчийг хэнтэй ч зүйрлүүлшгүйг Исаиа заадаг.

- Их Эзэн Исаиагаар дамжуулан зарим асуудлуудыг өөр өөр байдлаар дахин давтан асуусан байдаг. Дараах шүлэг нэг бүрд ямар асуулт асуусан байна вэ?
 - а. Исаиа 40:18 (“Та нар Бурханыг хэнтэй адилтгах юм бэ?”)
 - б. Исаиа 44:8 (“Надаас өөр Бурхан байдаг уу?”)
 - в. Исаиа 46:5 (“Намайг та нар хэнтэй адилтгаж, хэнийг надтай зэрэгцүүлэн зүйрлэх вэ?”)
- Өмнөх асуултуудтай юугаараа адил төстэй байна вэ? (Эдгээр нь бүгдээрээ, Аврагч бол бид түүнийг харьцуулж болох ямар ч хүн буюу юмнаас илүү агууг заадаг) Эдгээр асуултуудад та нар юу гэж хариулах вэ? Эдгээр асуултуудад Исаиагийн ном хэрхэн хариулсан байна вэ? (Доор жагсаасан асуултуудыг харж, жишээ бүрд Их Эзэн өөрсдийн алт, мөнгөн хуурамч бурхдыг үйлддэг хиймэл шүтээн шүтдэг хүмүүст хандан ярьсныг анхаар)
 - а. Исаиа 43:11 (“Надаас өөр Аврагч байхгүй”)
 - б. Исаиа 44:6 (“Надаас өөр Бурхан байхгүй”)
 - в. Исаиа 45:5 (“Надаас өөр Бурхан байхгүй”; мөн түүнчлэн шүлэг 6, 14, 18, 21–22-ыг үз)
 - г. Исаиа 46:9 (“Би бол Бурхан, надаас өөр байхгүй”)
- Эдгээр асуултууд болон хариултууд Исаиагийн номонд яагаад ийм олон удаа давтагдсан гэж та нар бодож байна? Эдгээр асуулт, хариултууд манай өнөө үед хэрхэн холбогдох вэ?

2. Аврагчийн зүйрлэшгүй чанаруудыг Исаиа дүрсэлдэг.

- Түүнд итгэлтэй байхын тулд “Бурханы зан чанар, төгс байдал хийгээд төлөв байдлын тухай зөв санаа” бидэнд хэрэгтэй хэмээн Бошиглогч Иосеф Смит заажээ (*Lectures on Faith* [1985], 38). Аврагчийн зан чанар, төлөв байдлын тухай Исаиа олон сайхан тодорхойлолт өгсөн байдаг. Доор жагсаасан хэсгүүдийн заримыг нь ангийн гишүүдээр уншуулж, дараах асуултуудыг ярилц: Аврагчийн ямар төлөв байдал уг хэсэгт дурдагдсан байна вэ? Энэ төлөв байдлыг мэдэх нь Аврагчид итгэх бидний итгэлийг өсгөн нэмэгдүүлэхэд хэрхэн тусалдаг вэ? Та эдгээр төлөв байдлуудыг самбар дээр жагсаан бичиж болно.
 - а. Исаиа 40:13–14 (Түүнд зөвлөгөө өгөх буюу зааварлах хэн ч үгүй.)
 - б. Исаиа 40:28–31 (Тэрбээр хэзээ ч ядардаггүй; Тэрбээр биднийг хүчирхэгжүүлдэг.)
 - в. Исаиа 40:12, 21–22, 26; 45:12, 18 (Тэрбээр ертөнцийг төлөвлөн бүтээсэн бөгөөд үүний хэсэг бүрийг мэддэг.)
 - г. Исаиа 41:17–18 (Бидэнд асуудал бэрхшээл тохиолдсон үед Тэрбээр биднийг сонсож, биднийг элбэг дэлбэгээр адисалдаг.)
 - д. Исаиа 42:1, 4 (Тэрбээр бүтэлгүйтэх нь үгүй, эсвэл түүний зорилгууд гүйцэлдэх хүртэл урам хугарах нь үгүй.)
 - е. Исаиа 42:16 (Төөрөлдсөн өөрийн хүмүүсийн замыг Тэрбээр гэрэлтүүлж, шулуусгадаг.)
 - ё. Исаиа 43:1–4 (Тэрбээр хүнд сорилтуудаар дамжуулан өөрийнхөө хүмүүст туслах болно.)

- ж. Исаиа 43:25–26; 44:21–23 (Тэрбээр бидний нүглүүдийг хэрэгсэхгүй болгож, тэдгээрийн тухай цаашид санадаггүй)
- з. Исаиа 44:2–4 (Тэрбээр хуурай газар дээр ус цутгах лугаа адил бидний гэр бүлүүд дээр өөрийн Сүнсийг цутгадаг.)
- и. Исаиа 46:3–4 (Тэрбээр өөрийн хүмүүсийг төрөхөөс нь өтөл насанд нь хүртэл авч явдаг.)
- й. Исаиа 49:14–16 (Тэрбээр биднийг хэзээ ч мартахгүй. Бид түүний гарын алган дотор “оршдог”.)

Аврагчийн эдгээр төлөв байдлын тухай гэрчлэлүүдийг нь бэхжүүлсэн туршлагынхаа талаар ярихад ангийн гишүүдийг урь.

3. Дэлхий (Вавилон) бидний бүхнээ зориулсан байдлын төлөө Аврагчтай өрсөлддөг.

- Исаиа 47 хэнд хандсан байна вэ? (Исаиа 47-гийн бүлгийн толгой гарчиг болон шүлэг 1-ийг үз. Вавилон бол эртний дэлхийн хүчирхэг хот байсан бөгөөд ёс бусынхаа улмаас устгагджээ. Судруудад Вавилон нь бас дэлхийн ёс бусын бэлэгдэл болон олонтаа хэрэглэгддэг.)
- Бүлэг 47-д, Вавилон ёс бусынхаа улмаас устгагдах болно гэдгийг сэрэмжлүүлжээ. Эдгээр сэрэмжлүүлгүүд дэлхийн бүрмөсөн устгал хийгээд үүний ёс бусад мөн адил холбогдож болно. Дэлхийн ёс бус замуудыг эрэлхийлэхийн үр дагавруудын талаар дараах хэсгүүд юу заадаг вэ?
 - а. Исаиа 47:1, 5 (Дэлхий тоосонд доош аваачигдаж, тэгээд чимээ аниргүй, тас харанхуй болно.)
 - б. Исаиа 47:7–9 (Дэлхий ялагдашгүй гэдэг үүний өөрийнх нь бодол санаанаас үл хамааран, энэ нь устгагдаж, нөхөр болон хүүхдүүдээ алдах явдлаар бэлэгдсэн, агуу үнэ цэнэтэй зүйлүүдээ алдах болно.)
 - в. Исаиа 47:10–11 (Дэлхий өөрийгөө Бурханаас илүү агуу хэмээн боддог учраас үгүйрэл түүн дээр ирэх болно.)
- Исаиа 47:8, 10-т, Аврагч өөрийнхөө талаар хийсэн мэдэгдэлтэй адил ямар мэдэгдлийг Вавилон (дэлхий) хийдэг вэ? (“Би, надаас өөр хэн ч [биш]”) Аврагчийн санал болгодог зүйлтэй харьцуулбал дэлхий юу санал болгож чадах вэ? Яагаад өдий олон хүмүүс Аврагчийн оронд дэлхийд бүхнээ зориулдаг вэ? Аврагчийн санал болгодог зүйлийг олж харахад нь бид бусдад хэрхэн тусалж чадах вэ?
- Исаиа 48:17–18-д, дэлхийг биш харин өөрийг нь эрэлхийлдэг хүмүүст Их Эзэн агуу адислалуудыг амласан байдаг. Эдгээр амлалтууд Аврагчийг бүх зүрх сэтгэлээрээ дагахад таныг хэрхэн хүргэдэг вэ?

4. Исаиа хожмын үеийн Израилыг дүрслэв

- Исаиа 49 хожмын үеийн Израилын үүрэг зорилгын тухай олон бошиглол агуулдаг. Эдгээр бошиглолууд бидний хүн бүрээр хийлгэх чухал ажил Их Эзэнд байдгийг ойлгоход бидэнд тусалж чадна. Доор жагсаасан судрын зарим хэсгүүдийг ангийн гишүүдээр уншуулж, дараах асуултыг ярилц: Эдгээр хожмын өдрүүд дэх бидний үүрэг хариуцлагын тухай энэ хэсэг юу заадаг вэ? (Бошиглолуудын олон нь Аврагчийн ажил болоод түүний үйлчлэгчдийн ажил, Израилын үр удам аль алинд нь хамаатайг анхаар [Исаиа 49:3])

- а. Исаиа 49:1, 5. “Хэвлийд байхаас минь ЭЗЭН намайг дуудсан” (Эцсийн өдрүүдэд Их Эзэний ажлыг гүйцэлдүүлэхийн тулд бид төрснөөсөө эхлэн дуудагдсан билээ; мөн Иеремиа 1:5-ыг үз)
- б. Исаиа 49:2. “Тэр миний амыг хурц илд мэт болгосон” (Энэ дүрслэл нь үнэний хүчтэй үгс—Их Эзэний үгсийг ярих тухай өгүүлж байна; мөн С ба Г 6:2-ыг үз)
- в. Исаиа 49:2. “Мутрынхаа нөмөрт Тэр намайг далдалсан” (Их Эзэн биднийг хамгаалж, бидний агуу үүрэг хариуцлагуудад биднийг бэлтгэсэн; мөн С ба Г 86:9-ийг үз)
- г. Исаиа 49:2. “Тэр намайг . . . шилмэл сум мэт болгосон” (Шилмэл [өнгөлсөн] сум шулуун нисч, байг онодог. Бид Их Эзэний илгээсэн газар уруу шулуун бөгөөд оновчтой нисэхийн тулд өнгөлөгдөж, бэлтгэгддэг билээ.)
- д. Исаиа 49:6. “Чи миний авралыг газрын хязгаарт хүргэж болно” (Их Эзэн өөрийн үйлчлэгчдийг босч, Израилын үлдэгдлийг сэргээн, Харийнханд гэрэл байхыг хүссэн билээ. Энэ арга замаар бид газар дэлхийн хязгааруудад авралыг авчрахад тусалж чадна; мөн С ба Г 86:8–11-ийг үз)

Дүгнэлт

Аврагчийг хайрлах илүү их хайрыг хөгжүүлж, тэрээр биднээр хийлгэхийг хүсдэг ажлыг илүү ихээр ойлгоход Исаиагийн бичээсүүд бидэнд тусалж чадна гэдгийг гэрчил. (*Сүмийн Дуулал ба Хүүхдийн Дуу*, д. 6) дууллыг та ангийн гишүүдээр буюу жижиг бүлгээр дуулуулж болно.

Нэмэлт заах санаанууд

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

1. Исаиагийн ашигласан бэлэгдлүүд

- Исаиа харалган байдлыг ёс бусын болон сүнсний харанхуйн бэлэгдэл болгон дахин давтан ашигласан байдаг (Исаиа 29:10, 18; 32:3; 42:6–7, 16–18; 43:8; 44:9). Та эдгээр шүлгүүдийг тунгаан бодоод, Аврагч өөрийгөө Дэлхийн Гэрэл хэмээн олонтаа тунхагласныг санагтун (Иохан 8:12). Бид өөрсдийн сүнсний мэлмийг Дэлхийн Гэрэл уруу хэрхэн илүү бүрэн дүүрнээр нээж чадах вэ?
- Исаиа усны дүрслэлийг дахин давтан хэрэглэсэн байдаг (Исаиа 12:3; 32:2; 41:17–18; 43:19–20; 44:3–4; 48:18, 21; 49:10). Тэрээр амьд усны эх булаг хэмээх Аврагчийн заадаг зүйл судрын эдгээр хэсгүүдийг ойлгоход та нарт хэрхэн тусалдаг вэ? (Иохан 4:7–14-ийг үз)

2. ЭЗЭНд найдах нь

- “ЭЗЭНд найдах” гэдэг нь юу гэсэн үг вэ? (Исаиа 40:31). Түүнд найддаг хүмүүсийн хүч чадлыг Их Эзэн ямар арга замаар шинэчилдэг вэ? (Исаиа 41:10-ыг үз) Их Эзэн хувь хүний сүнсний болон бие бялдрын хүч чадлыг шинэчилдэг туршлагуудыг хуваалцахад ангийн гишүүдийг урь.

3. “Харин чи намайг дуудсангүй”

- Бидний зарим нь Их Эзэн биднийг орхисон мэтээр яагаад заримдаа боддог вэ? Хэрэв бид Их Эзэн биднээс холдсон гэж боддог бол шалтгаан нь юу байж болох вэ? (Исаиа 43:22–26; Мозая 5:13-ыг үз) Түүнд дахин ойртохын тулд бид юу хийж болох вэ?

“Бурханлиг чанартай би санаандгүй харилцаанд орсон үед энэ нь, бурханлиг чих сонсоогүй мэт, мөн бурханлиг дуу хоолой яриагүй мэт байсныг мэдсэн тэр үед, үүнээс би хол, тун ч хол байж дээ. Хэрэв би судруудад гүн гүнзгийгээр шумбан орох юм бол, холын зай хумигдаж, тэгээд сүнслэг байдал эргэж ирдэг ” гэж Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл хэлжээ (*The Teachings of Spencer W. Kimball*, хэвлэсэн. Эдвард Л.Кимбалл [1982], 135).

“Уулсын дээр Ямар Үзэсгэлэнтэй вэ”

Хичээл
39

Исаиа 50–53

Зорилго	Есүс Христийн Цагаатгалын тухай ангийн гишүүдийн гэрчлэлийг хүчтэй болгох.
Бэлтгэл	<ol style="list-style-type: none">1. Энэ хичээлээр яригдах Исаиа 50–53-аас авсан судрын хэсгүүдийг залбирч судал. Эдгээр хэсгүүд Аврагчийн цагаатгагч золиослол дээр төвлөрдөг.2. Нэмэлт уншлага: Мозая 14–15.3. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашиглах бол, Аврагчийн хайр, золиослолын тухай дуртай нэг дууллыг сонгож, уг дууллын утгын тухай, мөн энэ дуулал тэдэнд хэрхэн нөлөөлсөн тухай ангийнхандаа ярихаар бэлтгэж ирэхийг ангийн хоёр буюу гурван гишүүнд даалга. Та Аврагчийн тухай өөрийн дуртай дуулуудын нэгнийх нь тухай ярьж болно.

Энэ хичээлийг заах зөвлөмж

Анхаарал
төвлөрүүлэх
үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагааг (эсвэл өөрийхөө нэг үйл ажиллагааг) ашиглахыг хүсч болно.

Өөрийн цагаатгагч золиослолоор дамжуулан бидний төлөө харуулсан Аврагчийн хайрыг ойлгоход Сүмийн олон дуулал бидэнд тусалдгийг тайлбарла. Аврагчийн хайр, золиослолын тухай дуртай нэг дууллынхаа тухай ярихыг даалгавар авсан ангийн гишүүн бүрээс хүс. Их Эзэний Сүнснийг ангид урихад тусалдаг учраас та ярилцаж байгаа дуулуудын нэгийг дуулахыг ангийн гишүүдээс хүсч болно.

Энэ хичээлээр Аврагчийн амьдрал, үүрэг зорилгын тухай Исаиагийн бошиглолуудаас заримыг нь ярилцах болно гэдгийг тайлбарла.

Судрын ярилцлага
ба хэрэглээ

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Баярт мэдээнүүдийг авчрах элчүүдийн тухай Исаиа өгүүлдэг.

- Исаиа 52:7-д агуу захиас авчрагч хүмүүсийг Исаиа утга уянгын байдлаар дүрсэлсэн байдаг. Исаиа яагаад элч нарын хөлний тухай өгүүлсэн гэж та нар боддог вэ? (Электрон холбоо бий болохоос өмнө эртний дэлхийд чухал захиасуудыг явганаар гүйгчид хүргэж ирэх нь олонтаа байжээ. Исаиа элч нарын хөлөөр тэднийг өөрсдийг нь бэлэгдэн харуулсан ажээ.) Эдгээр элч нарын талаар Исаиа ямар бодолтой байсан бэ?
- Хүргэж ирсэн захиасыг Исаиа хэрхэн дүрсэлсэн бэ? (Энэ бол баярт мэдээнүүдийн захиас, амар амгалан хийгээд авралын захиас байв.)

Мормоны Номны бошиглогч Абинадай, Исаиагийн дүрсэлсэн элчүүдэд бошиглогчид, бас Их Эзэн өөрөө багтаж байсныг тайлбарлажээ (Мозая 15:13–18). Амар амгалан хийгээд авралын тухай ямар агуу захиасыг эдгээр элчүүд авчирсан бэ? (2 Нифай 2:6–8)

- Сайн мэдээний захиасыг өөр хэн дэлхийд авчирдаг вэ? Сайн мэдээний захиасыг хуваалцсан тухай туршлагаудынхаа тухай ярихыг нь та ангийн гишүүдээс хүсч болно. Та бас эдгээр захиасуудыг тэдэнд авчирсан хүмүүсийн талаар ямар бодол санаатай байдгийг нь яриулахаар ангийн гишүүдээс хүсч болно.

2. Аврагчийн цагаатгагч золиослолын тухай Исаиа бошиглов.

Аврагчийн цагаатгагч золиослол болон үүний бидэнд өгдөг адислалуудын тухай дараах бошиглолуудыг ярилц.

- Исаиа 50:5–7. Бидний төлөө түүний хийсэн агуу золиослолын талаарх Аврагчийн төлөв байдлын тухай судрын энэ хэсэг юу заадаг вэ? Тэрбээр агуу зовлон шаналалтай нүүр тулгарсан үе дэх Аврагчийн төлөв байдлын талаар Матай 26:39, Филиппой 2:8 юу заадаг вэ?
- Исаиа 51:6. Энэ шүлэгт ямар харьцуулалт хийгдсэн байна вэ? Цагаатгалын үр нөлөө хэр зэрэг удаан үргэлжлэх вэ? (Мозая 16:9; Алма 34:10, 14-ийг мөн үз)
- Исаиа 51:22. Аврагч хэний төлөө гуйсан бэ? Цагаатгал түүнийг бидний Өмгөөлөгч байх боломжийг түүнд хэрхэн олгосон бэ? (С ба Г 45:3–5-ыг үз) Бидний төлөө Есүсийн уусан “согтуурлын аяга” юу вэ? (С ба Г 19:15–20-ийг үз) Цагаатгалаар дамжуулан санал болгогддог бүрэн адислалуудыг хүлээн авахын тулд бид юу хийх ёстой вэ?
- Исаиа 52:3. “Мөнгөгүйгээр гэтэлгэгдэх” гэсэн нь юу гэсэн үг вэ? (2 Нифай 26:27–28; Исаиа 55:1–3-ыг үз)
- Исаиа 53:2–4. Эдгээр шүлгүүд Аврагчийн амьдралын тухай бидэнд юу өгүүлдэг вэ? Яагаад тэрээр бидний уй гашуу, бидний зовлонг ойлгож чаддаг вэ? (Алма 7:11–13; Еврей 2:16–18; 4:15-ыг үз) Тэрээр бидний уй гашуу, зовлонг ойлгодгийг та нар хэрхэн мэдэрсэн бэ?
- Исаиа 53:5. Яагаад Аврагч биендээ шарх олох, цохиулах, ташуурдуулахын өвдөлтийг тэвчихэд бэлэн байсан бэ? (1 Нифай 19:9- үз)
- Исаиа 53:6–7. Тэрээр доромжлуулж, зовон шаналж, бидний алдсуудыг өөр дээрээ хүлээсэн үед Аврагч зан чанарын ямар шинжүүдийг харуулсан бэ? Заримдаа бид Тэнгэрлэг Эцэгийн таалалд захирагдахын оронд хэрхэн “[өөрсдийнхөө] зам” уруу эргэдэг вэ? Тэнгэрлэг Эцэгийн таалалд захирагдахад Аврагчийн үлгэр жишээ бидэнд хэрхэн тусалж чадах вэ?
- Исаиа 53:10. Аврагчийг “няцалж, өвтгөх нь ЭЗЭНий таалал байв” гэж Исаиа хэлсэн нь ямар учиртай вэ? Биднийг хайрладаг Тэнгэрлэг Эцэгийн талаар энэ хэсгээс бид юу сурч болох вэ? (мөн Иохан 3:16–17-г үз)
- Исаиа 53:8–11. Мормоны Номны бошиглогч Абинадай, Ноа Хааны ёс бус санваартнуудтай ярих үедээ эдгээр шүлгүүдийн талаар хүч нөлөө ихтэй тайлбар хийснийг тайлбарла (Мозая 15:10–13). Абинадайнхаар бол, хэн Аврагчийн үр удам байх вэ? (мөн Мозая 5:7–8-ыг үз)

- Исаиа 53:12. Тулалдааны эцэст ялсан цэргийн удирдагч ялалтын олз омгоо өөрийг нь дагалдагчдын дунд хуваадгийг тайлбарла. Тэрбээр бидэнтэй хуваалцахыг хүсдэг, үхэл, нүглийг ялсан Христийн ялалтын үр жимс юу вэ? (Ром 8:16–17; 2 Тимот 4:7–8-ыг үз)

3. Бидний зарим үүрэг хариуцлагыг Исаиа дүрсэлжээ.

- Исаиа 51, 52-т цэдэглэснээр, Аврагчийн Цагаатгалыг хүлээж авсан хүмүүсийн хувьд бидэнд ямар үүрэг хариуцлагууд ноогддог вэ?
 - а. Исаиа 51:1, 4, 7. Их Эзэнийг сонсож, дуулгавартай дага; хүмүүний зүхэлтээс бүү эмээ.
 - б. Исаиа 51:12–13. Бүтээгч болох Их Эзэнийг санагтун. Сатанаас бүү ай.
 - в. Исаиа 52:1–2. Сэрж, санваарын хүч чадлыг өмсөгтүн (С ба Г 113:7–8-ыг үз). Зөв шударга ёсны гоёмсог өмсгөлүүдийг өмсөгтүн (Илчлэлт 19:7–8-ыг үз). “Хүзүүнийхээ хүлээснээс өөрийгөө суллагтун” (С ба Г 113:9–10-ыг үз).
 - г. Исаиа 52:11. Дэлхийн ёс бусаас холдон зайлагтун. Бузар зүйлүүдэд бүү хүр; цэвэр ариун бай.
- Эдгээр үүрэг харицлага бүрийг бид хэрхэн илүү сайн биелүүлж чадах вэ?

Дүгнэлт

Түүний хөл уулсын дээр ямар үзэсгэлэнтэй вэ хэмээн Абинадай Аврагчийг элч байдлаар дүрсэлсэн Мозая 15:18-ыг нэгтгэн дүгнэ. Түүний хөл үзэсгэлэнтэй байсны нэг шалтгаан нь түүний цагаатгагч хайрын тэмдэг, хадаасны ормууд байсныг тайлбарла. Аврагчийг хайрлах таны хайрыг, түүний цагаатгагч золиослолын адислалуудын төлөө зохистой байх таны хүсэл эрмэлзлийг Исаиагийн заадаг зүйлүүд хэрхэн бэхжүүлсэн тухай гэрчлэлээ хэл. Мөн түүнчлэн тэдний гэрчлэлүүд хэрхэн бэхэжсэнийг хуваалцахыг ангийн гишүүдээс хүс.

Нэмэлт заах санаанууд

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

1. Гэрэлд алхах нь

Исаиа 50:10–11-ийг нэгтгэн дүгнэж, эдгээр шүлгүүдэд Исаиа бидэнд өгсөн сонголтыг тэмдэглэ. Хэрэв бид Их Эзэнээс эмээж, түүний үйлчлэгчдийн дуу хоолойг дуулгавартай дагаж, түүнд итгэх юм бол, биднийг удирдах түүний гэрэл бидэнд байж, тийнхүү бид харанхуйд алхахгүй байх болно (Иохан 8:12; 12:46). Хэрэв бид, гялалзагч гэрэлтэй зүйрлэгддэг өөрсдийнхөө гэрэлд алхахаар сонгох юм бол, бид “уйтгар гунигт доошлон унах болно” гэдгийг Их Эзэн сэрэмжлүүлдэг.

2. Номлогчийн ажил

Хэрэв *Family Home Evening Video Supplement Interantional* (53277) байдаг бол, та “Номлогчийн Ажил: Бидний Агуу Үүрэг” таван минутын бичлэгийг хичээлийнхээ хэсэг болгон үзүүлж болно.

Зорилго Сионы гадсуудыг бэхжүүлж, Хоёр дахь Ирэлт болон Мянган жилд бэлтгэхэд нь ангийн гишүүдийг урамжуулан дэмжих.

Бэлтгэл


1. Энэ хичээлээр яригдах Исаиа 54–56, 63–65-ын хэсгүүдийг залбирч, судал.
2. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашиглах бол, майхны нэг гадас авчир.
3. Хэрэв Амилсан Есүс Христийн зураг байгаа бол, та үүнийг хичээлийн үеэр ашиглаж болно (62187; Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 239).

**Энэ хичээлийг
заах зөвлөмж**

Анхаарал
төвлөрүүлэх
үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагааг (эсвэл өөрийхөө нэг үйл ажиллагааг) ашиглахыг хүсч болно.

Доор харуулсантай адил майхны зургийг самбар дээр зур. Тэгээд майхны гадсыг үзүүлж, дараах асуултуудыг асуу.



- Энэ майханд яагаад гадаснууд хэрэгтэй вэ? Хэрэв майхныг гадаснуудаар бэхлэхгүй бол яах вэ?
- Исаиа 54:2-т дурдагдсан майхан юуг төлөөлдөг вэ? (Есүс Христийн Сүмийг) Майхны гадаснууд юуг төлөөлдөг вэ?

Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон хэлсэн нь:

“Гадас гэдэг нэр томъёо бэлэгдлийн утга илэрхийлдэг. Газарт бөхөөр бэхлэгдсэн олон гадсаар аргамжигдсан агуу том майхныг санаандаа зураглан бод.

“Бошиглогчид хожмын үеийн Сионыг газар дэлхийг бүрхсэн асар том майхантай адилтгасан байдаг. Тэр майхан гадаснуудаар холбогдсон уяагаар

бэхлэгддэг байв. Мэдээж хэрэг, гадаснууд нь дэлхий даяар тархсан газар зүйн өөр өөр байршилтай байгууллагууд юм. Эдүгээ Израил Сионы янз бүрийн гадаснуудад цугларч байна.” (“Strengthen Thy Stakes,” *Ensign*, 1991 оны 1-р сар, 2)

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн анхны гадаснууд 1834 онд Огайогийн Көртланд, Миссурийн Клей Гүнлэгт зохион байгуулагдсаныг ангийнханд хэл. Сүм өсөхийн хэрээр, Их Эзэн зарлигласны дагуу илүү олон гадаснууд нэмэгдэж байлаа (С ба Г 101:20–21). Өнөөдөр дэлхий даяар байршилтай хэдэн зуун гадас байна.

Энэ хичээлээр Сионы гадаснуудыг бид хэрхэн бэхжүүлж болох талаар ярилцах болно гэдгийг тайлбарла. Мөн энэ хичээлээр Хоёр дахь Ирэлт болон Мянган жилийн тухай Исаиагийн заадаг хүч нөлөө ихтэй зүйлүүдийг бас ярилцах болно.

Судрын ярилцлага ба хэрэглээ

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. “Аргамжаагаа уртасгаж, гадсуудаа бөхлөгтүн” (Исаиа 54:2)

- “Майхныхаа талбайг өргөтгө” гэсэн өгүүлбэрийн утгыг та нар юу гэж боддог вэ? (Исаиа 54:2). (Сайн мэдээ дэлхийг бүрхэхийн тулд үүнийг олон хүмүүстэй хуваалцахыг Их Эзэн Сүмийн гишүүдээс хүсдэг. Хожмын өдрүүдэд Сүм түргэн өсч, дэлхий даяар олон хүмүүс үнэнд хөрвөгдөх болно гэдгийг Исаиа бошиглосон юм [Исаиа 54:3]).
- Исаиа 54:3-т майхны буюу Сүмийн талаар өөр ямар зөвлөгөө өгөгдсөн байна вэ? Энэ зөвлөгөөг бид хэрхэн дагаж болох вэ? Доор харуулсны дагуу та ярилцлагыг самбар дээр хураангуйлан дүгнэж болно.

<u>Исаиагийн зөвлөгөө</u>	<u>Бид юу хийж чадах вэ?</u>
Майхны хажуу талуудыг сунгаж, аргамжаануудыг уртасга.	Бүрэн цагийн номлогчдоор үйлчил; найз нөхөд болон хөршүүдтэйгээ сайн мэдээг хуваалц.
Майхны гадаснуудыг бэхэл	Манай орон нутгийн гадсуудыг бэхжүүл

- Бид өөрсдийн амьдардаг гадсыг хэрхэн бэхжүүлж чадах вэ? (Хариултууд нь: Өөрийн сүнсний хүч чадлыг бэхжүүлэх, мөн ингэхэд нь гэр бүлийн гишүүд, найз нөхөддөө нөлөөлөх, гишүүн болон гишүүн бус хөршүүддээ үйлчлэх, Сүмд үйлчлэхийн тулд санваартны удирдагчдаасаа дуудлага хүлээн авах зэрэг нь байж болно.)
- Гадаснууд хүмүүсийн амьдралыг хэрхэн адисалж чадах вэ? (С ба Г 115:5–6-г үз) Сионы гадаснууд бидний хувьд хэрхэн хамгаалах газрууд, хоргодох байр болдог вэ?

2. “Би чамайг агуу энэрлээр цуглуулна” (Исаиа 54:7)

- Хэдийгээр Израил олон жилийн туршид тараагдсан ч гэсэн, эцсийн өдрүүдэд Их Эзэн түүнийг үнэн Сүмд цуглуулах болно хэмээн амласан билээ (Исаиа 54:4–10). Исаиа 54:4–10-т бид Их Эзэний тухай юу мэдэж болох вэ? Их Эзэн өөрийн зөв шударга үйлчлэгчдэд ямар онцгой адислалууд амладаг вэ? (Исаиа 54:13–14, 17-г үз) Эдгээр амлалтууд яагаад чухал вэ?
- Гэгээнтнүүдтэй хамт цуглаж, хоргодох байр олохын тулд хэн уригддаг вэ? (Тэнгэрлэг Эцэгийн бүх хүүхдүүд) Өөрт нь ирж, сайн мэдээнд аюулгүй байдлыг олохыг Их Эзэн тэднээс хүсдэг бүлэг хүмүүсийг дүрсэлсэн Исаиагийн дараах хэсгүүдийг нэгтгэн дүгнэ:
 - а. Исаиа 55:1–3. (Цангадаг бүх хүмүүс) Эдгээр шүлгүүдэд ямар төрлийн цангалтын тухай өгүүлж байна вэ? Бид мөнгө болон хүч чармайлтаа дэлхийн зүйлүүдэд зарцуулснаар сүнсний цангаагаа гаргах гэж оролдвол юу болох вэ? Бидний сүнсний цангаа жинхэнээрээ яаж тайлагдах вэ? (2 Нифай 9:50–51; 3 Нифай 20:8-ыг үз)
 - б. Исаиа 55:6–7. (Наманчлах ёс бус хүмүүс) Наманчилдаг хүмүүст ямар амлалт өгөгддөг вэ?
 - в. Исаиа 56:3, 5–8. (Их Эзэнийг мэддэггүй харийнхан) Их Эзэнээр хүлээн зөвшөөрөгдөхийн тулд харийнхан юу хийх ёстой вэ?
- Эдгээр хэсгүүд Их Эзэний нигүүлслийн талаар юу заадаг вэ? Бид Тэнгэрлэг Эцэгийн бүх хүүхдүүдийг хэрхэн үзэх ёстой тухайд эдгээр хэсгүүд юу заадаг вэ?
- Бороо, цас үрийг тэжээдэг шиг Бурханы үг бидний сүнсийг тэжээж чаддаг тухай Исаиа бичжээ (Исаиа 55:10–13-ыг үз). Бурханы үг бидний сүнсийг хэрхэн тэжээдэг вэ? (Алма 32:28, 41-үз)

3. Мянган жил амар амгалангийн хийгээд баяр баясгалангийн үе байх болно.

- Хэдийгээр энэ дэлхийд тэмцлүүд, уруу таталтууд хийгээд зовлон зүдгүүр байх боловч, төгсгөлд сайн нь муут ялан дийлэх болно, учир нь зөв шударга хүмүүсийн учир, ирээдүй баяр баясгалангаар дүүрэн байх болно гэдгийг Исаиа өөрийн бичээсүүдэд бүгдэд нь гэрчилсэн юм. Ёс бусыг үйлдэгчдэд цээрлэл, зөв шударга хүмүүсийн хувьд агуу баяр баясгалан авчрах Аврагчийн Хоёр дахь Ирэлтийн төлөө Исаиа шаргуу залбирдаг байжээ (Исаиа 64). Найдвар, баяр баясгалангийн ямар захиас Исаиа 64:1–4-д агуулагддаг вэ? Энэ захиас Их Эзэнд үйлчлэх үйлчлэлд эцсийг хүртэл тэвчих хүслийг тань хэрхэн нэмэгдүүлдэг вэ?
- Исаиагийн цэдгийн сүүлчийн бүлгүүд, Аврагчийн Хоёр дахь Ирэлтээр эхлэх амар амгалангийн мянган жилийн үе—Мянганы гоё сайхан дүр зургийг гаргадаг. Исаиа 65:17–25-д цэдэглэснээр, Мянганы үед ямар нөхцөл байдал орших вэ? (Та эдгээр нөхцөл байдлуудыг самбар дээр жагсаан бичиж болно; мөн Исаиа 11:6–9-ийг үз)
 - а. Их Эзэн шинэ тэнгэрүүд мөн шинэ дэлхийг бүтээх болно (Исаиа 65:17).
 - б. Их Эзэний хүмүүст агуу баяр баясгалан ирж, тэд дахиад уйлахгүй байх болно (Исаиа 65:18–19).

- в. Хүмүүс залуугаараа үхэхээ боино; тэд 100 наслах хүртлээ амьдарна (Исаиа 65:20).
 - г. Хүмүүс хөдөлмөрийнхөө үр шимийг хүртэх болно (Исаиа 65:21–23).
 - д. Залбирлууд тэр даруйд хариулагдах болно (Исаиа 65:24).
 - е. Амьтдын дунд дайсагнал байхгүй болно (Исаиа 65:25).
- Их Эзэний хязгааргүй нинжин сэтгэл хийгээд хайрын тухай Исаиа 63:7–9 юу заадаг вэ? (Биднийг хайрладаг Аврагчийн хайрыг харуулсан үг, өгүүлбэрүүдийг эдгээр шүлгүүдээс олж хэлэхийг ангийн гишүүдээс хүс. Та эдгээрийг самбар дээр бичиж болно.) Аврагч ямар замаар “өөрийн үлэмж их энэрэл хайрыг” харуулсан бэ?

Дүгнэлт

Бид Сионы гадсуудыг бэхжүүлж, сайн мэдээг дэлхийтэй хуваалцахад, үүрд мөнхийн баялгууд биднийг хүлээж байдгийг гэрчил. Бид Аврагчийн Хоёр дахь Ирэлтийг, түүнчлэн Мянганы үед орших амар амгалан хийгээд баяр баясгаланг хүсэн хүлээж болно. Их Эзэнд үйлчлэх нь онцгой боломж бөгөөд ингэснээр тэрээр өөрийн шавь нарыг адисалдгийг санахад Исаиагийн бошиглолууд биднийг урамшуулан дэмждэг.

Нэмэлт заах санаанууд

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

1. Мацгийн үнэн хууль (Исаиа 58:3–12)

- Исаиа 58-аас бид мацгийн талаар юу мэдэж болох вэ? Үнэн мацгийн гурван бүрэлдэхүүн хэсэг юу вэ? (Исаиа 58:3–7-г үз)
- Үнэн мацгийн нэг бүрэлдэхүүн хэсэг бол мацгийн өргөлийг өгөөмөр сэтгэлээр өгөх явдал мөн. “Бидний олны нэгэн адил бид чинээлэг байгаа үед бид нэн их, нэн их өгөөмөрч байж . . . хэмнэсэн хоёр хоолныхоо үнэнээс илүү ихийг, магадгүй бүр илүү ихийг—одоо бид өгч байгаагаасаа арав дахин ихийг өгөх ёстой гэж би боддог” гэж Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл хэлжээ (Conference Report, 1974 оны 4-р сар, 184).
- Мацгийн хуулиар амьдарсны төлөө ямар адислалууд Исаиа 58-д амлагдсан байдаг вэ?
 - а. Бид уруу таталтыг эсэргүүцэхэд илүү хүчтэй болно (Исаиа 58:6).
 - б. Бидний ачаа хөнгөрнө (Исаиа 58:6).
 - в. Бидний бие бялдрын хийгээд сүнсний эрүүл мэнд дээшилнэ (Исаиа 58:8).
 - г. Бид даруу болж, Их Эзэнтэй харилцахад бэлтгэгдэнэ (Исаиа 58:9).
 - д. Ядуус хийгээд гачигдалтай хүмүүст бид тусална (Исаиа 58:10).
 - е. Бид Их Эзэнээс тогтмол удирдамж хүлээн авна (Исаиа 58:11).
 - ё. Бид ган болоход бодгалиа хангаж, “ширгэшгүй ундаргатай булаг мэт байх болно” (Исаиа 58:11).

Мацгийн хуулиар амьдарснаар ирдэг адислалуудыг харуулдаг судар, Сүмийн түүх буюу хувь хүний туршлагын жишээнүүдийг хуваалцахад ангийн гишүүдийг урь.

- Мацгийн хуулиар амьдрахад бид хэрхэн илүү хичээнгүй байж чадах вэ?

2. Аврагчийн тохинууллын дүр зураг

- Исаиа 61:1–3 бол Аврагчийн дуудлага ба тохинууллын тунхаглал юм. Назар дахь тохинууллынхаа эхэн үед Аврагч эдгээр шүлгүүдийг иш татан, “Энэхүү судар өнөөдөр сонсголд тань биеллээ” гэж хүмүүст хэлжээ (Лук 4:14–21). Эдгээр шүлгүүд Есүс Христийн зан чанар хийгээд үүрэг зорилгын тухай юу заадаг вэ?

3. Христийн Хоёр дахь Ирэлт (Исаиа 63:1–6)

- Аврагчийн Хоёр дахь Ирэлт Исаиа 63:1–6-д дүрслэгдсэн байдаг. Аврагч алдар суундаа хүрэлцэн ирэхэд түүний орхимж ямар өнгөтэй байх вэ? (Исаиа 63:2; Илчлэлт 19:11–13; С ба Г 133:46–48-ыг үз) Улаан өнгө юуг бэлэгддэг вэ? (Бидний нүглүүдийн төлөө Гетсеманид болон загалмай дээр зовон шаналж байх үед түүний асгаруулсан цусыг)

“Би чамайг өнөөдөр . . . төмөр багана болгов”

Хичээл
41

Иеремиа 1–2; 15; 20; 26; 36–38

Зорилго	Эсэргүүцэл, бэрхшээлийн үед итгэлтэй хэвээр үлдэхэд нь ангийн гишүүдийг урамшуулан дэмжих.
Бэлтгэл	<ol style="list-style-type: none">1. Энэ хичээлээр ярилцах Иеремиагийн хэсгүүдийг залбирч, судал. Иеремиа өөрийнх нь эргэн тойрон дахь хүн бүхэн түүнийг эсэргүүцэхэд, зоригтой, шийдвэр төгс байсанд энэ хичээл анхаарал төвлөрүүлэх болно.2. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашиглах бол, нэг төмөр саваа хичээл дээр авчир.

Энэ хичээлийг заах зөвлөмж

Анхаарал
төвлөрүүлэх
ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагааг (эсвэл өөрийхөө нэг үйл ажиллагааг) ашиглахыг хүсч болно.

Төмөр саваа үзүүлж, үүнийг хугалах гэж оролдоход ангийн нэг гишүүнийг урь. Тэгээд дараах асуултуудыг асуу:

- Хэрэв энэ зүйл хүний зан чанарыг төлөөлж байгаа бол, энэ нь түүний тухай юу өгүүлж байна вэ?
- Иеремиа 1:17–19-ийг уншихыг ангийн гишүүдээс хүс. Иеремиаг дүрслэхийн тулд Их Эзэн шүлэг 18-д ямар өгүүлбэрүүдийг ашигласан байна вэ? Иеремиа ямар хүн байсан тухай эдгээр өгүүлбэрүүд өгүүлж байна вэ? Хэрэв эдгээр өгүүлбэрүүд, Их Эзэнээс хүлээн авсан дуудлага буюу даалгавраа биелүүлэхээр чармайж байгаагаар таныг дүрслэхэд ашиглагдсан бол танд ямар санагдах байсан бэ?

Хаад, хунтайж нар, санваартнууд, түүнчлэн нутгийн бүх хүмүүс Иеремиаг, түүний номлолыг эсэргүүцэж байсан хэдий ч, тэрээр Их Эзэний зарлигласныг зоригтойгоор хийж байсныг тайлбарла. Төмөр саваа үзүүлж, Иеремиа бол бэрхшээл тулгарсан үед хугарахгүй бас нугарахгүй, агуу хүч чадалтай “төмөр багана” байсныг тайлбарла.

Судрын ярилцлага
ба хэрэглээ

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагауудаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

Иеремиа Иосиагаас Зедекиа хүртэл (МЭӨ 626–586) таван хааны хаанчлалын үед тохинуулж байжээ. Тэрээр Иосиагийн хамт хүмүүсийг хиймэл шүтээн болон ёс суртахуунгүй байдлаас эргүүлэх гэж оролдож байв. Гэвч Иосиагийн дараах хаад ёс бусаар захирч байсан бөгөөд хүмүүс нийтээрээ урвалтад байлаа. Иеремиагийн үүрэг бол эдгээр хүмүүст сэрэмжлүүлгийн дуу хоолойг өргөх явдал байв, иймээс тэдний ёс бусыг шүүмжилсэн түүний

шүүмжлэл бүх судрууд дахь хамгийн хүчтэй нь юм. Тэр бол Иудейг вавилончууд байлдан дагуулахаас өмнөх сэрэмжлүүлгийн сүүлчийн дуу хоолойнуудын нэг байлаа.

Иеремиагийн амьдрал уй гашуугаар дүүрэн байсан хэдий ч, хүнд сорилтод түүний үзүүлсэн хариулт нь бидэнд сургамж болж, сүнслэгээр нөлөөлж чадна. Иудейн хаант улсын эсрэг бошигლოსныхоо төлөө тэрээр зодуулж, шоронд орж байв. Түүний амь насанд байнга заналхийлж байлаа. Гэвч бүхий л бэрхшээл, эсэргүүцлийн туршид Иеремиа “төмөр багана” лугаа адил байсан ажээ (Иеремиа1:18). Иеремиагийн ном амьдралынхаа уй гашуу хийгээд цөхрөлд үзүүлсэн бошиглогчийн хариулт, хувь хүний итгэлийг хөхиүлэн дэмжсэн цэдэг мөн.

1. Иеремиа бошиглогч байхаар Бурханаас дуудагдав.

Иеремиа 1:4–10-т цэдэглэгдсэн, Иеремиа бошиглогч байхаар дуудагдсан тухай шастирыг нэгтгэн дүгнэ.

- Иеремиагийн дуудлага урьдчилсан томилолтын сургаалын талаар бидэнд юу заадаг вэ? (Иеремиа1:5-ыг үз) Мөнх бус байдлын өмнөх оршихуйд тэрээр бошиглогч байхаар урьдчилан томилогдсоноо мэдсэн нь Иеремиад хэрхэн тусалсан гэж та нар боддог вэ?

“Дэлхийн оршин суугчдад тохинуулахаар дуудагдсан хүн болгон энэ дэлхий байхаас өмнө Тэнгэрийн Их Зөвлөгөөн дээр чухамхүү энэ зорилгод томилогдсон юм” гэж Бошиглогч Иосеф Смит хэлжээ (*History of the Church*, 6:364).

- Иеремиа өөрийнхөө дуудлагыг хэрэгжүүлэхэд тохирохгүй гэж бодсон үед Их Эзэн юу хийсэн бэ? (Иеремиа 1:6–10-ыг үз) Та өөрийгөө тохирохгүй гэж бодсон үед Их Эзэн танд хэрхэн дахин итгэл төрүүлсэн бэ?

2. Олон хүмүүс Иеремиаг эсэргүүцэж, түүнийг үүрэг зорилгоо хэрэгжүүлэхээс нь холдуулах гэж оролдож байв.

Их Эзэнээс түүнд өгөгдсөн үүрэг зорилгыг биелүүлэх явцад Иеремиад тулгарсан эсэргүүцлийн тухай ярилцахын тулд дараах судруудыг ашигла:

- а. Иеремиа 20:1–6. Иеремиагийн бошиглолуудад дургүйцсэн, ариун сүмийн ерөнхий захирагч Пашур Иеремиаг зодуулж, олны өмнө гавлаж, дөнгөлж байжээ. Пашур, түүний гэр бүл, найз нар нь вавилончуудын боолчлолд орон Вавиланд үхэх болно гэж Иеремиа бошиглосон ажээ.
- б. Иеремиа 26:7–15. Нутгийн хүмүүсийн олонхи нь, түүний дотор санваартнууд Иеремиа болон түүний захиасыг эсэргүүцдэг байв (26:7–11). Гэвч, өгөхийг нь Их Эзэн түүнд зарлигласан захиасыг Иеремиа зоригтойгоор хүргэсээр байв (26:12–15). Тэр ч байтугай хөршүүд болоод төрөл садангууд нь Иеремиаг эсэргүүцэж, үзэн яддаг байжээ (11:19–21; 12:6. Иеремиа Анатот хотынх байсныг анхаар).
- в. Иеремиа 36:1–6, 20–32. Иеремиагийн бошиглолын үгс тэмдэглэгдэн, хүмүүст уншигддаг байв (36:1–6). Хаан эдгээр үгсийг шатаасан хэдий ч, эдгээрийг дахин цэдэглэхийг Их Эзэн Иеремиад зарлиглажээ (36:20–32).
- д. Иеремиа 37:12–15; 38:4–13. Иеремиаг шударга бусаар яллаж, шоронд хийв (37:12–15). Хожим нь тэрээр газар доорх гянданд хаягдаж, тэнд тэрээр намагт живж байжээ (38:4–6). Зедекиа хааны тушаалаар Иеремиа газар доорх гяндангаас суллагдаж, эргээд шоронд орсон аж (38:7–13).

- Тэрээр ийнхүү дааж давшгүй эсэргүүцлийг тэвчин тэсвэрлэж байхдаа Иеремиа санаа сэтгэл нь ямар байсан талаар Иеремиа 20:14–18 юуг илчилдэг вэ? Бид бэрхшээлтэй тулгарсан үед өөрсдөдөө туслахын тулд Иеремиагаас юу сурч болох вэ? (Хариултуудад нь Иеремиа бүр мөрдөгдөн хавчигдаж, санаа сэтгэлээр унасан үедээ ч Их Эзэнийг дуулгавартай дагаж, дуудлагаа үргэлжлүүлэн биелүүлсээр байсан нь багтаж болно; Иеремиа 26:12–15-ыг үз)
- Иеремиа 2:13-г, өөрийнх нь хүмүүс ямар хоёр хилэнц үйлдсэн гэж Их Эзэн хэлсэн бэ? (Тэд амьдралын усны оргилуур болсон түүнийг орхисон байлаа. Тэд өөрсөддөө зориулж, Их Эзэний амьдралын усыг хадгалж чаддаггүй эвдэрхий нөөцлүүрүүд хийсэн нь тэд дэлхийн зүйлүүдэд баяжихыг болон аюулгүй байдлыг эрэлхийлж байсан гэсэн үг юм.) Яагаад ийм зан чанартай хүмүүс Иеремиагийн үгсийг хүлээн авах нь хэцүү байсан бэ? Яагаад тэд бэрхшээлд Иеремиагийн адил хариулах чадваргүй байсан бэ? Заримдаа бид Их Эзэний амьдралын усыг тогтоон хадгалж чадахгүй “эвдэрхий нөөцлүүрийг” хэрхэн бий болгодог вэ?

Ахлагч Марион Д.Ханкс хэлэхдээ:

“Материаллаг зорилтууд бидний анхаарлыг хэтэрхий их татаж байна. Бидэнд хэрэгтэй зүйлүүдийн төлөөх тэмцэл эсвэл бидэнд хэрэгтэй байгаагаас илүү зүйлийн төлөөх тэмцэл бидний цаг хугацаа, эрч хүчийг шавхан барж байна. Бид таашаал, зугаа цэнгэлийн хойноос хөөцөлдөж, эсвэл холбоо нийгэмлэгүүд буюу иргэний асуудлуудтай хэт зууралдаж байна. Мэдээжийн хэрэг, хүмүүст идэвхтэй амралт, амжилт бүтээл, хувь нэмэр оруулах нь хэрэгтэй л дээ; гэвч эдгээр нь Христэй нөхөрлөхийн үнэ цэнээр оллоо байгаа бол, үнэ цэнэ нь хэтэрхий өндөр юм.

“Учир нь миний хүмүүс хоёр бузар мууг үйлдсэн билээ’, тэд өөрсөддөө зориулан ус тогтоож чаддаггүй эвдэрхий нөөцлүүрүүдийг чулуу ухан хийхийн тулд амьд усны ундарга болох намайг умартсан юм’ хэмээн Их Эзэн Израилд хэлсэн байдаг (Иеремиа 2:13).

“Бид амьдралдаа Бурханыг орлуулахаар хүсдэг тэр зүйлүүд үнэхээр ус тогтоон хадгалж чаддаггүй. Бид ‘амьдралын уснаас’ татгалзах тэр хэмжээгээрээ, бидэнд байж болох баяр баясгаланг бид үгүй хийдэг” гэжээ (Conference Report, 1972 оны 4-р сар, 127; *Ensign*, 1972 оны 7-р сар, 105).

Вавилончууд Иерусалимыг устгах болно гэсэн Иеремиагийн бошиглолууд Иеремиа 39-40-д цэдэглэгдсэнийхээ дагуу биелэгдсэн ажээ. Бүслэлтийн үед Иеремиа шоронд байсан боловч, дараа нь вавилончууд түүнийг суллаж, Иудейн нутагт үлдэхийг нь түүнд болон үлдсэн иудейчүүдэд зөвшөөрсөн аж. Үлдсэн хүмүүсийн удирдагч Иоханан, тэдэнд зориулж Их Эзэний тааллыг эрж хайхыг Иеремиагаас хүсч, үүнийг дуулгавартай дагахаар амлажээ (Иеремиа 42:1–6). Их Эзэн Иеремиагаар дамжуулан, Иудейн нутагт үлд гэж хүмүүст хэлэн, хэрэв тэд үлдэх юм бол, тэднийг адислахаар амлажээ (Иеремиа 42:9–22). Гэвч Иоханан хүмүүсийг Египет уруу удирдан дагуулж, тэнд тэдний ихэнх нь ёс бус байдлаа үргэлжлүүлжээ (Иеремиа 43–44).

3. Иеремиа Бурханы үгийг хайрлах хайраараа бэрхшээлийн дунд хүчирхэгжив.

Бэрхшээлийн үед хүчтэй хэвээр үлдэхэд нь Бурханы үг Иеремиад хэрхэн тусалсныг харуулдаг дараах судруудыг ярилц.

- Иеремиа 1:9-д цэдэглэснээр, Их Эзэн Иеремиагийн аманд юу хийсэн бэ? Иеремиа 15:16-д цэдэглэснээр, Иеремиа Их Эзэний үгсийг яасан бэ? (Тэр үгсийг идсэн нь, утга уянгын хэлээр бол Бурханы үг түүний нэг хэсэг болох учиртай ажээ.) Их Эзэний үгийн талаар Иеремиа ямар бодолтой байсан бэ?
- Бид Иеремиагийн нэгэн адил Их Эзэний үгсийг хэрхэн “идэж” болох вэ? (Судруудыг мөн хожмын үеийн бошиглогчдын зөвлөгөөг судалснаар) Мормоны Номын бошиглогч Нифай “Христийн үгс дээр найрлагтун” хэмээн хэлжээ (2 Нифай 32:3). Их Эзэний үгс дээр найрлах нь биднийг хэрхэн хүчирхэгжүүлж чадах вэ?
- Иеремиа 20:9-д, Иеремиа өөрийнхөө доторх Их Эзэний үгийг хэрхэн дүрсэлсэн бэ? Ясан дотор чинь Их Эзэний үг шатаж байхаар байна гэсэн нь юу гэсэн утгатай гэж та нар боддог вэ? Яагаад Иеремиа Их Эзэний үгийг заахаас ухарч чадахгүй байсан гэж та нар боддог вэ?

Дүгнэлт

Иеремиагийн үлгэр жишээ болон бэрхшээлийн үед итгэлтэй байх хэрэгцээний талаар өөрийн санаа бодлыг илэрхийл. Их Эзэний үгсийг эрж хайн, эдгээрийг тэдний ясан дахь гал болж, Их Эзэний ажлыг хийхэд нь тэднийг хүчирхэгжүүлэх хүртэл нь тунгаан бодоход ангийн гишүүдийг урамшуулан дэмж. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашигласан бол, төмөр савааг үзүүлж, Иеремиагийн адил Их Эзэний төлөө төмөр багана болоход нь ангийн гишүүдэд нөлөөл.

Нэмэлт заах санаанууд

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

1. “Ваарчны гар дахь . . . шавар” (Иеремиа 18:6)

- Иеремиа 18:1–4-т цэдэглэгдсэн, Иеремиа ваарчин дээр очсон тухай шастирыг нэгтгэн дүгнэ. Иеремиагийн туршлагаар дамжуулан Их Эзэн өөрийн хүмүүст юу заасан бэ? (Иеремиа 18:5–10-ыг үз. Хэрэв тэд наманчлах юм бол, яг ваарчин савыг дахин хэлбэрийг нь өөрчилж барьж байгаа шиг, тэрээр тэднийг илүү сайн хэвэнд оруулан барих болно гэдгийг Их Эзэн тэдэнд харуулжээ. Тэрээр бас хэрэв тэд наманчлахгүй бол тэднийг устгах хүч түүнд бий гэдгийг тэдэнд сануулжээ.)
- Энэ харьцуулалт өнөөдөр бидэнд хэрхэн хамаатай вэ? Бид Их Эзэний мутарт хэрхэн илүү сайн шавар байж чадах вэ? (Даруу байснаар— дуулгавартай дагаж, наманчлан, Их Эзэнд итгэснээр, түүнчлэн түүний тааллыг эрэлхийлснээр. Их Эзэн өөрийн зорилгуудыг биелүүлэхийн тулд хүмүүсийг хэрхэн хэлбэрийг нь өөрчилж, бэлтгэдгийг харуулсан туршлагаудыг хуваалцахад ангийн гишүүдийг урих) Их Эзэнээр хэвлэгдэн баригдахыг бид эсэргүүцэхэд юу тохиолдох вэ?

Ерөнхийлөгч Хебер С.Кимбалл Иеремиа 18:1–10 дахь харьцуулалтын талаар дараах ойлголтыг өгчээ :

“Бурханы мугарт уян хатан, мөн Түүний зарлигуудад дуулгавартай байдаг бүх [хүмүүс] бол алдар хүндийн савнууд бөгөөд Бурхан тэднийг хүлээн авах болно.” (*History of the Church*, 4:478)

“Барьж, хэлбэрийг нь өөрчилсний дараа устгадаг олон сав байдаг. Яагаад? Яагаад гэвэл тэдгээр нь ваарчны барих гэсэн хэлбэртэй зөрсөн байдаг, гэвч тэр даруйд тэдгээрийг өөрсдийг нь баярлуулах тийм хэлбэрт оруулдаг; тиймээс тэд Бурханы төлөвлөсөн ойлголтоос өөр байдаг, ингээд тэд өөрсдийнхөө сонгох эрхийн хүчний дагуу өөрсдийгөө устгадаг. [Эдгээр хүмүүс] үй олон загвар хэлбэрийг дамжих ёстой тэгээд дараа нь . . . гялгар түрхэц тавьж шатаадаг; тэгээд бүр шатаах явцад ч зарим сав хагардаг.” (Стейнли Б.Кимбалл, *Хебер С.Кимбалл: Mormon Patriarch and Pioneer* [1981], 270)

2. Мормоны Номны бошиглогч Лихайтай нэгэн үед Иеремиа бошиглож байжээ

Лихай Иерусалимыг орхисон тэр үед бошиглогч Иеремиа Иудейн хүмүүст зааж, тэднийг сэрэмжлүүлж байв. Иерусалим устгагдах болно гэдгийг Иеремиа, Лихай хоёр хоёул бошиглож байжээ.

- Лихай болон түүний гэр бүл Иерусалимыг орхин явахад Иеремиа хаана байсан бэ? (Иеремиа 37:15–16; 1 Нифай 7:14-ийг үз)
- Иеремиа Иудейн хаан Зедекиатай зөвлөлдөхөд их цаг зарцуулдаг байсан боловч Зедекиа Иеремиагийн хүргэдэг байсан Их Эзэний үгсийг дуулгавартай дагахаас татгалздаг байв. Дуулгаваргүй байдлынх нь үр дагавар болж Зедекиад ноу тохиолдсон бэ? (Иеремиа 39:4–7-г үз)
- Зедекиагийн хөвгүүдийн нэг нь вавилончуудаар алагдаагүйг бид Мормоны Номноос мэддэг. Түүний нэр хэн байсан бэ? (Хиламан 8:20–21-ийг үз) Тэр хаашаа явсан бэ? (Омнаи 1:15-ыг үз)

Зорилго Хожмын өдрүүд дэх Бурханы агуу ажилд оролцоход болон түүний хуулийг зүрх сэтгэлдээ бичүүлэхэд нь ангийн гишүүдийг урамшуулан дэмжих.

Бэлтгэл 1. Иеремиа 16; 23; 29; 31.
2. Нэмэлт уншлага: Иеремиа 3–9; 13; 30; 32:37–42; 33; 35.

Энэ хичээлийг заах зөвлөмж

Анхаарал
төвлөрүүлэх
үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагааг (эсвэл өөрийхөө нэг үйл ажиллагааг) ашиглахыг хүсч болно.

- Хэрэв та Хуучин Гэрээн дэх аль нэг түүх буюу үйл явдлын гэрч байсан буюу үүнд оролцсон бол, алийг нь сонгох вэ? (Та ангийн гишүүдийн хариултуудыг самбар дээр бичиж болно.)
- Та яагаад энэ үйл явдлыг гэрчилсэн буюу үүнд оролцсон бэ?
- Таны сонгосон үйл явдлуудын заримтай нь зүйрлүүлж болох ямар үйл явдал өнөөдөр Сүмд болдог вэ?

Хэдийгээр Иеремиа өөрийн үеийн хүмүүсийн хувьд найдварын цөөн хэдхэн захиастай байсан ч, тэрээр хожмын үеийн Израилын цугларалтын үе дэх найдварын үеийг угтан харсныг тайлбарла. Бид өнөөдөр үүнд оролцож байгаа хожмын үеийн агуу цугларалтын тухай Иеремиагийн бошиглоуудыг энэ хичээлээр ярилцах болно.

Судрын ярилцлага
ба хэрэглээ

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Иеремиа Израилын хожмын үеийн цугларалтыг угтан харав.

Хэрэв Израил Египетээс гарсан нь үйл ажиллагаанд дурдагдаагүй бол, энэ бол Хуучин Гэрээн дэх хамгийн гайхамшигтай үйл явдлуудын нэг мөн гэдгийг тайлбарла. Энэ нь Иеремиагийн номонд түүнчлэн Хуучин Гэрээний бусад номнуудад, бас Мормоны Номонд дурдагддаг.

- Египетээс Гарсаны ач холбогдлын тухайд Мосе юу гэж боддог байсан бэ? (Дэд Хууль 4:32–35-ыг үз) Египетээс Израил гарсны нэг хэсэг байх нь юутай адил гэж та нар боддог вэ?
- Египетээс Гарсантай адил тийм агуу их хэмээн Их Эзэн хэлсэн хожмын үеийн нэг үйл явдлыг олон үеийнхний дараа Иеремиа угтан харсан ажээ (Иеремиа 16:14–16; 23:3–8). Иеремиа 16:15, 23:3-т ямар үйл явдал дүрслэгдсэн бэ? (Израилын цугларалт болон Сүмийн өсөлт) Иеремиа

23:4-т өгүүлэгдсэн хоньчид хэн бэ? (Санваартны удирдагчид болон Сүмийн бусад удирдагчид) Иеремиа 23:5–6-д өгүүлэгдсэн Хаан хэн бэ? (Есүс Христ) Эдгээр үйл явдлууд яагаад Египетээс Гарсантай адил агуу их гэж та нар боддог вэ?

- Иеремиа 16:16-д дүрслэгдсэн загасчид, анчид бол Сүмийн номлогчид юм гэж Ахлагч ЛеГранд Ричардс хэлжээ (Conference Report, 1971 оны 4-р сар, 143; *Ensign*, 1971 оны 6-р сар, 98–99). Номлогчидтой адил нийтлэг ямар зүйл загасчид, анчдад байдаг вэ? (Матай 4:18–19-ийг үз) Бид яаж илүү үр ашигтай номлогчид байж чадах вэ?

2. Бурхан өөрийн хуулийг өөрийн хүмүүсийн зүрх сэтгэлд бичих болно.

- Израилын хүүхдүүд аглаг буйд дахь аяныхаа үед Мосе өөрсдийнх нь төлөө илчлэлт хүлээн авна гэдэгт найддаг байжээ. Тооллого 11:29-д Мосе ямар агуу хүсэл эрмэлзлээ илэрхийлсэн бэ? (Хүмүүс Бурханы хуулийг мэдэж, өөрсдийнхөө төлөө Сүнснийг сонсож сурахыг тэрээр хүмүүсээ хүсдэг байлаа.)
- Иеремиа 31:31–34-т цэдэглэсний дагуу, Их Эзэн хожмын өдрүүдэд юу хийхээр амласан бэ? (Мөн Езекил 11:17–20; 36:24–28; 2 Коринт 3:2–3-ыг бас үз) Бурханы хуулийг зүрх сэтгэлдээ бичүүлсэн байх гэдэг нь юу гэсэн үг вэ? Бурханы хуулийг зүрх сэтгэлдээ бичүүлсэн байхын тулд бид юу хийх ёстой вэ?
- Бид Бурханы хуулийг зүрх сэтгэлдээ бичүүлсэн үед бидний зан төлөвт хэрхэн нөлөөлдөг вэ? Энэ нь тодорхой өгөгдсөн зарлигуудыг дуулгавартай дагахад бидэнд хэрхэн тусалдгийг та ярилцаж болно:
 - а. Хөршүүдээ хайрлах
 - б. Эцэг эхээ хүндлэх
 - в. Ёс суртахууны хувьд цэвэр ариун байх
 - г. Хүндэтгэлийн Өдрийг ариунаар нь хадгалах
 - д. Тохиромжтой кино, телевизийн хөтөлбөрүүд, ном, сэтгүүлүүд сонгож үзэх
 - е. Даруу хувцас өмсөх
 - ё. Тохиромжтой хөгжим сонгож сонсох
- Ийм олон хүмүүсийг тэр яаж амжилттай удирддагийг нь Иосеф Смитээс нэг удаа асуухад тэрээр, “Би хүмүүст зөв зарчмуудыг заадаг, тэгээд тэд өөрсдийгөө удирддаг” гэж хэлжээ (*Journal of Discourses*, 10:57–58-д Жон Тейлор иш татжээ). Бид Бурханы хуулийг зүрх сэтгэлдээ бичүүлэхэд энэ нотолгоо хэрхэн холбогдох вэ?
- 70 жилийн дараа Иудейн хүмүүс Вавилоны боолчлолд орж, тэд нэгэнтээ дахин Бурхантай нийцэн амьдардаг болсон үед тэд эх нутагтаа эргэж ирэх болно гэдгийг Иеремиа бошигложээ (Иеремиа 29:10–14; энэ бошиглолын биелэлт хичээл 47-д яригдах болно). Иеремиа 29:12–14-т өгүүлснээр, Бурханд ойр байхын тулд бид юу хийж болох вэ? Бид Бурханд ойр байхыг хичээх үед *дуудах*, *залбирах*, *эрэлхийлэх*, *судлах* гэдэг үгнүүд бидний зан төлөвтэй хэрхэн холбогдох вэ? Тэд Бурхантай ойр байхыг эрэлхийлсэн үед тэдэнд бий болсон туршлагауудыг хуваалцахад ангийн гишүүдийг урь.

Иеремиа болон бусад олон бошиглогч баяр баясгалантайгаар хүсэн хүлээж байсан тэрхүү үед бид амьдарч байгааг гэрчил. Израилын цугларалтад оролцож, Бурханы хуулийг зүрх сэтгэлдээ бичүүлэхэд нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

Нэмэлт заах санаанууд

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

1. Одоо бол наманчлах цаг мөн

Наманчилдаг хүмүүст Их Эзэний нигүүлсэл ямагт нээлттэй байдаг. Гэтэл, наманчлалыг хойшлуулдаг хүмүүст наманчлах нь улам бүр хэцүү болдог.

“Өнгөрсөн үеийн буруу зүйлүүд буюу нүглийнхээ төлөө наманчилж, уучлал хүлээн аваагүй хүний хувьд хилэнцээс зайлсхийх нь боломжгүй бөгөөд дэлхий дэх түүний нөхцөл найдваргүй юм; учир нь тэрээр өнгөрсөн үеийн буруу зүйлүүд буюу нүглүүдээ наманчлаагүй байдаг. Тэгээд, бид цааш ахих тусам, бурханлиг нигүүлсэл хийгээд өршөөлийг эрэлхийлэх өдөр тутмын зуршил нь хилэнцээс зугтаах хүчийг бидэнд өгдөг” хэмээн Ерөнхийлөгч Иосеф Ф.Смит сургажээ (*Gospel Doctrine*, 5 дахь хэвлэл. [1939], 374).

- Их Эзэний үгийг сонсох хийгээд шуурхай наманчлахын ач холбогдлын талаар дараах судрын хэсгүүд юу заадаг вэ?

Иеремиа 5:1–5, 21–25

Иеремиа 6:10–17

Иеремиа 7:23–28

Иеремиа 8:6–12, 20

Иеремиа 13:11, 23

Иеремиа 17:23

2. Бошиглогчдын үгсийг сонсон дагах нь

- Хүмүүс түүний үгсийг сонсон дагахгүй байсныг Иеремиа олонтаа цэдэглэсэн байдаг (Иеремиа 7:13; 25:3–4; 26:2–5; 32:33). Хожмын үеийн бошиглогчдын ямар үгсийг бид илүү хичээнгүйлэн дагах хэрэгтэй вэ?

3. Өмнөх үеийнхний нүглүүдийг давтдаг нь

- Өөрийнх нь үеийн иудейчүүд, өнгөрсөн үеийнхэн үүний улмаас хатуу шийтгүүлсэн тэрхүү нүглүүдийг үйлдэж байсныг Иеремиа сэрэмжлүүлж байжээ (Иеремиа 11:1–12). Иеремиагийн үеийнхэн яагаад өвөг дээдсийнхээ нүглүүдээс, ялангуяа тэдгээр нүглүүдээс болж тэд шийтгэл хүлээсэн нь тодорхой баримтжуулагдсан байхад түүнээсээ сургамж аваагүй гэж та нар боддог вэ? Бурханы гэрээг хүмүүсийн өмнөх үеийнхний сургамжуудаас илүү бүрэн дүүрэн ашиг тусыг бид хэрхэн олж болох вэ?

4. Бурханд итгэхийн ач холбогдол

- Иеремиа 17:5–8-д хүнд итгэдэг хүмүүс, Бурханд итгэдэг хүмүүсийн хооронд ямар харьцуулалтууд хийгдсэн байна вэ? Эдгээр харьцуулалтууд үнэн гэдгийг та нар хэрхэн харсан бэ? Бурханд итгэдэг итгэлээ бид хэрхэн харуулж чадах вэ?

5. Хуурамч бошиглогчид

- Зедекиа бол өөрийнхөө сонсохыг хүсдэг зүйлийг бошиглогчид түүнд яриасай гэж хүсдэг хаан байжээ. Үүний улмаас, олон хуурамч бошиглогчид Иерусалим унахгүй хэмээн амладаг байсан аж (Иеремиа 28:1–4; 37:19). Өнөө үед “хонины арьс нөмөрсөн” олон хуурамч бошиглогч ирж байна (Матай7:15). Өнөөдөр бидний дунд хуурамч бошиглогчид байгаа гэсэн ямар нотолгоо байдаг вэ? Өнөөдрийн хуурамч бошиглогчдын зарим захиас юу вэ? Хуурамч бошиглогчдоор буруу замаар удирдагдахаас бид хэрхэн зайлсхийж болох вэ?

Езекиел 18; 34; 37

Зорилго

“Израилын хоньчид” байх үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэхэд нь ангийн гишүүдийг урамшуулан дэмжих (Езекиел 34:2)

Бэлтгэл

1. Дараах судруудыг залбирч, судал:

- а. Езекиел 34. Сүргээ тэжээдэггүй хоньчдыг Их Эзэн зэмлэдэг. Тэрээр бүх төөрсөн хонийг болон тэдний Хоньчныг эрэх болно.
- б. Езекиел 18:21–32. Наманчлах ёс бусчууд аврагдах болно, мөн ёс бус уруу эргэх зөв шударга хүмүүс зайлуулагдах болно гэж Езекиел заадаг.
- в. Езекиел 37:1–14. Олон хувхай ясанд амь оруулагдсан үзэгдлийг Езекиел харжээ.
- г. Езекиел 37:15–28. Иудейн саваа, Иосефын саваа хоёр Их Эзэний мутарт нэг болно хэмээн Езекиел бошигложээ.

2. Нэмэлт уншлага: Езекиел 2.

Энэ хичээлийг
заах зөвлөмж

Анхаарал
төвлөрүүлэх
үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагааг (эсвэл өөрийхөө нэг үйл ажиллагааг) ашиглахыг хүсч болно.

Дараах асуултыг унш (эсвэл самбар дээр бич):

- Хоньчин, хөлсөөр хонь хариулагчаас юугаараа ялгаатай вэ?

Энэ асуултын хариуг олохын тулд Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсоны дараах ишлэлийг сонсохыг ангийн гишүүдээс хүс (Та ишлэлийг ангийн нэг гишүүнээр мөн уншуулж болно):

“Есүсийн үед Палестины хоньчин хонио хамгаалдгаараа ялгардаг байв. Өнөө үеийн хонь хариулагчидтай адилгүй нь, уг хоньчин ямагт сүргийнхээ өмнө нь явдаг байжээ. Тэр хонио дагуулан удирддаг байв. Хоньчин хонь бүрээ мэддэг, ихэвчлэн хонь бүр нь нэртэй байдаг байж. Хонь нь түүний дууг таньдаг, түүнд итгэдэг бөгөөд танихгүй хүнийг дагадаггүй байв. Ингээд, дуудахад, хонь нь түүн рүү ирдэг байжээ. (Иохан 10:14, 16-г үз)

“Шөнө болоход хоньчид хороо хэмээн нэрлэгддэг хонины хашаанд хонио оруулдаг байж. Хороог өндөр ханануудаар хүрээлж, ханануудын орой дээр өргөс тавьдаг байсан нь зэрлэг амьтад, хулгайч нар авиран гарахаас хамгаалдаг байжээ.

“Гэвч зарим үед, өлссөн зэрлэг амьтад ханануудыг давж, хонины дунд орж тэднийг үргээн айлгадаг байжээ. Ийм нөхцөл байдалд хонио хайрлаж хамгаалдаг жинхэнэ хоньчныг— хөлсөөр хонь хариулж, үүнийхээ төлөө мөнгө авч, үүрэг хүлээдэг хүнээс ялган салгадаг байжээ.

“Жинхэнэ хоньчин хониныхоо төлөө амиа өгөхөд бэлэн байдаг байв. Тэрээр хониныхоо дунд явж, тэдний сайн сайхны төлөө тэмцдэг байв. Нөгөө талаар, хөлсний хоньчин өөрийн хувийн аюулгүй байдлыг хониноос дээгүүр үнэлж, аюулаас ихэвчлэн зугтаадаг.” (Conference Report, 1983 оны 4-р сар, 61; *Ensign*, 1983 оны 5-р сар, 43)

Ишлэлийг уншсаны дараа, хоньчин, хөлсөөр хонь хариулагч хоёрын ялгааг хураангуйлан дүгнэхийг ангийн гишүүнээс хүс. Хэрэв шаардлагатай бол дараах асуултуудыг ашиглаж, хариултуудыг самбар дээр жагсаан бич:

- Хоньчин хониныхоо хаана нь явдаг вэ? Хөлсний хоньчин хаана нь явдаг вэ? (Хоньчин хониныхоо түрүүнд явж, тэднийг араасаа дагуулан удирддаг; ишлэлд өгүүлснээр хөлсний хоньчин хониныхоо ард явж, тэднийг туудаг.)
- Хоньчин хонь нэг бүрд яаж ханддаг вэ? Хөлсний хоньчин хонь нэг бүрд яаж ханддаг вэ?
- Хонинд нь аюул тулгарсан үед хоньчин үүнд яаж хариулдаг вэ? Хөлсний хоньчин үүнд яаж хариулдаг вэ?

Энэ хичээлийн нэг хэсгээр сүнсний хоньчид болох бидний үүрэг хариуцлагын талаар ярилцдагийг тайлбарла.

Судрын ярилцлага
ба хэрэглээ

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагауудаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

МЭӨ 597 онд Вавилоны Хаан Небухаднезар Иудейн хаант улсаас олон хүмүүсийг боол болгожээ. Эдгээр боол бологчдын дунд Их Эзэн тавхан жилийн дараа бошиглогч гэж нэрлэсэн Езекиел байв. МЭӨ 587 онд вавилончууд Иерусалимыг устгаж, бүр олон хүнийг боол болгожээ. Езекиел цөлөгдсөн өөрийн хүмүүст МЭӨ 570 оныг хүртэл тохинуулжээ.

Езекиелийн бичээсүүд зөвхөн эртний Иудейн хаант улс төдийгүй, бүх Израил, түүний дотор өнөөдрийн Сүмийн гишүүдэд хамаатай хатуу зэмлэлүүд болон алдар суут амлалтуудыг агуулдаг. Иерусалим устгагдсан ч гэсэн, Израил цугларч, сэргээгдэх өдрийг Езекиел угтан харсан юм. Энэ үйл явдал нь хөндий дэх хувхай ясны тухай үзэгдэл болон Иудей, Иосеф хоёрын савааны тухай түүний бошиглолын бэлэгдэл болдог.

1. Израилын Хоньчид

Езекиел 34-ийг зааж, ярилц. Энэ бүлэгт Их Эзэн сүргээ тэжээдэггүй байсан Израилын өөртөө үйлчлэгч хоньчдыг шүүмжилсэн байдаг. Тэгээд Тэрээр өөрийнхөө сүргийг хожмын өдрүүдэд цуглуулж, тэднийг Мянганы үед удирдах Сайн Хоньчин мөн хэмээн өөрийгөө дүрсэлсэн юм.

- Езекиел 34-т өгүүлэгдсэн “Израилын хоньчид” гэж хэн бэ? (Езекиелийн үеийн шашны удирдагчид) Их Эзэн яагаад тэдэнд дургүй байсан бэ? (Езекиел 34:2–4-ийг үз) Хоньчид хонио хайхрахгүй байхад тэдэнд юу тохиолдсон бэ? (Езекиел 34:5–6-г үз)
- Ямар байдлаар бидний хүн бүр Израилын хоньчин гэж тооцогдох вэ? (Бид гэр бүлийн гишүүдийн хувьд бие биендээ, Сүмийн гишүүд,

хөршүүд, гэрийн болон айлчлагч багш нар, тэрчлэн чуулгууд болон ангийн гишүүдийг харж хандан, тэднийг бэхжүүлэх ёстой.)

“Сүмийн аливаа хүч чадалд үйлчилж байгаа, Их Эзэний хүүхдүүдийн сүнсний хийгээд материаллаг сайн сайхны төлөө хариуцлага хүлээдэг хэн ч гэсэн эдгээр сүргийн хоньчин мөн. Их Эзэн өөрийн хоньчдыг хониныхоо аюулгүй байдлын (авралын) төлөө хариуцлага хүлээх болгодог” гэж Ахлагч Брус Р.МкКонки хэлсэн байдаг (*Mormon Doctrine*, 2 дахь хэвлэл. [1966], 710).

- Сүргээ тэжээхийн оронд өөрсдийгөө тэжээдэг зарим хоньчдод Их Эзэн дургүйцдэг байв (Езекиел 34:2–3, 8). Бидний зарим нь энэ алдааг өнөө үед хэрхэн гаргаж болох вэ?
- Езекиел 34:11–16-д өгүүлснээр, жинхэнэ хоньчид хониныхоо төлөө юу хийдэг вэ? (*эрэх, хайх, чөлөөлөх, цуглуулах, тэжээх, уях, хүчирхэг болгох* гэсэн үйл үгнүүдийг анхаар) Төөрөх, тарж явахаас бусдыг урьдчилан сэрэмжлүүлэхийн тулд бид хэрхэн тусалж чадах вэ? Төөрсөн хүмүүсийг цуглуулахад бид хэрхэн тусалж чадах вэ? Их Эзэний сүргийг бид хэрхэн тэжээж, хүчирхэгжүүлж чадах вэ? Эдгээр зүйлүүдийг хийсэн жинхэнэ хоньчдоор та нар хэрхэн адислагдсан бэ?

“Өөрсдийгөө бүхнээ зориулах шинэчлэгдсэн байдалд оруулахыг бид та нарт уриалж байна. . . . Сүргийг харж хамгаалах, тэжээх, өсгөх, анхаарал халамж тавих, зарим нь түр алдагдахад, тэднийг олохыг бид та нараас хүсч байна, та нарт анхааруулж байна” гэж Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон хэлжээ (Conference report, 1983 оны 4-р сар, 64; *Ensign*, 1983 оны 5-р сар, 45).

- Аврагч бидний хувьд юугаараа хоньчинтой адилхан бэ? (Езекиел 34:11–16; Дуулал 23; Исаиа 40:11; Иохан 10:11–15-ыг үз) Эдгээр судруудад дүрслэгдсэн зүйлүүдээс Их Эзэн тус бүрийг нь хэрхэн биелүүлснийг та ярилцаж болно. Та Сүнсээр өдөөгдсөнөө мэдэрсэн үед Аврагчийн тухай гэрчлэлээ хэл.

2. Наманчлал ба уучлал

Езекиел 18:21–32-ыг зааж, ярилц.

- Энэ хэсэг наманчлал ба уучлалын тухай юу заадаг вэ? (Езекиел 18:21–22, 27–28-ыг үз) “Шинэ зүрх . . . шинэ сүнстэй болгох” гэсэн нь юу гэсэн үг вэ? (Езекиел 18:31). Наманчлал нүглээс эргэх болон зүрх сэтгэлийн өөрчлөлт аль алиныг багтаадгийг ойлгох нь яагаад чухал вэ? Зүрх сэтгэлийн энэ өөрчлөлтийг бид хэрхэн өөрсөд дээрээ амсч болох вэ? (Алма 5:7–14-ийг үз)
- Зөв шударга байдлаас нүүр буруулж, наманчилдаггүй хүмүүсийн талаар энэ хэсэг юу заадаг вэ? (Езекиел 18:24, 26-г үз)
- Их Эзэн ёс бусчуудыг шийтгэх үед түүний бодол санаа ямар байдаг талаар энэ хэсэг юу заадаг вэ? (Езекиел 18:23, 32-ыг үз)
- Их Эзэний шударга ёс хийгээд нигүүлслийн талаар энэ хэсэг юу заадаг вэ? (Езекиел 18:25, 29–32-ыг үз) Их Эзэн шударга, нигүүлсэнгүй гэдгийг мэдэх нь яагаад чухал вэ?

3. Хувхай ясны хөндийн тухай Езекиелийн үзэгдэл

Езекиел 37:1–14-ийг зааж, ярилц. Хувхай ясны хөндийн тухай Езекиелийн үзэгдэл Израилын хүүхдүүдийн Амилуулалт хийгээд тэд амлагдсан нутагтаа сэргээгдэхийг бэлэгддэг ажээ.

- Езекиелийн үзэгдэлд Амилуулалт хэрхэн бэлэгдэл болсон бэ? (Яснууд хоорондоо нэгдэж, мах, арьсаар бүрхэгдэн, амь оруулагдсан ажээ; Езекиел 37:1–10; мөн Алма 11:42–44; 40:23-ыг үз)
- Амлагдсан нутагтаа Израилын хүүхдүүд сэргээгдэхийг Езекиелийн үзэгдэлд хэрхэн бэлэгдсэн бэ? (Езекиел 37:11–14-ийг үз. Энэ сэргээлтийг бэлэгдэхийн тулд Амилуулалтыг ашиглажээ.)
- Езекиелийн үзэгдлийг бас Израилын “найдварын” шинэчлэлийг дүрсэлсэн адил төстэй байдал гэж үзэн уншиж болно (Езекиел 37:11). Израилын найдвар нь Езекиелийн харсан хувхай ясны “агуу арми” шиг үхмэл учир, Аврагч үүнийг амьдрах чадвар хийгээд аминд нь эргүүлэн авчирч чадна. Таны найдварыг Аврагч хэрхэн шинэчилсэн бэ? (Энэ асуултын тухай ярилцах үед та Моронай 7:41-ийг уншиж болно.)
- “Их Эзэний үгийг сонс” хэмээн Езекиел тэдэнд хэлсний дараа Езекиелийн үзэгдэл дэх яснууд амь орж эхэлжээ (Езекиел 37:4). Их Эзэний үг бидэнд хэрхэн амьдрал өгдөг вэ?

4. Иудейн саваа ба Иосефын саваа

Езекиел 37:15–28-ыг зааж, ярилц. Иудейн болон Иосефын саваануудын тухай Езекиелийн бошиглол давхар утгатай юм. Энэ нь Иудейн болон Иосефын (Израилын) судрын цэдгүүд хожмын үед нэгдэхийг хэлж байгаа болно. Бас энэ нь Иудейн болон Иосефын (Израилын) хаант улсууд хожмын үед дахин нэгдэхийг хэлж байгаа болно.

- Езекиел 37:15–20 дахь бошиглол хэрхэн биелэгдсэн бэ? (1 Нифай 5:14; 2 Нифай 3:12; С ба Г 27:5-ыг үз. Эдгээр шүлгүүд дэх *саваа* гэдэг үг Езекиелийн үед нийтлэг хэрэглэгддэг байсан бичгийн модон жижиг самбар юм гэдгийг тайлбарла. Иудейн саваа Библийг бэлэгддэг бол Иосефын саваа Мормоны Номыг бэлэгддэг.)

“Иудейн саваа буюу цэдэг—Хуучин Гэрээ, Шинэ Гэрээ хоёр—түүнчлэн Есүс Христийн бас нэгэн гэрээ, Ефраимын саваа буюу цэдэг—Мормоны Ном нь та нэгийг нь анхааралтай унших юм бол нөгөө рүү нь татагдах; та нэгнээс нь сурч мэдсэнээр нөгөөгөөр нь гэгээрэх тийм байдлаар хамтдаа сүлжилдэн нэгдсэн юм. Эдгээр нь чухамдаа бидний гарт нэг юм. Езекиелийн бошиглол эдүгээ хэрэгжиж байна” гэж Ахлагч Бонд К.Пакер хэлжээ (Conference report, 1982 оны 10-р сар, 75; *Ensign*, 1982 оны 11-р сар, 53).

- Библийн зэрэгцээгээр Мормоны Номтой байгаагийн улмаас ямар адислалууд ирдэг вэ? (1 Нифай 13:39–40; 2 Нифай 3:12-ыг үз) Библийг илүү сайн ойлгоход Мормоны Ном та нарт хэрхэн тусалсан бэ? Энэ нь Их Эзэн Есүс Христийн тухай Библийн гэрчлэлийг чинь таны хувьд хэр зэрэг хүчтэй болгосон бэ?
- Хоёр саваа хамтдаа тавигдсаны дараа юу тохиох болно гэж Езекиел хэлсэн бэ?

- а. Израилын хүүхдүүд хамтдаа цугларч, Аврагч Хаан нь болох нэг хаант улсад нэгдэх болно (Езекиел 37:21–22).
 - б. Хүмүүс ариусгагдан цэвэрших болно (Езекиел 37:23).
 - в. Хүмүүс Их Эзэний дүрмүүдийг баримтлах болно (Езекиел 37:24).
 - д. Хүмүүс амлагдсан нутагт амьдрах болно (Езекиел 37:25).
- Езекиел 37:26–28-д Их Эзэн өөр ямар адислалууд амласан бэ? (Нэг чухал адислал бол ариун сүм болох Их Эзэний дуган буюу асрыг сэргээсэн явдал мөн. Дараагийн хичээлээр ариун сүмийн адислалуудын тухай илүү нарийвчлан үзэх болно.)

Дүгнэлт

Бидний хүн нэг бүрийг Аврагч хичнээн их хайрлаж, анхаарал халамж тавьдгийг ойлгоход Езекиелийн заадаг зүйлүүд бидэнд тусалдаг. Тэр бол бидний Хоньчин. Тэрбээр өршөөхийг эгээрэн хүсдэг. Тэрбээр амилуулалтыг бидний хувьд боломжтой болгосон билээ. Тэрбээр хожмын үеийн Израилын цугларалтыг чиглүүлж байна. Тэрбээр өөрийнх нь тухай бас нэгэн гэрч болох Мормоны Номыг авчирсан билээ. Эдгээр үнэнүүдийн тухай гэрчлэлээ хуваалцахад ангийн гишүүдийг урь.

Нэмэлт заах санаанууд

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

1. Сайн хоньчин байхын тулд суралцах нь

Хоньчны хувьд бидний үүрэг хариуцлагуудыг ярилцахдаа та Ерөнхийлөгч Жеймс Е.Фаустын дараах түүхийг унших буюу ярихыг хүсч болно:

“Намайг бүр жаахан хөвгүүн байхад аав маань зэлүүд газраас нэг хурга олж билээ. Энэ хурганы эх, хамт явдаг хонин сүрэг нь бэлчээр хөөн одоход, хурга яагаад ч юм эхээсээ тасарчихаж, тэгээд хурга алга болсныг хоньчин мэдээгүй бололтой. Хурга зэлүүд газарт ганцаараа амьд мэнд үлдэж чадахгүй байсан учир, аав маань үүнийг авч, гэртээ авчирсан аж. Хургыг тэнд орхих нь түүнийг зайлшгүй үхэлд хүргэх байсан нь юув гэвэл, нэг бол талын чононуудын идэш болох, нэг бол хурга бүр нялх байсан болохоор түүнд сүү хэрэгтэй учир харангадахад хүрэх байлаа. . . . Аав маань хургыг надад өгч, тэгээд би үүний хоньчин болох нь тэр.

“Хэдэн долоо хоногийн турш би хүүхдийн угжинд үхрийн сүү халааж хургыг угждаг байлаа. Төдөлгүй бид хоёр найзууд боллоо. . . . Хурга өсч эхлэв. Миний хурга бид хоёр зүлгэн дээр тоглодог байв. Заримдаа бид хоёр ногоон дээр хэвтээд, би толгойгоо хурганы зөөлхөн ноосорхог бөөрөн дээр дэрлэж, цэнхэр тэнгэрийг, бас долгиотсон хөвөн цагаан үүлийг ширтэн хардаг байж билээ. Өдрийн цагаар би хургаа цоожилдоггүй байв. Хурга явчихдаггүй байлаа. Хурга маань удалгүй өвс идэж сурав. Би чадах чинээгээрээ хонь майлахыг дуурайн, хургаа хашаан дотор хаана ч байсан түүнийг дуудаж чаддаг байлаа. . . .

“Нэг шөнө аймаар шуурга болов. Тэр шөнө би хургаа амбаарт хийх ёстой байсан ч мартчихаж. Би унтаад өгсөн байв. Миний бяцхан найз шуурганаар айж, тэгээд майлахыг нь би сонсов. Би бяцхан найздаа туслах ёстойгоо мэдэж байсан ч, гадаа гарч норолгүй, орон дотроо би ая тухтай дулаахан байхыг

хүсч байлаа. Би босох ёстой байсан хэдий ч, боссонгүй. Маргааш өглөө нь гадагшаа гартал хурга маань үхсэн байхыг харав. Нэг нохой хурга майлахыг бас сонсоод, хургыг минь барьчихаж. Зүрх минь шимшрэв. Би сайн хоньчин байж чадсангүй, эсвэл аавынхаа надад итгэл хүлээлгэн өгсөн тэр зүйлийг хариуцаж чадсангүй. ‘Хүү минь, миний итгэл хүлээлгэсэн ганцхан хурганд анхаарал халамж тавьж чадсангүй юу?’ гэж аав минь хэлж билээ. Аавын маань үг бяцхан найзыгаа алдсанаас илүүгээр зүрхийг минь өвтгөж билээ. Тэр өдөр би бяцхан хөвгүүн байхдаа, хариуцсан ажил үүргээ хэзээ ч хөсөрдүүлэхгүй, ийм байдалд дахиад хэзээ ч хүрэхгүй гэж хатуу шийдсэн юм.

“Үүнээс хойш олон биш жилийн дараа би гэрийн багшийн бага хамтрагчаар дуудагдав. Их хүйтэн буюу шуургатай үед би гэртээ үлдэж, ая тухтай байхыг хүсдэг байсан ч, нөгөөх жаахан хурга майлах нь чихэнд сонсогдох шиг болж, тэгээд би сайн хоньчин байх хэрэгтэйгээ, бас ахлах хамтрагчтайгаа хамт явах хэрэгтэйгээ мэддэг байсан. Тэдгээр олон жилүүдэд үүргээсээ булгах гэсэн хүсэл төрөх бүрд, олон жилийн тэртээ сайн хоньчин байж чадаагүй тэр нэгэн шөнө болсон харамсалтай явдлын тухай дурсамж санаанд минь орж ирдэг байлаа.” (Conference report, 1995 оны 4-р сар, 62–63; *Ensign*, 1995 оны 5-р сар, 46)

2. Сэрэмжлүүлгийн дуу хоолойгоо өргөх харуулууд

- Их Эзэн Езекиелийг бошиглогчоор дуудсан үедээ, “Би чамайг Израилын гэрийн харуулаар томиллоо” хэмээн хэлжээ (Езекиел 3:17). Езекиелийн бошиглогчийн үүргүүд харуулын үүрэгтэй хэрхэн адилхан байсан бэ? (Езекиел 3:17–21; 33:1–9-ийг үз. Езекиелийн үед цамхаг дээрх харуул нь дайсны цэргийн аюул ойртож байгааг хүмүүст сэрэмжлүүлдэг байжээ. Тэдэнд сүнслэг байдлын хувьд аюул учруулж мэдэх дайснуудын талаар Езекиел өөрийн хүмүүсийг сэрэмжлүүлдэг байв.)
- Хожмын өдрүүдэд бидний харуулууд хэн бэ? Эдгээр харуулуудтай байх нь яагаад чухал вэ? Харуулууд байх бидний үүрэг хариуцлага юу вэ? (С ба Г 88:81-ийг үз. Энэ үүрэг хариуцлагын нэг хэсэг нь сайн мэдээг хүлээн аваагүй байгаа хүмүүст үүнийг заах явдал мөн.)

Бошиглогчдын сэрэмжлүүлгүүдэд анхаарал хандуулахын, түүнчлэн— манай хөршүүдэд сайн мэдээг зааснаар тэднийг сэрэмжлүүлэхийн ач холбогдлыг заахын тулд— Ахлагч Боид К.Пакер 1976 онд Айдаход Тетоны Далан нурахад хүргэсэн сүйрүүлэгч үерийн тухай ярьсан байдаг. Үерийн ширүүн урсгалын яг зам дээр 7,800 хүн байжээ. Үер доош хөндий рүү шуугин бууж, 790 гэр орныг хаман авч, дахиад бас 800 орон гэр, сүм, сургууль, бизнесийн байгууллагуудад ноцтой эвдрэл хохирол учруулжээ. Усны хэмжээ, хурд, тухайн бүс дэх хүн амын тоог харгалзан, 5,300 хүн амь үрэгдсэн байх ёстой гэж нэг мэргэжилтэн тооцоолжээ. Гэвч урьд хожид үзэгдээгүй хачирхалтай нь, ердөө 6 хүн усанд үйж нас барсан ажээ.

Ахлагч Пакер:

“Ийм аймшигтай сүйрэлд ийм цөөхөн хүний амь эрсэдсэний учир юу вэ? . . . Учир нь тэд сэрэмжлүүлэгдсэнийх! Тэд урт хугацааны өмнө биш ч гэсэн, ноутай ч сэрэмжлүүлэгдсэн ажээ; бас сэрэмжлүүлэгдсэн хүн бүр хөршөө сэрэмжлүүлсэн байв. . . .

“Харин усанд үйж нас барсан зургаан хүний тухайд? Тэдний нэг нь яг далангийн доод талд байсан бөгөөд түүнд ямар ч сонголт байгаагүй. Тэдний

хоёр нь сэрэмжлүүлэгт итгээгүй аж, тэгээд нэгэнт цаг нь өнгөрсөн байжээ. Дараа нь тэр хоёр машин дотроо олдсон бөгөөд тэдэнд сэрэмжлүүлэг хэрэггүй байж. Гурван хүн зарим эд хогшлоо авах гэж үер рүү буцаж ороод амиа алдсан байлаа.

“Гэвч үерийн асар их хэмжээтэй харьцуулбал энэ нь гайхамшиг байлаа. Хожмын үеийн гэгээнтнүүдийн хувьд бид сэрэмжлүүлэгт анхаарал хандуулж сурах хэрэгтэй. . . .

“Одоо, дэлхийд болж байгаа зүйлд үүнтэй ихэд ижил төстэй зүйлийг, дэлхий дэх хилэнц хийгээд ёс бусын давалгааны их түрлэгийг би олж хардаг. Энэ нь бидний эргэн тойронд тархаж, улам бүр гүн болсоор байна. Бидний амьдрал аюулд байна. Бидний өмч хөрөнгө аюулд байна. Бидний эрх чөлөө аюулд байна, түүнчлэн хөршийгөө сэрэмжлүүлэхээр сэрэмжлүүлэгдсэн хүн бүрийг араас нь юу дагаж буйг, ажилдаа санамсаргүй тохиолдох зүйлийг ойлгох чадваргүйгээр ихэвчлэн явдаг. . . .

“[Бид] бошиглогчоор сэрэмжлүүлэгдээд байна. Бид сэрэмжлүүлгийг анхаарах уу, эсвэл сэрэмжлүүлэг тэдэнд хамаагүй гэж бодсон Айдахо дахь нөгөө зургаагийн адил болох уу?” хэмээн асуужээ (*That All May Be Edified* [1982], 220–21, 223).

“Гол урсах газарт бүх юм амьдрах болно”

Хичээл
44

Езекиел 43–44; 47

Зорилго

Ариун сүм дэх амьдралыг тэтгэгч, эдгээгч хүчнээс хүртэхэд нь ангийн гишүүдийг урамшуулан дэмжих.

Бэлтгэл

- Дараах судруудыг залбирч, судал:
 - Езекиел 43:1–12; 44:6–9, 23. Иерусалим дахь ариун сүмийн тухай үзэгдэл Езекиелд үзүүлэгдэв.
 - Езекиел 47:1, 6–12. Цөлд амьдрал өгч, Сөнөсөн Тэнгисийг эдгэрүүлэн, ариун сүмээс эх аван урссан голыг Езекиел харжээ.
 - Езекиел 47:2–5. Езекиел голын гүнийг хэмжиж үзээд тэрээр үүнийг гатлах бүрд ус нь улам гүнзгий болж байгааг мэдэв.
- Хуудас 209 дээрх газрын зургийг том цаасан дээр буюу самбар дээр зурж, хичээл эхлэхийн өмнө бэлтгэ.
- Нэмэлт уншлага: Езекиел 40–42; Иоел 3:18; Зехариа 14:8; Илчлэлт 22:1–3; 1 Нифай 8:10–11; 11:25; Сургаал ба Гэрээ 97:8–20.

Энэ хичээлийг заах зөвлөмж

Анхаарал
төвлөрүүлэх
үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагааг (эсвэл өөрийхөө нэг үйл ажиллагааг) ашиглахыг хүсч болно.

Дараахтай адил асуултуудыг ангийн гишүүдээс асуу:

- Спортын тэмцээн буюу үзвэрийн өөр ямар нэг арга хэмжээ үзэх үед сэтгэл их догдолсон тохиолдол та нарт байсан уу?
- Та нар бүр босч, хашгирах буюу алга ташин баяр хүргэж, сэтгэл тийм ихээр догдолж байсан тохиолдол та нарт байсан уу?
- Баяр баясгалангийн болон талархлын урам хайрласан ариун үйл явдлын талаар та нар бодож чадах уу? Эдгээр үйл явдлуудын зарим нь:
 - Дэлхийн бүтээлт (Иов 38:4–7).
 - Есүс Иерусалимд ялгууснаар орсон нь (Иохан 12:12–16).
 - Христийн Хоёр дахь Ирэлт ба Амилалт (1 Тесалоник 4:16).
- Спортын тэмцээн буюу үзвэрийн бусад үйл ажиллагааны үеэрх сэтгэл хөдлөлтэй эдгээр ариун үйл явдлуудын сэтгэл хөдлөлийг хэрхэн харьцуулж болох вэ? (Спортын тэмцээн буюу үзвэрийн бусад үйл ажиллагааны үеэрх сэтгэл хөдлөлт түр зуурын байдаг бол, ариун үйл явдлуудтай холбоотой баяр баясгалан үүрд мөнхөд байдаг.)
- Оролцогчид нь босч, хашгиралдан, даллаж баяр хөөр, талархлаа харуулдаг Сүм дэх ариун үйл явдал юу вэ? (Ариун сүмийн онцгойлон

адислалтын үеэр цугларагсад Хосанна Уухайлалт хэмээн нэрлэгддэг баяр хөөрийн агуу илэрхийлэлтэд оролцдог.)

“Хосанна Уухайлалт бол эрүүл саруул сэтгэлээр, хүний хүч чадлын бүрэн хязгаарлалтаар өгөгддөг. Цугларагсад босч, ‘Хосанна, Хосанна Бурхан болон Хурганд Хосанна. Амен, Амен, Амен’ гэдэг үгсийг нэгэн дуугаар, гурвантаа давтан хашгирдаг. Үүнийг ихэвчлэн гараа өргөж, цагаан алчуураар нэгэн хэмнэлээр даллах явдал ихэвчлэн дагалддаг. ‘Хурга’ гэдэг чимэг үг Есүс Христийн хүлцэл хийгээд цагаатгалд холбогддог.” (Даниел Х.Людлоу, хэвлэсэн, *Encyclopedia of Mormonism*, 5 боть. [1992], 2:659)

Ариун сүмийн авчирдаг баяр баясгалангийн зарим хэлбэрүүдийг ойлгоход нь энэ хичээл ангийн гишүүдэд туслах болно гэдгийг тайлбарла.

Судрын ярилцлага
ба хэрэглээ

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагауудаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Иерусалим дахь ариун сүмийн тухай үзэгдэл Езекиелд үзүүлэгдэв.

Езекиел 43:1–12; 44:6–9, 23-ыг зааж, ярилц.

- Езекиел 43:1–12, 44:6–9, 23-ыг ангийн гишүүдээр уншуул. Эдгээр шүлгүүдээс бид ариун сүмийн талаар юу мэдэж болох вэ?


Та ангийн гишүүдийн хариултуудыг самбар дээр жагсаан бичиж, тэдгээрийн утгыг ярилцаж болно. Хариултууд нь дараах зүйлүүд байж болно:

- а. Их Эзэний алдар суу ариун сүмийг дүүргэдэг (Езекиел 43:2, 4–5).
- б. Ариун сүм бол дэлхий дээрх “[Их Эзэний] сэнтийний газар” мөн (Езекиел 43:7).
- в. Их Эзэн ариун сүм дотуур алхалж, үүнийг “миний хөлийн ул гишгэх газар” гэж нэрлэдэг (Езекиел 43:7).
- г. Ариун сүм бол Их Эзэн “өөрийн хүмүүсийн дунд оршиж” болох газар мөн (Езекиел 43:7).
- д. Ариун сүмд бид Их Эзэний хуулиудын тухай мэддэг (Езекиел 43:11).
- е. Ариун сүмд гүйцэтгэхийг Их Эзэн биднээс хүсдэг ёслолууд байдаг (Езекиел 43:11).
- ё. Бүр ариун сүмийн эргэн тойрон дахь газрууд “хамгийн ариун байх ёстой” (Езекиел 43:12).
- ж. Зөвхөн зохистой хүмүүс л ариун сүмд орох ёстой (Езекиел 44:6–9).
- з. Ариун сүмд бид ариун ба ариун биш зүйл, цэвэр ба бузар зүйлийн хоорондох ялгааг мэдэж авдаг (Езекиел 44:23).

2. Цөлд амьдрал өгч, Сөнөсөн Тэнгисийг эдгэрүүлэх, ариун сүмээс эх аван урссан голыг Езекиел харжээ.

Езекиел 47:1, 6–12-ыг зааж, ярилц.

- Иерусалим дахь ариун сүмийн зүүн хаалгануудаас юу ирж байхыг Езекиел харсан бэ? (Езекиел 47:1-ийг үз) Тэр ус хаашаа урсч байсан бэ? (Езекиел 47:8-ыг үз. Иудейн аглаг буйд болон Сөнөсөн Тэнгис Иерусалимаас зүүн тийш байдгийг газрын зураг дээр үзүүл)



- Иудейн аглаг буйд бол үржил шимгүй цөл, Сөнөсөн Тэнгис бол амьтдын амьдралыг тэтгэхэд хэтэрхий их давстай аж. Езекиелийн үзэгдлийн дагуу, ариун сүмийн голын улмаас Иудейн аглаг буйд болон Сөнөсөн Тэнгист ямар өөрчлөлтүүд гарах вэ? (Езекиел 47:6–12-ыг үз)
- Ариун сүмийн тухай Езекиелийн үзэгдэлтэй төстэй, Бурханы сэнтийний тухай нэг үзэгдэл Хайрт Иоханд үзүүлэгджээ (Илчлэлт 22:1–3. Езекиел 43:7-д, Их Эзэн ариун сүмийг “миний сэнтийний газар” гэж нэрлэсэн байдгийг анхаар) Иоханы үзэгдэлд Бурханы сэнтийнээс юу урсдаг вэ? (Илчлэлт 22:1-ийг үз) “Амьдралын ус” гэж юу вэ? (Сайн мэдээний сургаалууд; хичээл 30-ын анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг үз) Хэрэв бид амьдралын уснаас хүртэхгүй бол юугаараа Иудейн аглаг буйд болон Сөнөсөн Тэнгистэй адилхан бэ?
- Ариун сүмд байдаг амьдралын ус гэрлэлтэд, гэр бүлүүдэд, бидний овог дээдэст, тэрчлэн Сүмд хэрхэн эдгээлт хийгээд амьдрал өгдөг вэ? Сүнсний амьдрал хийгээд эдгээлт өгдөг ариун сүмээс өөр юу урсан гардаг вэ? (Хариултууд нь үнэн, мэргэн ухаан, илчлэлт хийгээд гэрээнүүд байж болно.)
- Езекиел 47:12-т Езекиелийн үзэгдэл дэх голын эргийн дагуу ургасан моддыг дүрсэлдэг. Эдгээр модод голын устай юугаараа адил нийтлэг байсан бэ? (Модод эдгээх болон амьдралыг тэтгэх хүчтэй байлаа.)
- Иоханы үзэгдэлд голын эргийн дагуу юу ургасан байсан бэ? (Илчлэлт 22:2-ыг үз) Судруудад өөр хаана амьдралын мод бошиглогчдод үзүүлэгдсэн бэ? (1 Нифай 8:10–11; 11:25-ыг үз) Лихай, Нифай нарт өгөгдсөн зүүдэнд амьдралын мод юуг төлөөлж байсан бэ? (1 Нифай 11:25)
- Бурханы хайр хэрхэн эдгээж, амьдрал өгдөг вэ? Сүнсний болон бие бялдрын ямар шархуудыг Бурханы хайр эдгээдэг вэ?

3. Езекиел голын гүнийг хэмжив.

Езекиел 47:2–5-ыг зааж ярилц.

- Езекиелийг анх удаа гатлахад голын гүн ямар байсан бэ? (Езекиел 47:2–3-ыг үз) Тэрээр голыг хоёр дахь, гурав дахь, дөрөв дэх удаа гатлахад гүн нь ямар байсан бэ? (Езекиел 47:4–5-ыг үз) Эдгээр шүлгүүд ариун сүмийн тухай ямар үнэнийг өгүүлдэг вэ? (Бид ариун сүмд хичнээн олон удаа орох тутам бидний амьдрал дахь ариун сүмийн хүч төдийчинээ ихэсдэг.)

- Гайхамшигтай үнэнүүд, олон нь бэлэгдлүүдээр дамжин ариун сүмүүдэд заагддаг. Хэрэв эдгээр үнэнүүдийн буюу ариун сүмийн ёслолуудын талаарх бидний анхны ойлголт зөвхөн “шагайгаар татахаар гүнзгий” байвал бид юу хийх ёстой вэ? (Езекиел 47:2–5-ыг үз. Бид энэ “голыг” дахин дахин гатлах буюу–өөрөөр хэлбэл, ариун сүмд аль болох удаа олон орох ёстой.)

Дүгнэлт

Их Эзэн ариун сүмийг “талархал илэрхийлэх газар” гэж нэрлэснийг ангийн гишүүдэд хэл (С ба Г 97:13). Ариун сүмийн улмаас ирдэг адислалуудын төлөө талархлаа илэрхийлж, ариун сүмийн төлөөх өөрсдийн санаа бодлыг хуваалцахад ангийн гишүүдийг урь. Ариун сүмээс урссан ус Иудейн аглаг буйд болоод Сөнөсөн Тэнгисийг Езекиелийн үзэгдэлд эдгээсэн шиг, хэрэв бид үүнээс хүртэх юм бол, Есүс Христийн сайн мэдээ биднийг эдгээж, цэвэршүүлэх болно.

Нэмэлт заах санаанууд

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

1. “Би Таны өргөөний оршихуйд дуртай” (Дуулал 26:8)

Дуулалд дурдагддаг адислалуудаас бид олныг нь бид ариун сүмд орсноос, тэрчлэн ариун сүмийн төлөө хайр, талархлын сайхан мэдрэмжийг илэрхийлснээс бид хүлээн авдаг. Дууллын дараах хэсгүүдийг ярилцах үедээ ариун сүмийн төлөөх талархлын мэдрэмжүүдээ илэрхийлэхийг та ангийн зарим гишүүдээс хүсч болно:

Дуулал 24:3–4

Дуулал 26:6–8

Дуулал 27:1, 4–6

Дуулал 65:4

Дуулал 84

Дуулал 122

Дуулал 134

2. “[Бидний] Гишүүнчлэлийн агуу бэлэгдэл”

“Их Эзэний ариун сүмийг гишүүнчлэлийнхээ агуу бэлэгдэл болгон харахад би Хожмын үеийн Гэгээнтнүүдийг урьж байна. Сүмийн гишүүн бүрийг ариун сүмд орохуйц зохистой байлгах нь зүрх сэтгэлийн минь гүн гүнзгий хүсэл эрмэлзэл юм. Насанд хүрсэн гишүүн бүр ариун сүмийн хувьд зохистой байж, ариун сүмийн хүчинтэй зөвшөөрлийн бичигтэй байх нь Их Эзэнийг баярлуулах болно. Ариун сүмийн зөвшөөрлийн бичигтэй байхын тулд бидний хийх ёстой, бас хийх ёсгүй зүйлүүд бол бид хувь хүний хувьд, мөн гэр бүлийн хувьд бид аз жаргалтай болгох чухам тэр зүйлүүд мөн” гэж Ерөнхийлөгч Ховард В.Хантер хэлжээ (Conference Report, 1994 оны 10-р сар, 8; *Ensign*, 1994 оны 11-р сар, 8).

- Бид ариун сүмийг хэрхэн “[өөрсдийн] гишүүнчлэлийн агуу бэлэгдэл” болгож чадах вэ? Ийм замаар ариун сүмийг үзэх нь амьдралыг үзэх бидний үзэлд, түүнчлэн Их Эзэний ажилд бид бүхнээ зориулахад хэрхэн нөлөөлөх вэ?

“Хэрэв би үхэх бол үхнэ”

Хичээл
45

Даниел 1; 3; 6; Естер 3–5; 7–8

Зорилго

Сайн мэдээний жишгүүдийн дагуу амьдрах зоригтой байхад нь ангийн гишүүдэд туслах.

Бэлтгэл

1. Дараах судруудыг залбирч судал:
 - а. Даниел 1. Даниел болон түүний найз нар Небухаднезар Хааны зоогноос идэж өөрсдийгөө бузарлахаас татгалзав (1:1–16; пульс гэдэг нь үр тариа болон хүнсэнд хэрэглэдэг ургамлын үрүүдээр хийдэг хүнс байсныг анхаар). Даниел болон түүний найз нарыг Их Эзэн сайн эрүүл мэнд, мэргэн ухаанаар адисалжээ (1:17–21).
 - б. Даниел 3. Шахрах, Мешах, Абеднего нар Небухаднезар Хааны хиймэл шүтээнээс татгалзав (3:1–12). Небухаднезар Хааны тэднийг шатаж байгаа галтай зууханд хаясан хэдий ч, Их Эзэн тэднийг үхлээс аварчээ (3:13–30).
 - в. Даниел 6. Дари хааны хүмүүс 30 өдрийн дотор бүх өргөдөл хүсэлт өөр хүнд буюу эсвэл Бурханд биш, харин түүнд чиглэгдэж байх ёстой гэсэн зарлигт гарын үсэг зурахыг хаанд ятгажээ (6:1–9). Даниел хааны зарлигийг эс хайхран Бурханд хандан залбирчээ (6:10–13). Зарлигийг дагаагүйн төлөөх шийтгэл болгож, Даниелыг арслангийн үүрэнд хаяжээ (6:14–17). Даниелыг хамгаалахын тулд Их Эзэн тэнгэр элчийг илгээв (6:18–23).
 - в. Естер 3–5; 7–8. Мордехай Хаманд хүндэтгэл үзүүлэн бөхийхөөс татгалзав (3:1–4). Хаант улс дахь бүх иудейчүүдийг үхэлд дуудах зарлиг бэлтгэхийг Хаман хаан Ахашверошт ятгав (3:5–14). Естер өөрийх нь хүмүүсийг алах Хаманы төлөвлөгөөг мэдэж, хаанаас тусламж гуйхаар очиж, амь насаараа аз туршжээ (4:1–17). Хаан Естерийг хүлээн авч түүний хүсэлтийг ёсоор болгохын тулд Хамантай хамт хүлээн авалтад ирэхийг соёрхжээ (5:1–8). Хүлээн авалт дээр Естер иудейчүүдийг алах Хаманы хуйвалдааныг илчилжээ (7:1–6). Хаан Хаманыг дүүжлэв (7:7–10). Хаан Мордехайг хүндэтгэн, Хаманы зарлигийг хүчингүй болгох Естерийн хүсэлтийг ёсоор болгон соёрхжээ (8:1–17).
2. Нэмэлт уншлага: Даниел 5; Естер 1–2; 6; 9–10.
3. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашиглах бол, тэд эсвэл тэдний таних хэн нэгэн Их Эзэнийг дуулгавартай дагахын тулд зоригоо харуулсан үеийн тухай товч ярихаар бэлтгэхийг ангийн хоёр гишүүнээс хүс.
4. Хэрэв дараах зургууд байдаг бол, та тэдгээрийн заримыг хичээлийнхээ үед ашиглаж болно: Хааны Зоог болон Дарснаас Даниел Татгалзсан нь (62094; Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 114); Галт Зуухан Доторх Гурван Хүн (62093; Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 116); Даниел Арслангийн Үүрэнд (62096; Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 117).

Энэ хичээлийг заах зөвлөмж

Анхаарал
төвлөрүүлэх
үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагааг (эсвэл өөрийхөө нэг үйл ажиллагааг) ашиглахыг хүсч болно.

Тэд эсвэл тэдний таних хэн нэгэн Их Эзэнийг зоригтойгоор дуулгавартай дагасан үеийн тухай товч ярихаар бэлтгэхийг даалгавар авсан ангийн гишүүдээс хүс.

Ангийн гишүүд туршлагаа хуваалцсаны дараа, энэ хичээл бол Их Эзэнийг дуулгавартай дагахын тулд эр зориг гаргасан Хуучин Гэрээн дэх зургаан хүний тухай юм гэдгийг тайлбарла.

Судрын ярилцлага
ба хэрэглээ

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Даниел болон түүний найз нар Небухаднезар Хааны зоогийг идэхээс татгалзав; тэд сайн эрүүл мэнд хийгээд мэргэн ухаанаар адислагдав.

Даниел 1-ийг зааж, ярилц.

Бага насны хөвгүүн байхдаа Даниел Иерусалимаас Вавилонд боолчлогдон иржээ. Тэр болон ирээдүйтэй бусад иудей залуус—түүний дотор түүний найзууд Шадрах, Мешах, Абеднего нар— Небухаднезар Хааны ордонд сургагдсан ажээ.

- Тэдэнд хааны зоог, дарс өгөх үед Даниел болон түүний найзууд ямар бодолтой байсан бэ? (Даниел 1:8–14-ийг үз) Эрүүл мэндийн тухай Их Эзэний хуулийг дуулгавартай дагаснаараа тэд ямар адислалууд хүлээн авсан бэ? Даниел I 1:15, 17, 20-ийг үз) Тэдний хүлээн авсан адислалууд, хэрэв бид Мэргэн Ухааны Үгийг дуулгавартай дагах юм бол Их Эзэн бидэнд амласан адислалуудтай хэрхэн адилхан бэ? (С ба Г 89:18–20-ийг үз)

“Мэргэн Ухааны Үгийн суурь зорилго нь илчлэлтийг хэрэгжүүлэх явдал гэдгийг би мэдсэн юм. . . Та нарыг бүр бага байхаас чинь эхлэн цай, кофе, чихэрлэг дарс, тамхи, мансууруулах бодис, түүнчлэн та нарын эрүүл мэндийг бусниулах бусад аливаа зүйлээс зайлсхийхийг бид та нарт заасаар ирсэн билээ. . . Хэрэв хэн нэг нь ‘эдгээрийн нөлөөнд автагдсан бол’ шууд яриаг сонсох нь хэцүү байж болно, тэдний хамгийн эмзэг нарийн мэдрэмжийг хөндөх сүнсний өдөөлтүүдэд тэд хэрхэн хариулж чадах вэ? Мэргэн Ухааны Үг эрүүл мэндийн хуулийн хувьд, танд бие бялдрын хувьд гэхээсээ илүүгээр сүнслэг байдлын хувьд хавьгүй илүү үнэ цэнэтэй байж болно” гэж Ахлагч Боид К.Пакер сургажээ (Conference Report, 1979 оны 10-р сар, 28–29; *Ensign*, 1979 оны 11-р сар, 20).

- Бид хийх ёсгүй ямар нэг зүйлийг хийх шахалт дарамттай учирсан үед бид хэрхэн хариулах талаар энэ түүх бидэнд юу заадаг вэ? (Даниел 1:5, 8-ыг үз) Ямар нөхцөл байдлууд Их Эзэний зарлигуудыг дуулгавартай дагахад өнөөдөр биднээс эр зориг шаарддаг вэ? Ийм нөхцөл байдалд хэрэгтэй зоригийг бид хэрхэн хөгжүүлж болох вэ?

2. Шадрах, Мешах, Абеднего нарыг галт зуухан дотор үхэхээс Их Эзэн аврав.

Даниел 3-ыг зааж, ярилц.

- Небухаднезар Хаан өөрийнх нь хиймэл шүтээнийг бишрэн шүтээгүй хэнийг боловч галт зууханд хаяж байх зарлиг гаргажээ (Даниел 3:1–6). Шадрах, Мешах, Абеднего гурав энэ зарлигт хэрхэн хариулсан бэ? (Даниел 3:12-ыг үз) Тэд өөрийнх нь хиймэл шүтээнийг шүтээгүйг Небухаднезар мэдээд яасан бэ? (Даниел 3:13–15, 19–20-ийг үз)
- Тэднийг галт зууханд хаяхаар хаан заналхийлсэн үед Шадрах, Мешах, Абеднего нар юу гэж хэлсэн бэ? (Даниел 3:16–18-ыг үз)

“Бидний амьдралд тохиолддог асуудлуудаас бид ангид байхгүй байх болно, гэвч бид үүрдийн үхлээс аврагдах болно! Дашрамд хэлэхэд, төгс найдвар нь олон зууны тэртээ гурван зоригт эрийн хэлсэн тэрхүү гурван үгийг хэлэхийг боломжтой болгодог. Хэрэв Тэрбээр сонгох юм бол Бурхан тэднийг галт зуухнаас аварч чадна гэдгийг тэд мэдэж байжээ. ‘Хэрэв тэгэхгүй байсан ч,’ тэд мөн л Бурханд үйлчлэх болно!” хэмээн тэд хэлсэн юм гэж Ахлагч Нил А.Маквелл хэлжээ (Conference Report, 1994 оны 10-р сар, 45; *Ensign*, 1994 оны 11-р сар, 35).

- Их Эзэний зарлигуудыг дуулгавартай дагах талаар Шадрах, Мешах, Абеднего нарын хариулт бидэнд юу зааж чадах вэ? (Шадрах, Мешах, Абеднего нар Их Эзэн тэднийг хамгаалах буюу хамгаалахгүй нь хамаагүй Их Эзэнийг дуулгавартай дагахад бэлэн байлаа. Бидний дуулгавартай байдал Их Эзэн бидний хүсэн хүлээсэн адислалыг хүсэн хүлээсэн цагт өгсөн үү, үгүй юу гэдгээс хамааралтай, хариу харсан байдалтай байх ёсгүй) Бидэнд тодорхой адислал өгснийх нь л хариуд зөвхөн Их Эзэнийг дуулгавартай дагахын аюул юу вэ?
- Шадрах, Мешах, Абеднего нарыг зууханд хаяхад юу болсон бэ? (Даниел 3:21–27-г үз) Тэдэнтэй хамт зууханд хэн байсан бэ? (Даниел 3:25-ыг үз) Бидэнд тохиолдсон хүнд сорилтуудын үед бид түүнд хандвал Аврагч бидэнд хэрхэн тусалдаг вэ?
- Шадрах, Мешах, Абеднего нарын эр зориг Небухаднезарт ямар нөлөө үзүүлсэн бэ? (Даниел 3:28–30-ыг үз) Бидний үйл ажиллагаанууд манай хөршүүдээс Сүмд хандах хандлагад нь хэрхэн нөлөөлдөг вэ?

3. Даниел хааны зарлигийг эс хайхран залбирч, ингээд арслангийн үүрэнд хаягдав. Даниелыг хамгаалахын тулд Их Эзэн тэнгэр элчийг илгээжээ.

Даниел 6-г зааж, ярилц.

Небухаднезар Хааныг түүний хүү Белшазар залгамжилжээ. Белшазарыг алагдахад “меде хүн Дари” хаант улсыг авч (Даниел 5:31), ингээд Даниел өндөр нэр хүндтэй албан тушаалд дэвшжээ. (Анхаар: Меде хүн Дари бол Корешийн дараа Персийн Эзэнт гүрнийг захирч асан, ариун сүмийг сэргээн барьж байх үед иудейчүүд түүнд хандан даван заалдсан Дари Хаан биш. Езра 4–6; хичээл 47-г үз)

- Хааны ерөнхийлөгчид болон хунтайж нар яагаад Даниелаас дутагдал олохыг хүсдэг байсан бэ? (Даниел 6:1–5-үз). Хаан Даниелыг илүүтэй

хүндэлдэг байсан учир тэд атаархаж, улмаар хаан түүнд илүү их эрх мэдэл өгөх вий хэмээн сэтгэл түгшдэг байв) Эдгээр хүмүүс ямар зарлигт гарын үсэг зуруулахаар хааныг ятгасан бэ? (Даниел 6:6–9-ийг үз. Даниел тогтмол залбирдгийг мэдээд тэд 30 өдрийн дотор бүх өргөдөл хүсэлт өөр хүнд буюу эсвэл Бурханд биш харин түүнд чиглэгдэж байх ёстой гэсэн зарлигт гарын үсэг зурахыг Дари хаанд ятгажээ. Энэ зарлигийг дуулгавартай дагаагүй хүмүүсийг арслангийн үүрэнд хаях ёстой байжээ.)

- Хааны зарлигт Даниел хэрхэн хариулсан бэ? (Даниел 6:10-ыг үз) Залбирлын ач холбогдлын талаар бид Даниелаас юу сурч болох вэ? (Залбирах нь бүр түүний амь насанд аюултай болсон үед ч гэсэн Даниел үргэлжлэн залбирахаар залбирлын ач холбогдол тийм их байлаа.) Бид Тэнгэрлэг Эцэгтээ хандан залбирах онцгой боломжийн үнэ цэнийн талаар тунгаан бодоход ангийн гишүүдийг урь.
- Даниелыг залбирч байхыг нь харлаа гэж өөрийнх нь хүмүүс илтгэхэд Дари Хаан хэрхэн хариулсан бэ? (Даниел 6:12–15-ыг үз) Бурханд итгэдэг итгэлээ Хаан хэрхэн харуулсан бэ? (Даниел 6:16, 18-ыг үз)
- Их Эзэн Даниелыг арслангийн үүрэнд хэрхэн адисалсан бэ? (Даниел 6:19–23-ыг үз) Даниелын итгэл хийгээд эр зориг Дари Хаан болон түүний хаант улсын хүмүүст ямар нөлөө үзүүлсэн бэ? (Даниел 6:24–28-ыг үз)

“Даниелын үйлчлэл зөвхөн хаанд ашиг тустай байсан төдийгүй, Даниел Их Эзэнд итгэдэг байсан учир энэ нь нутаг оронд бүхэлд нь нөлөөлжээ. Хаант улсын бүх хүмүүс үнэн хийгээд амьд Бурханыг, Даниелын шүтдэг Бурханыг шүтэн бишрэх ёстой гэсэн тунхгийг хаан илгээсэн ажээ. Тэрээр өөрийнхөө амьдарч байсан ‘дэлхийд’ үйлчилснээр зөв шударга ганцхан хүний үйлчлэл, өдий олон хүмүүст нөлөөлөн, хичнээн их хүчтэй байж вэ! Хэрэв бид өөрсдийн амьдардаг ‘дэлхийд’ өөрсдийн хувь хүний арга замаар үйлчлэхээ үргэлжлүүлэх юм бол бидний үйлчлэлийн үр нөлөө хичнээн их үр ашигтай байх билээ!” хэмээн Ахлагч Том Перри хэлжээ (Conference Report, 1988 оны 4-р сар, 16; *Ensign*, 1988, оны 5-р сар 15).

4. Естер өөрийн хүмүүсийг аврахын тулд амь насаараа аз туршив.

Естер 3–5; 7–8-ыг зааж, ярилц.

Естер бол Даниелын үеийн дараахан амьдарч асан иудей эмэгтэй байв. Эцэг эх нь нас барсны дараа, түүнийг үеэл Мордехай өсгөн хүмүүжүүлжээ. Естер нэн үзэсгэлэн гоо байж, ингээд Персийн болон Медийн хаан Ахашверошт түүний гоо үзэсгэлэн таалагдаж, тэрээр түүнийг хатнаа болгожээ.

- Ахашверош Хаан Хаманыг өөрийн өндөр хэргэм зэрэгт хунтайж болгон дэвшүүлжээ (Естер 3:1). Хаан Мордехайд болон бусад зарц нартаа Хаманд хүндэтгэл үзүүлэн бөхийхийг зарлиглахад тэрээр зоригоо хэрхэн харуулсан бэ? (Естер 3:2–4-ийг үз) Хаман хэрхэн хариу үйлдэл үзүүлсэн бэ? (Естер 3:5–14-ийг үз. Тэрээр уурлаж, “зарим тодорхой хүмүүсийг”—хаант улс дахь бүх иудейчүүдийг—устгахаар тушаахыг хаанд ятгаж байв.)
- Иудейчүүдийн доторх гашуудлыг Естер мэдээд, юу болохгүй болсныг асуухаар Мордехай уруу элч илгээв (Естер 4:1–6-г үз). Естерийн тухай Мордехай юу асуусан бэ? (Естер 4:7–9-ийг үз) Естерийн хувьд дотогшоо орж, хаантай ярилцах нь яагаад аюултай байсан бэ? (Естер 4:10–11-ийг үз.)

Түүн дээр урилгагүйгээр орж ирсэн хэнийг боловч алахыг хууль хаанд зөвшөөрдөг байжээ.)

- Хаан дээр орох тухай Естериин бодлыг мэдсэн Мордехаи түүнд ямар захиас үг илгээсэн бэ? (Естер 4:13–14) “Үүн шиг ийм цагийн төлөө л хаант улсад ирсэн” байж болохыг Естер хэрхэн бясалган бодсон гэж та нар боддог вэ? (Естер 4:14). Бидний амьдрал зорилготой гэдэг итгэлийг бид хэрхэн хүлээн авч болох вэ? Энэ итгэл бидэнд хэрхэн тусалдаг вэ?
- Естер хаан дээр орохоор бэлтгэж байхдаа өөрийн шивэгчингүүд болон нутгийн иудейчүүдээс юу асуусан бэ? (Естер 4:16-г үз) Олон хүмүүсийн нэгдсэн мацаг барилт, залбирлууд бидэнд хэрхэн тусалж чадах вэ?
- Естер хаан дээр орох өөрийн бодлын талаар нотлохдоо, “Хэрэв би үхэх бол үхнэ” гэж хэлжээ (Естер 4:16). Энэ мэдэгдэл, галт зууханд хаягдахаас өмнөх Шадрах, Мешах, Абеднего нарын мэдэгдэлтэй хэр зэрэг адилхан байна вэ? (Естер 3:17–18-ыг үз) Энэ мэдэгдэл өөрийн хүмүүс болон Бурханд Естериин бүхнээ зориулахад бэлэн байсныг хэрхэн харуулсан бэ?
- Естериинг хаан дээр ороход тэрээр түүнийг хүлээж аван, түүний хүссэн юуг ч гэсэн тэрээр соёрхон зөвшөөрөх болно гэж хэлжээ (Естер 5:1–3). Хаан, Хаман хоёрыг хүлээн авалтад ирнэ үү гэж тэр хүсчээ (Естер 5:4–8). Хүлээн авалтын хоёр дахь өдөр Естер хаанаас юу хүссэн бэ? (Естер 7:3–4-ийг үз) Хаманыг устгахаар хуйвалдаж байсан тэр хүмүүс бол иудейчүүд байсныг мэдсэн хаан юу хийсэн бэ? (Естер 7:5–10-ыг үз)
- Хаман дүүжлэгдсэн хэдий ч, бүх иудейчүүдийг алах зарлиг хаант улс даяар аль хэдийн тархсан байлаа. Естер хаанаас юу хийхийг хүссэн бэ? (Естер 8:5–6-г үз) Естериин эрэлхэг зориг хийгээд итгэлийн учир иудейчүүд ямар адислалууд хүлээн авсан бэ? (Естер 8:16–17-г үз) Бусдын эрэлхэг зориг хийгээд итгэлийн учир та нар ямар адислалууд хүлээн авсан бэ?
- Естериинх шиг зориг шаардах ямар хүнд сорилтууд өнөөдөр бидэнд тулгардаг вэ? Бид зөвийг хийхийг хичээх үед, тэр ч байтугай бид хүнд үр дагавруудтай тулгарах үед бид ямар адислалууд хүлээн авах вэ?

Дүгнэлт

Үнэний төлөө тууштай зогсох зориг бидэнд байгаа үед Их Эзэн биднийг адислах болно гэдгийг гэрчил. Даниел, Шадрах, Мешах, Абеднего, Естер, Мордехаи нарын үлгэр жишээг дагахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

Нэмэлт заах санаанууд

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

1. Дуулгавартай байх зоригийн төгс адислалууд

- Даниел, Шадрах, Мешах, Абеднего, Естер, Мордехаи нарт адил нийтлэг ямар зүйл байсан бэ? (Тэд бүгдээрээ, тэр ч байтугай ингэснээр тэд амь насаараа аз туршсан ч, зөв зүйлийг хийх зоригтой байлаа) Зөв гэдгийг нь та нар мэдэж байсан ямар зүйлүүдийг хийх үү, эсвэл болих уу гэдгийг шийдсэн ямар нөхцөл байдалтай та нар тулгарч байсан бэ?

Бид зарлигуудыг сахихын тулд хичээх үед Их Эзэн биднийг адислах болно гэдгийг гэрчил. Гэвч бидний хүлээн авдаг адислалууд үргэлж тэр дороо ирдэггүй. Та үүнийг үзүүлэхийн тулд дараах хүмүүсийн тэвчин туулсан хүнд сорилтуудыг ярилцаж болно:

- а. Сара 90 нас хүртлээ хүүхэдтэй болж чадахгүй байв (Эхлэл 17:15–17; 21:1–2).
 - б. Иосефыг ах нар нь худалдаж, хожим нь хийгээгүй гэмт гэргийн төлөө түүнийг шоронд хорьж байв (Эхлэл 37:27–28; 39:7–20).
 - в. Аврагчаас найз нь урван тэрсэлж, түүнийг хууль бусаар яллан, цовдолсон билээ (Иохан 18–19).
 - г. Нифайг ах нар нь зодож, дараа нь олсоор хүлж байв (1 Нифай 3:28; 18:10–11).
 - д. Эмэгтэйчүүд, хүүхдүүд итгэл бишрэлийнхээ учир галд шатаагдахыг харахад Алма, Амюлек хоёр албадуулагдаж байв (Алма 14:8–11).
 - е. Иосеф Смит шоронд хоригдож, алагдсан билээ (С ба Г 135).
- Их Эзэн яагаад эдгээр хүмүүсийг ийм хүнд сорилтуудыг тэвчих болгосон гэж та нар бодож байна вэ? Тэд яагаад эдгээр хүнд сорилтуудыг туулах учиртай байсан гэж та нар бодож байна вэ? Тэдний үлгэр жишээнээс бид юу сурч болох вэ?

2. Үнэнийг дэмжин хамгаалах нь

Зөв гэдгийг нь өөрсдийнхөө мэдэх зүйлүүдийг дэмжин хамгаалах өөр өөр нөхцөл байдалд ангийн гишүүдийг жүжигчлэн тоглуул. Ангийн гишүүдэд тохиолдож болох нөхцөл байдлуудын тухай бод. Дараах нөхцөлүүд тустай байж болно:

- а. Нэг найз чинь хэн нэгнийг басамжлан дорд үзэж, мөн ийн үйлдүүлэхээр чамайг түлхэж байна.
- б. Тохиромжгүй гэдгийг нь өөрийн чинь мэдэх хөгжмийг сонсооч хэмээн хэн нэг нь санал болгож байна.
- в. Ням гарагт Сүмийн цуглааны дараа чамайг хэн нэг нь зоогийн газарт очихыг хүслээ.
- г. Хэн нэг нь танд архи юм уу эсвэл Мэргэн Ухааны Үгэнд харшлах ямар нэг бодис санал болгожээ.

Даниел 2

Зорилго Есүс Христийн сэргээгдсэн Сүмийн тухай ангийн гишүүдийн гэрчлэлүүдийг бэхжүүлэх, Бурханы хаант улсыг дэлхий дээр байгуулахад туслахад нь тэднийг урамшуулан дэмжих.

Бэлтгэл

1. Дараах судруудыг залбирч, судал:
 - а. Даниел 2:1–23. Небухаднезар Хаан зүүд зүүдэлж, тэгээд үүнийг дүрсэлж, тайлахыг зөвлөхүүддээ зарлиглав (2:1–13). Даниел найз нартайгаа хамт залбирахад, уг зүүд хийгээд үүний тайллыг Бурхан түүнд илчлэв (2:14–23).
 - б. Даниел 2:24–49. Небухаднезар Хааны зүүд дэлхийн агуу хаант улсуудын өсөлт хийгээд уналтыг түүнчлэн хожмын үед Бурханы хаант улс бусад бүх хаант улсуудыг ялах тэрхүү ялгуусан ялалтыг угтан хэлснийг Даниел илчилжээ.
2. Нэмэлт уншлага: Сургаал ба Гэрээ 65.
3. Сүмийн үнэний тухай товч гэрчлэлээ хэлэхэд бэлтгэхийг ангийн хоёр буюу гурван гишүүнээс хүс.
4. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашиглах бол, энэ хуудасны доод тал дахь схемийг хичээл эхлэхээс өмнө том цаасан дээр буюу самбар дээр зур.
5. Хэрэв та “Небухаднезарын Зүүд” схемийг ашиглах бол (218-ыг үз), үүнийг хичээлийн өмнө том цаасан дээр буюу самбар дээр зур. Та нар схемийг хичээл дээр ярилцахаас өмнө бие даасан хаант улсуудын нэрсийг бичих хэрэггүй.
6. Хэрэв “Даниел Небухаднезарын Зүүдийг Тайлж Байгаа нь” зураг байдаг бол, та хичээлийнхээ үед үүнийг ашиглаж болно (62531; Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 115).

**Энэ хичээлийг
заах зөвлөмж**

Анхаарал
төвлөрүүлэх
үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагааг (эсвэл өөрийхөө нэг үйл ажиллагааг) ашиглахыг хүсч болно.

Том цаасан дээр буюу самбар дээр өөрийнхөө зурсан схем дээр ангийн гишүүдийн анхаарлыг хандуул:

	1830 оны Дөрөв- дүгээр сарын 6	1880	1930	1980	1995	2000
	6	133,628	670,017	4,639,822	9,340,898	11,000,000 гаруй
	1	10	16	44	88	100
	0	23	104	1,218	2,150	2,581
	0	10	30	188	307	334
	0	1	7	19	47	102

- Эдгээр тоонууд юуг төлөөлж байгаа гэж та нар бодож байна?

Энэ асуултын хариултуудыг бодож олоход ангийн гишүүдэд хэдэн минут олго. Тэгээд схемийг дор харуулснаар бөглө:

	1830 оны Дөрөв- дүгээр сарын 6	1880	1930	1980	1995	2000
Сүмийн гишүүд	6	133,628	670,017	4,639,822	9,340,898	11,000,000 гаруй
Мормоны Ном хэвлэгдсэн хэлүүд	1	10	16	44	88 (39 бүрэн, 49 хэсэгчилсэн орчуулга)	100 (61 бүрэн, 39 хэсэгчилсэн орчуулга)
Гадсууд	0	23	104	1,218	2,150	2,581
Номлолууд	0	10	30	188	307	334
Үйл ажиллагаа явуулж байгаа ариун сүмүүд	0	1	7	19	47	102

(Сүүлчийн статистикийн мэдээ баримтыг Сүмийн сүүлчийн үеийн хэвлэлүүдээс олж үзэж болно. Статистикийн эдгээр тоо баримтыг нэмэхийн тулд та схемд нэг багана нэмж болно.)

Сүмийн эрчимтэй өсөлтийн талаар тайлбар хийхэд ангийн гишүүдийг урь. Энэ хичээлээр дэлхий дээрх Бурханы хаант улс—Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн ялгуусан их ялалтыг угтан харсан эртний бошиглогч Даниелын тухай ярилцах болно гэдгийг тайлбарла.

Судрын ярилцлага
ба хэрэглээ

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Даниел Небухаднезар Хааны зүүдийг харж, үүний тайлал өгөгдсөн илчлэлийг хүлээн авав.

Даниел 2:1–23-ыг зааж, ярилц.

Небухаднезар хаан нэг шөнө муухай зүүд зүүдэлжээ. Тэрээр энэ зүүдээ мартчихсаныг зөвлөгчиддөө хэлж, зүүдийг илчлэн, тайлахыг тэдэнд зарлиглан тушаав. (Даниел 2:2–5). Тэд зүүдийг дүрсэлж чадсангүйгээ хэлэхэд Небухаднезар Вавилоны бүх мэргэн хүмүүсийг, түүний дотор Даниел болон түүний найз нарыг цаазаар авахыг тушаажээ (Даниел 2:10–13). Хааны ахмад Даниелыг алахаар авчрахад, Даниел хаан уруу хүрч очин, зүүдийг нь тайлах хугацаа өгөхийг хүсчээ (Даниел 2:14–16).

- Хааны зүүдийг тайлахын тулд Даниел хэрхэн бэлтгэсэн бэ? (Даниел 2:17–18-ыг үз. Тэрээр өөртэйгөө хамт залбирахыг найз нараасаа хүсчээ.) Гэр бүлийн гишүүд болон найз нарын чинь залбирлууд та нарт хэрхэн тусалдаг вэ?
- Даниел болон түүний найз нарын залбирлууд хэрхэн хариулагдсан бэ? (Даниел 2:19, 27–28-ыг үз) Хааны зүүдний тухай илчлэлт хүлээн авмагцаа Даниел юу хийсэн бэ? (Даниел 2:20–23-ийг үз) Бурханы талаарх өөрийх нь бодол санааны талаар түүний үгс юуг илчилсэн бэ? Бурханд талархлаа харуулах нь яагаад чухал вэ? Бид талархлаа түүнд хэрхэн харуулж болох вэ?
- Асуултуудын хариуг олох гэж хичээхдээ Даниел, Небухаднезар хоёрын хандсан эх сурвалжуудыг хооронд нь сөргүүлэн тавь. (Даниел 2:2, 19–23, 28-ыг үз) Өнөөдөр хүмүүс хүнд асуултуудад хариулахад тусламж хэрэгтэй болсон үед, эсвэл шийдвэр гаргахдаа эргэлзээтэй ямар эх сурвалжуудад ханддаг вэ? Ийм нөхцөлүүдэд Бурханаас тусламж эрэлхийлэхэд олон хүмүүст юу саад болдог вэ?

2. Даниел Небухаднезарын зүүдийг дүрсэлж, тайлав.

Даниел 2:24–49-ийг зааж, ярилц.

- Хаан зүүдэндээ үзсэн тэрхүү агуу дүрслэлийг Даниел хэрхэн дүрсэлсэн бэ? (Даниел 2:31–33-ыг үз. Даниел Небухаднезарын Зүүдийг Тайлсан нь зургийг үзүүлэх буюу доорх схемийг өөрийн зурснаар үзүүл)

Небухаднезарын Зүүд (Даниел 2:31–45)



- Дүрслэлийн өөр өөр хэсгүүд юуг төлөөлдөг вэ? (Даниел 2:36–43-ыг үз. Хэсгүүд нь дэлхийн их гүрнүүдийн хувьд бие биенээ хүчирхэгжүүлэх өөр өөр хаант улсуудыг төлөөлж байжээ.)

Та Ерөнхийлөгч Спенсер В.Кимбаллын дараах тайлбарыг нэгтгэн дүгнэхдээ схем дээр хаант улсуудын нэрсийг бич:

- Алтан толгой нь Небухаднезар болон Вавилоны хаант улсыг төлөөлж байв.
 - Мөнгөн цээж, гар нь Кореш болон түүний Медийн болон Персийн хаант улсыг төлөөлж байв.
 - Гуулин гэдэс болон дунд чөмөг нь Филип болон Александр, түүнчлэн Грек буюу Македонийн хаант улсыг төлөөлж байв.
 - Төмөр хөлийн шилбэ нь Ромын Эзэнт Гүрнийг төлөөлж байв.
 - Төмөр болон шавар хөлийн тавхай нь Европын хэсэг үндэстнийг төлөөлж байв. (Conference Report, 1976 оны 4-р сар, 10; *Ensign*, 1976 оны 5-р сар, 8)
- Небухаднезарын зүүдэнд дэлхийн хаант улсуудыг төлөөлж байсан дүрслэлийг юу устгасан бэ? (Даниел 2:34–35) “Хүний гар хүрэлгүйгээр . . . цавчигдсан чулуу” юуг төлөөлж байсан бэ? (Даниел 2:44–45; С ба Г 65:2-ийг үз)
- “Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм 1830 онд сэргээгдсэн юм. . . . Энэ бол тэнгэрийн Бурханаар байгуулагдсан хаант улс, энэ нь хэзээ ч устгагдахгүй бас хэзээ ч орлогдохгүй бөгөөд гар хүрэлгүйгээр уулнаас тасарсан чулуу, энэ чулуу агуу том уул болж, бүх дэлхийг дүүргэх болно” гэж Ерөнхийлөгч Кимбалл сургасан байдаг (Conference Report, 1976 оны 4-р сар, 10; *Ensign*, 1976 оны 5-р сар, 8–9).
- Хожмын өдрүүд дэх Сүмийн талаар Даниел юу бошиглосон бэ? (Даниел 2:34–35, 44-ийг үз)

Та дараах бошиглолуудыг самбар дээр жагсаан бичиж болно. Сүмийн талаар Даниел бошиглосон нь:

- а. “Хүнийг гар хүрэлгүйгээр тасрах” болно (Даниел 2:34).
 - б. “Агуу уул болж, бүх дэлхийг [дүүргэх]” болно (Даниел 2:35).
 - в. “Хэзээ ч устгагдахгүй” (Даниел 2:44).
 - г. “Бусад хүмүүсийн гарт орохгүй [өгөгдөхгүй] байх болно” (Даниел 2:44).
 - д. “Бүх [бусад] хаант улсуудыг залгих болно” (Даниел 2:44).
 - е. “Мөнхөд байх болно” (Даниел 2:44).
- Чулуу “хүний гар хүрэлгүйгээр тас цавчигдана” гэсэн нь юу гэсэн үг вэ? (Даниел 2:34-ийг үз) Энэ нь хүнээр хийгдэхгүй байх болно) Сэргээгдсэн Есүс Христийн Сүм хэрхэн хүний гар хүрэлгүйгээр тасарсан чулуутай адилхан байж болох вэ?

“Бидний Их Эзэн бөгөөд Аврагч энэ сүмийн тэргүүнд зогсож, үүгээр дамжуулан өөрийн үйлчлэгчдийг чиглүүлдэг. Энэ бол Их Эзэний сүм; энэ бол хүмүүний сүм биш” хэмээн Ахлагч Иосеф Б.Вертлин хэлжээ (Conference Report, 1993 оны 10-р сар, 4; *Ensign*, 1993 оны 11-р сар, 5).

- Сүм “бүх дэлхийг бүрхэх болно”, “хэзээ ч устгагдахгүй” гэсэн Даниелын бошиглол өнөөдөр хэрхэн биелэгдэж байна вэ? (Та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааны хоёр дахь схемийг үзүүлж болно.)

“Энэ Сүм үнэн. Энэ сүм өөрийнх нь эсрэг нүдсэн шуурга бүрийг намжаах болно. Энэ сүм өөрийг нь доог тохуу хийсэн шүүмжлэгч бүрээс илүү урт удаан оршин тогтнох болно. Энэ сүм бидний мөнхийн Эцэг Бурханаар, Түүний бүх үеийнхний хөвгүүд, охидын адислалын төлөө үндэслэн байгуулагдсан юм. Энэ Сүм өөрийн тэргүүнд зогсогч, бүр Их Эзэн Есүс Христ, дэлхийн Аврагчийн нэрийг авч явдаг. Энэ сүм санваарын хүчээр удирдагдаж, үүгээр хөдөлгөгдөг. Энэ сүм Их Эзэний бурханлиг чанарын өөр нэг гэрчийг дэлхийд илгээсэн билээ. Итгэлтэй байгтун, найз нар минь. Үнэнч байгтун. Энэ эрин үед илчлэгдсэн Бурханы агуу зүйлүүдэд үнэнч итгэлтэй байгтун” хэмээн Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли гэрчилсэн байдаг (“Keep the Faith,” *Ensign*, 1985 оны 9-р сар, 6).

- Бид гэр орондоо, хамт олнууд дотроо, түүнчлэн дэлхий даяар Бурханы хаант улсыг байгуулахад оролцохын тулд юу хийж болох вэ?

Сүмийн үнэний тухай товч гэрчлэлээ хуваалцахыг даалгавар авсан ангийн гишүүдээс хүс.

Дүгнэлт

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн сүм бол дэлхий дээрх Бурханы хаант улс бөгөөд Есүс Христ үүнийг удирддагийг гэрчил. Дэлхий дээр Бурханы хаант улсыг байгуулахад оролцоход нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

Зорилго

Сионыг барихад туслах, Их Эзэний ажлыг эсэргүүцдэг хүмүүст Христийнхтэй адил хайр үзүүлэхэд нь ангийн гишүүдийг урамшуулан дэмжих.

Бэлтгэл

1. Дараах судруудыг залбирч, судал:

- а. Езра 1–6. Кореш Хаан Исаиагийн бошиглолуудад өөрийн нэрийг уншаад, Их Эзэний тааллыг хэрэгжүүлэх хүслээр дүүрчээ. Вавилонд боолчлолд байсан иудейчүүдийг тэрээр чөлөөлж, тэднийг Иерусалим уруу буцаж, ариун сүмийг барихад урьсан аж (Езра 1). Зеруббабел, Иешуа нар ойролцоогоор 50,000 хүнийг Зеруббабел, Иерусалим уруу гэдрэг удирдаж, тэгээд тэд ариун сүм барьж эхэлжээ (Езра 2–3). Самаричууд ариун сүмийн ажилд туслах санал тавьсан боловч, татгалзсан хариу аваад, уг ажлыг зогсоохоор оролдох болжээ; ариун сүмийг дахин барих ажил зогсов (Езра 4). Хэдэн жилийн дараа, бошиглогч Хаггаи, Зехариа нар ариун сүмийг дуусгахыг иудейчүүдэд ухуулав; самаричууд үүнийг эсэргүүцэхээ үргэлжлүүлэв (Езра 5; мөн Хаггаи 1-ийг бас үз). Ариун сүмийг дахин барих тухай Корешийн зарлигийг Дари Хаан шинэчилж, тэгээд энэ нь МЭӨ 515 оны үед дуусч, онцгойлон адислагджээ (Езра 6).
- б. Езра 7–8. Ариун сүм онцгойлон адислагдсанаас хойш 50 гаруй жилийн дараа Езра өөр нэг хэсэг иудейчүүдийг Иерусалим уруу буцаан авч явах зөвшөөрлийг Персийн Хаан Артаксерксаас авчээ. Езра болон түүний хүмүүс мацаг барин залбирч, улмаар Их Эзэн тэднийг аян замд нь хамгаалжээ.
- в. Нехемиа 1–2; 4; 6. Иерусалимд буцаж ирсэн иудейчүүд “туйлын зовлон зүдгүүр эдлэн басамжлагдаж байсныг мэдээд, ”Нехемиа Иерусалим уруу явж, хотыг дахин босгох зөвшөөрлийг Артаксеркс Хаанаас авчээ (Нехемиа 1–2). Иудейчүүдийн дайснууд хотыг дахин босгохоос тэднийг саатуулахыг хичээж байв. Нехемиа ажилчдыг багаж зэвсгээр хангаж, хэрэмнүүд дуусах хүртэл ажлыг урагш ахиулжээ (Нехемиа 4; 6).
- г. Нехемиа 8. Иерусалимыг тойруулсан хэрэмнүүд дахин босгогдсоны дараа, Езра судруудыг хүмүүст уншиж өгөв. Хүмүүс хуулийн үгсийг сонсоод уйлцгааж, тэдгээрийг дуулгавартай дагахыг хүсч байлаа.

2. Нэмэлт уншлага: Хаггаи 1.

3. Та судрын эхний шастирын эхлэл дэх түүхийн товч хураангуйг бэлтгэхэд ангийн нэг гишүүнийг урьж болно.
4. Хэрэв Эрт Үед Ашиглагдаж Байсан Ариун Сүмийн зураг байдаг бол, та үүнийг хичээлийнхээ үеэр ашиглаж болно (62300; Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 118).

Энэ хичээлийг заах зөвлөмж

Анхаарал
төвлөрүүлэх
үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагааг (эсвэл өөрийхөө нэг үйл ажиллагааг) ашиглахыг хүсч болно.

Ахлагч Даллин Х.Өүксийн дараах ишлэлийг ангийн нэг гишүүнээр уншуул:

“Бүхэлдээ өөр өөр үеийн хүсэл бодол, Ариун Сүнсний тайлбарлагч нөлөөгөөр нилээд ялгаатай зорилгын тухай өгүүлдэг судрын өвөрмөц шүлэг . . . өнөөгийн бидний хувь хүний хэрэгцээнд тохирсон нэн хувь хүний шинжтэй захиасыг . . . бид олж болно. Хэрэв бид судруудыг өөрсдийнхөө хувийн нөхцөл байдалтай адилтгахыг эрэлхийлэх юм бол, ‘энэ нь бидний ашиг тус хийгээд суралцахын төлөө байж болно’ (1 Нифай 19:23), тэнгэр дэх хайрлагч Эцэг тэдгээрийг ихэд хувь хүнд чиглэсэн арга замуудаар биднийг адислахад ашиглаж болно.” (*Studying the Scriptures* [Солт Лейкийн Табернеклд онцгой цугларалтад хэлсэн үгнээс, 1985 оны 11-р сарын 24])

- Судруудыг уншихад аль нэг хэсэг нь шууд танд хандсан юм шиг санагдсан тийм тохиолдол урьд өмнө танд байсан уу? (Өөрсдийнхөө туршлагаудыг хуваалцахад ангийн гишүүдийг урь) Та нарын амьдралд судрууд хэрхэн тусгай чиглүүлээр тусалдаг байсан бэ?

Энэ хичээлээр яригдах үйл явдлууд, төрөхөөс нь 150 жилийн өмнө бичигдсэн судрын нэг хэсэг—хэрэг дээрээ, энэ нь түүнийг нэрээр нь дурдсаныг олж мэдсэн нэг хүнээр эхэлснийг ярилцана гэдгийг тайлбарла.

Судрын ярилцлага
ба хэрэглээ

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагауудаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Ариун сүмийг сэргээн барихын тулд иудейчүүдийг Иерусалимд буцахыг Кореш Хаан зөвшөөрөв.

Езра 1–6-г зааж, ярилц.

Дараах түүхийн мэдээллийн товч хураангуйг танилцуул (Даалгавар авсан ангийн нэг гишүүнээр танилцуул):

МЭӨ 721 онд, Израилын хаант улсыг (Умард хаант улс буюу арван овог) Ассирийн боолчлолд аваачигдах үед Ассирийн эзэнт гүрэн дэлхийд хамгийн агуу их нь байлаа. Гэвч МЭӨ 612 он гэхэд Ассирийн эзэнт гүрэн вавилончуудаар устгагдсан ажээ. Небухаднезарын хаанчлал дор Вавилон ассиричуудын байлдан дагуулсан нутгийн ихэнхийг захирч байлаа. Иудейн хаант улсыг өмнөх хаант улс Вавилон байлдан дагуулсан нь, тэд МЭӨ 605 оны орчимд олон иудейчүүдийг олзлон аваачсан үеэс, МЭӨ 587 онд Иерусалимыг устгах хүртэл үргэлжилжээ.

МЭӨ 562 онд Небухаднезар нас барсны дараа Вавилоны хүч түргэн буурч эхлэв. МЭӨ 539 онд Корешийн удирдлага дор нэгдсэн медичүүд болон персүүд Вавилоныг унагаав. Байлдан дагуулсан хүмүүстээ харгис хэрцгий ханддаг байсан Небухаднезартай адилгүй нь, Кореш аядуу зөөлөн захирагч байсан аж. Байлдан дагуулсан хүмүүстээ найрсаг хандаж, тэдний шашин

шүтлэгийг хүндэтгэн үздэг байснаараа Кореш захирдаг хүмүүсийнхээ үнэнч итгэлийг хүлээсэн ажээ.

Кореш Вавилоныг байлдан дагуулсныхаа дараахан Иерусалим дахь ариун сүм дахин баригдах ёстой хэмээх зарлиг гаргав. Тэрээр өөрийн эзэнт гүрэн дахь иудейчүүдийг Иерусалим уруу буцаж, ариун сүмийг сэргээн барихыг урьж, тэгээд тэрээр Небухаднезарын цэргүүд ариун сүмээс хулгайлан авчирсан алт, мөнгөн савуудыг буцааж өгчээ. (Шастирын Дэд 36:22–23; Езра 1:1–3, 7-г үз. Эдгээр шүлгүүдэд дурдагдсан Иеремиагийн бошиглоор бол, Вавилоны боолчлолоос хойш 70 жилийн дараа иудейчүүд Иерусалимд эргэж ирэх байлаа; Иеремиа 25:11–12; 29:10-ыг үз)

- Иерусалимд ариун сүм дахин баригдах ёстой гэсэн зарлигийг Кореш яагаад гаргасан бэ? (Езра 1:1–2-ыг үз) Их Эзэн үүнийг түүгээр хийлгэх гэж хүссэнийг Кореш яаж мэдсэн бэ? Езра 1:2-т цэдэглэгдсэн Корешийн үгс Исаиа 44:28-д Корешийг нэрээр нь дурдсан бошиглолыг заадаг (мөн Исаиа 45:1–5-ыг үз; Корешийн түүх Хуучин Гэрээн дэх Исаиагийн номноос өмнө ирсэн хэдий ч, Исаиа Корешийг төрөхөөс 150 орчим жилийн амьдарч байсныг тайлбарла). Кореш өөрийн нэрийг Исаиагийн бошиглолуудад уншсан нь Их Эзэний Сүнсээр өдөөгдсөнийх бөгөөд бичигдсэн зүйлийг биелүүлэхийг хүсчээ хэмээн эртний Иудейн түүхч Флавиус Жозефус мэдээлжээ (*The Works of Flavius Josephus, Antiquities of the Jews*, орчуулсан. Уллиам Вистон [n.d.], ном 11, бүлэг 1, догол мөр 1–2).
- Хэрэв та судар уншиж байтал өөрийн чинь нэрийг хэлж, таны хийвэл зохих тодорхой зүйлүүдийг дүрсэлсэн бошиглол уншвал танд ямар санагдах вэ?

Зеруббавел, Иешуа нар анхны хэсэг иудейчүүдийг Иерусалим уруу буцаан авч явах үед тэд тэнд самаричууд байгаа олж мэджээ. Самаричууд бол боолчлолын үед зугтааж, Ассири болон Вавилоны колоничлогчидтой цус холилдсон израилчуудын үр удмынхан байсан бөгөөд хаад тэднийг уг нутгийг эзэмшүүлэхээр тийш нь очуулсан байсныг та тайлбарлаж болно.

- Иудейчүүдийг эргэж ирсэн талаар самаричууд юу асуусан бэ? (Езра 4:1–2-ыг үз) Самаричуудын хүсэлтэд иудейчүүд юу гэж хариулсан бэ? (Езра 4:3-ыг үз. Самаричууд жинхэнэ израилчууд биш гэж боддог байсан учир ариун сүм дахин барихад тэднийг туслалцуулахаас Иудейчууд татгалзсан ажээ) Иудейчүүдэд туслахыг нь татгалзахад самаричууд яасан бэ? (Езра 4:4–7, 11–24-ийг үз. Тэд Корешийг залгамжилсан хаадад гомдол мэдүүлж, ариун сүм дахин барих ажлыг зогсоохоор оролдож байв.)
- Ариун сүмийн ажил эцэстээ зогсов. Хэдэн жилийн дараа ажлаа сэргээхэд иудейчүүдийг юу өдөөсөн бэ? (Езра 5:1–2; Хаггаи 1-ийг үз. Бошиглогч Хаггаи, Зехариа нар сүнсээр өдөөгдсөн удирдлага чиглүүлээр хангаж байлаа.) Их Эзэн Хаггайгаар дамжуулан Иерусалим дахь ариун сүмийн талаар юу гэж хэлсэн бэ? (Хаггаи 1:3–4, 7–8-ыг үз) Иудейчүүдийн дунд ариун сүмийг дахин барихад саад болж байсан зан төлвийн ямар хандлага байсан бэ? (Хаггаи 1:2-ыг үз) Ариун сүмд тогтмол шүтэн биширч, үйлчлэхэд бидэнд саад болдог хандлага юу вэ?
- Барилга эхлэхэд самаричууд ариун сүмийг дахин барихыг зогсоох гэж дахин оролджээ. Гэвч иудейчүүд Кореш Хааны зарлигийг тайлбарлаж, Дари Хаан уг ажлыг үргэлжлүүлэхийг зөвшөөрчээ (Езра 5–6). Ариун сүм дуусахад иудейчүүд юу хийсэн бэ? (Езра 6:15–22-ыг үз)

2. Езра өөр нэг хэсэг иудейчүүдийг Иерусалим уруу буцаан удирдав.

Езра 7–8-ыг зааж, ярилц.

- Их Эзэн өмнө нь Кореш Хааны зүрх сэтгэлийг иудейчүүдийг чөлөөлөхөд өдөөсөн шиг, Тэрбээр, Езра хэсэг иудейчүүдийг Иерусалим уруу буцаан авч явахад Артаксеркс Хааны зүрх сэтгэлийг өдөөжээ (Езра 7:27–28; мөн түүнчлэн шүлэг 11–26-г үз). Хожмын өдрүүдэд Сүмийн талаарх засгийн газрын удирдагчдын зүрх сэтгэлийг Их Эзэн зөөлрүүлсэн зарим жишээ юу вэ? Сүмийн талаар засгийн газрын удирдагчид зүрх сэтгэлээ зөөлрүүлэхийн тулд бид юу хийж чадах вэ? (Хариултууд нь улс орны хуулиудыг дуулгавартай дагах, сайныг үйлдэж, сайн мэдээг дэлхий даяар заахад бэлтгэх, тэрчлэн удирдагчдын зүрх сэтгэлийг зөөллүүлэхийн тулд Их Эзэнд хандан залбирах байж болно. С ба Г 58:21, 27; 98:4–6-г үз)
- Иерусалим уруу өөрийнх нь авч яваа хэсэг израилчууд найдвартай хамгаалагдсан байхын тулд Езра юу хийсэн бэ? (Езра 8:21–23, 31-ийг үз) Та өөрөө, гэр бүл чинь эсвэл өөрийн чинь таньдаг бусад хүмүүс мацаг барилтаар хэрхэн адислагдсан бэ?

3. Нехемиа Иерусалим уруу явж, хотыг хамгаалдаг хэрэмнүүдийг сэргээн босгоход хүмүүсийг удирдав.

Нехемиа 1–2; 4; 6-г зааж, ярилц. Нехемиа бол Персийн Артаксеркс Хааны сөнч байсныг та тайлбарлаж болно. Энэ бол хааны хоол хүнс, ундны аюулгүй байдлыг Нехемиа хариуцсан, асар их итгэл, үүрэг хариуцлага хүлээсэн албан тушаал байв. Нехемиа хэдийгээр Перст чухал албан тушаал хашиж байсан ч, Иерусалим дахь өөрийн хүмүүст анхаарал халамж тавьж, тэдний хүндрэл бэрхшээлүүдийн талаар сонссон үедээ тэдэнд туслахыг эрэлхийлж байжээ.

- Иерусалим дахь өөрийн хүмүүсийн бэрхшээлүүдийн талаар Нехемиа сонсоод, тэрээр юу хийсэн бэ? (Нехемиа 1:4–11; 2:1–5-ыг үз) Нехемиагийн хүсэлтэд Артаксеркс Хаан хэрхэн хариулсан бэ? (Нехемиа 2:6–8-ыг үз. Хаан Нехемиад явах зөвшөөрөл соёрхож, түүнийг харуул, хамгаалалтаар хангаж, хотын хэрэмнүүдийг сэргээн барихын тулд ойгоос гуалин ашиглах зөвшөөрөл олгосон аж.) Бусдын зовлон бидний санааг зовоосон үед биднийг удирдаж болох юуг бид Нехемиагаас сурч болох вэ?
- Хотыг тойруулан хэрэм дахин барихад Нехемиа хүмүүсийг хэрхэн урамшуулан дэмжиж байсан бэ? (Нехемиа 2:17–18-ыг үз) Үнэнийг, түүнчлэн сүнслэг туршлагуудыг гэрчлэх нь, сайныг үйлдэхэд бусдад сүнслэгээр нөлөөлөхөд яагаад ийм их хүчтэй байдаг гэж та нар боддог вэ? Бусдын гэрчлэлүүд хийгээд сүнслэг туршлагууд танд хэрхэн сүнслэгээр нөлөөлсөн бэ?
- Санбаллат бол Самарийн захирагч байсан бөгөөд тэр болон түүний хүмүүс Зеруббабелтай хамт Иерусалимд иудейчүүдийн дайснууд байлаа. Хотын хэрмийг сэргээн барих төлөвлөгөөнд Санбаллат хэрхэн хариу үйлдэл үзүүлсэн бэ? (Нехемиа 2:10, 19; 4:1–3, 7–8, 11-ийг үз) Хэрэм барихыг зогсоох гэсэн эдгээр хүч чармайлтуудад иудейчүүд хэрхэн хариулсан бэ? (Нехемиа 4:9, 13–15-ыг үз)
- Ажлаа зогсоож, өөртэйгөө уулзахыг Санбаллат түүнээс хүсэхэд Нехемиа яасан бэ? (Нехемиа 6:1–4-ийг үз) Өнөөдөр зарим хүмүүс Сүмийн гишүүдийг Их Эзэний ажлаас хөндийрүүлэхийг яаж оролддог вэ? Ийм оролдлогуудад бид хэрхэн хариулах ёстой вэ?

“Зарим тодорхой хүмүүс, байгууллага биднийг хорлон гүтгэж, шууд бусаар гутаан доромжлох хийгээд зохисгүй хуурмаг зүйлүүдээр биднийг өдөөн хатгаж, сэргэлдөөнд оруулахыг хичээж байна. Өнөөгийн нийгэмд бид өөрсдийгөө уур уцаар, айдас буюу гомдолд байлгах нь хичнээн тэнэг хэрэг вэ, учир нь бусад хүмүүс бидний байр суурь, оролцооны талаар хуурмаг нотолгоонууд гаргахдаа бах нь ханадаг бололтой. Бидний зарчмууд буюу жишгүүд тэдгээр нотолгоонуудаас доогуур байх нь үгүй, учир нь, тэдгээр нь зөрчил сэргэлдөөнийх юм. Учир нь шалтгаан, нөхөрсөг сэнхрүүлэл хийгээд үнэн зөв баримтуудаар дамжуулан өөрсдийн байр суурийг тайлбарлах нь бидний хэрэг мөн. Өнөө үеийн ёс суртахууны асуудлууд болон сайн мэдээний мөнхийн зарчмуудад гуйвшгүй чанд зогсох, гэвч хүмүүн буюу байгууллагатай сэргэлдэхгүй байх нь бидний хэрэг мөн. . . . Сонсож, заалгуулах нь бидний хэрэг мөн. Зөрчил сэргэлдөөнөөс зөвхөн зайлсхийх төдийгүй, харин ийм зүйлүүдийг байхгүй болгох нь бидний үүрэг” гэж Ахлагч Марвин Ж.Аштон зөвлөжээ (Conference Report, 1978 оны 4-р сар, 10; *Ensign*, 1978 оны 5-р сар, 8).

4. Езра хүмүүст судруудыг уншиж өгөхөд тэд баясав.

Нехемиа 8-ыг зааж, ярилц.

- Хүмүүс хотын хэрмийг сэргээн барьж дууссаны дараа, тэд Езрагаас юу хүссэн бэ? (Нехемиа 8:1–2-ыг үз. Иудейчүүдмйн ихэнх нь судруудыг хэзээ ч сонсож, уншиж чадахгүй болтлоо боолчлолд тийм удаан хугацаагаар байсныг анхаар)
- Езра хүмүүст хэр зэрэг удаан уншсан бэ? (Нехемиа 8:3, 17–18-ыг үз) Хүмүүс хэрхэн хариулсан бэ? (Нехемиа 8:3, 6, 9, 12-ыг үз) Бид судрууд уншихдаа яаж илүү их анхааралтай байж чадах вэ? (Судруудад болон тэдгээрийг уншиж байх үед ирдэг Сүнсний шивнээнүүдэд хэрхэн илүү анхааралтай байхыг ярилц) Эдгээр хүмүүст байсан тэрхүү сэтгэл хөдлөлтийг бид өөрсөддөө хэрхэн хөгжүүлж болох вэ?
- Судруудыг ойлгоход нь өөрийн хүмүүст туслахын тулд Езра юу хийсэн бэ? (Нехемиа 8:8-ыг үз) Судруудыг ойлгох өөрийн чинь хүч чармайлтуудад, түүнчлэн тэдгээрийг ойлгоход гэр бүлдээ туслахад юу та нарт тусалсан бэ? (Өөрсдөө болон гэр бүлээрээ судар судлахыг сайжруулахын тулд хийсэн өвөрмөц зүйлүүдээ хуваалцахад та ангийн гишүүдийг урьж болно.)
- Хүмүүс судруудыг сонсоод уйлж эхлэхэд Езра болон бусад удирдагчид юу гэж хэлсэн бэ? (Нехемиа 8:9–11-ийг үз) Судрууд та нарыг хэрхэн баясахад хүргэж байсан бэ?

Дүгнэлт

“Нехемиагийн эрч хүч, чадвар, амь бие хайргүй эх оронч үзэл хийгээд хувь хүний зарчимч байдал нь шинэ, хөгжил хөөртэй Иудейг дахин нэгэнтээ оршин тогтноход авчирсан билээ. Бүтэн хагас зууны туршид балгас болон нурсан байсан Иерусалимын сэргээн босголт эхлэв. Зөв шударга, бүхнээ зориулсан санваартан Езра энэ ажилд Нехемиатай нэгдэж, тэд Иерусалимд Иудейн нийгмийг нэгэнтээ дахин сэргээхэд амжилт олсон юм.” (*Хуучин Гэрээний Оюутны Гарын Авлага:Хаадын Дээд –Малахи* [1982], 314)

Иерусалимыг сэргээн босгоход иудейчүүд үүрэг хариуцлага хүлээсэн шиг, дэлхий даяар Сионыг байгуулахад Хожмын үеийн Гэгээнтнүүд үүрэг

хариуцлага хүлээдгийг тайлбарла. Үүнийг хийхэд өөрсдөдөө туслахын тулд бид судруудын заадаг зүйлүүдийг дагаж, ариун сүмийн ажилд оролцох хэрэгтэй. Судруудын үнэнийг хийгээд ариун сүмийн ажлын чухлыг гэрчил.

Зарим хүмүүс Их Эзэний ажлыг зогсоохыг оролдох болно гэдгийг ангийн гишүүдэд сануул. Бид тэдэнд Христийнхтэй адил хайр үзүүлэх ёстой, гэвч Бурханы хаант улсыг байгуулах хүч чармайлтаас маань биднийг холдуулах боломжийг тэдэнд олгох ёсгүй.

Нэмэлт заах санаанууд

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

1. “Ажил их, хүрээ өргөн, бид бие биеэсээ салсан байна” (Нехемиа 4:19)

Иерусалимыг тойрсон хэрмийг сэргээн босгох үед иудейчүүд хэрмийн өөр өөр хэсгүүд дээр нэгэн зэрэг ажиллахын тулд өөрсдийгөө хэсгүүдэд хуваасан ажээ (Нехемиа 3; 4:19-ийг үз). Зарим үед тэд хоорондоо хол байсан хэдий ч, тэд бүгдээрээ нэгэн зорилгын төлөө ажиллаж байсан бөгөөд тэд хамтдаа ажиллаж байснаар хэрмийг дуусгах боломжтой байсан юм. Сүм дэлхий даяар янз бүрийн нэгжүүдэд (гэр бүлүүд, хэсгүүд, салбар, гадас, дүүргүүд болон чуулгууд зэрэг) хуваагддагийг ангийн гишүүдэд сануул. Зарим үед нэг нэгж бусдаасаа хол юм шиг санагдаж болно. Гэвч бүх Гэгээнтнүүд нэг адил зорилгыг хэрэгжүүлэхээр ажиллах юм бол, хэрэв хувь хүн бүр, нэгж бүр хичээнгүйлэн ажиллах юм бол, Сүм нийтээрээ өсч хөгжсөөр байх болно.

2. “Ариун сүмүүд мөнхийн гэрээнүүдийн төлөө”

Хэрэв *Family Home Evening Video Supplement International* (5X736) байдаг бол, “Ариун сүмүүд Мөнхийн Гэрээнүүдийн Төлөө,” зургаан минутын бичлэгийг ариун сүмүүдийн ач холбогдлын тухай ярианы хэсэг болгон үзүүл.

Зорилго

(1) Их Эзэн Есүс Христийн Хоёр дахь Ирэлтэд бэлтгэх, (2) аравны нэг болон өргөлүүдийг үнэнч, өгөөмрөөр төлөхөд нь, түүнчлэн (3) санваарын лацдан холбох хүчний улмаас ирдэг залбирлуудыг хүртэхэд нь ангийн гишүүдийг урамшуулан дэмжих.

Бэлтгэл

1. Энэ хичээлээр ярилцах Зехариа 10–14-ийн хэсгүүд болон Малахийг залбирч, судал.
2. Нэмэлт уншлага: Сургаал ба Гэрээ 45.
3. Хичээлийн эхний хэсгийн судрын зарим ишлэлүүдийг та тусад нь хэсэг цаасан дээр бичиж, ангийн гишүүдэд тараан өгч болно.
4. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашиглах бол, Хоёр дахь Ирэлт зургийг олж ав (62562; Сайн Мэдээний Уран Зургийн Цугдуулга 238).
5. *Шинэ Гэрээний Ангийн Гишүүний Судлах Удирдамжийг* (31392) анги дахь хүн бүрийн тоогоор олж ав. (Хэсэг нь жил тутмын сургалтын төлөвлөгөөний нэг хэсэг болгон эдгээр судлах удирдамжуудыг захиалах ёстой; бишопын зөвлөлийн нэг гишүүн эдгээрийг Ням Гарагийн Сургуулийн ерөнхийлөгчийн зөвлөлд өгөх хэрэгтэй.)

Энэ хичээлийг заах зөвлөмж

Анхаарал
төлөрүүлэх үйл
ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд та дараах үйл ажиллагааг (эсвэл өөрийхөө нэг үйл ажиллагааг) ашиглахыг хүсч болно.

Хоёр дахь Ирэлт зургийг үзүүл. Тэгээд дараах асуултуудыг асуу:

- *Хоёр дахь Ирэлт, эцсийн өдрүүд*, эсвэл *цаг хугацааны тэмдгүүд* гэсэн үгсийг сонсох үед та нарт ямар бодол төрдөг вэ? Хоёр дахь Ирэлтийг судрууд “аугаа, аймшигт өдөр” хэмээн нэрлэсэн байдаг (Малахи 4:5). Энэ нь хэрхэн аугаа хийгээд аймшигтай аль аль байж болох вэ?

“[Аврагчийн] ирэлт үлдсэн хүмүүсийн сүнсний байдлаас хамааран алдар суут, аймшигтай аль аль нь байх болно” гэж Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон хэлжээ (“Prepare Yourself for the Great Day of the Lord,” *New Era*, 1982 оны 5-р сар, 49).

Энэ хичээл (1) эцсийн өдрүүдийн талаарх Зехариа, Малахи нарын бошиглолууд, (2) Хоёр дахь Ирэлтэд бэлтгэх бидний бэлтгэлийн тухай ярилцлагуудыг багтаадгийг тайлбарла.

Судрын ярилцлага
ба хэрэглээ

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээр нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбогдох туршлагаудаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Зехариа, Малахи нар эцсийн өдрүүдийн олон үйл явдлын тухай бошиглов.

Эцсийн өдрүүдийн үйл явдлуудыг дүрсэлдэг, Зехариа, Малахи нарын дараах бошиглолуудаас заримыг нь ярилц. Хэрэв та судрын ишлэлүүд бичсэн цааснууд бэлтгэсэн бол, тэдгээрийг ангийн гишүүдэд тарааж өг. Судрын хэсэг бүрийг ангийн гишүүдээр уншуулж, энэ нь юу заадгийг хэл. Хэрэв судрын хэсэг нь Хоёр дахь Ирэлтэд бэлтгэхэд бидэнд тусалж чадах мэдээллийг агуулж байвал, бид үүнийг хэрхэн хэрэглэж болохыг ярилц.

Хоёр дахь Ирэлтэд бэлтгэхэд биелэгдсэн бошиглолууд

- а. Малахи 3:1. Нэгэн элч Их Эзэний ирэх замыг бэлтгэх болно хэмээн Малахи бошигложээ. Иохан Баптист Их Эзэний мөнх бус тохинууллын замыг бэлтгэсэн бол, Иосеф Смит Хоёр дахь Ирэлтийн замыг бэлтгэсэн элч юм (Матай 11:10-ыг үз).
- б. Малахи 4:5–6. Хоёр дахь Ирэлтийн өмнө бошиглогч Елиа эцгүүдийн зүрх сэтгэлийг хүүхдүүд рүү нь, хүүхдүүдийн зүрх сэтгэлийг эцгүүд рүү нь эргүүлэхийн тулд буцаж ирэх болно хэмээн Малахи бошигложээ. Елиа Көртландын Ариун Сүмд Иосеф Смитэд үзэгдэж, лацдалтын хүчний түлхүүрүүдийг сэргээснээр энэ бошиглол биелэгдсэн юм (С ба Г 110:13–16-г үз). *Боломжит хэрэглээ:* Бид өвөг дээдсийнхээ нэрсийг хайж олон, ариун сүмд тэдний төлөө ёслолуудыг гүйцэтгэх ёстой (Энэ асуудал дараагийн хичээлд илүү нарийвчлалтайгаар яригдах болно).

 - Хоёр дахь Ирэлтийн тухай бошиглолуудын зарим нь аль хэдийн биелэгдсэнийг мэдэх нь яагаад ач тустай байдаг вэ?

Аврагчийг ирэхээс өмнө биелэгдсэн байх ёстой бошиглолууд

- а. Зехариа 10:6–8. Иудейн болон Иосефын хүмүүс цугларч, түүнчлэн Ефраимын хүмүүс хүчирхэг байх болно. Их Эзэн өөрийн хүмүүсийг “исгэрэн” дуудахад, тэд цугларах болно. *Боломжит хэрэглээ:* Сайн мэдээг бусадтай хуваалцах замаар бид энэ цуглалтад тусалж чадна.
- б. Зехариа 12:2–3, 8–9. Иерусалимын орчимд агуу тулалдаан болно, гэвч Их Эзэн хөндлөнгөөс оролцож, Иерусалимын оршин суугчдыг устгалаас аврах болно. *Боломжит хэрэглээ:* Эцсийн өдрүүдийн бэрхшээлүүдийн үед түүний хүмүүсийг хамгаалахын тулд бид Бурханд итгэх ёстой.
- в. Зехариа 14:8. Иерусалим дахь ариун сүмээс амьдралын ус урсч, Сөнөсөн Тэнгис болон Иудейн аглаг буйдыг эдгээх болно (мөн түүнчлэн Езекиел 47:1, 8–9).

 - Эцсийн өдрүүдийн тухай бошиглолуудаас олон нь дайн, байгалийн гамшиг, тэрчлэн ёс бус явдал өргөн далайцтай тархах зэрэг эмгэнэлт явдлуудыг агуулдаг. Бид эдгээр бошиглолуудын тухай сонсож, эдгээрийн биелэлтийг гэрчилсэн үед найдвараа хэрхэн хадгалах вэ? (С ба Г 38:28–30)

Аврагчийг ирэх үед биелэгдэх бошиглолууд

- а. Зехариа 14:3–4. Их Эзэн Чидуны Уулан дээр зогсох болно, тэр уул тал дундуураа хуваагдах болно (мөн түүнчлэн С ба Г 45:48-ыг үз).
- б. Зехариа 12:10; 13:6. Иерусалимын чөлөөлөлтийн үед амьдрах еврей хүмүүс Есүс Христийг үзэж, Мессиа болох түүнийг эсэргүүцсэнийхээ төлөө гашуудах болно (мөн түүнчлэн С ба Г 45:51–53).

- в. Зехариа 13:2. Хиймэл шүтээнүүд, цэвэр ариун бус сүнснүүд, тэрчлэн хуурамч бошиглогчид устгагдах болно.
- г. Зехариа 14:5. Дэлхий дээр амьд байх зөв шударга хүмүүс Аврагчийг угтахын тулд дээш аваачигдах болно. Нас барсан зөв шударга хүмүүс амилуулагдаж, түүнийг угтахын тулд дээш аваачигдах болно (мөн түүнчлэн С ба Г 88:96–98-ыг үз).
- д. Зехариа 14:9. Их Эзэн бүх дэлхийн хаан болж, Мянган жилийн турш захирах болно.
- е. Зехариа 14:12–13; Малахи 3:13–18; 4:1–3. Ёс бусчууд устгагдаж, зөв шударга хүмүүс хадгалагдан үлдэх болно (мөн түүнчлэн 1 Нифай 22:15–17, 19-ийг үз).
- Хожмын өдрүүд, Хоёр дахь Ирэлт, Мянган жилийн тухай эдгээр бошиглолуудыг Их Эзэн яагаад илчилсэн гэж та нар боддог вэ? (С ба Г 45:34–44-ийг үз). Аврагчийн хоёр дахь Ирэлтэд бид хэрхэн бэлтгэж болох вэ? (С ба Г 45:56–57-г үз).

“Бид Бурханы зарлигуудаар амьдарсан үед Их Эзэн Есүс Христийн хоёр дахь ирэлтийг баяртайгаар хүлээж, мөн бид зохистой байх юм бол өөрсдийн хүч чармайлтаар дамжуулан хайртай хүмүүсийнхээ хамт Түүний дэргэд үүрд мөнхөд оршихоо мэднэ. Энэхүү агуу зорилгод хүрэхэд хэцүү зүйл огтхон ч үгүй. Бид хормын төдийд ч доройтож болохгүй. Бид Их Эзэний тааллыг гүйцэлдүүлэх—сэргээгдсэн сайн мэдээг дэлгэрүүлэх, дэлхийд гэрчлэлээ илэрхийлэх, сайн мэдээг бусадтай хуваалцахын тулд бэлэн байдгаа амьдралынхаа өдөр тутамд бид нотлох ёстой” хэмээн Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон хэлжээ (*The Teachings of Ezra Taft Benson* [1988], 341).

- Зөв шударга ёс, ёс бус байдлыг эцсийн эцэст ялна гэдгийг мэдэх нь та нарт хэрхэн тусалдаг вэ?

2. Аравны нэг, өргөлүүдийг төлдөг хүмүүст ирдэг адислалуудын тухай Малахи заадаг байв.

Малахи 3:8–12-ыг зааж, ярилц.

- Аравны нэг болон өргөлүүдийг төлөхгүй байснаар хүмүүс “Бурханыг хэрхэн дээрэмддэг” вэ?
- Аравны нэгийг бүрэн төлөх гэсэн нь юу гэсэн үг вэ?

“Бидний мэддэг хамгийн энгийн нотолгоо бол Их Эзэний өөрийнх нь тухай, нэрлэвэл, Сүмийн гишүүд ‘өөрсдийн жил тутмын бүх орлогын аравны нэгийг’ төлөх ёстой нь дундаж орлого гэж ойлгогддог. Үүнээс өөр аливаа дүгнэлт хийхэд хэн ч эс зөвтөгдөнө” хэмээн Тэргүүн Зөвлөл мэдэгджээ (Тэргүүн Зөвлөлийн захидал, 1970 оны 3-р сарын 19; мөн түүнчлэн С ба Г 119:1–4-ийг үз).

- Хэрэв бид аравны нэгийг төлөх юм бол Их Эзэн бидэнд ямар адислалууд амласан бэ? (Малахи 3:10–12-ыг үз) Та нарыг аравны нэг болон өргөлүүдээ төлсөн үед Их Эзэн хэрхэн адисалсан бэ?

- Аравны нэг болон өргөлүүдийг төлөхөд биднийг юу өдөөн түлхдэг вэ?

Аравны нэгийг төлөгчдөд Их Эзэний өгдөг адислалуудын талаар Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хэлэхдээ:

“За, миний хэлснийг бүү буруу ойлгоорой. Хэрэв та нар аравны нэгээ шударгаар төлөх юм бол мөрөөдлийн гоё байшин, Роллс Роис машин юм уу эсвэл Хавайд амралтын цогцолбор эзэмшил газартай болно хэмээн хэлэх гэж би энд ирээгүй. Их Эзэн бидний шунаг хүслийн дагуу биш, харин бидний хэрэгцээний дагуу тэнгэрийн цонхуудыг нээх болно. Хэрэв бид баяжихын төлөө аравны нэгийг төлдөг бол, бид үүнийг буруу зорилгын төлөө төлж байгаа хэрэг. Аравны нэгийн үндсэн гол зорилго бол, түүний ажлыг явуулахад хэрэгтэй арга хэрэгслээр Сүмийг хангах явдал мөн” гэжээ (Conference Report, 1982 оны 4-р сар, 60; *Ensign*, 1982 оны 5-р сар, 40).

- Аравны нэгийн хуулийг дуулгавартай дагах нь яагаад заримдаа сорилт байдаг вэ? Энэ сорилтыг даван туулахын тулд юу хийх хэрэгтэй вэ?

3. Лацдалтын хүчний түлхүүрүүдийг сэргээхийн тулд Елиа дэлхийд эргэж ирэх тухай Малахи бошиглов.

Малахи 4:5–6-г зааж, ярилц.

- Их Эзэний Хоёр дахь Ирэлтийн өмнө бошиглогч Елиа дэлхийд ирэх болно гэж Малахи бошигложээ (Малахи 4:6). Энэ бошиглол хэрхэн биелэгдсэн бэ? (С ба Г 110:13–16-г үз. Елиа Көртландын Ариун Сүмд үзэгдэж, лацдалтын хүчний түлхүүрүүдийг Иосеф Смитэд сэргээн өгчээ). “Эцгүүдийн зүрх сэтгэлийг хүүхдүүд рүү нь, мөн хүүхдүүдийн зүрх сэтгэлийг эцгүүд рүү нь эргүүлэх” гэсэн нь юу гэсэн үг вэ? (Энэ нь бид бүгдээрээ өөрсдийн өвөг дээдэс—өөрсдийн “эцгүүдтэй”—түүнчлэн өөрсдийн бүх үр удам—өөрсдийн “хүүхдүүдтэй”—үүрд мөнхөд лацдуулан холбогдох ёстой гэсэн үг юм. Санваарын лацдах хүч хийгээд амьд байгаа хүмүүс болон нас барагсдын төлөөх ариун сүмийн ёслолуудын улмаас гэр бүлүүд үүрд мөнхөд хамтдаа холбогдож болно.)
- Та нар өвөг дээдэстээ зориулж, гэр бүлийн түүх, ариун сүмийн ажил хийсэн үедээ зүрх сэтгэл чинь тэдэн рүү эргэснийг хэрхэн мэдэрдэг вэ? Ариун сүмийн гэрээний амлалтууд та нарын зүрх сэтгэлийг эцэг эх, эхнэр буюу нөхөр, хүүхдүүд рүү чинь хэрхэн эргүүлдэг вэ?
- Малахи 4:5–6 дахь захиас нь дараах жишиг бүтээл тус бүрд заагддаг (Лук 1:17; 3 Нифай 25:5–6; С ба Г 2:1–3; Иосеф Смит—Түүх 1:37–39). Энэ захиас яагаад өдий олон удаа давтагддаг гэж та нар боддог вэ?

Дүгнэлт

Энэ хичээлээр ярилцахаар өөрийн сонгож авсан зүйлүүдийн талаар гэрчлэлээ хуваалц. Энэ жилийн суралцах хичээлийн төгсгөл болгож, та Хуучин Гэрээн дэх заадаг зүйлүүдийн төлөө талархлаа илэрхийлэхийг хүсч болно.

Шинэ Гэрээний Ангийн Гишүүний Судлах Удирдамжийн нэг хувийг ангийн гишүүн бүрд өг (31392; “Бэлтгэл” хуудас 225-ыг үз). Дараагийн жилийн судлах хичээл нь Шинэ Гэрээ гэдгийг тайлбарла. Судлах удирдамжийг ашиглаж эхлэн дараагийн долоо хоногийн хичээлд бэлтгэхэд нь болон Шинэ Гэрээг гэрийнхэнтэйгээ судлахад нь гишүүдийг урамшуулан дэмж.

Дараах материал нь зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болж байгаа болно. Та хичээлийнхээ хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг нь буюу түүнээс олныг ашиглаж болно.

1. Аврагчийн бошиглогдсон үзэгдэлтүүд

- Аврагчийн наад зах нь долоон удаагийн үзэгдэлт судруудад угтан хэлэгджээ. Тэдгээрээс та нар хичнээнийг нь мэдэх вэ?

Дараах мэдээлэл энэ асуултад хариулахад тусална:

- а. Анхны Үзэгдэлд Бошиглогч Иосеф Смит дээр хүрч ирсэн (Үйлс 3:19–21; Иосеф Смит—Түүх 1:15–17).
- б. Хожмын үеийн өөрийн ариун сүмүүдэд (Малахи 3:1; С ба Г 133:1–2).
- в. Адам-ондай-Аманы хөндийд (С ба Г 116; Даниел 7:13–14, 22; мөн түүнчлэн өнгөрсөн үед Адам-ондай-Аманд болсон цугларалтай адил цугларалт тэнд болно гэдгийг дүрсэлжээ С ба Г 107:53–56-г мөн үз).
- г. Армагеддоны тулалдаан хэмээн мэдэгддэг сөргөлдөөний үеэр Иерусалимд (Езекиел 38–39; Зехариа 12–14; Илчлэлт 11; С ба Г 45:47–53).
- д. Миссурийн Индепенденст, Шинэ Иерусалим хотод (3 Нифай 21:24–26).
- е. Өөрийн Хоёр дахь Ирэлтийн үеэр зөв шударга хүмүүст (Зехариа 14:5; 1 Тесалоник 4:16–17; С ба Г 88:96–98).
- ё. Ёс бусыг үйлдэгчдэд (С ба Г 133:42–51).

2. Хоёр дахь Ирэлт хэзээ тохиох вэ?

Тэрээр дахин ирэх нь гарцаагүйг Их Эзэн тодорхой болгосон ч, яг тодорхой цагийг нь хэн ч мэдэхгүй (С ба Г 39:20–21; 49:7).

“Зарим ах нар . . . [Ерөнхийлөгч Вилфорд Вудрафф] дээр орж . . . төгсгөл хэзээ болохыг —Эзэний ирэлт хэзээ болно гэж боддогийг нь түүнээс асуужээ. Эдгээр нь түүний шууд хэлсэн үг биш гэж би боддог, гэвч тэдгээр нь түүний хэлсэн хариуны сүнсийг дамжуулдаг: ‘Би үүнийг маргааш болох юм шигээр амьдрах учиртай—гэвч би интоорын мод тарьсаар л байна!’ Миний бодлоор төгсгөл маргааш болох юм шигээр бид энэхүү мэдэгдлийг хүлээн авч, үүнийг амьдралдаа хэрэгжүүлж—интоорын моддоо тарьсаар байцгаая! Бид юу ч хийж үл чадах ирээдүйн үйл явдлуудын тухайд гэвэл, бид гэр бүлүүд, найз нартайгаа ажиллах боломжуудыг хайхрахгүй байж болохгүй; ирээдүйд болох үйл явдлуудын тухайд гэвэл, одоо, энд хийх хэрэгтэй байгаа, бас өөрсдийнхөө хийж чадах ямар нэг зүйлийг бид үл тоомсорлох ёсгүй” гэж Ахлагч Ричард Л.Еванс хэлжээ (Conference Report, 1950 оны 4-р сар, 105–6).